

Монгол Улс
Татварын Ерөнхий газар

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБАНЫ
ТАТВАР ХУРААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
БОЛОН ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН
АСУУДЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ
ТӨСЛИЙН 2-Р ШАТ

Эцсийн тайлан

Хавсралт хэвлэмэл материал

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд

хийсэн зүйлс

2020 оны 3 сар

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
БАЙГУУЛЛАГА (JICA)

Санхүү, төсвийн судалгааны институт

Пакса ХХК

ГАРЧИГ

- Суурь судалгааны тайлан
- Хүний нөөцийг бэлтгэх төлөвлөгөө, Олон улсынтатварын асуудалд дэмжлэг үзүүлэх
- Олон улсын татвартай холбоотой сургалтын материал, хөтөлбөр
- Олон улсын татвар ногдуулалтыг хэрэгжүүлэх бүтэц бүрэлдэхүүний талаарх судалгааны тайлан
- Олон улсын татвар ногдуулалтын тогтолцоогбүрдүүлэх талаарх санал зөвлөмж
- Татварын өр барагдуулах, шаардахтай холбоотой судалгааны тайлан
- Өр дуудах төвийн үйл ажиллагааны нөхцөл байдал ба шийдвэрлэх асуудлууд
- Татварын албадын дотоод ажлын тайлан
- Татвар хураалттай холбоотой гарын авлага, материал

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

Суурь судалгааны тайлан

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БА ЯПОНЫ ОЛОН
УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
БАЙГУУЛЛАГЫН ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2017 ОН

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БА ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ОРШИЛ

Энэхүү суурь судалгааны зорилго нь татварын байгууллагын олон улсын татвар ногдуулалт, татвар хураалтын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, түвшинг тодорхойлоход оршино.

2017.02.15-нд энэхүү төслийн ажлыг хийх тухай анхны уулзалтыг Б.Бадрал дарга, С.Нармандах нартай хийж, ажлын төлөвлөгөө, ажлын хүрээний талаар хийлгэх ажлын даалгаврыг хүлээн авав.

Ажлын төлөвлөгөө, календарчилсан хуваарийг батлуулж ажилдаа 2017.03.03-наас орлоо. Бэлтгэл ажлын хүрээнд Сангийн яамны Татварын орлогын хэлтэс, Татварын ерөнхий газрын Татварын үйлчилгээний төв, Татварын өр дуудах төв, Татварын орлогын газар, ТЕГ-ын сургалтын төв болон Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн холбогдох хүмүүстэй уулзалт хийж тэмдэглэл хөтөлсөн бөгөөд ТЕГ-ын Татварын орлогын газар болон Мэдээлэл, технологи, статистикийн газраас тоон мэдээллийг авч боловсруулалт хийсэн болно.

Суурь судалгааг МУИС-ийн дэргэдэх Монгол Японы хүний нөөцийн төвийн захирал доктор Ц. Даваадорж ахалж, МУИС-ийн багш доктор Б.Алтанцэцэг, доктор Б.Соёлмаа, докторант Д.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэлээ.

Тайланг ажлын даалгаварт тусгагдсаны дагуу 3 үр дүнгээр багцалж бичлээ.

ҮР ДҮН 1: ОЛОН УЛСЫН ТАТВАР НОГДУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ДУНД БА ГҮНЗГИЙРҮҮЛСЭН ШАТНЫ МЭДЛЭГ, ПРАКТИК УР ЧАДВАР ОЛГОХ

Энэ хэсгийг ТЕГ-ын газар, хэлтсийн дарга болон ажилчидтай хийсэн уулзалтын тэмдэглэл болон сургалтанд хамрагдсан байцаагч нартай хийсэн ярилцлагын материал дээр суурилан боловсруулав.

Дараах 4 хэсгээр авч үзлээ.

1.1 Сургалтын одоогийн хөтөлбөр, төлөвлөгөө, багшийн заах арга зүйн материал, сургалтад хамрагдагсдын талаарх мэдээлэл, үүний дотор төсөлд хамаарах асуудлаар хийсэн сургалтууд, эдгээр сургалтад хамрагдсан татварын улсын байцаагчдын тоо, тэдгээрийн дундаж үнэлгээний талаар

Сургалтын төвөөс зохион байгуулсан сургалт

Олон улсын татварын сургалтын хөтөлбөрийг боловсруулж сайжруулах ажлын хүрээнд 2014 оны 8 сард тухайн үед ашиглаж байсан хөтөлбөрийг хянаж¹ улсын байцаагчийн эрх олгох сургалтад ашигласан. Сургалтын төвөөс 2014 онд зохион байгуулсан “Татварын улсын байцаагчийн эрх олгох анхан шатны танхимын сургалт” нь нийт 240 цагийн сургалт бөгөөд үүнээс 2 цагт нь олон улсын татварын ерөнхий ойлголт болон татварыг давхардуулан ногдуулахгүй байх гэрээний тухай товч ойлголтыг заадаг байна (Хавсралт А1.1). Энэхүү сургалтад нийт 60 байцаагч хамрагджээ.

Сургалтын төвөөс 2015 онд нийт 5 сургалт зохион байгуулж, 213 байцаагчийг хамруулсан. Эдгээрээс нэг сургалт нь дангаараа олон улсын татварын талаарх анхан шатны 40 цагийн сургалт байсан бөгөөд төслийн зөвлөх Ишигүро Хидэаки, Кодера Тошинари нартай хамтран уг хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, энгийн байцаагчдад зориулан хичээл заасан байна. (Хавсралт А1.2).

Хүснэгт 1.1 Сургалтын төвөөс зохион байгуулсан сургалт

Сургалт	Нийт цаг	Үүнээс ОУ-ын татвар хамарсан цаг	Хугацаа	Оролцсон байцаагчдын тоо
Татварын улсын байцаагчийн эрх олгох анхан шатны танхимын сургалт	240	2	2014.10.01-11.12	60
Татварын улсын байцаагч нарт зориулсан олон улсын татварын анхан шатны сургалт 1	40	40	2015.8.17-8.21	213
Татварын улсын байцаагчийн эрх олгох анхан шатны танхимын сургалт	240	2	2015 онд 4 удаа	
Татварын улсын байцаагч нарт зориулсан олон улсын татварын анхан шатны сургалт 2	40	40	2016.3.07-3.11	45/50
Татварын улсын байцаагч нарт	40	40	2016.9.19-9.23	

¹ Төслийн эцсийн үнэлгээний судалгааны тайланд дурьдсан.

зориулсан олон улсын татварын анхан шатны сургалт 3				
--	--	--	--	--

Эх үүсвэр: ТЕГ, Сургалтын төвийн өгсөн мэдээлэл

2016 онд тус хөтөлбөрөөр 3 дахь удаагийн сургалт зохион байгуулан, хөтөлбөрийг эцэслэн батлуулжээ. 2016 онд олон улсын татвар ногдуулалтын анхан шатны мэдлэг олгох сургалтыг татварын улсын байцаагчдад зориулан 2 удаа 2015 онд боловсруулсан хөтөлбөрөөр ЖАЙКА төслийн зөвлөхүүдтэй хамтран зохион байгуулсан (ХавсралтА1.3). Нийт 90 байцаагчид сургалтад хамрагдсан бөгөөд эдгээр байцаагчдын 45-аас нь шалгалт авахад дундаж үнэлгээ нь 65 гарчээ. Үүнээс өмнө дотоодод хийгдсэн улсын байцаагчдын сургалтуудад шалгалт авч, үнэлж байгаагүй нь сургалтын төвийн холбогдох ажилтантай хийсэн ярилцлагаар тодорхой болсон.

Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт

ЖАЙКА-тай хамтарсан төслийн хүрээнд хүний нөөцийн төлөвлөгөө боловсруулж, сургалтын төлөвлөгөөг батлуулжээ. Олон улсын татварын асуудал хариуцсан байцаагчдыг бэлтгэх төлөвлөгөөний дагуу олон улсын татварын анхан шатны сургалтыг Япон улсад 1 удаа, Монголд 1 удаа, дунд шатны сургалтыг Япон улсад 1 удаа, Монголд 3 удаа зохион байгуулсан. Төлөвлөгөөт сургалтуудаас гадна удирдах албан тушаалтнуудад зориулсан “Олон улсын татвар ногдуулалт”, “Мэдээлэл харилцан солилцох” болон “Гадаад ажил гүйлгээний хяналт шалгалт”сэдвээр сургалт хийсэн байна.

Хүснэгт 1.2 Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт

	Сургалт	Хугацаа	Оролцсон хүний тоо	Оролцогчид
1	Японд хийсэн олон улсын сургалт	2014.2.16-3.01	22	ОУ-ы татварын асуудал хариуцан ажиллах албан хаагчид
2	ТЕГ-ын удирдах ажилтанд зориулсан олон улсын татвар ногдуулалтын сургалт	2014.4.09-4.11	27	ТЕГ ба дүүргүүдийн татварын албадын дарга нар
3	Мэдээлэл харилцан солилцох сургалт	2014.5.19-5.21	40	ОУ-ын татвар хариуцан ажиллах байцаагч, удирдах албан тушаалтан
4	Олон улсын татвар ногдуулалтын анхан шатны сургалт	2014.6.22-7.04	21	Японд ОУ-ын татвар ногдуулалтын дунд шатны сургалтад хамрагдахаар нэр дэвшсэн байцаагчид
5	ОУ-ын татвар хариуцсан албан хаагч бэлтгэх 2 дахь удаагийн сургалт	2014.11.17-11.28	40	ОУ-ын татварын асуудал хариуцан ажиллах албан хаагчид
6	Японд хийсэн олон улсын сургалт	2015.2.16-2.27	21	ОУ-ын татварын асуудал хариуцан ажиллах албан хаагчид
7	Олон улсын татвар ногдуулалтын дунд шатны сургалт	2015.4.06-4.10	28	ОУ-ын татварын асуудал хариуцан ажиллах албан хаагчид
8	Давтан сургалт	2016.2.29-3.04	35	ОУ-ын татварын асуудал

				хариуцан ажиллах албан хаагчид
9	Японы ТЕГ-ын ажилтнууд Монгол улсад зохион байгуулсан сургалт	2016.6.21-6.23	53	
10	Хамт олны хэлэлцүүлэг	2016.9.27	29	

Эх үүсвэр: “Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь: Төслийн 2 дахь жилийн эцсийн тайлан” Монгол улс, Татварын Ерөнхий Газар, 2016 оны 10 сар

Одоогоор анхан болон дунд шатны сургалтуудыг зохион байгуулаад байна. Цаашид сургалтыг хоёр түвшинд явуулах шаардлагатай байна. Нэгдүгээрт, энгийн байцаагчид, ялангуяа хяналт шалгалтын байцаагчдыг олон улсын татвар ногдуулалтын талаар мэдлэгтэй болгох, хоёрдугаарт олон улсын татварын сургалтад хамрагдсан, мэргэшсэн байцаагчдыг илүү нарийн мэргэшүүлэх буюу ахисан түвшний мэдлэг олгох сургалтууд хэрэгцээтэй байна гэсэн саналууд уулзалт бүр дээр гарч байлаа.

Заах арга зүйн материал

Олон улсын татварын асуудлаар Японд болон дотоодод зохион байгуулсан сургалтын явцад 20-30 төрлийн сургалтын материал боловсруулсан² бөгөөд эдгээр сургалтын үед хэрэглэсэн илтгэл, лекцээр бэлтгэсэн 4-5 номыг сургалтын төвд сургалтын материал болгон хэрэглэж байна. Түүнчлэн сургалтын бэлэн материалаас гадна сургалт болон ажлын хэрэгцээнд зориулсан ном, тайлбар толь, гарын авлагыг төслийн хүрээнд Монгол хэлээр орчуулж, хэвлүүлэн сургалтын төв болон төслийн сургалтад хамрагдсан 40 байцаагчид тараасан. Эдгээр материалуудыг ашиглан сургалтын төв 2017 онд олон улсын татварын чиглэлээр зохион байгуулах анхан, дунд болон ахисан түвшний сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулжээ (Хавсралт А1.4).

Сургалтын төвд сургалтын материал, ном, гарын авлага хүрэлцэхүйц байдаг боловч бусад татварын албад, хэлтэс, газрууд, албан хаагчдад олон улсын татвартай холбоотой гарын авлага, материал, ном, тайлбар толь хүрэлцээгүй байна³. Жишээ нь, Сонгинохайрхан дүүргийн хэлтэст энэ талаар гарын авлага, материал огт байдаггүй гэж ярилцлагын үеэр дурдаж байсан⁴.

Ном болон гарын авлагын энэхүү хүрэлцээгүй байдлыг шийдэхийн тулд цахим номын санд эдгээр номнуудыг байршуулах хүсэлтийг сургалтын төвөөс ЖАЙКА-д гаргасан⁵. Түүнчлэн, Монголд олон улсын татвартай холбоотой гарсан кейсүүдээр ном, гарын авлага гаргах саналыг сургалтад хамрагдсан байцаагчид, сургалтын төвийн захирал хэлж байлаа. Монголд тулгарч байгаа бодит кейсүүдийг нэгтгэж, кейс бүрийг шинжилж, тайлбарласан ном, гарын авлага байвал илүү өгөөжтэй байна гэсэн санал олон улсын татварын сургалтад хамрагдсан байцаагчидтай хийсэн уулзалтын үеэр гарсан.

² ЖАЙКА үнэлгээний тайлан

³ Сургалтын төвийн даргатай хийсэн уулзалтын тэмдэглэл

⁴ Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэстэй хийсэн уулзалтын тэмдэглэл

⁵ Сургалтын төвийн даргатай хийсэн уулзалтын тэмдэглэл

Сургалтад хамрагдагсдын талаарх мэдээлэл

Сургалтын төвөөс хийсэн судалгаанаас харахад төсөлд хамрагдсан 42 байцаагч (ахалж явсан 2 хүнийг оролцуулаад)-ийн 12 нь ТЕГ-т, 20 нь ТЕГ-ын харъяа нэгжүүдэд ажиллаж байна. Бусад 10 байцаагчдаас зарим нэг нь гадаадад суралцах болон жирэмсний амралттай зэрэг шалтгаанаар татварын байгууллагад одоо ажиллалаагүй байгаа бол зарим нь татварын албанаас гарч өөр ажил хийж байгаа хүмүүс ч байна (Хавсралт А1.5).

ТЕГ-ын харъяа нэгжүүдэд ажиллаж байгаа 20 байцаагчдын 4 нь олон улсын татвартай холбоотой нэгжид ажиллаж байгаа. Тодруулбал, Улсын төсвийн орлого, хяналтын газрын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтэст 2 хүн, хяналт шалгалтын хэлтэст 1 хүн, хуулийн хэлтэст 1 хүн тус тус ажиллаж байна. Бусад 16 нь дүүрэг болон орон нутгийн татварын хэлтэст ажилладаг. Орон нутагт 5 байцаагч ажиллаж байгаагаас 1 хүн Орхон аймагт, 1 хүн Дархан-Уул аймагт, 1 хүн Өмнөговь аймагт, 2 хүн Төв аймагт тус тус ажиллаж байна.

Дүүрэг болон орон нутагт хяналт шалгалтын байцаагчийн албан тушаал дээр ажиллаж байгаа байцаагчдад олон улсын татвар ногдуулалтын мэдлэг, мэдээлэл маш их хэрэгцээтэй байдаг гэж сургалтад хамрагдсан байцаагчид болон бусад газруудтай хийсэн уулзалтууд дээр хэлж байлаа.

Сургалтад хамрагдсан татварын улсын байцаагчдын тоо, дундаж үнэлгээ

ТУХАГ-аас авсан мэдээллээр төслийн хүрээнд Японд хийх эхний сургалтад 22 хүн хамрагдсаны дараа олон улсын татварын чиглэлээр ажиллах албан хаагчдыг нэмж сонгон шалгаруулж, нийт 40 байцаагчдыг хамруулсан. Сонгон шалгаруулалтад тэнцсэн 40 албан хаагчдын дунд 2014 онд 2 удаагийн дотоодын сургалт зохион байгуулж, үүний үр дүнд цаашид мэргэшин ажиллах 20 албан хаагчийг сонгох зорилгоор дээрх албан хаагчдаас олон улсын татварын мэдлэгийн шалгалт авчээ. Шалгалтад нийт 33 албан хаагч хамрагдаж, 7 албан хаагч шалгалтад хамрагдаагүй. Шалгалт өгсөн байцаагчдын гуравны хоёр нь 50 болон түүнээс дээш оноо авсан бөгөөд дундаж оноо 56.8 байсан (Нийт 100 онооны шалгалт). Тус шалгалтын дүн болон ярилцлагын үр дүнг харгалзан Японд болсон хоёр дахь удаагийн сургалтад хамрагдах байцаагчдыг шалгаруулсан байна.

1.2. Сургалтын явцад олж авсан мэдлэгээ ажилдаа хэрхэн ашиглаж буй талаар

Төслийн сургалтад хамрагдсан 40 байцаагчдын 15 байцаагчаас асуулга болон ярилцлагын аргаар судалгаа авав. Судалгаанд оролцогчдын дундаж нас 37 бөгөөд 2 нь эрэгтэй, 13 нь эмэгтэй байна. Эдгээр байцаагчдын гуравны хоёр нь магистр болон түүнээс дээш, гуравны нэг нь бакалаврын боловсролтой бөгөөд татварын байгууллагад хамгийн багадаа 5, хамгийн ихдээ 22 жил ажилласан туршлагатай байна. Харин гуравны хоёр нь одоогийн албан тушаал дээрээ 1 жил болон түүнээс бага хугацаанд ажиллаж байгаа гэж хариулжээ.

Сургалтын агуулга нь байцаагчдын тухайн үеийн ажил болон цаашдын төлөвлөгөөтэй бүрэн нийцэж байсан гэж ихэнх нь (12 хүн), зарим талаар нийцэж байсан гэж 3 хүн хариулсан байна. Судалгаанд оролцсон байцаагчдын ажил дээр олон улсын татвартай холбоотой асуудал нэлээд гардаг бөгөөд эдгээрийн ихэнх нь давхар татварын гэрээтэй холбоотой, зарим нь үнэ шилжилт болон мэдээлэл харилцан солилцох талаарх асуудал байдаг гэжээ. Сургалтаар заалгасан зүйлээ ажилдаа хэр зэрэг ашигладаг талаар асуухад 6 хүн хааяа нэг ашигладаг, 9 хүн нэлээд олон удаа буюу байнга ашигладаг гэж хариулсан байна. Судалгаанд оролцсон ажилтнуудын ихэнх нь (13 хүн) сурсан зүйлээ ашиглан тодорхой асуудлыг шийдэж, хэн нэгэнд зөвлөгөө өгч байжээ.

Олон улсын татвар ногдуулалттай холбоотой асуудал тулгарахад ихэнх нь сургалтын үеэр тараасан материалаа хардаг (10 хүн), сургалтаар олж авсан мэдлэгээ ашигладаг (8 хүн), бусад гарын авлага, ном эсвэл хуулиас хардаг (9 хүн) гэж хариулсан. Сүүлийн гурван жилийн хугацаанд судалгаанд оролцогчид дунджаар 6-7 сургалтад хамрагдсан байна. Одоогийн байдлаар олон улсын татвартай холбоотой сургалтад суух хэрэгцээ их байна гэж 11 хүн хариулсан.

1.3 Хүний нөөц бэлтгэх төлөвлөгөөний талаар

ТЕГ-аас олон улсын татвартай холбоотойгоор хүний нөөцийн талаар баримталж буй бодлого нь ТЕГ-ын даргын 2013.12.13-ны өдрийн 983 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний татварын албаны хүний нөөцийн бодлого”-ын баримт бичиг болон ТЕГ-ын даргын 2017.01.11-ний А/11 тоот тушаалаар батлагдсан “Монголын татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд тодорхойлогддог. Эдгээр баримт бичгүүдэд олон улсын татвартай холбоотой асуудал шууд тусгагдаагүй байна. Гэхдээ 2017 оны хөтөлбөрт сургалтын сэдэв, агуулгыг өргөн хүрээний судалгаа, мэдээлэл, эрэлтэд үндэслэн боловсруулна гэж 4.1.2.8-д заажээ. 2017 онд сургалтын төвөөс авсан эрэлтийн судалгаагаар олон улсын татвартай холбоотой сургалт хамгийн их эрэлттэй байсан.

ТЕГ-ийн ТЗУГ-аас авсан санал, асуулгад өнөөгийн байдлаар олон улсын татвараар мэргэшсэн боловсон хүчин, хүний нөөц хангалттай биш байгааг дурдсан. Тухайлбал, одоогоор олон улсын татвараар мэргэшсэн боловсон хүчин нийт байцаагчдын 10 хувьд ч хүрэхгүй байна. Түүнээс гадна олон улсын татвараар мэргэшсэн боловсон хүчин нь ажлын байраа өөрчилж хувийн байгууллагад шилжин ажиллах, мөн татварын алба, хэлтэс, тасагт сэлгэн өөр албан тушаалд шилжин ажиллах зэргээр хөдөлгөөн гардаг нь хүний нөөцийн асуудлыг хүндрүүлж байна гэж ТЗУГ үздэг ажээ.

Олон улсын татвараар мэргэшсэн байцаагчид хүрэлцээгүй байгаа, цаашид байцаагчдаа сургах хэрэгцээ маш их байна гэж уулзсан бүх газар, хэлтэс, нэгжүүд санал гаргаж байсан. Тухайлбал, сургалтын төвд сургагч багшийн орон тоон дээр ажиллаж байгаа хүмүүс хүрэлцээтэй гэж хэлэхэд хүндрэлтэй байна гэж хариулсан. Жишээ нь нэг багш нь хөдөө явсан байхад төвдөө олон улсын татвараар хичээл заах багш байхгүй болчихдог. Мөн сургалтын төвд орчуулга хийдэг багш маш их хэрэгцээтэй байдаг, учир нь гарын авлага, ном хүрэлцээтэй байгаа боловч, шинээр гарч ирж байгаа

асуудлуудыг мэдэж авах, гэрээ хэлэлцээр дээр гарч байгаа өөрчлөлтүүд болон энэ талаарх олон улсын сүүлийн үеийн хандлага, чиглэлийг хардаг байх хэрэгцээ их байдаг. УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтэст одоогийн байдлаар олон улсын татвараар мэргэшсэн 2 байцаагч ажиллаж байгаа бөгөөд цаашид байцаагчдын тоог 4 болгож нэмэгдүүлэх ажлын хэрэгцээ байгаагаа шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан⁶. Түүнчлэн дүүргүүдэд байцаагчдаа олон улсын татварын чиглэлээр сургах ажлын хэрэгцээ, шаардлага их байдаг, мөн олон улсын татвартай холбоотой гарын авлага, материал огт байдаггүй байна⁷.

Олон улсын татвараар мэргэшсэн байцаагчид болон сургалтын төвтэй хийсэн уулзалтын үед олон улсын татвараар мэргэшсэн нэг багтай байх хэрэгтэй байна гэсэн санал хэлсэн. Олон улсын татвартай холбоотой асуудал гарч ирэхэд багаараа ярилцаад шийдвэр гаргадаг байвал энэ шийдвэртэй илүү итгэлтэй байх болно. Ганц, нэг хүн ажиллалахаар өөрийнхөө үйлдэлд эргэлзэх хандлагатай байдаг, учир нь акт төлбөр тооцоо тавьж байгаа үед нөгөө талаас, тухайлбал татвар төлөгч этгээдээс эсэргүүцэх, хүлээж авахгүй байдал гарна. Энэ тохиолдолд нэг хүний хүч дутагдаж байгаа тал ажиглагддаг байна⁸. Мөн байцаагч нар дээр гарч ирж байгаа кейсүүдээр хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцдэг байвал сургалтын хувьд болон гарч байгаа шийдвэрийн хувьд илүү үр дүнтэй байна⁹. Олон улсын татвараар мэргэшсэн байцаагч нараас 4-5 хүнтэй баг гарган олон улсын татварын асуудал Монгол улсад яаж хөгжиж байгаа талаар судалгааны ажлууд хийлгэх, эсвэл олон улсын татвартай холбоотой гарч байгаа кейсүүдийг судалж шинжлэн, тайлбар өгөх буюу хэрхэн шийдвэрлэх вэ? гэдэг дээр санал дэвшүүлэх ажил хийхээр сургалтын төвөөс төлөвлөж байна.

1.4 Сургалттай холбоотой төсөв

2017 онд ТЕГ-аас сургалт болон сургалтын үйл ажиллагааны зардалд 175 сая төгрөг төсөвлөсөн¹⁰. Үүнээс багахан хэсэг нь олон улсын татварын сургалтад төсөвлөгддөг.

Япон болон дотоод дахь сургалтуудад хамрагдсан олон улсын татвар хариуцсан ажилтнуудын хамт сургалтын төвийн 3 багшийг сургагч багшаар бэлдсэн. Тус сургагч багш нар тодорхой хугацаанд багшаар ажилласан боловч одоогийн байдлаар татварын албанд өөр ажил хийж байна. Гэхдээ сургалтын төвийн одоогийн захирал болон олон улсын татвар хариуцсан нэг сургагч багш нь төслийн сургалтад хамрагдсан тул олон улсын татварын сэдвээр хичээл заах боломжтой¹¹. Тодруулбал, хүний нөөцийн хувьд дутагдалтай байгаа боловч одоо байгаа нөөцийнхөө хүрээнд татварын нийт байцаагчиддаа үе шаттайгаар сургалт явуулах боломжтой гэж сургалтын төв үзэж байна.

⁶ УТОХГ-ын ЭБОУТХ-ийн танилцуулга, 2017 оны 1 сарын 9

⁷ Чингэлтэй болон Сонгинохайрхан дүүргүүдийн татварын салбартай хийсэн уулзалтын тэмдэглэл

⁸ Олон улсын татварын сургалтад хамрагдсан байцаагч нартай хийсэн уулзалтын тэмдэглэл

⁹ Сургалтын төвийн даргатай хийсэн уулзалтын тэмдэглэл

¹⁰ ТЗУГ-аас ирсэн тоо, мэдээ

¹¹ Сургалтын төвийн захиралтай хийсэн уулзалтын тэмдэглэл

ҮР ДҮН 2. ОЛОН УЛСЫН ТАТВАР НОГДУУЛАЛТЫН СУУРИЙГ ЦААШИД ХӨГЖҮҮЛЭХ

Энэ хэсгийн мэдээллийг бэлтгэхэд Сангийн яамны Татварын орлогын хэлтэс, Татварын ерөнхий газрын Татварын улирдлага, хамтын ажиллагааны газар (ТУХАГ), Улсын төсвийн орлого, хяналтын газрын (УТОХГ) Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтэс (ЭБОУТ), Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй хийсэн уулзалтын тэмдэглэлүүд, ТЕГ-ын олон улсын татвартай холбоотой мэдээлэл бүхий цахим хуудас, УТОХГ гаргасан олон улсын татварын орлогын судалгаа, Сангийн Яамны судалгааны мэдээлэл, татварын холбогдох хуулиуд болон ТЕГ-с өгсөн холбогдох бусад мэдээллийг ашиглалаа.

6 чиглэлээр асуудлыг авч үзэв.

2.1 ТЕГ-ын газрын олон улсын татвар ногдуулалт, олон улсын татвартай холбоотой татварын хяналт шалгалтын талаар хэрэгжүүлж байгаа ажлын өнөөгийн байдал, бүтэц бүрэлдэхүүн, тогтолцоо, олон улсын татвар ногдуулалтын менежментийн байдлын талаар

ТЕГ-ын олон улсын татвар ногдуулалт, олон улсын татвартай холбоотой татварын хяналт шалгалтын талаар хэрэгжүүлж байгаа ажлын өнөөгийн байдал

ТЕГ-ын ТУХАГ, ЭБОУТ-ын хэлтэс, Сангийн Яам болон зарим дүүргүүдийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр олон улсын татварын (ОУТ) асуудал шинэ зүйл бөгөөд хэрэгжих хууль эрх зүйн болон техникийн боломж нь бүрдээгүй байгааг тэмдэглэн хэлж байлаа.

Харин ТЕГ-ын холбогдох хүмүүсийн хувьд ОУТ-ын асуудал шинэ, эхлэлийн шатандаа байгааг хэлсэн. Холбогдох хүмүүс ОУТ-ын талаар боломжийн ойлголттой болсон бөгөөд мэдлэг, туршлагаа улам гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Эхний ээлжинд судалгааны ажлууд хийсэн, шаардлагатай журмуудаа боловсруулаад эхэлсэн байгаа. ТУХАГ болон ЭБОУТ-ын хэлтсүүд одоогоор олон улсын татварын асуудлаар судалгааны ажлуудыг илүү түлхүү хийж байна. Тухайлбал, ЭБОУТ-ын хэлтэс ТУХАГ-с өгсөн ОУТ-ын чиглэлээр хийх шаардлагатай судалгааны ажлуудын хүрээнд ААН-ийн суурь судалгаа, ОУТ-ын чиглэлээр олон улсын практик ямар явж байгаа талаарх судалгаануудыг хийгээд байна¹².

ТУХАГ-ын хувьд төслийн зөвлөхүүдтэй зөвшилцөөд “Үнэ шилжилтийн журам”, “ОУТ-ын хяналт шалгалтын журам”, “Мэдээлэл харицан солилцох журам”-уудыг боловсруулсан. Мөн эдгээр журмуудтай холбоотой суурь зарчмуудыг ТЕХ, ААНБОАТХ, ХХОАТХ-иудад өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулаад байна. Мөн түүнчлэн ОУТ-тай холбоотой нэр томъёонуудаа тодорхойлсон байгаа

¹² ЭБОУТ-ын хэлтэстэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

бөгөөд өөр бусад шаардлагатай ойлголтуудаа төслийн хүрээнд гаргасан ном, гарын авлагаас авдаг байна¹³.

Сангийн Яамны хувьд ОУТ-тай холбоотой хууль эрх зүйн орчин хангалтгүй байгаа бөгөөд нэн ялангуяа, дотоодын хуулиа сайжруулах шаардлагатайг хэлсэн. Тэгж байж авах ёстой татвараа авах нөхцөл байдал бүрдэнэ. Тиймээс ТЕГ болон Сангийн Яам хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, өргөн барьжээ. Хуулийн хүрээнд одоогийн түвшинд боломжийн хэмжээнд хийгээд хуулийн төсөл бэлдсэн¹⁴.

Хэрэгжилт дээр гарч байгаа хүндрэлийг бодлогоор засах шаардлагатайг яамны зүгээс тэмдэглэн хэлсэн. Үүний тулд байгаа нөхцөл байдалдаа сайн судалгаа хийх шаардлагатай байна. Тухайлбал, манай хуулинд харилцан хамаарлын зүйл заалтууд, давхар татварын гэрээний заалтууд байна. Гэхдээ энд ямар цоорхой байгааг судалж тогтоох шаардлагатай байна. Яамны хувьд ТЕГ-тай татвар дээр гарч байгаа кейсүүдээ авчраад хамтдаа суугаад хуулиа боловсруулах ажил дээр хамтран ажилладаг. Татварын байцаагчид, хяналт шалгалтын байцаагчдад тохиолдож байгаа кейсүүдийг хуулинд хамруулах нь чухал. Гэхдээ 1800 гаруй байцаагчдын кейс бүрэн хамруулах боломжгүй, энэ тал дээр ТЕГ дээр процесс нь байх ёстой гэж үзэж байна¹⁵.

Дүүргүүдийн албадууд болон ТЕГ-ын зохих газруудтай уулзсан ярилцлагаас харахад дүүргүүд дээр ОУТ-тай холбоотой шийдэх асуудал гарахад ТХШУАЗГ-таа хандаж зөвлөгөө аваад явдаг байна¹⁶. Гэхдээ уг нэгжид одоогоор ОУТ-аар мэргэшсэн албан хаагч байхгүй бөгөөд албан хаагчдын чиг үүрэгт тодорхой зааж өгөөгүй байгаа¹⁷.

ТЕГ-ын ТУХАГ болон ЭБОУТ-ын хэлтсийн ОУТ хариуцсан ажилтнууд уулзалтын үеэр олон улсын татвартай холбоотой мэдээлэл гаргаж авах ажлыг автоматжуулах, баазаас мэдээллийг гаргуулдаг болох ажлыг хийх шаардлагатай байна. Мөн үндэстэн дамнасан корпорациудын мэдээллийг гаргадаг тусгай програмтай болох шаардлагатай байгаагаа илэрхийлсэн.

Бүтэц бүрэлдэхүүн, тогтолцоо, олон улсын татвар ногдуулалтын менежментийн өнөөгийн байдал

Төслийн хүрээнд ТЕГ-ын олон улсын татвар (ОУТ) ногдуулалтын талаарх ойлголт гүнзгийрч ТУХАГ-ийн үндсэн 3 чиг үүргийн нэг нь олон улсын татвар ногдуулалтын бодлогын асуудал байхаар болжээ. ОУТ хариуцсан улсын байцаагч 4-ийг энэ газарт ажиллуулж байна. Эдгээр байцаагчид нь үнэ шилжилттэй холбоотой асуудал, ОУТ-ын судалгаатай холбоотой асуудал, BEPS-ын үйл ажиллагаа, олон улсын түвшинд ОУТ-ын асуудал ямар байгааг судлах болон давхар татварын гэрээ, мэдээлэл харилцан солилцооны асуудал гэсэн чиглэлийг хариуцан ажиллаж байгаа юм байна.

¹³ ТУХАГ-тай хийсэн уулзалтын тэмдэглэл.

¹⁴ Сангийн яамтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

¹⁵ Сангийн яамтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

¹⁶ Чингэлтэй болон Сонгинохайрхан дүүргийн уулзалтын тэмдэглэл.

¹⁷ ЭБОУТ-ын хэлтэстэй уулзалтын тэмдэглэл.

2016 оны 10 сард Улсын төсвийн орлогын хяналтын газарт эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийг шинээр байгуулан 2 байцаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. ТЕГ-ын даргын баталсан Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн 20 орчим чиг үүргээс 7 нь ОУТ-тай холбоотой чиг үүрэг байдаг.

ТЕГ-ын хэмжээнд ОУТ-тай холбоотой асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтонд тодорхой нарийн заагаагүй байна. ТХШУАЗГ болон хууль эрх зүйн газарт олон улсын татварын чиглэлийг хариуцсан хүн одоогоор байхгүй байна.

2.2 Олон улсын татвар ногдуулалттай холбоотой хууль эрх зүйн орчны нөхцөл байдал, өргөн мэдүүлсэн хуулийн багц өөрчлөлтөд тусгагдсан байдлын талаар

ТУХАГ-ын зүгээс “Бодит үнийн журам”, “Хяналт шалгалтын журам”, “Мэдээлэл харилцан солилцох журам”-уудыг боловсруулсан. “Бодит үнийн журам”-ыг 2015 оны 12 сард Сангийн Яам баталсан байна. Гэвч эдгээр журмуудыг ашиглахтай холбоотой суурь зарчмууд нь ТЕХ, ААНБОАТХ, ХХОАТХ гэсэн гол гол хуулиудад бүрэн тусгагдаагүй учраас ашиглахад асуудалтай. Тухайлбал, “Бодит үнийн журмын” хувьд хуулиараа Сангийн Яам батална гэсэн байдаг тул батлуулахад асуудалгүй боловч зарим нэр томьёо нь хуулинд заагдаагүй байдаг. Жишээлбэл, харилцан тохиролцох үйл ажиллагаа, харьцуулалтын шинжилгээ гэх мэт олон улсын жишигт нийцсэн нэр томьёо нь хуулинд байдаггүй учраас хууль зүй, дотоод хэргийн яам хуулиндаа нийцүүлэх хэрэгтэй гэдэг шалтгаанаар нийтээр дагаж мөрдөх журам болгож бүртгээгүй байна. Журмыг нийтээр дагаж мөрдөх журам болгож бүртгэхгүй тохиолдолд татвар төлөгчид уг журмуудыг дагаж мөрдөхгүй байх үндэстэй¹⁸.

Дээрх асуудалтай холбоотойгоор ТУХАГ болон Сангийн яамны зүгээс ТЕХ, ААНБОАТХ, ХХОАТХ-иудад ОУТ-тай холбоотой журмуудыг дагаж мөрдөхөд шаардлагатай байгаа зарчмуудыг тусгахаар боловсруулсан төслийг өргөн барьсан. Тухайлбал, ААНБОАТХ-ийн 4 дүгээр зүйл буюу хуулийн нэр томьёоны хэсэгт ОУТ-тай холбоотой нэр томьёонуудыг оруулж өгсөн. Уг хууль нь 2006 оны 6 сард шинэчлэн найруулагдсан байна. Хуучин хувилбарт байгаагүй нэг чухал ойлголт гэхэд “Монгол Улсад олсон орлого”, “Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого” гэсэн хоёр ангилал нэмсэн байхаар тусгасан байна. Түүнчлэн, сүүлийн хэсэгт хамаарах орлогыг 10 төрөл болгон ангилж оруулсан. Мөн хуучин хуулинд харилцан хамаарал бүхий этгээд гэдгийг дэлгэрэнгүй тодорхойлоогүй байсан бол шинэ боловсруулсан төсөл ёсоор үүнийг дэлгэрэнгүй байхаар заасан. Мөн үүнтэй холбоотойгоор харьцуулагдах байдлын шинжилгээ хэмээх ойлголтыг төсөлд тусгасан. Төлөөний газартай холбоотойгоор боловсруулсан төсөлд төлөөний газрын тухай тусад нь нэг хуулийн зүйл болгон тодруулж оруулсан байгаа.

¹⁸ Сангийн яам болон ТУХАГ-тай хийсэн уулзалтын тэмдэглэл.

ТЕХ-ийн одоо мөрдөгдөж буй хувилбар нь 2008 оны 5 сард батлагдсан. ТЕХ-ийн төсөлд хуулийн нэр томъёо хэсгийг нэлээд дэлгэрэнгүй байхаар тусгасан байна. Тухайлбал, шинэ төслөөр бол хуучин хуулинд байгаагүй ОУТ-тай холбоотой “бодит үнэ”, “бодит үнэ тодорхойлох зарчим”, “харилцан хамаарал бүхий этгээд”, “харьцуулалтын тохируулга хийх” гэх мэт нэр томъёог тодорхой байхаар оруулсан. ОУВС-тай хөтөлбөр тохирсон тохиолдолд 2017 оны 10 сар гэхэд татварын шинэчлэлт хийхээр төлөвлөж байна¹⁹.

2.3 Олон улсын татвараас зайлсхийх, давхар татвар ногдуулалтаас сэргийлэх, үнэ шилжилт, гадаадын татварыг хасалт хийх, төлөөний газрын талаарх өнөөгийн нөхцөл байдал, авч буй арга хэмжээний талаар

Үнэ шилжилттэй холбоотой асуудал нэлээд тулгамдсан асуудал болоод байгааг ТУХАГ-ын уулзалтын үеэр тэмдэглэн хэлсэн. Ялангуяа уул, уурхайн компаниудын хувьд засгийн газраас үнийг нь тогтоож өгдөг бөгөөд 2-3 ангилалтай үнүүд байдаг учраас үнэ шилжилттэй холбоотой маргаан их гардаг. Эрхийн шимтгэл, үйлчилгээнд олон улсын жишгээ дагаж үнэ шилжилтийн асуудал хэрэгжихгүй байгаа. Зах зээлийн үнийг харьцуулах замаар, Засгийн Газрын тогтоолоор тогтоодог том том үнүүдийг хянаж чадаж байгаа боловч техник үйлчилгээтэй холбоотой үнүүд яаж яваад байгааг, бусад компаниуд яаж аваад байгааг харьцуулж чадахгүй байна. Үүний гол шалтгаан нь холбогдох хуулинд нэр томъёог нарийвчлан заагаагүйгээс холбогдох журмуудыг мөрдөхөд хүндрэл гарч байна. ОУТ-ын тогтолцооны хувьд гол суурь нь хуулиндаа тусгагдах хэрэгтэй байна²⁰. Үнэ шилжилттэй холбоотой техникийн туслалцааг ОУВС, Канадын Уул уурхайн салбар дахь чадавхийг сайжруулах 8 сая долларын өртөгтэй төслөөс авч байгаа²¹. Үнэ шилжилт дээр дан ганц хуулийг шийдэх нь хангалтгүй, мэдээллийн сангийн асуудал байгаа. Манайд ямар үед мэдээллийн санг яаж бүрдүүлэх, яаж шинэчлэх, хэн санхүүжүүлэх, хэн хандалт хийх эрхтэй байх вэ? зэрэг асуудал байна²².

Сангийн яамны уулзалтын үеэр төлөөний газрын хувьд шийдэх ёстой асуудлын нэг, шинэчлэлийн гол цөм нь гэдгийг тэмдэглэн хэлсэн. Тухайлбал, төлөөний газрын асуудал нь хэт урт хугацааг гэрээгээр олгоод байгаа, тэгэхээр богино хугацаанд үйл ажиллагаа явуулаад МУ-д татвар төлөхгүй гараад явчхаад байгаа. Орлого нь МУ-д бүртгэгдэхгүй байгаа. Тэгэхээр гэрээг шинэчлэхгүйгээр энэ асуудлыг шийдэж чадахгүй. Түүнчлэн, том төслүүдтэй татварын харилцаа үүсгээд эхлэхээр манай татварын хуулийн хийдлийг ашиглаад маш бага татвар төлөөд явж байна. Гол орлого олдог уул уурхайн компаниуд нэг ордын ашгаа нөгөө орд руугаа шилжүүлэх замаар татварын сууриа бууруулах зэрэг аргууд хэрэглэдэг²³.

¹⁹ Сангийн яамны уулзалтын тэмдэглэл.

²⁰ ТУХАГ-тай хийсэн уулзалтын тэмдэглэл.

²¹ Сангийн яамны уулзалтын тэмдэглэл.

²² Сангийн яамны уулзалтын тэмдэглэл.

²³ Сангийн яамны уулзалтын тэмдэглэл.

Одоогоор улсын хэмжээнд нийт бүртгэгдсэн төлөөний 11 газар байна. Төлөөний газрыг дүүргийн татварын алба бүртгэн авч хариуцан ажилладаг. Одоогоор давхар татварын гэрээтэй улсуудын төлөөний газрыг бүртгээд, гэрээгүй улсын давхар татварын газрыг бүртгэхгүй гэсэн зарчим ТЕГ баримталж байна²⁴.

Төлөөний газартай холбоотой асуудал ТЕГ дээр судалгааны түвшинд байна. ОУТ хариуцсан хэлтэст ТУХАГ-аас төлөөний газрыг хэрхэн татварт хамруулах вэ, ашгийг нь хэрхэн тодорхойлдог талаар олон улсын туршлагыг судлах үүрэг аваад ажиллаж байгаа. Төлөөний газрын бүртгэлийг зөвхөн дүүргийн татварын албанд бүртгэж байна. Хуулинд нь зааж өгөөгүй учраас улсын бүртгэлийн газар бүртгэдэггүй. Зөвхөн татвартай холбоотойгоор л энэ ойлголт гардаг учраас татварын албад л бүртгэж байна²⁵.

Дүүргүүдийн хувьд төлөөний газартай холбоотой гардаг бэрхшээлтэй асуудал нь нэгдүгээрт төлөөний газрын ойлголт нэгдсэн болоогүй, хоёрдугаарт төлөөний газрын бүртгэлийн мэдээллийг авахад төвөгтэй байдал үүсдэгт байна. Мэдээллийн системийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа тухайг дүүргийн уулзалтын үеэр ажилтнууд хэлж байсан. Тухайлбал, ЧД-ийн хувьд бүртгэлтэй төлөөний газар байгаа ч татварын асуудлаар холбоо барих боломжгүй, бүртгэлээс хасагдсан, эсвэл бүртгэлдээ байгааг тодруулахад төвөг учирдаг талаар хэлж байлаа.

Хүснэгт 2.1 Төлөөний газрын бүртгэл

Бүртгүүлсэн аймаг/дүүрэг	Тоо	Татвар төлөгчийн төрөл	Бүртгүүлсэн огноо
Баян-Өлгий	1	Байгууллага	2013
Баянзүрх дүүрэг	2	Байгууллага	2014-2015
Сүхбаатар дүүрэг	2	Байгууллага	2016
Хан-уул	1	Байгууллага	2016
Чингэлтэй	4	Байгууллага	2014-2016
Нийт	10		

Эх үүсвэр: ТУХАГ-с ирсэн төлөөний газрын бүртгэлийн мэдээлэл

Улсын төсвийн орлого хяналтын газар /УТОХГ/-т бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээс гадаад улсад шилжүүлсэн мөнгөн гүйлгээнд болон ногдуулсан суутган татварын талаарх мэдээллийг Хавсралт А2.1-д харууллаа.

2.4 Олон улсын татвар ногдуулалттай холбоотой хүний нөөц, бусад газар хэлтсүүдтэй ажын уялдаа холбоо (Татварын хяналт шалгалт, арга зүйн газар, том татвар төлөгч хариуцсан газрын болон болон хууль эрх зүйн гэх мэт газрууд Сангийн яамтай хэрхэн уялдаж ажиллах бүтэц)-ны талаар

Сангийн сайдын тушаалаар баталсан ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт олон

²⁴ ТУХАГ-тай хийсэн уулзалтын тэмдэглэл.

²⁵ ЭБОУТ-ын хэлтэстэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

улсын татвар ногдуулалтын асуудлыг бодлогын түвшинд ямар байх талаар тусгасан байна. ТЕГ-ын үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд тусгаснаар ТЕГ нь: *Татварын хууль тогтоомжийн хэрэгжилт болон олон улсын татварын асуудлаар судалгаа хийж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, холбогдох шинэчлэл хийх чиглэлээр санал боловсруулж, шийдвэр гаргах түвшний байгууллагуудтай хамтарч ажиллах (хөтөлбөрийн 2.5.1.1)* гэж заасан байна.

ТЕГ нь нийт 9 газар, хэлтэстэй байхаар батлагдсанаас ТУХАГ дээр олон улсын татварын бодлогын асуудлаар ажиллах чиг үүргийг нэлээд нарийвчилсан байдалтай зааж өгсөн байгаа. Үүнд Сангийн Яам, олон улсын татварын байгууллагууд болон бусад холбогдох дотоодын болон гадаадын байгууллагуудтай хэрхэн уялдаатай ажиллах талаар заасан байна (ТУХАГ-ын үндсэн чиг үүргийн 3.3.3.4 хэсэг, 3.3.3.7 хэсэг, 3.3.3.9 хэсэг, 3.3.3.11 хэсэг, 3.3.3.12 хэсэг). Олон улсын татварын асуудалд бодлогын чиглэлд Сангийн яамтай хамтран ажиллах гол газар нь ТЕГ-аас ТУХАГ байхаар заажээ.

Олон улсын татварын үйл ажиллагаа хэрэгжүүлэх үндсэн үүрэг нь одоогоор ганцхан Улсын төсвийн орлого, хяналтын асуудал хариуцсан нэгжид байна. Хөтөлбөрийн 3.4.4.9 дүгээрт олон улсын татвартай холбоотой аливаа асуудлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд уг нэгж нь ТУХАГ-с чиглэл аван ажиллалахаар заажээ.

ТУХАГ-ийн үндсэн 3 чиг үүргийн нэг нь олон улсын татвар ногдуулалтын бодлогын асуудал байхаар болжээ. ТУХАГ-т ОУТ хариуцсан 4 улсын байцаагч энэ чиглэлээр ажил үүргийн хуваарьтай ажиллаж байна. Эдгээр нь ОУТ ногдуулалтын асуудал хариуцан ажиллаж байгаагаас үнэ шилжилттэй холбоотой асуудал хариуцсан нэг байцаагч, ОУТ-ын судалгаатай холбоотой асуудал хариуцсан нэг байцаагч, BEPS-ын үйл ажиллагаа, олон улсын түвшинд ОУТ-ын асуудал ямар байгааг судлах асуудал хариуцсан нэг байцаагч, давхар татварын гэрээ, мэдээлэл харилцан солилцоо хариуцсан нэг ажилтан байна²⁶.

Шинээр байгуулагдсан ЭБОУТ-ын хэлтсийн үндсэн чиг үүрэг нь ОУТ-тай холбоотой судалгаа хийх болон ОУТ-тай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг (давхар татварын гэрээ, хөрөнгө оруулалтын гэх мэт олон улсын хэмжээнд байдаг гэрээний хэрэгжилт гэх мэт) улсын төсвийн орлогын хяналтын газарт хангах гэсэн 2 үндсэн чиг үүрэгтэй.

Сангийн Яаман дээр ОУТ хариуцсан 1 ажилтан, 1 зөвлөх ажилладаг. Сангийн Яам, ЭБОУТ-ын хэлтсийн хувьд ОУТ хариуцсан боловсон хүчин дутагдалтай бөгөөд дүүргүүдийн татварын албадад огт байхгүй байна. Мөн түүнчлэн, боловсон хүчний хувьд ТХШУАЗГ болон хяналт шалгалтын газар, дүүргүүдийн хяналт шалгалтын газруудад ОУТ-ын чиглэлийн байцаагч байх шаардлагатай байгааг уламжилсан. Мөн

²⁶ ТУХАГ-тай хийсэн уулзалтын тэмдэглэл.

дүүргүүдийн татварын албадын хувьд мэдээллийн системийн асуудлыг шийдэх шаардлагатай байгааг хэлж байлаа.

ТЕГ-ын хэмжээнд ОУТ-тай холбоотой асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын чиг үүрэгт нь тодорхой нарийн заагаагүй байна²⁷. Нэн ялангуяа, ТХШУАЗГ, хууль эрх зүйн газарт энэ чиглэлээр одоогоор хүнгүй байна. Энэ байдал нь асуудлыг хэрэгжүүлэхэд төвөгтэй байдал үүсгэж байна²⁸.

2.5 OECD/G20 –оос гаргасан BEPS-ийн саналуудыг дотоодын тогтолцоо, татварын гэрээ байгуулахад хэрхэн тусгахаар төлөвлөж байгаа талаар

BEPS-ын саналуудыг одоогоор дотоодын тогтолцоо, татварын гэрээ байгуулахад хэрхэн тусгах төлөвлөгөө хараахан гараагүй байна. Харин ТЕГ-ын зохих албан хаагчдад BEPS-ын үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулах ажлыг зохион байгуулсан.

2.6 Давхар татвар ногдуулалтаас сэргийлэх хоёр талт ба олон талт гэрээний өнөөгийн байдлын талаар

Одоогоор Монгол Улс 25 улстай давхар татварын хүчин төгөлдөр гэрээтэй. Эдгээр нь 1993 оноос 2005 оны хооронд хүчин төгөлдөр болсон гэрээнүүд байна. Сангийн Яам болон ТУХАГ-ын уузгалтын үеэр давхар татварын гэрээнүүдийг шинэчлэх шаардлагатай байгааг тэмдэглэж байсан.

Өмнө нь 29 улстай гэрээтэй байсан бөгөөд Кувейт, Люксембургийн Вант Улс, Арабын Нэгдсэн Эмират Улс болон Нидерландын Вант улсуудтай байгуулсан давхар татварын гэрээнүүдийг 2014-2015 онд хүчингүй болгосон байна²⁹. 2012 онд Сангийн Яамнаас Монгол Улсын давхар татварын гэрээнүүдэд харьцуулсан судалгаа хийж, эдгээр улсуудтай хийсэн гэрээнүүд нь манай улсын хувьд ашиггүй гэж үзэн эдгээр улсуудтай хийсэн гэрээнд өөрчлөлт оруулах санал тавьсан боловч харилцан тохироонд хүрээгүй ажээ³⁰. Годруулбал, гэрээний нөхцөл ёсоор Монголын талд 0 хувь, нөгөө талд 100 татвар төлөхөөр нөхцөлтэй байсан. Яамны зүгээс өөрчлөх санал явуулаад, гэрээнд заасан хугацаанд хариу өгөөгүй тул нэг талын санаачилгаар хүчингүй болгожээ³¹.

ТЕГ-аас Монгол улсад ашиггүй давхар татварын гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлтийг Сангийн яаманд 2 удаа явуулсан гэдгээ хэлсэн³². Яамны хувьд дахиад 10-аад гэрээг шинэчлэх шаардлага байгаа бөгөөд 2 улсын дипломат харилцаа бас үүний цаана байгаа учраас ЗГ болон холбогдох удирдлагууддаа танилцуулж байж шийднэ гэсэн хариу өгч байжээ. Одоогоор ГЯЯ-д эдгээр улсуудаас алинд нь хандвал зохимжтой талаар саналаа өгөөч гэсэн хүсэлт явуулсан байна³³.

²⁷ ЭБОУТ-ын хэлтэстэй уулзалтын тэмдэглэл.

²⁸ ЭБОУТ-ын хэлтэстэй уулзалтын тэмдэглэл.

²⁹ ТЕГ-ын сайт: <http://www.mta.mn/c/view/11957>

³⁰ Сангийн яамны хийсэн судалгаа: <http://www.iltod.gov.mn/?p=2712>

³¹ Сангийн яамтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

³² ТУХАГ-тай хийсэн уулзалтын тэмдэглэл.

³³ Сангийн яамтай хийсэн уулзалтын тэмдэглэл.

ҮР ДҮН 3. ТАТВАР ХУРААЛТЫН СУУРИЙГ БЭХЖҮҮЛЭХ

4 хэсэгт хуваан бичлээ.

3.1 Татвар хураалтын тогтолцоо, татварын өр барагдуулалтын талаар авч буй арга хэмжээний талаар


Татварын орлогын газар нь улсын болон орон нутгийн төсвийн татварын орлогыг бүрдүүлэх, Улсын Их Хурал болон Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах үндсэн чиг үүрэгтэй.

Татварын тайлангаар болон татварын хяналт шалгалтаар ногдсон төлбөрийг хураан барагдуулах ажлыг зохион байгуулдаг. Хуулиар улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын нэр төрлийг ялгаатай тогтоосон байдаг. Харьяа татварын 31 албанд татварын орлогын асуудал хариуцсан нэгжтэй.

Мөн татварын орлогын бүртгэлийн асуудлыг хариуцаж, хариуцсан чиг үүргийн хүрээнд харъяа татварын албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажилладаг. Татварын орлогын газар нь 9 татварын улсын байцаагчтай бол улсын хэмжээнд нийт 1000 гаруй татварын улсын байцаагч ажиллаж байна. Хугацаандаа төлөөгүй татварын өрийг хураахдаа Татварын ерөнхий хуулийн 8-р бүлэгт заасан арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.³⁴

Цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайлан ирүүлэх татвар төлөгч байгууллагын тоо сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2013 онд 35899 байсан бол 2016 онд 42867 болж 19.4 хувиар өссөн байна. Ялангуяа, 1-ээс 9 ажилтантай жижиг татвар төлөгчийн тоо илүү хурдацтай өсөх хандлагатай байгаа бөгөөд сүүлийн 3 жилд 28.8%, 2016 онд өмнөх оноос 6.0 хувиар өссөн. Эдгээр жижиг татвар төлөгчид тооны хувьд олон ч татвар төлөлтийн дүнд эзлэх хувь нь 2016 онд 4.8% байна.

Зураг 3.1 Татвар төлөгч байгууллагын тоо, байршлаар



Эх үүсвэр: ТЕГ, Мэдээлэл технологи, статистикийн төв

³⁴ ТЕГ-ын Татварын орлогын газрын даргатай хийсэн уулзалтын тэмдэглэл

Харин 50-иас дээш ажилтантай байгууллагын тоо 3508 байгаа нь харьцангуй цөөн бөгөөд нийт татвар төлөгчийн 8.1 хувийг эзэлж байна. Татвар төлөлтийн хувьд эдгээр том байгууллагууд татварын дийлэнх хэсгийг төлдөг. Тухайлбал, 2015 онд 86.6%, 2016 онд 84% тус тус эзэлж байна.

Хүснэгт 3.1 Татвар төлөгч байгууллагын тоо

	2013	2014	2015	2016
1.5 татвар төлөгч байгууллагын тоо, тоогоор				
1-9 ажилтантай	21 568	25 353	26 203	27 773
10-19 ажилтантай	4 484	5 017	4 868	5 014
20-49 ажилтантай	4 245	4 589	4 469	4 556
50-аас дээш ажилтантай	3 589	3 697	3 416	3 508
1.6 татвар төлөгч байгууллагын дундаж орлого, сая төг.				
1-9 ажилтантай	147.4	140.0	133.2	124.2
10-19 ажилтантай	584.3	558.1	529.9	518.5
20-49 ажилтантай	1 048.3	1 294.4	1 089.7	1 106.2
50-аас дээш ажилтантай	4 012.2	4 544.2	4 303.3	4 361.4
1.7 татвар төлөгч байгууллагын дундаж зарлага, сая төг.				
1-9 ажилтантай	152.1	145.5	141.6	144.7
10-19 ажилтантай	584.3	566.1	550.5	534.5
20-49 ажилтантай	1 057.7	1 327.1	1 132.2	1 183.0
50-аас дээш ажилтантай	4 374.5	4 652.4	4 391.1	4 332.9
1.8 татвар төлөгч байгууллагын татвар төлөлт, сая төг.				
1-9 ажилтантай	94.5	106.0	90.6	105.0
10-19 ажилтантай	78.3	83.0	77.6	84.2
20-49 ажилтантай	128.0	175.0	178.0	157.0
50-аас дээш ажилтантай	2 180.0	2 260.0	2 230.0	1 820.0

Эх үүсвэр: ТЕГ, Мэдээлэл технологи, статистикийн төв

Сүүлийн жилүүдэд өртэй татвар төлөгчийн тоо болон татварын өрийн үнийн дүн өсөх хандлагатай байна. Хүснэгт 3.2 болон Хүснэгт 3.3-аас үзэхэд 2015 оны эцэст татварын өрийн үлдэгдэл 706.3 тэрбум төгрөг байсан бол 2016 оны эцэст 1033.3 тэрбум төгрөг болж 46.3 хувиар өссөн байна. Түүнчлэн татварын төрлөөр давхардсан тоогоор өртэй татвар төлөгчийн тоо ч мөн нэмэгдэх хандлагатай байна. 2015 онд нийт 286.2 мянган өртэй татвар төлөгч байсан бол 2016 онд 333.1 болж 16 хувиар өсчээ. Хүснэгт 3.2-оос үзэхэд 2015-2016 онд дуудлага худалдаанаас бусад өр барагдуулах процесс ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3.2 Татварын өрийн үлдэгдэл, гүйцэтгэсэн процесс ажиллагаагаар

	Өмнөх оны		Тайлант он		Нийт	
	2015	2016	2015	2016	2015	2016
1 Татварын өрийн дүн, сая	410 586.2	680 551.4	295 689.3	352 748.8	706 275.5	1 033

төг.						300.2
2 Татварын өртэй ТТТоо	87 733	82 654	198 429	250 477	286 162	333 131
3 Татварын өр барагдуулалтын гүйцэтгэл						
3.1 Харилцах дансны зарлагын гүйлгээ хаасан						
Тоо	5 019	3 507	2 950	2 054	7 969	5 561
Өрийн дүн, сая.төг	131 867.3	124 476.2	87 894.4	57 083.7	219 761.7	181 559.9
3.2 Эд хөрөнгөөс						
Тоо	69	30	104	16	173	46
Өрийн дүн, сая төг.	2 010.6	145.6	878.6	14.1	2 889.2	159.6
3.3 Барьцаат гэрээ байгуулсан						
Тоо	77	28	40	6	117	34
Өрийн дүн, сая төг.	4 373.9	2 145.6	1 361.2	134.7	5 735.1	2 280.3
3.4 Дуудлага худалдаа хийсэн						
Тоо	0	0	0	0	0	0
Өрийн дүн, сая төг.	0	0	0	0	0	0
3.5 Мэдэгдэх хуудас хүргүүлсэн						
Тоо	14 612	12 873	10 383	9 172	24 995	22 045
Үнийн дүн, сая төг.	245 593.5	379 093.4	187 005.8	198 848.2	432 599.2	577 941.6
3.6 Хөрөнгө битүүмжилсэн						
Тоо	273	62	21	18	294	80
Өрийн дүн, сая төг.	19 464.2	1 072.3	1 309.8	569.3	20 774.0	1 641.6
3.7 Шүүхээр нэхэмжлэл хийгдсэн өр						
Тоо	697	401	84	49	781	450
Өрийн дүн, сая төг.	109 903.3	20 328.2	2 641.2	423.7	112 544.5	20 751.9

Эх үүсвэр: ТЕГ, Татварын орлогын газар

Татварын ерөнхий хуульд заасан татвар хураах, өр барагдуулах шат дараалсан арга хэмжээний дагуу хэрэгжүүлсэн процесс ажиллагааны хувьд 2016 онд өмнөх оноос буурсан байна. Тухайлбал, 2015 онд 6135 өртэй татвар төлөгчийн өрийг барагдуулах арга хэмжээ авсан байхад 2016 онд энэ нь 4028 болж 34.0 хувиар буурчээ. Дүнгийн хувьд 2015 онд 513.2 тэрбум төгрөгийн өр барагдуулах арга хэмжээ авсан бол 2016 онд 527.3 тэрбум (2.7) төгрөг өр барагдуулах арга хэмжээ авчээ. Хэрэгжүүлсэн ажиллагааны гүйцэтгэл (Хүснэгт 3.2) 2016 онд процесс ажиллагааны төрөл бүр дээр буурсан байна.

Хүснэгт 3.3 Татварын өр барагдуулалт, төсөвт орсон гүйцэтгэлээр, сая.төг

Татварын тооцоолол	Оны эхний үлдэгдэл		Тайлант оны ногдол		Барагдуулсан		Эцсийн үлдэгдэл	
1. 2015 он	781416.0		2811824.3		2886964.8		706275.5	
2. 2016 он	706275.5		3024127.8		2697103.1		1033300.2	
3. Татварын өр барагдуулалтын гүйцэтгэл								
	Өмнөх оны		Тайлант он		Нийт			
	2015	2016	2015	2016	2015	2016		

3.1 Харилцах дансны зарлагын гүйлгээ хаасан						
Тоо	2249	1563	1,339	1291	3,588	2854
Үнийн дүн	35 346.6	46 804.0	17 042.7	37031.3	52 389.3	83835.3
3.2 Эд хөрөнгөөс						
Тоо	32	20	84	1	139	21
Үнийн дүн	78 0	5.9	43.5	0.2	2 194.7	6.1
3.3 Барьцаат гэрээ байгуулсан						
Тоо	36	19	17	2	53	21
Үнийн дүн	597.7	827.9	176.0	23.4	773.7	851.4
3.4 Дуудлага худалдаа хийсэн						
Тоо	0	0	0	0	0	0
Үнийн дүн	0	0	0	0	0	0
3.5 Мэдэгдэх хуудас хүргүүлсэн						
Тоо	7 338	6 006	5 693	4 627	13 031	10 633
Үнийн дүн	52 639.5	138 441.5	52 169.1	70 704.1	104 808.7	209 145.7
3.6 Хөрөнгө битүүмжилсэн						
Тоо	67	40	6	18	73	58
Үнийн дүн	3 101.4	1 072.3	473.7	189.0	3 575.1	1 261.3
3.7 Шүүхээр нэхэмжлэл хийгдсэн өр						
Тоо	339	91	57	19	396	110
Үнийн дүн	23 793.6	2856.9	204.8	10.5	23 998.4	2867.4

Эх үүсвэр: ТЕГ, Татварын орлогын газар

Татварын өр барагдуулах процесс ажиллагааны үр дүнг хэрэгжүүлсэн процесс ажиллагаа ба түүнээс төсөвт орсон гүйцэтгэлээр хэмжиж болох юм. 2015, 2016 оныг харьцуулахад хэрэгжүүлсэн процесс ажиллагааны үр дүн харилцах дансны зарлагын гүйлгээ хаах, барьцаат гэрээ байгуулах, хөрөнгө битүүмжлэх болон шүүхээр нэхэмжлэх төрлүүд дээр 2016 онд өмнөх оноос сайжирсан байна.

Арга хэмжээ тус бүр дээр татвар төлөгчийн тоо болон өрийн дүн буурсан байдалтай байна. Сүүлийн хоёр жилийн энэхүү хандлагад өнөөгийн эдийн засгийн хямралтай нөхцөл байдал мөн Засгийн газраас татварын өртэй татвар төлөгчдөд авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээг тодорхой хугацаанд түдгэлзүүлсэн³⁵ нь нөлөөлсөн талаар дүүргийн Татварын хэлтсийн болон ТОГ-ын албан хаагчид дүгнэж байна.

3.2 Татварын ногдол, өр дуудах төвийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал³⁶ ын талаар

2016 онд Монгол Улсад анх удаа татварын ногдол, өр дуудах төв ажиллуулж эхэлсэн байна. Өнөөдөр татварын өр дуудах газар нь 9 хүнтэй (нэг ахлах байцаагч, 7 улсын байцаагч, 1 туслах ажилтан) ажиллаж байна. Дуудлагын байцаагчид (дундаж нас 34, 1

³⁵ ЗГ-ын 2016 оны 8-р сарын 3-ны өдрийн хуралдааны шийдвэр

³⁶ Татварын өр дуудах төвийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ТҮТ-ийн дарга болон ТӨДТ-ийн ахлах байцаагч нартай хийсэн хийсэн уулзалтын тэмдэглэл

эрэгтэй, 6 эмэгтэй) хураалтын чиглэлээр голдуу ажиллаж байсан бөгөөд 5-аас дээш ажилласан жилийн туршлагатай. Байцаагчдын ажлын ачаалал нилээн өндөр байдаг. ЖАЙКА төслийн хүрээнд төвийг компьютер, ширээ сандал зэрэг тоног төхөөрөмжөөр хангасан. Анх 5 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий өрийг дуудаж эхэлсэн ч явцийн дунд 3 сая төгрөгөөс доош болгож буулган, өнөөгийн байдлаар 10000 төгрөгөөс 1 сая төгрөгийн үнийн дүн бүхий өрийг дуудаж байна.

Өнгөрсөн онд нийслэлийн 6 том дүүргээс тус бүр 3 удаа дуудлага хийж, хөдөө орон нутгаас Ховд, Баянхонгор аймгуудаас дуудлага хийж туршсан байна. Дуудлага хийх үйл ажиллагааг ТЕГ-ын даргын 2016 оны 10 сарын 24-ний өдрийн А24 тушаалаар батлагдсан журмаар зохицуулдаг.³⁷ Дуудлага, дуудлагын үр дүнг бүртгэхдээ Excel програм дээр байцаагч тус бүр өөрсдөө шивж оруулдаг. Ажилтнуудаа хоёр удаа харилцааны чиглэлээр сургалтад хамруулж, ажлын байрны нөхцөлийг сайжруулав. Ялангуяа хана, шалны дуу шингээлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хүсэлт гарган зарим асуудлаа шийдвэрлэсэн байна. Сангийн Яам болон ТЕГ-ын зүгээс өр дуудах төвийн үйл ажиллагааг татвар хураалтын зардлыг бууруулах, татварын хураалтыг сайжруулах, улмаар процессийн үйл ажиллагааг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой гэж үзэн дэмждэг. Төслийн явцад Японоос зөвлөхүүд ирж ажилласан нь их дэмжлэг болсон.

2016 онд төв нь 23201 татвар төлөгчийн 10.7 тэрбум төгрөгийн ногдол өр хүлээж авснаас 16566 татвар төлөгчийн 6.4 тэрбум төгрөгийн өр барагдуулжээ. Мөн хугацаанд 31203 дуудлага хийснээс 17773 удаагийнх амжилттай болж, үүнээс 9717 татвар төлөгчөөс 4.6 тэрбум төгрөгийн ногдол, өр төлөх амлалт авсан. 2016 оны 12 сарын байдлаар эдгээр татвар төлөгчдийн 82 хувь болох 8006 татвар төлөгч 3.5 тэрбум төгрөгийн ногдол өр барагдуулжээ. Нийт дуудлага хийвэл зохих татвар төлөгчдийн 40.5 хувь буюу 9401 татвар төлөгчийн мэдээлэл зөрүүтэй, холбогдох боломжгүй байжээ. ТЕГ-ын тоон өгөгдлөөр 2016 онд өр дуудах төвөөр 23201 асуудал дамжиж, үүнээс 16566 асуудал шийдэгдсэн байна.

Хэдийгээр энэхүү нэг жилийн хугацаанд амжилттай ажиллаж байгаа ч үйл ажиллагаанд нь тулгамдсан хэд хэдэн асуудал байна. 1) Татварын өр дуудах үйл ажиллагааг Татварын ерөнхий хуультай нийцүүлэх. Тухайлбал одоо татварын өрийг 60 хоногийн хугацаанд дуудаж байгаа боловч хуульд мэдэгдэх хуудаст заасан хугацаанд төлөөгүй бол шат дараалсан арга хэмжээг авах зохицуулалттай зөрчилдөж байна. 2) Дуудлагад зориулсан зориулалтын чихэвч шаардлагатай. 3) Нэгдсэн мэдээллийн сантай болох, мэдээллийн сангийн бодит байдлыг сайжруулах шаардлага тулгарч байна. Өнөөгийн байдлаар татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл зөрүүтэйгээс нийт 17000 дуудлагын 10000 нь л амжилттай холбогдож үүнээс 70%-д нь татвар төлөгчтэй шууд холбогдож чадсан байна. 4) Хүмүүсээ сургах хэрэгцээ их. Ялангуяа, татвар төлөгчтэй харилцах харилцааны талаарх сургалтын хэрэгцээ өндөр.

³⁷ Өмнө нь Гааль татварын ерөнхий газрын даргын 2016 оны 5 сарын 26-ны өдрийн А191 тушаалаар батлагдсан журмыг мөрдөж байсан.

3.3 Татвар хураалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар татварын багц хуулийн төсөлд тусгасан байдлын талаар

Татвар хураалтын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага байна. Энэ тал дээр СЯ болон ТЕГ-аас нилээн анхаарч ажиллан хуулийн төсөл боловсруулсан. Татвар хураалтын гүйцэтгэлийн бие даасан эрх мэдлийг дээшлүүлэх, татвар хураах үйл ажиллагааг сайжруулахад нилээн анхаарч, саналаа оруулсан. Цаашид, хураалтын чиглэлээр технологийн дэвшлийг ашиглан хураах зардлыг бууруулах чиглэлд голлон анхаарч байна.³⁸ ТОГ-аас татварын багц хуулинд өгсөн саналыг Хавсралт А.1-ээс үзнэ үү.

3.4 Татварын албаны дотоод үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын талаар

Чингэлтэй болон Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэст хийсэн уулзалт, ТЕГ-аас авсан статистик мэдээлэлд үндэслэн энэ хэсгийг бичлээ. Энэ хоёр хэлтсийн талаарх мэдээллийг хүснэгт 4-т тоймлон харуулж байна.

ЧДТХ нь 113 татварын улсын байцаагчтай бөгөөд бүгд орон тооны байцаагч байна. Орлогын тасаг нь 39 байцаагчтай, 15871 татвар төлөгч байгууллагатай. Татвар төлөгчийн холбогдох мэдээлэл харьцангуй сайн. 2016 онд 138.4 тэрбум төгрөгийн татварын орлогын төлөвлөгөөтэй ажилласнаас 154.4 тэрбум төгрөг төсөвт оруулан төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн байна. Татвар төлөгчид аль болох хурч ажиллан татварын өрөө барагдуулахад анхааран ажиллаж байна.

Хүснэгт 3.4. ЧДТХ, СДТХ-ийн талаарх товч мэдээлэл

	Чингэлтэй дүүргийн хэлтэс	Сонгинохайрхан дүүргийн хэлтэс
Байцаагчийн тоо	Нийт 113 ажилтантай, Орлогын тасагт 39 ТУБ ажилладаг.	Нийт 93 орон тооны албан хаагч, орон тооны бус 45 албан хаагчтай. Орлогын тасаг 33 орон тооны, 7 орон тооны бус байцаагчтай.
Байцаагчийн ачаалал	Нэг байцаагч дунджаар 430-480 ААН хариуцдаг. Олдохоо байсан, эрэн сурвалжилж буй 1593 гаруй байгууллага нэг байцаагч дээр байдаг.	Нэг байцаагч дунджаар 600-700 ААН хариуцдаг, үүнээс 200-аад нь өртэй. 2 байцаагч тус бүр хүндрэлтэй өртэй 200 байгууллага хариуцдаг ба 1 байцаагч 1500-г хариуцдаг.
Татвар төлөгч байгууллагууд	нийт 15871 татвар төлөгч байгууллагатай, 19 хороотой бөгөөд энд 55500 орчим иргэд ХЭАА болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 10 гаруй том худалдааны төвтэй	15422 татвар төлөгч байгууллагатай, үүнээс 1 тэрбумаас дээш татвар төлөлттэй нь 6-7 ААН л байдаг. Үйл ажиллагаа явуулдаггүй Х тайлантай 10-аад мянга байна
Өртэй татвар төлөгчийн тоо,	Урд оны 2612; 36.3 турбум ₮ Тайлант оны 3223; 133.6 тэрбум ₮	Урд оны 6578; 21.8 тэрбум ₮ Тайлант оны 43799; 65.6 тэрбум ₮

³⁸ ТЕГ-ын Татварын орлогын газрын даргатай хийсэн уулзалтын тэмдэглэл

өрийн дүн ³⁹		
Өр төлөлт	Өр барагдуулалтад ахиц гарч байгаа. 2015 онд жаахан тасарсан ч, 2016 онд биелэлт сайн байгаа, хураалтад ахиц гарсан гэж үздэг. 10-аас дээш сая төгрөгийн өртэй байгууллагын хувьд шат дараалсан арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлдэг.	Өр төлөлт удааширсан, 2015 оны ногдолоо төлж чадаагүй, шүүхэд шилжих өрийн хэмжээ өссөн. Өршөөлийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой 2015 онд ХШ-ын өр буурсан. Төсвийн хүндрэлээс шалтгаалж концессийн гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн татварын өр нэмэгдсэн.
Татвар төлөвлөгөөний гүйцэтгэл	2016 онд 138.4 тэрбум төгрөгийн төлөвлөгөө, 154.4 тэрбум төгрөг улсын төсөвт оруулсан.	2016 онд гүйцэтгэл буурсан, 66.0 тэрбумаас 60.0 тэрбум, 2015 он 66.0 тэрбумаас 65.0 тэрбумын гүйцэтгэл
Сургалтад хамрагдсан байдал	ОУТ-ын чиглэлээр сургалтад хамрагдсан хүмүүс нь ажлаа өөрчилсөн. Одоогоор ажиллаж байгаа хүмүүстээ сургалт авах шаардлагатай.	Оны эхээр сургалтад сууж байсан. ОУТ-ын чиглэлээр тууштай сурсан хүмүүс байхгүй. Цаашид сургалт авах шаардлагатай.

Эх үүсвэр: ЧДТХ, СДТХ-тэй хийсэн уулзалтын тэмдэглэл

СДТХ нь орон тооны 95 татварын улсын байцаагч, орон тооны бус 45 албан хаагчтай бөгөөд орлогын тасаг 33 албан хаагчтай. 15422 татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагатай бөгөөд том татвар төлөгчид цөөн, олон жижиг татвар төлөгчтэй гэдгээрээ онцлог. 2016 онд 66.0 тэрбум төгрөгийн татварын орлогын төлөвлөгөөтэй ажиллан төсөвт 60.0 тэрбум төгрөг оруулсан. Энэ хэлтсийн хувьд олон жижиг татвар төлөгчтэй ажилладаг, татвар төлөгчид нь төлөвшөөгүй зэрэгтэй холбоотойгоор процесс ажиллагааны тоо олон татвар хураалтын зардал өндөртэй байдаг байна.

Татварын хэлтэс өр дуудах төвөөс дуудлага хийн тэдэнд тусалж байгааг тэмдэглэж байна. Гэвч тухайн татварын өр нь хэлтсийн хариуцлага тул өр дуудах төвийг дуудлага хийж байхад ч хэлтсүүд давхар дууддаг байна. Иймд өр дуудах төвийн дуудлагаар хэдий хэмжээний өр барагдсан, татварын хэлтсийн үйл ажиллагааны үр дүнд хэд нь төлөгдсөнийг цаашид ялгах шаардлагатай байна.

Нөгөө талаар хэлтсүүд өөрсдөө олон тооны дуудлага хийн өр дууддаг, ачаалал ихтэй байдаг бөгөөд дуудлага хийх тоног төхөөрөмж хангалтгүй байдаг байна. Ялангуяа, чихэвч, утас зэрэг тоног төхөөрөмж шаардлагатай.

Татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл байнга өөрчлөгддөг, улсын бүртгэлийн байгууллагаас бүртгэлийн мэдээлэл, лавлагаа авахад хугацаа, зардал шаарддаг.

ОУТ-ын чиглэлээр асуудал гарахад хэлтсүүд ТЕГ-ын ТХШАГ-аас зөвлөгөө аван ажилладаг. Хэлтсүүдэд гарын авлагатай болох хэрэгцээ их байна. Түүнчлэн энэ чиглэлээр байцаагчидаа сургалтад хамруулах хүсэлтэй. СДТХ-тэй хийсэн уулзалтын үеэр ОУТ-ын чиглэлийн сургалтад ХШХТ-ийн байцаагч нарыг хамруулах шаардлага байгааг онцолж байсан.

³⁹ ТЕГ-ийн ТОГ-ын тоон мэдээлэл

ХАВСРАЈТ

Хавсралт А. Судалгааны үед цуглуулсан мэдээ, мэдээлэл, тоон өгөгдөл

А.1. Олон улсын татвар ногдуулалттай холбоотой дунд ба гүнзгийрүүлсэн шатны мэдлэг, практик ур чадвар олгох

А.1.1. Татварын улсын байцаагчийн эрх олгох анхан шатны танхимын сургалтын хичээлийн хуваарь

Сургалтын үргэлжлэх хугацаа: **Ажлын 30 өдөр, 240 цагийн хичээл /2014.10.01-ээс 2014.11.12-ыг дуустал/**

Өдөр	Цаг	Хичээлийн нэр	Сэдэв	Цаг	Багшийн нэр
Х/01 Лхагва	08.00-08.10	Хичээлийн нээлт			ТЕГ-ын дэд дарга, ТЗУГ, СТ
	08.10-09.30	Ёс зүй	Ёс зүйн үндсэн ойлголт, Төрийн албан хаагчийн болон ТУБ-ийн ёс зүйн дүрэм.	2	ТЗУГ Т.Заяахишиг СТ М.Чойжилсүрэн
	09.40-11.10	Харилцаа	Төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйн зөрчлөөс зайлсхийх аргууд	2	ТЗУГ Т.Заяахишиг СТ Б.Очирхуяг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	Татварын онол	Татварын тухай ойлголт, татварын ангилал, төрөл, татварын үүрэг, зорилго, зарчим	4	СТ Х.Хурметхан
Х/02 Пүрэв	08.00-09.30 09.40-11.10	Татварын онол	Тест бөглүүлэх, дадлага ажил	2	СТ Х.Хурметхан
		Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ	Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, чиг хандлага	2	ТТҮГ. Д.Баяраа СТ. Д.Баярцэцэг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	Нягтлан бодох бүртгэлийн үүрэг, зорилго, зарчим	<ul style="list-style-type: none"> ➢ НББүртгэл гэж юу вэ, НББ-ийн зорилго, үүрэг, НББ-ийн зарчим, НББ-ийн бүрэлдэхүүн, НББүртгэл хөтөлдөг бизнесийн нэгжүүд 	2	СТ Б.Батдорж
14.10-15.40	<ul style="list-style-type: none"> ➢ Тест бөглөх, харилцан ярилцах 				

X/03 Баасан	08.00-09.30	Татварын ерөнхий хууль	<ul style="list-style-type: none"> ➤ Нийтлэг үндэслэл, зорилт, нэр томъёоны тодорхойлолт ➤ Монгол улсын татварын бүрэлдэхүүн, татвар ногдох зүйл, төрөл, ангилал, татварын хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх чөлөөлөх хэлбэр, хөөн хэлэлцэх хугацаа ➤ Татвар төлөгч, татвар төлөгчийн бүртгэл, татвар төлөгчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх, татвар төлөгчид үйлчлэх, татвар төлөгчийн эрх, үүрэг 	2	СТ Б.Очирхуяг
	09.40-11.10	Татварын ерөнхий хууль	<ul style="list-style-type: none"> ➤ Монгол улсын үндэсний татварын албаны бүтэц, чиг үүрэг, зарчим, удирдлага болон байцаагчийн бүрэн эрх, хориглох зүйл, үйлдэх баримт бичиг, татварын улсын байцаагчийн цалин хөлс, эрхийн баталгаа, татварын маргаан таслах зөвлөл ➤ Татвар ногдуулах төлөх тайлагнах ➤ Татварын хяналт шалгалт 	2	СТ Б.Очирхуяг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	Татварын ерөнхий хууль	<ul style="list-style-type: none"> ➤ Татварын бүртгэл, өр, хугацаандаа төлөөгүй татварын өрийг хураан барагдуулах процесс ажиллагаа ➤ Бусад байгууллагын хүлээх үүрэг ➤ Татварын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 	2	СТ Б.Очирхуяг
	14.10-15.40	ТЕХ-д нийцүүлэн гаргасан журам, дүрэм, заавар, аргачлал	Татвар төлөгчийг бүртгэх журам, түүний хэрэгжилт	2	ТТҮГ Б.Батболд СТ Б.Очирхуяг
X/06 Даваа	08.00-09.30	Данс, давхар бичилтийн систем	НББ-ийн данс, давхар бичилтын систем, дансны мөн чанар, дебет, кредитийн тухай, байнгын данс, түр данс, дансыг хаах	2	СТ Б.Батдорж
	09.40-11.10	Данс, давхар бичилтийн систем	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Б.Батдорж
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	ТЕХ-д нийцүүлэн гаргасан журам, дүрэм, заавар, аргачлал	Татвар төлөгчдөд нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам, стандарт	2	ТТҮГ З.Ганболд СТ Б.Батдорж
	14.10-15.40	Татварын ерөнхий хууль	Тест бөглөх, бодлого бодох, кейс ажиллуулах	2	СТ Б.Очирхуяг
X/07 Мягмар	08.00-09.30 09.40-11.10	Санхүүгийн тайлан	Санхүүгийн тайлан, түүний бүтэц, санхүү байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан /тодруулга /	2	СТ Б.Батдорж
			-Жижиг хэмжээний санхүүгийн тайлан гаргах	2	СТ Б.Батдорж

	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	ААНОАТ-ын тухай хууль	Хамрах хүрээ, татвар ногдох орлого, ТНО-оос хасагдах зардал, татварын хувь хэмжээ	2	СТ Х.Хурметхан
	14.10-15.40		Хөнгөлөлт чөлөөлөлт, алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, төлөх тайлагнах	2	СТ Х.Хурметхан
Х/08 Лхагва	08.00-09.30 09.40-11.10	ААНОАТ-ын хуульд нийцүүлэн гаргасан дүрэм журам	<ul style="list-style-type: none"> ➢ Уул уурхай, дэд бүтцийн салбарт алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох журам /ЗГ-ын тогтоол/ ➢ ААНОАТ-ын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох заавар /ТЕГ-ын даргын тушаал/ 	2	СТ Х.Хурметхан
			<ul style="list-style-type: none"> ➢ ААНОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх заавар /ТЕГ-ын даргын тушаал/ 	2	СТ Х.Хурметхан
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	ТЕХ-д нийцүүлэн гаргасан журам, дүрэм, заавар, аргачлал	<ul style="list-style-type: none"> ➢ Татварын тайлан гаргах, татварын албанд тайлан хүлээн авах журам 	2	ТТҮГ Н.Бат-Эрдэнэ СТ Н.Жаргалцэцэг
	14.10-15.40		<ul style="list-style-type: none"> ➢ Татварын тайланд ногдуулалтын хяналт хийх журам 	2	ТХУАЗГ Д.Гансүх СТ М.Чойжилсүрэн
	Х/09 Пүрэв	08.00-09.30	ТЕХ-д нийцүүлэн гаргасан журам, дүрэм, заавар, аргачлал	Татварын өр барагдуулах ажлын удирдлага, хяналт, бүртгэлийн журам	2
09.40-11.10		Хугацаандаа төлөөгүй татварын өрийг хураан хураан барагдуулах процесс ажиллагаа		2	ХЭХ В.Халиунцэцэг СТ Б.Очирхуяг
11.10-12.30			Үдийн завсарлага		
12.30-14.00 14.10-15.40		ААНОАТ-ын тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	4	СТ Х.Хурметхан
Х/10 Баасан	08.00-09.30 09.40-11.10	Мөнгөн хөрөнгийн бүртгэл	Мөнгөн хөрөнгийн тухай / Орлого, орлогыг бүртгэх, цэвэр ашиг ба хуримтлагдсан ашиг	2	СТ Н.Жаргалцэцэг
			Дадлага ажил	2	СТ Н.Жаргалцэцэг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	ААНОАТ-ын тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	4	СТ Х.Хурметхан
Х/13 Даваа	08.00-09.30	Зардал өртгийн тухай	Зардлын мөн чанар, уялдаат ба тохируулгын арга, зардлын хэлбэр	4	СТ Б.Батдорж
	09.40-11.10		Дадлага ажил		
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	ТЕХ-д нийцүүлэн гаргасан журам, дүрэм, заавар, аргачлал	Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны ерөнхий журам	2	ТХШУАЗГ Н.Ганбаатар Х.Хурметхан
	14.10-15.40		Татварын маргаан таслах зөвлөл, түүний үйл ажиллагаа	2	ХЭХ С.Төгсжаргал СТ Х.Хурметхан

Х/14 Мягмар	08.00-09.30	Авлагын бүртгэл	Авлагын бүртгэл, нийт ба цэвэр дүнгийн арга, найдваргүй авлагын бүртгэл	2	СТ М.Чойжилсүрэн
	09.40-11.10		Дадлага ажил	2	
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	НӨАТ-ын тухай хууль	Хамрах хүрээ, татвар ногдох орлого, татварын хувь хэмжээ	2	СТ Д.Баярцэцэг
	14.10-15.40		НӨАТ-ын хасалт, хөнгөлөлт чөлөөлөлт, төлөх тайлагнах	2	
Х/15 Лхагва	08.00-09.30	НӨАТ-ын хуульд нийцүүлэн гаргасан дүрэм журам:	➤ НӨАТ-ын хасалтыг тодорхойлох аргачлал /ҮТЕГ-ын даргын тушаал/	2	СТ Д.Баярцэцэг
	09.40-11.10	НӨАТ-ын хуульд нийцүүлэн гаргасан дүрэм журам:	➤ Буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, концессийн зээлийн хөрөнгөөр худалдан авсан барааг НӨАТ-аас чөлөөлөх тухай журам /Сангийн сайдын тушаал/	2	СТ Д.Баярцэцэг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	НӨАТ-ын тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Д.Баярцэцэг
	14.10-15.40	НӨАТ-ын тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Д.Баярцэцэг
Х/16 Пүрэв	08.00-11.10	ХХОАТ-ын тухай хууль	Хамрах хүрээ, татвар ногдох орлого, татварын хувь хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлт, төлөх тайлагнах	4	СТ Б.Очирхуяг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	НӨАТ-ын тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Д.Баярцэцэг
	14.10-15.40	НӨАТ-ын тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Д.Баярцэцэг
Х/17 Баасан	08.00-09.30	Үнэт цаасны, ашиглалт, түүнд тавих хяналт	Үнэт цаасны хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавих журам	2	СХОХ Л.Бямбадорж СТ Б.Очирхуяг
	09.40-11.10	ХХОАТ-ын тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Б.Очирхуяг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	ХХОАТ-ын тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	4	СТ Б.Очирхуяг
Х/20 Даваа	08.00-09.30	Бараа материалын бүртгэл	Бараа материалын бүртгэл, худалдааны байгууллага, үйлдвэрлэлийн байгууллага	2	СТ Д.Жаргалцэцэг
	09.40-11.10	Бараа материалын бүртгэл	Бараа материалын өртөг тооцох арга	2	СТ Д.Жаргалцэцэг
	12.30-14.00	Бараа материалын бүртгэл	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Д.Жаргалцэцэг
	14.10-15.40	Бараа материалын бүртгэл	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Д.Жаргалцэцэг
	08.00-11.10	ҮХЭХ, Буу, АБДТ, АТБӨЯХ	Хамрах хүрээ, татвар ногдох зүйл, татварын хувь хэмжээ, хөнгөлөлт	4	СТ М.Чойжилсүрэн

Мягмар		АТхууль	чөлөөлөлт, төлөх тайлагнах		СТ Б.Батдорж
---------------	--	----------------	----------------------------	--	-----------------

	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-15.40	ҮХЭХ, Буу, АБДТ, АТБӨЯХ АТхууль	Тест бөглөх, бодлого бодох	4	СТ М.Чойжилсүрэн СТ Б.Батдорж
Х/22 Лхагва	08.00-09.30	Үндсэн хөрөнгийн бүртгэл	Үндсэн хөрөнгө, элэгдэл тооцох арга	2	СТ Д.Баярцэцэг
	09.40-11.10	Үндсэн хөрөнгийн бүртгэл	Үндсэн хөрөнгийг данснаас хасах, солилцоо	2	СТ Д.Баярцэцэг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	Үндсэн хөрөнгийн бүртгэл	Дадлага ажил	4	СТ Д.Баярцэцэг
Х/23 Пүрэв	08.00-09.30	Онцгой албан татвар тухай хууль	Хамрах хүрээ, татвар ногдох зүйл, татварын хувь хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлт, төлөх тайлагнах	2	СТ М.Чойжилсүрэн
	09.40-11.10		Тест бөглөх, бодлого бодох	2	М.Чойжилсүрэн
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	ОТБТБАҮЭИО АТ-ын тухай хууль	<ul style="list-style-type: none"> ➢ Хамрах хүрээ, татвар ногдуулах ажил үйлчилгээний төрөл, татварын хувь хэмжээ, татвар төлөгчийг бүртгэх, гэрчилгээ олгох, төлөх тайлагнах ➢ Тест бөглөх 	2	СТ Н.Жаргалцэцэг
	14.10-15.40	Онцгой албан татвар тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ М.Чойжилсүрэн
Х/24 Баасан	08.00-09.30	Эх үүсвэр, эздийн өмчийн бүртгэл	<ul style="list-style-type: none"> ➢ Өр төлбөр ба эзний өмч ➢ Богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр ➢ Хувьцаат капитал 	2	СТ Н.Жаргалцэцэг
	09.40-11.10	Эх үүсвэр, эздийн өмчийн бүртгэл	<ul style="list-style-type: none"> ➢ Дадлага ажил 	2	СТ Н.Жаргалцэцэг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	ТЕХ-д нийцүүлэн гаргасан журам, дүрэм, заавар, аргачлал	Шүүхэд татварын албыг төлөөлж ажиллахад анхаарах зарим асуудал	2	ХЭХ Б.Баттогтох СТ М.Чойжилсүрэн
	14.10-15.40	ХХОАТ-ын хуульд нийцүүлэн гаргасан дүрэм журам:	<ul style="list-style-type: none"> ➢ ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн заавар” ТЕГ-ын даргын 2009 оны 523 тоот тушаал/ ➢ Албан татварын хасалт хийх, буцаан олгох тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах жухам” /Сайдын 2009 оны 104 тоот тушаал/ 	2	ТХУАЗГ Д.Болор-Эрдэнэ

Х/27 Даваа	08.00-09.30	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай	Ашигт малтмалын нөөцийн тухай ойлголт, ангилал, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хамрах хүрээ, төлбөр ногдох зүйл, төлбөрийн хувь хэмжээ, төлбөрийн хуваарилалт, төлбөр төлөх, тайлагнах, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	2	СТ Б.Очирхуяг
	09.40-11.10	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулж төлөхтэй холбогдож гарсан дүрэм журам	<ul style="list-style-type: none"> ➢ АМНАТ-ийг төлөх, хуваарилах, зарцуулах журам” ЗГ-ын 2006 оны 272-р тогтоол. ➢ ТЕГ, Ашигт малтмалын газрын хооронд мэдээлэл солилцох журам ➢ АМНАТ-ийн хувийг тооцох, төлбөр ногдуулах аргачлал”. ЗГ-ын 2014 оны 89-р тогтоол ➢ “Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тооцох аргачлал” ТЕГ-ын даргын 2010 оны 322-р тушаал 	1	СТ Б.Очирхуяг
		Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай	<ul style="list-style-type: none"> ➢ Тест бөглөх, бодлого бодох 	1	СТ Б.Очирхуяг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.10	Газрын төлбөрийн тухай хууль	Хамрах хүрээ, төлбөр ногдох зүйл, хувь хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлт төлөх тайлагнах	2	СТ Х.Хурметхан
	14.10-15.40	Газрын төлбөрийн тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ Х.Хурметхан
Х/28 Мягмар	08.00-11.10	Татварын бүртгэл	<ul style="list-style-type: none"> ➢ ХХОАТ-ын бүртгэл ➢ НӨАТ-ын бүртгэл ➢ ОАТ-ын татварын бүртгэл ➢ Хөрөнгийн татварын бүртгэл ➢ Бусад 	4	СТ Н.Жаргалцэцэг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-15.40	Татварын бүртгэл	<ul style="list-style-type: none"> ➢ ААНОАТ-ын бүртгэл ➢ Санхүүгийн тайлан ба татварын тайлангийн ялгаа ➢ Зөрүүгийн тайлан 	4	СТ Д.Баярцэцэг
Х/29 Лхагва	08.00-09.30 09.40-11.10	Системд нэвтрэх эрх	Хэрэглэгчийн эрхийн бүртгэл /IMS/ Хэрэглэгчийн бүртгэл /Tax_ac/t	4	МТТ Г. Ганхуяг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	Татвар төлөгчийн болон татварын бүртгэл	ДБ-ийн ТУМ-ийн систем /TRIPS/ Нийслэлийн ҮХЭХ, иргэний бүртгэл / Capital.mta.mn/	4	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
Х/30 Пүрэв	08.00-09.30 09.40-11.10	Татвар төлөгчийн болон татварын бүртгэл	Татварын хуулийн хэрэгжилтийг хангах / Tax_act /Burtgel// Иргэний бүртгэлийн програм / Tax_act /Taxpayerperson/	4	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
	11.10-12.30		Үдийн завсарлага		

	12.30-14.00 14.10-15.40	Хөрөнгийн бүртгэл	Нийслэлийн ҮХЭХ, иргэний бүртгэл / Capital.mta.mn/ ҮХЭХ-ийн бүртгэл /Tax_act /Immove tax//	4	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
Х/31 Баасан	08.00-09.30	Хөрөнгийн бүртгэл	АТБӨЯТХ-ийн програм / Autotax/ Бууны бүртгэл / Tax_act /Guntax/	2	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
	09.40-11.10	Татварын тайлангийн бүртгэл	Цахим татварын систем / e-taxmta.mn/ Татварын ХШ, эрдлийн удирдлагын мэдээллийн систем / Fisher/	2	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	Татварын тайлангийн бүртгэл	НӨАТ-ын падааны бүртгэл / VAT_entry 3.0/ ХХОАТ-ын тайлан, хавсралт / Suutgan 2.0/	4	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
ХI/03 Даваа	08.00-09.30 09.40-11.10	Татвар төлөлтийн бүртгэл	Орлогын бүртгэл / Taxpayment/ Орлогын төлөвлөгөөний бүртгэл / Tax_act /Plan/	4	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	Татварын тооцоолол	Татварын тооцооллын бүртгэл / Tax_act/Tax_accounting//	4	
ХI/04 Мягмар	08.00-09.30	Татварын өрийн бүртгэл	Өрийн удирдлага, алдангийн програм / Debt_managment/ Өрийн удирдлагын програм / Tax_act / Debt_managment /	2	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
	09.40-11.10	Бусад программ	Өгөгдлийн уурхай, ухаалаг тайлангийн систем / Dataware house,B/ ХШҮДА-ын програм / E-monitoring/ Байгууллагын дотоод үйл ажиллагааны програм / E-office/	2	
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	Бусад программ	Үнэт цаасны бүртгэл / Excisemark/ ТТ-д үнэлгээ өгөх програм / Tax_act /Statusn/ ТТ-д тодорхойлолт гаргаж өгөх програм / Tax_act Reference/	2	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
	14.10-15.40	Хөндлөнгийн мэдээллийн систем	Гаалийн экспорт, импортын мэдээ / TPI/ Төрийн сангийн зарлагын мэдээ /TPI/ НӨАТ-ын падааны хөрвүүлэлт /TPI/ Суутган-1-ийн хавср хөрвүүлэлт /TPI/ Хөндлөнгийн цаасан мэдээлэл /TPI/ Спиртийн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ / TPI/ Э-балансын мэдээ / TPI/	2	МТТ Д. Энхтуяа Б. Батгэрэл Ж. Бүрэндэлгэр
ХI/05 Лхагва	08.00-09.30 09.40-11.10	Байгалтийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	Хамрах хүрээ, төлбөр хураамж ногдох зүйл, төлбөр хураамжийн хувь хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлт, төлөх тайлагнах	4	СТ. М.Чойжилсүрэн
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	4	СТ М.Чойжилсүрэн

XI/06 Пүрэв	08.00-09.30	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	Тест бөглөх, бодлого бодох	2	СТ М.Чойжилсүрэн
	09.40-11.10	ТЕХ-д нийцүүлэн гаргасан журам, дүрэм, заавар, аргачлал	Эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, үзлэг, тооллог, ажлын зураг авалт хийх журам	2	ХЭХ Халиунцэцэг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	Бие даалтын ажил хамгаалах			Багш нар
	14.10-15.40	Нийслэл, дүүргийн татварын албаны үйл ажиллагаатай танилцаж, дадлага ажил хийх		2	Багш нар
XI/7 Баасан	08.00-09.30	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль	Хамрах хүрээ, төлбөр ногдох зүйл, хувь хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлт төлөх тайлагнах <ul style="list-style-type: none"> ➢ Агаарын бохирдлын төлбөрийн хэмжээг тогтоох тухай /ЗГ-ын 2010 оны 273-р тогтоол/ ➢ Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдал, бохирдуулах бодисын төлбөрийн хувь хэмжээ /2011 оны 92-р тогтоол/ ➢ Агаарын бохирдлын төлбөрийн тухай /БОЯ болон Автотээврийн газрын хамтарсан тушаал. /2011.03.07-ний өдрийн А-63/67 дугаар хавсралт/ ➢ Түүхий нүүрс олборлодог ААНБ-ыг агаарын бохирдлын төлбөрөөс хөнгөлөх журам /ЗГ-ын 2012 оны 139-р тогтоол/ ➢ Тест бөглөх, бодлого бодох 	2	СТ Б.Очирхуяг
	09.40-11.10	Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль	<ul style="list-style-type: none"> ➢ Хамрах хүрээ, төлбөр ногдох зүйл, хувь хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлт төлөх тайлагнах ➢ Тест бөглөх, бодлого бодох 	2	СТ Б.Батдорж
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00	Архив албан хэрэг хөтлөлтийн стандарт	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт	2	ТЗУГ, СТ Б.Батдорж
	14.10-15.40	Шалгалт	<ul style="list-style-type: none"> ➢ Явцын шалгалт авах 	2	Багш нар
XI/10 Даваа	08.00-09.30	Олон улсын татвар	<ul style="list-style-type: none"> ➢ ОУ-ын татварын тухай ерөнхий ойлголт ➢ Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх гэрээний тухай товч ойлголт 	2	СТ Х.Хурметхан
	09.40-11.10	Цогц бодлого, тайлан гаргах	<ul style="list-style-type: none"> ➢ Ажил гүйлгээг бүртгэх ➢ Санхүүгийн тайлан гаргахад бэлтгэх 	2	СТ Д.Баярцэцэг Н.Жаргалцэцэг
	11.10-12.30		Үдийн завсарлага		
	12.30-14.00 14.10-15.40	Цогц бодлого, тайлан гаргах	<ul style="list-style-type: none"> ➢ Ажил гүйлгээг бүртгэх ➢ Санхүүгийн тайлан гаргахад бэлтгэх 	4	СТ Д.Баярцэцэг Н.Жаргалцэцэг

XI/11 Мягмар	08.00-09.30	Цогц бодлого, тайлан гаргах	<ul style="list-style-type: none"> ➤ Ажил гүйлгээг бүртгэх ➤ Санхүүгийн тайлан гаргах 	2	СТ Д.Баярцэцэг Н.Жаргалцэцэг	
	09.40-11.10	Цогц бодлого, тайлан гаргах	<ul style="list-style-type: none"> ➤ ААНОАТ-ын тайлан гаргах ➤ НӨАТ-ын тайлан гаргах 	2	СТ Б.Очирхуяг	
	11.10-12.30		Үдийн завсарлага			
	12.30-14.00	Цогц бодлого, тайлан гаргах	<ul style="list-style-type: none"> ➤ ХХОАТ-ын тайлан гаргах ➤ Холбогдох бусад тайлан гаргах 	2	СТ Б.Очирхуяг	
	14.10-15.40	Шалгалтанд бэлтгэхэд анхаарах асуудлууд	<ul style="list-style-type: none"> ➤ Явцын шалгалтын дүнг танилцуулах ➤ Шалгалт өгөхөд анхаарах асуудал 	2	Х.Хурметхан Д.Баярцэцэг Б.Очирхуяг	

СУРГАЛТЫН ТӨВ

A.1.2.

Олон улсын татвар ногдуулалт (2015.8.17-2015.8.21)

Он сар өдөр	Цаг	Сургалтын хэлбэр	Сургалтын агуулга	Хариуцсан багш
2015.8.17 (Даваа)	09:00-10:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо Φ (Эх үүсвэрийн дүрэм)	ТЕГ, Сургалтын төвийн багш Жаргалцэцэг
	10:40-12:00	Семинар		
	13:00-14:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо Θ (Төлөөний газар)	
	14:40-16:00	Семинар		
2015.8.18 (Мягмар)	09:00-10:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо Φ (Үнэ шилжилт)	ТЕГ, Сургалтын төвийн багш Жаргалцэцэг
	10:40-12:00	Семинар		
	13:00-14:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо Φ Татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх үнэ шилжилтээс бусад арга	
	14:40-16:00	Семинар		
2015.8.19 (Лхагва)	09:00-10:30	Лекц	Олон улсын татвар ногдуулалтын үндэс Φ	Төслийн зөвлөх Ишигүро Хидэаки
	10:40-12:00		Олон улсын татвар ногдуулалтын үндэс Θ	
	13:00-14:30			
	14:40-16:00			
2015.8.20 (Пүрэв)	09:00-10:30	Лекц	Үнэ шилжилтийн татварын тогтолцооны үндэс Φ	Төслийн зөвлөх Кодера Тошинари
	10:40-12:00		Үнэ шилжилтийн татварын тогтолцооны үндэс Θ	
	13:00-14:30			
	14:40-16:00			
2015.8.21 (Баасан)	09:00-10:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо Φ (Татварыг давхардуулан ногдуулахаас сэргийлэх арга)	ТЕГ, Сургалтын төвийн багш Жаргалцэцэг
	10:40-12:00	Семинар		
	13:00-14:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо Φ (Олон улсын татварын гэрээ)	
	14:40-16:00	Семинар		

A.1.3.

Олон улсын татвар ногдуулалтын анхан шатны мэдлэг олгох сургалт (2016.3.7-2016.3.11)

Он сар өдөр	Цаг	Сургалтын хэлбэр	Сургалтын агуулга	Хариуцсан багш
2016.3.7 (Даваа)	09:00-10:30	Лекц	Үнэ шилжилтийн татварын тогтолцооны үндэс	Төслийн зөвлөх Кодера Тошинари
	10:40-12:00			
	13:00-14:30	Лекц	Олон улсын татвар ногдуулалтын үндэс - Япон улсын туршлагаас -	Төслийн зөвлөх Ишигүро Хидэаки
	14:40-16:00			
2016.3.9 (Лхагва)	09:00-10:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо ① (Байнгын оршин суугч, байнгын бус оршин суугч)	ГТЕГ, Сургалтын төвийн багш Б.Очирхуяг
	10:40-12:00	Семинар		
	13:00-14:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо ② (PE: Төлөөний газар)	
	14:40-16:00	Семинар		
2016.3.10 (Пүрэв)	09:00-10:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо ③ (Эх үүсвэрийн дүрэм)	ГТЕГ, Сургалтын төвийн багш Б.Очирхуяг
	10:40-12:00	Семинар		
	13:00-14:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо ④ Татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх	ГТЕГ, Сургалтын төвийн багш Н.Жаргалцэцэг
	14:40-16:00	Семинар		
2016.3.11 (Баасан)	09:00-10:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо ⑤ (Татварыг давхардуулан ногдуулахаас сэргийлэх арга)	ГТЕГ, Сургалтын төвийн багш Н.Жаргалцэцэг
	10:40-12:00	Семинар		
	13:00-14:30	Лекц	Монгол улсын татварын тогтолцоо ⑥ (Олон улсын татварын гэрээ)	
	14:40-16:00	Семинар		

A.1.4

БАТЛАВ. СУРГАЛТЫН ТӨВИЙН ДАРГА



Б.БАДАМЦЭЦЭГ

2017 ОНД ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Сургалтын түвшин	Сургалтын хэлбэр	Сургалтын сэдэв	Хамрагдах ТУ(А)Б	Хугацаа	Заах багшийн нэр
1	Ахисан түвшин	Танхим	- Олон улсын татвар - Үнэ шилжилтийн асуудал	ТЕГ-ийн дотоод бүтцийн нэгж, харьяа нэгж, НТГ, төвийн 6 дүүргийн ХШТ-ийн ТУ(А)Б нар	1-р улиралд 40 цаг	Сургагч багш нар Ш.Ундраа
2	Анхан, дунд шат	Цахим	-Олон улсын татвар ногдуулалтын үндэс - Төлөөний газрын төрөл ба татвар ногдуулах арга - Олон улсын татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх арга замууд -ЭЗХАХБ-ын Татварын загвар гэрээнууд -Татварын албадын хоорондын хамтын ажиллагаа	ТУ(А)Б, хураагч	2-р улиралд 40 цаг	Сургагч багш нар Ш.Ундраа
3	Анхан, дунд шат	Ажлын байран дахь сургалт, хэлэлцүүлэг	-Цахим хичээлүүдээ бататгах -Монгол Улсад гарч байгаа бодит иеис дээрх хэлэлцүүлэг	Төвийн 6 дүүргийн ТУ(А)Б, хураагч	3-р улиралд 24 цаг	Сургагч багш нар Ш.Ундраа
4	Анхан, дунд шат	Зайн сургалт	-Олон улсын татвар ногдуулалтын үндэс - Төлөөний газрын төрөл ба татвар ногдуулах арга - Олон улсын татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх арга замууд	Орон нутгийн ТУ(А)Б, хураагч	4-р улиралд 8 цаг	Сургагч багш нар Ш.Ундраа

СУРГАЛТЫН ТӨВ

А.1.5.

Япон Улсын ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөлд хамрагдагсад					
/ 2017.02.20-ны өдрийн байдлаар/					
Д/Д	Д/Д	Нэрс	Татварын алба	Харьяа нэгж	Хариуцсан ажлын чиг үүрэг
					2017.03.07
ДОТООД БҮТЦИЙН НЭГЖ					
1	1	Татварын улсын байцаагч 1	ТЕГ	ТУХАГ	Давхар татварын гэрээ, Мэдээлэл харилцан солилцох
2	2	Татварын улсын байцаагч 2	ТЕГ	ТУХАГ	ААНОАТ, ХХОАТ
3	3	Татварын улсын байцаагч 3	ТЕГ	ТУХАГ	ОУ-ын татвар, судалгаа
4	4	Татварын улсын байцаагч 4	ТЕГ	ТЗУГ	Дотоод ажил
5	5	Татварын улсын байцаагч 5	ТЕГ	ДАГ	ТУАБ
6	6	Татварын улсын байцаагч 6	ТЕГ	ТТХГ	НӨАТ
7	7	Татварын улсын байцаагч 7	ТЕГ	ТОГ	Орлогын бүртгэл, мэдээллийн сан
8	8	Татварын улсын байцаагч 8	ТЕГ	СТ	Дарга
9	9	Татварын улсын байцаагч 9	ТЕГ	СТ	ОУ-ын татвар, Татвар хураалтын үйл ажиллагаа
10	10	Татварын улсын байцаагч 10	ТЕГ	ТҮТ	Үйлчилгээний танхимын ТУАБ
11	11	Татварын улсын байцаагч 11	ТЕГ	ТҮТ	Утсаар зөвлөгөө өгөх
12	12	Татварын улсын байцаагч 12	ТЕГ	ТҮТ	НӨАТУС
ХАРЬЯА НЭГЖ					
13	1	Татварын улсын байцаагч 13	УТОХГ	ХШХ	ТУАБ-уул уурхай
14	2	Татварын улсын байцаагч 14	УТОХГ	ЭБОУТХ	Олон улсын татвар
15	3	Татварын улсын байцаагч 15	УТОХГ	ЭБОУТХ	Нүүрс
16	4	Татварын улсын байцаагч 16	УТОХГ	ХТ	ТУАБ
17	5	Татварын улсын байцаагч 17	НТГ	ТТХХ	Бүртгэл, ҮХЭХАТ
18	6	Татварын улсын байцаагч 18	НТГ	Дүнжингарав	Нэг цэгийн үйлчилгээ
19	7	Татварын улсын байцаагч 19	БЗД	ЭСТ	Хөндлөн
20	8	Татварын улсын байцаагч 20	БЗД	ТОТ	Аж ахуйн нэгж
21	9	Татварын улсын байцаагч 21	БГД	ХШТ	Татан буугдах аж ахуйн нэгж
22	10	Татварын улсын байцаагч 22	БГД	ХШТ	Хяналт шалгалт
23	11	Татварын улсын байцаагч 23	БЗД	ТОТ	Аж ахуйн нэгж
24	12	Татварын улсын байцаагч 24	ХУД	ХШТ	ТУАБ
25	13	Татварын улсын байцаагч 25	СБД	ЭСТ	Хөндлөн
26	14	Татварын улсын байцаагч 26	СБД	ХШТ	Хяналт шалгалт
27	15	Татварын улсын байцаагч 27	ЧД	ТОТ	Аж ахуйн нэгж
28	16	Татварын улсын байцаагч 28	Өмнөговь аймаг	ТТХТ	ТУАБ
29	17	Татварын улсын байцаагч 29	Орхон аймаг	ТЗТ	ТУАБ

30	18	Татварын улсын байцаагч 30	Төв аймаг	ТТХТ	ТУБ-нэг цэгийн үйлчилгээ
31	19	Татварын улсын байцаагч 31	Төв аймаг	ХШТ	Хяналт шалгалт
32	20	Татварын улсын байцаагч 32	Дархан-Уул аймаг	ТОТ	Аж ахуйн нэгж
АЖИЛЛАХГҮЙ БАЙГАА					
33	1	Татварын улсын байцаагч 33	Жирэмсний амралттай		
34	2	Татварын улсын байцаагч 34	Жирэмсний амралттай		
35	3	Татварын улсын байцаагч 35	Жирэмсний амралттай		
36	4	Татварын улсын байцаагч 36	Гадаадад суралцаж байгаа		
37	5	Татварын улсын байцаагч 37	Нас барсан		
38	6	Татварын улсын байцаагч 38	Татварын албанаас гарсан		
39	7	Татварын улсын байцаагч 39	Татварын албанаас гарсан		
40	8	Татварын улсын байцаагч 40	Татварын албанаас гарсан		
41	9	Татварын улсын байцаагч 41	Татварын албанаас гарсан		
42	10	Татварын улсын байцаагч 42	Татварын албанаас гарсан		
		Судалгаа гаргасан ТУБ:	Ш.Ундраа		

A.1.6. ТЗУГ-ын санал

1. Хүний нөөц бэлтгэх төлөвлөгөө

А. Олон улсын татвартай холбоотойгоор хүний нөөцийн талаар баримталж буй бодлого байгаа юу? Байгаа бол ямар бичиг баримт, төлөвлөгөө хаана, хэзээ батлуулсан бэ?

- ТЕГ-ын даргын 2013.12.13-ны өдрийн 983 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний татварын албаны хүний нөөцийн бодлого”-ын баримт бичиг

- ТЕГ-ын даргын 2017.01.11-ний А/11 тоот тушаалаар батлагдсан “Монголын татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр”

.....

Б. Өнөөгийн байдал

I. Олон улсын татвараар мэргэшсэн боловсон хүчин хангалттай байгаа гэж үзэж байна уу? Тийм эсвэл үгүй бол яагаад гэдгийг тайлбарлана уу?

-Үгүй

Тайлбар: Олон улсын татвараар мэргэшсэн боловсон хүчин татварын албаны албан хаагчдын тоонд харьцуулахад хангалттай биш байдаг.

ТЕГ, УТОХГ, Нийслэл, дүүрэг, аймгийн татварын албадын хэрэгжүүлж байгаа чиг үүргээс хамаарч Олон улсын татвараар мэргэшсэн боловсон хүчин 40-оос доошгүй хувь байх шаардлагатай байдаг. Гэвч одоогоор 10 хувьд хүрэхгүй байгаа.

Олон улсын татвараар мэргэшсэн боловсон хүчин нь ажлын байраа өөрчилжхувийн байгуулагад шилжин ажиллах, мөн татварын алба, хэлтэс, тасагт сэлгэн ажиллах зэргээр шилжилт хөдөлгөөн хийгдэж байгаа

II. Одоогийн боловсон хүчин олон улсын татвар ногдуулалтаар ямар түвшинд мэргэшсэн байгаа вэ? (анхан, дунд, ахьсан түвшин?)

- Олон улсын татвараар мэргэшүүлэх боловсон хүчний анхан болон дунд түвшиний мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан цөөн албан хаагчид байгаа

III. Дээрх хүний нөөцийн төлөвлөгөө биелэгдсэн байгаа юу? Биелэлт нь хэдэн хувь гэж үзэж байна вэ?

- Олон улсын татвараар мэргэшүүлэх боловсон хүчний сургалт зохион байгуулагдаж байгаа боловч албан хаагчдын хамрагдах тоо хэмжээ хангалттай биш байна.

С. Хүний нөөцтэй холбоотой цаашдын төлөвлөгөө байгаа юу? Юун дээр анхаарах хэрэгтэй вэ?

- ТЕГ-ын даргын 2017.01.11-ний А/11 тоот тушаалаар батлагдсан “Монголын татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд төлөвлөгөө гарган ажиллана.

А.2. Олон улсын татвар ногдуулалтын суурийг цаашид хөгжүүлэх


А.2.1. Улсын төсвийн орлого хяналтын газар /УТОХГ/-т бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээс гадаад улсад шилжүүлсэн мөнгөн гүйлгээнд болон ногдуулсан суутган татварын талаар

УТОХГ-ын аж ахуйн нэгжүүдийн гадаад улсад шилжүүлсэн орлогод ногдуулсан татварын орлогын мэдээ

Үзүүлэлт	2013.12.31	2014.12.31	2015.12.31
Татвар төлөгчийн тоо	73	85	76
Орлого хүлээн авагч оршин суугч бус этгээдийн татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын тоо	96	130	120
Шилжүүлсэн орлогын дүн /тэрбум төг/	714.33	1025.65	1918.1
ААНОАТ-ын хуулийн дагуу ногдуулсан албан татварын дүн /тэрбум төг/	143.68	205.90	383.6
Давхар татварын гэрээний дагуу ногдуулсан албан татварын дүн /тэрбум төг/	22.79	46.21	144.8
Нийт ногдуулсан татварын дүн /тэрбум төг/	60.76	125.23	293.8

Эх сурвалж: ТЕГ-ын ЭУХ, УТОХГ

График-1. УТОХГ-ын аж ахуйн нэгжүүдийн гадаад улсад шилжүүлсэн нийт орлого болон орлогын хувийг ДТГ-тэй болон ДТГ-гүй улсуудаар ангилсан мэдээлэл



А.2.2. Хамгийн их орлого шилжүүлсэн улсуудын мэдээ


/тэрбум

төг/

Он	Орлого хүлээн авагч оршин суугч бус этгээдийн Татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын нэр	Шилжүүлсэн орлогын дүн	ААНОАТ-ын хуулийн дагуу ногдуулах албан татварын дүн	Давхар татварын гэрээний дагуу хөнгөлөлт эдэлсэн дүн	Давхар татварын гэрээний дагуу ногдуулсан албан татварын дүн	Нийт ногдуулсан татварын дүн
2013	Нидерланд	93.15	18.63	18.33	0.3	2.44
	Канад	90.39	18.79	15.7	3.08	8.33
	Хятад	84.12	16.82	13.85	2.97	3.88
	Нийт дүн	267.66	54.24	47.89	6.35	14.65
2014	Люксембург	314.97	62.99	33.38	29.62	33.37
	Япон	123.26	24.59	24.58	0	24.59
	Сингапур	116.99	23.4	16.31	7.08	7.42
	Нийт дүн	555.22	110.98	74.27	36.71	65.38
2015	Нидерланд	1,045.98	209.20	107.86	101.34	107.85
	Люксембург	304.50	60.90	31.50	29.40	31.45
	Сингапур	144.80	28.96	21.78	7.18	7.18
	Нийт дүн	1,495.28	299.06	161.14	137.92	149.48

Эх сурвалж: ТЕГ-ын ЭУХ, УТОХГ

УТОХГ-ын аж ахуйн нэгжүүдийн гадаад улсад шилжүүлсэн орлогод ногдуулсан татвар, үзүүлсэн хөнгөлөлтийн мэдээ /ДТГ-тэй болон ДТГ-гүй улсуудаар, тэрбум төгрөг/



А.3 Татвар хураалтын эрх зүйг боловсронгуй болгох талаар татварын багц хуульд тусгасан байдал

А.3.1. Татвар хураалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар татварын багц хуулийн төсөлд тусгасан байдал:

Татвар хураалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр дараах өөрчлөлтийг Татварын ерөнхий хуулийн төсөлд тусгасан:

1.1. Татварын өрийг тодорхойлох, хуулиар тогтоосон хугацаанд татвараа төлөөгүй татвар төлөгчид шаардлага хүргүүлэх, татвар төлөгч бүрт хүрсэн тэгш шударга байх зорилгоор нэхэмжлэх, шаардлага хүргүүлэх хугацааг тодорхой болгох зорилгоор татварын өр үүссэн хугацаанаас хойш 90 хоногт багтаан татварын өр төлөх нэхэмжлэх (цахим татварын системээр дамжуулан мэдэгдсэнээр татвар төлөгчид хүргүүлсэнд тооцно) хүргүүлнэ. Нэхэмжлэх хүргүүлснээс хойш 30 хоногт багтаан төлсөн тохиолдолд алданги төлөхгүй, дараагийн 60 хоногт төлбөл алданги төлнө;

1.2. Татварын өр нэхэмжилсэн хугацаанд төлж чадахгүй байгаа татвар төлөгчид хөнгөлөлт үзүүлж, сар бүр тодорхой хэмжээгээр төлөх нөхцөлтэйгээр татвар төлөх хугацааг 12 хүртэл сараар сунгах. Татвар төлөх график тохирно, татварын албанд учирч болох эрсдлийг тооцож хөрөнгө барьцаална. Энэ хугацаанд торгууль оногдуулахгүй, мөнгөний үнэ цэнийг тооцсон алданги ногдуулна, албадлагын арга хэмжээ авахгүй.

1.3. Татвар хураалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн бие даасан эрх олгох, өөрөөр хэлбэл татварын өрөө барагдуулахад санаачилга гаргахгүй байгаа татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг гаргуулах арга хэмжээг шүүхэд нэхэмжлэхгүйгээр бие дааж явуулах эрхтэй байна.

1.4. Татварын давуу эрхийг бий болгох, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Дампуурлын тухай хуулийн хүрээнд татварын авлага нь бусад авлагын эрхтэй адил түвшинд хураахаар байна. Тиймээс Татварын ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид “Албан татварыг бусад авлагаас давуу эрхтэйгээр хураана.” гэсэн зарчмын өөрчлөлтийг оруулж, Иргэний хуулийн заалтыг хүндэтгэн үзэхийн барьцаат авлага болон татварын авлага хоорондох зохицуулалт, өр барагдуулахдаа гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах зохицуулалтыг бий болгосон.

1.5. Татвар төлөх хоёрдогч үүргийн тогтолцоог бий болгох шаардлагатай гэж үзэж байгаа. Татварын өр барагдуулах ажиллагааг гүйцэтгэх явцад өртэй татвар төлөгч эд хөрөнгөө нуух, бусдад шилжүүлэх, эд хөрөнгөө ойр дотны хүндээ үнэгүй эсвэл маш бага үнээр худалдах зэргээр татвар төлөхөөс зугтах асуудал гардаг. Өртэй татвар төлөгчийн эд хөрөнгөөс татварын өрийг гаргуулах ажиллагааг хэрэгжүүлээд ч хураах ёстой татварын өрийн хэмжээнд хүрэлцэхгүй тохиолдолд хөрөнгийг үнэгүй эсхүл хэт хямд үнээр шилжүүлэн авсан этгээд буюу хамааралтай гуравдагч этгээдэд татвар төлөх хоёрдогч үүргийг хүлээлгэж татварын өрийг хураана.

1.6. Хөөн хэлэлцэх хугацааг зогсоох тогтолцоог нэвтрүүлэх, өөрөөр хэлбэл татвар хураахад зарцуулж байгаа цаг хугацаа, хүн хүч, зардлыг зохистой, үр өгөөжтэй байлгах, эдгээр үйл ажиллагааг хялбарчлах шаардлагын дагуу татварын өр нь түүнийг хураах зардлаас бага бол хүчингүй болгох, мөн татвар төлөгч төлбөрийн чадваргүй нь тогтоогдсон бол нөхцөл

байдал сайжрах хүртэл хугацаанд өр барагдуулах ажиллагааг түр түтгэлзүүлэх зохицуулалтыг тусгасан.

Татварын орлогын газар

2017-03-06

А.3.2 ТЕГ-ийн Өр дуудах төвийн тайлан, 2016

Тайлант хугацаанд Ногдол, өр дуудах төв нь Нийслэлийн 6 дүүрэг, 2 аймгийн 23,201 татвар төлөгчийн 10,7 тэрбум төгрөгийн ногдол, өр хүлээж авсанаас 16566 татвар төлөгчийн 6,4 тэрбум төгрөг барагдсан нь 71,4 хувийг эзэлж байна. Үүнээс 13745 татвар төлөгчийн өрийг бүрэн барагдуулж бага өртэй татвар төлөгчийн тоог 59,2 хувиар бууруулж ажилласан байна. 31,203 удаа холболт хийснээс 17,773 удаа амжилттай холбогдсон. Нийт татвар төлөгчийн 42% буюу 9,717 татвар төлөгчтэй холбогдож 4,6 тэрбум төгрөгийн ногдол, өрийг төлөх амлалт авсанаас 2016 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт амлалт авсан татвар төлөгчдийн 82 хувь нь буюу 8,006 татвар төлөгч 74 хувь буюу 3,5 тэрбум төгрөгийг ногдол, өрийг төлсөн байна. 2,101 татвар төлөгч 1,5 тэрбум төгрөгийн ногдол, өрийн дутууг төлөх амлалт өгөөгүй байна.

Нийт дуудлага хийвэл зохих татвар төлөгчдийн 40.5 хувь буюу 9,401 татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл буруу, холбогдох боломжгүй байгаагийн улмаас 5,1 тэрбум төгрөгийн ногдол, өрийн мэдээллийг хүргэж чадаагүй байна. Дуудлага бүрийн дараа дуудлагын үр дүнгийн мэдээллийг гарган татварын албадад хүргүүлж, бүртгэлийн мэдээлэл буруу татвар төлөгчдийн судалгааг гарган засуулахаар файлаар хүргүүлж ажилласан.

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

Хүний нөөцийг бэлтгэх төлөвлөгөө, Олон улсын

татварын асуудалд дэмжлэг үзүүлэх

**Монгол дахь төсөл (Олон улсын татварын асуудалд дэмжлэг үзүүлэх)
Хүний нөөцийг бэлтгэх төлөвлөгөө**

2017 он 7 сар, төслийн зөвлөх Ишигүро Хидеаки

I. Төслийн хүний нөөцийг бэлтгэх зорилт болон чухал асуудлууд

1. Үндсэн зорилт

ТЕГ-ын олон улсын татвар ногдуулалтын салбарт хүний нөөцийг бэлтгэхдээ холбогдох албан хаагчдын гүйцэтгэлийн чадавхйн түвшинг дор дурдсан байдлаар тодорхойлж, ТЕГ-ын сонгосон 40 байцаагчдыг анхан⇒дунд⇒гүнзгий түвшинд хүргэх зорилттойгоор хэрэгжүүлсээр ирсэн.


Төслийн эхний шатанд сургалтад хамрагсдыг дунд түвшинд хүргэсэн тул энэ удаад (төслийн 2-р шатанд) гүнзгийрүүлсэн түвшинд хүргэх зорилготойгоор хүний нөөцийг бэлтгэнэ.

Хүснэгт 1. Олон улсын татвар ногдуулалтын гүйцэтгэлийн чадварын түвшин


	Тогтолцооны мэдлэгт суурилсан чадавх	Тогтолцооны хэрэгжилтэнд суурилсан чадавх (Хяналт шалгалтын чадвар)
Түвшин	Өөрийн улсын олон улсын татвар ногдуулалтын дүрмийг үнэн зөв ойлгон тайлбарлах чадавх болон байвал зохих дүрмийн нэмэлт өөрчлөлтийг санал болгох чадавх	Өөрийн улсын олон улсын татвар ногдуулалтын дагуу бодит тохиолдолд татвар ногдуулах үндэслэлийг үнэн зөвөөр тодорхойлон үнэлэх чадавх
Анхан шат	Олон улсын татвар ногдуулалтын үндсэн хүрээ болон гэрээ, хууль тогтоомж, тушаалын тодорхой заалттай хамааруулан өөрийн улсын олон улсын татвар ногдуулалтын тогтолцоог судалж дүгнэх	Санхүү, төсөв, үйлчилгээ зэрэг олон улсын үндсэн арилжаа гүйлгээнд хамаарах тогтолцооны талаар ойлголт авч, тухайлсан тодорхой ажил, гүйлгээний тухайд татвар ногдуулах талаар зохих түвшинд шийдвэр гаргах
Дунд шат	OECD гэрээний заалт болон бусад улс орны олон улсын татвар ногдуулалтын тогтолцоотой харьцуулан өөрийн улсын олон улсын татвар ногдуулалтын тогтолцооны онцлогийг судалж дүгнэх	Ойлгоход хүндрэлтэй олон улсын арилжаа гүйлгээ болон төв ба охин компани, төв ба салбар компанийн хооронд хийгдэх олон улсын ажил, гүйлгээний талаар зөв тодорхойлж, тухайлсан тодорхой нэг ажил, гүйлгээний татвар ногдуулалтыг зөв тодорхойлдог болох.
Гүнзгий шат	Олон улсын татвар ногдуулалтын динамик орчинд өөрийн улсын олон улсын татвар ногдуулалтын асуудалтай талыг үнэн зөвөөр, хугацааны зохистой байдлаар ойлгож дүгнэн, бодит нөхцөл байдалд тохирсон өөрчлөлт шинэчлэлийг татварын тогтолцоонд оруулах талаар санал гаргах	Олон улсын ажил гүйлгээний дотор хүнд хэлбэрийн олон улсын татвараас зайлсхийх үйлдлийг үнэн зөвөөр тодруулж, тухайлсан тодорхой нэг ажил, гүйлгээний татвар ногдуулалтыг зөв тодорхойлдог болох.

2. Онолын мэдлэгийн чадварыг дээшлүүлэх

Онолын мэдлэгийн чадварыг дээшлүүлэх нь мөн чанартаа өөрийн улсын татварын тогтолцооны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадварыг нэмэгдүүлэхэд хэрэгтэй бөгөөд үүнийг дор дурдсан шат алхмын дагуу хэрэгжүүлдэг.



Үүний дотроос “байвал зохих хэлбэр” гэдэг нь үндсэндээ Япон Улсын олон улсын татвар ногдуулалтын тогтолцоо (зур.1) болон OECD загвар гэрээн дэх олон улсын загварт тулгуурлах боловч, үндэстэн дамнасан корпорацийн олон улсад татвараас зайлсхийх оролдлогоос сэргийлэхийн тулд олон улсын хамтын ажиллагааны талаас авч үзэн, 2015 оны 9 сард гарсан 15 үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс бүтсэн OECD/G20-ийн BEPS (Base Erosion and Profit Shifting : татварын суурийн гажуудал болон ашгийн шилжилт) буюу төслийн эцсийн тайланд тусгасан агуулгын дагуу хөгжиж буй оронд хамгийн хэрэгтэйгээс эхлэн авч үзэх шаардлагатай (зур. 2).




Зур.1 Япон Улсын олон улсын татвар ногдуулалтын тогтолцоо

Хүснэгт 2. BEPS-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө ба үр дүн (Хөгжиж буй улсад хамааралтай дарааллаар)

Түвшин	Үйл ажиллагаа	Үр дүн	Түвшин	Үйл ажиллагаа	Үр дүн	
Өндөр	4	Хүүг зардалд тусган татварын суурийг гажуудуулахыг хязгаарлах	Дунд	8	Үнийн үүсэлтэд нийцсэн үнэ шилжилтийг хийх: Биет бус хөрөнгө	Үнэ шилжилтийн гарын авлага, татварын загвар гэрээ
Өндөр	6	Татварын гэрээг урвуулан ашиглахаас сэргийлэх	Дунд	9	Үнийн үүсэлтэд нийцсэн үнэ шилжилтийг хийх: Эрсдэл ба үндсэн хөрөнгө	Үнэ шилжилтийн гарын авлага, татварын загвар гэрээ
Өндөр	7	Төлөөний газрыг тодорхойлуулахаас санаатай зайлсхийхээс сэргийлэх	Дунд	12	Татвар төлөгчдөд татварын төлөвлөлтөө тайлагнах шаардлага тавих	Дотоодын дүрэм
Өндөр	10	Үнийн үүсэлтэд нийцсэн үнэ шилжилтийг хийх: Бусад эрсдэл өндөртэй ажил гүйлгээ	Дунд	14	Харилцан тохиролцоог үр өгөөжтэйгөөр хэрэгжүүлэх	Татварын загвар гэрээ
Өндөр	11	BEPS-ийн талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх арга ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэх	Сул	2	Сөрөг үр дагавартай холимог зохицуулалт (Hybrid mismatch)-ийн нөлөөг хүчингүй болгох	Дотоодын дүрэм, татварын загвар гэрээ
Өндөр	13	Үнэ шилжилтийн татварыг документацижуулах асуудлыг дахин авч үзэх	Сул	3	Гадаад улсад байх охин компанийн ашгийг нэгтгэн тооцох тогтолцоог чангатгах	Дотоодын дүрэм
Дунд	1	Цахим ажил гүйлгээнд татвар ногдуулах	Сул	15	Олон талт гэрээг дэмжих	Холбогдох олон улсын нийтлэг хууль болон татварын асуудлын тайлан
Дунд	5	Хор хөнөөлтэй татварын асуудалтай үр дүнтэйгээр ажиллаж, тунгалаг байдал болон бүрэлдэхүүн хэсгийн талаар авч үзэх	OECD (2014), Part 1 of A Report to G20 Development Working Group on the Impact of BEPS in Low Income Countries, Paris.			

3. Хяналт шалгалт хийх чадварыг бэхжүүлэх

Татвар ногдуулалтыг зохистойгоор хэрэгжүүлэхийн тулд татварын хяналт шалгалтын байцаагчдын хуулийн гурван шатлалт аргын процессийг (зураг 2) алдаа мадаггүй, үр дүнтэйгээр хэрэглэдэг болгох шаардлагатай. Төслийн явцад төслийн нэгдүгээр үе шатыг үргэлжлүүлэн жишээн дээр суралцах (case study) бөгөөд энэхүү ажлыг хяналт шалгалт хийх чадварыг дээшлүүлэх үндсэн арга барил болгон Монгол улсад үүссэн олон улсын татвар ногдуулалтын хяналт шалгалтын ярвигтай, төвөгтэй жишээнүүд дээр ажиллана. Ингэхдээ сургалтад оролцогчид хооронд хэлэлцүүлэг хийж ① тухайн хэргийн бодит байдлыг үнэн зөвөөр дүгнэж, үнэлгээ хийж чадаж байгаа эсэх, ② нийцэх хууль тогтоомжийн заалтыг зөв сонгож байгаа эсэх, ③ тэдгээрт хийх тайлбар үндэслэлтэй байгаа эсэх, ④ гаргасан дүгнэлт тохирч байгаа эсэхийг харилцан баталгаажуулсанаар олон улсын татвар ногдуулалтад холбоотой хууль эрх зүйн үндэслэлтэйгээр дүгнэлт хийх чадвар бий болж үүгээр дамжуулан татварын хяналт шалгалтын чадавхыг бэхжүүлнэ гэж үзэж байна.



Зураг 2 Хуулийн гурван шатлалт аргын зураглал


Жишээн дээр суралцах ажлыг үндсэндээ доорх дарааллаар явуулна. Сургалт тус бүрийн өмнө 4-5 багт хуваан, илтгэл тавьж хэлэлцүүлэг зохион байгуулна.



II Төслөөр хэрэгжүүлэх хүний нөөцийг бэлтгэх хөтөлбөр

Төсөл хэрэгжих хугацаанд (3 жил) зохион байгуулах Олон улсын татвар ногдуулалтаар мэргэших байцаагчдад зориулсан хүний нөөцийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг одоогийн байдлаар гаргав. Үндсэндээ төслийн нэгдүгээр шатны хүний нөөц бэлтгэх сургалтын хөтөлбөр дээр үндэслэн гаргасан бөгөөд төслийн хоёрдугаар шатанд шинээр сонгогдсон ОУТН-аар мэргэших байцаагчдад зориулан өмнөх ОУТН-аар мэргэшсэн байцаагчид хоорондын мэдлэгийн түвшний ялгааг арилгах үүднээс дунд түвшний “Олон улсын татвар ногдуулалтын бэлтгэл сургалт”-ыг оруулж өгсөн.

Олон улсын татвараар мэргэших байцаагчдад зориулсан сургалтын төлөвлөгөө



- ОУТН бэлтгэл сургалт: Шинээр сонгогдсон байцаагчид болон өмнөх ОУТ мэргэшсэн байцаагчид хоорондын түвшингийн ялгааг арилгах үүднээс төслийн 1-р шатанд хэрэгжүүлсэн сургалтын агуулгаар зохион байгуулагдах сургалт
- ОУТН гүнзгий шатны сургалт: ОУТН мэргэших байцаагчдын чадварыг гүнзгий түвшинд хүргэх чухал сургалт
- ОУТН тусгай сургалт: ОУТН мэргэших байцаагчдын ажил дээрх ОУТН-ын сургалтын үр дүнг харж, дүгнэлт өгөх сургалт бөгөөд Япон улсад хийх сургалтад хамрагдах сонголтод нөлөөлөх сургалт
- Япон улсад зохион байгуулах татварын удирдлагын сургалт: Сонгогдсон байцаагч нарт гүнзгий шатны мэдлэг олгох сургалт
- Давтан сургалт: Сонгогдоогүй үлдсэн байцаагч нарт зориулан Япон улсад зохион байгуулсан сургалтын агуулгаар хийх сургалт
- Хамт олны хэлэлцүүлэг: Япон улсад хийсэн сургалт болон давтан сургалтад хамрагдсан байцаагчдын бодит үр дүнг нэгтгэн үнэлэх

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

**Олон улсын татвартай холбоотой сургалтын
материал, хөтөлбөр**


**Олон улсын татвар ногдуулалтын бэлтгэл сургалт
(Олон улсын татвараар мэргэших шинээр сонгогдсон байцаагч нарт
зориулсан сургалт)**

(2017.8.21-2017.8.25)

Он сар өдөр	Цаг	Сургалтын агуулга	Хариуцсан багш
2017.8.21 (Даваа)	09:00-10:30	Олон улсын татвар ногдуулалтын үндэс	Төслийн зөвлөх Ишигүро Хидээки
	10:40-12:00		
	13:00-14:30	Төлөөний газар (Жишээн дээр суралцах)	
	14:40-16:00		
2017.8.22 (Мягмар)	09:00-10:30	Олон улсын татварын гэрээ	Төслийн зөвлөх Кодера Тошинари
	10:40-12:00		
	13:00-14:30	Олон улсын татварын гэрээ	
	14:40-16:00		
2017.8.23 (Лхагва)	09:00-10:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Үндсэн онол)	Төслийн зөвлөх Кодера Тошинари
	10:40-12:00		
	13:00-14:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Үндсэн онол)	
	14:40-16:00		
2017.8.24 (Пүрэв)	09:00-10:30	Олон улсын татвараас зайлсхийх (Жишээн дээр суралцах)	Төслийн зөвлөх Ишигүро Хидээки
	10:40-12:00		
	13:00-14:30	Олон улсын татвараас зайлсхийх (Жишээн дээр суралцах)	
	14:40-16:00		
2017.8.25 (Баасан)	09:00-10:30	Урьдчилсан үнийн гэрээ, Харилцан тохирох журам, Мэдээлэл харилцан солилцох	Төслийн зөвлөх Кодера Тошинари Төслийн зөвлөх Кодера Тошинари Ишигүро Хидээки
	10:40-12:00		
	13:00-14:30	Асуулт хариулт	
	14:40-16:00		

Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийн жагсаалт

№	Нэрс	Харьяа нэгж
1	Х.Сувд-Эрдэнэ	ТЕГ-ын Төрийн захиргааны удирдлагын газрын ТУБ
2	Ж.Цэрэнцоо	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
3	А.Сувдаа	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
4	Г.Энхжин	ТЕГ-ын Татварын орлогын газрын ТУБ
5	Ц.Баярмаа	ТЕГ-ын Дотоод аудитын газрын ТУБ
6	Б.Ариунгэрэл	ТЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ТУБ
7	Н.Туул	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
8	Б.Золзаяа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
9	С.Гүнжинлхам	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
10	Л.Батцэцэг	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харила хэлтсийн дарга
11	Г.Бямбасүрэн	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
12	П.Отгонсүрэн	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
13	Н.Болорчимэг	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
14	Н.Мөнхдаваа	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
15	Н.Хандхүү	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
16	Ц.Ишжамц	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
17	Б.Төгсжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
18	Ш.Энхжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
19	Ё.Мөнхбат	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
20	Б.Халиун	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
21	Ш.Батзаяа	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
22	Б.Уранцэцэг	УТОХГ-ын Эрсдэл, статистикийн хэлтсийн ТУБ
23	Ц.Түвшинбаяр	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
24	Г.Банзрагч	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
25	Х.Алтанхүү	УТОХГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
26	О.Цэнд-Аюуш	НТГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтэс
27	Б.Бат-Эрдэнэ	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
28	Ч.Лхамрагчаа	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
29	Д.Солонго	СБД-ын Татварын хэлтсийн ТУБ
30	Ц.Ундармаа	СХД-ын Татварын хэлтсийн ТУБ
31	С.Наранбаатар	Дорнод аймгийн Татварын хэлтсийн ТУБ
32	Ц.Өнөрмөнх	Орхон аймгийн Татварын хэлтсийн ТУБ
33	С.Дүүбаяр	Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн ТУБ
34	Л.Мөнхтуул	ТЕГ-ын Хуулийн хэлтсийн ТУБ



Олон улсын татвар ногдуулалтын үндэс *Basis of International Taxation*

1



Агуулга

- СЭДЭВ 1 Олон Улсын татварын тогтолцоо
- СЭДЭВ 2 Дотоодын хуулиар өөрийн улсын татвар ногдуулалтын эрхийг баталгаажуулах
- СЭДЭВ 3 Дотоодын хуулиар олон улсын татвараас зайлсхийхээс сэргийлэх
- СЭДЭВ 4 Дотоодын хуулиар давхар татвар ногдуулалтыг халах
- СЭДЭВ 5 Япон Улсын татварын гэрээ

2

СЭДЭВ 1


ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО

Outline of International Taxation System


3

Япон улсын олон улсын татвар ногдуулалтын тогтолцоо

International Taxation System of Japan




4



СЭДЭВ 2
ДОТООДЫН ХУУЛИАР ӨӨРИЙН
УЛСЫН ТАТВАР НОГДУУЛАЛТЫН
ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ
Securement of home country's tax
jurisdiction by domestic laws

5



Байнгын байрлах улсын эрх ба орлогын эх
үүсвэрийн улсын эрх
Residence Jurisdiction and Source Jurisdiction

- Байнгын оршин суух улсын эрх
 - Орлого олж буй этгээдтэй холбоотой хүмүүсийг (nexus) үндэслэл болгоно.
 - Дэлхий даяарх орлогод (world-wide income) татвар ногдуулна.
- Орлогын эх үүсвэрийн улсын эрх
 - Орлогыг тооцох үйл ажиллагаатай биет холбоог үндэслэл болгоно.
 - Дотоодын эх үүсэртэй орлогод (domestic source income) татвар ногдуулах.

6

Татвар төлөгчийн ангилал ба татвар ногдуулалтын хүрээ

Categories of Taxpayers and Scope of Taxation of Japan

Татвар төлөгчийн ангилал		Татвар ногдох орлогын хүрээ	
Иргэн	Оршин суугч	Дотоодод хаягтай иргэн эсвэл, өнөөг хүртэл тасралтгүй 1-ээс дээш жилээр хаяг байршилтай байсан иргэн	Дэлхий даяарх орлого (Дотоодод эх үүсвэртэй орлого + гадаад эх үүсвэртэй орлого)
	Түр оршин суугч	Японы иргэншилгүй бөгөөд өнгөрсөн 10 жилд дотоодод хаяг байршилтай байсан хугацаа нь 5 аас доош жил байсан иргэн	Дотоодод эх үүсвэртэй орлого + гадаадад эх үүсвэртэй орлого (Зөвхөн дотоодод төлсөн, дотоодод шилжүүлсэн дүнд)
	Оршин суугч бус	Оршин суугчаас бусад иргэн	Зөвхөн дотоодын эх үүсвэртэй орлогод
ААН	Дотоодын ААН	Дотоодод төв компани, эсвэл үндсэн ажлын байртай ААН	Дэлхий даяарх
	Гадаадын ААН	Дотоодын ААН-ээс бусад ААН	Зөвхөн дотоодын эх үүсвэртэй орлогод

7

Эх үүсвэрийн дүрэм ба татвар ногдуулах арга

Source Jurisdiction and Taxation Methods

Дотоодын хөрөнгө оруулалтын ангилал	Үйл ажиллагааны ангилал	Татвар ногдуулах хэлбэр	Татвар төлөх хэлбэр	Татвар ногдуулалтын жишиг
Шууд хөрөнгө оруулалт (direct)	Актив бизнесийн үйл ажиллагаа (positive)	Нэгдсэн татвар ногдуулалт (comprehensive)	Тайлагнан төлөх (self-assessment)	Цэвэр (net)
Портфелийн хөрөнгө оруулалт (portfolio)	Пассив хөрөнгө оруулалт (passive)	Суутган татвар ногдуулалт (withholding)	Суутган татвар (withholding)	Нийг (gross)

- ① Дотоод эх үүсвэртэй орлогын үүсэлтийн шалтгаан болох дотоод хөрөнгө оруулалтын дотроос, 「Хяналт」 (control) –ыг дагалдах хөрөнгө оруулалтыг шууд хөрөнгө оруулалт, тийм бусыг портфелийн хөрөнгө оруулалт гэнэ.
- ② Оршин суугч бус гадаадын ААН –ын дотоодод байрлах салбар 「Төлөөний газар PE : permanent establishment」 нь тухайн улстай 「холбоо уялдаа (nexus)」 хүчтэй бөгөөд төлөөний газраар дамжуулан эрхлэх бизнесийн үйл ажиллагаанд шууд хөрөнгө оруулалт байдлаар нэгдсэн татвар ногдуулалт хийгдэнэ.

8



Төлөөний газар

Permanent Establishment

- Тодорхойлолт

“Төлөөний газар” гэдэг нь ААН-ын үйл ажиллагаа бүхлээрээ болон хэсэгчилэн явагддаг бизнесийн тогтсон байршлыг хэлнэ. (OECD Model Tax Convention, Article 5, para.1)

the term “permanent establishment” means a fixed place of business through which the business of an enterprise is wholly or partly carried on. (OECD Model Tax Convention, Article 5, para.1)

- Жишиг бус

Зөвхөн бараа бүтээгдэхүүний хадгалалт, үзүүлэн, дамжуулалтанд зориулсан байгууламжийн ашиглалт, бэлтгэл болон нөөцийн шинж чанартай (a preparatory or auxiliary character) үйл ажиллагааны зорилготой тохиолдолд, төлөөний газар PE болохгүй. (ditto, para.4)



Төлөөний газар

Permanent Establishment

- «Төлөөний газаргүй бол татвар ногдуулалт хийхгүй байх» зарчим

Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан бизнес эрхлээгүй тохиолдолд уг аж ахуйн нэгжийн ашигт зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна.

(OECD Model Tax Convention, Article 7, para.1, 1st sentence)

profits of an enterprise of a Contracting State shall be taxable only in that State unless the enterprise carries on business in the other Contracting State through a permanent establishment situated therein.

(OECD Model Tax Convention, Article 7, para.1, 1st sentence)



Төлөөний газар

Permanent Establishment

■ Жишээ (from OECD Model Tax Convention, Article 5)

▪ Салбар төлөөний газар PE

Менежментийн байрлал, салбар, оффис, үйлдвэр, урлан, уул уурхай, газрын тос хийн худаг, байгалийн ашигт малтмал олзворлох баяжуулах газар
a place of management, a branch, an office, a factory, a work-shop, and a mine, an oil or gas well, a quarry or any other place of extraction of natural resources.

▪ Барилгын төлөөний газар PE


Барилга ба барилгын талбай эсвэл суурилуулалт хийснээс хойш 12 сараас дээш хугацаа болсон байгууламж

A building site or construction or installation project constitutes a permanent establishment only if it lasts more than twelve months.

▪ Төлөөлөгч төлөөний газар PE

ААН-ыг төлөөлөн ажилласан хувь хүн (бие даасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад), ААН-ийн нэрийн өмнөөс гэрээ хийх эрхтэй гэрээлэгчийн тухайд, тухайн ААН-ийг тус улсад өөрийн төлөөний газартай гэж үзнэ.

where a person (excluding independent agents) is acting on behalf of an enterprise and has, and habitually exercises, in a Contracting State an authority to conclude contracts in the name of the enterprise, that enterprise shall be deemed to have a permanent establishment in that State.



Манай улсын хуулиар төлөөний газрыг тодорхойлсон нь

Permanent Establishment under Tax Laws of Japan

□ Салбар төлөөний газар

Салбар, үйл ажиллагааны газар, оффис, үйлдвэр, агуулах, уурхай, чулууны орд гэх мэт байгалийн ашигт малтмал олборлох газар гэх мэт (Гэхдээ, хөрөнгө худалдах, хадгалах зорилгоор ашигладаг газар, эсвэл сурталчилгаа, мэдээлэл өгөх, зах зээлийн судалгаа, суурь судалгаа, зөвхөн бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй үйл ажиллагаанд ашигладаг газар энд хамаарахгүй.)

□ Барилгын төлөөний газар

Барилга, угсралт, суурилуулалтын үйл ажиллагаа, мөн барилгын хяналтын үйл ажиллагааг 1-ээс дээш жилээр эрхэлж буй бол тухайн байршил.

□ Төлөөлөгч төлөөний газар

Дотоодод үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах эрхтэй этгээд бөгөөд энэ эрхээ байнга хэрэгжүүлдэг этгээд (Байнгын төлөөлөгч), бараа бүтээгдэхүүнээрх хөрөнгийг хадгалж, үйлчлүүлэгчдэд дамжуулдаг этгээд (Агуулахтай төлөөлөгч), эсвэл захиалга хүлээн авах процессийн хамгийн чухал хэсгийг гүйцэтгэдэг этгээд (Захиалга хүлээн авах төлөөлөгч).

(Гэхдээ, тухайн үйл ажиллагаатай холбоотой ажлыг бие даан энгийн аргаар гүйцэтгэдэг төлөөлөгчийг (бие даасан эрх бүхий төлөөлөгч) орохгүй)

Төлөөний газарт хамаарах ашиг *Profits Attributable to PE*

■ Нийт орлогын зарчим (entire income principle)

Дотоодод төлөөний газартай тохиолдолд, дотоодод эх үүсвэртэй орлогын тухайд, оршин суугч ба дотоодын ААН-ын адилаар нийт орлогыг төлөөний газартай нэгтгэн тооцох арга

■ Хамааруулах орлогын зарчим (attributable income principle)


Дотоодод төлөөний газартай тохиолдолд, дотоодод эх үүсвэртэй орлогын тухайд, зөвхөн төлөөний газарт хамаарах орлогыг оршин суугч ба дотоодын ААН-ын адилаар төлөөний газрын орлого болгон нэгтгэн тооцох арга

Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан байдлаар бизнес эрхэлж байвал энэхүү зүйлийн 2 дахь заалтын дагуу төлөөний газарт хамаарах ашигт Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно. (ditto, 2nd sentence)

If the enterprise carries on business as aforesaid, the profits that are attributable to the permanent establishment in accordance with the provisions of paragraph 2 may be taxed in that other State. (OECD Model Tax Convention, Article 7, para.1, 2nd sentence)

13

Төлөөний газарт хамаарах ашиг *Profits Attributable to PE*



14

Төлөөний газарт хамаарах ашиг *Profits Attributable to PE*


AOA (Authorized OECD Approach)

Энэхүү зүйл болон [23 A], [23B] дугаар зүйлийн хувьд Хэлэлцэн тохирогч Улс тус бүрт 1 дэх заалтад дурдсан төлөөний газарт хамаарах ашиг гэж уг төлөөний газар нь адил эсхүл төстэй нөхцөлд, адил эсхүл төстэй үйл ажиллагаа эрхэлдэг тусдаа, бие даасан аж ахуйн нэгж байсан тохиолдолд, ялангуяа аж ахуйн нэгжийн бусад хэсгүүдтэй харьцахдаа олж болох байсан, аж ахуйн нэгжээс төлөөний газраараа болон аж ахуйн нэгжийн бусад хэсгээр дамжуулан гүйцэтгүүлсэн ажил үүрэг, ашигласан хөрөнгө, хүлээсэн эрсдэлийг бодолцсон ашгийг хэлнэ. (OECD Model Tax Convention, Article 7, para.2)

For the purposes of this Article and Article [23 A] [23B], the profits that are attributable in each Contracting State to the permanent establishment referred to in paragraph 1 are the profits it might be expected to make, in particular in its dealings with other parts of the enterprise, if it were a separate and independent enterprise engaged in the same or similar activities under the same or similar conditions, taking into account the functions performed, assets used and risks assumed by the enterprise through the permanent establishment and through the other parts of the enterprise. (OECD Model Tax Convention, Article 7, para.2)

15

Төлөөний газарт хамаарах ашиг *Profits Attributable to PE*



16

Япон улсын гадаадын ААН-д ногдуулдаг татвар

Taxation of Japan on Foreign Corporations (until March, 2016)

Орлогын төрөл	Гадаадын ААН-ын ангилал	Дотоодод РЕ-тэй ААН		Дотоодод РЕ-гүй ААН	Суутган татварын хувь
		Салбар РЕ	Барилгын РЕ, эсвэл төлөөлөгч РЕ		
① Үйл ажиллагааны орлого					
② Хөрөнгийн менежмент, хадгалалт					Байхгүй (ерөнхий)
③ Хөрөнгө шилжүүлсний орлого (Зөвхөн YXX)					
④ Ажил үйлчилгээ үзүүлсний орлого					
⑤ YXX түрээсийн орлого					20.420%
⑥ Бусад дотоод эх үүсвэртэй орлого					20.420%
⑦ Хүү					15.315%
⑧ Ноогдол ашиг					20.420%
⑨ Зээлийн хүү					20.420%
⑩ Роялти					20.420%
⑪ Сурталчилгааны орлого					20.420%
⑫ Амьдралын даатгалын тэтгэмж					20.420%
⑬ Хугацаат хуримтлал					15.315%
⑭ Хоршооллын гэрээний ашгийн хуваарилалт					20.420%

Тодруулсан хэсэг нь ААНОАТ ногдуулалтын хамрах хүрээ (нэгдсэн татвар ногдуулалт)

Гадаадын ААН-ын төвөөс хийсэн портфел хөрөнгө оруулалтыг шууд хөрөнгө оруулалт гэж тооцон татвар ногдуулах

Дотоодын үйл ажиллагаанд хамаарах

Эх үүсвэр хуваалтын татвар ногдуулалт

17

Япон улсын гадаадын ААН-д ногдуулдаг татвар

Taxation of Japan on Foreign Corporations (From April, 2016)

Орлогын төрөл	Гадаадын ААН-ын ангилал	Дотоодод РЕ-тэй ААН		Дотоодод РЕ-гүй ААН	Суутган татварын хувь
		РЕ-д хамаарах орлого	РЕ-д хамаарахгүй орлого		
Үйл ажиллагааны орлого					
② Хөрөнгийн менежмент, хадгалалт					Байхгүй (ерөнхий)
③ Хөрөнгө шилжүүлсний орлого (Зөвхөн YXX)					
④ Ажил үйлчилгээ үзүүлсний орлого					20%
⑤ YXX түрээсийн орлого					20%
⑥ Бусад дотоод эх үүсвэртэй орлого					байхгүй
⑦ Хүү					15%
⑧ Ноогдол ашиг					20%
⑨ Зээлийн хүү					20%
⑩ Роялти					20%
⑪ Сурталчилгааны орлого					20%
⑫ Амьдралын даатгалын тэтгэмж					20%
⑬ Хугацаат хуримтлал					15%
⑭ Хоршооллын гэрээний ашгийн хуваарилалт					20%

① РЕ-д хамаарах орлого

Тусдаа суутган татвар ногдуулалт

18



СЭДЭВ 3
ДОТООДЫН ХУУЛИАР ОЛОН
УЛСЫН ТАТВАРААС
ЗАЙЛСХИЙХЭЭС СЭРГИЙЛЭХ
Prevention of international tax avoidance by
domestic laws

19




Гадаадын охин компанийн нэгдсэн
татвар ногдуулалтын тогтолцоо
Anti-Tax Havens Rules

- Асуудал
Манай улсын дотоодын ААН нь татварын ачаалал хэт багатай улсын охин компаниар дамжуулан, хил дамнасан ажил гүйлгээ хийн, хил дамнасан шууд хийгдсэн ажил гүйлгээтэй харьцуулаад татварын ачааллаа зүй бусаар хөнгөвчилөн, зайлсхийснээр дотоодод ноогдох ёстой татвараас чөлөөлөгдөх бодит байдал үүсдэг.
- Авах арга хэмжээ
 - Татварын хувь хэмжээ нь тодорхой түвшнээс бага (20%) гадаад улсад байх охин компанийн (тухайлсан гадаадын охин компани) орлогыг, дотоодын ААН-ын орлогод тооцон нэгдсэн байдлаар татвар ногдуулдаг тогтолцоо. (Компаниар нь нэгтгэн тооцож татвар ногдуулах)
 - Хөрөнгийн менежментээр олсон орлогын тухайд, татвараас чөлөөлөх нөхцөлийг хангаж байсан ч, тухайн үнийн дүнг нэгтгэн тооцож татвар ногдуулна. (Хөрөнгийн шинжтэй орлогын нэгдсэн татвар ногдуулалт)

20

Гадаадын охин компанийн нэгдсэн татвар ногдуулалт *Anti-Tax Havens Rules*



21

Гадаадын охин компанийн нэгдсэн тооцооны татварын тогтолцоо *Anti-Tax Havens Rules*

- Татвараас чөлөөлөх нөхцөл
- 1. **Үйл ажиллагааны жишиг** (Үндсэн үйл ажиллагаа нь хувьцаа эзэмших гэх мэт тогтсон үйл ажиллагаа бус байх)
- 2. **Бодит байдлын жишиг** (Төв компанийн байрлах улс оронд үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай ажлын байртай байх)
- 3. **Удирдлага, хяналтын жишиг** (Төв компанийн байрлах улс оронд үндсэн үйл ажиллагааны менежмент, удирдлага, хяналтыг өөрсдийн хүчээр хийдэг байх)
- 4. **Дараах аль нэг жишиг**
 - (1) **Байрлах улсын жишиг** (Төв компанийн байрлах улс оронд голлон үйл ажиллагаа эрхэлдэг байх)
 - ※ Дараахаас бусад салбарт ашиглах
 - (2) **Харилцан хамааралгүй этгээдийн жишиг** (Харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ажил гүйлгээний хувь хэмжээ 50%-иас илүү байх)
 - ※ Бөөний худалдаа, банк, санхүү, санхүүгийн бүтээгдэхүүний арилжаа, даатгал, загас агнуур, агаарын тээвэрт ашиглана.

22

Үнэ шилжилтийн татварын тогтолцоо

Transfer Pricing Rules

- Асуудал


ААН нь гадаад дахь харилцан хамааралтай ААН-тэй хийсэн ажил гүйлгээний үнийг (шилжсэн үнэ) энгийн үнэтэй ялгаатайгаар тогтоосон тохиолдолд, нэг талын (манай улсын) олох ашгийг нөгөө тал руу шилжүүлэх боломжтой болно.

- Авах арга хэмжээ

ААН-ын гадаад дахь харилцан хамааралтай ААН-тэй хийсэн ажил гүйлгээний үнийг (Үнэ шилжилт) энгийн ажил гүйлгээний үнээр (Сунгасан гарын үнэ = ALP : Arm's Length Price) –ээр хийгдсэн гэж үзэн, орлогыг тооцон, татвар ногдуулдаг тогтолцоо.

Үнэ шилжилтийн татварын тогтолцоо

Transfer Pricing Rules



Үнэ шилжилтийн татварын тогтолцоо

Transfer Pricing Rules

<Япон улсын сунгасан гарын үнийг тооцох аргууд>

Үндсэн 3 арга	Харьцуулагдах үнийн арга CUP: Comparative Uncontrolled Price Method	Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээтэй адил төрлийн бараа материалыг харилцан хамааралгүй этгээд хооронд ижил нөхцлийн үндсэн дээр худалдан авч борлуулах үнийг жишиг болгон тооцдог арга
	Дамжуулан борлуулах үнийн арга RP: Resale Price Method	Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээнд хамаарах бараа материалыг худалдан авагчийн харилцан хамааралгүй этгээдэд борлуулсан (дахин борлуулсан үнэ) үнээс ердийн ашгийг (борлуулалтын нийт ашгийн хувь) хасч тооцсон үнийг жишиг болгон тооцдог арга
	Өртөг дээр нэмэх арга CP: Cost Plus Method	Гадаадын харилцан хамаарал бүхий ажил гүйлгээнд хамаарах бараа материалыг борлуулагчийн харилцан хамааралгүй этгээдээс худалдан авсан үндэс ердийн ашгийг нэмж тооцсон үнийг жишин болгон тооцдог арга
Бусад арга	Ажил гүйлгээний цэвэр ашгийн арга TNMM: Transactional Net Margin Method	Харилцан хамааралгүй этгээд хоорондын ажил гүйлгээгээр олсон үйл ажиллагааны ашгийн түвшинд үндэслэн RP, PS аргатай ижил аргаар тооцсон үнийг жишиг болгон тооцдог арга
	Ашиг хуваах арга PS: Profit Split Method	Дотоодын ААН болон гадаадын харилцан хамааралтай этгээдийн харилцан хамаарал бүхий ажил гүйлгээнд хамаарах үйл ажиллагааны ашгийг нийлүүлэн тооцож, тухайн ашиг үүсэхэд нөлөөлсөн талуудын оролцооны шалгуурт үндэслэн хуваариж, ААН болон гадаадын харилцан хамааралтай этгээдэд хамааруулах арга <ul style="list-style-type: none"> ┌ Харьцуулан ашиг хуваах арга (Comparative PS Method) ├ Оролцооны байдалд үндэслэн ашиг хуваах арга (Contribution PS Method) └ Үлдэгдэл ашиг хуваах арга (Residual Profit PS Method)

25

Нимгэн капиталын татварын тогтолцоо

Thin Capitalization Rules

■ Асуудал


ААН нь гадаад дахь харилцан хамааралтай ААН-ээс санхүүжилт авахдаа, хөрөнгө оруулалтыг (Харилцан хамааралтай ААН-д хуваасан ноогдол ашгийг зардалд тооцохгүй) зээлийн хэмжээг (Харилцан хамааралтай ААН-д төлсөн хүүг зардалд тооцох боломжтой) ихэсгэвэл манай улсад төлөх татварын ачааллаа бууруулах боломжтой.

■ Авах арга хэмжээ

Хөрөнгө оруулалт ба зээлийн харьцаа нь тодорхой хувь хэмжээнээс (зарчмын хувьд гадаад дахь төв компанийн үндсэн хөрөнгийн эзэмшлийн хувиас 3 дахин) хэтэрсэн хэсгийг зардалд тооцохыг зөвшөөрөхгүй байх.

26

Нимгэн капиталын татварын тогтолцоо *Thin Capitalization Rules*



27

Хэт өндөр хүүгийн төлбөрийн татварын тогтолцоо *Earnings Stripping Rules*

■ Асуудал

ААН-ын орлогын тооцоонд хүүгийн төлбөр нь зардалд тусгагддаг болохыг ашиглан, харилцан хамааралтай этгээд хооронд зээлийн гэрээг зорилготойгоор байгуулан, харилцан хамааралтай этгээдийн нийт ашиг алдагдалд нөлөөлөхгүйгээр хэт их хүүгийн төлбөрийг зардалд тусгаснаар татварын ачааллаа бууруулах гэсэн татвараас зайлсхийх үйлдэл хийх боломжтой болно.

■ Авах арга хэмжээ


■ Харилцан хамааралтай этгээдэд төлсөн цэвэр хүүгийн төлбөрийн дотроос зохицуулсан орлогын дүнгийн тодорхой хувиас (50%) давсан хэсгийг тухайн тайлант үеийн зардалд тусгахгүй.

■ Ойрын үед, хөгжингүй орнуудад татварын гэрээндээ хүүгийн эх үүсвэрийн улс орны татвараас чөлөөлөх заалтыг оруулж, хүүгийн төлбөрийг зардалд тусгахад хязгаарлалт хийх чиглэлийг баримталж байна.

28

Хэт өндөр хүүгийн төлбөрийн татварын ТОГТОЛЦОО

Earnings Stripping Rules



СЭДЭВ 4

ДОТООДЫН ХУУЛИАР ДАВХАР ТАТВАР НОГДУУЛАЛТЫГ ХАЛАХ

Elimination of double taxation by domestic laws



Гадаад улсын татварыг хөнгөлөх

ТОГТОЛЦОО

Foreign Tax Credit (FTC) System

- Ач холбогдол
 - Олон улсын хэмжээнд давхар татвар ногдуулалтыг халах зорилгоор дотоодын ААН-ийн гадаад улс дахь салбарын (Төлөөний газар PE) тухайн гадаад улсад төлсөн татварыг, гадаадад олсон орлогод ногдуулах манай улсын ААНОАТ-ын хүрээнд хөнгөлөлт үзүүлэхийг зөвшөөрөх тогтолцоо юм.
 - Хөгжиж буй улстай байгуулсан татварын гэрээнд гадаадын татварын хэмнэлт хөнгөлөлтийг (Tax Sparing Credit) зөвшөөрөх тохиолдол байдаг.

31



Гадаад дахь охин компанийн ноогдолыг ашигт үл тооцох тогтолцоо

Exemption of Dividends from Foreign Subsidiaries System

- Ач холбогдол
 - Төв компани нь гадаад дахь охин компаниас авах ноогдолыг ашигт тооцохгүйгээр, тухайн охин компанид гадаадад ногдуулах татвар, төв компанийн охин компаниас авсан ноогдолд ногдуулах манай улсын татварт давхар татвар ногдуулалтын зохицуулалт хийх тогтолцоо
 - Ашигт үл тооцох үнийн дүнгийн тухайд, гадаад дахь охин компаниасаа авах ноогдолын үнийн дүнгийн 95%-тай тэнцэх үнийн дүн (5%-тай тэнцэх үнийн дүнг тухайн ноогдол ашигтай холбоотой зардлын дүнтэй тэнцэнэ хэмээн ашигт тооцно.)

32

Давхар татвар ногдуулалтаас сэргийлэх татварын тогтолцоо *Rules for Prevention of Double Taxation*



33

СЭДЭВ 5 ЯПОН УЛСЫН ТАТВАРЫН ГЭРЭЭ *Tax treaties of Japan*

34



Татварын гэрээ

Tax Treaties

- Татварын гэрээ нь, давхар татвар ногдуулалтаас зайлсхийх, татвараас зугтах, зайлсхийхийн эсрэг авах арга хэмжээгээр дамжуулан хоёр улс хоорондох хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжихэд хувь нэмэр оруулдаг зүйл юм.
- Татварын гэрээнд олон улсын жишиг болох “ЭЗХАХБ-ын загвар гэрээ” байдаг бөгөөд ЭЗХАХБ-ын гишүүн улс орнууд татварын гэрээ байгуулахдаа загвар болгон ашигладаг. Гишүүн орон болох Япон улс ч гэсэн үүнд нийцсэн заалтыг дагаж мөрддөг.

35



ЭЗХАХБ-ын загвар гэрээ

OECD Model Tax Convention


1. Давхар татвар ногдуулалтаас зайлсхийх
 - Эх үүсвэрийн улс (орлого бий болох улс)-ын татвар ногдуулах орлогын хүрээг тодорхойлох
 - Үйл ажиллагааны орлогын хувьд салбар гм-ийн үйл ажиллагаанаас олсон орлогод зөвхөн татвар ногдуулна.
 - Хөрөнгө оруулалтын орлогын хувьд (ноогдол ашиг, хүү, роялти) татварын хувийн дээд хэмжээг тогтоох
 - Байнгын оршин суух улс дах давхар татвар ногдуулалтыг халах арга
 - Гадаад улсын татварыг хасах гм
 - Татварын алба хоорондын харилцан тохиролцох гэрээнд (арбитрийн ажиллагаа хамаарна) нийцэхгүй татвар ногдуулалтыг халах
2. Татвараас зугтах, зайлсхийхийн эсрэг арга хэмжээ
 - Татварын алба хооронд татвар төлөгчийн мэдээлэл (банкны нууц хамаарна) солилцох
 - Татвар хураахад харилцан туслалцаа үзүүлэх

36

Японы татварын гэрээний сүлжээ

Network of Tax Treaties of Japan

Нийт 200 улс орон, бүс нутагтай байгуулсан 69 татварын гэрээ (2017.8.1-ний байдлаар)



Японы татварын гэрээний сүлжээ

Network of Tax Treaties of Japan

Төрөл	Гол зорилго	Гэрээний тоо	Улсын тоо
Татварын гэрээ	Давхар татвар ногдуулалтыг халах, татвараас зугтах, зайлсхийхээс сэргийлэх ажлыг хамтран хийх	56	67
Мэдээлэл харилцан солилцох гэрээ	Татвартай холбоотой мэдээлэл солилцох	11	11
Татварын удирдлагыг бэхжүүлэхтэй холбоотой гэрээ	Мэдээлэл харилцан солилцох, татвар хураах болон албан бичиг баримтын хүргэлт хийхтэй холбоотой асуудал дээр харилцан туслалцах	1	81* (96)
Япон Тайваны хоорондох татварын зохицуулалт	Нийтийн ашгийн төлөөх ААН-үүдийн хамтын ажиллагааны холбоо (Япон) болон Зүүн Өмнөдийн харилцааны холбоо (Тайван) хоорондох иргэдийн татварын зохицуулалтыг хууль тогтоомжид тусган татварын гэрээний хэмжээнд авч үзэх	1	1

*Үүнээс 41 улс орон Японтой татварын гэрээ байгуулаагүй байгаа.




Ашигласан материал *Reference Materials*

- Сангийн яамны веб хуудас
http://www.mof.go.jp/tax_policy/
- OECD веб хуудас
<http://www.oecd.org/tax/treaties/>
- Масүи Ёшихиро, Миязаки Юүко 『Олон улсын татварын хууль (3-р хувилал)』 (Токиогийн их сургуулийн хэвлэл, 2015)



Төлөөний газартай холбоотой жишээ дасгал

1



Жишээ дасгал 1 Салбар төлөөний газар PE

Дараах тохиолдлуудад Монголын “F” компани Японд салбар төлөөний газартай гэж үзэх үү?

1. “F” компани нь жижиг дунд ААН-д зориулж үйл ажиллагааны зөвлөгөө өгдөг бөгөөд 2 жилийн гэрээтэйгээр Токио хотын нэг барилгад өрөө түрээслэн, Монголоос нэг ажилтан томилж, 4 ажилтныг тухайн орон нутгаас ажилд авсан тохиолдолд.
2. “F” нь аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд Хоккайдод цанын баазтай тохиолдолд.
3. “F” нь цэцгийн худалдаа эрхэлдэг бөгөөд Хоккайдод агуулахаа байршуулж, агаараар тээвэрлэж ирсэн цэцгээ Зүүн Азийн орнуудад экспортлодог тохиолдолд.
4. “F” нь кино түгээлтийн бизнес эрхэлдэг бөгөөд Японд шинэ киноны сурталчилгаа хийдэг тохиолдолд.

2

Жишээ дасгал 1

Тайлбар

1. Салбар төлөөний газар

Салбар, үйлдвэр ба бусад үйл ажиллагаа явуулдаг тогтсон газар (Салбар, томилолтын газар, оффис, үйлдвэр, агуулах, уурхайн орд, чулууны орд зэрэг бусад байгалийн нөөц олборлох газар, ХАА фирм, ферм)

2. Салбар зэрэг төлөөний газарт хамаарахгүй зүйлс ⇒ туслах ба бэлтгэл үйл ажиллагаа эрхэлдэг газар

- a. Зөвхөн хөрөнгө худалдаж авах зорилгоор ашигладаг тодорхой газар
- b. Зөвхөн хөрөнгө хадгалах зорилгоор ашигладаг тодорхой газар
- c. Сурталчилгаа, мэдээлэл өгөх, зах зээлийн судалгаа, суурь судалгаа зэрэг бусад үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой зөвхөн туслах үйл ажиллагаа эрхлэхэд ашигладаг тодорхой газар

3

Жишээ дасгал 2

Интернет худалдаа

【Бодит байдал】

1. Япон улсын иргэн “А” нь интернетэд нээсэн веб хуудас болон дуудлага худалдааны хуудас ашиглан гадаадаас импортолсон ухаалаг утсыг Японы худалдан авагчдад борлуулах ажлыг ганцаараа эрхэлдэг байсан.
2. “А” нь 2010 оны 1 сард “S” улсын иргэнтэй гэрлэж, тус улс руу гарсан.
3. “А” нь Японоос гарсны дараа ч урьд нь түрээсэлж байсан орон сууц дээрээ нэмж агуулах түрээслэн, ажилтандаа үргэлжлүүлэн бараа бүтээгдэхүүнийг хадгалуулж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн.
4. “А” нь “S улсад дараах үйл ажиллагааг хийдэг.
 - a. Веб хуудас нээх, шинэчилэх
 - b. Веб хуудсаар дамжуулан, худалдан авагчаас захиалга авах
 - c. Худалдах барааны сонголт, худалдан авалтын захиалга
 - d. Япон руу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, барааны үнийг тогтоох
 - e. Хэрэглэх зааврыг Япон хэл дээр бэлтгэх
 - f. Ажилтандаа агуулах, байрныхаа асуудлаар зааварчилгаа өгөх



4

Жишээ дасгал 2


Интернет худалдаа

5. Агуулахад утасны аппарат, компьютер, факс зэрэг харилцаа холбооны хэрэгсэл, интернетэд бараа бүтээгдэхүүний зургийг байршуулахад зориулсан зургийн аппарат байрлуулсан байдаг.
6. Түрээсийн байр болон агуулахад дараах үйл ажиллагааг эрхэлдэг:
 - a. Импортолсон барааны хөдөлгөөнийг хянах
 - b. Барааны сав баглаа боодол, Япон хэл дээр хэрэглэх зааврыг хавсаргах
 - c. Барааг худалдан авагчид илгээх
 - d. Буцаагдсан барааг хүлээн авч, үйлдвэрлэгчид буцаах
 - e. Веб хуудсанд тавих барааны зураг авалт
7. “А” нь түрээсийн байр, агуулахад бараа бүтээгдэхүүн хадгалсан зорилгоо 『Худалдан авагчид барааг шууд илгээснээс хүргэлтийн зардал бага тусч, богино хугацаанд хүргэлт хийх боломжтой болдог учраас』 гэж тайлбарласан.


5

Жишээ дасгал 2

Ажил гүйлгээний зураглал



6




Жишээ дасгал 2

Интернет худалдаа

【Судлах асуудлууд】 Бодит байдалд тулгуурлан, “А”-д ногдуулах татварыг дараах байдлаар судлаж үзье.


1. “А” нь байнгын оршин суугч уу, байнгын бус оршин суугч уу?
2. Байнгын ба байнгын бус оршин суугчид хэрхэн татвар ногдуулдаг вэ? Татвар ногдуулалтын ялгаа нь юу вэ?
3. “А” нь байнгын бус оршин суугч бол, Японд дараах төлөөний газартай гэж үзэж болох уу? Тохиолдол тус бүрдээр судлаж үзье.
 - a. Салбар
 - b. Барилгын үйлдвэрлэлийн газар
 - c. Төлөөний этгээд
4. “А”-г хянан шалгах үед хүндрэлтэй байж болох асуудлуудыг гарган тавья.



Жишээ дасгал 2

Судлах гол асуудлууд

1. Байнгын оршин суугчийг тодорхойлох шалгуур юу болох?
「Амьжиргааны эх」 нь Японд байгаа эсэх?
(Амьдрах сууц, эрхэлдэг ажил, оршин суух хугацаа, гэр бүл гэх мэт)
2. Төлөөний газрыг тодорхойлох
Ямар үндэслэлээр тодорхойлсон болох?
(Жиш: Агуулахын ашиглалт, ажилтны ажил үүрэг гэх мэт).
3. Хяналт шалгалт хийх дараалал
Мэдээлэл цуглуулах⇒Бэлтгэл судалгаа⇒Ажлын байранд хийх хяналт шалгалт⇒Бодит байдлыг тодорхойлох (баримт нотолгоо, татвар төлөгчид асуулга хийх) ⇒ Орлогыг тооцоолох⇒тайлагнах, татвар төлөх



Жишээ дасгал 2 нэгтгэл

Интернет худалдаа

Интернет худалдааны бизнест ашиглаж байсан түрээсийн байр, агуулахыг Төлөөний газар гэж үзэн, орлогын албан татвар төлөх үүрэгтэй болохыг тодорхойлж, орлогын татвар төлөхөөр шийдвэр гарсан жишээ.

【Ерөнхий зүйл】

Энэ тохиолдлын агуулах нь:

1. Импортын болон бараа хүргэлтийн зардал бууруулах
2. Худалдан авагчийн захиалгаас бараа хүргэлт хүртэлх хугацааг богиносгох
3. Хэрэглэх зааврыг Япон хэл дээр хавсаргах зэрэг эдийн засгийн хувьд нэмүү өртөг шингэсэн үйлдэл хийгдсэн ба зүгээр нэг агуулахын үүргээр ашиглагдах бус ашгийн үйл ажиллагаанд чухал шаардлагатай зүйл байгааг тогтоосон.



Жишээ дасгал 3

Гадаадын охин компани

【Оршил】

2100 онд Японд эдийн засгийн тогтворгүй байдлаас гадаадын хөрөнгө оруулалт буурсан. Ингэснээр Японы иен тогтворгүй болж, ханш нь хурдацтайгаар буурсан. Японы Засгийн газар хариу арга хэмжээ болгон дотоодын хөрөнгө оруулалтын компанид (Үнэт цаасны компани) зөвхөн иенээр бараа борлуулахыг хуульчилсан.

Үүний үр дүнд, Японы хөрөнгөтэй хэсэг нь иенээс өөр валютаар хөрөнгө оруулалт хийхийн тулд гадаадын хөрөнгө оруулалтын компанид хөрөнгөө шилжүүлж эхэлсэн.

Жишээ дасгал 3

Гадаадын охин компани

Японы алдартай үнэт цаасны компани болох “J” нь энэхүү хөрөнгийн шилжилтээс шалтгаалсан бизнесийн алдагдлаас гарахын тулд дараах арга хэмжээг авахаар болсон:


1. Одоо Монголын эдийн засгийн байдал сайн байгаа бөгөөд Японы хөрөнгө оруулагчдын эрэлт өндөр байгаа тул нүүрсний олборлолтын компанитай холбоотой хөрөнгө оруулалтын итгэмжлэл, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэмжлэл (REIT) зэрэг төгрөгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын бичгийг Японы үйлчлүүлэгчдэд худалдах.
2. Кейман арал дээр “J” компанийн охин компани болох “K”-г байгуулах.
3. Монголын хөрөнгө оруулалтын компани болох дээрх бүтээгдэхүүнийг эзэмшдэг Монгол траст Улаанбаатар (цаашид “U” гэх) компани болон “K” компанийн хооронд гэрээ байгуулж, “J” компанийн харилцагчийн хөрөнгийг “U”-аар хөдөлгүүлэх.
4. Японы үйлчлүүлэгчдэд “K”-ээр дамжуулан, Монголын хөрөнгө оруулалтын итгэмжлэлийг борлуулах.

Энэ аргаар “J” компани нь Японы үйлчлүүлэгчдэд иенээс өөр валютаар бүтээгдэхүүнийг борлуулах боломжтой болсон.

11

Жишээ дасгал 3

Ажил гүйцэтгэний зураглал 1



12

Жишээ дасгал 3

Гадаадын охин компани

Гэвч, “U” нь үйлчилгээний хураамж гэж үйлчлүүлэгчийн цэвэр хөрөнгийн 0,75%-ийг үйлчлүүлэгчдийн данснаас шууд авахаас гадна, “K”-гээс хөрөнгийн менежментийн хураамжийг нэхэмжилдэг байсан. Иймд “K” нь дараах байдлаар шийдэхээр болсон:


1. Монголд “K” компанийн 100% хөрөнгө оруулалттай “L” компани байгуулах.
2. “L” компани нь “K” компанитай гэрээ хийж, “U”-ийн хийж байсан ажил үйлчилгээг оронд нь хийх.
3. “L” компани нь “K” компаниас хөрөнгийн менежментийн хураамж авах.
4. Гэрээний заалтын дагуу “L” компани нь дараах ажил үйлчилгээг хийнэ.
 - a. Хөрөнгө оруулалттай холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийх
 - b. Хөрөнгө оруулалтын талаар “K”-д зөвлөгөө өгөх
 - c. “K”-ийн үйлчлүүлэгчдийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх

Энэ байдлаар “L” компанийн үйл ажиллагааны ихэнхийг “K”-тэй хийсэн гэрээний дагуух ажил үйлчилгээ эзэлж, орлогын 90%-ээс илүү хувь нь “K” компаниас орж ирдэг.

13

Жишээ дасгал 3

Ажил гүйцэтгээний зураглал 2



14

Жишээ дасгал 3

Гадаадын охин компани

Түүнээс хойш хэдэн жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг хэвийн өсөлттэй байж, хөрөнгө оруулалтын итгэмжлэлийн үнэ өссөн ба “К” компани жилд 50 тэрбум иений орлого олсон.

Нэг өдөр “К” компанийн төлөөлөгч “Х”-д Монголын татварын албан “Ү”-аас дуудлага ирсэн.

Ү: Татварын алба байна. “К” компанийн татварын хяналт шалгалтын асуудлаар ярьж байна.

Х: ??? Манай компани нь Кэйманы ААН бөгөөд Монголд салбаргүй шүү дээ

Ү: Хөрөнгө оруулалтын итгэмжлэлийн үйлчилгээний хураамжийн орлого олж байгаа биз дээ.

Х: Аан, хураамжийн тухайд, үйлчлүүлэгчдийн хөрөнгийг юунд, хэрхэн хөрөнгө оруулалт хийх талаар Японд зөвлөгөө өгч олсон мөнгө болохоор Монголд олсон орлого бишээ. Хөрөнгө оруулалтын менежментийн хувьд охин компани болох “L” компанитай гэрээ хийн гүйцэтгүүлж байгаа бөгөөд үйлчилгээний хураамж төлж байгаа шдээ.

Ү: Аль нь ч байлаа гэсэн Монголд татвар ногдох орлого олж байх магадлалтай тул хяналт шалгалт хийнэ.

Х: ????????????

15

Жишээ дасгал 3

Гадаадын охин компани

【Судлах асуудал】

“Ү”-ийн хэлж байгаачилан Монгол Улс “К” компанид татвар ногдуулах уу?

16

Жишээ дасгал 3

Судлах гол асуудлууд

1. Монгол Улсын дотор орлого үүсч байна уу?
“К” компанийн олсон хураамжийн орлого нь Японд олсон орлого уу, Кэйманд олсон орлого уу, Монголд олсон орлого уу?
2. “L” компани нь “К” компанийн охин компани хэдий боловч, энэ компанийн ажлын чиг үүрэг, оролцоо нь юу вэ?

17

Жишээ дасгал 3

Гадаадын охин компани

【Асуудлууд】

1. Кэйманы охин компани болох “К” компани нь Монгол дахь үйл ажиллагаанд оролцож байсан эсэх?
2. Монголд эх үүсвэртэй орлого байгаа эсэх?

【Шийдвэр】

Монгол дахь зээ компани болох “L” нь Кэйманы охин компани болох “К”-ийн Төлөөлөгч төлөөний газар болж, “К” нь Монгол Улсад санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байсан гэж үзэх боломжтой.

【Шалтгаан】

1. “L” компанийн орлогын 90% илүү нь Кэйманы охин компани болох “К” компаниас олсон орлого байна.
2. “L” компани нь бусад үйлчлүүлэгчдэд зориулж маркетингийн үйлчилгээ үзүүлээгүй байна.
3. Тодорхой хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг “L” бие даан гаргаж байсан боловч, “L” компанийн нэгдсэн баримтлах чиглэлийн талаарх зааварчилгааг “К” компаниас өгдөг байсан.

(Ашигласан материал) Inverworld, Inc. v. Commissioner, T.C. Memo1996-301

18

ТАТВАРЫН ГЭРЭЭ

2015 оны 2 сар

Татварын гэрээний агуулга - OECD Загвар гэрээний гол агуулга -

Давхар татвар ногдуулалтаас сэргийлэх

- Эх үүсвэрийн улс татвар ногдуулах орлогын хүрээг хязгаарлах
- -- Үйл ажиллагааны орлогын тухайд, зөвхөн салбарын үйл ажиллагааны хүрээнд олсон орлогод татвар ногдуулах
- -- Хөрөнгө оруулалтын орлогод (Ноогдол ашиг, хүү, ашиглалтын хураамж) татварын хувь хэмжээний дээд хязгаарыг тогтоох
- Оршин суугаа улс дахь давхар татвар ногдуулалтыг халах арга
 - -- Гадаад улсын татварын дүнг хасалт хийх
- Татварын байгууллага хоорондын харилцан тохиролцлын (Арбитрын шүүхийг оруулаад) дагуу, гэрээний заалтад үл нийцэх татвар ногдуулалтыг халах

Татвараас зугтах, зайлсхийхтэй тэмцэх

- Татварын байгууллага хооронд татвар төлөлтийн талаар (Банкны нууцлалын мэдээллийг оруулаад) мэдээлэл солилцох
- Татвар хураалтад дэмжлэг үзүүлэх

Татварын загвар гэрээ

- OECD Model Tax Convention
<http://www.oecd.org/tax/treaties/>
- United Nations Model Double Taxation Convention between Developed and Developing Countries
<http://www.un.org/esa/ffd/tax/unmodel.htm>
- Convention on Mutual Administrative Assistance in Tax Matters
<http://www.oecd.org/ctp/exchange-of-tax-information/>

3

Нэгдсэн онол

Татварын гэрээний зорилго

- Давхар татвар ногдуулалтаас сэргийлэх
- Татвараас зугтаахаас сэргийлэх

Татварын загвар гэрээ

- OECD загвар гэрээ
- Олон улсын нэгдсэн загвар гэрээ

Дотоодын хуультай холбогдох нь

- treaty override
- preservation clause

4

Хамрах хүрээ

Хамрагдах татварын төрөл

- Улсын татвар, орон нутгийн татвар
- Орлогын болон хөрөнгийн татвар

Газар зүйн байрлалын хамрах хүрээ

- Татварын талаарх хууль тогтоомжийн үйлчилдэг бүх бүс нутаг
- Эзэмшил (possession), територ (territory)

Хамрагдах хүмүүс

- Оршин суугч (resident)
- Татвар ногдуулалтад хамрагдах ёстой бүх хүмүүс

5

Гэрээний нэгжлэгт (treaty shopping) авах арга

ХЭМЖЭЭ

Өгөөж хүртэгсдэд (beneficial owner) тавигдах шаардлага

- look-through approach
- Хүлээн авагч тал

Ашиг тус хүртэх хязгаарын талаарх заалт (limitation on benefit clause)

- channel approach
- Хүртэх шалгуурт нийцэхгүй оршин суугч

Урвуулан ашиглахаас сэргийлэх заалт

- bo-na fide approach
- Сувгаар дамжих ажил гүйлгээ

6

Татвар ногдуулах эрхийн хуваарилалт - Эх үүсвэрийн улсын татвар ногдуулах эрхийн хуваарилалт -

Орлогын төрөл	Төлөөний газарт хамаарах орлого	Төлөөний газарт хамаарахгүй орлого
ҮХХ	Татвар ногдуулна	Татвар ногдуулна
Үйл ажиллагаа	Татвар ногдуулна	
Ноогдол	Татвар ногдуулна	*Татварын хувь хэмжээний хязгаар 5%/15%
Хүү	Татвар ногдуулна	*Татварын хувь хэмжээний хязгаар 10%
Ашиглалтын хураамж	Татвар ногдуулна	
Шилжүүлсний орлого	Татвар ногдуулна	*ҮХХ (ҮХХ шилжүүлсэн хувьцаа) бусдад шилжүүлэх гэх мэт
Цалин	Татвар ногдуулна	*Богино хугацаагаар оршин суугчийг татвараас чөлөөлнө
Удирдлагын урамшуулал	Татвар ногдуулна	Татвар ногдуулна
Урлагийн	Татвар ногдуулна	Татвар ногдуулна

Эх үүсвэр: OECD загвар гэрээ

7

Процедурын болон бусад чухал заалтууд

Харилцан тохирох

- Тухайлсан тохиолдлын талаар, тайлбарын зарчмын талаар, хууль боловсруулж шийдэх аргын талаар харилцан тохирч, зөвшилцөх
- Арибитрын шүүх

Мэдээлэл солилцох, татвар хураалтын дэмжлэг

- Хүсэлтийн дагуу, сайн дурын болон ердийн мэдээлэл харилцан солилцох
- Татвар хураалтад дэмжлэг үзүүлэх

Үл ялгах зарчим

- Иргэншил, төлөөний газартай эсэх, төлөх хасалт хийх болон үндсэн хөрөнгөөр ялгаварлахгүй

8

Татварын хэрэгжилтэд харилцан дэмжлэг үзүүлэх гэрээ

Мэдээлэл харилцан солилцох

- Гэрээ байгуулсан улс хооронд татвартай холбоотой мэдээллийг харилцан солилцох боломжтой

Татвар хураалтад дэмжлэг үзүүлэх

- Татварын өртэй этгээдийн хөрөнгө нь гэрээт улсад байрладаг тохиолдолд, тухайн улсад татварын өр барагдуулалтын талаар хүсэлт гаргах боломжтой.

Илгээх, хүргэлт хийхэд дэмжлэг үзүүлэх

- Татвартай холбоотой албан бичгийн хүлээн авагч нь гэрээт улсад байгаа тохиолдолд, тухайн улсын татварын байгууллагад албан бичгийг тухайн этгээдэд хүргэж өгөхийг хүсэх боломжтой.

Үнэ шилжилтийн татварын ТОГТОЛЦОО

**2014 он
ТЕГ-ын татварын дээд сургууль**

1

ГАРЧИГ

- 1. Үнэ шилжилт гэж юу болох**
- 2. Үнэ шилжилтийн татварын тогтолцоо**
- 3. Үнэ шилжилтийг тооцох арга**
- 4. Үнэ шилжилтийг судлах**


2

1. Үнэ шилжилт гэж юу вэ?

3

1-1 Жишээ (1)


➤ Бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



4

1-2 Жишээ (2)

➤ Бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



1-3 Үнэ шилжилтийн агуулга

➤ Үнэ шилжилт (Transfer Price) гэдэг нь харилцан хамааралтай этгээдийн хооронд хийгдсэн арилжаа (Биет ба биет бус хөрөнгө, үйлчилгээ)

(ЖИЧ) Харилцан хамааралтай хуулийн этгээд (Associated Enterprise) гэдэг нь жишээлбэл, Төв ба охин компани, ах дүү компанийн хоорондын харилцааг хэлнэ.

➤ Олон улсын татвар ногдуулалтаар харилцан хамааралтай ААН-ын хил дамнасан арилжааг асуудал болгон үзнэ. (Controlled transaction)



Жишээ (1) ба (2) –г гадаадын ААН ба түүний Монгол дахь охин компанийн хооронд хийгдсэн барааны арилжаа(\$70) нь харилцан хамааралтай ААН хоорондын арилжаа болно.

2. Үнэ шилжилтийн татварын ТОГТОЛЦОО

7

2-1 Үнэ шилжилтийн татварын ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ

- Бизнесийн үйл ажиллагааны даяарчилал
↓
- Нийт групп компанийн ашгийн төлөөх тэмцэл
↓
- Групп доторх (Intra-Group) арилжаа гүйлгээг нөлөөлөн удирдах
↓
- Орлогыг гадаад улс руу шилжүүлэх (татвар ногдох орлогоо бууруулах) ↓
- Үнэ шилжилтийн татварын тогтолцоог нэвтрүүлэх
8 (Transfer Pricing Legislation)

2-2 Үнэ шилжилтийн татварын ТОГТОЛЦООНЫ ЗОРИЛГО

- Үнэ шилжилтийн татварын тогтолцоо нь ААН-ын гадаад дахь харилцан хамааралтай хуулийн этгээдтэй хийх арилжаагаар дамжуулан гадагш шилжүүлсэн орлогыг Сунгасан гарын зарчмаар, зохистой хуваарилах зорилготой тогтолцоо юм.

(Жич) Сунгасан гарын зарчим (Arm's Length Principle) гэдэг нь харилцан хамааралтай этгээдийн хооронд хийгдсэн арилжаанд бие даасан ААН хооронд хийгдэх арилжааны нөхцөлөөс өөр нөхцөл тавигдаад, энэ нөхцөлөөр өөрийн улсын ААН-ын ашиг буурч байгаа тохиолдолд, Татварын байгууллага нь энэ нөхцөл тавигдаагүй үед тухайн ААН-ын ашиг болох байсан ашигийг оруулан, өөрийн улсын ААН-д ногдуулалт хийх боломжтой байх зарчим (ЭЗХАБ-ын загвар гэрээний 9-р зүйл)

9

2-3 Үнэ шилжилтийн татварын ТОГТОЛЦООНЫ ОНЦЛОГ

- (1) Харилцан хамааралтай этгээд хоорондын арилжааг хамаарч үзнэ.
- (2) Зөвхөн өөрийн улсын дотор татвар ногдох орлого хэт багаар тооцогдсон тохиолдолд үйлчилнэ.
- (3) Татвараас зайлсхийх санаархал нь татвар ногдуулалтын шалгуур болохгүй



10

3. Үнэ шилжилтийг тооцох арга

11

3-1 Сунгасан гарын үнэ буюу бие даасан ААН хоорондын үнэ

- Сунгасан гарын үнэ (ALP: Arm's Length Price) гэдэг нь харьцуулах боломжтой нөхцөлд, харилцан хамааралтай бус этгээдийн хооронд хийсэн харьцуулах боломжтой арилжааны (Comparable Uncontrolled Transaction) үнийг хэлнэ.



【Асуулт】

Жишээ (1)-д ямар нөхцөл байдал, нөхцөл хангагдсан тохиолдолд, гадаадын ААН ба бие даасан ААН хоорондын барааны борлуулалтын үнэ нь (\$50) сунгасан гарын үнэ буюу ALP гэж үзэж болох вэ?

12

3-2 Үнэ шилжилтийг тооцох арга

➤ ALP-ийг тооцох аргыг үнэ шилжилтийг тооцох арга (Transfer Pricing Method) гэх ба OECD-ийн үнэ шилжилтийн гарын авлагад дараах 5 аргыг хэрэглэхээр заасан байдаг:

➤ *Харьцуулах арга (Transaction method)*

- (1) Харьцуулах жишиг үнийн арга (Comparable Uncontrolled Price (CUP) Method)
- (2) Дахин борлуулах жишиг үнийн арга (Resale Price (RP) Method)
- (3) Жишиг өртгийн арга (Cost Plus (CP) Method)

➤ *Ашгийн арга (Profit Method)*

- (1) Арилжааны цэвэр ашгийн арга (Transactional Net Margin Method (TNMM))
- (2) Ашиг хуваах арга (Profit Split (PS) Method)

13

3-3 Харьцуулах жишиг үнийн арга (CUP арга)

➤ CUP арга нь харилцан хамааралтай этгээдийн хоорондох хөрөнгө, үйлчилгээний үнийг, харьцуулах боломжтой нөхцөлд, харьцуулах боломжтой харилцан хамааралгүй этгээд хоорондын адил төрлийн үнэтэй шууд харьцуулах арга юм.


➤ ALP нь харьцуулах боломжтой нөхцөлд, харьцуулах боломжтой харилцан хамааралгүй этгээд хоорондын арилжааны үнэ юм.

➤ Харьцуулах хөрөнгө, ажил үйлчилгээ нь адил төрлийн буюу маш төстэй байх ёстой гэсэн шаардлага тавигддаг.

14

3-4 Жишээ (1)-ийн тайлбар


➤ Нэг төрлийн бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



15

3-5 Жишээ (3)

➤ Адил төстэй бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



16


3-6 Дахин борлуулалтын жишиг үнийн арга (RP арга)

- RP арга нь харилцан хамааралтай этгээдээс ААН-ын худалдан авсан барааг харилцан хамааралгүй этгээдэд дахин худалдах үеийн нийт ашгийн хувийг, (Resale Margin Ratio) харилцан хамааралгүй этгээд хооронд хийгдсэн харьцуулах боломжтой нийт ашгийн хувьтай харьцуулах арга юм.
- ALP –ийг дахин борлуулсан үнээс зохих ашгийг хасч тооцоолно.
- Барааны адил төстэй байдлаас илүү ААН-ын үүргийг чухалчилна. (Үйл ажиллагааны түвшин)
- ААН нь(Дахин борлуулагч)өндөр үнэтэй биет бус хөрөнгөтэй тохиолдолд энэ аргыг хэрэглэхгүй.

17

3-7 Жишээ (3)-ийн тайлбар


- Адил төстэй бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



18

3-8 Жишээ (4)

➤ Адил төстэй бараа бүтээгдэхүүний арилжаа (гадагш гарсан-Outbound)




3-9 Жишиг өртгийн арга (CP арга)

- ААН нь харилцан хамааралтай этгээдэд бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэх үеийн өртөг тооцсон үнийн хувийг, харилцан хамааралгүй этгээд хооронд хийгдсэн харьцуулах боломжтой өртөг тооцсон үнийн хувьтай харьцуулах аргыг CP арга гэнэ.
- ALP-ийг өртөг дээр зохих зардлыг нэмж тооцож гаргана.
- Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний адил төстэй шинжээс илүү ААН-ын үйл ажиллагааны түвшинг чухалчилна.
- ААН нь өндөр үнэтэй биет бус хөрөнгөтэй тохиолдолд энэ аргыг хэрэглэхгүй.

3-10 Жишээ (4)-ийн тайлбар


➤ Адил төстэй бараа бүтээгдэхүүний арилжаа (гадагш гарсан-Outbound)



21

3-11 Жишээ (5)

➤ Адил төстэй бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



22

(Жич) Чиг үүрэг нь охин компаниас бага зэрэг ялгаатай


3-12 Арилжааны цэвэр ашгийн арга (TNMM)

- TNMM нь ААН-ын хамгийн зохистой жишигт утгад (жиш, борлуулалт, өртөг, хөрөнгө) эзлэх үйл ажиллагааны ашгийн хувийг, харилцан хамааралгүй этгээд хоорондын харьцуулах боломжтой дээрх хувьтай харьцуулах арга юм.
- ALP нь RP арга ба CP-д нийцүүлэн тооцоологдоно.
- Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний адил төстэй шинжээс илүү ААН-ын үйл ажиллагааны түвшинг чухалчилна.
- Гэхдээ, TNMM-д RP арга болон CP аргуудын адил үйл ажиллагааны адил төстэй байдлыг хатуу шаардахгүй.

23

3-13 Жишээ (5)-ийн тайлбар


- Адил төстэй бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



24

3-14 Жишээ (6)

➤ Бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



25


3-15 Ашиг хуваах арга (PS арга)

- PS арга нь харилцан хамааралтай этгээд хоорондын арилжаанаас үүссэн нийлбэр ашгийг (Combined Profit)-ийг үндэслэлтэй жишгийн дагуу хуваах арга юм.
- ALP-ийг нийлбэр ашгийг үндэслэлтэй хуваах харьцаагаар үржүүлж тооцоолно.
- Нийлбэр ашгийг харилцан хамааралтай этгээдүүдийн үйл ажиллагааны ашгийн нийлбэрээр тооцно.
- Хуваах харьцааг, харилцан хамааралгүй этгээдүүдийн харьцуулах боломжтой хуваах харьцаа ба холбогдогч тус бүрийн оролцооны хувийг ашиглан тооцоолно.

26

3-16 Жишээ (6)-ийн тайлбар

➤ Бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



27

3-17 Хамгийн зохистой аргыг сонгох

- Үнэ шилжилтийг тооцоолох аргыг ашиглахдаа, тухайн тохиолдол тус бүрийн хувьд хамгийн зохистой байх аргыг сонгох нь зүйтэй. Үүнийг хамгийн зохист аргын дүрэм гэнэ. (Best Method Rule)
- Тухайн тохиолдлын бодит байдал, нөхцөл байдлын хувьд хамгийн их найдвартай байх ALP-ийг тооцоолох боломжтой байх аргыг хамгийн зохистой арга гэнэ.
- Хамгийн зохистой аргын дүрмээр, харилцан хамааралгүй этгээд хоорондын арилжааны харьцуулах боломжтой үзүүлэлтүүдийн найдвартай байдлыг чухалчилдаг.

28

4. Үнэ шилжилтийг судлах

29

4-1 Үнэ шилжилтийн талаарх хяналт шалгалтын дэс дараалал

Step 1: Мэдээлэл цуглуулах

- Хяналт шалгалтанд хамруулах ААН, гадаад дахь харилцан хамааралтай этгээд
- Хяналт шалгалтанд хамруулах ААН-ын харьяалагдах салбар, бүтээгдэхүүний төрөл

Step 2: Орлого гадаад руу шилжсэн байх магадлал

Step 3: Асуудалтай арилжааг тогтоох

Step 4: Хамгийн зохистой үнэ шилжилт тооцох аргыг сонгох

Step 5: Харилцан хамааралгүй этгээд хооронд хийгдсэн харьцуулах боломжтой арилжааг тодорхойлох

Step 6: Зөрүүгийн зохицуулалт (Comparability Adjustment) хийх

⇒ зөвхөн шаардлагатай тохиолдолд

Step 7: ALP-ыг тооцоолох

4-2 Харьцуулах боломжийн ШИНЖИЛГЭЭ

- Харилцан хамааралгүй этгээд хоорондын харьцуулах боломжтой арилжааг тодорхойлохдоо, ашиглах боломжтой мэдээллийн сангаас харьцуулах боломжтой арилжааг сонгосны дараа, харьцуулах боломжийн шинжилгээ хийх шаардлагатай. (Comparability Analysis)
- Харьцуулах боломжийн шинжилгээний гол үзүүлэлтүүд:
 - Шилжсэн хөрөнгө, ажил үйлчилгээний онцлог
 - Холбогдогч талуудын гүйцэтгэх үүрэг
 - Гэрээний нөхцөл
 - Холбогдогч талуудын эдийн засгийн байдал
 - Холбогдогч талуудын бизнесийн стратеги



31

4-3 Харьцуулах боломжийн утга

- Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ба харилцан хамааралгүй этгээд хооронд хийгдсэн арилжааны нөхцөл, бодит байдлын зөрүү (Differences) байхгүй тохиолдолд харьцуулах боломжтой гэж үзнэ.
- Зөрүүтэй байсан тохиолдолд ч дараах 2 тохиолдолд, харьцуулах боломжтой гэж үзнэ.
 - Энэ зөрүү нь арилжааны үнэ, ашигт нөлөөлөхөөргүй байх
 - Энэ зөрүүний нөлөөг арилгахын тулд хийх зөрүүний тохиргоог алдаа мадаггүй хийх боломжтой байх

32

4-4 Үнэ шилжилтийн татвар

НОГДУУЛАЛТЫН ОНЦЛОГ

- Хяналт шалгалтанд хугацаа их ордог
- Ногдуулалтын дүн өндөртэй
- Эдийн засгийн давхар татвар ногдуулалт үүсдэг.




【Жич】

- Эдийн засгийн давхар татвар ногдуулалт гэдэг нь тухайлсан нэг орлогод (ашиг) олон улс орон татвар ногдуулалт хийхийг хэлнэ.
 - Шийдвэрлэх арга ⇒ Харилцан тохиролцох
- Нэг ААН-д олон улс татвар ногдуулахыг хуулиар давхар татвар ногдуулалт гэнэ. (Жиш: Эх үүсвэрийн улсын ба оршин суух улсын ногдуулалт)
 - Шийдвэрлэх арга ⇒ Гадаад улсын татварыг хасч тооцох

33

4-5 Жишээ (7)

- Бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



Японы татварын байгууллагаас үнэ шилжилтийн татвар ногдуулсны дараа \$50


Нийт ашиг	Охин компани	Төв компани	Нийт
Татвараас өмнөх	\$30	\$50	\$80
Татварын дараах	\$50	\$50	\$100

34

Эдийн засгийн давхар татвар ногдуулалт \$20

Анхаарал тавьсанд баярлалаа





**Олон Улсын татвараас
зайлсхийх
(Жишээн дээр суралцах)**

1



Агуулга

- **Татвараас зайлсхийх гэж юу вэ?**
- **Татвараа нуун дарагдуулах гэж юу вэ?**
- **Татварын төлөвлөлт гэж юу вэ?**
- **Татварын хэмнэлт гэж юу вэ?**

2



Тодорхойлолт

Татвараас зайлсхийх

Дараах зүйлтэй холбогдоно:

- Хууль бус арга
- Олсон орлогоосоо санаатайгаар багаар татвар төлөх
- Нуун дарагдуулах-холбогдох бодит зүйлсийг буруу тайлагнах (дутуу болон худлаа тайлан)
- Гэмт хэрэг (Үр дагавар: торгууль, эсвэл хорих ял)

Татвараа нуун дарагдуулах

Дараах зүйлтэй холбогдоно:

- Хуулийн хүрээнд татвар төлөх үүргээ бууруулах
- Хуулийн хүрээнд хийж буй үйлдэл... ..боловч хуулийн зорилготой зөрчилддөг.
- Эдийн засгийн мөн чанар, бизнесийн зорилгын тэнцвэр алдагдах
- Татвараа хэмнэхийг гол, ганц сэдлээ болгох

3



Тодорхойлолт

Татвараа төлөвлөх

- Ерөнхийдөө “Хүлээн зөвшөөрөгдөх татварын нуун дарагдуулалт” гэж үздэг
- Хуулийн зорилго, шугамын дагуу татвараа бууруулах гэсэн оролдлого
- Бизнесийн зорилго / эдийн засгийн мөн чанар

Татварын хэмнэлт

Хуулийн дагуу, татвар ногдох орлогоо бууруулах хүлээн зөвшөөрөгдөх арга

4


Татвараас зайлсхийх хэлбэрүүд

Татвараас зайлсхийх (Tax evasion)

- Татвараа нуун дарагдуулах /
Түрэмгий татварын төлөвлөлт
- Татварын төлөвлөлт
- Татварын хэмнэлт

5

Image of Tax Avoidance



6

Гол зүйл!

- Татвараа нуун дарагдуулах: Хүлээн авах боломжгүй!
 - ✓ Татварын хуулинд тодорхой заалт байхгүй бөгөөд шүүхийн жишиг байдаггүй, энэ талаар тодорхой тайлбар, арга хэмжээ авдаггүй (бол үүнийг “Тогцоо нүх” = “loop hole” гэдэг)
 - ✓ Хиймэл, хуурамч болон нарийн төвөгтэй эдийн засгийн жижиг үндэслэл
 - ✓ Хуулийн зорилгоос ангид байх

7

Татвараа нуун дарагдуулах хэлбэрүүд

1. Орлого бүхий этгээдийг солих




2. Орлогын хуваарийг солих



3. Орлогын эх үүсвэрийг шилжүүлэх



4. Орлого тооцсон жилийг өөрчлөн залилах



8

Жишээн дээр суралцах

1. Дараах жишээ тус бүрдээр ажил гүйлгээний зураглал гаргана уу.
2. Жишээ тус бүрдээр татварын ямар асуудал байгааг олж, авах арга хэмжээний талаар саналаа хэлнэ үү.

9

Жишээ 1

- i) “X” улсын “P” компани нь “M” брендийн цахилгаан барааг “α” улсын “S” охин компаниас импортолж, дотоодын зах зээл дээр борлуулдаг.
- ii) “P” компанийн энэхүү арилжаанаас тусад нь “P” компанийн төлөөлөгч болох “A” нь “α” улсын “GS” компаниас “M” брендийн цахилгаан барааг импортолж “X” улсын зах зээл дээр борлуулдаг байсан.
- iii) “GS” компани нь “P” компанийн 100%-ийн хөрөнгө оруулалттай “β” улсад байрлах “SS” компанийн 100% охин компани бөгөөд “α” улсын ААН боловч, зөвхөн цаасан дээр бүртгэлтэй компани юм.
- iv) “GS” компанийн менежмент болон “X” улсад харилцагчидтай үнийн хэлэлцээр хийх зэрэг шаардлагатай ажлыг “P” компанийн ажилтан “X” улс дотор эрхлэн явуулдаг.
- v) “P” компани нь “S” компаниас импортолсон болон “X” улс доторх борлуулалтын талаар ААНБОАТ-ын тайланд тусгадаг байсан боловч, “GS” компаниас импортолсон болон “X” улс дотор борлуулсан орлогыг тусгадаггүй байсан.

10

Жишээ 2

- i) “А” нь 2011 оны 12 сарын 31 хүртэл “Х” улсад байрлах “Р” компанид “Р” компанийн ажилтан гэгдэн ажилладаг байсан. Цалингийн хэмжээ нь жилийн \$50 сая байсан.
- ii) “А” нь 2011 оны 12 сарын 31-нээр “Р” компаниас гарч, “Х” улсын хүний нөөцийн “α” компаниас (Харилцан хамааралгүй этгээд) томилогдон “Р” компанид ажиллах болсон.
- iii) 2012 оноос эхлэн “α” компани нь “А”-ийн ажлын хөлсний төлбөр болгон “Р” компаниас жилд \$51 саяыг нэхэмжилж, энэ үнийн дүнг “Р” компани аутсорсинг үйлчилгээний хөлс болгон төлж, зардалд тусгадаг байсан.
- iv) “α” компани нь “Татварын диваажин” болох “J” арал дээрх хүний нөөцийн “β” компаниас энэ ажлыг жилийн \$50 саяар хүлээн авч хийдэг.
- v) “β” компани нь “Р” компанийн зөвлөх нягтлан бодогчийн байгуулсан цаасан дээрх компани болох нь тогтоогдсон.
- vi) “А”-д төлсөн цалин нь “β” компаниас “Х” улсын банкин дахь “А”-ийн нэр дээрх дансанд жил бүр \$15 сая шилжиж, “J” арлын банкин дахь “А”-ийн нэр дээрх дансанд \$35 сая шилждэг.
- vii) “А” нь “Х” улсын өөрийн нэр дээрх дансанд орсон \$15 саяын тухайд “Х” улсад орлогын албан татварын тайланд тусгасан байна.

11

Жишээ 3

- “Х” Улсын “А” банк нь дараах татвар хэмнэх схемийг “Y” Улсын “α”, “β”, “Θ” компаниудад (цаашид “3 ААН” гэх) худалдсан.
- i) 2013 оны 1 сард “А” банкны “Z” улс дахь харилцан хамааралтай “B” компани нь тус улсад нөхөрлөл (цаашид “P/S J” гэх) байгуулж, дээрх 3 ААН тус бүр \$100 мянган долларын хөрөнгө оруулж нөхөрлөл болсон.
 - ii) Нисэх онгоц үйлвэрлэгч “C” компаниас \$300 саяар онгоц худалдан авсан ба энэ санхүүжилтыг худалдан авсан онгоцоо барьцаалан “А” банкнаас зээлсэн.
 - iii) P/S нь худалдан авсан онгоцоо “D” лизингийн компанид 5 жилийн хугацаагаар жилийн \$20 саяар түрээсэлсэн. Энэ нь P/S-ээс “А” банкинд төлөх зээлийн хүүтэй адил үнийн дүнтэй байсан.
 - iv) 2013 оны P/S-ийн ашиг алдагдлын тухайд, “D”-ээс авсан түрээсийн төлбөр \$20 сая, “А” банкинд төлсөн зээлийн хүү \$20 сая, онгоцны элэгдэл хорогдлын зардал \$34 сая, засвар үйлчилгээний зардал \$5 сая, бусад зардал \$3 сая байсан ба нийт \$42 саяын алдагдалтай байсан.
 - v) P/S-ын ашиг алдагдал энэ үнийн дүнгээрээ нөхөрлөлийн гишүүдэд хуваарилагдах тул 3 ААН-д тус бүр \$14 саяын алдагдал хуваарилагдсан.

12

GAAR & SAAR

Татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм нь үндсэндээ “ерөнхий” ба “онцлог” гэсэн 2 том категорид хуваагддаг.

➤ **SAAR (Татвараас зайлсхийхийн эсрэг онцлог дүрэм-Specific Anti-Avoidance Rules)**

Нимгэн капиталын дүрэм, Өндөр хүүгийн дүрэм, CFC дүрэм, ...

➤ **GAAR (Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм- Anti-Avoidance Rule)**

✓Татвараа нуун дарагдуулах, зайлсхийхийн эсрэг тухайн улсын хууль эрх зүйн актад заасан өргөн хүрээтэй ерөнхий заалтуудын багц.

✓Татвар ногдуулах эрх бүхий байгууллагад татварын ашиг бий болгох өөр ямар нэгэн арилжааны бүрэлдэхүүнгүй ажил гүйлгээнд татварын хөнгөлөлт үзүүлэхгүй байх механизмыг хангах боломжийг олгодог.

13

GAARs ба онол

➤ Концепцийн эхлэлийн цэг нь:

- Татвараа нуун дарагдуулах, зайлсхийх,
- Эрхээ урвуулан ашиглах
- *fraus legis (Хуулийг урвуулан ашиглах)*
- Бизнесийн зорилго, эдийн засгийн бүрэлдэхүүнгүй байх
- Эдийн засгийн бодит шинж чанар

➤ Зайлсхийх үйлдэл нь үргэлж хуулийн хүрээнд байдаг боловч, тухайн хуулийн зорилгын эсрэг хийгдсэн байдаг.

➤ Урвуулан ашиглах үйлдэл нь ихэвчлэн өөр ялгаатай тайлбар хийгддэггүй.

➤ GAARs нь татвар төлөгчийг татвараас зайлсхийх зорилгоор хийгдсэн арилжаа гүйлгээнээс ашиг хүртэхээс сэргийлсэн хуулийн заалтуудыг даган мөрдөхийг хатуу шаарддаг.

➤ Зарим улс оронд татвараас зайлсхийх онол сурталыг хуульчлаагүй байдаг ба тухайн тохиолдлоос хамаарч шүүхээр шийдвэрлэхээр тогтсон байдаг.

14



Энэ тохиолдол GAAR-д хамаарах магадлалтай!

- Татвараа нуун дарагдуулах: Хүлээн авах боломжгүй!
 - ✓ Татварын хуулинд тодорхой заалт байхгүй бөгөөд шүүхийн жишиг байдаггүй, энэ талаар тодорхой тайлбар, арга хэмжээ авдаггүй (бол үүнийг “Тогцоо нүх” гэдэг)
 - ✓ Хиймэл, хуурамч болон нарийн төвөгтэй эдийн засгийн жижиг үндэслэл
 - ✓ Хуулийн зорилгоос ангид байх

15

Японы жишээ

- Татвараас зайлсхийх схемээс гарах үр нөлөөнд нэгдсэн байдлаар хориг тавих заалт байхгүй.
- Ерөнхий заалтууд
- (1) гэр бүлийн корпораци (2) нэгдсэн корпораци болон (3) бизнесийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой хийгдэх үйлдэл, тооцооны дүнд татварын дүнг бууруулсан тохиолдолд хориг тавих боломжтой
- ААНОАТ хууль.
 - 11-р зүйл: Ерөнхий зарчмын эд зүйлс (Татварт хамрах бодит өгөөж хүртэгч)
 - 132-1-р зүйл: Гэр бүлийн компаниудын тооцоо, хийгдэх үйлдлийг үл зөвшөөрөх
 - 132-2-р зүйл: Байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбоотой тооцоо, хийгдэх үйлдлийг үл зөвшөөрөх
 - 147-р зүйл: 132 –р зүйлийн заалтыг гадаадын ААН-д хамааруулан ашиглах

16 16

Жишээ 4

- i. Нидерландад төв компанитай (“Pco”), охин компани нь (“Subco”) Японд байдаг ба Японд шинэ бизнес (“New Biz”) эхлүүлэхээр болж, чимээгүй нөхөрлөлийн хэлбэрээр Tokumei Kumiai (“TK”) – ийг байгуулахаар харилцан тохирсон.
- ii. Pco нь партнераар, Subco нь оператораар ажиллахаар болсон
 - TK нь дараах онцлог шинжтэй:
 - ✓ TK-ийн өмч нь Операторт хамаарах шинж чанартай.
 - ✓ Оператор бизнес хийх, эсвэл хөрөнгө оруулалт хийнэ.
 - ✓ Партнер тал TK-ийн бизнест оролцохгүй, New Biz-ийн хувьд,
 - ✓ Ашгийг хэрхэн хуваахыг гэрээгээр зохицуулна,
 - ✓ Олсон ашиг эцсийн байдлаар Партнерт очино.

Жишээ 4

- iii) Pco компани TK компанид \$90 саяын хөрөнгө оруулалт хийж, үүнийгээ хадгаламж гэдэг байдлаар шийдсэн. Ашиг хуваах харьцаа нь 9:1 = Pco : Subco.
- iv) Subco нь New Biz-ээс \$200 саяын ашиг олсон.
- v) Дотоодын татварын хуулиар Subco нь татвар ногдох орлогоос \$20 саяын ашигтайгаар тайлагнасан.(ашиг \$200 сая – зардлын хасалт \$180 сая).
- vi) \$180 саяыг Pco компанид шилжүүлсэн. Японы орлогын татварын хуулиар Японы эх үүсвэрээс олсон орлого болж суутган татвар ногдоно. Суутган татварын хувь 20%.
- vii) Нидерландын хуулиар энэ тохиолдолд, гадаад эх үүсвэртэй орлогыг тухайн эх үүсвэрийн улсын буюу Японы татвар ногдуулна.
- viii) Нидерланд-Японы татварын гэрээгээр энэ төрлийн татварыг “Бусад татвар” гэж үзэх ба “Байнгын оршин суух газартаа татвар ногдуулах” орлогод хамаарна.

Урьдчилсан үнийн гэрээ Харилцан тохирох журам

1

ГАРЧИГ

- 1. Урьдчилсан үнийн гэрээ**
- 2. Харилцан тохирох журам**

2

1. Урьдчилсан үнийн гэрээ

3

1-1 Урьдчилсан үнийн гэрээ гэдэг нь

- Урьдчилсан үнийн гэрээ (АРА : Advance Pricing Arrangement) гэдэг нь ААН-ээс татварын байгууллагад гаргасан үнэ шилжилт тооцох аргын талаарх хүсэлтийг татварын байгууллага үндэслэлтэй эсэхийг шалган баталгаажуулсан бөгөөд тухайн ААН нь энэ дагуу татвараа тайлагнаж байгаа бол үнэ шилжилтийн ногдуулалт хийхгүй байх тогтолцоо юм.
- АРА-гийн хүсэлт гаргах ААН нь харилцан хамааралтай этгээдтэй хийх арилжаа, хугацаа (Үйл ажиллагааны жил) , үнэ шилжилт тооцох арга зэргийг бичсэн урьдчилсан баталгаажуулах хүсэлтийг (АРА Request) татварын албанд гарган өгөх шаардлагатай.

4


1-2 Урьдчилсан үнийн гэрээний зорилго

- АРА-ын зорилго нь ААН ба татварын байгууллагын хооронд үнэ шилжилтийг тооцох аргыг урьдчилан тодорхойлж, тохирсноор үнэ шилжилтийн татвар ногдуулалттай холбоотой ААН-ын урьдчилсан тооцоог баталгаажуулж, үнэ шилжилтийн татварын тогтолцоог зохистой хэрэгжүүлэхэд оршино.
- Урьдчилсан тооцооны боломжийг өндөржүүлэхийн тулд зөвхөн өөрийн орны татварын байгууллагаар зогсохгүй, харилцагч талын татварын байгууллагаар баталгаажуулах шаардлагатай байдаг. Үүнийг хоёр талт (Bilateral) АРА гэнэ. Нөгөө талаас, зөвхөн нэг талаас баталгаажсан АРА-г дотоодын (Unilateral) АРА гэнэ.

5

1-3 Жишээ (Хоёр талт АРА хүсэлт)

- А бүтээгдэхүүний арилжаа (Гаднаас орсон-Inbound)



【Хоёр талт АРА-ийн хүсэлтийн жишээ】

- Баталгаажуулах арилжаа: Төв ба охин компани хооронд А барааны арилжаа хийх
- Баталгаажуулах хугацаа: 5 жил (2014 оны 4 сарын 1-нээс 2019 оны 3 сарын 31)
- Үнэ шилжилт тооцох арга: Арилжааны цэвэр ашгийн арга (TNMM)
- Бие даасан ААН хоорондын үнийн хүрээ: Охин компанийн борлуулалтын ашгийн 3%~6%

6

1-4 Урьдчилсан үнийн гэрээний ОНЦЛОГ

- Ирээдүйн жилүүдийг хамруулна.
⇒ Судалгаа (хяналт шалгалт) нь өнгөрсөн жилүүдийг хамруулдаг
- Сунгасан гарын үнэд (ALP) хязгаар (Range) тогтооно
⇒ Хяналт шалгалтаар тодорхой түвшнээр татвар ногдуулдаг (Жишээ, борлуулалтын ашгийн хувь 3%)
- ALP-ийг тооцохдоо нээлттэй мэдээллийг ашиглана.
⇒ Хяналт шалгалтанд хаалттай мэдээлэл ашиглаж болно.

Татварын байгууллага нь ААН-ын гарган өгсөн мэдээллийг (бодит байдалтай холбоотой зүйлсийг оруулахгүй) хяналт шалгалтанд ашиглахгүй

7

1-5 Дотоодын урьдчилсан үнийн гэрээний процедур

Step 1: Урьдчилсан уулзалт (Pre-filing Meeting)

Step 2: Урьдчилсан үнийн баталгаажуулалтын хүсэлт (APA Request) гарган өгөх

Step 3: Урьдчилсан үнийн баталгаажуулалтын үнэлгээ (APA Evaluation)

Step 4: Урьдчилсан үнийн гэрээний үнэлгээний үр дүнг мэдэгдэх

Step 5: Жилийн тайлан гаргах (Annual Report)

(Жич) Жилийн тайлан гэдэг нь гэнээний агуулгатай нийцэх тайланг гаргаж байгаа болохыг тайлбарласан тайлан байх ба баталгаажуулалт хийгдсэн

8

ААН жил бүр энэ тайланг гаргах шаардлагатай.

1-6 Хоёр талт урьдчилсан үнийн гэрээний процедур

Step 1: Урьдчилсан уулзалт (Pre-filing Meeting)

Step 2: Урьдчилсан үнийн гэрээний баталгаажуулалтын хүсэлт гаргах

Step 3: Урьдчилсан үнийн баталгаажуулалтын хүсэлтийг хянах (APA Evaluation)

Step 4: Харилцан тохирох (Mutual Agreement Procedure)

Step 5: Урьдчилсан үнийн баталгаажуулалтын хүсэлтийг хянасан үр дүнгийн мэдэгдэл

Step 6: Жилийн тайлан (Annual Report) гарган өгөх

9

1-7 Урьдчилсан уулзалт

➤ АРА-ийн хүрээнд урьдчилсан уулзалт хийх гэдэг нь ААН-д чирэгдэл учруулахгүй байх үүднээс АРА-ийн хүсэлт гаргах гэж буй ААН-ын хүсэлтийн дагуу урьдчилан санал солилцохыг хэлнэ.

➤ Урьдчилсан уулзалтанд оролцогчид

➤ ААН талаас

- Санхүү хариуцсан ажилтан
- Төлөөний этгээд (Татварын нягтлан, мэргэшсэн нягтлан гэх мэт)


➤ Татварын байгууллагаас

- Урьдчилсан баталгаажуулалт хариуцсан байцаагч
- Харилцан тохирох асуудал хариуцсан ажилтан (Зөвхөн хоёр талт АРА)



10

1-8 Урьдчилсан уулзалтын дараах ажлын дараалал



1-9 Урьдчилсан үнийн гэрээний хүсэлт

➤ АРА-ийн хүсэлт гаргах ААН нь урьдчилсан үнийн гэрээний хүсэлтэд, шинжилгээ хийхэд шаардлагатай материалуудыг хавсарган татварын байгууллагад гарган өгнө.

- Гэрээнд хамаарах арилжаа, холбогдох этгээдүүдийн талаарх мэдээлэл
- Үнэ шилжилт тооцох арга ба энэ аргын үндэслэлийн талаарх тайлбар
- Урьдчилсан үнийн гэрээнд хамаатай үйл ажиллагааны ба эдийн засгийн нөхцөлүүд
- Баталгаажуулах арилжааны санхүүжилт хийх урсгал, төлбөр хийх валютын төрөл
- Хилийн гаднах харилцан хамааралтай этгээдтэй үндсэн хөрөнгийн ямар хамааралтай болох
- Арилжаанд оролцогсдын гүйцэтгэх үүрэг
- Өнгөрсөн 3 жилийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдал



1-10 Урьдчилсан үнийн гэрээний баталгаажуулалтыг хянах

➤ Хяналт, үнэлгээ хариуцсан ажилтан нь АРА-ийн хүсэлт хүлээн авсны дараа, бүрдүүлэлтийг шуурхай эхлүүлнэ:

- Үнэ шилжилт тооцох арга ба шалгагдах ААН (Tested Party)
- Баталгаажуулах арилжаа ба хамрах хугацаа
- Харилцан хамааралгүй этгээд хоорондын харьцуулах боломжтой арилжаа (Comparable Uncontrolled Transaction)
- Ашиг хуваах хувь (PS аргын хувьд)
- Зөрүүний тохиргоо (Comparability Adjustment)
- Сунгасан гарын үнийн хязгаар (ALP Range)
- Тэгшитгэх тохиргоо (Compensating Adjustment)
- Чухал нөхцөлүүд (Critical Assumption)



13

2. Харилцан тохирох журам

14

2-1 Харилцан тохирох журам гэж юу болох

- Харилцан тохирох журам (MAP : Mutual Agreement Procedure) гэдэг нь үнэ шилжилтийн татвар ногдуулалттай холбоотойгоор давхар татвар ногдуулалт үүссэн тохиолдолд болон ААН нь хоёр талт АРА-ийн хүсэлт тавьсан үед, татварын гэрээний заалтад үндэслэн, харьцагч улсын татварын байгууллагатай эдгээр асуудлыг шийдвэрлэх процедур юм.
- MAP -ийг татвар төлөгчдийн хүсэлтийн дагуу өөрийн улс ба харьцагч улсын эрх бүхий байгууллагууд (Competent Authority) харилцан уулзах зэрэг тулж уулзах хэлбэрээр (Face to Face) хийдэг.
- Хоёр талын татварын байгууллагууд нь MAP дээр санал нэгдсэн зүйлсээ хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

15

2-2 Японы хэрэгжүүлэх бүтэц

- Татварын ерөнхий газрын эрх бүхий байгууллага
 - Харилцан тохирох ⇒ Дэд дарга (Олон улс хариуцсан)
(Deputy Commissioner (International))
(Жич) Дэд даргын удирдлага, зааврын дагуу харилцан тохирох ажлын хэрэгжилтийг Харилцан тохирох тасаг (MAP Office) хариуцан хийнэ.
 - Мэдээлэл харилцан солилцох ⇒ Олон улсын хэлтсийн дарга (Director, International Operation Division)
- ТЕГ-ын харилцан тохирох тасгийн бүтэц
 - Одоогоор 41 хүний бүрэлдэхүүнтэй (3 нь тасгийн дарга)
 - Дэд даргаар удирдуулсан 1 баг нь 4 хүний бүрэлдэхүүнтэй.
 - Баг тус бүрийн хариуцах улс орныг тогтоосон байдаг.

16


2-3 Японы харилцан тохирох асуудлуудын ангилал

(2012 оны байдлаар)

Ангилал	Үүссэн тоо
Урьдчилсан баталгаа (АРА)	131
Үнэ шилжилтийн татвар	30
Бусад (Төлөөний газар, суутган татвар гэх мэт)	6
Нийт	167


17

2-4 Японы харилцан тохирсон асуудлуудын өөрчлөлт




18

2-5 Японы харилцан тохирсон асуудлуудын бүсчилсэн задаргаа



19

2-6 Японы харилцан тохирсон асуудлуудын аргаар ялгасан задаргаа



20

2-7 Харилцан тохирох дэс дараалал

Step 1: Урьдчилсан уулзалт

Step 2: Харилцан тохирох хүсэлт гаргах (MAP Request)



Step 3: Харьцагч улсад харилцан тохирох хүсэлт гаргах

Step 4: Харилцан тохирох \Rightarrow Санал нэгдэх, үл нэгдэх

Step 5: Татварын байгууллагад албан бичиг солилцох

Step 6: Татвар төлөгч ба холбогдох хэлтэст мэдэгдэх

21

2-8 Урьдчилсан уулзалт

➤ MAP –ын үеийн урьдчилсан уулзалт гэдэг нь ААН-д хүндрэлгүй байх үүднээс MAP-ийн хүсэлт гаргах гэж буй татвар төлөгчтэй урьдчилсан байдлаар уулзахыг хэлдэг.

➤ Урьдчилсан уулзалтад оролцогсад

➤ ААН талаас

- Санхүү хариуцсан ажилтан
- Төлөөний этгээд (Татварын нягтлан, мэргэшсэн нягтлан гэх мэт)

➤ Татварын байгууллагаас


- Урьдчилсан үнийн гэрээ хариуцсан байцаагч
- Харилцан тохирох асуудал хариуцсан ажилтан (Зөвхөн хоёр талт АРА)



22

2-9 Жишээ (Татвар ногдуулалт, харилцан тохирох хүсэлт)

➤ Бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



23

2-10 Харилцан тохирох хүсэлт гаргах

➤ МАР-ийн хүсэлт гаргагч татвар төлөгч нь шаардлагатай материалуудыг хавсарган Татварын албаны харилцан тохирох асуудал хариуцсан тасагт хүсэлтээ гаргана.

- Залруулгын мэдэгдэл зэрэг татвар ногдуулалтыг нотлох баримтын хуулбар
- Татвар ногдуулалтын бодит байдлыг харуулах болон холбогдогчдын саналыг тусгасан бичиг
- Гаргасан гомдол, татварын маргаан таслах нэхэмжлэлийн хуулбар (Гомдол, нэхэмжлэл гаргасан тохиолдолд)
- Холбогдогчдын хоорондын үндсэн хөрөнгийн болон эрхийн хамаарлыг харуулах материал (Үнэ шилжилттэй холбоотой тохиолдолд)
- Харьцагч улсад хандсан харилцан тохирох хүсэлтийн хуулбар (Хүсэлт гаргасан тохиолдолд)

24

2-11 Харьцагч улсад харилцан тохирох хүсэлт гаргах

- МАР-ийн хүсэлт гаргах шалтгаан байгаа гэж үзэж байгаа тохиолдолд, харилцан тохирох асуудал хариуцсан тасагт харьцагч улсад хандсан харилцан тохирох тухай хүсэлтийг бичгээр гарган өгнө.
- Харьцагч улсын тал харилцан тохирох хүсэлтийг хүлээн авсны дараа, харилцан тохирох асуудал хариуцсан тасаг нь өөрийн улсын байр суурийг илэрхийлсэн бичгийг (Position Paper) харьцагч улсад илгээхийн хамт харилцан тохиролцоог хийх өдрийн талаарх зохицуулалт хийнэ.

(Жич) Position Paper-д тусгах агуулга

- Үнэ шилжилтийн татвар ногдуулалтын тохиолдол ⇒ татвар ногдуулалтын агуулга, зохист байдал
- Урьдчилан баталгаажуулсан тохиолдол ⇒ Хүсэлтийн агуулга, хяналтын үр дүн гэх мэт

25

2-12 Харилцан тохиролцох

➤ Харилцан тохиролцлын агуулга


- Хийх газар: Өөрийн оронд эсвэл харьцагч улсад (Ихэвчилэн аль алинд нь хийдэг)
- Хугацаа: 1-2 долоо хоног
- Хийх давтамж: Жилд 2 удаа
- Оролцогсдын тоо: 6 хүн (2 талаа тус бүр 3 хүн)
(Жич) Татвар төлөгч оролцох боломжгүй
- Орчуулагч: 1-2 хүн, (Хийж байгаа улс зардлыг хариуцна)
- Үр дүн: Санал нэгдэх, үл нэгдэх
- 1 тохиолдлыг шийдэхэд шаардагдах хугацаа: 2 жил



26

2-13 Жишээ (Харилцан тохиролцолд хүрэх)

➤ Бараа бүтээгдэхүүний арилжаа (гаднаас орсон-Inbound)



27

2-14 Харилцан тохирсны дараах ажил

- Татварын албад хооронд албан бичиг солилцох
- Санал нэгдсэн тохиолдолд: Агуулгыг нарийвчилан баталгаажуулна.
 - Санал нэгдээгүй тохиолдолд: Санал нэгдэлгүй харилцан тохиролцоо дуусч байгааг баталгаажуулна.
(жич) Албан бичиг солилцсоны дараа санал нэгдсэн нэгдээгүй асуудал албан ёсоор баталгаажна.
- Татвар төлөгч ба холбогдох хэлтэст мэдэгдэх
- Харилцан тохирох хүсэлт гаргасан татвар төлөгчид үр дүнг бичгээр мэдэгдэнэ.
 - Харилцан тохирсон асуудлыг хэрэгжүүлэх шаардлагатай тул холбогдох хэлтэст адил мэдэгдлийг хүргүүлнэ.
(жич) Жишээнд үзүүлснээр Япон \$5 бууруулж, Х улс нь \$15 бууруулах шаардлагатай.

28

Мэдээлэл харилцан солилцох үндэс

1

Улс дамнасан ААН-ын татвараас зайлсхийх асуудлыг олон улсаас шүүмжилж байгаа нь....

GOOGLE

- Английн ААН нь Ирланд ба Бамутын ах дүү компанид ашгаа шилжүүлсэн (Ашиглалтын хураамжийн төлбөрөөр дэмжуулан)?

※ Ирландын ААН-ын татварын хувь хэмжээ 12.5%.
Гэхдээ, Ирландад

Ирланд нь удирдлагын байршлын жишгээр татвар ногдуулдаг тул Ирландад байгуулсан ААН байсан ч гадаадаас удирдлаг бол Ирландад татвар ногдуулахгүй.

※ Бамут нь ААНОАТ байхгүй.

- 2011 онд Англи дахь борлуулалтын орлого Англид хийсэн борлуулалт 400 сая паунд (60 тэрбум иен) байсантай харьцуулаад Английн ААН-ын татварын дүн 6 сая паунд (900 сая иен)
- Английн парламент нь дотоод мэдээллээр Английн ААН нь Англи улс дахь үйлчлүүлэгчдээ вебээр дамжуулан борлуулалт хийж байгааг илрүүлсэн гэж мэдэгдсэн.
- Google-ийн удирдлага нь Английн ААН бус, Ирландын ах дүү компаниас Английн үйлчлүүлэгчдэд шууд сурталчилгаа, худалдаа хийсэн гэж мэдүүлсэн.

AMAZON

- Люксембургийн ах дүү компанийн ашгийг шилжүүлсэн. (Ашиглалтын хураамжаар дамжуулан)
- 2011 онд Англи улс дахь борлуулалтын үнийн дүн 3,3 тэрбум паунд (495 тэрбум иен) байсантай харьцуулаад Английн ААН-ын татварын дүн 1,8 сая паунд (270 сая иен)
- Английн парламентаас Английн ААН-ын удирдлагыг дуудан асуулга хийсэн.

APPLE

- Америкийн төв компаниас Ирландын охтн компанид ашгаа шилжүүлсэн эсэх. (Ашиглалтын хураамж, хүүгийн төлбөрөөр дамжуулан)
- 2009~12 оны хооронд 74 тэрбум долларын (7 их наяд 400 тэрбум иен) ашгийг Ирландад цуглуулсан ба татварын хувь хэмжээ 2%.
- Америкийн парламент тус компанийн захирлыг дуудан асуулга авсан.

Мэдээлэлд үндэслэн бэлтгэсэн

Английн Старбакс ААН ба Английн татварын албатай санал нэгдсэн нь (1)

1. Асуудлын агуулга
 - 1998 онд Англид үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш, 3 тэрбум паундын (426 тэрбум иен) борлуулалттай боловч, их хэмжээний алдагдлыг санхүүгийн тайландаа тусгаснаас төлсөн ААНОАТ нь дөнгөж, 8,6 сая паунд байсан. (1,2 тэрбум иен)
 - Үүнтэй холбоотойгоор тухайн ААН-ийг татварын хувь хэмжээ багатай улсад ашгаа шилжүүлсэн гэж үзсэн.


2. Ашгаа шилжүүлсэн нь



Английн Старбакс ААН ба Английн татварын албатай санал нэгдсэн нь (2)

3. Тухайн ААН-ын талаарх шүүмж ихэссэн.
 - Тухайн ААН нь түрээсийн өндөр төлбөр төлсөн бөгөөд менежментийн стратегийн алдаанаас шалтгаалсан алдагдал гэж тайлбарласан.
 - Английн Старбакс компанийн татвар төлөлтийн дүнгийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр зарлагдсанаар Худалдан авахгүй байх хөдөлгөөн өрнөж, эсэргүүцэл нэмэгдсэн.
4. Сайн дурын “Татвар” төлөлтийн амлалт
 - 2013-14 оны хоорондох 2 жилийн хугацаанд ААН дотрын зээлийн хүүгийн төлбөр, түүхий эдийн зардалтай холбоотойгоор 20 сая паунд (2,8 тэрбум иен) төлснийг зардалд тусгуулахгүй байхаар болсон.
 - 2013-14 оны хоорондох 2 жилийн хугацаанд ашигтай ажилласан эсэхээс үл хамааран, жилд 10 сая паундыг (1.4 тэрбум иен) Английн Засгийн газарт төлөх.
5. Европ дахь Төв компани Англи улс руу шилжүүлэх.
 - Шилжүүлсний дараа Англид төлөх татварын хэмжээ өссөн бөгөөд олон нийтээс ирэх шүүмжийг бууруулах оролдлого байсан.


Офшор, нийцлийг сайжруулахтай холбоотой урсгал



САНХҮҮ, ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ 2-Р УУЛЗАЛТААС ГАРСАН УЛС ОРНУУДЫН УДИРДЛАГЫН ТУНХАГЛАЛ (2009 ОНЫ 4 САРЫН 2, ЛОНДОН ХОТ)

Татварын диваажинг оруулаад хамтын ажиллагаанд идэвхгүй байдаг улс орон, бүс нутагт чиглэсэн арга хэмжээ авах. Бид төсөв эдийн засаг, санхүүгийн системийг хамгаалахын тулд хориг арга хэмжээ авахад бэлэн байна. Банкны нууцын цаг үе дууссан. Татварын мэдээлэл харилцан солилцох стандартыг зөрчсөн ба дэлхийн чуулга уулзалтаар үнэлгээ өгсөн улс орнуудын жагсаалтыг OECD нийтэд зарласныг анхаарч үзэх шаардлагатай.

Татварын гэрээ, татварын мэдээлэл харилцан солилцох гэрээнд гарын үсэг зурсан тоон өсөлт



(жич) гарын үсэг зурагдсан тоо нь 2008 оны 1 сараас хойш зурагдсан татварын гэрээ, мэдээлэл харилцан солилцох гэрээний тоо (нэмэгдсэн дүн)

Эх үүсвэр: Global Forum on Transparency and Exchange of Information for Tax Purposes, A Background Information Brief (2011.10.26)


7

Татварын тунгалаг байдал, мэдээлэл харилцан солилцохтой холбоотой олон улсын чуулга уулзалт (Global Forum on Transparency and Exchange of Information for Tax Purposes)

- Татварын тунгалаг байдал, мэдээлэл харилцан солилцохтой холбоотой OECD-ийн гишүүн ба гишүүн бус улс орнуудын харилцан санал солилцох уулзалт
- 2014 оны 4 сарын байдлаар, OECD гишүүн орнуудаас гадна, гишүүн бус улс орнуудыг оруулаад нийт 121 улс орон, бүс нутаг оролцсон.
- Татварын мэдээлэл харилцан солилцохтой холбоотой олон улсын стандартыг хэрэгжүүлэхийн тулд мэдээлэл харилцан солилцох гэрээ, дотоодын хүчинтэй хуулийн орчны бүрдүүлэлт, хэрэгжилтийн байдлын талаар харилцан үнэлгээ өгөх, мониторинг хийх боломжтоор хангаж байна.
- Харилцан үнэлгээ хийхдээ дараах үзүүлэлтийг барина.
 - ① Мэдээллийн бүртгэл, хадгалалт (Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, санхүү бүртгэлийн зохистой бүртгэл, хадгалалт)
 - ② Татварын байгууллагын мэдээлэл цуглуулах эрх (Санхүүгийн байгууллагаас мэдээлэл авах эрх гэх мэт)
 - ③ Татварын байгууллага хоорондын мэдээлэл солилцоо (Мэдээллийн нөхцөл байдал, мэдээллийг зохих хугацаанд солилцох, өөрийн улсын татвар ногдуулалтын эрх ашигтай холбоогүйгээр мэдээлэл харилцан солилцох зэрэг)

8

Олон улсын чуулга уулзалтад оролцогсад (121 улс орон, бүс нутаг)



9

G20-ийн тунхаглал (OECD олон улсын чуулга уулзалттай холбоотой)

G20 Сангийн сайд, төв банкны ерөнхийлөгчдийн тунхаглал
(2014 оны 2 сар, Сидней)

(9-р догол мөр) Бид хүсэлтийн дагуу мэдээлэл харилцан солилцохтой холбоотой хүчинтэй стандартыг мөрдөхгүй байгаа бүх улс, бүс нутагт хандан тус стандартыг яаралтай мөрдөж эхлэх, татварын удирдлагын хэрэгжилтийг хангах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурахыг шаардаж байна. 2-р шатны үнэлгээнд хамрагдах эрхгүй 14 улс орон, бүс нутаг илүү хатуу арга хэмжээ авах бэлтгэл хангадаад байна.

10

Мэдээлэл харилцан солилцох 3 хэлбэр

1. Тухайлсан мэдээлэл харилцан солилцох (Хүсэлтэд үндэслэсэн)

Тухайлсан татвар төлөгчид хяналт шалгалт хийхдээ, зөвхөн дотоодын мэдээллээр бодит байдлыг тодорхойлоход хангалтгүй тохиолдолд, татварын гэрээтэй улс орон, бүс нутгийн татварын байгууллагаас (гадаад улсын татварын байгууллага) мэдээлэл гарган өгөхийг хүсэхийг хэлнэ. Татвар төлөгчийн харилцагч тал нь гадаад улсад байрладаг бөгөөд дотоодын мэдээллээр хөөн хангалттай татварын хяналт шалгалт хийх боломжгүй үед маш үр ашигтай арга юм.

2. Сайн дурын мэдээлэл харилцан солилцох

Өөрийн орны татвар төлөгчид татварын хяналт шалгалт хийх үедээ олсон мэдээлэл нь гадаад улсын татварын байгууллагад ач холбогдолтой мэдээлэл болохыг тогтоосон бол тухайн мэдээллийг сайн дураар тухайн улсын татварын байгууллагад гарган өгөхийг хэлнэ.

3. Энгийн аргаар мэдээлэл харилцан солилцох

Албан баримт мэдээллээс илрүүлсэн байнгын бус оршин суугчид төлөгдсөн хүү, ноогдол ашиг, ашиглалтын хураамжийн төлбөртэй холбоотой мэдээллийг тухайн хүү, ноогдол ашиг, ашиглалтын хураамжийг төлсөн улсын татварын байгууллагаас хүлээн авсан улсын татварын байгууллагад илгээдэг мэдээлэл.

Оффшор, нийцлийг сайжруулахад чиглэгдсэн шинэ хандлага

ОГМэдээллийг энгийн аргаар харилцан солилцох J-ыг эрчимжүүлэх

- Байнгын бус оршин суугчид төлөгдсөн хүү, ноогдол ашиг, ашиглалтын хураамж, цалингийн талаарх нэгдсэн мэдээллийг эх үүсвэрийн улсын татварын байгууллагаас тухайн төлбөрийг хүлээн авсан хүний оршин суугаа улсын татварын байгууллага руу тогтмол хугацаанд илгээх
- G20-ийн Сангийн сайд, төв банкны ерөнхийлөгчдийн нэгдсэн хуралдаанаас гарсан тунхаглалаар (2012 оны 2 сар) мэдээллийг энгийн аргаар харилцан солилцох асуудлыг сайжруулахын тулд OECD-ээс тайлагнаж байх хүсэлт гаргасан.

ОАНУ-ын гадаад дансны татварын нийцлийн тухай хууль (FATCA)

- АНУ-ын иргэнтэй холбоотой дансны мэдээллийг, гадаад улсын санхүүгийн байгууллагаас АНУ-ын татварын байгууллагад гарган өгөхийг үүрэг болгодог.

Санхүүгийн байгууллагын дансны талаарх мэдээллийг энгийн аргаар солилцох тухай

Түүхэн замнал


- Байнгын бус оршин суугчид төлсөн төлбөрийн талаарх албан мэдээллийн эх үүсвэрт үндэслэн, мэдээллийг энгийн аргаар солилцох ажлыг улс орон хооронд харилцан хэрэгжүүлж ирсэн.
- Нөгөө талаас, АНУ-д 2010 онд «Гадаад улс дахь дансны татварын нийцлийн тухай хууль» (FATCA) батлагдсан. Энэ хуулиар санхүүгийн байгууллага нь АНУ-ын иргэний дансны үлдэгдлийн мэдээллийг АНУ-ын орлогын байгууллагад гарган өгдөг.
- FATCA-аар дамжуулан, санхүүгийн дансны үлдэгдлийн мэдээллийг энгийн аргаар харилцан солилцох ажлыг дэлхий дахинаар эрчимжүүлж, OECD-д энгийнээр мэдээлэл харилцан солилцох стандартыг боловсруулах ажлыг эхлүүлсэн.

Хуваарь

- ① Шинэ стандартыг 2014 оны 1 сарын OECD-ийн татварын зөвлөлд албан ёсоор батлагдаж, 2 сарын 13-нд OECD-ээс нийтэд зарласан.
- ② Тухайн стандартыг 2014 оны 2 сарын 22-23-нд G20-ийн Сангийн сайд, төв банкны ерөнхийлөгчийн нэгдсэн хурал дээр тайлагнасан. (Сидней)
- ③ IT-тай холбоотой технологийн асуудлын талаар 2014 оны дунд хүртэл OECD-д боловсруулахаар төлөвлөж байна.
- ④ 2015 оны эцэс хүртэл G20-ийн орнуудад тухайн стандартын дагуу мэдээллийг энгийн аргаар солилцох ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

17

Нийтлэг тайлагналтын стандартаар мэдээлэл энгийнээр харилцан солилцох (Гадаад улс ⇒ Япон)



14

Thank you !

Олон улсын татвар ногдуулалтын гүнзгий шатны сургалт

(2017.9.11-2017.9.15)

Он сар өдөр	Цаг	Сургалтын агуулга	Хариуцсан багш
2017.9.11 (Даваа)	09:00-10:30	Олон улсын татварын өнөөгийн байдал (BEPS-тэй холбогдуулан)	Төслийн зөвлөх Ишигүро Хидэаки
	10:40-12:00		
	13:00-14:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (BEPS-тэй холбогдуулан)	Төслийн зөвлөх Кодера Тошинари
	14:40-16:00		
2017.9.12 (Мягмар)	09:00-10:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Үнэ шилжилтийн аргууд)	Төслийн зөвлөх Кодера Тошинари
	10:40-12:00		
	13:00-14:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Үнэ шилжилтийн аргууд)	
	14:40-16:00		
2017.9.13 (Лхагва)	09:00-10:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Жишээн дээр суралцах)	Тажино Микио
	10:40-12:00		
	13:00-14:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Жишээн дээр суралцах)	
	14:40-16:00		
2017.9.14 (Пүрэв)	09:00-10:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Жишээн дээр суралцах)	Тажино Микио
	10:40-12:00		
	13:00-14:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Жишээн дээр суралцах)	Тажино Микио
	14:40-16:00		
2017.9.15 (Баасан)	09:00-10:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Жишээн дээр суралцах)	Тажино Микио
	10:40-12:00		
	13:00-14:30	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (Жишээн дээр суралцах)	
	14:40-16:00		

Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийн жагсаалт

№	Нэрс	Харьяа нэгж
1	Ч.Эрдэнэчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУАБ
2	Х.Сувд-Эрдэнэ	ТЕГ-ын Төрийн захиргааны удирдлагын газрын ТУБ
3	Н.Жаргалцэцэг	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
4	Ж.Цэрэнцоо	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
5	А.Сувдаа	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
6	Г.Энхжин	ТЕГ-ын Татварын орлогын газрын ТУБ
7	Ц.Баярмаа	ТЕГ-ын Дотоод аудитын газрын ТУБ
8	Б.Ариунгэрэл	ТЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ТУБ
9	Н.Туул	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
10	Ш.Ундраа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
11	Б.Золзаяа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
12	Б.Батчимэг	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
13	С.Гүнжинлхам	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
14	Д.Батжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУАБ
15	С.Төгсжаргал	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУАБ
16	Ц.Дэлгэрмаа	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
17	Г.Бямбасүрэн	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
18	П.Отгонсүрэн	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
19	Н.Болорчимэг	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
20	Н.Мөнхдаваа	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
21	Н.Хандхүү	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
22	Ц.Ишжамц	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
23	Б.Төгсжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
24	Ш.Энхжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
25	Ё.Мөнхбат	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
26	Ш.Батзаяа	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
27	Б.Уранцэцэг	УТОХГ-ын Эрсдэл, статистикийн хэлтсийн ТУБ
28	Ц.Түвшинбаяр	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
29	Г.Банзрагч	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
30	Х.Алтанхүү	УТОХГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
31	О.Цэнд-Аюуш	НТГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтэс
32	Ж.Эрдэнэбүрэн	НТГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
33	Л.Даваасүрэн	БЗД-ын Татварын хэлтсийн ТУБ
34	Б.Бат-Эрдэнэ	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
35	Ч.Лхамрагчаа	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
36	Д.Солонго	СБД-ын Татварын хэлтсийн ТУБ
37	Ц.Ундармаа	СХД-ын Татварын хэлтсийн ТУБ
38	Б.Очирхуяг	ХУД-ын Татварын хэлтсийн ТУБ
39	С.Наранбаатар	Дорнод аймгийн Татварын хэлтсийн ТУБ
40	Ц.Өнөрмөнх	Орхон аймгийн Татварын хэлтсийн ТУБ
41	С.Дүүбаяр	Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн ТУБ
42	Л.Мөнхтуул	ТЕГ-ын Хуулийн хэлтсийн ТУБ

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ТАТВАР НОГДУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГИЙН ҮР ДҮН БА ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

— *BEPS* —Г ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД —


1

2017.9.11

ЖСА төслийн зөвлөх

Ишигүро Хидэаки

Япон Улсын олон улсын татвар ногдуулалтын ТОГТОЛЦОО



2

OECD/G20 BEPS ТӨСӨЛ

○ BEPS (Татварын суурийг гажуудуулах, ашиг шилжүүлэх, Base Erosion and Profit Shifting)

Улс дамнасан ААН нь олон улсын ажил гүйлгээгээр дамжуулан, нийт группынхээ татварын ачааллыг хамгийн бага болгох зорилготойгоор хуулийн хүрээнд ашгаа шилжүүлэх, эх үүсвэрээ үгүйсгэх ажиллагаа юм.

○ BEPS-н эсрэг арга хэмжээ

2012 оны 6 сар ЭЗХАХБ-аас G20-ийн улс орнуудын хүсэлтээр эхлүүлсэн.

2013 оны 7 сар BEPS үйл ажиллагааны төлөвлөгөөг зарласан.

2015 оны 9 сар Эцсийн тайланг гаргасан.

11 сар G20-ийн Анталяа чуулганаар баталсан.

3

BEPS БА ХӨГЖИЖ БҮЙ УЛС ОРНУУДЫН ХАРИЛЦАН УЯЛДАА

- Гадаадын харилцан хамааралтай ААН-д төлсөн хүү, үйлчилгээний хураамж, менежмент ба технологийн төлбөр, ашиглалтын хураамжийг хэтрүүлэн төлөх байдлаар татварын эх үүсвэрийг үгүйсгэх.
- Татварын хувь хэмжээ багатай улсад байх харилцан хамааралтай ААН-д гэрээний үндсэн дээр эрсдэл ба холбогдох ашгийг дахин хуваарилах замаар хийх нийлүүлэлтийн гинжин холбоосоор дамжуулан ашгийг шилжүүлэх.
- BEPS-ийн асуудлыг үнэлэх, арга хэмжээ авах, үнэ шилжилтийн татварт шаардлагатай мэдээлэл олж авахад хүндрэлтэй байх.
- Татварын гэрээний заалтыг урвуулан ашиглах
- Дотоодод байх хөрөнгийг борлуулах үедээ татвараас зайлсхийх.


4

ТАТВАРЫН ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫГ УРВУУЛАН АШИГЛАХ

Түвшин	Үйл ажиллагаа	Хугацаа	Түвшин	Үйл ажиллагаа	Хугацаа
Өндөр	4-Хүүг зардалд тусган татварын суурийг гажуудуулахыг хязгаарлах	Sep. 2015	Дунд	8-Үнийн үүсэлтэд нийцсэн үнэ шилжилтийг хийх:Биет бус хөрөнгө	Sep. 2014
		Dec. 2015			Sep. 2015
Өндөр	6-Татварын гэрээг урвуулан ашиглахаас сэргийлэх	Sep. 2014	Дунд	9-Үнийн үүсэлтэд нийцсэн үнэ шилжилтийг хийх: Эрсдэл ба үндсэн хөрөнгө	Sep. 2015
Өндөр	7-Төлөөний газрыг тодорхойлуулахаас санаатай зайлсхийхээс сэргийлэх	Sep. 2015	Дунд	12-Татвар төлөгчдөд татварын төлөвлөлтөө тайлагнах шаардлага тавих	Sep. 2015
Өндөр	10-Үнийн үүсэлтэд нийцсэн үнэ шилжилтийг хийх: Бусад эрсдэл өндөртэй ажил гүйлгээ	Sep. 2015	Дунд	14-Харилцан тохиролцоог үр өгөөжтэйгээр хэрэгжүүлэх	Sep. 2015
Өндөр	11- BEPS-ийн талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх арга ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэх	Sep. 2015	Сул	2-Сөрөг үр дагавартай холимог зохицуулалт (Hybrid mismatch)-ийн нөлөөг хүчингүй болгох	Sep. 2014
Өндөр	13- Үнэ шилжилтийн татварыг документацижуулах асуудлыг дахин авч үзэх	Sep. 2014	Сул	3- Гадаад улсад байх охин компаний ажгийг нэгтгэн тооцох тогтолцоог чангатгах	Sep. 2015
Дунд	1- Цахим ажил гүйлгээнд татвар ногдуулах	Sep. 2014	Сул	15- Олон талт гэрээг дэмжих	Sep. 2014
Дунд	5- Хор хөнөөлтэй татварын асуудалтай үр дүнтэйгээр ажиллаж, тунгалаг байдал болон бүрэлдэхүүн хэсгийн талаар авч үзэх.	Sep. 2014			Dec. 2015
		Sep. 2015	Dec. 2015	OECD (2014), <i>Part 1 of A Report to G20 Development Working Group on the Impact of BEPS in Low Income Countries</i> , Paris.	

5

ОЛОН УЛСЫН ТАТВАР НОГДУУЛАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ХӨДӨЛГӨГЧ 3-Н ГОЛ АРАА



6

ОЛОН УЛСЫН ТАТВАР НОГДУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ ӨРГӨЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

○ Үр дүн

ААНБОАТ-ын үнэ шилжилттэй холбоотой зүйл заалтад оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл

- Урьдчилсан үнийн гэрээ (АРА) ♦ 4-р зүйл
- Үнэ шилжилтийг тооцох арга (ТРМ) ♦ 12-р зүйл

○ Шийдвэрлэх асуудал

BEPS төслийн саналд тулгуурлан дотоодын хууль тогтоомж, татварын гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлт (Өндөр хүүгийн төлбөрийн татвар, төлөөний газар (PE: Permanent Establishment) хамрах хүрээг тэлэх, үнэ шилжилтийн татварын тогтолцоог өргөжүүлэх зэрэг)

7

БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

○ Үр дүн


Татварын гэрээн дээр үндэслэсэн мэдээлэл харилцан солилцох тогтолцоог ашиглахтай холбоотой сургалт, сургалчилгааг Хамтын ажиллагааны газраар дамжуулан нийт татварын албадын дарга, байцаагчдад хийсэн.

○ Шийдвэрлэх асуудал

Олон улсын татвар ногдуулалтын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дунд ба урт хугацааны алсын хараатай илүү мэргэжлийн үйл ажиллагаатай бүтцийг бүрдүүлэх.

8

ОЛОН УЛСЫН ТАТВАР НОГДУУЛАЛТЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ПИРАМИД



9

ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ АРГА ХЭМЖЭЭ (ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ДЭМЖИХ)

o Үр дүн

- Олон улсын татварын нэр томъёоны тайлбар толь
- ЭЗХАХБ загвар гэрээ (Монгол хэлээр)
- Үнэ шилжилтийн хяналт шалгалтын жишээний эмхэтгэл
- Үнэ шилжилтийн гарын авлага

o Шийдвэрлэх асуудал

Олон улсын татвар ногдуулалтад хийх хяналт шалгалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд салбараар ялгаатай хяналт шалгалтын гарын авлага боловсруулах.

10

ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ АРГА ХЭМЖЭЭ (СУРГАЛТ)

o Үр дүн (ойролцоогоор 38,000 хүн-өдөр)

- Олон улсын татвар ногдуулалт хариуцсан байцаагчдын сургалт (36 өдөр, давхардсан тоогоор 180 хүн)
- Олон улсын татвар ногдуулалт хариуцсан байцаагчдын Японд хийсэн сургалт (26 өдөр, давхардсан тоогоор 43 хүн)
- Японы ТЕГ-ын ажилтан уригдан ирж хийсэн сургалт (6 өдөр, нийт 93 хүн)
- Энгийн байцаагчдад зориулсан сургалт (83 өдөр, нийт 145 хүн)

o Шийдвэрлэх асуудал

- Сонгогдон бэлтгэгдсэн байцаагчдыг ахисан түвшинд үргэлжлүүлэх сургах.
- Олон улсын татвар ногдуулалт хариуцан ажиллах байцаагчдыг нэгдсэн цогц, тасралтгүй сургалтаар хангаж, бэлтгэх

TP & BEPS Q&A

2017.9.11

ЛСА мэргэжилтэн
Кодера Тошинари

1

АГУУЛГА

- 2010 оны OECD-ын үнэ шилжилтийн гарын авлагын дагуу хийх баримтжуулалт
- BEPS-ийн өмнөх Японы баримтжуулалт
- 2015 он, BEPS-ийн хүрээнд хийх баримтжуулалт (BEPS-ийн Үйл ажиллагааны төлөвлөгөө 13)
- 2016 он, BEPS-ийн дараах Японы баримтжуулалт

2

Q 2010 он OECD-ийн үнэ шилжилтийн GUIDELINE

5-р бүлгийн баримтжуулалтын агуулга

A Дараах догол мөрөнд тусгасан байдаг.

o Para 5.1

Баримтжуулалт нь үнэ шилжилтийн асуудлыг шийдвэрлэх, татварын хяналт шалгалтыг хийхэд хялбар болгоход шаардлагатай удирдамжаар хангах зориулалттай.

o Para 5.4

Татвар төлөгч нь үнэ шилжилтийг тооцох суурь болох мэдээлэл, тооцоо хийх аргын тухайд, бие даасан аж ахуйн нэгжийн зарчмыг баримталсан болохоо батлах нотолгоо баримтыг бэлтгэх шаардлагатай.

o Para 5.7

Эдгээр баримт нь харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээ нь бие даасан аж ахуйн нэгжийн зарчмаар хийгдсэн эсэхийг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай бичиг баримт болно.

3

Q BEPS-ийн өмнө Японы баримтжуулалтын агуулга

Q BEPS-ээс өмнө Японд баримтжуулалтын талаарх заалт байсан эсэх.

A YES. Үнэ шилжилтийн татварын тогтолцооны хэрэгжилтийг хангахын тулд татвар ногдуулалтад шаардлагатай баримтыг татварын байгууллага цуглуулах шаардлагатай байдаг.

Q BEPS-ийн өмнө Японы баримтжуулалтын байдал ямар байсан болох.

A Тусгай арга хэмжээний тухай хуулийн 66-4-т гадаад харилцан хамаарал бүхий этгээдтэй хийсэн ажил гүйлгээтэй холбоотой болон, сунгасан гарын үнэ тооцохтой холбоотой бичиг баримтыг шаарддаг байсан. BEPS-ийн локал файльтай адил төрлийн зүйл.

Q Гарган өгөхийг үүрэг болгодог байсан эсэх.

A Үүрэг болгодоггүй байсан. Гэхдээ, гарган өгөхийг шаардсан үед, саадгүй гарган өгөөгүй тохиолдолд, татварын байгууллага үнэ шилжилтийн тооцоог жишгээр тооцон татвар ногдуулах эрхтэй байсан.

4

**Q Японы BEPS-ийн ӨМНӨХ БАРИМТЖУУЛАЛТ ДАХЬ
ГАДААД ХАРИЛЦАН ХАМААРАЛ БҮХИЙ АЖИЛ
ГҮЙЛГЭЭНИЙ АГУУЛГАТАЙ ХОЛБООТОЙ БИЧИГ
БАРИМТ ГЭДЭГ НЬ**

А Дараах бичиг баримт болно:

- Ажил гүйлгээнд хамаарах хөрөнгийн дэлгэрэнгүй, үйлчилгээний агуулга
- Холбогдох талуудын үүрэг, хариуцах эрсдэл

Q Хариуцах үүрэг, хариуцлага, эрсдэлийн жишээ гаргах.

- Холбогдох талуудын ашигласан биет бус хөрөнгө
- Гэрээ
- Үнэ тогтоох арга ба хэлэлцэх үе шат
- Ажил гүйлгээний холбогдогч талуудын ашиг, алдагдлын задаргаа
- Ажил гүйлгээтэй холбоотой зах зээлийн дүн шинжилгээ
- Ажил гүйлгээнд холбогдогч талуудын бизнесийн чиглэл
- Ажил гүйлгээтэй нягт холбоотой бусад ажил гүйлгээ байгаа эсэх, байгаа бол агуулга

5

**Q BEPS-ийн ӨМНӨХ ЯПОНЫ БАРИМТЖУУЛАЛТАД
СУНГАСАН ГАРЫН ҮНЭ ТООЦОХОД ЗОРИУЛСАН БИЧИГ
БАРИМТЫН ТАЛААР**

А Дараах 3 бичиг баримт байсан:

- Сунгасан гарын үнэ тооцох арга

Q Үнэ тооцох аргуудыг бүгдийг харуулж, тэдгээрийн онцлогийг тодорхойлох.

- Харьцуулах ажил гүйлгээг сонгохтой холбоотой зүйлс

Q Сонголт хийхдээ юуг анхаарах ёстой вэ.

- Харьцуулах ажил гүйлгээний талаар зөрүүний зохицуулалт хийсэн бол ямар шалтгаанаар, ямар аргаар хийх.

Q Зөрүүний зохицуулалтын жишээ гаргах.

6

Q BEPS-ийн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 13-Т ЮУГ АСУУДАЛ БОЛГОН ТАВЬДАГ ВЭ. ЯМАР АГУУЛГАТАЙ ВЭ.

A1 Хил дамнасан групп компанийн групп дотроо хийсэн ажил гүйлгээгээр олсон орлогыг гадаадад шилжүүлэхийн тухайд, үнэ шилжилтийн татвар ногдуулалтыг зохистой хийхийн тулд, тухайн ажил гүйлгээний нийт зураглалтай холбоотой (OECD-д BIG PICTURE гэдэг) мэдээлэл шаардлагатай байдаг.

A2 Тодруулбал, дараах 3 мэдээлэл байдаг:

1. Улсаар ялгасан тайлан (Country-by-Country Report)

➔ Улс тус бүрээр ялгасан орлого, эдийн засгийн үйл ажиллагаа, татварын дүнгийн мэдээллийг нийтлэг форматаар татварын байгууллагад тайлагнах.

2. Мастер файл (Master File)

➔ Хил дамнасан ААН-ын нийт группын мэдээллийн тайлан

3. Локал файл (Local File)

➔ Охин компани тус бүрийн мэдээлэл.

7

Q BEPS-ийн ҮЙЛ АЖИЛЛАГААНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 13-ИЙН ЗӨВЛӨМЖИЙН АГУУЛГА

А Дараах зөвлөмжийг өгдөг:

1) Улсаар ялгасан тайлан

○ Өмнөх тайлант хугацааны нэгдсэн орлогын дүн нь 750 сая еврогоос (100 тэрбум иен орчим) их байх хил дамнасан групп компанид улс тус бүрээр ялгасан мэдээллийг (улс бүрээрх орлогын дүн, татварын өмнөх тухайн тайлант хугацааны ашиг (алдагдал), төлсөн татварын хуваарилалт гэх мэт) татварын байгууллагад гарган өгөхийг шаардах.

○ Татварын байгууллагад гарган өгсөн мэдээлэл нь мэдээлэл харилцан солилцох зарчмаар холбогдох улсын татварын байгууллагууд харилцан солилцож, үнэ шилжилтийн эрсдэлийн өндөр түвшний дүн шинжилгээнд ашиглагддаг.

Q Ямар мэдээллийг харилцан солилцдог болох

2) Мастер файл (Master File)

○ Хил дамнасан группын доторх бүтэц зохион байгуулалт, санхүү, үйл ажиллагааны агуулга, олон улсад хийсэн эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг татварын байгууллагад гарган өгөхийг шаардах.

3) Локал файл (Local File)

○ Харилцан хамаарал бүхий этгээд хоорондын ажил гүйлгээний үнэ шилжилтийг тооцох үндэслэл болох нарийвчилсан мэдээллийг боловсруулах, хадгалах (баримтжуулалт)-ыг шаардах.

8

Q BEPS-ийн үйл ажиллагааны ТӨЛӨВЛӨГӨӨ 13 БА ЯПОНЫ ТАТВАРЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧИЛЭЛТ

А Японы хувьд, 2016 оны өөрчлөлт шинэчилэлтээр дээрх 1)-ээс 3)-ийн тухайд, 「Улсаар ялгасан тайлан」, 「Үйл ажиллагааны нөхцөл байдлын тайлан」, 「Сунгасан гарын үнэ тооцоход шаардлагатай бичиг баримт」гэсэн байдлаар тусган, шинэчилэлт хийж байна.

Q BEPS-ийн үйл ажиллагааны ТӨЛӨВЛӨГӨӨ 13-д НИЙЦҮҮЛСЭН ЯПОНЫ 2016 ОНЫ ТАТВАРЫН ШИНЭЧИЛЭЛТИЙН АГУУЛГА 1

A1 2016 оны татварын шинэчилэлтийн хүрээнд, хил дамнасан группын улсаар ялгасан үйл ажиллагааны нөхцөл байдлын мэдээлэл (「Улсаар ялгасан тайлан」), ААН-ын олон улсад хийж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл (「Үйл ажиллагааны нөхцөл байдлын тайлан (Мастер файл)」 болон харилцан хамаарал бүхий этгээд хоорондын ажил гүйлгээний сунгасан гарын үнэ тооцоход шаардлагатай нарийвчилсан мэдээллийг (「Локал файл」) татварын байгууллагад гарган өгөхийг (эсхүл бэлтгэн, хадгалах) үүрэг болгосон.

A2 Улсаар ялгасан тайлан ба Мастер файлийн тухайд, өмнөх тайлант хугацааны нийт орлогын дүн 100 тэрбум иенээс их байсан хил дамнасан группын төв компани нь тайлант хугацааны эцсийн өдрийн дараагийн өдрөөс 1 жилийн дотор, улсын татварын цахим тайлан, татвар төлөлтийн (e-Tax) системд гарган өгөхөөр заасан.

A3 Эдгээрээс, улсаар ялгасан тайланг, **татварын гэрээний хүрээнд хийх ердийн мэдээлэл солилцоонд** үндэслэн, хил дамнасан компанийг бүрдүүлэгч компаниуд, оршин суугаа улсынхаа татварын байгууллагад мэдээлэл болгон гарган өгөхөөр болсон. Манай улсын хувьд, 2018 оны 9 сар хүртэл хугацаанд гадаад улсын татварын байгууллагад мэдээлэл гарган өгөх ажлыг эхлүүлэх, гадаад улсаас улсаар ялгасан тайлантай дүйцэх мэдээллийг хүлээн авах ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Q СУНГАСАН ГАРЫН ҮНЭ ТООЦОХ БИЧГИЙГ ХЭРХЭН ГАРГАН ӨГӨХ.

- A1 Сунгасан гарын үнийг (ALP) тооцоход шаардлагатай бичиг баримтыг татварын тайлангийн хугацаа хүртэл боловсруулж, дотоодод хадгалах шаардлагатай.
- A2 Гадаад харилцан хамаарал бүхий этгээдийн ажил гүйлгээний тухайд, өмнөх тайлант хугацааны ажил гүйлгээний нийт дүн 5 тэрбум иенээс их, эсхүл биет бус хөрөнгийн ажил гүйлгээний дүн 300 сая иенээс их байсан ААН нь локал файлийг татварын тайлан гаргах хугацаа хүртэл бэлтгэн, хадгалах үүрэгтэй. Энэ локал файлийг татварын хяналт шалгалтын байцаагчийн шаардсан өдрөөс тооцон тодорхой хугацаанд үзүүлэх, эсхүл гарган өгөх шаардлагатай. 2017 оны 4 сарын 1-нээс хойших тайлант жилээс эхлүүлэх

Q ЯПОНЫ ШИНЭЧИЛЭЛТЭЭР 「УЛСААР ЯЛГААТАЙ ТАЙЛАН」-Д ТУСГАХ АГУУЛГА. (ТӨВ КОМПАНИ БЭЛТГЭХ) МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНД ХАМРУУЛАХ ЭСЭХ.

A1 Төв ба охин компанийн байрлах улс тус бүрээрх хил дамнасан
групшын талаарх дараах мэдээлэл

- Нийт орлого, орлого, татварын дүн, үндсэн хөрөнгө зэрэг санхүүгийн мэдээлэл
- Ажилчдын тоо
- Биет хөрөнгийн дүн
- Гол бизнесийн үйл ажиллагаа

Q Ямар мэдээлэл солилцоо болох.

Q Японы шинэчилэлт дэхь 「УЛСААР ЯЛГАСАН ТАЙЛАН」-ИЙН ГОЛ АСУУДАЛ

A1 Үнэ шилжилтийн эрсдэлийг өндөр түвшинд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг гарган өгөх.

A2 Хил дамнансан группын бизнес эрхэлдэг улс тус бүрээрх орлого, татварын өмнөх тухайн тайлант хугацааны ашиг, татвар төлөлтийн талаарх мэдээллийг тусгах.

A3 Мэдээлэл гаргах үүрэг хүлээгч нь дараах 2 этгээд байна:

1. Татварын гэрээний хэлбэр (BEPS хэлбэр)

Төв компани нь Япон бол Японы дотоодын ААН нь тус улсын татварын байгууллагад, гадаад бол гадаадын татварын байгууллагад гарган өгнө. (Тусгай арга хэмжээний тухай хуулийн 66-4-4①)

2. Охин компанийн хэлбэр

Охин компани болох Японы дотоодын ААН, эсвэл төлөөний газар бүхий гадаадын ААН (Дээрхийн адил ②)

13

Q Японы шинэчилэлтээр МАСТЕР ФАЙЛЬД (ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН)-Д ТУСГАХ АГУУЛГА. (ТӨВ КОМПАНИ БЭЛТГЭХ).

А Дараах бичиг баримт байна:

- Группын бүтэц зохион байгуулалтын зураг
- Бизнесийн үйл ажиллагаа
- Эзэмших биет бус хөрөнгийн мэдээлэл
- Группын доторх санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл
- Нийт группын санхүүгийн болон татвар төлөлтийн нөхцөл байдал

14

Q Японы шинэчилэлтээр МАСТЕР ФАЙЛЬД (ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН)-Д ТУСГАХ ГОЛ АСУУДЛУУД

- А1 Татварын байгууллагыг үнэ шилжилтийн гол эрсдэлүүдийг тодорхойлох боломжоор хангахын тулд нийт группын 「Ерөнхий зураглал」-ыг гаргах.
- А2 Хил дамнасан группын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны агуулга, санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг тусгах.
- А3 Хил дамнасан группыг бүрдүүлэгч компани болох дотоодын ААН болон Японд төлөөний газар бүхий гадаадын ААН мөн адил тайлагнана.
- А4 Хугацааны хувьд, тайлагнах тайлант жилийн эцсийн өдрийн дараагийн өдрөөс 1 жилийн дотор, цахим тайлангаар (e-tax) Япон ба Англи хэлээр тайлагнана. (ТАХТХ 66-4-5①)
- А5 Тайлангийн хэлбэр нь охин компанийн хэлбэртэй байна.

15

Q BEPS-ийн ЛОКАЛ ФАЙЛЬД ТУСГАХ АГУУЛГА (ТӨВ БА ОХИН КОМПАНИ БЭЛТГЭХ)

А Дараах бичиг баримт байна:

- Бүтэц зохион байгуулалтын зураг
- Үйл ажиллагааны стратеги
- Гол өрсөлдөгч ААН
- Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн гол ажил гүйлгээ ба ажил гүйлгээний агуулга
- Үнэ шилжилтийн үнэ тооцох үндэслэл
- Санхүүгийн тайлан

16

Q BEPS-ийн ЛОКАЛ ФАЙЛЬД ТУСГАХ АГУУЛГЫН ГОЛ АСУУДЛУУД

A1 Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг гарган өгөх.

A2 Тухайлсан ажил гүйлгээтэй холбоотой санхүүгийн мэдээлэл, харьцуулах боломжийн дүн шинжилгээ, хамгийн зохистой сунгасан гарын үнэ тооцох аргыг сонгох, ашиглахтай холбоотой мэдээллийг тусгах.

A3 Мэдээллийг цаасаар гаргах, e-tax биш байж болно.

Q why?

17

Q Японы шинэчилэлтийн хүрээнд хийх БАРИМТЖУУЛАЛТЫН ХАДГАЛАХ ХУГАЦАА, АРГА ХЭМЖЭЭ

A1 Хадгалах хугацаа: Зарчмын хувьд 7 жил дотоодод хадгалах.

A2 Гарган өгөөгүй тохиолдолд авах арга хэмжээ:

1. Улсаар ялгаатай тайлан

➔ 300 мянган иен хүртэлх торгууль

2. Үйл ажиллагааны нөхцөл байдлын тайлан (Мастер файл)

➔ 300 мянган иен хүртэлх торгууль

3. Сунгасан гарын үнэ тооцохын тулд шаардлагатай бичиг баримт (локал файл)

➔ Татварын байгууллагаас шаардсаны дараа, тодорхой хугацааны дотор буюу байцаагчийн заасан өдөр хүртэл бичиг баримтыг гарган өгөөгүй бол, жишгээр татвар ногдуулна.

18

**Q ЭДГЭЭР 3 ФАЙЛИЙН ТУХАЙД, ЯПОНД ҮЛ
ХАМААРУУЛАХ ЗААЛТ БАЙДАГ ЭСЭХ.**

o А Байдаг:

1. Улсаар ялгаатай тайлан: Нэгдсэн группын орлого 100 тэрбум иен хүрэхгүй.
 2. Мастер файл: Дээрхийн адил
 3. Дараах бага үнийн дүн бүхий ажил гүйлгээ байх үед,
- o Өмнөх тайлант хугацааны ажил гүйлгээний нийт дүн 5 тэрбум иенээс бага.
 - o Биет бус хөрөнгийн ажил гүйлгээний нийт дүн 300 сая иенээс бага байх
 - o Тухайлсан ажил гүйлгээ бүрээр шийдвэр гаргах

**Q ЯПОНД ЛОКАЛ ФАЙЛЬ БЭЛТГЭХ ҮҮРГЭЭС
ЧӨЛӨӨЛӨГДВӨЛ, ҮНЭ ШИЛЖИЛГИЙН ТАТВАРЫН
ТОГТОЛЦООНД ХАМРУУЛАХГҮЙ ЮУ.**

А Үнэ шилжилтийн татварын тогтолцоонд хамруулна.

Локал файльд хамруулахгүй тохиолдолд ч, үнэ шилжилтийн татварын тогтолцоонд хамруулж, татварын хяналт шалгалт хийнэ. Хяналт шалгалт ба сунгасан гарын үнэ тооцоход шаардлагатай бичиг баримтыг гарган өгөхийг шаардах тохиолдол байна.

Мөн, сунгасан гарын үнийг тооцоолохын тулд шаардлагатай бичиг баримтыг татварын байцаагчийн заасан 「45 хоногийн дотор」 гарган өгөх үүрэг хүлээнэ.

Q ФАЙЛИУД БА ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХАМААРАЛ

А Дараах дэс дарааллаар хийгдэнэ:

1. Үнэ шилжилтийн хяналт шалгалт нь ААН ба түүний гадаад харилцан хамаарал бүхий этгээд хооронд хийсэн ажил гүйлгээ нь сунгасан гарын үнээр хийгдсэн эсэхийг хянахын тулд хэрэгждэг.
2. Үүний тулд, үнэ шилжилтийн ажлын удирдамжид, «Локал файл» болон «Гадаад харилцан хамааралтай этгээдийн талаарх нарийвчилсан мэдээлэл» (Хавсралт хүснэгт 17(4))-ийг хавсаргасан эсэх. Мөн тусгасан агуулгыг хянахаар (ТР ажлын удирдамж 3-3) заасан байдаг.
3. Үнэ шилжилтийн ажлын удирдамжийн 3-4-т заасан дараах бичиг баримтаас үнэ шилжилтийн асуудлыг тодорхойлно.

Хөрөнгө, ажил гүйлгээ, хувьцаа, үнэт цаасны тайлан, бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт

21

Q ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД, ЛОКАЛ ФАЙЛЬД БАЙХ ХАМГИЙН ЧУХАЛ БИЧИГ БАРИМТ ЮУ БОЛОХ.

А Гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээтэй холбоотой сунгасан гарын үнэ тооцоход дараах бичиг баримт шаардлагатай:

- Тухайн ААН-ын сонгосон үнэ шилжилт тооцох арга ба шалтгааныг бичсэн бичиг баримт, сунгасан гарын үнэ тооцохдоо бэлтгэсэн бичиг баримт
➔ Ялангуяа энэ бичиг баримт маш чухал ! ! !
- Тухайн ААН-ын гадаад ажил гүйлгээтэй холбоотой харьцуулахаар ашигласан ажил гүйлгээний сонголт, тухайн ажил гүйлгээний дэлгэрэнгүйг бичсэн бичиг баримт
- Тухайн ААН нь үнэ шилжилт тооцох аргыг сонгосон тохиолдолд, тухайн аргаар тухайн ААН-тэй холбоотой гадаад харилцан хамаарал бүхий этгээдэд хамаарах зүйлсийн үнийн дүнг тооцоход шаардлагатай бичиг баримт
- Тухайн ААН нь хэд хэдэн гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээг нэг ажил гүйлгээ болгон, сунгасан гарын үнэ тооцсон тохиолдолд, шалтгаан ба ажил гүйлгээ тус бүрийн агуулгыг тусгасан бичиг баримт
- Харьцуулах ажил гүйлгээнд зөрүүний зохицуулалт хийсэн бол, шалтгаан болон зөрүүний зохицуулалт хийсэн аргыг бичсэн бичиг баримт

22

TPM & BEPS Q&A

1

2017.9.12

ЛСА мэргэжилтэн
Кодера Тошинари

ЛЕКЦИЙН АГУУЛГА

1. Жишээний эмхэтгэлд тусгасан хууль тогтоомж ба үнэ шилжилт тооцох аргын талаар ойлголт өгөх (Хавсралт)
2. Жишээн дээр ажиллахад дэмжлэг болохын тулд эмхэтгэлд тусгасан харьцуулах ажил гүйлгээ олохтой холбоотой зураглал, хүснэгтийн талаар ойлголт өгөх. (Тараах материал)
3. Үнэ шилжилттэй холбоотой BEPS-ийн Үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар ойлголт өгөх

2

Q ЯПОНЫ ТРМ-ИЙН ОНЦЛОГ ЮУ БОЛОХ.

A ТРМ нь дараах 2 хэсэгт хуваагддаг

- 1 Inventory sales transactions
- 2 Non Inventory sales transactions

3

Q INVENTORY SALES TRANSACTION ГЭДЭГ НЬ

A Дараах бүлэгт хуваагддаг.

- Group A: Traditional transaction 3 methods in the law and other 7 methods
- Group B: Methods consistent with the traditional 3 methods in the law and other 7 methods in the cabinet order.

4

**Q NON INVENTORY SALES TRANSACTION
ГЭДЭГ НЬ**

A Дараах бүлэгт хуваагддаг.

- Group C: Methods equivalent to the traditional transaction 3 methods in the law and other 7 methods in the cabinet order
- Group D: Methods equivalent to methods consistent with the traditional 3 methods in the law and other 7 methods in the cabinet order

5

Q TRADITIONAL 3 METHODS ГЭДЭГ НЬ

A Дараах 3 арга болно.

- Comparable uncontrolled price (CUP)
- Resale Price method (RP)
- Cost plus method (CP)

6

Q CONSISTENT (ДҮЙЦЭХ) АРГА ГЭДЭГ НЬ

- **А Жишээлбэл**, борлуулалтын нийт ашгийн хувийг ашиглан, харилцан хамааралтай ажил гүйлгээ ба харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ажил гүйлгээг харьцуулах арга болох RP аргатай дүйцэх арга гэдэг нь харьцуулалт дахь ашгийн түвшинг шалгуур үзүүлэлт болгон, борлуулалтаас өртгийг хассан дүн болох борлуулалтын нийт ашгийн хувийг биш **「тооцсон」 борлуулалтын ашгийн хувийг ашиглах арга юм.**
- Тооцооны жишээ
- $X\% = \text{шалгах ажил гүйлгээ SG\&A(зардал)} \div \text{ажил гүйлгээний борлуулалт}$
- Шалгах ажил гүйлгээнд хамаарах үйл ажиллагааны ашгийн хувь $+ X\% = \text{Борлуулалтын нийт ашгийн хувь } (\alpha)$
- Харьцуулах ажил гүйлгээнд хамаарах үйл ажиллагааны ашгийн хувь $+ X\% = \text{Харьцуулах ажил гүйлгээний 「тооцсон」 борлуулалтын ашгийн хувь } (\beta)$
 - ➔ А ба β -г харьцуулна. Энэ нь **「тооцсон」 борлуулалтын ашгийн хувийг ашигласан RP аргатай 「Дүйцэх арга」 болно.**

7

Q ӨМНӨХ СЛАЙДЫН RP АРГАД ДҮЙЦЭХ АРГА НЬ БОДИТ БАЙДАЛ ДЭЭР TNMM БИШҮҮ.

- **А YES**
- **R** Энэ нь борлуулалтын нийт ашгийн хувийг харьцуулж байгаа харагдаж байгаа боловч, харьцуулах компанийн үйл ажиллагааны ашгийн хувь дээр шалгаж буй компанийн SG&A (борлуулалтын зардал) -ын түвшинг нэмж байгаа тул, бодит байдал дээр үйл ажиллагааны ашгийн харьцуулалтыг хийж байна. Энэ нь TNMM-тэй адил юм.
- Иймд, SG&A-ын зохицуулалтыг хийвэл, борлуулалтын нийт ашгийн хувийн харьцуулалтын боломж өндөр байх боловч, энэ нь зарцуулсан зардлын зохицуулалтаас хэтрэхгүй, эдгээр зардалтай хамт үүсэх ашиг орлогын зохицуулалтыг хийхгүй тул харьцуулах боломжийн нөхцөл шаардлага нэг их сайжрахгүй юм. Өөрөөр хэлбэл, зөрүү багатай тохиолдолд л ашиглахад зохистой бөгөөд өргөн хэрэглээний зохицуулалтын арга биш юм.

8

Q TNMM АРГА ЯПОНД ОРОЙТОЖ НЭВТЭРСЭН БОЛОХ НЬ.

- A1 TNMM нь Америкийн CPM (Comparable Profit Method) : ашиг харьцуулах аргад үндэслэн OECD хүлээн зөвшөөрсөн арга бөгөөд татвар төлөгчид статистик аргаар тооцсон ашгийн түвшинг албадан тулгадаг арга тул...
- A2 Өөрөөр хэлбэл, хөндлөнгийн статистик мэдээллээс хэт хамааралтай бөгөөд ширээний ард сууж шалгаад л ихээхэн хэмжээний үнийн дүнгийн залруулга хийдэг тул...
- A3 Үндсэн хуулиар баталгаажсан хөрөнгийн эрхэд халдах аюултай байсан.
- A4 Гэхдээ, үндсэн 3 аргыг ашигладаг үнэ шилжилтийн татварын хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй байсан болон TNMM аргыг олон улс нэвтрүүлэх болсон тул 2004 онд Япон энэхүү аргыг нэвтрүүлсэн.

Q Японд TNMM НЭВТРҮҮЛСНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

А Татварын байгууллага ба татвар төлөгчийн аль алинд үнэ шилжилт тооцох хялбар арга болсон.

Японы татварын албад, TNMM-ийг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор дэлхийн улс орнуудын ААН-ын мэдээлэл бүртгэгдсэн өндөр үнэ бүхий мэдээллийн санг нэвтрүүлж эхэлсэн. Энэ нь TNMM-ийн дагуу, статистик хандлагад тулгуурласан үнэ шилжилтийн хяналт шалгалтыг хийх гэсэн Японы татварын байгууллагын байр суурийг харуулж байна.

Q ХАРЬЦУУЛАХ БОЛОМЖИЙН ШИНЖИЛГЭЭГ ХЭРХЭН ХИЙДЭГ БОЛОХ

- Жишээний зураглалыг ашиглах
- 「Сунгасан гарын үнэ тооцох аргын дэс дараалал」
(Харьцуулах боломжийн шинжилгээний жишээ)
「Харьцуулах ажил гүйлгээг сонгох аргын жишээ」

11

Q OTHER 7 METHODS ГЭДЭГ НЬ

A Дараах 7 арга байдаг

(PS (Profit Split) methods)

- ① Comparable PS
 - ② Contribution PS
 - ③ RPSM (Residual Profit Split Method)
- (TNMM (Transactional Net Margin Method))
- ④ TNMM (Import)
 - ⑤ TNMM(Export)
 - ⑥ TNMM(Import & Berry ratio)
 - ⑦ TNMM(Export & Berry ratio)

12

Q Жишээний эмхэтгэлийн эхний хагаст тусгасан хууль тогтоомж ба тооцооны жишээг ойлгосон уу.

Q1 Үнэ шилжилттэй холбоотой хууль тогтоомжуудыг тусгасан ба ялангуяа, англиар бичсэн мэргэжлийн үг хэллэг ба хуулийн заалтыг тогтоосон уу.

Q2 Зураглал, тооцооны хэсгийн тооцоонд алдаа байсан уу.

13

Q Яагаад BEPS-д үнэ шилжилттэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан болох.

- А «Cash box scheme» гэдэг татвараас зугтах тохиолдол их гарч байсан. Мөн, эрсдэлийн шинжилгээ хийх болон ТР журмыг сайжруулах шаардлага тулгарсан.
- Дээрх схемийн тухайд, тухайлсан эдийн засгийн үйл ажиллагаа явуулдаггүй мөртөө баялаг охин компаниа (Cash box) татварын хөнгөлөлттэй улсад байршуулж, тэндээ биет бус хөрөнгийн өмчлөлийн эрх ба гэрээний эрсдэлээ хамаатуулан, ашгийг төвлөрүүлэх арга бөгөөд энэхүү схемийн эсрэг BEPS-ийн хүрээнд хэлэлцэж эхэлсэн.

14

Q BEPS-ийн ХҮРЭЭНД 「CASH BOX」-ИЙГ ШИЙДСЭН НЬ

- А Энэхүү мөнгөний хайрцаг (Cash Box) нь биет бус хөрөнгийн хөгжүүлэлт хийдэггүй бөгөөд эрсдэлийг ч хянадаггүй тул үнэ цэнэ бүрдүүлэлт хийж байгаа гэж хэлэхээргүй байна.
- Иймд, зохистой бус орлогыг мөнгөний хайрцагт хамаатуулахгүй байх.

15

Q BEPS-ийн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 8-10-ИЙН ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАТВАРЫН ТОГТОЛЦООТОЙ ХОЛБООТОЙ АГУУЛГА

- А **「Үнэ шилжилтийн үр дүн ба үнэ цэнэ бүрдүүлэлттэй нийцэх байдал」**гэсэн зарчим гарсан.
Өөрөөр хэлбэл, **「Үнэ цэнэ бүрдүүлэлт (Value creation) байгаа газар ашгийг хамаатуулах шаардлагатай」**гэсэн зарчим.
- Үйл ажиллагааны төлөвлөгөө 8. Энэхүү зарчмыг биет бус хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээнд хэрхэн ашиглахыг авч үзсэн байна.
- Үйл ажиллагааны төлөвлөгөө 9. Гэрээний эрсдэлийг хуваарилах, хөрөнгө бүхий охин компанийн хувьд хэрхэн тооцохыг шинжилж байна.
- Үйл ажиллагааны төлөвлөгөө 10. Хил дамнасан группын дотроо харилцан тусалж, их ашиг бүрдүүлж байгаа тохиолдолд, үнэ цэнэ бүрдүүлэлтэд нийцсэн хамгийн зохистой татвар ногдуулалтын аргө болох TNMM-ийг ашиглах боломжийг судалж байна.

Q ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 8-ИЙН АГУУЛГА

А Биет бус хөрөнгийн тодорхойлолтыг гаргаж, биет бус хөрөнгөтэй холбоотой ашигт хамаатуулах, үнэ тооцох аргын талаарх удирдамжийг өргөжүүлсэн.

➔ Үүний үр дүнд, ТР журмын 6-р бүлэгт (Биет бус хөрөнгөд үзүүлэх тусгай арга хэмжээ) нэмэлт өөрчлөлт оруулсан.

Q ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 8 БИЕТ БУС ХӨРӨНГИЙН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

o А Өмнө нь ТР журамд байгаагүй биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хийсэн.

Биет бус хөрөнгийн шалгуур нөхцөл

1. Биет ба санхүүгийн хөрөнгө биш байх
2. Худалдааны үйл ажиллагаанд ашиглах зорилгоор эзэмших, хянах боломжтой байх.
3. Харьцуулах боломжтой бие даасан холбогдогч талуудын хоорондын ажил гүйлгээнд ашиглах, эсхүл шилжүүлэхтэй холбоотой төлбөр хийгддэг байх.

Q ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 8 БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ХУУЛИЙН ЭЗЭМШЛИЙН ЭРХИЙН ТАЛААР

- А Татварын талаас харвал, зөвхөн биет бус хөрөнгийн хуулийн эзэмшлийн эрхтэй гэдгээр тухайн биет бус хөрөнгөөр дамжуулан олсон ашигтай холбоотой эрхийг заавал эдэлнэ гэж хэлэх боломжгүй.
- Группын дотор чухал чиг үүргийг гүйцэтгэж, эдийн засгийн хувьд чухал эрсдэлийг хянахын дээр хөрөнгөд хувь нэмрээ оруулдаг ААН нь бодит ажил гүйлгээнд энэхүү хувь нэмрийг тооцсон зохистой урамшуулалыг хүртэх боломжтой гэж үздэг.

Q ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 8-д «ОРЛОГОД НИЙЦЭХ ЖИШИГ»-ИЙГ АШИГЛАЖ БАЙГАА НЬ ALP-ЫН ЗАРЧИМТАЙ ЗӨРЧИЛДӨХГҮЙ ЮУ

A Зөрчилдөхгүй. R

1. Бие даасан ААН хооронд, үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийн тухайд, жишээ нь тухайн үеийн шилжүүлсэн үнээр тооцон хямдаар тогтоосон байлаа ч, дараа нь гарах үр дүнгээс хамаарч, эхний үнэ дээр дахин ярилцах, шилжүүлсэн талын борлуулалтад нийцүүлэн нэмж төлбөр хийх ч боломжтой.
2. Тийм бол, үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийн тухайд, бага шилжүүлгийн үнээр 1 удаагийн ажил гүйлгээгээр хийсэн ААН байгаа тохиолдолд, дараа нь гарсан үр дүнгээс хамаарсан байсан ч хараат бус ААН₂₀ ийн зарчимтай зөрчилдөхгүй.

Q ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 9-ИЙН АГУУЛГА

- А Эрсдэлийн талаар яригддаг.
(Кодерагийн ойлголт)
- Биет бус хөрөнгө нь орлогын үндсэн шинж чанар бөгөөд угаасаа оршин буй үнэ цэнэ.
- Гэхдээ, эрсдэл нь ирээдүйд үнэ цэнийг үүсгэх магадлалтай.
(Өөрөөр хэлбэл, тодорхойгүй байдал)

21

Q ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 9-ИЙН ХҮРЭЭНИЙ ЭРСДЭЛ ГЭДЭГ НЬ

А

- 「Тодорхойгүй байдал нь үйл ажиллагааны зорилгод үзүүлэх нөлөөлөл」 гэж тодорхойлсон.
- Үнэ шилжилтийн удирдамжийн хүрээнд эрсдэл гэдэг үгийг 500 удаагаас илүү ашигладаг боловч, тодорхойлолт байгаагүй.

22

**Q ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 9-ИЙН ХҮРЭЭНД,
БОДИТ БАЙДАЛ ДЭЭР ЭРСДЭЛИЙГ ХЯНАГЧ НЬ АШИГ
ХҮРТЭГЧ ҮҮ.**

- **A YES !**
- R ААН нь гэрээний хүрээнд эрсдэлийг хүлээж байгаа боловч, бодит байдал дээр энэхүү эрсдэлийн талаар үр өгөөжтэй бөгөөд тодорхой заасан хяналтыг хэрэгжүүлдэггүй тохиолдолд,
- ➔Хэдийгээр эрсдэлийг үүрэхгүй байгаа ч бодит байдал дээр энэхүү эрсдэлийг хянаж, тухайн эрсдэлийг хаах санхүүгийн нөөц бүхий ААН нь тухайн эрсдэлд дүйцэх ашгийн хуваарилалтад хамрагддаг гэж үзнэ.

23


**Q ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 10-ЫН
АГУУЛГА**

- **A Non-recognition (Ажил гүйлгээнээс татгалзах)-ийг ашиглах**
- Бие даасан хараат бус ААН хооронд хийгддэггүй, мөн бараг хийгддэггүй ажил гүйлгээ, өөрөөр хэлбэл, арилжааны хувьд зөв зохистой бус ажил гүйлгээгээр дамжуулан татварын хөнгөлөлттэй улс орон байгаа групп доторх харилцан хамаарал бүхий ААН-д ашгаа шилжүүлэх асуудал гарсан.
- Иймд BEPS-ийн эцсийн тайланд харилцан хамаарал бүхий ААН хооронд, арилжааны хувьд оновчтой бус ажил гүйлгээ байгаа тохиолдолд, үнэ шилжилтийн хүрээнд энэхүү ажил гүйлгээнээс татгалзахыг зөвшөөрдөг.

24

**Q ДАРААХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ 10-ЫН ХҮРЭЭНД [АЖИЛ ГҮЙЛГЭЭНЭЭС
ТАТГАЛЗАХ] БОЛОМЖТОЙ ЮУ**

- Үйлдвэрлэгч S1 компани нь олон агуулахтай бөгөөд үйлдвэр, тоног төхөөрөмжид их хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг. Энэ хөрөнгө байрладаг нутагт ойрын жилүүдэд үер болсноос энд даатгалын зах зээл идэвхгүй байдаг. Иймд гадаад харилцан хамаарал бүхий S2 компани нь S1 компанид даатгал өгсөн. Жилийн даатгалын хураамж нь агуулах ба хөрөнгийн үнийн 80% бөгөөд S1 компани төлбөр хийнэ.
- **Q Энэ S1 ба S2 компани хоорондын ажил гүйлгээг арилжааны хувьд зөв зохистой ажил гүйлгээ гэж хэлэх үү.**



Үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах

2017/9/11- 9/15

Проф. ТАЖИНО Микио

1



Сургалтын арга барил

Үнэ шилжилтийн жишээнүүд багаар ажиллах хэлбэрээр суралцана. Нийт 9 жишээ байгаа.

Жишээ тус бүрийн ажил гүйлгээний зургийг (хавсралт материал) ашиглан “урьдчилсан нөхцөл”-ийг сайтар уншиж ойлгон “Асуулт”-д хариулна уу.

Баг дотроо сайтар ярилцан хэлэлцэж багийнхаа хариултыг гаргана. Баг бүр бүх жишээн дээр ажиллах бөгөөд хариултаа бусад багт танилцуулна.

2

Жишээ 1

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “P” компани нь “A” болон “B” бүтээгдэхүүнийг борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө “A” бүтээгдэхүүнийг борлуулах “S” охин компанийг “X” улсад байгуулсан.
2. “P” компани нь “S” компанид “A” бүтээгдэхүүнийг борлуулдаг бөгөөд “S” компани худалдаж авсан бүтээгдэхүүнээ “X” улсын дотоодын гуравдагч этгээд болох 200-аад жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
3. “P” компани нь “S” компанийг байгуулсантай адил цаг үеэс “X” улсын гуравдагч этгээд болох “T” салбартаа “B” бүтээгдэхүүнийг борлуулж байгаа бөгөөд “T” компани энэхүү бүтээгдэхүүнээ “X” улсын дотоодын жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
4. “B” бүтээгдэхүүн ба “A” бүтээгдэхүүн нь “P” компаний доторх барааны ангилаар ялгаатай бүтээгдэхүүн гэж ангилагддаг (өөр загварын дугаартай) боловч шинж чанар, бүтэц, ашиглалтын зориулалтын хувьд нэг төрлийн бүтээгдэхүүн юм.

【Асуулт】

1. “P” компани болон “S” компани хоорондох “A” бүтээгдэхүүний үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ эхлээд аль үнэ шилжилт тооцох аргыг авч үзэх ёстой вэ?
2. Сонгосон үнэ шилжилтийн тооцох аргыг ашиглан сунгасан гарын үнийг тооцохдоо ямар асуудлуудын талаар судлах шаардлагатай вэ?

3

Жишээ 2

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “S” компани нь “A” бүтээгдэхүүнийг Япон улсад борлуулдаг компани юм.
2. “S” компанийн толгой компани болох “X” улсын “P” компани нь “X” улсад “A” бүтээгдэхүүнийг борлуулдаг.
3. “S” компани нь “P” компанийн импортын ерөнхий салбар агент байдлаар “A” бүтээгдэхүүнийг импортлож, Япон улсын дотоодын гуравдагч этгээд болох 10-аад салбарт борлуулдаг.
4. Япон улсын “T” компани нь бие даасан импортын ерөнхий салбар агент бөгөөд “B” бүтээгдэхүүнийг Япон улсын дотоодод борлуулдаг компани юм.
5. “B” бүтээгдэхүүн нь “A” бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн биш боловч шинж чанар, бүтэц, ашиглалт зориулалтын хувьд адил төстэй.

【Асуулт】

1. “P” компани болон “S” компани хоорондох “A” бүтээгдэхүүний үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ эхлээд аль үнэ шилжилт тооцох аргыг авч үзэх ёстой вэ? Энэ тохиолдолд аль компанийг гол судлах ААН (Tested Party) гэж авч үзэх вэ?
2. Сонгосон үнэ шилжилт тооцох аргыг ашиглан сунгасан гарын үнийг тооцохдоо ямар асуудлуудын талаар судлах шаардлагатай вэ?

4

Жишээ 3

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “Р” компани нь “А” болон “В” бүтээгдэхүүнийг борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө “А” бүтээгдэхүүнийг борлуулах “S” охин компанийг “X” улсад байгуулсан.
2. “Р” компани нь “S” компанид “А” бүтээгдэхүүнийг борлуулж, “S” компани нь үүнийг “X” улсын дотоодын гуравдагч этгээд болох 200-аад жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
3. “Р” компани нь “S” компанийг байгуулсан үеэс “X” улсын гуравдагч этгээд болох “Т” салбар агент компанид “В” бүтээгдэхүүнийг борлуулж байгаа бөгөөд “Т” компани үүнийгээ “X” улсын дотоодын жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
4. “В” бүтээгдэхүүн нь “А” бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн биш боловч шинж чанар, бүтэц, ашиглалт зориулалтын хувьд адил төстэй.

【Асуулт】

1. “Р” компани болон “S” компани хоорондох “А” бүтээгдэхүүний үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ аль үнэ шилжилт тооцох аргыг авч үзэх ёстой вэ? Энэ тохиолдолд аль компанийг гол судлах ААН (Tested Party) гэж авч үзэх вэ?
2. Сонгосон үнэ шилжилт тооцох аргыг ашиглан сунгасан гарын үнийг тооцохдоо ямар асуудлуудын талаар судлах шаардлагатай вэ?

5

Жишээ 4

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “Р” компани нь “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө “А” бүтээгдэхүүний “а” түүхий эдийг нийлүүлэх зорилгоор “X” улсад “S” охин компанийг байгуулсан.
2. “S” компани нь “а” түүхий эдийг бүгдийг нь “Р” компанид борлуулж, “Р” компани нь үүнийг ашиглан “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж Япон улсын дотоодын гуравдагч этгээд болох салбар агентуудад борлуулдаг.
3. “Р” компани нь “S”-ээс бусад компаниас “а” түүхийн эд авдаггүй.
4. “А” бүтээгдэхүүний “а” түүхий эд нь бүтээгдэхүүний биржүүдээр дамжин олон улсын хэмжээнд зарагддаг бөгөөд зах зээл дээр жишиг (зах зээлийн үнэ) үнэ тогтсон байдаг.

【Асуулт】

1. “Р” болон “S” компани хоорондын “а” түүхий эдийн үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ эхлээд аль үнэ шилжилт тооцох аргыг авч үзэх ёстой вэ?
2. Сонгосон үнэ шилжилт тооцох аргыг ашиглан сунгасан гарын үнийг тооцохдоо ямар асуудлуудын талаар судлах шаардлагатай вэ?

6

Жишээ 5

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “Р” компани нь “А” бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулагч компани бөгөөд 10 жилийн өмнө “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулах “S” охин компанийг “Х” улсад байгуулсан.
2. “S” компани нь “Р” компанийн үйлдвэрлэсэн “а” эд ангийг худалдан авч, үүн дээрээ өөр эд анги нэмж “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг бөгөөд “Х” улсын дотор гуравдагч этгээдэд борлуулдаг.
3. Мөн “Р” компани нь “S” компанийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, хяналтын үйлчилгээ үзүүлдэг.
4. “Х” улсын гуравдагч этгээд болох “Т” компани нь “Р” компаниас “а” эд ангийг худалдан авч, үүндээрээ өөр эд анги нэмж “В” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн “Х” улсын дотор гуравдагч этгээдэд борлуулдаг.
5. “Р” компани нь “S” болон “Т” компанид “а” эд ангийг нэг ижил үнээр борлуулдаг бөгөөд ажил гүйлгээний хэмжээ болон гэрээний нөхцөл ч адил болно.

【Асуулт】

1. “Р” компани нь “S” компанид нийлүүлдэг үйлчилгээний үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ ямар үнэ шилжилт тооцох аргыг авч үзэх ёстой вэ?
2. Сонгосон үнэ шилжилт тооцох аргыг ашиглан сунгасан гарын үнийг тооцохдоо ямар асуудлуудын талаар судлах шаардлагатай вэ?

7

Жишээ 6

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “Р” компани нь “А” бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулагч компани бөгөөд 10 жилийн өмнө “А” бүтээгдэхүүнийг борлуулах “S” охин компанийг “Х” улсад байгуулсан.
2. “А” бүтээгдэхүүн нь “Р” компанийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд гарган авсан тусгай технологийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн юм.
3. “Р” компани нь “S” компанид “А” бүтээгдэхүүнийг борлуулж, “S” компани нь үүнийг “Х” улсын дотоодын гуравдагч этгээд болох 10-аад салбар агентад борлуулдаг.
4. “S” компани нь өөрийн онцлог бүхий зар сурталчилгаа, борлуулалтыг идэвхжүүлэх арга хэмжээ авдаггүй ч өөрсдийн борлуулалтын төлөвлөгөөний дагуу “А” бүтээгдэхүүнийг тодорхой тоо хэмжээгээр хадгалан хяналт тавьж “Х” улсад дахин борлуулдаг.

【Асуулт】

1. “Р” болон “S” компани хоорондох бүтээгдэхүүн “А”-ийн үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ үнэ шилжилт тооцох ямар аргыг авч үзэх шаардлагатай вэ? Энэ тохиолдолд аль ААН-ийг гол судлах ААН (Tested Party) гэж авч үзэх вэ?
2. Сонгосон үнэ шилжилт тооцох аргыг ашиглан сунгасан гарын үнийг тооцохдоо ямар асуудлуудын талаар судлаж, юуг ашгийн түвшингийн шалгуур үзүүлэлт (Profit Level Indicator: PLI) болгон авч үзэх ёстой вэ?

8

Жишээ 7

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “Р” компани нь “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө “А” бүтээгдэхүүн борлуулах охин компани болох “S” компанийг “X” улсад байгуулсан.
2. “А” бүтээгдэхүүн нь “Р” компанийн судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд гарган авсан тусгай технологийг (биет бус хөрөнгө) ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн юм.
3. “Р” компани нь “S” компанид “А” бүтээгдэхүүн үйлдвэрлэх патент болон үйлдвэрлэлийн ноухауг ашиглах эрхийг өгсөн бөгөөд “S” компаниас эрхийн хураамж (Royalty) авдаг.
4. “S” компани нь “X” улсад түүхий эд худалдан авч “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн “X” улсын гуравдагч этгээд болох салбар агентуудад борлуулдаг.
5. “Р” болон “S” компани хооронд бараа материалаарх хөрөнгийн ажил гүйлгээ хийгддэггүй.

【Асуулт】

1. “S” компани “Р” компанид төлдөг эрхийн хураамжийн үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ аль үнэ шилжилт тооцох аргыг авч үзэх шаардлагатай вэ?
2. Сонгосон үнэ шилжилт тооцох аргыг ашиглан сунгасан гарын үнийг тооцохдоо ямар асуудлуудын талаар судлаж, юуг ашгийн түвшингийн шалгуур үзүүлэлт (Profit Level Indicator: PLI) болгон авч үзэх ёстой вэ?

9

Жишээ 8

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “Р” компани нь “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулах “S” охин компанийг “X” улсад байгуулсан.
2. “А” бүтээгдэхүүн нь “Р” компанийн судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон тусгай технологиор (биет бус хөрөнгө) үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн юм.
3. “Р” компани нь “S” компанид “А” бүтээгдэхүүнд ашигладаг “a” эд ангийг (“Р” компанийн тусгай технологиор хийгдсэн гол эд анги) борлуулахын зэрэгцээ, “А” бүтээгдэхүүнтэй холбоотой патент болон үйлдвэрлэлийн ноухауг ашиглах эрхийг өгсөн бөгөөд “S” компаниас эрхийн хураамж (Royalty) авдаг.
4. “S” компани нь “a” эд анги дээр бусад эд ангийг нэмж “А” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг бөгөөд “X” улсын гуравдагч этгээд болох 200-аад жижиглэнгийн худалдаачдад худалдан борлуулдаг.
5. “S” компани нь маркетинг хариуцсан олон тооны ажилтнуудаараа дамжуулан өөрийн онцлог бүхий зар сурталчилгаа, борлуулалтын идэвхжүүлэлтийн арга хэмжээ авдаг. Үүний үр дүнд жижиглэнгийн сүлжээг бүрдүүлж “X” улсын зах зээлд байр суурь эзэлж чадсан ба тодорхой зах зээлийг эзэлсэн.

10

Жишээ 8

【Асуулт】

1. “а” эд анги болон “S” компанийн “Р” компанид төлдөг эрхийн хураамжийн үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ ямар үнэ шилжилт тооцох аргыг ашиглах вэ?
2. Сонгосон үнэ шилжилт тооцох аргыг ашиглан сунгасан гарын үнийг тооцохдоо ямар асуудлуудын талаар судлах шаардлагатай вэ?

11

Жишээ 9

【Урьдчилсан нөхцөл】

1. Япон улсын “Р” компани нь “А” бүтээгдэхүүнийг борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө “А” бүтээгдэхүүнийг борлуулах “S” охин компанийг “Х” улсад байгуулсан.
2. “Р” компани нь “S” компанид “А” бүтээгдэхүүнийг борлуулж, “S” компани нь үүнийгээ “Х” улсын дотоодын гуравдагч этгээд болох 200-аад жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
3. “Р” компани нь “S” компани байгуулагдахаас өмнө “Х” улсын гуравдагч этгээд болох “Т” салбар агент компанид “А” бүтээгдэхүүнийг борлуулсаар ирсэн бөгөөд “Т” компани нь үүнийгээ “Х” улсын дотоодын жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
4. “Р” компаниас “S” болон “Т” компанитай хийдэг ажил гүйлгээний хувьд доорх зүйлээс бусад ажил гүйлгээний хэмжээ, гэрээний нөхцөл нь адилхан.
 - ① Хүлээлгэн өгөх нөхцөл : “S” компани CIF ⇔ Т компани FOB
 - ② Төлбөр хийх хугацаа : “S” компани 30 хоног ⇔ Т компани 90 хоног
(Хүү аль аль нь 5%)

【Асуулт】

- “Р” болон “S” компани хоорондох “А” бүтээгдэхүүний үнэ шилжилтийн шалгалтыг хийхдээ CUP аргыг ашиглах тохиолдолд хэрхэн зөрүүний зохицуулалтыг хийх вэ?

12

Олон улсын татвар ногдуулалтын тусгай сургалт

(2017.11.27-2017.12.1)

Он сар өдөр	Цаг	Сургалтын агуулга	Хариуцсан багш
2017.11.27 (Даваа)	09:00-12:00	Япон улсын Олон улсын татвартай холбоотой хэргүүд	Төслийн зөвлөх Кодера Тошинари
	13:00-16:00		
2017.11.28 (Мягмар)	09:00-12:00	Монгол улсын жишээн дээр ажиллах (Case 1-3)	Төслийн зөвлөх Кодера, Ишигүро
	13:00-16:00		
2017.11.29 (Лхагва)	09:00-12:00	Монгол улсын жишээн дээр ажиллах (Case 4-6)	Төслийн зөвлөх Кодера, Ишигүро
	13:00-16:00		
2017.11.30 (Пүрэв)	09:00-12:00	Монгол улсын жишээн дээр ажиллах (Case 7-9)	Төслийн зөвлөх Кодера, Ишигүро
	13:00-16:00		
2017.12.1 (Баасан)	09:00-12:00	Монгол улсын жишээн дээр ажиллах (Case 10)	Төслийн зөвлөх Кодера, Ишигүро
	13:00-16:00	Хэлэлцүүлэг	

Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийн жагсаалт

№	Нэрс	Харьяа нэгж
1	Ч.Эрдэнэчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУАБ
2	Х.Сувд-Эрдэнэ	ТЕГ-ын Төрийн захиргааны удирдлагын газрын ТУБ
3	Н.Жаргалцэцэг	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
4	Ж.Цэрэнцоо	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
5	А.Сувдаа	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
6	Г.Энхжин	ТЕГ-ын Татварын орлогын газрын ТУБ
7	Ц.Баярмаа	ТЕГ-ын Дотоод аудитын газрын ТУБ
8	Б.Ариунгэрэл	ТЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ТУБ
9	Н.Туул	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
10	Ш.Ундраа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
11	Б.Золзаяа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
12	Б.Батчимэг	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
13	С.Гүнжинлхам	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
14	Д.Батжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУАБ
15	С.Төгсжаргал	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУАБ
16	Ц.Дэлгэрмаа	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
17	Г.Бямбасүрэн	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ

18	П.Отгонсүрэн	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
19	Н.Болорчимэг	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
20	Н.Мөнхдаваа	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
21	Н.Хандхүү	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
22	Ц.Ишжамц	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
23	Б.Төгсжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
24	Ш.Энхжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
25	Ё.Мөнхбат	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
26	Ш.Батзаяа	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
27	Б.Уранцэцэг	УТОХГ-ын Эрсдэл, статистикийн хэлтсийн ТУБ
28	Г.Банзрагч	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
29	Х.Алтанхүү	УТОХГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
30	О.Цэнд-Аюуш	НТГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтэс
31	Ж.Эрдэнэбүрэн	НТГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
32	Б.Бат-Эрдэнэ	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
33	Ч.Лхамрагчаа	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
34	Д.Солонго	СБД-ын Татварын хэлтсийн ТУБ
35	Ц.Ундармаа	СХД-ын Татварын хэлтсийн ТУБ
36	Б.Очирхуяг	ХУД-ын Татварын хэлтсийн ТУБ
37	С.Наранбаатар	Дорнод аймгийн Татварын хэлтсийн ТУБ
38	Ц.Өнөрмөнх	Орхон аймгийн Татварын хэлтсийн ТУБ
39	С.Дүүбаяр	Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн ТУБ
40	Л.Мөнхтуул	ТЕГ-ын Хуулийн хэлтсийн ТУБ

Японд гарсан олон улсын татвартай холбоотой хэргүүд

Кодера Тошинари
ЛСА мэргэжилтэн

1

Японы олон улсын татвартай холбоотой шүүхийн шийдвэрийн жишээ


1. Үнэ шилжилтийн татвар: Имабари Сейжакү хэрэг, Тайландын батсаар хийсэн зээлийн хүүгийн хэрэг, Адобийн хэрэг, Хондагийн хэрэг
2. PE: Амазоны хэрэг
3. Татварын диваажин: Граксо хэрэг (PE-д мөн хамааралтай), Райрёо боловсруулалтын хэрэг
4. Гадаадын татварыг хасах: Ганжи арлын хэрэг (ТН-д мөн хамааралтай)
5. Гадаадын ААН: Мөнгө цэвэршүүлэх үйлдвэрийн хэрэг (ашиглалтын хураамж)
6. Байнгын оршин суугч бус этгээд: Такефүжигийн хэрэг
7. ОУ-ын татвараас зайлсхийх: Киноны түрээсийн хэрэг (АНУ-ын Apple компанийн хэрэг)
8. Япон Улсын олон улсын татварын тогтолцоо ба Монгол Улсын хууль тогтоомжийн ялгаа
9. GAAR (Татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм)

2

1. Үнэ шилжилтийн татвартай холбоотой шүүхийн шийдвэрийн жишээ

3

**★1-1 Имабари Сейжакү хэрэг
Ажил гүйлгээний зураг**



4

★1-2 Агуулга

- Гадаад харилцан хамаарал бүхий энэхүү ажил гүйлгээ нь Японы хөлөг онгоц үйлдвэрлэгч ба Панамад байрлах нэгэн охин компани хооронд хийгдсэн хөлөг онгоц үйлдвэрлэх захиалга юм.
- Татварын байгууллага Панама, Риберт байх харилцан хамааралгүй ААН-ыг харьцуулах ажил гүйлгээ болгон авсан.
- Үнэ шилжилт тооцох аргаар CUP аргыг сонгосон.
- Татвар төлөгч нь 400 сая иений татвар ногдох орлого нь 「Хязгаар」(Range) дотроо байгаа гэж зүтгэсэн.


5

★1-3 Такамацүгийн дээд шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

- Татварын байгууллагын үнэ шилжилт тооцох арга нь (Transfer Pricing Method) хуульд заасан CUP арга байсан.
- Энэ хэрэгт хэд хэдэн харьцуулах ажил гүйлгээнээс тооцох「Хязгаар (range)」-ийг ашиглах боломжгүй.
- Харьцуулах ажил гүйлгээ хэд хэд байсан ч, харьцуулах боломж талаасаа ялгаатай болох нь тодорхой бөгөөд эдгээр ажил гүйлгээг нэгтгэн нэг болгох боломжгүй тохиолдолд, 「Хязгаар」-ын ухагдахууныг ашиглалгүйгээр, харьцуулах боломж өндөртэй ажил гүйлгээг сунгасан гарын үнэ гэж үзэж болдог.
- Мөн 「зөрүүгийн тохируулга」-ын тухайд, зөвхөн үнэд бодитой нөлөөлөх зүйлсийг тооцоход хангалттай.
- Үнэ шилжилтийн татварын тогтолцоог ашиглан, татвар төлөгч татвараас зайлсхийхийг зорих шаардлагагүй.

6

★ 2-1 Тайландын баттын хэрэг Ажил гүйлгээний зураг



7

★2-2 Агуулга

- Энэхүү гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ нь Японы ААН ба Тайландын охин компанийн хооронд Тайландын мөнгөн тэмдэгт баттаар хийгдсэн.
- Татварын байгууллагаас харьцуулах ажил гүйлгээгээр, гуравдагч этгээдтэй хийсэн бодит ажил гүйлгээг бус, Лондонгийн санхүүгийн зах зээлээс санхүүжилт босгодог зохиомол зах зээлийн үнийн индикаторыг (Тайланд батт swop rate + spread) сонгосон.
- Татварын байгууллага үнэ шилжилт тооцох аргаар 「CUP-тай нийцэх аргатай дүйцэх арга」-ыг сонгосон.

8

★2-3 Токиогийн орон нутгийн шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

- Татварын байгууллагын ашигласан үнэ шилжилт тооцох арга нь хуульд заасан [CUP –тай нийцэх аргатай дүйцэх арга] гэж үзэхээр байна.
- Бодит ажил гүйлгээ бус боловч, объектив ба бодит индикаторуудын тусламжтайгаар гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээтэй харьцуулах боломжтой ажил гүйлгээг тодорхойлж байвал энэхүү ажил гүйлгээг ашиглан харьцуулалт хийх боломжтой. (иймд зах зээлийн үнийн индикатор ч тогтсон нөхцөлд ОК)

➔Энэ шүүхийн шийдвэр нь OECD TP guideline-д нийцэж байна.

9


★2-4 Тайлбар

- [CUP-тай нийцэх аргатай дүйцэх арга] гэдэг нь....
- Нийцэх арга: Хууль тогтоомжид тодорхойлсон заалт байхгүй боловч, жишээлбэл, ажил гүйлгээний агуулгад тохироод, Үндсэн 3 аргын үзэл санааг зөрчихгүй байх үндэслэл бүхий аргыг хэлнэ.
- Дүйцэх арга: Үйлчилгээ зэрэг бараа материалаарх хөрөнгөөс бусад ажил гүйлгээний үнэ шилжилт тооцох аргыг хэлнэ.

10

★3 Адоби хэрэг Ажил гүйлгээний зураг 1

(1) Эхний хэлбэр




Японы татвар төлөгч нь эхлээд компьютерийн програм хангамжийн талаар дамжуулан борлуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг байсан.

11

★3-1 Адоби хэрэг Ажил гүйлгээний зураг 2


(2) Үйл ажиллагааны хэлбэрээ өөрчлөх (Адоби нь худалдааны төлөөлөгчийн гэрээ болгон өөрчилсөн.)



12

★3-1 Адоби хэрэг Ажил гүйлгээний зураг 3

(3) Татварын байгууллагын авсан харьцуулах ажил гүйлгээ



Японы харьцуулах ААН нь график програм хангамжийн бөөний болон жижиглэнгийн худалдаа (Дамжуулан борлуулалт) хийдэг байсан. Борлуулалтаа сайжруулахын тулд үйлчлүүлэгчдийг дэмжих үйл ажиллагааг бас эрхэлдэг байсан.

13

★3-2 Агуулга

- Нидерландын В компани ба Адоби (Япон) хооронд үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээнд үндэслэн, Нидерландын ААН-ээс Адобид борлуулалтын 1.5% + зардалыг хураамж болгон төлсөн.
- Татварын байгууллага нь захиалгын дагуу борлуулалт хийх хэлбэртэй импортын ажил гүйлгээг, бараа материалын эрсдэл хүлээхгүй байдал нь харилцан хамаарал бүхий ажил гүйлгээтэй төстэй гэж үзээд харьцуулах ажил гүйлгээгээр авч, ТРМ-ийг дамжуулан борлуулах үнийн аргатай нийцэх ба дүйцэх арга гэж үзсэн.
- Адобигаас, гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээ нь үйлчилгээ үзүүлэх хэлбэртэй байхад, татварын байгууллагын сонгосон харьцуулагдах ажил гүйлгээ нь дамжуулан борлуулах ажил гүйлгээ байгаа тул үйл ажиллагаа нь ялгаатай аргыг буруу сонгосон гэж гомдол гаргасан.

14

★3-3 Токиогийн дээд шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялсан)

- Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээтэй харьцуулах ажил гүйлгээ нь дараах шалтгаанаар үйл ажиллагаа болон эрсдэл нь эрс ялгаатай тул татварын байгууллагын сонгосон арга нь хуульд заасан 「RP-тай нийцэх аргатай дүйцэх арга болохгүй.
 - 「Шалтгаан」
 - Үйл ажиллагаа талаасаа: Энэхүү ажил гүйлгээ нь хуулийн хүрээнд ч, эдийн засгийн хувьд ч үйлчилгээ үзүүлэх ажил гүйлгээ байхад, харьцуулагдах ажил гүйлгээ нь дамжуулан борлуулалтын ажил гүйлгээ бөгөөд үйлчлүүлэгчдийг дэмжих, борлуулалтыг нэмэгдүүлэх ажил байгаа тул хоорондоо ялгаатай байна.
 - Эрсдэл талаасаа: Энэ ажил гүйлгээний хувьд, шаардлагатай бүх зардлыг оруулсан төлбөр хийгдэж байхад, харьцуулах ажил гүйлгээний хувьд, захиалгын дагуу борлуулах хэлбэртэй боловч, тодорхой түвшнээс доош борлуулалт хийвэл алдагдал хүлээхээр байгаа нь эрсдэл хүлээх тал дээр ч ихээхэн ялгаатай байна.
- ➔Иймд шүүхээс үйл ажиллагаа, эрсдэлийн төстэй шинж чанар байгаа эсэхийг тодорхойлохдоо, үйлчилгээ юу, дамжуулан борлуулалт уу гэсэн хуулийн хэлбэрийг анхаарч үзсэн.

15

★3-4 Тайлбар (Анхан шатны шүүхийн шийдвэрийн онцлог: Бодит байдлыг нарийвчилан шинжилсэн)

- Анхан шатны шүүхийн шийдвэр: (Токио орон нутгийн): Үйл ажиллагаа, эрсдэл нь харьцуулж буй ААН-тэй адил төстэй шинж чанартай байна.
- Учир нь,
- Үйл ажиллагаа тал дээр, шалгагдаж буй ААН нь борлуулалт дэмжих, маркетинг, сурталчилгаа хийдэг бол харьцуулагдах ААН нь борлуулалт дэмжих, сурталчилгээ хийдэг,
- Эрсдэлийн тал дээр, шалгагдаж буй ААН нь барааны эрсдэл, үйлчлүүлэгчээс авах авлагыг цуглуулах эрсдэл байхгүй, харьцуулагдах ААН нь бас (Дамжуулан борлуулалт гэсэн ч: Кодера)захиалгын дагуу борлуулдаг тул барааны үлдэгдлийн эрсдэл бараг байхгүй, худалдан авагч тал том ААН байдаг тул найдваргүй авлагын эрсдэл бараг байхгүй.

16

★3-5 Токиогийн дээд шүүхийн шийдвэрийн эсрэг шүүмж

- Хуулийн хэлбэрийн ялгааг (үйлчилгээ юу, дамжуулан борлуулалт уу?) хэт дөвийлгөх нь хэвшмэл хандлагын дагуу хийсэн шийдвэр болох ба татвар төлөгч нь харьцуулах ажил гүйлгээг зохистой сонгоход хүндрэлтэй болно.

(Татвар төлөгч нь хуулийн хэлбэрийн ялгаанаас хамаарахгүйгээр, бодит байдлын шинжилгээг Токиогийн шүүхийн адилаар харьцуулах боломжийг олохыг хичээх тохиолдол байдаг.)

- Харьцуулах ажил гүйлгээг урьтал болгодог Үндсэн 3 аргаас (CUP.RP.CP) илүү PS аргыг (RPSM) ашиглахаар болдог.


17

★3-6 Бизнесийн дахин төлөвлөлттэй холбоотой ALP тооцох

- Энэ хэрэгтэй адилаар Японы ААН нь эхлээд дамжуулан борлуулалтаар ашиг олдог байснаа, бизнесийн дахин төлөвлөлтөөр, үйлчилгээ үзүүлэх ажил гүйлгээ хийх болж, ингэснээр дамжуулан борлуулалттай холбоотой нийлүүлэлт, борлуулалтын орлогоосоо үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг хассанаар, энэ хэмжээгээр ашиг буурах тул нөхөх олговор асуудал болдог. (OECD TP Guideline 9 –р бүлэг)

18

★4-1 Хондагийн хэрэг Ажил гүйлгээний зураг



19

★4-1 Хондагийн хэрэг Ажил гүйлгээний зураг 2

- Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ
- (1) Автомат 2 дугуйтын худалдаа
- (2) Сэлбэгийн худалдаа
- (3) Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн худалдаа
- (4) Технологийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

20

★4-1 Хондагийн хэрэг

Ажил гүйлгээний зураг 3

Татварын байгууллагын тогтоосон харьцуулах ажил гүйлгээний дагуу хийсэн татвар ногдуулалт

(1)Харьцуулах ААН

2 дугуйт, 4 дугуйт болон тэдгээртэй холбоотой бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг Бразилын ААН-ээс 8 компанийг сонгосон. (Манасын чөлөөт бүсэд байдаггүй ААН)

(2)НАД зэрэг үндсэн ашиг

Борлуулалтын авлага, бараа материалаарх хөрөнгө, худалдан авалтын өглөгтэй холбоотой хүүний тухайд, зөрүүний тохируулга хийж, нийт зардал үйл ажиллагааны ашгийн хувийн дундаж утгаас тооцох.

- Япон талын хүчин зүйл (Бразилд зориулан хөгжүүлэлт хийх зардал, технологийн зааварчилгааны хураамж гэх мэт)
- Бразил талын хүчин зүйл (Дилер олох зардал, сурталчилгааны зардал)

21

★4-2 Агуулга

- Автомат 2 дугуйтын үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг дотоодын ААН ба охин ба зээ компани бөгөөд Бразилын чөлөөт бүсэд байрлах 2 дугуйтын үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг гадаадын ААН болох НАД хооронд сэлбэгийн худалдаа ба үйлчилгээний ажил гүйлгээ хийгдсэн.

□ Татвар ногдуулалтын арга хэмжээ

- ААНОТ-ын зөрүүний өсөлт 25,4 тэрбум иен, ААНОТ-ын нөхөн татвар 7,5 тэрбум иен
- Татварын байгууллага PPSM(Үлдэгдэл ашиг хуваах арга)-ыг ашиглан ALP-ийг тооцохоор болсон. Бразилын харьцуулах ААН-ээр 8 компанийг сонгож, зөрүүгийн тохиргоо хийн үндсэн ашгийг тооцсон. Мөн, гаргасан зардлаас үлдэгдэл ашгийг хуваах замаар ALP-ийг тооцон, татвар ногдуулах арга хэмжээ авсан.

22

★4-3 Токиогийн орон нутгийн шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялсан)

- 2015 оны 5 сарын 8-нд охин компанитай хийсэн ажил гүйлгээний ашгийг гадаадад шилжүүлсэн гэсэн нөхөн татвар ногдуулалтыг хүлээн зөвшөөрөхгүй хэмээн Хондагаас гаргасан нэхэмжлэлийг Токиогийн дээд шүүхээс үндэслэлтэй хэмээн үзсэн ба улсаас энэ шийдвэрт давж заалдаагүй тул Хонда ялж, 7,5 тэрбум иений нөхөн татвар ногдуулалт хүчингүй болгосон анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр батлагдсан.
- Хонда нь Бразилийн Манаус чөлөөт бүсэд (Чөлөөт худалдааны бүс. Импортын татвараас чөлөөлөгддөг)автомат 2 дугуйтын үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг шууд бус охин компанитайгаа хийсэн сэлбэгийн борлуулалтын үнийн тухайд, улсын тооцсон сунгасан гарын үнэ хууль бус эсэхийн маргасан.
- Улс талаас сонгосон харьцуулах ААН нь зохистой эсэх нь маргааны цөм болсон. Давж заалдах шатны шүүх ба Токиогийн дээд шүүхийн шийдвэрийн шалтгаан нь охин компанийн эдэлж байгаа татварын хөнгөлөлт нь энэхүү компанийн ашигт ихээр нөлөөлж байгаа гэж үзээд, анхан шатны шүүхийн шийдвэртэй нэг адилаар тухайн улсад татварын хөнгөлөлт эдлээгүй адил төрлийн ААН-тэй харьцуулах замаар татвар ноогдох ашгийг тооцсон нь алдаатай арга гэж үзсэн.
- **⇒Өөрөөр хэлбэл, татварын хөнгөлөлт эдэлж байгаа адил төрлийн ААН-тэй харьцуулах нь ашгийн хувь өндөр гарах тул асуудалгүй байх боломжтой байх магадлалтай.**

23

★4-4 Тайлбар (харьцуулах боломж)


- OECD-ийн үнэ шилжилтийн гарын авлагын 1.55, 1.73
- Харьцуулах ААН ба шалгах ААН-ийн зах зээл дээрх адил төстэй байдал чухал.
- Хэрвээ, шалгагдаж буй ААН-ын үйл ажиллагаа нь Засгийн газрын хязгаарлалт, оролцоонд хамрагддаг бол харьцуулалт хийгдэх ААН нь мөн адил хязгаарлалт, хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж байх шаардлагатай.
- Манаус чөлөөт бүсийг татварын ашгийн бүс гэж хэлж болно. (үйл ажиллагааны ашгийн 59% нь татварын энэхүү хөнгөлөлтийн үр дүн)
- Иймд чөлөөт бүсэд байгаа ААН-ийг харьцуулах ААН-ээр сонгох нь алдаа байсан бөгөөд хэрвээ сонгон ашиглахаар бол зөрүүгийн тохиргоо (үйл ажиллагааны ашгийг бууруулах)хийх шаардлагатай. (зөрүүгийн тохиргоо ч хийгээгүй)

24

2. Төлөөний газартай холбоотой шүүхийн шийдвэрийн жишээ

25

★5-1 Амазоны хэрэг Ажил гүйлгээний зураг (харилцан тохирох)



26

★5-2 Агуулга (PE-тэй холбоотой хэрэг)

PE(төлөөний газар) хэрэг: Амазоны хэрэг(Токиогийн улсын татварын газрын хийсэн ногдуулалт, харилцан тохирооны асуудал)

Асуудал болсон олон улсын ажил гүйлгээ:

- Амазоны Америк дахь төв компани нь Японд салбараа байршуулахгүйгээр үйлчлүүлэгчидтэй шууд гэрээ хийн, борлуулалтын орлогоо Америктаа тусгадаг. Борлуулалт ба түгээлтийн ажлаа Амазон Жапан болон Амазон Жапан Ложистик компаниудаар гэрээлэн гүйцэтгүүлж, шимтгэлийн төлбөр төлдөг. (Нэг төрлийн шимтгэл авагч (бөөний худалдааны схем))

Токиогийн улсын татварын газрын татвар ногдуулалт:

- Токиогийн улсын татварын газар нь эдгээр Японы ААН нь Америкийн төв компанийн төлөөний газрын үүргийг гүйцэтгэж байна гэж үзээд, Японы үйлчлүүлэгчдэд борлуулалт хийхтэй холбоотой орлогыг Японд хийсэн үйл ажиллагааны орлого гэж тодорхойлсон. (2009 он: 14 тэрбум иений нөхөн татвар ногдуулсан.)

Амазон тал:

- Татвар ногдуулалт дээр гомдол үүсгэн, Япон Америкийн хоорондын татварын гэрээний дагуу харилцан тохироо хийх хүсэлт гаргасан.

27

★5-3 Токиогийн улсын татварын газраас бодит байдлыг хэрхэн тодорхойлсон тухай

Токиогийн улсын татварын газраас бодит байдлыг тодорхойлсон байдал:

Амазон Жапан Ложистик компани нь Чибад ложистик төвтэй бөгөөд худалдан авсан хайрцагтай бараанууд хураасан байсан. Энгийн агуулах бол төлөөний газар болохгүй боловч, татварын байгууллага дараах бодит байдлыг тодруулсан:

1. Харилцан хамаарал бүхий компанийн компьютер, төхөөрөмжийг ашигладаг.
2. Ложистикийн төвийн доторх барааны байрлал зэргийг өөрчлөхөд Америкийн төв компанийн зөвшөөрөл шаардлагатай байдаг.
3. Төв компаниас энэхүү ложистик компанийн ажилтнуудад мэйлээр зааварчилгаа өгдөг.
4. Бараа түгээлтийн үйл ажиллагаанаас гадна, Америкийн талаас гэрээгээр гүйцэтгүүлэхээр заагаагүй, Америкийн компанийн үйл ажиллагааны нэг хэсгийг ложистик компани гүйцэтгэдэг.

28

★5-4 Тайлбар

Q Commissioner ажил гүйлгээ гэдэг нь?

- Хуулийн хүрээнд худалдах худалдан авах ажиллагаанд оролцож байгаагийн хувьд эрх, хариуцлагыг хүлээнэ. Гэхдээ, эдийн засгийн хувьд, захиалагч тал болох гуравдагч этгээдэд эдийн засгийн үр өгөөж хамаарч, Commissioner нь өөрөө зөвхөн шимтгэл (Commission) л авдаг.
- Шимтгэл авагч нь барааны үлдэгдлийн эрсдэл, борлуулалтын авлага найдваргүй болох эрсдэлийг хүлээхгүй тул ашгийн хувьд өндөр бус боловч, хамгийн багадаа л шимтгэлийн орлого олох ба ААНОТ ногдох орлого угаасаа бага байна.

29

★5-5 Хуулийн хүрээний дүн шинжилгээ

Хуулийн шинжилгээ:

- Q1 Төлөөний газраар татвар ногдуулахдаа, аль төлөөний газраар ногдуулсан болох?
- Q2 1-р төлөөний газар уу?
- Японы бараа түгээлтийн ложистик төвийн дотор Америкийн төв компанийн [Үйл ажиллагааг удирдах газар], [Офис] гэх мэт 1-р төлөөний газар байсан эсэх. (Япон Америк хоорондын татварын гэрээний 5-②) Японы аж ахуйн нэгжийн татварын хуулинд, үйл ажиллагаа явуулах төвлөрсөн газар болох зочид буудлын нэг өрөө ч тогтсон байршилтай 1-р төлөөний газар болно гэж заасан байдаг.
- Q3 Төлөөлөгч төлөөний газар уу? Бие даасан төлөөлөгч төлөөний газар уу?
Шимтгэл авагч нь захиалагч гадаадын компанийн охин компани байсан ч, бие даасан төлөөлөгч байсан ч захиалагч болох үйлчлүүлэгчийн бүтээгдэхүүнийг борлуулж байгаа л бол борлуулах захиалга өгсөн гадаадын төв компанийн Төлөөлөгч төлөөний газар (3-р төлөөний газар) болохгүй. (Япон Америк хоорондын татварын гэрээний 5-⑥⑦)


30

3. Татварын диваажингийн талаарх шүүхийн шийдвэр

31

★6-1 Граксогийн хэрэг Ажил гүйлгээний зураг

- Татварын ачааллын харьцаа 25%-аас бага бол ТН тогтолцоонд хамруулах



32

★6-2 Агуулга 1

- Шалгагдаж буй ААН нь Сингапурын GCS компанийн(ходоодны шархлааны эмийн үйлдвэрлэл, худалдаа) 90%-ийн хөрөнгө оруулагч юм.
- GCS компани нь тухайн үйл ажиллагаагаа харилцан хамаарал бүхий компанид шилжүүлсэнээс олсон ашгаа тайланд тусгасан.
- Тухайн үед (1998 он)хувьцаа зарсны ашигт татвар ногдуулдаггүй байсан тул татварын ачааллын харьцаа 4.32% байсан.
- Татварын байгууллагаас, тухайн үеийн татварын диваажингийн тогтолцоонд хамруулах татварын ачааллын хувь хэмжээ 25% хүртэл гэсэн хязгаар дотор орж байгаа тул GCS компанийг ТН татварын тогтолцоонд (CFC)хамруулж үзсэн.

33

★6-2 Агуулга 2

• Шалгагдаж буй ААН-ын мэдэгдэл

1. CFC татварын тогтолцоо нь бодит орлого ологчид татвар ногдуулах зарчмыг (ААНОТ хуулийн 11 зүйл) тодорхой болгосон бөгөөд гадаадын охин компанийн хуримтлагдсан орлогыг төв компанид хамаатуулахтай холбоотой заалт юм.
2. Гадаадын охин компанийн хуримтлагдсан орлого нь үйл ажиллагааны орлого болно.
3. Япон Сингапурын хоорондын татварын гэрээний 7-①-д ГРЕ байхгүй бол татвар ногдуулахгүй зарчмыг заасан байдаг ба Сингапурын ААН-ын орлогын тухайд, тухайн ААН нь Японд төлөөний газаргүй бол татвар ногдуулалт хийх боломжгүй.
4. Японы Үндсэн хуулийн хүрээнд олон улсын гэрээ нь дотоодын хуулиас давуу эрхтэй тул, CFC татварын тогтолцооны дагуу Японд төлөөний газаргүй Сингапурын компанийн үйл ажиллагааны орлогод татвар ногдуулалт хийж байгаа энэ удаагийн асуудал нь хоёр улсын хоорондын татварын гэрээний 7-①-ийг зөрчиж байгаа тул зөвшөөрөгдөхгүй.

34

★6-2 Агуулга 3

• Татварын байгууллагын мэдэгдэл

1. CFC татварын тогтолцоо ба бодитоор орлого олсон этгээдэд татвар ногдуулах зарчмын үзэл баримтлал, зорилго нь ялгаатай.
2. Учир нь CFC татварын тогтолцоо нь татварын хөнгөлөлттэй улсад байгуулсан гадаадын ААН-ын орлогыг дотоодын ААН-ын орлого ашиг гэж үзээд татвар ногдуулдаг бөгөөд татвараас зайлсхийхээс сэргийлэх зорилготой бол, бодитоор орлого олсон этгээдэд татвар ногдуулах зарчим нь хэлбэр ба чанар нь ялгаатай тохиолдолд олсон орлогын хамаарлыг зааж өгдөг.
3. CFC татварын тогтолцоо нь Японд байршилтай төв компанид татвар ногдуулж байгаа тул Япон Сингапурын татварын гэрээний 7-① заалтыг зөрчихгүй.

35

★6-2 Агуулга 4

• OECD загвар гэрээний 7-①-ийн тайлбарын талаар

1. Энэхүү тайлбар нь CFC татварын тогтолцоог загвар гэрээний мөнхүү заалтыг зөрчихгүй гэж заасан.
2. Гэвч, Сингапур нь OECD-ийн гишүүн улс биш тул энэ тайлбарыг Япон ба Сингапур хоорондын татварын гэрээний тайлбар болгон ашиглах боломжтой эсэхийн талаар ч энд бас маргасан.

36

★6-3 Анхан ба давж заалдах шатны шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

- Шалгагдаж буй аж ахуйн нэгжийн нэхэмжлэлийг түдгэлзүүлсэн.

37

★6-4 Дээд шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

- Давж заалдсан нэхэмжлэлийг хүчингүй болгосон
1. Япон Сингапурын хоорондын татварын гэрээний 7-① нь 「РЕ байхгүй бол татвар ногдуулахгүй」 гэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг баталгаажуулсан байдаг.
 2. Япон Сингапурын хоорондын татварын гэрээгээр хориглодог зүйл нь энэ асуудлын хүрээнд, Японы татварын байгууллага нь Сингапурын ААН-д хуулийн хүрээнд давхар татвар ногдуулалт үүсгэх эрхээ хэрэгжүүлэхгүй байх явдал байсан.
 3. Японы СФС татварын тогтолцоо нь Японы дотоодын ААН-д татвар ногдуулдаг тул энэхүү татварын гэрээний хориглох заалтад хамаарахгүй.


38

★6-5 Шнайдерын хэрэг (Франц) 2002 оны 6 сарын 28-нд гарсан шийдвэр

- Францын аж ахуйн нэгжийн (Шнайдер компани) Швейцарь дахь охин компанийн олсон орлогын тухайд, Францын татварын байгууллагаас CFC татварын тогтолцоонд (Татварын ерөнхий хуулийн 209В) үндэслэн, төв компани болох Шнайдер компанид татвар ногдуулсан асуудал нь Франц ба Швейцарь улсын хооронд байгуулсан татварын гэрээнд заасан үйл ажиллагааны орлогын тухай заалтыг (7-①) зөрчиж байгаа тул энэхүү татвар ногдуулалт нь хууль бус болно.

39

★7-1 Райрёо боловсруулалтын хэрэг Ажил гүйлгээний зураг



40

★7-2 Агуулга

- Оптик линз, оптикийн хэрэгслийн Японы хөрөнгө оруулалттай ААН-ийн, Хонконгийн ААН ба Хятадын ААН-тэй хийсэн райрёо боловсруулалт, худалдааны тухайд, татварын диваажингийн тогтолцоог ашиглах боломжтой эсэхийн талаарх маргаан
- Татварын диваажингийн тогтолцоонд хамруулахгүй байх нөхцөлд нийцэж байгаа эсэх дээр маргасан бөгөөд Хонконгийн ААН нь бөөний худалдаа эрхэлдэг байвал, харилцан хамааралгүй этгээдийн шалгуур үзүүлэлтэд(харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ажил гүйлгээний хувь хэмжээ 50%-аас давах) нийцэх боломжийг авч үзнэ.
- Нөгөө талаас, үйлдвэрлэгч байвал үйлдвэрлэгчийн шалгуурт нийцэх эсэхийг (төв офисын байрлах газарт үндсэн үйл ажиллагааг эрхэлдэг байх) авч үзэх.

41

★7-3 Токиогийн орон нутгийн шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

- Токиогийн орон нутгийн шүүхээс үндсэн үйл ажиллагааг тодорхойлохдоо, үйл ажиллагааны тодорхой бодит байдалд нийцсэн ажиглалтад үндэслэн, нэгдсэн болон тухайлсан байдлаар хийх шаардлагатай бөгөөд зөвхөн талуудын хооронд байгуулсан гэрээний агуулгаар хязгаарлаж болохгүй гэж үзээд, тухайн ААН-ын үндсэн үйл ажиллагааг үйлдвэрлэл гэж тогтоосон.

42

★7-4 Токиогийн орон нутгийн шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

- Токиогийн дээд шүүх нь Гадаадын охин компанийн үндсэн үйл ажиллагааг тодорхойлохдоо, тухайн үйл ажиллагааны эдийн засгийн бодит байдлыг нийгмийн нийтлэг ухагдахуунтай тулгаж, нэгдсэн болон тухайлсан байдлаар хийх шаардлагатай хэмээн үзэж, Токиогийн орон нутгийн шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гэж үзсэн.
- Улс бол Үйлдвэрлэл гэж тогтоосон. Гэвч төв офисын байршилд үйлдвэрлэл явуулаагүй байсан тул татварын диваажингийн тогтолцоонд хамруулахгүй байх нөхцөлд нийцэхгүй. Иймд, татвар ногдуулалт хийсэн.

43

★7-5 Японы татварын диваажингийн тогтолцоонд хамруулахгүй байх нөхцөл 1

- Японы татварын диваажингийн тогтолцоонд, хэлбэрийн хувьд татвараас зайлсхийсэн эсэхийг тогтоож, нэгдсэн татвар ногдуулалтад хамруулна.
- Гэвч ийм хэлбэрийн байдлаар тогтоосноор, татварын диваажинд бодитойгоор үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн хувьд бодитой охин компани ч бас хамрагдахаар болчихдог.
- Иймд, охин компани нь татварын диваажинд үйл ажиллагаа эрхэлдэг гэх мэт тодорхой тохиолдолд энэхүү тогтолцоонд хамруулахгүй байх тухай заалт байдаг.

44

★7-5 Японы татварын диваажингийн тогтолцоонд хамруулахгүй байх нөхцөл 2

- Татварын тусгай арга хэмжээний тухай хууль 66-6-③
- Татварын диваажингийн улсад үйл ажиллагаа бодитой байгаа эсэх. Энэхүү ажил гүйлгээнд эдийн засгийн бодитой шинж чанар байгаа эсэх гэсэн жишгээр тодорхойлдог.
- Өөрөөр хэлбэл, тогтолцоонд хамруулахгүй байх шалгуурыг хангахын тулд,
 - ① Үйл ажиллагааны жишиг, ② Бодит байдлын жишиг, ③ Удирдлага, хяналтын жишгийг бүгдийг хангаж, дээр нь
 - ④ Байршлын жишиг, ⑤ Харилцан хамааралгүй этгээдийн жишгийн аль нэгийг хангасан байх нөхцөл тавигддаг.
- Гэхдээ, хөрөнгийн шинжтэй орлого (Хүү, ноогдол ашиг) байгаа тохиолдолд нэгдсэн татвар ногдуулалт хийдэг.

45

★7-5 Японы татварын диваажингийн тогтолцоонд хамруулахгүй байх нөхцөл 3

- Татварын тусгай арга хэмжээний тухай хуулийн 66-6 ④ (хөрөнгийн шинжтэй орлого)
- Q Хөрөнгийн шинжтэй орлогыг (хүү, ноогдол ашиг, үйлдвэрийн эзэмшлийн эрхийг шилжүүлсэний орлого гэх мэт) яагаад нэгдсэн татвар ногдуулалтад хамруулдаг вэ?
- A : Хөрөнгийн шинжтэй орлогын тухайд, тухайн орлогын эх үүсвэрийн байршлыг хялбараар өөрчлөх боломжтой бөгөөд өөр улс оронд орлогоо амархан шилжүүлж татвараас зайлсхийх, ялангуяа татварын диваажингийн охин компанид энэ төрлийн орлого байгаа нь өөрөө татвараас зайлсхийх боломжтой гэж үздэг.

46

★7-5 Японы татварын диваажингийн тогтолцоонд хамруулахгүй байх нөхцөл 4

- Татварын тусгай арга хэмжээний тухай хуулийн 66-6③-т заасан жишиг шалгуурын талаар ойлголт авцгаая. !
- ① Үйл ажиллагааны жишиг шалгуур: хэрвээ хувьцаа эзэмшдэг бол хаана ч үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой бөгөөд заавал татварын диваажинд байх охин компаниар дамжуулан үйл ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлага байхгүй. ➔ **Үйл ажиллагааны жишигийг хангахгүй**
- ② Бодит байдлын ба ③ удирдлага, хяналтын жишиг шалгуур: Үйл ажиллагаанд шаардлагатай үндсэн хөрөнгө, удирдлага, хяналт байхгүй бол тухайн аж ахуйн нэгжийг бодитой оршдог гэж үзэхгүй. ➔ **Энэхүү шалгуурыг хангахгүй**
- Дээрх ①-ээс ③-ийг бүгдийг хангаагүй тул,
- ④ Оршин байрлах улсын жишиг шалгуур (үйлдвэрлэл): Үндсэн үйл ажиллагааг төв офисын байрлах улс оронд эрхэлдэг байх. ➔ **Энэхүү шалгуурыг хангаагүй.**
- ⑤ Харилцан хамааралгүй этгээдийн жишиг шалгуур (Жиш, бөөний худалдаа): Бөөний худалдааны хувьд үйл ажиллагаа нь улс дамна хэрэгжүүлэх шаардлагатай байдаг тул харилцагчдын 50% дээш хувь нь харилцан хамааралгүй этгээд байгаа тохиолдолд, эдийн засгийн хувьд бодитой гэж үздэг. Гэвч, харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ажил гүйлгээний хэмжээ 50%-д хүрэхгүй байгаа бол эдийн засгийн хувьд бодитой бус гэж үзнэ. ➔ **Энэ шалгуурыг хангахгүй байна.**
- Дээрх ④ эсвэл ⑤ шалгуурын аль нэгийг хангах шаардлагатай.

47

★7-6 Токиогийн дээд шүүхийн 2011 оны 8 сарын 10-ны шийдвэр(Байрших улсын жишиг шалгуурыг ашиглахтай холбоотойгоор бодит байдлыг нарийвчилан тодорхойлох тухай)

- ① А нь төв компани В ба а үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа хийх зорилгоор байгуулагдсан ба үйлдвэрлэл эрхлэх гэсэн улсын бүртгэлтэй.
 - ② А нь а үйлдвэрийн үйлдвэрлэлийн удирдлага, хяналтыг хийдэг байсан.
 - ③ А нь а үйлдвэрийн хүний нөөцийг удирддаг байсан.
 - ④ А нь төв компани В болон а үйлдвэрийг нэгтгэн, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, санхүү, хүний нөөцийн удирдлага, хяналтыг хийдэг байсан.
 - ⑤ А нь Хонконгод бөөний худалдаа, Хятадад үйлдвэрлэл эрхэлдэг гэж тайлагнасан.
 - ⑥ А нь а үйлдвэрт борлуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өөрсдөө бодитойгоор явуулдаг байсныг А ба орон нутгийн компанийн хооронд байгуулсан гэрээний заалтаар батлагдаж байна.
 - ⑦ Иймд, а үйлдвэрт бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажил нь А-ийн үндсэн үйл ажиллагаа болно.
 - ⑧ Гэхдээ, а үйлдвэр нь төв офисын байрдах Хонконгод байрладаггүй.
 - ⑨ Иймд, үйлдвэрлэлийн байршил нь оршин суух байршилтай холбоотой жишиг шалгуурыг хангахгүй байна.
- ➔ Нэгдсэн татвар ногдуулалт хийнэ.


48

4. Гадаадын татварыг хасч тооцох талаарх шүүхийн шийдвэр

49

8-1 Английн Guernsey арлын хэрэг

ОУ-ын татвар ногдуулалтын батламжлалтай этгээд нь ААНОТ-ын хувь хэмжээг 0-ээс 30% хүртэл сонголт хийх боломжтой



50

★8-2 Агуулга (Татвар төлөгч ялсан)

- Татварын хувь хэмжээг чөлөөтэй тогтоох боломжтой “Татвар” нь манай улсын ААН-ын татварын хуульд заасан [Гадаад ААН-ын татвар]-тай нийцэх эсэхийг тогтоох шүүх ажиллагаа бөгөөд 2009 оны 12 сарын 3-нд татвар төлөгч, давж заалдагч болох Хохирлын даатгалын компанийн гомдлыг зөвшөөрч, татвар төлөгчийн талд шийдвэрлэсэн.
- Хохирлын даатгалын компанийн 100% охин компани болох Английн [Guernsey арал] дээр татварын хувь хэмжээг [0%-ээс 30% хүртэл] интервалын хүрээнд татварын байгууллага ба татвар төлөгчийн хооронд харилцан тохирч тогтоодог. Тухайн охин компани нь татварын диваажингийн тогтолцоонд хамаатуулж үзэх тухайлсан гадаадын охин компани болохын хувьд [25% хүртэл] гэсэн хэмжээнээс илүү буюу 26%-иар татварын хувиа тогтоосон байсан.
- Тусгай гадаадын охин компанийн шалгуур үзүүлэлтийн нэг болох [ААН-ын орлогод ногдуулах “татваргүй” улс орон, эсвэл бүсэд компанийн төв болон гол төлөөлөгчийн газар бүхий гадаадын хамааралтай ААН (Тусгай арга хэмжээний тухай хуулийн 39-р зүйлийн 14-1-1)] гэж заасан байдаг бол энэхүү арал дээрх [Татвар] нь Татварын тусгай арга хэмжээний тухай хуулийн 66-6-1-д заасан [Гадаадын ААН-ийн татвар]-т нийцэхгүй тул, энэ охин компани нь тусгай гадаадын охин компани болохгүй гэж татварын байгууллага үзсэн. Мөн, гадаадын ААН-ын татварын заалтад ч нийцэхгүй тул гадаад улсын татварыг хасаж тооцох тогтолцооны шалгуурт нийцэхгүй гэж үзсэн.

51

★8-3 Дээд шүүхийн шийдвэр

- Дээд шүүхээс [Бодит байдал дээр татвар төлөгч нь энэхүү үүргээсээ санаатайгаар зайлсхийх боломж бүхий татварын тухайд, ААН-ын татварт энэхүү татвар тохирохгүй бөгөөд гадаадын ААН-ын татварт ч хамаарахгүй гэж тайлбарлах боломжтой] гэж үзсэн.
- Нөгөө талаас, энэхүү арлын “Татвар” нь [Guernsey арлын хуульд үндэслэн Guernsey-ээс энэхүү охин компанийн орлогыг татвар ногдуулах жишиг болгон ногдуулсан татвар болох тул татвар гэж үзэхгүй байх боломжгүй бөгөөд гадаадын ААН-ын татварт хамаарахгүй гэж үзэхийн тухайд, ААН-ын татварын хуулийг хэрэгжүүлэх аргачилалын 141-3-1 ба 141-3-2-т заасан татварт ч, эдгээртэй адил төрлийн татварт ч орохгүй бөгөөд ААН-ын татвар биш гэж үзэхэд ч бас хүндрэлтэй.
- Иймд, гадаадын ААН-ын татвар биш гэж үзэх боломжгүй] гэж үзээд татвар төлөгчийн талд шүүхийн шийдвэр гарсан.

52

★8-4 Хуульд гадаадын ААНОТ-ын талаар тодорхойлсон нь

Q ААНОТ-ын хуулийн 69-①-д заасан (гадаадын татварын хасалт)Г Гадаад улсын ААНОТ 1гэдэг нь юу болох?

А

ААНОТ хуулийн хэрэгжүүлэх аргачилалын 141-① (Гадаадын ААН-ын татварын тодорхойлолт)■ Хэлбэрийн хувьд тодорхойлсон

➔ Гадаад улсын хуульд үндэслэсэн ААНОТ

ААНОТ хуулийн хэрэгжүүлэх аргачилалын 141- ② (Гадаадын ААН-ын татварт орох зүйлс)■ Чанарын хувьд тодорхойлсон

➔ ① Гэнэтийн ашгийн татвар, ② Нэмэгдсэн өртгийн татвар, ③ Орлогын татвар ногдуулалт

ААНОТ хуулийн хэрэгжүүлэх аргачилалын 141- ③ Гадаадын ААН-ын татварт орохгүй зүйлс)■ Чанарын хувьд тодорхойлсон

➔ ① Сайн дураар буцаан олголтын хүсэлт гаргах боломжтой татвар, ② Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийг сайн дураар тогтоох боломжтой татвар


Дээд шүүхээс ③-д хамаарахгүй гэж үзсэн.

53

5. Гадаадын аж ахуйн нэгжийн талаарх шүүхийн шийдвэр

54

★9-1 Мөнгөний сайжруулалтын хэрэг Ажил гүйлгээний зураг



55

★9-2 Агуулга

(Эвлэрэх зөвшилцөл ба татвар ногдуулалт)

Японы ААН болох X болон Америкийн ААН болох В хооронд (1983 оны II сард байгуулсан) эвлэрлийн гэрээний агуулга

- 1) X нь Америкт борлуулагдаж байсан В-ийн патенттай бүтээгдэхүүний эрхийг зөрчсөний роялтиг В компанид төлсөн. (760 мянган доллар)
- 2) В нь энэхүү роялтийн төлбөрийг авснаар патентын эрхийн асуудал тавихгүй.
- 3) Мөн энэхүү төлбөр нь цаашил 2 компанийн хооронд гарч болох асуудлыг шийдвэрлэх төлбөр болно.
- ➔ X нь В-д энэ гэрээний заалтын дагуу 760,000 долларыг суутган татвар авалгүйгээр төлсөн.
- ➔ Татварын албаны дарга энэхүү төлбөр нь Орлогын татварын хуулийн 161-7-ийн И-д заасан дотоод эх үүсвэртэй орлого болно гэж үзээд суутган татвар ногдуулсан.

56

★9-3 Шүүхийн шийдвэр (Анхан, давж заалдах ба дээд шүүхэд улс ялагдсан)

• Дээд шүүх

1)Энд хийсэн төлбөр нь Америк улсад тоног төхөөрөмж борлуулахтай холбоотой Америкийн патентын хураамж болно.

2)Иймд, Х-ийн Япон Улсад хийсэн үйл ажиллагаанд төлөгдсөн зүйл биш.

3)Иймд энэ төлбөр нь Орлогын тухай хуулийн 161-7-ийн И-д заасан дотоод эх үүсвэртэй орлогод орох хураамж биш.

Шалтгаан

Энэхүү мөнгөн дүн нь Х компани В-ийн Америк дахь патентын эрхийг ашиглан Америкт хэвлэх машин худалдан борлуулах хязгаарлагдмал эрхийг авахын төлөө хийсэн төлбөр бөгөөд Америкт худалдан борлуулсан тохиолдолд, тухайн улсын патентын эрхийг хэрэгжүүлсний хураамж юм.

57

★9-4 2 Дээд шүүхийн шүүгчийн санал зөрөлдөөн

Энэхүү мөнгөн дүн нь Х компани Япон улсад хэвлэх машиныг үйлдвэрлэн, борлуулах талаарх Америкийн патентын эрхийн агуулгыг бататган, технологийн хувьд хэрэгжүүлсний хураамж болно.

↓

Дотоод эх үүсвэртэй орлого болно

58

★9-5 Митчелийн хэрэг (1985 он)

Хэрэг

Дотоодын ААН нь гадаадын ААН-ээс Америкийн патентийн эрх, Япон болон бусад хэд хэдэн улсад хүчинтэй байх зөвшөөрөл, тусгайлсан лицензийг авч, Японд бүтээгдэхүүн үйлдвэрлэн, бүтээгдэхүүний нэг хэсгийг Японы охин компаниар дамжуулан гадаадад экспортолдог байсан.

Маргасан асуудал

Эрхийн хураамжийн эх үүсвэрийн улс хаанах болох.

Токиогийн орон нутгийн шүүх

Японд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэг хэсэг нь эцсийн байдлаар гадаадад борлуулагдсан байсан ч хураамжийг тухайн зөвшөөрлийг ашиглаж байгаа үндсэн шат болох үйлдвэрлэлийн шатны төлөө төлөгдөж байгаа тул нийт хураамжийг Япон улсад эх үүсвэртэй гэж үзнэ гэж шийдвэрлэсэн.


Гэвч, Япон Америкийн татварын гэрээнд хураамжийг татвараас чөлөөлөхөөр заасан байдаг.

59

6. Байнгын оршин суугч бус этгээдийн талаарх шүүхийн шийдвэр

60

★10-1 Такефүжи (Зурагт тайлбар)



61

★10-2 Такефүжийн хэргийн агуулга

- Хэрэглээний санхүүгийн Такефүжигийн ерөнхийлөгчийн эхнэр нь 2000 онд өв залгамжлал ба бэлэглэлийн татварын хуульд өөрчлөлт орохын өмнө, 1999 онд Нидерландын компанийн хувьцааг том хүүдээ бэлэглэсэн. Энэ үед, том хүү нь Такефүжи ба Хонконгийн охин компанийн удирдах зөвлөлийн гишүүн байсан ба хуралд суух зорилгоор Япон, Хонконгийн хооронд зорчдог байсан. Бүртгэлээр 1997-2000 оны хугацаанд 2/3 нь Хонконгод амьдарч байсан ба Хонконгийн охин компанийн үйл ажиллагаанд оролцож байсан.
- Бэлэглэсэн Нидерландын компани нь Такефүжийн хувьцааг эзэмшихийн хамт, Японд хөрөнгөтэй байсан. Энэ байдлаараа өв залгамжлал үүсвэл, дотоодын хөрөнгөөс гадна, гадаад дах бүх хөрөнгөд өв залгамжлалын татвар ногдоно. Өөрөөр хэлбэл, том хүү нь хувьцааг өв залгамжилж авснаар ихээхэн хэмжээний өв залгамжлалын татвар ногдсон.
- Гэхдээ Такефүжийн хувьд, том хүү нь гадаадад байсан ба Японд «Оршин суудаг» эсэх нь асуудал болсны дээр бэлэглэсэн хөрөнгө нь ч гадаад дахь хөрөнгө байсан тохиолдолд бэлэглэлийн татвар ногдуулахгүй гэсэн хуультай байсан тул Нидерландын компанийн хувьцааг татваргүйгээр бэлэглэж, Японд бэлэглэлийн татварын тайланд тусгаагүй.
- Бэлэглэлийн үнийн дүн өндөр байсантай холбоотойгоор татварын байгууллагын хяналт шалгалт орж, 2005 онд энэхүү бэлэглэл нь татвараас зайлсхийх зорилгоор хийгдсэн бөгөөд татварын хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзээд 133 тэрбум иений нөхөн татвар ногдуулсан. Бэлэглэлийн татвар болох тул тухайн үеийн хамгийн өндөр татварын хувь хэмжээ буюу 70% хүрч байсан ба 2001 онд 50% хүртэл татварын хувь хэмжээг бууруулсан.
- Дээд шүүхийн шийдвэрээр том хүүдээ бэлэглэсэн асуудал нь татвараас зайлсхийсэн бус бөгөөд бэлэглэлийн татварын хэмжээ 0 бөгөөд нөхөн татварыг хэрэгсэхгүй болсон. Иймд, 133 тэрбум иенийг буцаан олгохын хамт, 40 тэрбум иений хүүг улсаас төлөхийг татварын байгууллагад тушаасан.

62

★10-3 Шүүхийн шийдвэрийн гол асуудал

- Q Том хүүгийн амьдарч байсан газар, өөрөөр хэлбэл хаяг нь Японы дотор уу, Хонконгийн дотор уу? Том хүү бэлэглэл хүлээн авахын өмнө хойнох 3 жил хагасын хугацааны 65%-аас илүүг Хонконгод амьдарч байсан тул хаяг нь яг хаанахаар байна гэдэг нь гол асуудал болсон.
- Анхан шатны шүүх Токиогийн орон нутгийн шүүхийн 2007 оны 5 сарын шийдвэр: Татвар төлөгч ялсан
- Давж заалдах шатны шүүх Токиогийн дээд шүүхийн 2008 оны 1 сарын шийдвэр: Улс ялсан
- Дээд шүүх 2011 оны 2 сарын шийдвэр: Татвар төлөгч ялсан.

63

★10-4 Токиогийн орон нутгийн шүүхийн шийдвэр (татвар төлөгч ялсан)

- 「Хаяг байршил гэдэг нь хүмүүсийн амьжиргааны үндсэн цэгийг зааж байгаа ба амьжиргааны үндсэн цэг гэдэг нь тухайн хүний амьдралтай хамгийн гүн гүнзгий холбоотой байгаа ерөнхий амьдралыг, нийт амьдралын төвийг заасан зүйлийг хэлнэ.」
- ➔ Анхан шатны шүүхийн шийдвэрээр бэлэглэлийн татвараас зайлсхийх зорилготой байсан ч, Хонконгод амьжиргааны үндсэн цэг байгаа гэсэн бодит үнэнг үгүйсгэх боломжгүй. Иймд, 「Амьжиргааны үндсэн цэг」 нь Хонконгод байна гэж үзээд, ногдуулсан татварыг нийт үнийн дүнгээр хүчингүй болгосон.

64

★10-5 Токиогийн дээд шүүхийн шийдвэр (Улс ялсан)

Давж заалдах шатны шүүхээс хүүгийн Хонконгод байрлах зорилго нь бэлэглэлийн татвараас зайлсхийх төлөвлөгөөтэй байсан гэж үзсэн. Бэлэглэл хүлээн авахын өмнө, хойно 3 жилийн хугацаанд 65%-аас илүүг нь Хонконгод амьдарсан байгаа боловч, оршин суусан хоногийн тоогоор "Амьжиргааны үндсэн цэг"-ийг тодорхойлох нь буруу гэж үзсэн.

Иймд (a) Амьдрах газар (b) Ажил (c) Хөрөнгийн байршил (d) Оршин суух шийдвэрийн талаар дараах байдлаар шийдвэр гаргасан.

Такефүжийн ерөнхийлөгчийн эхнэр нь өмгөөлөгчтэй олон удаа ярилцаж, удаан хугацаанд энэхүү схемийг боловсруулж, том хүүгээ Хонконгод амьдруулсан асуудлыг анхаарах. Том хүү нь Японд ч өөрийн гэртэй бөгөөд гэр орны тавилга ч хэвээрээ байсан ба Хонконгод шилжүүлээгүйн дээр ажил нь Хонконгод байсан ч интернет, утсаар Такефүжийн ажлыг хийсээр байсан нөхцөл байдлаас "Амьжиргааны төв нь Японд байсан" гэж тогтоосон ба энэхүү бэлэглэл нь татвараас зайлсхийх зорилготой байсан ба Хонконгод амьдарсан хоногийн тоог татвараас чөлөөлөгдөх зорилгоор зохицуулалт хийсэн гэж үзээд татварын байгууллагаас хийсэн ногдуулалтаа хуульд нийцнэ гэж үзсэн.

65

★ 10-5 Токиогийн дээд шүүхийн шийдвэр (Бодит байдлыг тодруулсан байдал)

1. Японы орон гэр нь Хонконг явсны дараа ч хэзээ ч эргэн хэрэглэхээр байдалд байдаг.
2. Японд амьдарч байх хугацааны орон гэрийн амьжиргаа нь Хонконгод амьдрахаас өмнөх байдалтай ямар нэг ялгаа байхгүй.
3. Хонконгод байхдаа ч Японд байх компанийхаа удирдах ажилтан гэдгээрээ үйл ажиллагаанд нь оролцож, тушаал дэвшиж байна.
4. Япон дахь компанийн үйл ажиллагааны удирдлагыг үргэлжлүүлэн хүлээн ажиллахаар төлөвлөгдөж байгаа ба энэхүү ажил нь бизнесийн хувьд хамгийн гол цөм болж байна.
5. Хонконгод амьдрахын тулд тавилга, эд хогшлоо шилжүүлээгүй хувцсаа л аваад нүүсэн байна.
6. Бэлэглэлийн үед, Хонконгод байгаа хөрөнгийн үнэлгээ, Япон дахь хөрөнгийн үнэлгээний 0.1%-аас хэтрэхгүй байна.
7. Хонконгийг амьжиргааны цөм болгох санаатай гэдэг нь батлагдахгүй байна.

66

★10-6 Дээд шүүхийн шийдвэр (татвар төлөгч ялсан)

「Тухайлсан газрыг хаяг байршил болох эсэхийг амьжиргааны үндсэн цэг болохуйц бодит байдлыг үүсгэсэн байгаа эсэхээр тодорхойлох ёстой бөгөөд субъектив талаасаа бэлэглэлийн татвараас зайлсхийх санаатай байсан ч амьжиргааны бодит байдлын объектив шинж чанарыг энэ нь үгүйсгэх боломжгүй тул Хонконгод байсан хоногийн тоо нь нийт хамаарах хугацааны гуравны хоёртой (Японд байсан хугацааны 2.5 дахин) тэнцүү байгаа нэхэмжлэгчийн тухайд, Хонконгод амьжиргааны үндсэн цэг байгаа бодит байдлыг үгүйсгэх боломжгүй.」

ОИЙмд, бэлэглэсэн этгээд, бэлэг хүлээн авсан этгээд нь 5-аас дээш жилээр гадаадад оршин суусан бөгөөд гадаадад байх хөрөнгөө бэлэглэсэн тохиолдолд татвар ногдуулахгүй.


67

7. Олон улсын татвараас зайлсхийхтэй холбоотой шүүхийн шийдвэр

68

★11-1 Киноны түрээсийн хэрэг Ажил гүйлгээний зураг 1


α Нийтлэг байдаг ажил гүйлгээний хэлбэр



69

★11-1 Ажил гүйлгээний зураг 2

β Нийтлэг байдаггүй ажил гүйлгээ



70

★11-2 Агуулга 1

Америкийн ААН Х хөрөнгө оруулалтын зөвлөхийн дагуу хийсэн гэрээний гол асуудал

1. Японы хөрөнгө оруулагчдыг цуглуулж, иргэний хуулийн дагуу С хоршоог байгуулах(Хөрөнгө оруулагчид нь хоршооллын гишүүн)
2. С хоршоо нь гишүүний өөрийн хөрөнгө болон Нидерландын Е банкнаас авсан зээлийг хөрөнгийн эх үүсвэр болгон, Америкийн В компаниас кино худалдан авахтай холбоотой худалдах худалдан авах гэрээ байгуулсан. Америкийн В компани бас адилхан кино худалдан авах гэрээг Америкийн А компанитай байгуулсан.
3. С хоршоо нь Нидерландын ААН-тэй түрээс хэлбэрээр кино түгээх эрх бүхий гэрээ байгуулсан.
4. Нидерландын D компани нь киноны хальс эзэмшигч Амщрикийн А компанитай кино түгээх хоёрдогч гэрээг түрээс хэлбэрээр байгуулсан.

71

★11-2 Агуулга 2

Гэрээнд үндэслэсэн мөнгөн урсгал

1. С хоршоо нь өөрийн хөрөнгө болох 2.6 тэрбум иен ба Е банкнаас зээлсэн 6.4 тэрбум иен, нийт 9 тэрбум иенийг киноны төлбөр болгон Америкийн В компанид төлсөн.
2. В компани нь тухайн 9 тэрбум иенийг Америкийн А компанид кино худалдан авсны төлбөрт төлсөн.
3. Америкийн А компани нь Нидерландын D компанид хоёрдогч түгээлтийн гэрээний түрээсийн төлбөрт 6.4 тэрбум иен төлсөн. (С хоршооллын Е банкнаас авсан зээлийн дүнтэй тэнцэх мөнгөн дүн)
4. D компани нь С хоршоонд тухайн зээлтэй тэнцэх үнийн дүн болох 6.4 тэрбум иенийг төлсөн.
5. Мөн, С хоршоонд буцаж ирсэн 6.4 тэрбум иен нь Е банкнаас авсан зээлтэй адил үнийн дүнтэй тул зээлээ төлбөл, С хоршоонд 0 мөнгө үлдэнэ.
6. С хоршоо нь эцсийн байдлаар өөрийн хөрөнгө болох 2.6 тэрбум иенийг Америкийн А компанид өгч байгаа хэрэг болно.

72

★11-2 Агуулга 3

Эргэлтийн санхүүжилтын асуудал

- Санхүүжилт нь С хоршоо ➡ Америкийн В компани ➡ Америкийн А компани ➡ Нидерландын D компани ➡ С хоршоолол гэсэн байдлаар эргэлдэж байна.

(Эзэмшлийн эрхтэй эсрэгээр эргүүлэх)

(Киноны эзэмшлийн эрх нь Америкийн А компани ➡ Америкийн В компани ➡ С хоршоо....)

Эргэлтийн санхүүжилт гэдэг нь оролцогсдоос хэлбэрийн хувьд мөнгийг эргэлдүүлж, [Бодитоор төлбөр хийгдсэн юм шиг харагдуулж, барааг татвараас чөлөөлөх техник арга юм]

73

★11-3 Татвар төлөгчийн (Ү хоршооны гишүүн, хуулийн этгээд) санхүүгийн боловсруулалт, татварын байгууллагаас авсан арга хэмжээ

Татвар төлөгчийн санхүүгийн боловсруулалт

1. Хоршооны гишүүн Ү нь өөрийн хөрөнгөтэй холбоотой киноны хальсыг тоног төхөөрөмж байдлаар хөрөнгөдөө тусган (ашиглалтын хугацаа 2 жил), элэгдэл хорогдлын зардлыг тооцсон. Дараа нь энэхүү хальсаа Нидерландын ААН-д түрээслэсэн.
2. Хоршоо нь энэ киноны хальсыг эзэмших эрхийг авсны дараа, түрээслэх үйл ажиллагаа эрхэлсэн гэж хэлсэн.

Татварын байгууллагаас авсан арга хэмжээ

Бодит байдал дээр С хоршоо нь киноны хальс худалдан аваагүй ба Америкийн А компанид киноны түгээлтийн зээл өгсөн тул хоршооны гишүүн болох Ү компани нь элэгдэл хорогдлын зардал тусгахыг зөвшөөрөхгүй.

74

★11-4 Осакагийн орон нутгийн шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

Хуулийн бүтцийн тайлбарын үндэслэлийг ашиглах

- Г (Нийт гэрээг нэгдсэн байдлаар харж) нийт асуудлыг нэгтгэн үзвэл, Y компани нь C хоршоогоор дамжуулан, Америкийн А компанийн кинонд санхүүжилт болох зээлийг өгсөн байна.]
- C хоршоо ба Y компани нь кино хальсны эзэмшлийн эрхийг бодит байдал дээр аваагүй.
- Y компанийн элэгдэл хорогдлын зардлыг нийт үнийн дүнгээр үгүйсгэсэн.

75

★11-5 Осакагийн орон нутгийн шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

Хуулийн бүтцийн тайлбарын үндэслэлийг ашиглах

1. Татвар ногдуулалтыг хуульд нийцэх эдийн засгийн ажил гүйлгээнд ногдуулна.
2. Татвар ногдуулах үндэслэл болох хуулийн холбогдогчдын зорилгыг, эдийн засгийн бодит байдлыг тусган санал нэгдсэн агуулгад үндэслэн тодорхойлох.
3. Татвараас зайлсхийх зорилго байгаа тохиолдолд, холбогдогч талуудын хуулийн хүрээний бодит байдлыг тодорхойлж, татвар ногдуулалт хийх шаардлагатай хэрхэн нийцэхийг тодорхойлох.
4. Ингэвэл, А компанийн гэрээ байгуулсантай холбоотой зорилго нь киноны үндсэн эрхийг өөрсдөө эзэмших байдлаар санхүүжилт олох асуудал бөгөөд, C хоршооны хувьд татвараас зайлсхийх асуудал юм.
5. Иймд, Y компани нь киноны хальсны эзэмшлийн эрхийг бодит байдал дээр аваагүй.
6. Киноны хальстай холбоотой элэгдэл хорогдлын зардлыг нийт үнийн дүнгээр үгүйсгэсэн.

76

★11-6 Дээд шүүхийн шийдвэр (Татвар төлөгч ялагдсан)

Дээд шүүхийн шийдвэр нь доод шатны шүүхийн шийдвэрүүдийг батлах болон хуулийн бүтцийн тайлбарыг ашиглаагүй. Мөн гэрээнүүдийн агуулгыг үгүйсгээгүй.

1. Киноны хальс нь С хоршоо ба Ү ААН-ын бизнесийн үйл ажиллагаанд ашиглагдаж байна гэж үзэхээргүй байгаа тул ААНОТ хуулийн 31-① (хэрэгжүүлэх аргачилалын 13-①)-д заасан элэгдэл хорогдлын зардалд тооцон тусгах боломжгүй.
2. Учир нь С хоршоо нь Америкийн В компанитай киноны хальс худалдах худалдан авах гэрээ хийн, эрхийг авсан байсан ч, энэхүү эрхийн ихэнх нь тухайн эрхийг шилжүүлэн авсан огноотой адил хугацаанд Нидерландын D компанитай хийсэн түрээсийн гэрээний дагуу энэ компанид эрх шилжиж, бодит байдал дээр хоршоо эрхээ алдаж байна. Дээр нь киног худалдан авч буй Ү ААН нь ҮХХ-ийн бизнес эрхэлдэг тул энэ салбарын хөрөнгө оруулалтыг сонирхохгүй байхаар байна.
3. Мөн, С хоршооны Е банкнаас авсан зээлийн буцаан төлөлт нь Нидерландын D компаниас хийгдэх түрээсийн төлбөрөөр хаагдаж байгаа тул хоршооны хувьд зээлдэгчийн хүлээх эрсдэл байхгүйн дээр энэхүү ажил гүйлгээнээс С хоршоонд хамаарах бизнесийн үйл ажиллагаа байхгүй байна.


77

★11-7 Хуулийн бүтцийн тайлбар

- Токиогийн Их сургуулийн Накасато багшийн тайлбар
- [Хуулийн бүтцийн тайлбарын хүрээнд үгүйсгэх]
- Татвар ногдуулах нөхцөл байдлыг тодорхойлохдоо, холбогдогч талуудын сонгосон гадаад хэлбэр, үзэмжид хэт анхааралгүйгээр, талуудын зорилгоо болгож буй хуулийн хүрээний бодит байдлын уялдаа холбоог анхаарч, татвар ногдуулах нөхцөл байдалд нийцүүлэх замаар татвараас зайлсхийх үйлдлийг зогсоох арга
- Энэхүү ажил гүйлгээний хүрээнд авч үзвэл, Японы иргэний хуулийн 1-③-ийн [Эрхээ урвуулан ашиглах], 94-р зүйлийн [Хуурамч байдал] зүйл заалтад нийцүүлэн, Америкийн В компани ба С хоршооны хоорондын худалдах худалдан авах гэрээ хүчингүй болсон тохиолдолд, ард нь [Зээлийн гэрээ] бодитойгоор үлдэж байна.
- ➔ Гэхдээ, Иргэний хуулийн хүрээний ажил гүйлгээ нь [Хүчингүй] болохгүй л бол, ажил гүйлгээг өөрчлөх боломжгүй.

78

★12-1 Америкийн Apple компанийн хэрэг (Double Irish · Dutch Sand Type Tax Avoidance) Ажил гүйлгээний зураг



79

★Америкийн Apple компанийн хэргийн агуулга 1

• Агуулга

1. Америкийн энэхүү компани ба Ирландын 1-р охин компани (цаасан компани) хооронд зардлаа хуваах гэрээ байгуулан, Apple компанийн биет бус хөрөнгийн Америкаас гадна олсон орлогыг тус охин компанид хамаатуулахаар болсон.
 - ➔ Америкийн ААНОТ-ын хувь хэмжээ 35%, Ирландад 12.5%
2. Ирландын 1-р охин компанийн хяналт харьяаллын бүс нь Виржиний арал байна.
 - ➔ Ирландын хяналт, харьяаллын зарчмаар, охин компани нь Ирландад оршин суугч бус болох бөгөөд татвар ногдохгүй.
3. 1-р охин компани нь Ирландын 2-р охин компанид (ажиллагсадтай бодитой компани) биет бус хөрөнгө ашиглах эрхийн зөвшөөрөл өгсөн.
4. 2-р охин компани нь биет бус хөрөнгийг ашиглан, Англи улсын дотор Америкийн Apple компанийн аппликейшн борлуулах ажлыг хийхийн тулд Apple компанийн Английн охин компанид үйлчлүүлэгч олох хүсэлт гарган, ажлын төлбөр төлдөг.
5. Apple компанийн Англи дахт охин компанийн олсон Английн үйлчлүүлэгч нь Ирландын 2-р компанид зар сурталчилгааны хураамж төлдөг.

80

★ Америкийн Apple компанийн хэргийн агуулга 2

6. Ирландын 2-р охин компани нь Английн үйлчлүүлэгчээс авсан зар сурталчилгааны хураамжийн эх үүсвэр болгон Нидерландын компанид роялти төлж, энэхүү компани нь Ирландын 1-р компанид роялти төлдөг.
- ➔ Ирланд ба Нидерландын татварын гэрээ, Нидерландын татварын тогтолцооны дагуу суутган татвараас чөлөөлөгдөнө. Ирландын 2-р охин компанийн [Зар сурталчилгааны хураамжийн орлого—Нидерландын компанид төлөх роялти]-ийн орлогод Ирландад ААН-ын татвар (12.5%) ногдуулагдана.
7. Америкийн Apple компани нь check the box тогтолцоогоор Ирландын 2-р охин компанийг Ирландын 1-р компанийн салбар болгосон.
- ➔ Ирландын 1-р охин компани нь үйл ажиллагаа бодитой эрхэлдэг Ирландын 2-р компанийг салбараа болгосноор энэхүү 1-р компани бас бодитой компани болж, Америкийн татварын диваажингийн татвараас чөлөөлөгдсөн.

81

8. Япон Улсын олон улсын татварын тогтолцоо ба Монгол Улсын хууль тогтоомжийн ялгаа

82

Япон улсын Олон улсын холбоотой татварын хууль (Ач холбогдлын эрэмбээр)

М: Монгол улсын хууль тогтоомж хоорондын харьцуулалт

1. Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (М: Хэсэгчилсэн хуулийн заалттай)
2. Төлөөний газарт татвар ногдуулах (М: Хэсэгчилсэн хуулийн заалттай)
3. Нимгэн капиталын татварын тогтолцоо (М: Хуулийн заалттай)
4. Өндөр хүүгийн татварын тогтолцоо (М: Хуулийн заалт байхгүй)
5. Татварын диважингийн тогтолцоо (М: Хуулийн заалт байхгүй)
6. ААН-ын урвуу татварын тогтолцоо (М: Хуулийн заалт байхгүй)
7. Гадаадын татварын хасалт хийх тогтолцоо (М: Хэсэгчилсэн хуулийн заалттай)
8. Гадаадын охин компанийн ноогдол ашгийг тооцохгүй байх тогтолцоо (М: Хуулийн заалт байхгүй)
9. Гадаад харилцан хамааралтай этгээдэд өгөх хандивт татвар ногдуулах (М: Хуулийн заалт байхгүй)
10. Гадаад валютаар хийгдэх ажил гүйлгээг шилжүүлэн тооцох (М: Хуулийн заалт байхгүй)
11. Оршин суугч биш этгээд болон гадаадын ААН-ын суутган татвар (М: Хэсэгчилсэн хуулийн заалттай)
12. Олон улсын хэрэглээний татвар (М: Хуулийн заалт байхгүй)

83

1 Үнэ шилжилтийн татварын тогтолцооны үндсэн зүйл заалт(Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4①) ба хуулийн бүтэц

(Гадаад харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээнд ногдуулсан татварын жишээ)

- Аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны тайлант хугацаанд, тухайн аж ахуйн нэгжтэй гадаад харилцан хамаарал бүхий этгээдтэй (гадаадын аж ахуйн нэгж бөгөөд тухайн аж ахуйн нэгжтэй тусгай харилцаа бүхий этгээдийг хэлнэ)хөрөнгийн худалдаа, хөрөнгийн худалдан авалт, үйлчилгээ үзүүлэх болон бусад ажил гүйлгээ хийсэн бол, энэхүү гадаад харилцан хамааралтай этгээдээс хүлээн авсан төлбөр, эсвэл төлсөн төлбөр нь сунгасан гарын үнийн шаардлагыг хангаагүй, эсвэл төлсөн төлбөр нь сунгасан гарын үнээс хэтэрсэн тохиолдолд, тухайн аж ахуйн нэгжийн тайлант хугацаанд олсон орлоготой холбоотой ААНОТ хууль болон бусад хуулийн заалтын нийцлийн тухайд, эдгээр ажил гүйлгээ нь сунгасан гарын үнээр хийгдсэн гэж үзнэ.
- Хуулийн бүтэц ➡ хэрэгжүүлэх аргачилал ➡ дагалдах журам ➡ тушаал, шийдвэр ➡ ТР үйл ажиллагааны удирдамж & ТЕГ-ын жишээний эмхэтгэл ✖ үнэ шилжилтийн гарын авлагыг саяхан боловсруулан гаргасан.

84

Үнэ шилжилтийн татварын тогтолцооны гол чухал зүйл заалтууд

(Гадаад харилцан хамаарал бүхий этгээдтэй хийсэн ажил гүйлгээнд татвар ногдуулах жишээ)

➔ Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4 ①

(Сунгасан гарын үнэ: CUP, RP, CP-ийн тайлбар)

➔ Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4 ②

(Сунгасан гарын үнэ: PS, RPSM, TNMM-ийн тайлбар)

➔ Тусгай арга хэмжээний тухай хуулийн хэрэгжүүлэх аргачилал 39-12 ⑧

(Харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ажил гүйлгээнд ашиглах)

➔ Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4 ⑤

(Сунгасан гарын үнийг тодорхойлж тохируулга хийх ба үнийг тогтох)

➔ Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4 ⑧

(Гадаад харилцан хамаарал бүхий этгээдэд хавсарган өгөх ажил гүйлгээний задаргаа)

➔ Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4 ⑩

85

2 Төлөөний газарт татвар ногдуулах үндсэн зүйл заалт (ААН-ын татварын хууль 141-р зүйл) ба хуулийн бүтэц

ААН-ын татварын хууль 141-р зүйл

Гадаад ААН-д үйл ажиллагааны тайлант жилийн орлогод татвар ногдуулах ААН-ын татварын жишиг нь дараах гадаадын ААН-ын ангилалын дагуу тухайн ангилалд хамаарах дотоодын эх үүсвэрт хамаарах орлогрын үнийн дүн байна.

1. Төлөөний газар бүхий гадаадын ААН-ын тайлант жилийн дотоод эх үүсвэртэй орлого

• 138-р зүйлийн 1-1-т заасан Дотоод эх үүсвэртэй орлого

• 138-р зүйлийн 1-2-оос 6 хүртэл заасан Дотоод эх үүсвэртэй орлого

2. Төлөөний газаргүй гадаадын ААН-ын тайлант хугацаан дахь 138-р зүйлийн 1-2-оос 6 хүртэл заасан дотоод эх үүсвэртэй орлого

Дотоод эх үүсвэртэй орлого

• Хуулийн бүтэц ААНОТ хууль ➔ хэрэгжүүлэх аргачилал ➔ дагалдах журам ➔ тушаал, хэрэгжилтийн тухай хууль ➔ тушаал

86

Төлөөний газартай холбоотой гол, чухал зүйл заалтууд

(Гадаадын ААН-ын татвар төлөх үүрэг)

➔ ААНОТ хууль 2-р зүйл, 4-р зүйл

(Гадаадын хуулийн этгээдийн ангилал)

➔ ААНОТ хууль 141-р зүйл

(Дотоод эх үүсвэртэй орлого)

➔ ААНОТ хууль 138-р зүйл

(Төлөөний газарт хамаарах орлогын дүнг тодорхойлох)

➔ ААНОТ хууль 142-р зүйл

(Төлөөний газартай холбоотой баримт нотолгоо)

➔ ААНОТ хууль 146-2

87

3 Нимгэн капиталын татварын тогтолцооны үндсэн зүйл заалт (ТТАХ-ний тухай хууль 66-5-1) болон хуулийн бүтэц

- Дотоодын ААН нь үйл ажиллагааны тайлант хугацаанд, тухайн дотоодын ААН-тэй **холбоотой гадаад дахь хувьцаа эзэмшигч болон санхүүжүүлэгчдэд өглөгийн хүү** төлөх тохиолдолд, тухайн тайлант хугацаан дахь өглөгийн дундаж үлдэгдэл нь тухайн тайлант хугацааны тухайн дотоодын ААН-тэй холбоотой гадаадын хувьцаа эзэмшигчийн үндсэн хөрөнгийн хувиас **3 дахин их үнийн** дүнгээс давах тохиолдолд, тухайн төлөх өглөгийн хүүний үнийн дүнгийн дотроос дээрх хязгаарыг давсан хэсгийг зохих журмын дагуу тооцож гарган, тухайн тайлант хугацааны орлогыг тооцохдоо зардалд тусгахгүй.

88

Нимгэн капиталын татварын тогтолцоо ТТАХ-ний тухай хууль 66-5-1 үргэлжлэл

- Гэхдээ, тухайн дотоодын ААН-ын тухайн тайлант хугацааны нийт өглөгтэй холбоотой дундаж өглөгийн үлдэгдэл нь тухайн дотоодын ААН-ын өөрийн хөрөнгийн хэмжээг 3 дахин үржүүлсэн үнийн дүнд хүрэхгүй тохиолдолд дээрх хязгаарлалтад хамаарахгүй.

89

Чухал заалт 1 Гадаад хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт ТТАХ-ний тухай хуулийн 66-5-5, хэрэгжүүлэх аргачилалын 39-13,12

- Дараах харилцаанд байх оршин суугч бус этгээд, эсвэл гадаад ААН
 1. Дотоодын ААН-ыг хянан удирдах харилцаа (Гаргасан хувьцааны 50%-аас илүүг шууд ба шууд бусаар эзэмшдэг)
 2. Нэг адил этгээдийн хяналт удирдлагад байгаа 2 ААН-ын харилцаа
 3. Дотоодын ААН-ын үйл ажиллагааны чиглэлийг бүхэлд нь эсвэл хэсэгчилэн шийдвэр гаргах боломжтой харилцаа

90

Чухал заалт 2

Зардалд тооцохгүй хүүгийн төлбөрийн дүнг тооцох арга ТТАХ-ний тухай хуулийн 66-5-1, хэрэгжүүлэх аргачилалын 39-13-1

$$\text{Гадаад хувьцаа эзэмшигчид төлөх нийт хүү} \times \frac{\left[\text{Гадаад хувьцаа эзэмшигчийн өглөгийн дундаж үлдэгдэл} \right] - \left[\text{Гадаад хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн хувь} \right] \times 3}{\text{Гадаад хувьцаа эзэмшигчийн өглөгийн дундаж үлдэгдэл}}$$

Тооцооны жишээ: Нийт хүүгийн төлбөр	200
Гадаад хувьцаа эзэмшигчийн өглөгийн дундаж үлдэгдэл	100
Гадаад хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн хувь	20
200 × 40% = 80.....зардалд тооцохгүй хүүгийн төлбөр	

91

4 Өндөр хүүгийн татварын тогтолцооны үндсэн зүйл заалт ТТАХ-ний тухай хууль 66-5-2

(Харилцан хамаарал бүхий этгээд хоорондын хүүгийн төлбөрийг зардалд тусгахгүй байх)

- Тайлант хугацаанд харилцан хамаарал бүхий этгээд хооронд хүүгийн төлбөр байгаа тохиолдолд, тухайн ААН-ын тайлант хугацаанд харилцан хамаарал бүхий этгээдэд төлөх нийт үнийн дүнгээс тухайн хугацаанд хамаарах хасалтад хамрах үнийн дүнг хассан үлдэгдэл (「Харилцан хамаарал бүхий этгээд хооронд төлөх хүүгийн үнийн дүн」 гэнэ.) нь **тухайн хугацааны зохицуулах орлогын дүнгийн** (харилцан хамааралтай этгээдийн цэвэр хүүгийн дүнтэй харьцуулах жишиг болох орлого хэмээн хуульд заасан дүн) зууны **50 хувьтай тэнцэх үнийн дүнгээс хэтрэх үед, тухайн хэтэрсэн хэсгийг** тухайн тайлант хугацааны ААН-ын зардалд тусгахгүй.

92

Чухал заалт 1
Харилцан хамаарал бүхий этгээдийн тодорхойлолт
ТТАХ-ний тухай хууль 66-5-2-2, хэрэгжүүлэх аргачилал
39-2-8-3, 10

Харилцан хамааралтай этгээдийн хамрах хүрээ

- ① Шууд ба шууд бусаар эзэмших хувийн харьцаа 50%-аас их байх
- ② Бодит хянан удирдуулах харилцаатай байх
- ③①②-ийн авлагын баталгаа бүхий гуравдагч этгээд

93

Чухал заалт 2
Зардалд тооцохгүй үнийн дүн
ТТАХ-ний тухай хууль 66-5-2①②③ хэрэгжүүлэх
аргачилал 39-13-2

Харилцан хамааралтай этгээдийн цэвэр хүүгийн төлбөр — Зохицуулах орлогын дүн × 50%

- Харилцан хамааралтай этгээдийн хүүгийн төлбөр = цэвэр хүүгийн төлбөр—хүлээн авсан хүү
- Зохицуулах орлогын дүн = Суутганы өмнөх орлого + цэвэр хүүгийн төлбөр + элэгдэл хорогдлын зардал + хүлээн авсан ноогдол ашиг зэрэг ашигт тооцохгүй дүн + зээлийн алдагдлын тусгай зардал
- Харилцан хамааралтай этгээдийн хүүгийн төлбөр : Төлбөр хүлээн авах хамаарал бүхий этгээдийн Японы ААНОТ, орлогын татвар ногдуулах орлогод тооцогдох хэсгийг хасах.

94

Чухал заалт 3

Зардалд тусгахгүй үнийн дүнгийн дотроос урагшлуулсан ба хэтэрсэн хүүгийн дүнг зардалд тусгах нь ТТАХ-ний тухай хууль 66-5-3

Зардалд тусгахгүй үнийн дүнгийн дотроос урагшлуулсан ба хэтэрсэн хүүгийн дүнг зардалд тусгах нь

- Зардалд тусгахгүй үнийн дүнг 7 жилээр урагшлуулж, харилцан хамаарал бүхий этгээдэд хийх төлбөрийн дүн нь зохицуулалттай орлогын 50%-иас ихгүй байх тайлант жилд шилжүүлэн зардал болгон тооцох боломжтой.

95

5 Татварын диваажингийн тогтолцоо (Гадаадын охин компанийг нэгтгэн тооцох татварын тогтолцоо), ТТАХ-ний тухай хууль 66-6①

- Дотоодын ААН-тэй холбоотой гадаадын харилцан хамааралтай ААН-ын дотроос төв компани, эсвэл гол ажлын байр байрладаг улс орон, бүс нутагт орлогод ногдох татварын ачаалал нь Японд ноогдох татварын ачаалалтай харьцуулаад маш бага хэмээн **албан ёсоор тогтоосон гадаадын хамаарал бүхий компани нь (Тухайлсан гадаадын ААН]гэх)**тайлант жилдээ энэхүү журамд хамаарах орлоготой байгаа тохиолдолд, тухайн орлогын дотроос, дотоодын ААН-ын эзэмшиж буй тухайдсан гадаадын охин компанийн хувьцааны тоотой дүйцэх нэхэмжлэлийн эрхийг тооцон тогтоосон үнийн дүнг (**Татвар ногдох үнийн дүн]гэх**) тухайн дотоодын ААН-ын ашиг гэж үзэж, **ашгийн тооцоонд оруулж тооцно.**

96

Агуулга

Тусгай арга хэмжээний тухай хууль 66-6

- Шалгуурт нийцэх гадаадын ААН-ын орлоготой (хамаарах орлогын дүн) холбоотойгоор дотоодын ААН-ын эзэмших хувьтай дүйцэх үнийн дүнг, дотоодын ААН-ын ашиг гэж үзээд орлогын тооцоонд ашиг болгон тусгах тогтолцоо

97

Чухал заалт 1 Шалгуур нөхцөл

ТТАХ-ний тухай хууль 66-6^{①②}, хэрэгжүүлэх аргачилал 39-14^①

- 1) Дотоодын ААН нь татварын диваажинд байрлах гадаадын хамаарал бүхий компанийн хувьцааг 10%-аас илүү эзэмшдэг.
➔ Тухайн гадаад хамаарал бүхий компанийн хуримтлагдсан орлогын дотроос, тухайн эзэмшлийн хувьтай дүйцэх үнийн дүнг, тухайн дотоодын ААН-ын ашигт тооцно.
- 2) Татварын диваажинд байх гадаадын хамаарал бүхий ААН гэдэг нь гаргасан хувьцаа эсвэл хяналтын багц бүхий хувьцааны 50%-аас дээш хувийг оршин суугч ба дотоодын ААН нь шууд ба шууд бусаар эзэмшдэг гадаадын ААН юм.
- 3) Төв компани нь орлогод татвар ногдуулдаггүй улс орон, бүс нутагт байрладаг, эсвэл орлогод ноогдох татварын хэмжээ 20%-аас бага байх.
- 4) Гадаад хамаарал бүхий ААН нь шалгуурт нийцэхгүй, эсвэл нийцэж байсан ч хөрөнгийн хэлбэртэй орлоготой байх.

98

Чухал заалт 2 Шалгуураас хасах жишиг ТТАХ-ний тухай хууль 66-6③

Дараах жишиг үзүүлэлтийг бүрэн хангаж байгаа тохиолдолд шалгуураас хасна.

1. Үйл ажиллагааны жишиг: Хувьцаа эзэмших, эрх олгох ажлыг гол бизнесээ болгоогүй байх
2. Бодит байдлыг жишиг: Төв компанийн байрлах улсад, ажлын байр зэрэг тогтсон байгууламжтай байх.
3. Захирч, удирдах жишиг: Төв компанийн байрлах улсад үйл ажиллагааны менежмент, хяналт, удирдлагыг өөрсдөө хийдэг байх.
4. Дараах аль нэг жишиг үзүүлэлт:
 - Байрлал: Төв компанийн байрлах улсад үйл ажиллагааг голлон эрхэлдэг байх.
 - Хамааралгүй этгээдийн жишиг: Харилцан хамааралгүй этгээдтэй хийх ажил гүйлгээ 50%-аас илүү байх.

99

Чухал заалт 3 Хөрөнгийн шинжтэй орлогыг нэгтгэн татвар ногдуулах ТТАХ-ний тухай хууль 66-6④

- Шалгуураас хасах жишгийг хангаж байсан ч, хөрөнгийн шинжтэй орлогын нэгтгэн татвар ногдуулалтын шалгуураас хасагдаагүй л бол дараах орлого (хөрөнгийн орлого) эзэмшлийн хувьд дүйцүүлж, нэгтгэн татвар ногдуулна.
 1. Хувьцааны эзэмшлийн хувийн 10% хүрэхгүй хувьцааны ноогдол ашиг, хувьцаа шилжүүлэхтэй холбоотой орлого
 2. Бондын хүү, буцаан авах зөрүүний ашиг, үнэт цаас шилжүүлэх орлого
 3. Патент, зохиогчийн эрхээр олох орлого
 4. Усан онгоц, нисэх онгоцын түрээсийн орлого

100

6 ААН-ын урвуу татварын тогтолцоо ТТАХ-ний тухай хууль 66-9-2

Онцгой хамаарал бүхий хувьцаа эзэмшигч болох дотоодын ААН-тэй холбоотой тухайлсан гадаадын ААН-ын орлогын татвар ногдуулалтын жишээ

- (Онцгой хамаарал бүхий хувьцаа эзэмшигч болох дотоодын ААН-тэй холбоотой тухайлсан гадаадын ААН-ын татвар ногдуулах орлогын ашгийг тооцох)
- **66-9-2 заалт** Онцгой харилцаатай хувьцаа эзэмшигч нь онцгой харилцаатай дотоодын ААН-ын гаргасан хувьцаа ба санхүүжилтыг бүгдийг, эсхүл нийт үнийн дүнгийн 80%-аас их тоо ширхэг, эсхүл үнийн дүнтэй хувьцааг шууд бусаар эзэмших хуулийн харилцаатай байх,
- Тухайн онцгой харилцаа бүхий хувьцаа эзэмшигч ба дотоодын ААН-ын дунд, тэдгээрийн гаргасан хувьцааны эзэмшилтэй холбоотойгоор хуульд заасан дундын компани байдлаар орших гадаадын ААН-ын (Гадаад харилцаатай ААН) дотроос, төв компани, эсхүл гол ажлын байр байрлах улс орон, бүс нутагт олсон орлогод ноогдох татварын ачаалал нь өөрийн улсдаа ААН-ын орлогод ноогдох татварын ачаалалтай харьцуулаад маш бага хэмээн хуулиар тогтоосон гадаадын ААН мөн бөгөөд энэхүү тогтолцоонд хамаарах орлоготой байх,
- Энэхүү хамаарах орлогын дүнгийн дотроос, тухайн онцгой хувьцаа эзэмшигч болох дотоодын ААН-ын шууд ба шууд бусаар эзэмших хувьцааны тоонд нийцэх тухайн хувьцааны нэхэмжлэлийн эрхийн (ашгийн ноогдол, хөрөнгийн хуваарилалт, эдийн засгийн ашгийн хуваарилалтын нэхэмжлэлийн эрхийг хэлнэ.) агуулгыг тусган хуулийн хүрээнд тооцсон үнийн дүнг, тухайн онцгой харилцаа бүхий дотоодын ААН-ын орлого гэж үзээд ашгийн тооцоонд нэмж тусгана.

101

Агуулга

Тусгай арга хэмжээний тухай хууль 66-9-5

- Дотоодын ААН-ын хувьцаа эзэмшигч нь бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн дараа, татварын ачаалал багатай улсад (20% хүртэл хувь) байх гадаадын ААН-ээр (Төв компани) дамжуулан, тухайн дотоодын ААН-ын хувьцааны 80%-аас дээш хувийг шууд бусаар эзэмших
- Тухайн гадаадын ААН нь тайлант хугацаанд хамаарах орлогын дотроос, хувьцаа эзэмшигч оршин суугч ба дотоодын ААН-ын эзэмшлийн хувь хэмжээнд дүйцүүлэн тооцсон үнийн дүнг тухайн этгээдийн орлогод нэмж татвар ногдуулах
- Өөрөөр хэлбэл, энэхүү тогтолцоо нь бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр, дотоодын ААН-ын хувьцаа эзэмшигч ба дотоодын ААН-ын хооронд гадаадын ААН-ыг хавчуулснаар дотоодын ААН-ын хувьцаа эзэмшигч нь гадаадын ААН-ээр дамжуулан тухайн дотоодын ААН-ыг шууд бусаар эзэмших.

102

Чухал заалт Татвар төлөгч ТТАХ-ний тухай хууль 6-9-2①, хэрэгжүүлэх аргачилал 39- 20-2①②③

- Энэхүү татварын тогтолцоонд хамаарах дотоодын ААН нь «Онцгой хамаарал бүхий хувьцаа эзэмшигч болох дотоодын ААН»
- «Онцгой хамаарал бүхий хувьцаа эзэмшигч болох дотоодын ААН» гэдэг нь «Онцгой хувьцаа эзэмшигч»-д дүйцэх этгээд, эсвэл эдгээр этгээдтэй онцгой хамаарал бүхий иргэн ба ААН-ийг хэлнэ.

103

7 Гадаадын татварыг хасалт хийхтэй холбоотой үндсэн зүйл, заалт(ААНОТ 69-р зүйл, хэрэгжүүлэх аргачилал 141-150-р зүйл)

ААНОТ-ын тухай хуулийн 69-р зүйл

Дотоодын ААН нь үйл ажиллагааны тайдант хугацаандаа гадаад улсад ААНОТ төлөхөөр бол, тухайн тайлант хугацааны орлогын дүнгийн тухайд, хуулийн 66-1-ээс 3 заалтад (тухайн тайлант хугацааны орлогод ногдох ААНОТ-ын хувь хэмжээ) нийцүүлэн тооцсон үнийн дүнгээс гадаад улсад олсон орлого хэмээн хуулиар заасан үнийн дүнгээр («хасалт хийх хязгаар») хязгаарлан, энэхүү татвары дүнг («хасалт хамаарах гадаад улсын ААНОТ-ын дүнг») тухайн тайлант хугацааны орлогод хамаарах ААНОТ-ын дүнгээс хасаж тооцно.

104

Гадаадын татварыг хасах ААНОТ-ын хууль 69-р зүйл, хэрэгжүүлэх аргачилал 141-150

Гадаад улсын ААН-ын татвар гэдэг нь

⇒Гадаад улсын хууль тогтоомжийн дагуу, гадаад улс, эсвэл орон нутгийн эрх бүхий байгууллагаас ААН-ын орлогыг татвар ногдуулах жишиг болгон ногдуулах татварыг хэлнэ.

105

Чухал заалт 1 Хасалтын хязгаарыг тооцох арга (ААНОТХ 69, хэрэгжүүлэх аргачилал 141-150)

Гадаадад төлсөн татварын хасалт хийх хязгаар

Дараах А ба Б-ийн аль бага үнийн дүн

А Тухайн тайлант жилд төлсөн хасалтад хамаарах гадаад улсын ААН-ын орлогын татвар

В Дараах аргаар тооцсон үнийн дүн:

Тайлант хугацааны дэлхий даяарх орлогод × тайлант хугацааны гадаад орлого(*)
ногдуулсан ААНТ

(*)Гадаад орлогын дүн гэдэг нь дэлхий даяар олсон орлогын дотроос дотоод эх үүсвэртэй орлогоос бусад орлогыг зааж байна.

106

Чухал заалт 2

Хасалтад хүрэлцэхгүй үнийн дүн ба илүүдэл үнийн дүнг урагшлуулан шилжүүлэх ААНОТ хэрэгжүүлэх аргачилал 142-2⑦-3, ААНОТ23-2②-1

Хасалтад хүрэлцэхгүй үнийн дүн ба илүүдэл үнийн дүнг урагшлуулан шилжүүлэх

- Хасалтад хамаарах гадаадын ААНОТ $>$ хасалтын хязгаар \Rightarrow хүрэлцэхгүй үнийн дүнг 3 жилээр урагшлуулан хасалт хийх боломжтой
- Хасалтад хамаарах гадаадын ААНОТ $<$ хасалтын хязгаар \Rightarrow илүүдэл үнийн дүнг 3 жилийн турш урагшлуулан ашиглах боломжтой

107

8 Гадаадын охин компаниас авсан ноогдол ашгийн үндсэн зүйл заалт ААНОТ 23-2① хэрэгжүүлэх аргачилал 22-4①②

- Дотоодын ААН нь гадаадын охин компаниас авсан илүүдэл мөнгөний ноогдол ашиг байгаа бол тухайн ноогдол ашгаас, энэхүү ноогдол ашигтай холбоотой хуулиар зөвшөөрсөн зардлыг хассан үнийн дүнг, дотоодын ААН-ын ашигт тусган тооцохгүй.

108

Гол санаа

ААНОТ хууль 23-2①, хэрэгжүүлэх аргачилал 22-4①②

- Олон улсын хүрээнд давхар татвар ногдуулалтыг халах
- Гадаадаас санхүүгийн буцах урсгалыг дэмжих
- Үүний тулд дотоодын ААН-ын гадаадын охин компаниас авах ноогдол ашгийг татвараас чөлөөлөх тогтолцоо

109

Чухал заалт 1 (ААНОТХ 23-2)

- Дотоодын ААН нь гадаадын охин компаниас (25%-аас илүү хувьцаа эзэмших (*)) авсан ноогдол ашгийн 95%-тай дүйцэх үнийн дүнг ашигт тооцохгүй.

(*) Татварын гэрээний давхар татвар ногдуулалтыг халах заалт байгаа тохиолдолд, тухайн татварын гэрээнд заасан харьцаагаар шийднэ. (хэрэгжүүлэх аргачилал 22-4 ②) жишээлбэл, АНУ, Австрали, Бразилд 10%-аас дээш, Франц 15%-аас дээш.

110

Чухал заалт 2

Шалгуураас хасах (ААНОТХ23-2②)

Шалгуураас хасах

- ① Нийт ноогдол ашиг, эсвэл ноогдол ашгийн нэг хэсэг нь гадаадын охин компанийн байрлалтай холбоотойгоор орлогын тооцоонд зардалд тусгагдах зүйл байх.
жиш) Австралийн давуу эрхтэй ноогдол ашиг, Бразилийн ноогдол ашиг
- ② Өөрийн хувьцаа болгох зорилгоор авсан хувьцаатай холбоотой таамаглаж буй ноогдол ашиг

111

Чухал заалт 3 Үргэлжлэл

(ААНОТХ 23-2⑤, 39-2, 69)

- Ашигт тусган тооцох тогтолцоог ашиглахын тулд, татварын тайланд нарийвчилсан бичилт хийх, шаардлагатай баримт материалыг хадгалах шаардлага тавигддаг.

112

Чухал заалт 4
Ноогдол ашигтай холбоотой гадаадын суутган
татварыг ашигт тусгахгүй байх.
(ААНОТ хууль хэрэгжүүлэх аргачилал 142-2⑦-3)

- Ноогдол ашигтай холбоотой гадаадын суутган татварыг ашигт тусгахгүй байх.
- Ашигт тусгахгүй байх тогтолцоонд хамрагдах тохиолдолд, энэхүү ноогдол ашигтай холбоотой гадаадын суутган татварын дүнг зардалд тусгах боломжгүй бөгөөд гадаад улсад төлсөн татварыг хасалт хийх тогтолцоонд хамрагдахгүй.

113

9 Гадаад харилцан хамааралтай этгээдэд өгсөн хандивт
ногдуулах татвар
Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4-③

- ААН нь тайлант хугацаанд зарцуулсан хандивын дүнгийн дотроос, тухайн ААН-тэй харилцан хамаарал бүхий гадаадын ААН-д өгсөн хандивын дүнг тухайн тайлант жилийн орлогын тооцоонд зардал болгон тусгахыг зөвшөөрөхгүй.

114

Чухал заалт 1

Гадаад харилцан хамаарал бүхий этгээдийн хамрах хүрээ ТТАХ-ний тухай хууль 66-4^①, хэрэгжүүлэх аргачилал 39-12 ①-④

- Энэхүү хандивт татвар ногдуулахтай холбоотой гадаадын харилцан хамаарал бүхий этгээд гэдэг нь үнэ шилжилтийн татвар ногдуулалтын хүрээнд тодорхойлогдох гадаад харилцан хамаарал бүхий этгээдтэй нэг утгатай бөгөөд дотоодын ААН-тэй 50%-аас илүү хөрөнгийн хамаарал бүхий гадаад компани болон бодит хяналт, удирдлагын харилцаа бүхий гадаадын ААН-ыг оруулан ойлгоно.

115

Чухал заалт 2

Үнэ шилжилтийн татварын тогтолцоо ба хандивт татвар ногдуулалтад хамруулах ангилалыг тодорхойлох, ТР үйл ажиллагаанд баримтлах чиглэл

- Гадаад харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний тухайд, бэлэн мөнгө болон бусад хөрөнгө, эсхүл эдийн засгийн ашгийг бэлэглэх, буцалтгүйгээр шилжүүлсэн тохиолдолд, тухайн үнийн дүнгийн хувьд хандивын татвар ногдуулалтад хамруулж үзнэ.
- Гэхдээ, татварын хяналт шалгалтаар хандивын татвар ногдуулалт хийхүү эсвэл үнэ шилжилтийн татвар ногдуулалт уу гэдэг шийдвэр гаргахад хүндрэлтэй байдаг тул зардлын ачаалал ба хүүгүй зээл олгох зэрэг санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой нь тодорхой байгаа зүйлсийн хувьд, хандивын татвар ногдуулалт хийнэ.
- Энэ тохиолдолд, татварын гэрээний хүрээний харилцан тохиролцоо хийхгүй.

116

Чухал заалт
ААНОТ-ын хууль дахь хандивын татвар ногдуулалт
ААНОТ-ын хуулийн 37

- Хандивын энгийн татвар ногдуулалт
- $(A + B) \times \frac{1}{4} = \text{Зардалд тусгах хязгаар}$

A: $\frac{\text{Тайлант хугацааны эцсийн хөрөнгө} \times \text{Тухайн тайлант хугацааны сарын тоо}}{12} \times 0.25\%$

B: $\text{Хандивын зардлын өмнөх орлогын дүн} \times 2.5\%$

117

10 Гадаад валютаар хийсэн ажил гүйлгээг шилжүүлэн тооцох
ААНОТ хуулийн 61-8①

- (Гадаад валютаар хийсэн ажил гүйлгээг шилжүүлэн тооцох)
- **61-8** Дотоодын ААН нь гадаад валютаар ажил гүйлгээ хийсэн тохиолдолд, тухайн ажил гүйлгээний иенд шилжүүлсэн үнийн дүн (гадаад валютаар илэрхийлсэн үнийн дүнг дотоодын валютад шилжүүлсэн үнийн дүнг хэлнэ.) нь тухайн ажил гүйлгээг хийсэн үеийн гадаад валютын зах зээлийн ханшаар шилжүүлсэн дүн гэж үзнэ.

118

Чухал заалт 1

Иенд шилжүүлэх арга: үүссэн үед нь шилжүүлэх ААНОТ 61-8, 61-9, хэрэгжүүлэх аргачилал 13-2-1-2, орлогын албан татварын хууль 57-3

- Зарчим Цахим худалдааны зах зээлийн дундаж утга (ТТМ)
- Жишиг бус (тасралтгүй ашиглах нөхцөлтэйгээр)
 - Ашиг орлого...хөрөнгө.....цахим худалдааны зах зээл (ТТВ)
 - Зардал, өр төлбөр.....цахим худалдааны зах зээл(ТТС)

119

Чухал заалт 2

Тайлант хугацааны эцэст шилжүүлэх арга (гадаад валютын хөрөнгө) ААНОТ-ын хууль 61-9, хэрэгжүүлэх аргачилал 122-4,7

- ① Гадаад валютаарх авлага, өглөг....үүссэн үед нь шилжүүлэх арга, эсвэл тайлант хугацааны эцэст шилжүүлэх арга
- ② Гадаад валютаарх үнэт цаас
 - 1) Худалдаж, худалдан авах зорилготой үнэт цаас....тайлант хугацааны эцэст шилжүүлэх арга
 - 2) Эргүүлэн татах үнэт цаас..... үүссэн үед нь шилжүүлэх арга, эсвэл тайлант хугацааны эцэст шилжүүлэх арга
 - 3) Бусад үнэт цаас..... үүссэн үед нь шилжүүлэх арга
- ③ Гадаад валютаарх хадгаламж..... үүссэн үед нь шилжүүлэх арга, эсвэл тайлант хугацааны эцэст шилжүүлэх арга
- ④ Гадаад валют..... тайлант хугацааны эцэст шилжүүлэх арга

120

11 Оршин суугч бус этгээд ба гадаадын ААН-ын суутган татвар ногдуулалт

Орлогын татварын хууль 212① 213①

- Дотоодын ААН нь оршин суугч бус этгээд эсвэл гадаадын ААН-д дотоод эх үүсвэртэй орлогыг дотоодод төлөхдөө, энэхүү орлогод ноогдох суутган татварыг суутган тушаах шаардлагатай.

121

12 ОУ-ын хэрэглээний татварын үндсэн зүйл заалт

Хэрэглээний татварын хууль 2-①-8, дагалдах журам 42

- Урвуу төлбөрийн арга: Гадаадаас үйлчилгээ авах тохиолдолд, гадаадын үйлчилгээ үзүүлэгч ААН-ыг татвараас чөлөөлж, худалдан авагч тал болох дотоодын ААН нь хэрэглээний татвар (VAT) төлөх үүрэг хүлээнэ.
- Энгийн үед, үйлчилгээ үзүүлэгч тал татвар төлөх үүрэг хүлээх боловч, худалдан авагч тал нь татвар төлөх үүрэг хүлээх хэлбэртэй болох тул энэхүү нэршлээр урвуу төлбөрийн арга гэж нэрлэдэг.
- Гэхдээ, худалдан авагч тал нь худалдан авалтын татварын хасалтыг эдлэх боломжтой.

122

★ Урвуу төлбөрийн аргын тухай

- 2008 оны ЕС тушаал: Европт 2015 оны 1 сараас хойш, цахим худалдаа, цахилгаан холбоо, нэвтрүүлгийн үйлчилгээнд ногдуулах VAT-ийн тухайд, цацагч ба хүлээн авагчийн байршлаас үл хамааран, хүлээн авагчийн байршил дээр татвар ногдуулахаар болсон.
- 2015 оны татварын шинэчилэлтээр, гадаадын ААН-ын үзүүлэх цахим эдийн засагтай холбоотой үйлчилгээний тухайд, энэ нь «бизнес эрхлэгчдэд зориулсан ажил гүйлгээ» ба «хэрэглэгчдэд зориулсан ажил үйлчилгээ»-ний аль нь болохоос хамаарч, «урвуу төлбөрийн арга» ба «гадаадад бизнес эрхлэгчийн тайлангийн арга»-ыг тус тус хэрэглэн, татвар төлөх үүргийг оногдуулахаар өөрчилсөн.

123

9. GAAR

(Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм)

124

Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм (GAAR)

- GAAR (General Anti-Avoidance Rules)-ийн онцлог
- Дотоодын хуулиар зохицуулах, татвар ногдуулах байгууллагын хувьд татвараас зайлсхийхийн эсрэг хууль тогтоомж.
- Зөвхөн татварын хувьд давуу байдал эдлэхийг зорилгоо болгосон ажил гүйлгээний тухайд татварын байгууллагыг энэхүү давуу эрхийг түдгэлзүүлэх боломжоор хангах заалт. Татвар ногдуулалтын хамрах хүрээ өргөн бөгөөд орлогын татвар, ААНОТ, өв залгамжлалын татвараас гадна бусад татварын төрөлд хэрэглэдэг ерөнхий зарчим.
- GAAR-ийг дэлхийн 24 улсад нэвтрүүлсэн бөгөөд G20-ийн дотор GAAR-гүй улс нь Япон, БНСУ, Индонези, Саудын Араб, Мексик, Аргентин, Орос, Турк гэсэн 8 улс байдаг.

125

★GAAR 2 Япон улсын GAAR

Түдгэлзүүлэх заалт

- Хэт өндөр хүүгийн татварын тогтолцоо, Нимгэн капиталын татварын тогтолцоо, LOB (Тусгайлан хязгаарласан заалт)

Япон улсын GAAR

- ААНОТ-ын ачааллыг зохисгүйгээр багасгах “үр дүн” –д хүргэсэн ~~бөжөөн~~ хуулийн этгээдийн “үйлдэл” эсвэл “тооцоолол”-ыг түдгэлзүүлж, энгийн үйлдэл, тооцоололд шилжүүлэн засч татвар ногдуулах тухай “Үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх хязгаарлалт хийх заалт” байдаг.
- Гэр бүлийн компанийн хооронд хийсэн үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт (Дайны өмнөх үеэс)
- Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотой хийсэн хооронд хийсэн үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт (2001 он)
- Татварын нэгтгэсэн тайлан гаргах үед толгой болон охин компани хоорондын тооцооллын үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт (2002 он)
- Компания дараа үедээ залгамжлуулахтай холбогдуулан хийсэн үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт (2009 он)

126

★GAAR-ийн үндэслэл болох хууль

- Америк хэлбэр**
- IRC 7701-р зүйл(о). Эдийн засгийн агуулгын зарчим (Economic Substance Doctrine : ESD)
- Герман хэлбэр**
- Татварын ерөнхий хуулийн 42-р зүйл (Татвараас зайлсхийхийг түдгэлзүүлэх заалт)
- Англи хэлбэр**
- 2013 оны Санхүү, төсвийн хуулийн 207-р зүйл (Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээ, урвуулан ашиглахыг тодорхойлох)
- Бельги хэлбэр**
- GAAR арга (Хувийн эрх зүй дэх Sham transaction)
- Франц хэлбэр**
- Татварын процессийн хуулийн 64-р зүйл (Хувийн эрх зүй дэх эрх урвуулан ашиглах)
- Хятад хэлбэр**
- ААН-ын орлогын татварын хууль 47-р зүйл (Эдийн засгийн агуулгын зарчим ба эдийн засгийн хувьд зохистой байх бизнесийн зорилго)

127

★Америк улсын GAAR: IRC 7701 зүйлийн (о). 2010 оны хууль

- ESD (Economic Substance Doctrine): Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм болох GAAR-ийг шинээр гаргаж ирсэн бус Нийтлэг эрх зүйн үзэл дээр үндэслэсэн.
- ESD-ийн нөхцөл болон тодорхойлолт
 - ① Тухайн ажил гүйлгээ нь *дотоодын орлогын татвараас гадна бодит талаас татвар төлөх үүрэгтэй этгээдийн* эдийн засгийн нөхцөл байдлыг өөрчилж байх (объектив нөхцөл)
 - ② Татвар төлөх үүрэгтэй этгээд нь тухайн ажил *гүйлгээний хувьд дотоодын орлогын татвараас өөр* бодит зорилготой байх (Субъектив нөхцөл)

128

★ Англи улсын GAAR(2013 оны GAAR-ийн заалт: Урвуулан ашиглахаас сэргийлэх онцгой арга хэмжээний заалт ➔ Татвараас зайлсхийхээс сэргийлсэн заалт биш!)

Нотлох хариуцлага: Татварын байгууллага

Татгалзах нөхцөл: Урвуулан ашиглахыг (Abusive) тодорхойлох шалгуур (←avoidance (зайлсхийх) биш)

- ① Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээний бодит үр дүн нь татварын хуулийн үзэл баримтлалын зарчимтай нийцэж байгаа эсэх?
- ② Энэхүү үр дүнд хүрэх процесс нь тодорхой эсвэл хэвийн бус шат дамжлагыг багтаадаг эсэх?
- ③ Зохион байгуулалттай ажил гүйлгээ нь татварын хуулийн цоорхойг хайн ашигласан эсэх?

GAAR-т хамруулах тодорхойлолтын шалгуур: Давхар сорил

- ① Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээ нь зохистой үйл ажиллагаа мөн эсэх?
- ② Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээний талаар зохистой шийдвэр гаргах боломжтой эсэх?

129

★ Ерөнхий хуулийн татвараас зайлсхийхийн эсрэг зарчим (Англо- Америк хандлага)


- ① business purpose (үйл ажиллагааны зорилго)
- ② step transaction (шаталсан ажил гүйлгээ)
- ③ substance over form (бодит байдлын зарчим)
- ④ sham transaction (зохиомол ажил гүйлгээ)
- ⑤ economic substance (эдийн засгийн бодит байдал)

130

Кейс -1

1. Нидерланд улсын А компанийн 100% охин компани болох Б нь МУ-д ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшдэг.
2. А компани охин компани болох Б компаниа Нидерланд улсын С компанид 10.0 сая доллараар худалдсан.


3.



4. Энэ ажил гүйлгээнээс МУ-д татвар төлөөгүй. С компани Б компанийн тусгай зөвшөөрлийг худалдаж авахыг хүссэн.
5. Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7-д эрх борлуулсны орлогод 30 хувиар татвар ногдуулна. Давхар татварын гэрээ байхгүй, цуцлагдсан.
6. Татвар ногдуулаагүй. Мэдээлэл солилцох хангалттай мэдээллийн бааз байхгүй. Татварын хуулинд зохицуулалт оруулж өгөх (ямар зохицуулалт байх тухай санал)

Кейс -2


1. Монгол улсын Х компанийн хөрөнгө оруулалттай Англи улсын А компани болон Монгол улсын Х компанийн хөрөнгө оруулалттай Монгол улсын М компани хооронд гарсан ажил гүйлгээ.
2. А компани М компаниас 1 тонн нүүрсийг \$25 худалдаж авдаг. М компани дотоодын бусад компаниудад 1 тонн нүүрсийг \$27.5 худалдан борлуулдаг.



4. Харилцан хамааралтай этгээдүүдийн хооронд зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулсан.
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1. Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан этгээдүүд хоорондоо зах зээлийнхээс хямд буюу өндөр үнээр бараа борлуулсан буюу шилжүүлсэн, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бол татварын алба нь харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын зах зээлийн үнийг жишиг болгон албан татвар ногдох орлогыг тодорхойлно.
11.2. Энэ хуулийн 7.5, 11.1-д заасан жишиг үнэ хэрэглэх аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
6. \$2.5-г татвар ногдуулаагүй. Учир нь А компанийг Х компанийн харилцан хамааралтай гэдгийг нотлох баримт байхгүй байсан.
7. Олон улсын татварын ногдуулалтанд ашиглах мэдээллийн баазтай болох (Мэдээллийн бааз хэрхэн бий болгох саналаа өгөх)

Кейс -3


1. Монгол улсын А компани, худалдааны зуучлалын Б компани, БНХАУ-ын Х болон У компани
2. БНХАУ-ын Х компани А уул уурхайн компанид хөрс хуулах ажил гүйцэтгэдэг. Хөрс хуулах ажлын хөлсөнд нүүрс бартераар авах гэрээ хийсэн. 1 тонн нүүрс \$20. Х компани нүүрсээ худалдааны зуучлалын Б компаниар зуучлуулан БНХАУ-ын У компанид 1 тонныг \$30 борлуулдаг.



4. А компани АМНАТ болон НӨАТ-ыг Х компанийн орлогоос суутган авч төсөвт төлсөн байсан. Зуучлалын Б компанийн Х компанид шилжүүлсэн орлогоос татвар суутгагдсан орлого гэж үзэн татвар ногдуулаагүй. ААНОАТ ногдуулаагүй.
5. ААНОАТ 5.4.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид дараахь аж ахуйн нэгж хамаарна: 5.4.1.төлөөний газраараа дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж;
 17.2.9.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон дараахь орлогод 20 хувиар;
 Татварыг давхардуулж оногдуулахгүй байх татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1991-8-26-ны өдрийн гэрээний 5 дугаар зүйлийн 3 заалт:
 “Төлөөлөгчийн газар гэж 18 сараас илүү хугацаагаар үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт, суурилуулалтын ажил болон эдгээртэй холбогдсон удирдлага, хяналтын үйл ажиллагаа”
6. Худалдааны зуучлагч Б компанийг Х компанийн төлөөний газар гэж үзэж ААНОАТ ногдуулах байсан. Мөн зуучлагчийн шилжүүлсэн орлогоос НӨАТ болон ААНОАТ суутгахаар байна.
7. Олон улсын татвартай холбоотой заалтуудыг нарийвчлан судлах, хуулинд оруулах шаардлагатай (ямар заалт оруулах тухай саналаа өгөх)

Кейс -4

1. БНХАУ-ын “Х” ХХК, Монгол улсын А компани хооронд гарсан ажил гүйлгээ.
2. Барилга угсралтын гэрээтэй ба ажил гүйцэтгэх гэрээний нийт дүн 800.0 сая төгрөг
3. Монгол улс БНХАУ



4. Барилга угсралтын ажлын хөлсийг гэрээ байгуулагч талд бус уг компанийн толгой компани руу татвар авахгүйгээр шилжүүлсэн. Гадаадад шилжүүлсэн орлогоос татвар суутгаагүй.
5. Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17-р зүйлийн 17.2.8-д “гадаадын аж ахуйн нэгжийн төлөөний газар өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсэн ашгийн 20 хувиар;”

Татварыг давхардуулж оногдуулахгүй байх татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1991-8-26-ны өдрийн гэрээний 5 дугаар зүйлийн 3-т “Төлөөлөгчийн газар: гэж 18 сараас илүү хугацаагаар үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт, суурилуулалтын ажил болон эдгээртэй холбогдсон удирдлага, хяналтын үйл ажиллагаа”


6.

Taxes	Taxes that could have been imposed (MNT)	Taxes imposed	Difference (MNT)
CIT	$800\,000\,000 \times 10\% = 80\,000\,000$	0	80 000 000
VAT	$800\,000\,000 \times 10\% = 80\,000\,000$	0	80 000 000
Total	160 000 000	0	160 000 000

7. Татварын ерөнхий хуулинд олон улсын татвартай холбоотой заалтуудыг нарийвчлан оруулах.

Кейс -5

1. БНХАУ-ын “Х” ХХК болон Монгол улсын А компани хооронд гарсан ажил гүйлгээ
2. Цахилгаан станц барих гэрээтэй ба гэрээний дүн 500.0 сая төгрөг
- 3.



4. Ажлын хөлсийг татвар ногдуулахгүйгээр шилжүүлсэн. Гадаадад шилжүүлсэн орлогоос татвар суутгагүй.
5. Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17-р зүйлийн 17.2.8-д “гадаадын аж ахуйн нэгжийн төлөөний газар өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсэн ашгийн 20 хувиар;”

Татварыг давхардуулж оногдуулахгүй байх татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1991-8-26-ны өдрийн гэрээний 5 дугаар зүйлийн 3-т “Төлөөлөгчийн газар: гэж 18 сараас илүү хугацаагаар үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт, суурилуулалтын ажил болон эдгээртэй холбогдсон удирдлага, хяналтын үйл ажиллагаа”


6.

Taxes	Taxes that could have been imposed (MNT)	Taxes imposed	Difference (MNT)
CIT	$500\,000\,000 \times 10\% = 50\,000\,000$	0	50 000 000
VAT	$500\,000\,000 \times 10\% = 50\,000\,000$	0	50 000 000
Total	100 000 000	0	100 000 000

7. Татварын ерөнхий хуулинд олон улсын татвартай холбоотой заалтуудыг нарийвчлан оруулах.

Кейс-6

1. БНСУ-ын “Х” ХХК ба Монгол улсын Б компани хооронд гарсан ажил гүйлгээ
2. Өргөн дэлгэцээр уран сайхны кино нэвтрүүлэх эрхийг БНСУ-ын Х ХХК-аас 100.0 сая төгрөгөөр авсан.
3. Монгол улс



4. Роялти буюу 100.0 сая төгрөгийг Монгол улсад суутгахгүйгээр БНСУ-д ногдуулахаар шилжүүлсэн. Зөрчил гараагүй боловч Монгол улсад татвар ногдуулж болно.
5. Орлогын татварыг давхар ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийхийг сэргийлэх тухай Монгол улс, БНСУ-ын хоорондын 1992.04.17-ны өдрийн хэлэлцээрийн:
 - 12.1 “Хэлэлцэн тохирогч нэг улсад бий болж байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байнга оршин суугчид төлөгдсөн шанд Хэлэлцэн тохирогч нөгөө улс татвар ногдуулна.”
 - 12.2 “Гэхдээ Хэлэлцэн тохирогч улсад бий болж байгаа шанд тухайн улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч уг шанг авагч нь түүний жинхэнэ эзэмшигч нь бол ийнхүү ногдуулж байгаа татвар нь шангийн нийт хэмжээний 10 хувиас хэтрэхгүй байна.”
 - 12.3 “Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй шан гэсэн нэр томъёонд уран зохиолын хэвлэн нийтлэх эрх, урлагийн болон шинжлэх ухааны бүтээл, түүний дотор уран сайхны кино, бусад кино, радио болон телевизийн нэвтрүүлэгт зориулсан бичлэг...мэдээллийг ашиглах буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөрийг хамруулна.”


6. Монгол улсад суутган татвар ногдуулж, БНСУ-д хасалт хийлгэж болно.

Татварын төрөл	Ногдуулах байсан татвар	Ногдуулсан татвар	Зөрүү
ААНОАТ	$100\,000\,000 * 10\% = 10\,000\,000$	0	10 000 000
НӨАТ	$100\,000\,000 * 10\% = 10\,000\,000$	0	10 000 000
Нийт	20 000 000	0	20 000 000

7. Татварын ерөнхий хуулинд олон улсын татвартай холбоотой заалтуудыг нарийвчлан оруулах

Кейс № 7

1. Монгол улсын “Z” компани нь Сингапур улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй “X” компанийн охин компани. Коксжих нүүрс олборлож, борлуулдаг. Сингапур улс дахь толгой компани “X” нь БНХАУ-ын Өвөр Монголд “Y” гэсэн охин компанийг байгуулсан. “Z” компанийн Монгол улсад олборлосон нүүрснээс БНХАУ-ын “Y” компани худалдаж авдаг бөгөөд цаашаа дамжуулан борлуулдаг.
2. “Z” компани нь 1 тонн ижил ангилалын нүүрсийг БНХАУ-ын “Y” компанид 120 юань, бусад компанид 135 юаниар худалдаж борлуулдаг. Гэрээний нөхцөл ижил.
- 3.




4. Харилцан хамаарал бүхий этгээдэд зах зээлийн үнээс хэт хямд үнээр нүүрс борлуулсан.(2016 он)
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1” Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан этгээдүүд хоорондоо зах зээлийнхээс хямд буюу өндөр үнээр бараа борлуулсан буюу шилжүүлсэн, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бол татварын алба нь харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын зах зээлийн үнийг жишиг болгон албан татвар ногдох орлогыг тодорхойлно.” Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6.1.Албан татвар төлөгчтэй дор дурдсан харилцаатай бол “харилцан хамаарал бүхий этгээд” гэж үзнэ: 6.1.1.энгийн хувьцааных нь 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг;
6. Татварын Ерөнхий хуулийн 74 дүгээр зүйл 74.1-д заасан “Дараахь үйлдэл, эс үйлдэхүйгээр татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар

төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна гэсний дагуу 305.0 сая төгрөгийн төлбөр ногдуулсан.

Кейс 8


1. Монгол улсын “Z” компани нь Сингапур улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй “X” компанийн охин компани. Коксжих нүүрс олборлож, борлуулдаг. “Z” компанийн Монгол дахь нүүрсний уурхайн үндсэн хөрөнгө нь Канад улсын даатгалын “W” компанид даатгалтай.
2. “Z” компанийн нэг жилийн даатгалын төлбөр болох 2.3 тэрбум төгрөгийг Сингапур дахь толгой компани болох “X” өмнөөс нь төлж, охин компанид өглөг үүсгэдэг.
- 3.



4. Хөрөнгийн даатгалын төлбөрийг Канад улсын “W” Co.Ltd даатгалын компанид Сингапур улсын толгой компани төлсөнийг Монгол улс дахь “Z” компани өглөгөө 2.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, зардалд тооцсон боловч Монгол Улсаас эх үүсвэртэй даатгалын орлогод татвар суутган, төсөвт төлөөгүй.
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 4 дүгээр зүйлийн 4.1.6 “суутгагч” гэж албан татвар төлөгчид олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг;”, 17 дугаар зүйлийн 17.2.9 “Монгол улсад байрладаггүй албан татвар төлөгч Монгол Улсад олсон дараах орлогод 20 хувиар:
6. “Монгол Улсаас эх үүсвэртэйгээр шууд болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлого” гэж заасны дагуу 340.0 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьсан.

Кейс 9

1. Монгол улсын “Z” компани нь Сингапур улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Х” компанийн охин компани. Коксжих нүүрс олборлож, борлуулдаг.
2. Сингапур улс дахь толгой компани “Х” нь 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг охин компанидаа үзүүлсэн. Бодит байдалд Сингапур улс дахь толгой компани нь Монгол улс дахь уурхайн төслөөр дамжуулж Торонтогийн хөрөнгийн бирж дээрээс хөрөнгө татсан.
- 3.




4. Толгой компаниас авсан хөрөнгө оруулалт нь харилцан хамаарал бүхий хуулийн этгээд хооронд үнэ төлбөргүй хийгдсэн үйлчилгээ ба Олон улсын санхүүгийн зах зээлийн дундаж хүүгийн тооцооллоор Нимгэн капиталжуулалтын зохицуулалт хийсэн гэж үзэж байна. Албан татвар ногдуулалт төлөлтийн тайланд тусгаагүй, татвар суутган төлөөгүй,
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 14дүгээр зүйл “Албан татвар ногдох орлогоос хасч тооцох зардалд хамрах зээлийн хүү”, 14.3. “Хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид олгосон зээлийн дүн өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс гурав дахинаас илүү гарсан бол ийнхүү илүү гарсан зээлд төлсөн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасч тооцохгүй
6. ... түүнийг тухайн хөрөнгө оруулагчийн ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна” заалтын дагуу тухайн оны алдагдлыг 5 тэрбум төгрөгөөр бууруулсан.

Кейс 10

1. “С” компани нь МУ-д үйл ажиллагаа явуулж буй Томоохон нүүрсний төслийн үндсэн /Хөрс хуулалт, олборлолтын мэргэжлийн түвшинд/ гүйцэтгэгч компани бөгөөд Австрали улсын “А” компаний охин компани юм. “С” компани нь МУ-д үүсгэн байгуулагдахдаа Сингапур улсын хуулийн дагуу байгуулагдсан “В” компаний охин компани гэж байгуулагдсан. Сингапур улсын хуулийн этгээд “В” компани нь Австрали улсын “А” компаний охин компани юм. В, С хоёр хоёулаа А-ын охин компани гэсэн үг.
2. Австрали Улсын “А” компани уул уурхайн салбарт маш том байр суурь эзэлддэг бөгөөд Хөрс хуулалт олборлолтыг мэргэжлийн төвшинд олон арван жил хийсэн дэлхийд салбартаа тэргүүлэгч компани юм.

Австрали Улсын “А” компани МУ-д үйл ажиллагаа явуулахын тулд “С” охин компани байгуулах хэрэгтэй болсон ба Манай хууль эрх зүйн орчинг судалж үзэн Давхар татварын гэрээтэй орон болох Сингапур улсад бүртгэгдсэн өөрийн санхүүжилт олгох “В” компанийг байгуулсан. Санхүүжилт 2 тэрбум төгрөг.

3.



4. МУ-д бүртгэлтэй “С” компанийг шалгахад МУ-д хэрэгжиж буй томоохон нүүрсний төслийн үндсэн гүйцэтгэгч бөгөөд хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаа эрхлэдэг ба дээрх ажлыг хийхийн тулд өөрсдийн томоохон машин механизм, эксковатор зэрэг өртөг өндөртэй тоног төхөөрөмж хэрэглэдэг байсан. Дээрх машин тоног төхөөрөмжийн санхүүжилтыг шууд хамаарал бүхий

Сингапур улсад бүртгэгдсэн “В” компаниас зах зээлийн ямар нэг хүүгүй эргэн төлөх ямар нэг болзолгүйгээр авсан байсан.

5. МУ-ын ААНОАТ хуулийн 11.1 заалт “Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан этгээдүүд хоорондоо зах зээлийнхээс хямд буюу өндөр үнээр бараа борлуулсан буюу шилжүүлсэн, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бол татварын алба нь харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын зах зээлийн үнийг жишиг болгон албан татвар ногдох орлогыг тодорхойлно”, мөн хуулийн 14 дүгээр зүйл “Албан татвар ногдох орлогоос хасч тооцох зардалд хамрах зээлийн хүү”-ийн 14.3 заалт “Хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид олгосон зээлийн дүн өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс гурав дахинаас илүү гарсан бол ийнхүү илүү гарсан зээлд төлсөн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасч тооцохгүй бөгөөд түүнийг тухайн хөрөнгө оруулагчийн ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна” гэснийг тус тус зөрчсөн.
6. ААНОАТ-ын ногдуулалт төлөлтийн тайланд холбогдох тооцооллыг тусгаж, татвар суутган ногдуулан төлөөгүй зөрчил гэж үзэн толгой компаниудаас санхүүжилт мэтээр хүлээн авч, харилцан хамаарал бүхий хуулийн этгээд хооронд үнэ төлбөргүй санхүүгийн үйлчилгээ үзүүлэн урт хугацаат өр төлбөрийн дүнг нэмэгдүүлсэн зөрчилд зээлийн хүүгийн хувийг олон улсын санхүүгийн зах зээлийн дундаж хүүгийн тооцооллоор тооцож, нимгэн капиталжуулалтын зохицуулалт хийж Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулалт төлөлтийн тайланд тусгаагүй, татвар суутган ногдуулан төлөөгүй төлбөр төлөхийг хариуцуулсан.
7. Дээрх зөрчлийг татвар төлөгч “С” компани хүлээн зөвшөөрөөгүй ба ТЕГ-ын МТЗ хандсан болно.

“С” компани нэхэмжлэлдээ дотоодын хуулийн заалтаар “А” компаний шууд хамаарал байхгүй гэж үзсэн.

Нэхэмжлэлийн хууль эрх зүйн үндэслэлийг бичвэл: ААНОАТ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан этгээдүүд хоорондоо зах зээлийнхээс хямд буюу өндөр үнээр бараа борлуулсан буюу шилжүүлсэн, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бол татварын алба нь харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын зах зээлийн үнийг жишиг болгон албан татвар ногдох орлогыг тодорхойлно” мөн зүйлийн 11.2-д “Энэ хуулийн 7.5, 11.1-д заасан жишиг үнэ хэрэглэх аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” хэмээн тус тус заасан байдаг.

Татварын улсын байцаагчийн актын хавсралт болох татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, ногдуулсан төлбөрийн тооцоог ажиглахад 2012-2016 онуудад хийгдсэн таван жилийн хугацааны санхүүжилтийг 2,000,000,000.0 төгрөгийн зээл хэмээн үзэн, зах зээлийн дундаж хүүг ашиглан 500,000.0 төгрөгийн зээлийн хүүг харилцан хамааралтай этгээдүүдэд төлсөн гэж үзжээ. Улмаар энэ зээлийн хүүгийн дүнг ААНОАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дэх заалт буюу нимгэн капиталжуулалтын зохицуулалтад заасан хөрөнгө оруулалт, зээлийн харьцаа 3:1-ээс илүү гарсан зээлд төлсөн хүү хэмээн үзэж түүнийг ногдол ашигт тооцжээ. Татварын улсын байцаагчид дээр

дурдснаар ААНОАТ-ын тухай хуульд заасан ямар хүчин төгөлдөр татварын хууль тогтоомж болон аргачлал, түүний зүйл заалтад үндэслэн гадаад улсаас гадаад валютаар (ам.доллараар) авсан санхүүжилтийг зээл гэж үзэн, ямар албан ёсны мэдээллийн эх сурвалжаас зээлийн хүүгийн хувийг олон улсын санхүүгийн зах зээлийн дундаж хүүгийн хувиар тооцсон нь тодорхойгүй буюу хуулийн үндэслэлгүй байна. ТЕГ-ын даргын 2007.08.31-ний 165 дугаар тушаалаар баталсан “Харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдэж байгаа борлуулалтад бодит бус үнэ хэрэглэж болзошгүй дотоодын бараа, ажил, үйлчилгээний төрөл, зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалжийн жагсаалт”– д харилцан хамааралтай этгээдүүдийн дотоодын зээлийн хүүгийн хувийг Монгол банкны Статистикийн сарын мэдээ – банкнуудын зээлийн жилийн дундаж хүүг үндэслэхээр заасан байна. Гадаад улсаас гадаад валютаар авсан зээлийн хувьд жишиг болгон баримтлах зээлийн хүүгийн жишиг хувь хэмжээг тогтоох талаарх зохицуулалт манай улсын татварын хууль тогтоомжид одоогоор байхгүй, хуулиар зохицуулагдаагүй, тодорхойгүй байгаа тухай гэж нэхэмжилдээ дурдсан байдаг.

Олон улсын татвар ногдуулалтын давтан сургалт

(2018.4.30-2018.5.4)

Он сар өдөр	Цаг	Сургалтын агуулга	Хариуцсан багш
2018.4.30 (Даваа)	09:00-12:00	Сургалтын өмнөх шалгалт	Төслийн зөвлөх Кодера Тошинари Ишигүро Хидеаки
	13:00-16:00	Монгол улсын жишээн дээр ажиллах (Case 1-3)	
2018.5.1 (Мягмар)	09:00-12:00	Монгол улсын жишээн дээр ажиллах (Case 4-6)	Төслийн зөвлөх Кодера, Ишигүро
	13:00-16:00		
2018.5.2 (Лхагва)	09:00-12:00	Монгол улсын жишээн дээр ажиллах (Case 7-9)	Төслийн зөвлөх Кодера, Ишигүро
	13:00-16:00		
2018.5.3 (Пүрэв)	09:00-12:00	Монгол улсын жишээн дээр ажиллах (Case 10, 11)	Төслийн зөвлөх Кодера, Ишигүро
	13:00-16:00	Монгол улсын олон улсын татвар ногдуулалттай холбоотой татварын тогтолцооны өөрчлөлт	
2018.5.4 (Баасан)	09:00-12:00	Монгол улсын олон улсын татвар ногдуулалттай холбоотой татварын тогтолцооны өөрчлөлт	Төслийн зөвлөх Кодера
	13:00-16:00	Хэлэлцүүлэг	

Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийн жагсаалт

№	Нэрс	Харьяа нэгж
1	Ч.Эрдэнэчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУАБ
2	Д.Батжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУАБ
3	С.Төгсжаргал	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУАБ
4	Ц.Дэлгэрмаа	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
5	Г.Бямбасүрэн	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
6	Б.Ариунгэрэл	ТЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ТУБ
7	Н.Болорчимэг	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
8	Н.Хандхүү	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ

9	Ш.Ундраа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
10	Б.Төгсжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
11	Ё.Мөнхбат	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
12	П.Дашболд	ТЕГ-ын Төрийн захиргааны удирдлагын газрын ТУБ
13	Б.Халиун	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
14	Ш.Батзаяа	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
15	Б.Уранцэцэг	УТОХГ-ын Эрсдэл, статистикийн хэлтсийн ТУБ
16	Ц.Түвшинбаяр	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
17	Г.Банзрагч	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
18	Х.Алтанхүү	УТОХГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
19	Л.Даваасүрэн	БЗД-ын Татварын хэлтсийн ТУБ
20	Ч.Лхамрагчаа	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
21	Д.Солонго	СБД-ын Татварын хэлтсийн ТУБ
22	Ц.Ундармаа	СХД-ын Татварын хэлтсийн ТУБ
23	Б.Очирхуяг	ХУД-ын Татварын хэлтсийн ТУБ
24	Г.Гансүх	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
25	Ж.Эрдэнэтуул	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
26	Н.Энхсаруул	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
27	Б.Пүрэвдулам	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
28	Ц.Энхнаран	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
29	Д.Бямбасүрэн	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
30	Ч.Сарангэрэл	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
31	Энхзул	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
32	Д.Ганбат	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
33	Э.Буд	ТЕГ-ын Татварын орлогын газрын ТУБ

Монгол улсын Олон улсын
татвартай холбоотой шинэчилсэн
татварын хууль
ТЕХ, ААНОАТХ
Асуулт - Хариулт

ЖАЙКА байгууллагын зөвлөх
Кодера Тошинари
2018 оны 5 сар
1

Агуулга

- Олон улсын татварын асуудлууд?
- Монгол улсын татварын хуульд ямар өөрчлөлт шаардлагатай вэ?
- Жишээтэй холбосон Олон улсын татварын асуудал
- Шинэчилсэн найруулгын гол зүйл нь?
- ТЕХ-ийн өөрчлөх гол зүйл нь юу вэ?
- ААНОАТХ-ийн өөрчлөх гол зүйл нь юу вэ?
- Татварын диваажингийн тогтолцоо?

А: Олон улсын татварын асуудлуудыг бүгдийг нэрлэж чадах уу?

- ААНОАТ ?
- ХХОАТ ?
- Татвар хураалтын хууль ?
- ТЕХ ?

- OECD загвар гэрээ ?
- UN загвар гэрээ ?
- BEPS ?

3

А: Одоо мөрдөгдөж байгаа татварын хуулийг хэрхэн өөрчлөх шаардлагатай гэж бодож байна вэ?

- Жишээндээр ажиллах сургалтыг дууссаны дараа ямар татварын хууль хэрэгтэй байгааг бодож үзээрэй.
- Яг одоо бодож үзнэ үү.
- А: Хууль боловсруулалт хариуцсан байцаагч?
- А: ААН хяналт шалгалтын байцаагч? (УТОХГ, Татварын алба)?
- А: ХХОАТ-ын хяналт шалгалтын байцаагч (УТОХГ, Татварын алба)?
- А: Татвар хураалтын байцаагч?
- А: Бусад байцаагч?

4

A: Case study болон өөрчлөх шаардлагатай асуудлуудыг дахин нэг уялдуулж үзээд цэгцлэнэ үү?

- Q: Case тус бүрийн хувьд ямар хууль шаардлагатай байна вэ? Зөвхөн хууль байхад болох уу? Хэрэгжүүлэх журам? Дүрэм? –ийн талаар бас бодож үзнэ үү?
- Q: Энэ удаагийн Case-үүд дээр ажиллаж үзээд, Монгол улсын олон улсын татвартай холбоотой асуудлуудыг бүгдийг хамарч чадсан байна гэж үзэж байна уу?
- Q: Олон улсын татварын онолын талаас авч үзвэл эдгээрээс гадна өөр авч үзэх шаардлагатай case байна уу? Хэрвээ байвал яг одоо тэр case-ийг гаргаж ирнэ үү?

5

Өөрчлөх гол зүйл юу вэ?

- Question: Inbound эдийн засагтай Монголын татварын хуулийг өөрчлөхдөө аль татварын хуулийн аль зүйл заалтыг өөрчлөх шаардлагатай вэ?
- Answer: Дотоод эх үүсвэртэй орлогын заалт, Үнэ шилжилтийн татварын тогтолцоог бүрэн бүрдүүлэх, олон улсын татварын үндсэн заалт шаардлагатай
- Reason: Яагаад гэвэл, OECD зэрэг олон улсын байгууллага нь BEPS-ийн хэлэлцүүлгээр улс орнуудын олон улсын татварын заалтуудыг нэгтгэх шаардлага тавьж байгаа.

6

ТЕХ-ийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ?

- Q: Яагаад GAAR-ийн заалт (16-р зүйл) орсон бэ?
- A: Олон улсад гарч буй татвараас зайлсхийх жишээнүүдэд, бүр тусгайлсан татвараас зайлсхийх заалт болох TP, PE гм заалтаар татвар ногдуулах боломжгүй болж ирж байгаа учраас.
- R: TP гм-ийн заалтын шаардлага нь хатуу бөгөөд PE гм байнгын бус оршин суугч этгээдэд ... эх үүсвэртэй орлогын заалтаар татвар ногдуулах нь бодит байдалд үүсч буй ажил гүйлгээг хамарч чаддаггүй.
- Анхаарах: Татвараас зайлсхийх тусгайлсан заалт болох TP гм-ийг ашиглаж үзээд хэрвээ боломжгүй байх бол ТЕХ-ийн GAAR-ийг ашиглах нь эрх зүйн хувьд боломжтой. “Тусгай хууль нь Ерөнхий хуулиас давуу эрхтэй” учир.

7

ТЕХ-ийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ? 2

- Q: Яагаад TP-ийн (19-р зүйл) заалт орсон бэ?
- R: Татварын хяналт шалгалтын заалт нь ТЕХ-д байдаг бөгөөд үнэ шилжилтийн хяналт шалгалт ч бас орж байгаа тул ТЕХ-ийн заалт дотор TP-ийн үзэл баримтлалыг тусгасан заалтыг оруулж өгөх шаардлагатай байсан учраас юм.

8

ААНОАТХ-ийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ? 1

- Q: ААНОАТХ-д хамгийн чухал үндсэн заалт юу вэ?
- А: Гадаадын ААН, байнгын бус оршин суугчийн олон улсын эх үүсвэртэй орлогын (4-р зүйл нэмэлт) заалт юм.
- R: Олон улсын татварын үндсэн ухагдахуун нь “Дотоод эх үүсвэртэй орлого”-ын заалт бөгөөд гадаадын ААН, байнгын бус оршин суугчид зөвхөн “Дотоод эх үүсвэртэй орлого”- оор татвар ногдуулдаг тул дотоод эх үүсвэртэй орлогын заалт байхгүй бол татварын алдагдлын асуудал их гардаг учраас юм. Япон улсын хувьд ч ААНОАТ, ХХОАТ-ын Олон улсын татвартай холбоотой хэсгийн эхэнд нэлээн дэлгэрэнгүй оруулсан байдаг.

9

ААНОАТХ-ийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ? 2

- Q: Монгол улсын хувьд байгалийн баялагийн талаас нь харвал ААНОАТХ-д байх хамгийн чухал үндсэн заалт юу вэ?
- А: PE (6-р зүйл шинэ) –ийн заалт
- R1: Гадаадын ААН-ийн Монгол улсад байгалийн баялаг олборлох хэлбэр нь үйл ажиллагаа явуулах байр, үйлдвэр, салбар, охин компани зэрэг олон PE хэлбэр байх учир дотоодын хуулиа илүү нарийвчлан зааж өгөхгүй бол татварын алдагдал үүснэ.
- R2: Гэрээний PR заалт нь хэтэрхий энгийнээр зааж өгсөн байгаа тул бодит байдал дээр үүсч байгаа асуудлуудыг шийдвэрлэх боломжгүй.
- R3: BEPS дээр PE-ийн татварын алдагдлын асуудлаас урьдчилан сэргийлэх нөхцөл шаардлагыг нэмэхээр ажиллаж байгаа. BEPS-ийн гишүүн орны хувьд ОК боловч, зөвхөн энэ байлаа гээд хангалтгүй бөгөөд дотоодын хуульд бас оруулж өгөхгүй бол Монгол улсад татварын алдагдлын асуудал үүснэ.

10

ААНОАТХ-ийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ? 3

- Q: Олон улсын татварын онолын, бодит байдлын талаас нь харвал ААНОАТХ-д хамгийн чухал заалт нь юу вэ?
- A: TP (13-р зүйл шинэ) –ийн заалт
- R1: Асуудал болдог олон улсын ажил гүйлгээний бараг ихэнх нь толгой болон охин компани хоорондын гадаад ажил гүйлгээ байдаг бөгөөд энэ ажил гүйлгээтэй холбоотой нарийвчилсан заалт байхгүй улс орны хувьд татварын алдагдлын асуудал нэлээд гардаг.
- R2: TP-ийн талаар OECD, BEPS-д ч судалж байгаа бөгөөд бодит байдалд ихээхэн нөлөөлөл үзүүлэх чухал өөрчлөлтийг хийж байгаа тул үүний араас явна гэхэд л нэлээд жил шаардлагатай.
- R3: Зөвхөн TP-ийн хуулиар бодит байдалд гарч буй асуудлуудыг шийдвэрлэх боломжгүй. Япон улсын хувьд нэлээд хэмжээний хэрэгжүүлэх журам, дүрэм, аргачлалууд байдаг. Эдгээр журам, дүрмүүдийг гаргахад ч гэсэн нэлээн хугацаа шаардагдана.

11

ААНОАТХ-ийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ? 4

- Q: Үнэ шилжилтийн хамгийн чухал заалт юу вэ?
- A: TP баримтжуулалтын заалт (31-р зүйл нэмэл)
- R1: Их хэмжээтэй, төвөгтэй олон улсын ажил гүйлгээ хийдэг толгой болон охин компаний хувьд ААНОАТ-ын хяналт шалгалтын байцаагч нь татварын хяналт шалгалт хийсний дараа тухайн хяналт шалгалтад орсон ААН-ээс ажил гүйлгээтэй холбоотой бичиг баримт, ТРМ (ҮНА: CUP арга гм) хэрхэн тооцсон байдал зэргийг асууж шалгааснаар хангалттай, сайн хяналт шалгалт болохгүй.
- R2: Иймд их хэмжээний ажил гүйлгээ хийдэг ААН-ээс баримтжуулалт гэх тогтолцоог ашиглан толгой болон охин компанийн харилцаатай компанийн оршин байх улсаарх тайлан (country report: төлөх татвар гм), үйл ажиллагааны тайлан (master file: биет бус хөрөнгийн бодлого гм), мөн хяналт шалгалтад хамгийн чухал локал файл (TRM материал гм) –ийг жилийн тайлан гаргах хугацаа хүртэл бэлдүүлдэг.

12

ААНОАТХ-ийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ? 5

- Q: Асуудал болоод байгаа Толгой болон охин компани хоорондын өндөр хүүгийн төлбөрийг шийдвэрлэхэд зөвхөн Нимгэн капиталжуулалтын татварын тогтолцоо байхад хангалттай юу?
- A: Хэт өндөр хүүгийн татварын тогтолцоог (17-р зүйл шинэ) нэвтрүүлэх шаардлагатай.
- R1: Дан ганц Нимгэн капиталжуулалтын татварын тогтолцоо (BS хэлбэр) хангалтгүй. Орлогод суурилж хүүгийн хэт өндөр үнийн дүнг тогтоосноор (PL хэлбэр) татварын алдагдлыг шалгах боломжтой байх тохиолдол байдаг учир.
- R2: Хэт өндөр хүүгийн татварын тогтолцоог толгой, охин компанийн альнаас нь ч төлсөн бай ашиглах боломжтой.
(Нимгэн капиталжуулалтын татварын тогтолцоо нь охин компаниас төлж буй хүүнд л хамаатай байдаг)

★ Гэвч нимгэн капиталжуулалтын тогтолцоог ашиглан татварын алдагдлаас сэргийлэх тохиолдол байдаг учир нимгэн капиталжуулалтын тогтолцоог хасч бол болохгүй. Япон улс Нимгэн капиталжуулалт, Хэт өндөр хүүгийн татварын тогтолцоо аль алиныг нь оруулж өгсөн байдаг.

13

ААНОАТХ-ийн өөрчлөлтийн гол зүйл юу вэ? 6

Цаашид тулгарах томоохон асуудал: Татварын диваажин

Q: Татварын диваажийн асуудал

“ Монголын ААН толгой компани нь Англи улсын Бержины аралд байдаг охин компанитай ажил гүйлгээ хийдэг бөгөөд охин компани нь Монгол дах толгой компаниас бүтээгдэхүүн авч Гуравдагч улсад экспортлодог. Энэ охин компани нь толгой компаниасаа илүү ашигтай ажилладаг юм шиг байна. Толгой компанийн захирлын аав нь энэ Татварын диваажин дах охин компанийн хувьцаа эзэмшигч. Мөн толгой компани нь энэ охин компаниас их хэмжээний зээл авсан тул маш их хэмжээний хүүг охин компанидаа төлдөг. Энэ толгой компани нь уул уурхай олборлолтын технологийг үбүртгүүлсэн бөгөөд үүнийгээ охин компанидаа ойрын хугацаанд шилжүүлэх гэж байгаа. Толгой компани нь энэ технологио гадаад компаниудад ашиглах зөвшөөрөлтэйгөөр ашиглуулдаг бөгөөд ашиглуулсаны төлбөр авдаг гэж сонссон. Ойрын хугацаанд охин компани нь энэ зөвшөөрлийг гуравдагч улсын ААН-д зарах төлөвлөгөөтэй байгаа. Охин компани нь толгой компанид хуваарилалт хийдэг.”

→Q: Ийм байдалд одоогийн Монгол улсад мөрдөгдөж байгаа татварын хуулиар ямар арга хэмжээ авч чадах вэ?

14

Олон улсын татвар ногдуулалтын гүнзгий шатны сургалтын

(2018.8.27-8.31)

	8 сарын 27	8 сарын 28	8 сарын 29	8 сарын 30	8 сарын 31
	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
Үдээс өмнө (9:00-12:00)	(Урьдчилсан тест) Монгол Улсын олон улсын татварын тогтолцооны шинэчилэлийн чиглэл	Үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах	Үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах	Үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах	Үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах
	Кодера	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро
Үдээс хойш (13:00-16:00)	Биет бус хөрөнгө ба ТРМ	Үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах	Үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах	Үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах	(Сургалтын дараах тест) Дүгнэлт
	Кодера	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Нийт багш нар

Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийн жагсаалт

№	Нэрс	Харьяа нэгж
1	Ч.Эрдэнэчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУАБ
2	Х.Сувд-Эрдэнэ	ТЕГ-ын Төрийн захиргааны удирдлагын газрын ТУБ
3	Н.Жаргалцэцэг	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
4	Ж.Цэрэнцоо	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
5	А.Сувдаа	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
6	Г.Энхжин	ТЕГ-ын Татварын орлогын газрын ТУБ
7	Ц.Баярмаа	ТЕГ-ын Дотоод аудитын газрын ТУБ
8	Б.Ариунчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
9	Н.Туул	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
10	Ш.Ундраа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
11	Ц.Түвшинбаяр	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
12	Б.Батчимэг	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
13	С.Гүнжинлхам	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
14	Д.Батжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУАБ
15	С.Төгсжаргал	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУАБ
16	Ц.Дэлгэрмаа	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
17	Г.Бямбасүрэн	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
18	П.Отгонсүрэн	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
19	Н.Болорчимэг	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
20	Н.Мөнхдаваа	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ

21	Н.Хандхүү	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
22	Ц.Ишжамц	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
23	Б.Төгсжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
24	Ш.Энхжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
25	Ё.Мөнхбат	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
26	Ш.Батзаяа	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
27	Б.Уранцэцэг	УТОХГ-ын Эрсдэл, статистикийн хэлтсийн ТУБ
28	Г.Банзрагч	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
29	Х.Алтанхүү	УТОХГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
30	О.Цэнд-Аюуш	НТГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтэс
31	Ж.Эрдэнэбүрэн	НТГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
32	Б.Халиун	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
33	Ч.Лхамрагчаа	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
34	Д.Солонго	СБД-ын Татварын хэлтсийн ТУБ
35	Ц.Ундармаа	СХД-ын Татварын хэлтсийн ТУБ
36	Ж.Уянга	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
37	С.Наранбаатар	Дорнод аймгийн Татварын хэлтсийн ТУБ
38	Ц.Өнөрмөнх	Орхон аймгийн Татварын хэлтсийн ТУБ
39	С.Дүүбаяр	Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн ТУБ
40	Л.Мөнхтуул	ТЕГ-ын Хуулийн хэлтсийн ТУБ

Япон улсын ТР баримтжуулалт

ТР-ийн хамгийн чухал хэсэг

Кодера Тошинари
2018 оны 8 сарын 27

1

Гарчиг

- Баримтжуулалтын тогтолцоо гэдэг нь
- ① Үндэстэн дамнасан групп компаниас шаардах бичиг баримт ба хугацааны хязгаар
- ② Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ хийсэн хуулийн этгээдээс шаардах бичиг баримтын боловсруулалт, хадгалалтын үүрэг

2

Баримтжуулалтын ТОГТОЛЦОО ГЭДЭГ НЬ...

• BEPS төслийн 13-ийн дагуу, 2016 оны татварын шинэчилэлтээр хийгдсэн үнэ шилжилтийн баримтжуулалтын хүрээнд боловсруулах шаардлагатай бичиг баримт:

① “Үндэстэн дамнасан групп компаниас шаардах бичиг баримт”

② “Гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээ хийсэн хуулийн этгээдээс шаардах бичиг баримт” гэсэн 2 төрлийн бичиг баримт байдаг.

3

① Үндэстэн дамнасан групп компаниас шаардах бичиг баримт ба хугацааны хязгаар

1. Үндсэн толгой компанийн мэдэгдэл

Хугацаа: Үндсэн толгой компанийн үйл ажиллагааны тайлант жилийн сүүлийн өдөр

2. улс улсаарх тайлагнал (CbCR)

Хугацаа: Үндсэн толгой компанийн үйл ажиллагааны тайлант жилийн сүүлийн өдрийн дараагийн өдрөөс тооцон 1 жилийн дотор

3. Үйл ажиллагааны тайлан (Мастер файл)

Хугацаа: Үндсэн толгой компанийн үйл ажиллагааны тайлант жилийн сүүлийн өдрийн дараагийн өдрөөс тооцон 1 жилийн дотор

4

② Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ хийсэн хуулийн этгээдээс шаардах бичиг баримтын боловсруулалт, хадгалалтын үүрэг

1. Сунгасан гарын үнийг тооцоход шаардлагатай бичиг баримт ТАХТХ-ын хэрэгжүүлэх дүрмийн 22-10①-д заасан бичиг баримт 2016 оны татварын шинэчилэлээр, тусгах үзүүлэлтүүдийг тодорхой болгож, BEPS төслийн тунхаглалтай холбоотой үзүүлэлтүүдийг нэмсэн.

□ Зэрэгцүүлэн баримтжуулах

Тогтсон гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ хийдэг ААН-ийн тухайд, тайлагнах үүрэгтний татварын тайлан гаргах хугацаа хүртэл, энэхүү бичиг баримтыг бэлтгэх, эсхүл олж авч хадгалах үүрэгтэй.

5

Үндэстэн дамнасан групп компанийн тайлагнах үүргийг тодорхойлох Reporting Entity

- Тодорхойлох дэс дараалал
- ①「Групп компани」мөн эсэх
- ②「Үндэстэн дамнасан групп компани」 мөн эсэх
- ③「Тусгайлсан Үндэстэн дамнасан групп компани」 мөн эсэх
- ④「Бүтцийн бүрэлдэхүүн компани」 мөн эсэх

6

ААН-ын групп гэдэг нь (Enterprise groups)

Дараах тохиолдлыг хэлнэ:

А: Дараах тохиолдлоос бусад санхүүгийн нэгдсэн тайлан гаргадаг ААН-ын нэгдлийг хэлнэ.

- (1) энэхүү компанийн нэгдэл дэхь хяналтын компанийн хөрөнгө, ашиг, алдагдлын нөхцөл байдал нь бусад компанийн нэгдлийн санхүүгийн нэгдсэн тайланд тусгагддаг бол,
- (2) энэхүү компанийн нэгдэл дэхь хяналтын компанийн хөрөнгө, ашиг, алдагдлын нөхцөл байдал нь бусад компанийн нэгдэл дэхь хяналтын компанийн хувьцааг хөрөнгийн бирж дээр нээлттэй болгохын тулд шаардагдах санхүүгийн нэгдсэн тайланд тусгагддаг бол,

7

Б: Энэхүү компанийн нэгдэл дэхь хяналтын компанийн хувьцааг хөрөнгийн бирж дээр нээлттэй болгохын тулд санхүүгийн нэгдсэн тайлан боловсруулах шаардлагатай бөгөөд, дараах нэгдлээс бусад,

- (1) энэхүү компанийн нэгдэл дэхь хяналтын компанийн хөрөнгө, ашиг, алдагдлын нөхцөл байдал нь бусад компанийн нэгдлийн санхүүгийн нэгдсэн тайланд тусгагддаг бол,
- (2) энэхүү компанийн нэгдэл дэхь хяналтын компанийн хөрөнгө, ашиг, алдагдлын нөхцөл байдал нь бусад компанийн нэгдэл дэхь хяналтын компанийн хувьцааг хөрөнгийн бирж дээр нээлттэй болгохын тулд шаардагдах санхүүгийн нэгдсэн тайланд тусгагддаг бол,

8

Үндэстэн дамнасан групп компани (MNE group)

Энд дараах зүйлс багтана:

- А Групп компанийн гишүүн компанийн оршин байх улс нь 2-оос дээш байх.
- Б Группын доторх гишүүн компаниуд нь бүгд нэг улсад оршин байрладаг байх тохиолдолд, энэ улсаас өөр улс ба бүсэд байх, энэхүү бүтцийн аль нэг компанитай холбоотой төлөөний газраар дамжуулан олсон орлогод, оршин байгаа улсаас бусад улс ба бүсээс ногдуулах ААНОАТ ба энэ татвартай дүйцэх татвар байгаа тохиолдол

9

Тусгайлсан Үндэстэн дамнасан групп компани (Specified MNE Group)

- Тусгайлсан Үндэстэн дамнасан групп компани гэдэг нь Үндэстэн дамнасан групп компанийн дотроос, Үндсэн толгой компанийн өмнөх тайлант жил дэхь группын нийт орлого 100 тэрбум иенээс их байх гэсэн шалгуурт нийцэх,
- Мөн, нийт орлогын дүн нь Үндэстэн дамнасан группын санхүүгийн нэгдсэн тайлан дахь борлуулалт ба орлого, бусад ашиг алдагдлын дүнгийн нийлбэр байх,
- Мөн, борлуулалт ба орлого, бусад ашиг алдагдлын дүнгийн нийлбэрийн тухайд, жишээлбэл, борлуулалтын дүнгээс гадна, хүү, үнэт цаасны хүү, ноогдол ашиг, үнэт цаас борлуулсны ашиг, ханшийн зөрүүний ашиг, хөрөнгийн нөөцийн буцаалтын ашиг, хөрөнгө оруулалтын ашиг, үндсэн хөрөнгө борлуулсны ашиг, үүссэн сөрөг гүүдвилийн орлого зэрэг санхүүгийн нэгдсэн тайланд тусгагдсан бүх ашиг орлого хамаарна гэж үздэг.

10

Гишүүн компани (Constituent Entity)1

Энд дараах зүйлс багтана:

- А Групп компанийн санхүүгийн нэгдсэн тайлан гардаг тохиолдолд,
- (1) Групп компанийн санхүүгийн нэгдсэн тайланд, хөрөнгө ба ашиг алдагдлын нөхцөл байдлыг тусган оруулдаг компани,
- (2) Групп компанийн санхүүгийн нэгдсэн тайланд, ач холбогдол багатай хэмээн нэгдсэн тайлангийн хамрах хүрээнээс хасагдах компанийн дотроос, шийдвэр гаргах эрхийн талаас илүүг тухайн группын өөр компани эзэмшдэг болон бусад шалтгаанаар шийдвэр гаргах байгууллагыг хянадаг компани,

11

Гишүүн компани (Constituent Entity)2

Энд дараах зүйлс багтана:

- А Групп компанийн санхүүгийн нэгдсэн тайлан гардаг тохиолдолд,
- (1) Групп компани дахь хяналтын компанийн хувьцааг хөрөнгийн бирж дээр нээлттэй болгохын тулд шаардагдах санхүүгийн нэгдсэн тайланд хөрөнгө, ашиг алдагдлын нөхцөл байдлыг тусгадаг компани,
- (2) Групп компани дахь хяналтын компанийн хувьцааг хөрөнгийн бирж дээр нээлттэй болгохын тулд шаардагдах санхүүгийн нэгдсэн тайлангаас ач холбогдол багатай хэмээн нэгдсэн тайлангийн хамрах хүрээнээс хасагдах компанийн дотроос, шийдвэр гаргах эрхийн талаас илүүг тухайн группын өөр компани эзэмшдэг болон бусад шалтгаанаар шийдвэр гаргах байгууллагыг хянадаг компани,

12

Үндсэн толгой компани (Ultimate Parent Entity)

- Үндсэн толгой компани гэж, групп компанийн гишүүн компани дотроос, энэ группын бусад компанитай холбоотой шийдвэр гаргах эрхийн талаас илүүг эзэмшдэг болон бусад шалтгаанаар энэхүү компанийн санхүү, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлогч байгууллагыг хянадаг бөгөөд дээрээ толгой компанигүй этгээдийг хэлнэ.

13

Үндсэн толгой компанийн талаарх мэдэгдэл 1

- ① Агуулга: Үндсэн толгой компани ба төлөөлөх толгой компанитай холбоотой мэдээллийг тусгасан бичиг баримт

【Гарган өгөх үүрэгтэн】

Тусгайлсан Үндэстэн дамнасан группын бүтцэд байх дотоодын хуулийн этгээд, эсхүл төлөөний газар (PE) бүхий компани

【Мэдэгдэх асуудлууд】

Үндсэн толгой компани ба төлөөлөх толгой компанийн нэр, төв ба гол оффисын байршил.

【Хугацаа】 Үндсэн толгой компанийн тайлант жилийн сүүлийн өдөр хүртэл e-tax-аар харьяа татварын албаны даргад хүргүүлэх.

14

Үндсэн толгой компанийн талаарх мэдэгдэл 2

- **【Мэдэгдлийн маягт】**
- Тусгайлсан Үндэстэн дамнасан групп компанитай холбоотой Үндсэн толгой компанийн талаарх мэдэгдэл, улс улсаарх тайлагнал, үйл ажиллагааны тайланг гаргагч нь хэд хэд байгаа тохиолдолд, төлөөлөн тайлагнагчийн талаарх мэдээллийг өгөх.
- **【хэрэгжиж эхлэх】**
- 2016 оны 4 сарын 1-нээс эхлэх Үндсэн толгой компанийн тайлант жил

15

Үндсэн толгой компанийн талаарх мэдэгдэл 3

- **②Бичигдэх агуулга**
- Үндсэн толгой компанийн мэдэгдэл ба тусгай нөхцөлтэй холбоотой асуудлуудыг тусгасан мэдээллийг e-tax-аар тайлагнана.

16

Улс улсаарх тайлагнал (CbCR) 1

① Агуулга: Үндэстэн дамнасан групп компанийн улс орнууд ба бүсүүдээр ялгасан орлого, татварын өмнөх тухайн хугацааны ашиг, төлсөн татвар болон бусад мэдээллийг тусгасан бичиг баримт

【Гарган өгөх үүрэгтэн】

Татварын гэрээний хэлбэр: Тусгайлсан Үндэстэн дамнасан группын бүтцэд байх дотоодын хуулийн этгээд (Үндсэн толгой компани эсхүл төлөөлөх толгой компаниар хязгаарлах)

Охин компанийн хэлбэр: Тусгайлсан Үндэстэн дамнасан группын бүтцэд байх дотоодын хуулийн этгээд, эсхүл төлөөний газар (PE) бүхий компани (Үндсэн толгой компани эсхүл төлөөлөх толгой компаниар хязгаарлах)

17

Улс улсаарх тайлагнал (CbCR) 2

- **【Тайлагнах үзүүлэлт】**
- Тусгайлсан Үндэстэн дамнасан групп компанийн гишүүн компанийн үйл ажиллагаа эрхлэх улс эсхүл бүс нутаг тус бүрээр
- ① Орлого, татварын өмнөх ашиг, татварын дүн, үүссэн татварын дүн, хөрөнгийн дүн, эсвэл хөрөнгө оруулалтын дүн, хуримтлагдсан ашиг, ажилчдын тоо, биет хөрөнгийн дүн
- ② Гишүүн компаниудын нэр, оршин байх улс, төв оффисын байршил ондоо бол энэхүү байршил бүхий улсын нэр, гол үйл ажиллагааны агуулга
- ③ Жич
- **【Хугацаа】** Сүүлчийн тайлант жилийн сүүлийн өдрийн маргаашаас тооцон 1 жилийн дотор e-tax-аар харьяалах татварын албаны даргад хүргүүлнэ.

18

Улс улсаарх тайлагнал 3

- 【Тайлангийн маягт】
- Тусгайлсан Үндэстэн дамнасан групп компанитай холбоотой улс улсаарх тайлагнал. Хүснэгт 1-3
- 【Ашиглах хэл】Англи
- 【Авах арга хэмжээ】
- Хүндэтгэх шалтгаангүйгээр улс улсаарх тайлагналыг заасан хугацаанд гарган өгөөгүй бол 300 мянган иен хүртэл төргууль ногдуулна.
- 【Хэрэгжүүлж эхлэх】
- 2016 оны 4 сарын 1-нээс хойших Үндсэн толгой компанийн тайлант жил

19

Улс улсаарх тайлагнал (CbCR) 3

- ③ Үндсэн толгой компани, эсхүл төлөөлөх толгой компани нь гадаадад байрлах тохиолдол
(Зарчим)
- Үндсэн толгой компани, эсхүл төлөөлөх толгой компани нь гадаадад байрлах тохиолдолд, тэдгээрийн тухайн улсын татварын байгууллагад гаргасан CbCR нь манай улсын татварын байгууллагад хүргэгддэг тул зарчмын хувьд, энэ бүтцийн бүрэлдэхүүнд байгаа дотоодын хуулийн этгээд, эсхүл Японд байх төлөөний газар бүхий гадаадын хуулийн этгээдийн хувьд улс улсаарх тайлагнал гаргах үүрэг үүсэхгүй.

20

Улс улсаарх тайлагнал (CbCR) 4

- ③ Үндсэн толгой компани эсхүл төлөөлөх толгой компани нь гадаадад байрладаг тохиолдол

(Жишиг бус)

- Гэхдээ, манай улсын татварын байгууллага нь гадаад улсын татварын байгууллагаас CbCR тайланг олж авах боломжгүй байх дараах 1)–3) тохиолдлуудад өмнөх охин компанийн хэлбэрийг ашиглана.
- Үндэстэн дамнасан тусгайлсан групп компанийн гишүүн компани болох дотоодын хуулийн этгээд, эсхүл Японд байх төлөөний газар бүхий гадаадын хуулийн этгээд нь улс улсаарх тайлагналыг тайлант хугацааны сүүлийн өдрийн дараагийн өдрөөс тооцон 1 жилийн дотор e-tax-аар харьяа татварын албаны даргад хүргүүлэх ёстой.

21

Улс улсаарх тайлагнал (CbCR) 5

- 1) Үндсэн толгой компани эсхүл төлөөлөх толгой компанийн байрлах улсад, үндсэн толгой компанийн санхүүгийн тайлант жилтэй холбоотой CbCR-ийг гарган өгөхийг шаардах арга хэмжээ аваагүй бол,
- 2) Сангийн сайд ба үндсэн толгой компани, эсхүл төлөөлөх толгой компанийн тухайн улсын эрх бүхий байгууллагатай зохих зөвшилцөл тогтоогоогүй бол,
- 3) Үндсэн толгой компанийн тайлант жилийн сүүлийн өдрөөр тооцсон хугацаанд, үндсэн толгой компани ба төлөөлөх толгой компанийн оршин байх улс нь манай улсад CbCR гарган өгөх боломжгүй улс, бүс болох нь ТЕГ-ын даргад тодорхой байгаа бол,

22

Улс улсаарх тайлагнал (CbCR) 6

- Мэдээлэл харилцан солилцох ба улс улсаарх тайлагнал гаргах үүрэг
- (Зарчим)
- Гадаад улсад байрлах үндсэн толгой компани, эсхүл төлөөлөх толгой компанийн гадаадын татварын байгууллагад гаргасан CbCR-ийн тухайд, зарчмын хувьд татварын гэрээний дагуу мэдээлэл харилцан солилцох тогтолцооны хүрээнд манай улсын татварын байгууллагад ирнэ.
- Иймд, энэхүү гадаадын хөрөнгө оруулалттай үндэстэн дамнасан тусгайлсан группын дотоодын хуулийн этгээд ба салбар нь улс улсаарх тайлагналыг гаргах үүрэг хүлээхгүй.
- (Жишиг бус) гэхдээ, өмнө дурьдсан 1)-3)-т таарах буюу татварын гэрээний дагуу мэдээлэл харилцан солилцох замаар гадаадын татварын байгууллагаас CbCR-ийг манай улс олж авч чадахгүй тохиолдолд, дотоодын хуулийн этгээд ба салбар нь улс улсаарх тайлагнал гаргах үүрэг хүлээнэ.

23

Улс улсаарх тайлагнал (CbCR) 7

- ④Манай улсын үндсэн толгой компани нь гадаадын хуулийн этгээдийг төлөөлөх толгой компаниар сонгон мэдэгдсэн тохиолдолд, эсхүл сайн дурын мэдүүлэг ашиглах тохиолдол,
- (Зарчим)
- Манай улсад байх үндсэн толгой компанийн татварын байгууллагад гарган өгсөн улс улсаарх тайлагналыг, манай улстай татварын гэрээ бүхий гишүүн компанийн байрлах улсын татварын байгууллагад хүргүүлэх зарчимтай. (гэрээний хэлбэр)
- Иймд, гадаадад байх гишүүн компани нь тухайн байрлах улсынхаа татварын байгууллагад CbCR гаргах шаардлагагүй.

24

Улс улсаарх тайлагнал (CbCR) 8

- ④ Манай улсын үндсэн толгой компани нь гадаадын хуулийн этгээдийг төлөөлөх толгой компаниар сонгон мэдэгдсэн тохиолдолд, эсхүл сайн дурын мэдүүлэг ашиглах тохиолдол,
- (Жишиг бус)
- Дараах нөхцөлд нийцэх гадаадад байх гишүүн компанийн тухайд, оршин суух улсын татварын байгууллагад манай талаас CbCR хүргүүлэхгүй тул тухайн гишүүн компани өөрийн улсын татварын байгууллагад энэхүү тайланг (охин компанийн хэлбэр) гаргах үүрэг хүлээх тохиолдол байдаг.
- 1) Үндэстэн дамнасан тусгайлсан групп компанийн гадаад дахь гишүүн компани бөгөөд тухайн улсын дотоодын хуулиар тайлант хугацаанд CbCR гаргах үүрэг хүлээх улсад оршин байгаа бол,
- 2) Манай улстай CbCR-ийн мэдээлэл харилцан солилцох боломжгүй улсад байрлах гадаадын гишүүн компани,

Биет бус хөрөнгө ба ТРМ (BEPS-д суурилсан)

ЛСА мэргэжилтэн
Кодера Тошинари
2018 оны 8 сарын 27

1

ГАРЧИГ

- А ТРМ
- В BEPS-ийн асуудал ба биет бус хөрөнгө
- С OECD-Үнэ шилжилтийн удирдамж ба биет бус хөрөнгө
- D Япон Улсын ТР-ийн талаарх шүүхийн шийдвэрт биет бус хөрөнгийг тусгасан нь

2

A ТРМ

- Q ТРМ-ийг тайлбарлаж чадах уу?
- Япон Улсын ТРМ-ийн бүтэц
- Үлдэгдэл ашиг хуваах аргын томъёолол

3

Q Дараах ТРМ-ийн талаар юу ч харалгүйгээр амаар товч тайлбарлана уу.

● Үндсэн 3 арга
CUP, RP, CP

● Бусад аргууд
PS(Харьцуулах PS, Оролцоо PS, RPSM)

Ажил гүйлгээний цэвэр ашгийн арга TNMM(Верри харьцаа, Борлуулалт үйл ажиллагааны ашгийн харьцаа, нийт зардал үйл ажиллагааны ашгийн харьцаа)

★ Тооцооллын аргыг жишээний эмхэтгэлээс сонгон тусад нь хавсаргав.

4

Японы ТРМ-ийн бүтэц

1. Бараа материалаарх хөрөнгийн ажил гүйлгээнд ашиглах ТРМ

Group A (үндсэн)

★ CUP арга, RP арга, CP арга, PS арга, TNMM

Group B (Аргуудыг хослуулан хэрэглэх, харьцуулагдах бодит ажил гүйлгээг ашиглахгүйгээр зах зээлийн үнэ ханшийг харьцуулагдах ажил гүйлгээгээр сонгон ашиглах)

★ CUP арга, RP арга, CP арга, PS арга, TNMM-тэй дүйцэх арга гэнэ.

2. Бараа материалаарх хөрөнгөөс бусад ажил гүйлгээнд ашиглах ТРМ

Group C (үйлчилгээ, биет бус хөрөнгө ашиглах ажил гүйлгээ)

★ CUP арга, RP арга, CP арга, PS арга, TNMM-тэй адилтгах арга

Group D (Адилтгэх аргуудыг хослуулан хэрэглэх)

★ CUP арга, RP арга, CP арга, PS арга, TNMM-тэй дүйцэх ба адилтгах аргууд

5

Үлдэгдэл ашиг хуваах аргын тооцооны томъёолол

Үндсэн (үйл ажиллагааны) ашгийн тооцоо

[P төв компанийн үндсэн ашгийн тооцоо]

[S охин компанийн үндсэн ашгийн тооцоо]

Үлдэгдэл ашгийг хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан хуваарилах тооцоо

6

Q Үндсэн ашгийн тооцоо гэдэг нь...

Q Үндсэн ашиг гэдэг нь

- Чухал биет бус хөрөнгийг ашиглахгүйгээр харилцан хамааралгүй этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээнээс олох ашиг.

Q Үндсэн ашгийг тооцох гэдэг нь...

Жишээлбэл,

1. Гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээнд хамаарах үйл ажиллагаатай адил төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг
2. Зах зээл, үйл ажиллагааны цар хүрээ төстэй хуулийн этгээдийн (чухал биет бус хөрөнгө бүхий хуулийн этгээдээс бусад) тухайн үйл ажиллагаанд ашиглах хөрөнгө, борлуулалтаас олох ашгийн харьцаагаар илэрхийлэгдэх ашгийн түвшний индикаторт үндэслэн тооцоо хийгдэнэ.

7

Q TNMM ба RPSM-д их ашиглагддаг ашгийн түвшний индикатор (PLI) гэдэг нь...

1) Үйл ажиллагааны ашиг, борлуулалтын харьцаа

= Үйл ажиллагааны ашиг ÷ борлуулалт

➔ үйл ажиллагаа нь PL-ийн борлуулалтын менежментийн зардалд тусдаг худалдааны компанид илүү нийцдэг.

2) Борлуулалтын нийт ашиг үйл ажиллагааны зардлын харьцаа (Берри харьцаа)

= Борлуулалтын нийт ашиг ÷ үйл ажиллагааны зардал (борлуулалтын менежментийн зардал)

➔ Худалдааны компанид илүү нийцдэг.

3) Үйл ажиллагааны ашиг, хөрөнгийн харьцаа (ROA)

= Үйл ажиллагааны ашиг ÷ үйл ажиллагааны хөрөнгө

➔ Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл эрхэлдэг, хөрөнгийг төвлөрүүлсэн хэлбэрийн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид нийцдэг.

4) Үйл ажиллагааны ашиг нийт зардлын харьцаа (Net Cost Plus цэвэр өртөг нэмэгдүүлэх)

= Үйл ажиллагааны ашиг ÷ [өртөг + борлуулалтын менежментийн зардал]

➔ Ажиллах хүчийг төвлөрүүлсэн хэлбэрийн үйлдвэрлэгч болон үйлчилгээний аж ахуйн нэгжид нийцдэг.

8

Q Харьцуулагдах аж ахуйн нэгж олон байх тохиолдолд сунгасан гарын үнийг тооцох

Үйл ажиллагааны удирдамж 3-5

Зарчим: Харьцуулагдах ашгийн хувийн **дундаж утга**

Жишиг бус: **Төв утга** гэх мэт

Тавигдах нөхцөл: Энэхүү харьцуулагдах ашгийн түвшний тархалтын нөхцөл байдалд нийцсэн өөр бодит утга байгаа тохиолдолд,

★Төв утга гэдэг нь жишээлбэл, квартал аргын хоёрдугаар кварталыг хэлнэ.

9

Р төв компанийн үндсэн ашгийн тооцоо

• Р төв компани борлуулалт 400

Үйл ажиллагааны ашиг 40

Үйл ажиллагааны ашгийн хувь 0.1 (10%)

• Р төв компанитай адил улсад байрлан, чухал биет бус хөрөнгө эзэмшдэггүй хөндлөнгийн хэд хэдэн компанийн статистик зохистой ашгийн хувь

Хөндлөнгийн үйл ажиллагааны ашгийн хувь 0.0625(6.25%)

★Р төв компанийн үндсэн ашиг=Р компанийн борлуулалт × хөндлөнгийн ашгийн хувь=400 × 0.0625=25

10

S охин компанийн ашгийн хувийг тооцох

- S охин компанийн борлуулалт _____ 300
 - Үйл ажиллагааны ашиг 60
 - Үйл ажиллагааны ашгийн хувь 0.2(20%)
- S охин компанитай адил улсад байрлан, чухал биет бус хөрөнгө эзэмшдэггүй хөндлөнгийн хэд хэдэн компанийн статистик зохистой ашгийн хувь
 - Хөндлөнгийн ашгийн хувь 0.05(5%)
- ★ S охин компанийн үндсэн ашиг=S компанийн борлуулалт × хөндлөнгийн ашгийн хувь=300 × 0.05=15

11

Үлдэгдэл ашгийн тооцоо

- **Үлдэгдэл ашгийн тооцоолол**
- R&S компаниудын ашгийн нийлбэр 40 + 60=100
- R&S компаниудын үндсэн ашиг=25 + 15=40
- **Үлдэгдэл ашиг=100 – 40=60**

12

R&D зардлыг хуваах хүчин зүйлээр сонгох үлдэгдэл ашгийг хуваах тооцоо

P төв компанийн R&D зардал 40

S охин компанийн R&D зардал 20

- Бүтцийн харьцаа $40 : 20 = 2 : 1$

P төв компанийн үлдэгдэл ашиг = Нийт үлдэгдэл ашиг $60 \times 2 / [2 + 1] = 40$

S охин компанийн үлдэгдэл ашиг = Нийт үлдэгдэл ашиг $60 \times 1 / [2 + 1] = 20$

13

P&S компанийн байх ёстой эцсийн (үйл ажиллагааны) ашиг

- P төв компани = үндсэн ашиг 25 + үлдэгдэл ашиг 40 = 65
- S охин компани = үндсэн ашиг 15 + үлдэгдэл ашиг Residual 20 = 35
- 5 үнэ шилжилтийн татвар ногдуулалтад хамаарах орлого

P төв компани

= эхний үйл ажиллагааны ашиг 40 (татвар ногдуулсан) + TP татвар ногдуулах орлого 25 (= 65 - 40) = 65

S охин компани

= эхний үйл ажиллагааны ашиг 60 (татвар ногдуулсан) - TP бууруулан тохируулсан орлого 25 = 35

14

В BEPS асуудлууд ба биет бус хөрөнгө

15

**BEPS үйл ажиллагаа 8-ын
(Биет бус хөрөнгөтэй холбоотой үнэ шилжилтийн
дүрэм) агуулга**

- 1 Биет бус хөрөнгийн тодорхойлолт
- 2 Биет бус хөрөнгийн өгөөжийн тухай
- 3 ТРМ-ийн талаар

16

Биет бус хөрөнгө ба ТР дүрмийг тунхагласан шалтгаан

- Оюуны өмч буюу биет бус хөрөнгүүд нь тус бүртээ онцлогтой
- Группын дотоод ажил гүйлгээ ихтэй
- Харьцуулагдах ажил гүйлгээ бараг байдаггүй
- Дээрх шалтгаануудаар зохистой үнийг тооцоход хүндрэлтэй
- Иймд, биет бус хөрөнгийг татварын ачаалал багатай улсад байрлах эдийн засгийн хувьд бодитой бус харилцан хамаарал бүхий компанидаа хямдаар шилжүүлж, тэндээ их хэмжээний ашиг олох байдлаар татварын хэмнэлт хийдэг улс дамнасан аж ахуйн нэгжүүд байсан.

17

Биет бус хөрөнгийн тодорхойлолт

- BEPS-ийн эцсийн тайланд, өргөн хүрээний ухагдахууныг ашигласан.
- Биет бус хөрөнгийн «жишээ» жагсаалт гаргадаг бүтцийг бүрдүүлсэн.
- Тодорхойлолт: Биет бус хөрөнгө гэдэг нь,
 1. Биет ба санхүүгийн хөрөнгө бус байх,
 2. Худалдааны үйл ажиллагаанд ашиглагдах зорилгоор эзэмших, хянах боломжтой,
 3. Харьцуулах боломжтой, хараат бус холбогдогч талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээнд ашиглах, шилжүүлэх үед төлбөр төлөгддөг хөрөнгө

18

Бие бус хөрөнгийн жишээ

- Патент
- Ноухау
- Аж ахуйн нэгжийн нууц
- Худалдааны тэмдэгт
- Худалдааны дугаар
- Бренд
- Гэрээний эрх гэх мэт

19

Биет бус хөрөнгөтэй холбоотой өгөөжийн хамаарал

- Аж ахуйн нэгжүүд нь биет бус хөрөнгийг хөгжүүлэх, сайжруулах, хадгалах, засвар үйлчилгээ ашиглахтай холбоотой үүсэх үнэ цэнэд үндэслэн өгөөжийг хүртэнэ.
- Хөгжүүлэх (Development)
- Сайжруулах (Enhancement)
- Засвар үйлчилгээ (Maintenance)
- Хадгалах, хамгаалах (Protection)
- Ашиглах (Exploitation)
- DEMPE (дэмпи) гэж хэлэгддэг.

Өөрөөр хэлбэл, улс дамнасан групп компани нь зөвхөн хуулийн хүрээнд эзэмшлийн эрхтэй байснаар, биет бус хөрөнгөөс олох ашиг орлогоос хуваарилалт эдэлнэ гэсэн үг бас биш юм.

20

Биет бус хөрөнгийн үнэ тооцох аргын тухай

- Биет бус хөрөнгийг харилцан хамаарал бүхий этгээд хооронд шилжүүлэхийн тухайд, найдвартай харьцуулагдах ажил гүйлгээг тодорхойлох боломжгүй байвал, шилжүүлсэн үнийг тооцохдоо дараах аргуудыг ашиглана:

➔「Үнэлэх техник арга」(Valuation Technique)-ыг ашиглах боломжтой.

Тодруулбал, DCF арга (Хөнгөлсөн мөнгөн гүйлгээний арга Discounted Cash Flow)

Энэ нь биет бус хөрөнгөөс ирээдүйд үүсэх cash flow-ийг өнөөгийн үнэ цэнэд шилжүүлсэнийг тухайн биет бус хөрөнгийг бусдад шилжүүлсэн үнэ гэж үзнэ.

- Мөн, үнэлгээ хийхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийн тухайд, тодорхой тохиолдолд,

➔「Орлогын нийцлийн жишиг」-ийг ашиглахаар болсон.

21

DCF арга

- Аж ахуйн нэгжийн бий болгох ашиг орлогыг (Ирээдүйн чөлөөт мөнгөн гүйлгээ) жишиг болгон тухайн аж ахуйн нэгжийн үнэ цэнэ хэмээн тодорхойлох арга
- Тодруулбал, чөлөөт мөнгөн гүйлгээг хөнгөлөлтийн хувь гэсэн индикароор хөнгөлж өнөөгийн үнэ цэнэд шилжүүлэн, түүнийхээ нийлбэрийг үйл ажиллагааны үнэ цэнэ хэмээн тодорхойлдог.

22

Орлогод нийцүүлэх жишиг гэдэг нь...

- OECD удирдамжийн 6-р бүлэгт оруулах болсон.
- АНУ, Германд аль хэдийн ашиглагддаг.
- Ажил гүйлгээний үед, алдаа мадаггүйгээр урьдчилан үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийн тухайд, урьдчилсан таамаг ба бодит гүйцэтгэлийн үр дүнгийн хооронд ихээхэн зөрүү гардаг. Жишээлбэл, охин компанидаа оюуны өмчийн эрхийг 800 мянган иенээр шилжүүлсэн боловч, бодит үнэ нь 10 сая иен байсан биш үү гэх мэтийн асуудал
- Ийм асуудлын тухайд, [Дараа нь гарах үр дүн дээр үндэслэн, урьдчилсан таамаглах үнэлгээг хийх онол]-ыг орлогын нийцлийн жишиг гэж хэлдэг.

23

Q Орлогын нийцлийн жишиг нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн зарчимтай зөрчилдөх үү.

- BEPS-ийн эцсийн тайлан
- Дүгнэлт: Зөрчилдөхгүй
- Шалтгаан: Бие даасан аж ахуйн нэгжийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний тухайд, үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийг шилжүүлэх үедээ, багаар үнэлсэн байсан ч,
- Бараа бүтээгдэхүүн амжилттай болох зэрэг дараа нь гарах үр дүнгээс хамаарч, эхний үнэлгээг дахин харилцан ярилцах, шилжүүлэн авсан талын борлуулалттай уялдуулан, шилжүүлсэн талд нэмэлтээр төлбөр хийх зэрэг боломж байна.
- Иймд, үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийн тухайд, хямдаар шилжүүлсэний дараа, үр дүнгээс хамаарч шилжүүлсэн үнийг дахин ярилцаж өөрчлөлт оруулах нь бие даасан аж ахуйн нэгжийн зарчимтай зөрчилдөхгүй.

24

Q Япон Улсын татварт биет бус хөрөнгийг ҮЗЭХ НЬ...

ААНОАТ хуулийн дагалдах журам 13-8

Уул уурхай, загас агнуур, далан ашиглалтын эрх, ус ашиглалтын эрх, патент, шинэ бүтээл оновчтой санал, зураг дизайн эрх, худалдааны эрх, програм хангамж, тариалагчийн эрх, нийтийн байгууламжийн ашиглалтын эрх, үйл ажиллагааны эрхийг элэгдэл тооцох биет бус хөрөнгө гэж заасан байдаг.

Арга хэмжээний тухай хуулийн аргачилал 66-4(3)-3(Жич)1

Худалдагч, худалдан авагчийн ашиглах биет бус хөрөнгө (зохиогчийн эрх, ААНОАТ-ын хуулийн үндсэн журмын 20-1-21-т заасан үйлдвэрийн эзэмшлийн эрхээс гадна, харилцагчийн жагсаалт, борлуулалтын сүлжээ зэрэг чухал үнэ цэнэ бүхий зүйлийг хэлнэ)...

ААНОАТ хуулийн үндсэн журам 20—1—21

Салбарын өөрчлөлт, хөдөлгөөн, борлуулалтын статистик мэдээлэл, дүн шинжилгээ, үнэлгээний ажил нь биет бус хөрөнгө болохгүй.

25

С ОЕСД-үнэ шилжилтийн удирдамж ба биет бус хөрөнгө

26

ОЕСД үнэ шилжилтийн удирдамжийн шинэ 6-р бүлэг

- Шинэ 6-р бүлэгт, биет бус хөрөнгийн ажил гүйлгээтэй холбоотой сунгасан гарын үнэ тооцох шинэ аргаар, үнэлгээний техникийг ашиглах, мөн үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгөтэй холбоотой үнэ шилжилтийн дүрмийн талаар зааж өгсөн.

1. Үнэлгээний техникийг ашиглах (Use of valuation technique)
(DCF аргыг ашиглах)
2. Үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгө (Commensurate with income standard)
(Орлогын нийцлийн жишгийг ашиглах)

27

Үнэлгээний техник ашиглах (Use of valuation technique)

- ОЕСД үнэ шилжилтийн удирдамжийн шинэ 6-р бүлэг D2.6.3
- Г Үнэлгээний техникэд суурилсан орлогыг ашиглах, үнэлж буй биет бус хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд олох орлогын төсөөлөл, эсхүл мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэд шилжүүлсэн тооцоонд суурилсан үнэлгээний техникийг ашиглахын тухайд, ялангуяа зохистой ашиглаж чадвал ихээхэн үр дүнтэй.]

28

Үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийн талаар

- Шинэ 6-р бүлэг (6.185)
- «Харьцуулагдах боломжтой нөхцөлд байгаа бие даасан аж ахуйн нэгжийн хувь, биет бус хөрөнгийн үнэлгээний тодорхой бус байдлыг шийдвэрлэх механизмийг (жишээлбэл, үнийн тохируулгын зүйл заалт оруулах) хүлээн зөвшөөрөхөөр бол,
- Татварын байгууллага, энэ механизмд үндэслэн, биет бус хөрөнгө, эсхүл биет бус хөрөнгийн эрхтэй холбоотой ажил гүйлгээний үнийг тооцох асуудлыг хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай.
- Мөн адилаар, харьцуулагдах байдалд байгаа бие даасан аж ахуйн нэгжийн хувьд, дараа нь үүссэн нөхцөл байдал нь бодитой бөгөөд энэхүү нөхцөл байдал үүссэнээр, ажил гүйлгээний үнийг ирээдүйд дахин тохиролцох магадлалтай бол харилцан хамаарал бүхий этгээдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний үнийн тооцоонд залруулга хийх нь зүйтэй.]

29


D Япон Улсын ТР-ийн талаарх шүүхийн шийдвэрт биет бус хөрөнгийг тусгасан нь

30

Шүүхийн шийдвэрийн жишээ 1

Ажил гүйлгээний зураг

Гадаад харилцан
хамаарал бүхий ажил
гүйлгээ



31

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

- Татварын байгууллагын арга хэмжээ
- Харилцан хамааралгүй этгээд хоорондын жолооны хүрд үйлдвэрлэх лицензийн ажил гүйлгээг харьцуулагдах ажил гүйлгээгээр сонгож, **харьцуулагдах үнийн аргатай** адилтгах аргаар татвар ногдуулна.
- Гол маргасан асуудлууд
- Татварын байгууллага харьцуулагдах үнийн аргатай адилтгах аргаар татвар ногдуулж байгаа бөгөөд гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хооронд төстэй шинж чанар байгаа эсэх.
- ➔ Нэхэмжлэгч тал нь төстэй шинж чанар байхгүй байна гэж эсэргүүцсэн
- Төстэй шинж чанар байхгүй тохиолдолд, зөрүүний тохируулга хийх шаардлагатай бус уу?

32

Шүүхээс бодит байдлыг тодруулан(лицензийн ажил гүйлгээний талаар)гаргасан шийдвэр

- Технологийн асуудлын тухайд, гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээнд жолооны хүрд, жолооны аппарат, усны насос хамаарч байгаа ба харьцуулагдах ажил гүйлгээ нь зөвхөн жолооны хүрд байсан боловч, роялти нь аль аль нь адилхан 3% байсан.
- Газар нутгийн хувьд, гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээ нь АНУ ба Солонгост гэсэн ялгаатай улс орныг сонгосон боловч, АНУ-ын автомашины эд ангийн үйлдвэрлэлийн 200 гаруй мэдээллийн 40%-ийн роялти нь борлуулалтын 3%, Солонгост ч 60% нь адилхан 3% байсан.
- Гэрээ хийсэн хугацааны тухайд, гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээг 1989 оны 11 сард, харьцуулагдах ажил гүйлгээг 1990 оны 12 сард хийсэн байгаа боловч, энэ салбарын роялти хувь нь энэ хугацааны туршид ихэнхдээ 3% байсан.

33

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хооронд адил төстэй шинж чанар байна.

Зөрүүний тохируулга хийх шаардлагагүй.


- Шалтгаан ?

34

Шүүхийн шийдвэрийн жишээ 2

Ажил гүйлгээний зураг

Гадаад харилцан
хамааралтай ажил гүйлгээ



35

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

- Татварын байгууллагын арга хэмжээ
- Харьцуулагдах үнийн аргатай дүйцэх ба адилтгах аргаар татвар ногдуулна.
- Харьцуулагдах ажил гүйлгээ болох 23 гэрээний дотроос 18-ын роялти 3% байж таарч байгаа ба салбарын жишиг роялтийн хувь хэмжээ 3% гэж тодорхойлогдсон тул, роялтийг 3% гэж тооцоонд ашигласан.
- Гол маргаантай асуудлууд
- Татварын байгууллага нь харьцуулагдах үнийн аргатай адилтгах аргаар татвар ногдуулж байгаагийн тухайд, гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээ нь адил төстэй шинж чанартай юу гэсэн асуулт гарч байна.
- ➔ Нэхэмжлэгч тал нь төстэй шинж чанар байхгүй байна гэж эсэргүүцсэн
- Төстэй шинж чанар байхгүй тохиолдолд, зөрүүний тохируулга хийх шаардлагатай бус уу?

36

★ Харьцуулагдах үнийн аргатай дүйцэх арга ба адилтгах арга

- Шүүхийн тайлбар
- Г Харьцуулагдах ажил гүйлгээний сонголтын тухайд, хамрах хүрээг өргөтгөж, адил төстэй биет бус хөрөнгийн ажил гүйлгээтэй адилтгах байдлаар сунгасан гарын үнийг тооцох арга гэж үзсэн.]

37

Шүүхээс бодит байдлыг тодруулан(лицензийн ажил гүйлгээний талаар)гаргасан шийдвэр

- Харьцуулагдах 23 ажил гүйлгээний зөвхөн 18-ийн хувьд 3% байна.
- Нэхэмжлэгчээс гадаад харилцан хамааралтай этгээдэд өгч байгаа эд анги үйлдвэрлэхтэй холбоотой технологийн мэдээлэл нь харьцуулагдах ажил гүйлгээ хоорондын технологийн мэдээллээс ялгаатай байна.
- Гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хэлбэр ялгаатай байна.
- Дээрх нөхцөл байдлаас 3% гэж тогтоох шалтгаан хангалтгүй байна.
- Гэхдээ, татварын байгууллагын сонгосон харьцуулагдах ажил гүйлгээ нь аль аль нь 2%-аас дээш байна.
- Мөн, гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хувьд, тээврийн хэрэгслэлийн хөдөлгүүр ба удирдлагын эд анги хэмээн үйл ажиллагааны хувьд адил байна.

38

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хооронд адил төстэй шинж чанар байна.

Зөрүүний тохируулга хийх шаардлагагүй.


Роялтийн хувьд 2% байхад болно.

- Шалтгаан?

39

Шүүхийн шийдвэрийн жишээ 3 Ажил гүйлгээний зураг

Гадаад харилцан хамааралтай
ажил гүйлгээ



40

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

Татварын байгууллагын арга хэмжээ

- Электрон эд ангийн худалдаа, биет бус хөрөнгийн ажил гүйлгээнд үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулах.
- Гол маргаантай асуудал
 1. Гадаад харилцан хамааралтай этгээдээс ноогдол авдаг тул ТР татвар ногдуулах шаардлагагүй эсэх.
➔ нэхэмжлэгч тал нь ТР татвар ногдуулалт шаардлагагүй гэж эсэргүүцсэн
 2. CUP, RP, CP үндсэн 3 аргыг ашиглах боломжтой [нэг ажил гүйлгээ] юм биш үү?
➔ нэхэмжлэгч тал [нэг ажил гүйлгээ] гэж байгаа.
 3. Ажил гүйлгээ тус бүрээр үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглах уу?
➔ нэхэмжлэгч тал нь ажил гүйлгээ тус бүрээр үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглана гэж байгаа
 4. Үндсэн ашиг тооцоход харьцуулагдах ААН-ыг зохистой сонгосон эсэх.
➔ нэхэмжлэгч тал харьцуулагдах ААН-ын сонголт дээр хэсэгчилсэн алдаа байна гэж үзсэн.
 5. R&D зардлыг гадаад харилцан хамааралтай этгээд даасан байхад яагаад нэхэмжлэгчийн хуваарилалтын индикатороор авч үзсэн болох.
➔ нэхэмжлэгч нь гадаад харилцан хамааралтай этгээдийн даасан зардлыг энэ этгээдийн хуваарилалтын индикатороор авах ёстой гэж үзсэн.

41

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 1

1. Манай улсын ТР татварын тогтолцоонд гадаад харилцан хамааралтай этгээдээс ноогдол ашиг хуваарилсан бол ТР татварын тогтолцоог ашиглахгүй гэсэн заалт байхгүй.
2. Үндсэн 3 арга ба адилтгах аргыг ашиглах боломжтой [нэг ажил гүйлгээ] биш.
3. Нэхэмжлэгч ба гадаад харилцан хамааралтай этгээд нь тус бүртээ чухал биет бус хөрөнгөтэй байхаас гадна, энэ 3 ажил гүйлгээ нь харилцан уялдаатай байна.

Иймд, нэхэмжлэгч ба гадаад харилцан хамааралтай этгээдийн үйл ажиллагааны ашгийн нийлбэрт үндэслэн, нийт ажил гүйлгээг хамруулан үлдэгдэл ашгийн аргыг ашиглах нь зохистой.

42

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 2

4. Үндсэн ашгийг тооцох тохиолдолд, харьцуулагдах ААН нь

「Адил төрлийн үйл ажиллагаа эрхэлж, зах зээл, үйл ажиллагааны цар хүрээ адил төстэй бөгөөд, чухал биет бус хөрөнгөгүй хуулийн этгээдийг харьцуулагдах ААН-ээр сонгох шаардлагатай. 」

Харьцуулагдах ААН-ээс дараах тохиолдолд хасна:

- 1) Санхүүгийн тайлангийн тоон үзүүлэлтийн өөрчлөлт ихтэй.
- 2) Ашиг алдагдлын мэдээлэл зөвхөн богино хугацаанд гарсан ААН

43

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 3

5. Гадаад харилцан хамааралтай этгээдүүдийн биет бус хөрөнгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

1) Зөвхөн хуулийн хүрээний эзэмшлийн эрх биш

2) Биет бус хөрөнгийг бий болгоход холбогдогч талуудын оруулсан хувь нэмрийг тооцох

3) Биет бус хөрөнгийг бий болгохтой холбоотой шийдвэр гаргалт, үйлчилгээ үзүүлэх, зардал даах, эрсдлийн удирдлагад холбогдогч талуудын үүрэг хариуцлага хэр байсан зэрэг нэгдсэн байдлаар авч үзэх

4) Гадаад харилцан хамааралтай этгээд эрдэм шинжилгээний сэдэв тогтооход оролцож, хөгжүүлэлтийн явцад эрсдэл үүрэлцсэн байх.

5) Иймд, гадаад харилцан хамааралтай этгээдийн даасан R&D нь нэхэмжлэгч тал болох Японы ААН бус тухайн гадаадын этгээдийн хуваарилалтын индикатор болно.

44

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Татварын байгууллага үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан нь хуулийн хүрээнд байна.


Гадаад харилцан хамааралтай этгээдийн даасан R&D-ийн зардал нь нэхэмжлэгчийн хуваарилалтын хүчин зүйл биш байна.

- Шалтгаан?

45

Шүүхийн шийдвэрийн жишээ 4 Ажил гүйлгээний зураг

Гадаад харилцан хамааралтай
ажил гүйлгээ



46

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

- Татварын байгууллагын арга хэмжээ
- Үйлдвэрлэл, худалдааны лицензийн ажил гүйлгээнд (Биет бус хөрөнгийн ашиглалтын зөвшөөрлийн ажил гүйлгээ) үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан.
- Гол маргаантай асуудал
Үлдэгдэл ашиг хуваах аргын хуваарилалтын хүчин зүйл юу болох.

47

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр

1. Нэхэмжлэгч нь дотоод ажил гүйлгээг харьцуулагдах ажил гүйлгээгээр авч, [Харьцуулагдах үнийн аргатай адилтгах арга]-ыг хэрэглэхийг шаардсан.
2. Дотоод ажил гүйлгээ ба гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний хувьд, ашиглалтын зөвшөөрлийн биет бус хөрөнгө нь адил төрөл болно.
3. Гэхдээ, ашиглалтын зөвшөөрөлтэй холбоотой нөхцөл шалгуур нь ялгаатай.
1)Ашиглалтын зөвшөөрлийн эхлэх хугацаа, 2)Хугацаа, 3)Ашиглалтын зөвшөөрлийн нөхцөл, 4)Зөвшөөрөлд мэргэжилтэн дагалдан томилогдох эсэх, 5)Ашиглахаар зөвшөөрөгдсөн борлуулалтын бүс нутаг нь гэрээнд ч, бодит байдал дээр ч ялгаатай.
4. Эдгээр нь сунгасан гарын үнэ ALP(роялтийн хувь)-д нөлөөлнө.
5. Нэхэмжлэгч нь эдгээр нь ALP-д нөлөөлөхгүй гэдгийг нотлоогүй байна.
6. Татварын байгууллага, хуваарилалтын хүчин зүйлээр, биет бус хөрөнгийг бүрдүүлэх ажлыг хариуцсан нэгжийн ажилтны, өөрөөр хэлбэл, [хэтэрсэн хүний нөөцийн зардал](= жилийн хүний нөөцийн зардал — холбогдох үйлдвэрлэлийн дундаж хүний нөөцийн зардал)-ыг авсан нь бодитой байна.

48

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Татварын байгууллага үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан нь хуулийн хүрээнд байна.


Нэхэмжлэгч талын тавьж буй дотоод ажил гүйлгээ нь харьцуулагдах ажил гүйлгээ болохгүй.

- Шалтгаан?

49

Шүүхийн шийдвэрийн жишээ 5 Ажил гүйлгээний зураг

Гадаад харилцан хамаарал
бүхий ажил гүйлгээ



50

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

Татварын байгууллагын арга хэмжээ

- Лицензийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний худалдаанд үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан.

Гол маргаантай асуудлууд

1. Лицензийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний худалдааны ажил гүйлгээг тус тусад нь авч үзэх ёстой эсэх.
⇒Татвар төлөгч нь тусдаа ажил гүйлгээ гэж үзэж байгаа.
2. Харьцуулагдах үнийн аргатай адилтгах аргыг ашиглах ёстой эсэх.
⇒Татвар төлөгчөөс энэ аргыг хэрэглэхийг шаардаж байгаа.
3. Үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглах ёстой эсэх.

51

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 1

1. Хагас боловсруулсан бүтээгдэхүүнд, лицензээр үйлдвэрлэх ноухаугийн нэг хэсэг шингэсэн байгаа. Мөн, лиценз эзэмшигч гадаад харилцан хамаарал бүхий этгээд нь энэхүү бүтээгдэхүүнийг нэхэмжлэгчээс худалдан авахыг үүрэг болгож байгаа. Иймд, хагас боловсруулсан бүтээгдэхүүний ажил гүйлгээнд ч биет бус хөрөнгийн ашиглалтын зөвшөөрлийн үнийн төлбөрийг авч байгаа гэж үзэхээр байгаа тул, лицензийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний худалдааны ажил гүйлгээ нь нэгдсэн зүйл гэж үзээд ALP-ийг тооцох боломжтой.
2. Эдгээр ажил гүйлгээний хувьд, 1)Биет бус хөрөнгө нь адил төрөл, гэхдээ 2)Ашиглалтын зөвшөөрлийн патент ба «технологийн мэдээлэл»-ийн хамрах хүрээ ялгаатай. 3)Лицензийн бүтээгдэхүүний бүтэц ялгаатай. 4)Борлуулалт ба зах зээлийн нөхцөл байдал ялгаатай. Иймд, эдгээр 2 ажил гүйлгээнд адил төстэй шинж чанар байхгүй байна.
⇒Иймд харьцуулагдах үнийн аргатай адилтгах аргыг ашиглахгүй.

52

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 2

3. Үндсэн ашгийг тооцоолохдоо, харьцуулагдах ажил гүйлгээг сонгохын тухайд

Нэхэмжлэгч: Гадаад харилцан хамааралтай этгээд нь нарийн, том оврын тоног төхөөрөмж шаардлагагүй байхад, татварын байгууллагаас SIC кодоор том оврын тоног төхөөрөмжийн ААН болон өөр бараа бүтээгдэхүүн бүхий ААН-ыг харьцуулагдах ААН-ээр сонгосон байна.

Шүүх: 1)Татварын байгууллагын сонгосон SIC код бодитой бус байна.

2)Үлдэгдэл ашиг хуваах арга нь үйл ажиллагааны ашгийн түвшинг ашигладаг тул, нийт ашгийн хувьтай харьцуулаад, ажил гүйлгээний (бүтээгдэхүүн) зөрүүний нөлөөлөлд орох нь бага.

53

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 3

4. Үлдэгдэл ашиг хуваах аргын хуваарилалтын хүчин зүйлийн тухайд,

Нэхэмжлэгч тал: Гадаад харилцан хамаарал бүхий этгээд нь 24 цагийн турш асуудалд хариулт өгөх нэгжтэй бөгөөд энэ нь биет бус хөрөнгийг бий болгоход ихээхэн хувь нэмрээ оруулсан.

Шүүх: Энэ нэгжийн үйл ажиллагаа нь туслах чанартай.

5. Үлдэгдэл ашиг хуваах аргын хуваарилалтын хүчин зүйлийн тухайд,

Татварын байгууллага: Нэхэмжлэгчийн хуулийн нэгжийн зардал ч хуваарилалтын хүчин зүйл болно.

Шүүх: Хуулийн нэгжийн зардалд, харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ажил гүйлгээтэй холбоотой зардал бас орсон байгаа тул, үүнийг хуваарилалтын хүчин зүйлийн зардлаас хасч тооцох нь зүйтэй.

54

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан


- Дүгнэлт

Татварын байгууллага үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан нь хуулийн хүрээнд байна. Гэхдээ, татварын байгууллагын хуваарилалтын хүчин зүйлийн нэг хэсэг алдаатай байгаа тул энэ хэсгээр хязгаарлан, татварын байгууллагын авсан арга хэмжээг хүчингүйд тооцох.

- Шалтгаан?

55

Шүүхийн шийдвэрийн жишээ 6 Ажил гүйлгээний зураг (Global trading)



56

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

Татварын байгууллагын арга хэмжээ

- Global trading-д үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулах

Гол маргаантай асуудлууд

1. Үндсэн 3 арга, эсхүл дүйцэх ба адилтгах аргыг ашиглах боломжтой эсэх.
2. Үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглах боломжтой эсэх.

57

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр

1. Харьцуулагдах ажил гүйлгээг олоогүй тул үндсэн 3 аргатай адилтгах ба дүйцэх аргыг ашиглах боломжгүй.
2. Энэ тохиолдолд, ашгийн анхдагч хуваарилалт дахь үндсэн ашиг гэж үзэж болохоор ашгийн тухайд, худалдаа ба эрсдлийн удирдлагын үйл ажиллагаатай харьцуулаад ашиг олох үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр багатай үйл ажиллагаа байна.

Хоёрдогч ашгийн хуваарилалтын хүрээнд үлдэгдэл ашгийг бүрдүүлж байгаа нь 1)Худалдааны үйл ажиллагаа, 2)Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа байна.

58

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан


- Дүгнэлт

Татварын байгууллага үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан нь хуулийн хүрээнд байна. Борлуулагчийн хүний нөөцийн зардал ба хөрөнгө бүрдүүлэх өртгийг хуваарилалтын хүчин зүйл болгох.

- Шалтгаан?

59

Х автомашины компанийн ТР татвар ногдуулалт Ажил гүйлгээний зураг



60

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

Татварын байгууллагын арга хэмжээ

- Бараа материалаарх хөрөнгө болох 2 дугуйтын ажил гүйлгээнд үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан.
- Энэ ТРМ-ийн дотроос харьцуулагдах ажил гүйлгээний нийт зардал үйл ажиллагааны ашгийн түвшний дундаж утгыг Бразил талын үндсэн ашгийн хувь болгодог [Нийт зардал үйл ажиллагааны ашгийн түвшний арга]-ыг ашигласан.
- Энэ үндсэн ашгийн хувь \times [Гадаад харилцан хамааралтэй этгээдийн нийт зардал—гадаад харилцан хамааралтай этгээдийн гаргасан чухал биет бус хөрөнгийн үнэ цэнийн индикатор болох зардал]= Бразилийн гадаад харилцан хамааралтай этгээдийн үндсэн ашиг болно.

Гол маргаантай асуудал

1. Энд байх олон ажил гүйлгээ нь [нэг ажил гүйлгээ] болох уу?
2. Үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглах нь татварын хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй юу?
3. Үндсэн ашиг тооцоход гадаад харилцан хамааралтай этгээд ба харьцуулагдах ААН-ыг харьцуулах боломж байна уу?

➔ **3 нь хамгийн гол маргаантай асуудал !!!**

61

Q ТРМ-д хамаарах ажил гүйлгээ хэд байгаа болох?

Дараах 4 ажил гүйлгээ байна.

1. Хоёр ба дөрвөн дугуйтын эд анги, бүтээгдэхүүний худалдаа
2. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн худалдаа
3. Технологийн үйлчилгээ үзүүлэх ажил гүйлгээ (Хариуцагч нь гадаад харилцан хамааралтай этгээдийн үйлдвэрт инженер томилон зааварчилгаа өгөх үйлчилгээ үзүүлсэн)
4. Биет бус хөрөнгийн ажил гүйлгээ (Хариуцагчийн худалдааны тэмдэгт ашиглах зөвшөөрөл)

➔ Татварын алба эдгээр ажил гүйлгээг [нэгдсэн ажил гүйлгээ] гэж үзэн, нийт зардал үйл ажиллагааны ашгийн түвшнийг ашиглан үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан.

62

Q Үндсэн ашгийн тооцоонд чөлөөт бүсийн гадна үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ыг харьцуулагдах ААН-ээр сонгосон татварын байгууллагын сонголт зөв үү?

1. Гадаад харилцан хамааралтай этгээдтэй адил төрлийн үйл ажиллагаа эрхэлж, зах зээл ба үйл ажиллагааны цар хүрээ төстэй ААН бөгөөд чухал биет бус хөрөнгөгүй ААН.
2. Нийтэд зарагддаг BUREAU VAN DIJK компанийн 「OSIRIS」, MERGENT компанийн 「MERGENT ONLINE」 болон Лексис Жапан компанийн 「LexisNexis」-д тавигдсан Бразилийн ААН-ийн дотроос Америкийн SIC код нь 3713, 3714, 3751 байх 2 ба 4 дугуйт, холбогдох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг компаниудын дотроос дараах 6 нөхцөлд нийцэх компанийг хассан.
 - 1) Хоёр ба 4 дугуйтад холбоогүй үйл ажиллагаа нь 50%-аас дээш ААН
 - 2) Жилийн борлуулалтын орлого нь 25сая доллараас бага ААН
 - 3) 3-аас дээш жилийн санхүүгийн мэдээллийг олох боломжгүй ААН
 - 4) Засвар үйлчилгээ гэх мэт борлуулалтын дараах зах зээлд зориулсан бүтээгдэхүүний борлуулалт нь 50%-аас дээш байх ААН
 - 5) Харилцан хамааралтай ААН-тэй хийх ажил гүйлгээ нь борлуулалт, эсхүл нийт зардлыг 50%-аас дээш байх ААН
 - 6) Үйл ажиллагааны ашгийн хувь нь хасах бөгөөд өр төлбөрийн хэмжээ хэтэрсэн байдалтай үргэлжилж байгаа ААН

63

Q Манаусын татварын хөнгөлөлтөөс олох ашиг нь үлдэгдэл ашиг биш үү?

Татварын байгууллага

- Манаусын татварын хөнгөлөлтөөс олох ашиг нь татвар төлөгч ба гадаад харилцан хамааралтай этгээдийн эзэмшиж буй чухал биет бус хөрөнгөтэй нэгдсэн хамааралтай байна.
- Иймд, Манаус чөлөөт бүсээс олох ашиг нь үлдэгдэл ашиг бөгөөд биет бус хөрөнгийн хүчин зүйлсэд үндэслэн хуваана.

Шүүх

- Гэхдээ, Манаус дахь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн эрхийг олж авахын тулд, энгийн үйлдвэрлэлийн дамжлагын жишигт нийцэхэд хангалттай бөгөөд чухал биет бус хөрөнгөгүй хуулийн этгээд хүртэл энэ чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх боломжтой.
- Иймд Манаусын татварын хөнгөлөлтөөс олох ашиг нь чухал биет бус хөрөнгө болохгүй тул үлдэгдэл ашиг биш.
- Харин ч үндсэн ашиг тооцох шатанд энэ талаар авч үзэх шаардлагатай.
 - ➔ Гадаад харилцан хамааралтай этгээд нь Манаусын татварын хөнгөлөлт эдэлдэг бол харьцуулагдах ААН бас энэ хөнгөлөлтийг эдэлдэг байх нь зүйтэй.

64

Q Татвар төлөгч ба гадаад харилцан хамааралтай этгээдийн эзэмших чухал биет бус хөрөнгө гэж юу болох?

• Шүүх

1. **Хариуцагчийн** гадаад харилцан хамааралтай этгээдэд өгөх 1) Хоёр дугуйтын үйлдвэрлэл, худалдаатай холбоотой **технологийн мэдээлэл**, 2) Эд анги, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийн сүлжээг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн бүтцэд өөрчлөлт хийх **ноухау**, 3) Харуцагчийн ашиглахыг зөвшөөрсөн **худалдааны тэмдэгт, брендын зах зээлтэй холбоотой биет бус хөрөнгө** болно.
2. Гадаад харилцан хамааралтай этгээдийн хувьд ч хариуцагчаас өгсөн технологийн мэдээлэл, ноухауг ашиглан өөрийн үйл ажиллагааны бүтэц дээр бүрдүүлсэн өөрийн **технологи, ноухау** нь биет бус хөрөнгө болно.
3. Мөн, **гадаад харилцан хамааралтай этгээдийн**, хүмүүсийг цуглуулж, машин худалдан авагчийн групп үүсгэн, групп дотроо төлбөрийн давтамжаа тогтоон төлбөрөө хийж, сар бүр групп дотроо сугалаагаар машин авах хүнээ сонгож, төлбөр дуустал хамтдаа төлбөрөө гүйцэтгэдэг **Консолжиэ хэмээх өөрийн борлуулалтын онцлог бүхий сүлжээг** бүрдүүлсэн нь биет бус хөрөнгө болно.

65

Q Үлдэгдэл ашиг хуваах хүчин зүйлийн зардал гэж юуг хэлэх вэ?

• Шүүх

1. **Хариуцагч тал**

Технологийн мэдээлэл, ноухау, худалдааны тэмдэгт, брендийн зах зээлтэй холбоотой биет бус хөрөнгө бүрдүүлэх зардал

➔ **R&D зардал**

2. **Гадаад харилцан хамааралтай этгээд**

Өөрийн бие даасан технологи, ноухау

➔ **R&D зардал**

3. **Гадаад харилцан хамааралтай этгээд**

Консолжиэ худалдаа гэсэн өөрийн борлуулалтын сүлжээ

➔ **Сурталчилгааны зардал, борлуулалтыг дэмжих зардал**

66

Токиогийн орон нутгийн шүүхийн бодит байдлын тодруулга ба шийдвэр

1. Энэхүү гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ нь татвар төлөгч ба гадаад харилцан хамааралтай этгээдийн оршин байх улсад 2 дугуйт үйлдвэрлэн борлуулах үйл ажиллагаа гэж үзээд, эдгээр этгээдүүд үйл ажиллагаагаа хуваарилан гүйцэтгэж байгаагаас хэтрэхгүй байгаа тул нэгдсэн үйлдвэрлэл худалдааны ажил гүйлгээ гэж үзсэн татварын байгууллагын шийдвэр зөв байна.
2. Үлдэгдэл ашиг хуваах аргын тухайд, татвар ногдуулах үед, Арга хэмжээний тухай хуулийн дагалдах журмын 66-4(5)-5-д заасан, өөрөөр хэлбэл журмын заалтаар татвар ногдуулсан байна. Гэвч, мөн хуулийн хэрэгжүүлэх аргачилалын 39-12-8-ийн шинэчилсэн найруулга хийгдэхээс өмнө, мөн зүйлд энэ талаар заасан байсан гэж үзэх боломжтой тул, журмын заалтаар татвар ногдуулсан болохгүй тул татварын байгууллагын хэрэглэсэн ТРМ-ийг зөвшөөрнө.
3. Татварын байгууллагын сонгосон харьцуулагдах ААН нь гадаад харилцан хамааралтай этгээдтэй адил Манаусын бүсэд байгаа ААН биш тул харьцуулах боломжгүй. Засгийн газрын дэмжлэг хүртэх зах зээлийн нөхцөлд адил төстэй зүйл байхгүй байна. Манаус чөлөөт бүсээс гадна байгаа ААН-ыг харьцуулагдах ААН-ээр сонгосон бол зөрүүний тохируулга хийх шаардлагатай байхад Татварын байгууллага хийгээгүй байна.

67

Токиогийн орон нутгийн шүүхийн бодит байдлын тодруулга ба шийдвэр

- Үлдэгдэл ашиг хуваах арга нь үндсэн 3 аргатай харьцуулаад, харьцуулагдах ААН-д тавигдах харьцуулагдах байдлын түвшин зөөлөн боловч, үүнээс гадна нийт зардал үйл ажиллагааны ашгийн түвшнээр зах зээлийн адил төстэй байдлыг тогтоосон байсан ч,
- Манаусын бүсэд эдлэх татварын хөнгөлөлтөөс олох ашиг нь гадаад харилцан хамааралтай этгээдийг харьцуулагдах ажил гүйлгээтэй харьцуулах боломжийг тодорхойлоход ихээхэн нөлөөтэй.
- Иймд, татварын байгууллага нь чухал нөлөө бүхий зөрүүний тохируулга хийгээгүй тул, татварын байгууллагын үлдэгдэл ашиг хуваах аргыг ашигласан татвар ногдуулалт нь хууль бус байна.
- Татварын байгууллагын нийт зардал үйл ажиллагааны ашгийн түвшний талаарх зөрүүний тохиргоог шүүх хурал дээр гаргаж ирэх нь хууль бус юм.

68

★ Татварын байгууллагаас дээд шүүхэд давж заалдан, үндсэн ашиг тооцоход харьцуулах боломжтой гэж эцсээ хүртэл хичээсэн !

Татварын байгууллагын зөрүүний тохируулга

- Гадаад харилцан хамаарал бүхий этгээдийн Манаус бүсээс олсон ашгийг тусгасан нийт зардал үйл ажиллагааны ашгийн харьцаа =10% (А)
- Гадаад харилцан хамаарал бүхий этгээдийн Манаус бүсээс олсон ашгийг хассан нийт зардал үйл ажиллагааны ашгийн харьцаа =9% (В)
- Зөрүүний тохируулгын хувь = $A \div B = 10 \div 9 = 1.11$
- Зөрүүний тохируулгын дараах харьцуулагдах ААН-ын шинэ нийт зардал үйл ажиллагааны ашгийн харьцаа (шинэ үндсэн ашгийн хувь)=Харьцуулагдах ААН-ын анхны нийт зардал үйл ажиллагааны ашгийн харьцаа (анхны үндсэн ашгийн хувь) $6\% \times 1.11 = 6.66\%$

○Зөрүүний тохируулгын дараах гадаад харилцан хамааралтай этгээдийн үндсэн ашиг = $6.66\% \times$ [Гадаад харилцан хамааралтай этгээдийн нийт зардал – чухал биет бус хөрөнгийн үнэ цэнийг бүрдүүлэх зардал]

★Татварын байгууллага нь дээд шүүхэд энэ тооцоог харуулж, харьцуулагдах ААН-ын нийт зардал үйл ажиллагааны ашгийн харьцааг өсгөж, ногдуулах татварын хэмжээг бууруулах оролдлого хийсэн гэж тэмцсэн боловч, ялагдсан.

69

★Татварын байгууллагын зөрүүний тохируулгын асуудалтай байдал

• Процедурын асуудал

➔Ийм зөрүүний тохируулга нь татвар төлөгчийн шинэ дайралтын бай болдог тул, хууль бус 「Цэнхэр тайлангаар шалтгаалсан солилцоо」болсон.

• Тооцооны асуудал

➔Үндсэн ашиг тооцож байгаа тул биет бус хөрөнгөтэй холбоотой үлдэгдэл ашгийг хасаад, нийт зардал үйл ажиллагааны ашгийн харьцааг тооцох ёстой байтал, үлдэгдэл ашиг болон түүнийг бий болгоход гаргасан зардлыг оруулан тооцоолсон байна. Өөрөөр хэлбэл, үндсэн ашгийн шатны тооцооны хувьд зөв биш байсан.

★Эхнээсээ тооцоолсон бол ямар нэг эерэг үр дүн гарах байсан байж магадгүй.

70

TP Case Study

(Intangible Property)

August, 2018

Prof. Hideaki ISHIGURO

Prof. Mikio TAJINO

1


Сургалтыг хэрхэн явуулах талаар

Багаар хуваагдан Үнэ шилжилтийн 5 жишээн дээр ажиллана. Нийт суралцагсад жишээ бодлогын нөхцөлийг сайтар уншихын хамт ажил гүйлгээний зураг ба бусад өгөгдлийг ашиглан бодлогын асуултад хариулна.

Бодлогын талаар баг дотроо сайтар ярилцаж, хариултыг багийн хариулт байдлаар бүх багууд бусдадаа танилцуулга хийнэ.

2

Case 1



3

Case 1

【Бодлогын нөхцөл】


1. Японы P компани нь A бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт хийдэг бөгөөд 10 жилийн өмнө A бүтээгдэхүүнийг борлуулах S охин компанийг X улсад байгуулсан.
2. A бүтээгдэхүүн нь P компанийн судалгаа шинжилгээний үр дүнд, бие даасан технологийг ашиглан үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн юм.
3. P компани нь A бүтээгдэхүүнийг S компанид борлуулж, S компани нь X улсын доторх 10 орчим хөндлөнгийн салбар дэлгүүрүүдэд борлуулдаг.
4. S компани нь тусгайлсан сурталчилгааны болон борлуулалтын арга, үйл ажиллагаа явуулдаггүй боловч, өөрсдийн боловсруулсан борлуулалтын төлөвлөгөөний дагуу A бүтээгдэхүүнийг тодорхой хэмжээгээр хадгалан, X улсад дамжуулан борлуулж байгаа.

【Асуулт】

1. P компани ба S компани хооронд хийгдэж буй A бүтээгдэхүүний үнэ шилжилт дээр хяналт шалгалт хийх тохиолдолд, үнэ шилжилт тооцох ямар аргыг (TRM) ашиглах вэ. Мөн энэ тохиолдолд, аль компанийг шалгалтанд хамруулах (Tested Party) хэрэгтэй вэ.
2. Сонгосон TRM-ийг ашиглан, сунгасан гарын үнийг (ALP) тооцох тохиолдолд, ямар зүйлсийг анхаарч, ашгийн түвшний шалгуур үзүүлэлт (Profit Level Indicator: PLI) болгон ашиглах вэ.

4

Case 2



5

Case 2



【Бодлогын нөхцөл】

1. Японы P компани нь A бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт хийдэг бөгөөд 10 жилийн өмнө A бүтээгдэхүүнийг борлуулах S охин компанийг X улсад байгуулсан.
2. A бүтээгдэхүүн нь P компанийн судалгаа шинжилгээний үр дүнд, бие даасан технологийг (биет бус хөрөнгө) ашиглан үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн юм.
3. P компани нь S компанид A бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой патент болон үйлдвэрлэлийн ноухауг ашиглах зөвшөөрөл өгсний хариуд S компаниас ашиглалтын хураамж (Royalty) авдаг.
4. S компани нь X улсад түүхий эд худалдан авч, A бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн тус улсын хөндлөнгийн салбар дэлгүүрүүдэд борлуулдаг.
5. P компани ба S компанийн хооронд бараа бүтээгдэхүүнээрх хөрөнгийн худалдах худалдан авах ажил гүйлгээ хийгддэггүй.
6. P компани нь A бүтээгдэхүүнийг S компанид борлуулж, S компани нь X улсын доторх 10 орчим хөндлөнгийн салбар дэлгүүрүүдэд борлуулдаг.
7. S компани нь тусгайлсан сурталчилгааны болон борлуулалтын арга, үйл ажиллагаа явуулдаггүй боловч, өөрсдийн боловсруулсан борлуулалтын төлөвлөгөөний дагуу A бүтээгдэхүүнийг тодорхой хэмжээгээр хадгалан, X улсад дамжуулан борлуулж байгаа.

【Асуулт】

1. S компаниас P компанид төлдөг ашиглалтын хураамжийн үнэ шилжилт дээр хяналт шалгалт хийх тохиолдолд, ямар тооцооны арга ТРМ ашиглах вэ.
2. Сонгосон ТРМ-ийг ашиглан, сунгасан гарын үнэ ALP-ийг тооцох тохиолдолд, ямар зүйлсийг анхаарч, ашгийн түвшингийн шалгуур үзүүлэлт (PLI) болгон юуг ашиглах вэ.

6



Case 3


【Бодлогын нөхцөл】

1. Японы P компани нь A бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт хийдэг бөгөөд 10 жилийн өмнө A бүтээгдэхүүнийг борлуулах S охин компанийг Х улсад байгуулсан.
2. A бүтээгдэхүүн нь P компанийн судалгаа шинжилгээний үр дүнд, бие даасан технологийг (биет бус хөрөнгө) ашиглан үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн юм.
3. P компани нь S компанид A бүтээгдэхүүний а деталийг (P компанийн бие даасан технологийг ашиглан бүтээсэн гол хэсэг) борлуулахын зэрэгцээ, A бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой патент болон үйлдвэрлэлийн ноухауг ашиглах зөвшөөрөл өгсний хариуд S компаниас ашиглалтын хураамж (Royalty) авдаг.
4. S компани нь а деталь дээр бусад деталийг нэмж A бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, Х улсын хөндлөнгийн 200 –аад жижиглэнгийн борлуулагчдад худалддаг.
5. S компани нь олон тооны борлуулалтын ажилтныг ашиглан, тусгайлсан сурталчилгаа, борлуулалтын үйл ажиллагааг эрхэлж, хангалттай сайн жижиглэнгийн борлуулалтын сүлжээг бүрдүүлэн тогтвортой ажиллагааг хангаж байгаагаас, Х улсад энэ бүтээгдэхүүнийг хэрэглэгчид сайн мэддэг бөгөөд тодорхой хэмжээнд зах зээлийг эзэлж чадсан байна.


【Асуулт】

1. а деталь ба S компаниас P компанид төлдөг ашиглалтын хураамж дээр үнэ шилжилтийн хяналт шалгалт хийх тохиолдолд, ямар TPM аргаар тооцоо хийх вэ.
2. Сонгосон TPM-ийг ашиглан сунгасан гарын үнэ ALP-ийг тооцох тохиолдолд, ямар зүйлсийг анхарч авч үзэх ёстой вэ.

Case 3 (Reference)



Case 4



11

Case 4

【Бодлогын нөхцөл】


1. ~4. нь Case 3-ийн 1~4-тэй адил.
5. P компанийн төлөвлөлтөөр, дэлхий даяар том компани болох талаар сурталчилгаа хийгддэг бөгөөд энэхүү компанийн нэр, лого нь улс даяар бүгд мэддэг.
6. Мөн, P компанийн төлөвлөлтөөр, A бүтээгдэхүүний талаар дэлхий даяар телевиз, сэтгүүл, интернетээр өргөн хүрээнд сурталчилгаа хийгддэг бөгөөд X улсад ч энэ бүтээгдэхүүний талаар хүмүүс сайн мэддэг.
7. Нөгөө талаас, S компани нь олон тооны орлуулалтын ажилтнаар дамжуулан жижиглэнгийн борлуулагчид ба эцсийн хэрэглэгчдэд зориулсан төрөл бүрийн сурталчилгааны үйл ажиллагааг явуулж, жижиглэнгийн худалдааны сүлжээг сайтар бүрдүүлж чадсан байна.
8. Үүний үр дүнд, A бүтээгдэхүүн нь X улсын зах зээл дээр тодорхой хувь эзлэхийн хамт, тогтвортой үнээр борлуулагддаг.

【Асуулт】

1. Энэ жишээний хувьд ямар төрлийн биет бус хөрөнгө холбоотой байж болох вэ.
2. Энэхүү биет бус хөрөнгийг P компанийн бий болгосон ба S компанийн бий болгосон хөрөнгөд салгана уу.

12

Case 5



13

Case 5

【Бодлогын нөхцөл】

1. Японы P компани нь A бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, Японы дотоодод борлуулалт хийдэг бөгөөд 10 жилийн өмнө A бүтээгдэхүүнийг борлуулах S охин компанийг X улсад байгуулсан.
2. S компани нь A бүтээгдэхүүний борлуулалтаас гадна, X улсын доторх үйлдвэрлэгчээс B бүтээгдэхүүнийг худалдан авч, X улсын доторх хэрэглэгчдэд борлуулдаг.
3. A бүтээгдэхүүн нь P компанийн судалгаа шинжилгээний үр дүнд, бие даасан технологийг (биет бус хөрөнгө) ашиглан үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн юм.
4. P компани нь S компанид A бүтээгдэхүүний а деталийг (P компанийн бие даасан технологийг ашиглан бүтээсэн гол хэсэг) борлуулахын зэрэгцээ, A бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой патент болон үйлдвэрлэлийн ноухауг ашиглах зөвшөөрөл өгсний хариуд S компаниас ашиглалтын хураамж (Royalty) авдаг.
5. S компани нь а деталь дээр бусад деталийг нэмж A бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, X улсын хөндлөнгийн 200 –аад жижиглэнгийн борлуулагчдад худалддаг.
6. S компани нь олон тооны борлуулалтын ажилтныг ашиглан, тусгайлсан сурталчилгаа, борлуулалтын үйл ажиллагааг эрхэлж, хангалттай сайн жижиглэнгийн борлуулалтын сүлжээг бүрдүүлэн тогтвортой ажиллагааг хангаж байгаагаас, X улсад энэ бүтээгдэхүүнийг хэрэглэгчид сайн мэддэг бөгөөд тодорхой хэмжээнд зах зээлийг эзэлж чадсан байна.
7. P ба S компанийн ашиг, алдагдал дараах байдалтай болно.

14

Case 5

Company P profit and loss data

Sales of product A	200
Sales of part "a"	35
Royalties received	5
Total sales	240
Cost of sales of product A	95
Cost of sales of part "a"	25
Total cost of sales	120
Gross profit on sales	120
Product A selling expenses	48
Part "a" selling expenses	2
R&D cost	25
Administrative expenses	15
Total selling and administrative expenses	90
Operating profit	30

Company S profit and loss data

Sales of product A	110
Sales of product B	500
Total sales	610
Purchases of part "a"	35
Other costs of product A	10
Purchases of product B	480
Royalties paid	5
Total cost of sales	530
Gross profit on sales	80
Product A selling expenses	15
Product B selling expenses	5
Administrative expenses	10
Total selling and administrative expenses	30
Operating profit	50

15

Case 5

【Асуулт】

Энэ жишээний хувьд, үлдэгдэл ашиг хуваах арга (RPSM)-ийг ашиглан, P компанийн үнэ шилжилтэд татвар ногдуулах тохиолдолд, дараах 1~8-д заасан асуултанд хариулна уу.

1. P ба S компанийн ашиг, алдагдлын мэдээлэлд үндэслэн, хоёр компанийн хооронд хийгдсэн гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээтэй холбоотой P ба S компанийн үйл ажиллагааны ашгийг тус тус тооцох. Энд, P компанийн судалгаа шинжилгээний зардал ба удирдлагын зардал, S компанийн удирдлагын зардалд хоёр тал хооронд хийгдсэн гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээтэй холбоотой зардал ба бусад зардал багтаж байгаа.
2. Хуваагдах ашгийг (Profits to be split) тооцно уу.

16

Case 5

【Асуулт】

3. P компани ба S компанийн үндсэн ашгийг (Routine Profits) тооцохын тулд эдгээр компаниудтай харьцуулагдах аж ахуйн нэгжүүдийг (Comparable Corporations) тус тус сонгох шаардлагатай бөгөөд энэ үед юуг анхаарах ёстой вэ.
4. P ба S компаниудын үндсэн ашгийг тооцоходоо, эдгээр компаниудын ашгийн түвшний шалгуур үзүүлэлтээр (PLI) тус тус юуг ашиглах вэ.
5. P ба S компанийн харьцуулагдах аж ахуйн нэгжийн PLI нь тус бүр 12% ба 4% байсан тохиолдолд, P компани ба S компанид хуваарилагдах үндсэн ашгийг тус бүр тооцно уу.
6. Үлдэгдэл ашгийг (Residual Profits) тооцно уу.

17

Case 5

【Асуулт】

7. Үлдэгдэл ашиг үүсэх хүчин зүйл нь P компанийн патентийн эрх ба үйлдвэрлэлийн ноухау, мөн S компанийн сурталчилгаа, борлуулалтыг дэмжих үйл ажиллагаа болох нь тодорхой бол, гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээтэй холбоотой дараах мэдээллээс, ①Үлдэгдэл ашгийн хуваарилалтын харьцаа (P компани:S компани) болон②P ба S компанид тус бүр хуваарилагдах үлдэгдэл ашгийг тооцно уу.
 - P компанийн хуваарилалтын дараах судалгаа шинжилгээний зардал: 9
 - S компанийн А бүтээгдэхүүний борлуулалтын зардлын доторх сурталчилгааны зардал: 6
8. P компанид хийгдэх үнэ шилжилтийн тохируулгыг (TP Adjustment Amounts) тооцно уу.

18

Олон улсын татвар ногдуулалтын тусгай сургалт

(2018.11.27 - 11.30)

	11/26	11/27	11/28	11/29	11/30
	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
09:00-12:00	Амралтын өдөр	(Сургалтын өмнөх шалгалт) Монгол улсын жишээн дээр ажиллах	Монгол улсын жишээн дээр ажиллах	Монгол улсын жишээн дээр ажиллах	Монгол улсын Олон улсын татвар ногдуулалтын цаашдын асуудал-Үнэ шилжилтийн хяналт шалгалтын кэис-
		Кодера, Ишигүро	Кодера, Ишигүро	Кодера, Ишигүро	Кодера
13:00-16:00	Амралтын өдөр	Монгол улсын жишээн дээр ажиллах	Монгол улсын жишээн дээр ажиллах	Монгол улсын жишээн дээр ажиллах (Сургалтын дараах шалгалт)	Нэгтгэсэн хэлэлцүүлэг
		Кодера, Ишигүро	Кодера, Ишигүро	Кодера, Ишигүро	Кодера

Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийн жагсаалт

№	Нэрс	Харьяа нэгж
1	Ч.Эрдэнэчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУАБ
2	Х.Сувд-Эрдэнэ	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
3	Н.Жаргалцэцэг	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
4	Ж.Цэрэнцоо	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
5	А.Сувдаа	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
6	Г.Энхжин	ТЕГ-ын Татварын орлогын газрын ТУБ
7	Ц.Баярмаа	ТЕГ-ын Дотоод аудитын газрын ТУБ
8	Н.Туул	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
9	Ш.Ундраа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
10	Б.Батчимэг	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
11	С.Гүнжинлхам	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
12	Д.Батжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУАБ
13	Ц.Дэлгэрмаа	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
14	Г.Бямбасүрэн	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
15	П.Отгонсүрэн	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
16	Н.Болорчимэг	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
17	Н.Мөнхдаваа	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
18	Н.Хандхүү	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
19	Ц.Ишжамц	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ

20	Б.Төгсжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
21	Ш.Энхжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
22	Ё.Мөнхбат	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
23	Б.Уранцэцэг	УТОХГ-ын Эрсдэл, статистикийн хэлтсийн ТУБ
24	Ц.Түвшинбаяр	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
25	Г.Банзрагч	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
26	Х.Алтанхүү	УТОХГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
27	О.Цэнд-Аюуш	НТГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтэс
28	Ж.Эрдэнэбүрэн	НТГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
29	Ч.Лхамрагчаа	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
30	Д.Солонго	СБД-ын Татварын хэлтсийн ТУБ
31	Ц.Ундармаа	СХД-ын Татварын хэлтсийн ТУБ
32	Б.Ариунчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
33	Ж.Уянга	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
34	С.Наранбаатар	Дорнод аймгийн Татварын хэлтсийн ТУБ
35	Д.Наранцэцэг	Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн дарга
36	С.Дүүбаяр	Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн ТУБ

МОНГОЛ УЛСЫН ҮШ-ИЙН ЖИШЭЭ

ЛСА төслийн зөвлөх Кодера

Үнэ шилжилтэд гарч болох асуудлуудыг нэгтгэсэн жишээ 1

- Өмнөговь аймагт байрлах Х улсын Биг Экс ХХК (ВХ компани)-ийн 100%-ийн хөрөнгө оруулалттай Монгол Улсын Литле Экс ХХК (LX компани) нь ашигт малтмалын олборлолт хийдэг.
- KODERA байцаагч нь LX-д хийсэн урьдчилсан шалгалтаар LX-ийн ВХ-тэй хийсэн борлуулалтын хэмжээ 400, мөн LX-ийн үйл ажиллагааны ашиг 40 болохыг тогтоосон. Гэхдээ ВХ-ийн энэ талаарх мэдээлэл тодорхойгүй байсан. LX-ийн харилцагч нь ВХ-ээс өөр компани байхгүй.
- Ажлын байранд хийсэн хяналт шалгалтаар LX компанийн санхүү хариуцсан ажилтнаас энэ талаар тодруулга авахад ВХ-ийн нийт үйл ажиллагаатай хамааралтай тоо, өөрөөр хэлбэл дэлхий даяарх борлуулалт 1000, үйл ажиллагааны ашиг нь нэгдсэн байдлаар 10 гэдгээс өөр хариулт өгөөгүй.
- Байцаагчаас ҮШ-ийн асуудал нь дэлхий дахины жишиг болсон зүйл хэмээн LX-ийн санхүүгийн ажилтанд ойлгуулсны дараа ВХ-ийн LX-д хамаарах борлуулалт 300 бөгөөд үйл ажиллагааны ашиг нь 60 гэж тодруулсан тайлбар хийсэн.

Жишээ үргэлжлэл

- KODERA байцаагч, ажлын байранд хийсэн хяналт шалгалтаар LX ба BX-д биет бус хөрөнгө байгаа эсэхийг тодорхойлоход LX ба BX-ийн R&D зардал нь тус бүр 40, 20 болох нь тодорхой болсон.
- Байцаагч энэ хүртэлх процессоор Монголын LX ба X улсын BX-ын хооронд хийгдсэн ажил гүйлгээний хувьд аль нэг тохирох ҮША-ыг ашиглах ёстой гэж үзсэн.
- ТЕГ-ын мэдээллийн сангаас биет бус хөрөнгө бүхий хэд хэдэн гуравдагч хуулийн этгээдийн үйл ажиллагааны ашгийн түвшинг статистик аргаар тооцох боломжтой болохыг мэдэж байсан тул мэдээллийн сангаас компаниудын үйл ажиллагааны ашгийн хувийг LX нь 6.25%, BX нь 5% гэж тогтоосон. Энэхүү арга нь цорын ганц ҮША биш боловч харилцан хамааралтай компаниудын аль аль нь биет бус хөрөнгөгүй тохиолдолд Японд ч их хэрэглэгддэг ҮША болохыг KODERA байцаагч мэддэг байсан.

Жишээ үргэлжлэл

- Ажлын байранд хийсэн шалгалтын үеэр байцаагч энэ тохиолдолд тодорхой нэг ҮША-аар татвар ногдуулахаар шийдсэн. LX-ын гарган өгсөн ҮШ-ийн баримтжуулалтын нэг болох локал файлд мэдүүлсэн мэдээлэлдээ үндэслэн LX компани нь CP аргыг сонгосон байсан.
- Татвар ногдох орлогын үнийн дүнг явцын байдлаар LX-д мэдэгдэхэд үйлдвэрлэл, импортын үйл ажиллагаа эрхэлдэг тул локал файлд ашигласан CP аргыг ашиглах ёстой гэсэн байр суурь илэрхийлж байсан.
- Гэвч KODERA байцаагч CP аргыг ашиглахад харьцуулагдах ажил гүйлгээ байх шаардлагатай бөгөөд LX-тэй адил төрлийн ашигт малтмалын олборлолт хийдэг, биет бус хөрөнгө бүхий ажил гүйлгээ олдохгүй хэмээн LX компанитай санал зөрөлдсөн.
- Байцаагч эцсийн байдлаар LX компанийн тайлагнасан орлогыг 25-аар нэмэгдүүлж татвар ногдуулсан.

Жишээ үргэлжлэл

- KODERA байцаагч энэхүү 25-ын орлогод татвар ногдуулахдаа үнэ шилжилтийн татвар болох тул давхар татварын гэрээний дагуу харилцан тохиролцоог харилцагч улстай хийхгүй бол татварын давхардлыг шийдвэрлэх боломжгүй болохыг LX компанид тайлбарласан. Мөн гомдол гаргах, нэхэмжлэл гаргах процедурын талаар тайлбарласан.
- LX компани нь ҮШ татвар ногдуулалттай санал нэгдэхгүй байгаа бөгөөд харилцан тохиролцооны аргыг сонгож энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр ВХ компанитай нэг зэрэг харилцан тохиролцооны хүсэлт гаргасан.
- Гэвч энэхүү тохиролцоо бүтээгүй. Х улсад ҮШ-ийн татвар ногдуулалттай холбоотой нийцүүлэх тохиргооны зүйл заалт байхгүй тул Монгол улсын ТЕГ-аас Х улстай тохиролцооноос татгалзсан. Татварын гэрээнд зохицуулалтын заалт байгаа боловч Х улсын дотоодын хуульд заалт байхгүйгээс тохиролцоо хийсэн тохиолдолд ч Монгол улсын татвар ногдох орлогыг бууруулах гэсэн Х улсын нийцүүлэх тохиргоог хэрэгжүүлэх боломжгүй байх эрсдэл байна гэж үзсэн.

Жишээ үргэлжлэл

- Харилцан тохиролцоогоор асуудлыг шийдвэрлэх боломжгүй байсан тул LX компаниас Монгол Улсын татварын маргаан таслах зөвлөлд хандсан.
- Гэвч маргаан таслах зөвлөлөөс ТЕГ-ын татвар ногдуулалтыг зөв гэсэн шийдвэр гаргасан.
- LX компаниас энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй хэмээн шүүхэд нэхэмжлэл гаргасан. ВХ компанийн LX-тэй харьцах тоон үзүүлэлт (үйл ажиллагааны ашгийн түвшин) алдаатай байгаа бөгөөд татвар ногдох орлогыг бууруулах (татвар ногдох орлогын 50%) нэхэмжлэлийг шүүхэд гаргаж ялсан ба ТЕГ ч энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрснөөр энэ асуудал шийдэгдсэн.

Үнэ шилжилтэд гарч болох асуудлуудыг нэгтгэсэн жишээ (Асуулт)

- Локал файлиар LX компани CP аргыг сонгосон тул байцаагч зөвхөн энэ ҮША-ыг авч үзэх ёстой бус уу.
- KODERA байцаагчийн ашигласан арга юу болох.
- KODERA байцаагч нь SG&A expense, FOB • CIF зэрэг харьцуулагдах боломжийн дагуух зөрүүний тохиргоо хийгээгүй бус уу.
- Эхний татвар ногдох орлого 25-ийн тооцооны агуулгыг нарийвчлан үзүүлнэ үү.
- Харилцан тохиролцоогоор яагаад үнэ шилжилтийн давхар татвар ногдуулалт шийдвэрлэгдэх вэ.
- Энэ тохиолдолд яагаад харилцан тохиролцоо амжилттай болоогүй вэ.
- Шүүхийн нэхэмжлэлээр 50% буурсан тул татварын байгууллага яах ёстой вэ.
- Шүүхийн шийдвэрээр үнийн дүн буурсан тул LX компанийн хувьд “сэтгэл хангалуун” болсон бус уу.

ҮШ хяналт шалгалтын процесс 1

- 1 Бэлтгэл судалгаа (Байцаагч өөрийн ажлын байрандаа хийх)
 - Татварын тайланг шалгах ➔ Гадаад ажил гүйлгээ байгаа эсэх
 - ★ АРА (Урьдчилсан үнийн гэрээ) байгаа эсэх (Япон)
 - ★ Хавсралт 17(4)-ыг шалгах ➔ ★ Хяналт шалгалтанд хамруулах ААН-ыг сонгох (Япон)
 - ★ ҮШ баримтжуулалтыг авч үзэх ➔ ялангуяа локал файлыг авч үзэх
 - ★ Биет бус хөрөнгө байгаа эсэх, агуулгыг хянах ➔ ҮША-ыг авч үзэх (best method)

ҮШ хяналт шалгалтын процесс 2

2 Ажлын байранд хийх шалгалт Эхэн шат

Компани дээр байрлан, гадаад ажил гүйлгээний зураглалыг гаргуулж, тайлбар авна.

Байцаагч өөрийн зураглалыг хийж, ОУ-ын ажил гүйлгээний талаар нэгдсэн ойлголт авна.

Хамааралтай ажил гүйлгээний асуудлыг тодорхойлох ➔ ҮША-ыг тогтох

Харьцуулагдах ажил гүйлгээг сонгох ➔ Мэдээллийн сан ашиглах

comparability буюу харьцуулагдах байдлыг хянах

Зөрүүгийн тохиргоог тооцох ➔ Татвар ногдох орлогыг тооцох

3 Ажлын байранд хийх шалгалт Дунд шат

Татвар төлөгчид явцыг танилцуулах ➔ татвар төлөгчтэй маргаантай асуудлуудын (ҮША, зөрүүний тохиргоо гэх мэт) талаар хэлэлцэх

4 Ажлын байранд хийх шалгалт Төгсгөлийн шат

Залруулгын агуулгыг татвар төлөгчид тайлбарлах

Татвар ногдуулалтын дараах татвар төлөгчийн авах арга хэмжээ, эрхийн талаар зөвлөгөө өгөх (харилцан тохиролцоо, арбитрайн шүүх, маргаан таслах зөвлөл, шүүхэд нэхэмжлэл гаргах) Харилцагч талын улсад нийцүүлэх тохиргооны тогтолцоо байдаг эсэхийг тодруулах

ҮШ-ийн хяналт шалгалтын процесс 3

харилцан тохиролцоо, маргаан таслах, шүүхийн нэхэмжлэл

• Татвар төлөгчийн хүсэлтээр хийх харилцан тохиролцоо

Татварын гэрээний дагуу давхар татвар ногдуулалтаас сэргийлэх зорилгоор гадаад харилцан хамаарал бүхий этгээдийн оршин суух улстай хэлэлцээр хийх ➔ Санал нэгдсэн үнийн дүнгээр харилцагч улс нийцүүлэх тохируулга хийнэ.

Харилцагч улсын тухайд дотоодын хуулинд нь нийцүүлэх тохиргоо хийх боломжгүй байвал санал нэгдэхэд хүндрэлтэй (Татварын гэрээний заалтыг дангаар ашиглах нь хангалттай бус) ➔ Монгол улсад нийцүүлэх тохиргооны заалт байдаггүй тул харилцагч улс ҮШ татвар ногдуулсан тохиолдолд харилцан тохирч санал нэгдэхээс татгалзах магадлалтай тул **Цаашид зайлиггүй энэ талаар хуулиндаа тусгах шаардлагатай!!!**

• Татвар төлөгч гомдол гаргах

Хэчнээн жил болоод ч харилцан тохиролцоогоор санал нэгдэх боломжгүй байгаа тохиолдолд Япон Улсын хувьд, татвар төлөгч нь дотоодын хуулийн дагуу гомдол гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Харилцан тохиролцоо эхлэхтэй зэрэгцүүлэн татвар төлөгч гомдол гаргадаг ба маргаан таслах зөвлөл нь харилцан тохиролцооны явцтай уялдуулан, гомдол барагдуулалтыг түр зогсоодог. Нэхэмжлэлийн тухайд, маргаан таслах зөвлөлийн шийдвэр, процедурын дагуу хийгддэг.

ҮШ-ийн бэлтгэл ажлын гол асуудал 1 (Үйл ажиллагааны ашгийн түвшин)

- Монголын хяналт шалгалтын байцаагч нь компани дээр очиж шалгалт хийхийн өмнө өөрийн ажлын байранд бэлтгэл судалгаа хийх ба хяналт шалгалтанд хамруулах ААН-ыг **харилцан хамааралтай этгээд хоорондын үйл ажиллагааны ашгийн түвшинг харьцуулах** замаа сонгох шаардлагатай. (гадаадын ААН-ын үйл ажиллагааны ашгийн түвшин бэлтгэл судалгааны шатанд тодорхой бус байгаа бол ажлын байранд хийх шалгалтын хамгийн эхэнд тодруулга хийх хэрэгтэй.)

Жишээлбэл,

Монголын охин компанийн үйл ажиллагааны ашгийн түвшин 3%

Гадаадын ААН-ын зөвхөн Монголын охин компанитай хийсэн ажил гүйлгээнд хамаарах үйл ажиллагааны ашгийн түвшин 20%

➔ *Монголын охин компанийн орлого гадаадын ААН-д шилжиж байгаа нь тодорхой байна. !*

ҮШ-ийн бэлтгэл ажлын гол асуудал 2 (Биет бус хөрөнгө ба ҮША)

- Жишээлбэл, Монголын охин компани уул уурхайн олборлолтын эрхийн хүрээнд патентын хэлбэрээр биет бус хөрөнгөтэй бол гадаадын төв компани нь ямар нэг хэлбэрийн биет бус хөрөнгөтэй байдаг. Хоёр тал биет бус хөрөнгөтэй байгаа тохиолдолд,
 - ➔ ҮША-аар RPSM-ыг эхлээд авч үзэх хэрэгтэй!
- Бараа бүтээгдэхүүний үнэ тодорхой бол CUP арга, Монгол талын охин компанид биет бус хөрөнгө байхгүй бол TNMM эсхүл PS аргыг авч үзэх боломжтой.

★ APA (Advanced Pricing Agreement) Урьдчилсан үнийн гэрээ байгаа эсэх

- Урьдчилсан үнийн гэрээний тогтолцооны тухайд татвар төлөгчийн хүсэлтээр, гадаад харилцан хамааралтай этгээдтэй хийх ажил гүйлгээтэй холбоотой бодит үнэ тооцох арга болон тодорхой агуулгыг татварын байгууллагаас урьдчилан баталгаажуулах тогтолцоо юм.
- Энэхүү тогтолцооны хүрээнд татвар төлөгч ААНОАТ-ын тайлангаа сэтгэл амраар гаргах ба нөгөө талаас татварын байгууллагаас үнэ шилжилтийн хяналт шалгалт хийхгүйгээр үнэ шилжилтийн татварын тогтолцоог зохистойгоор хэрэгжүүлэх боломжоор хангагддаг.
- Урьдчилсан үнийн гэрээний хамрах хугацаанд үнэ шилжилтийн татварын хяналт шалгалт хийдэггүй.

★ Хавсралт хүснэгт 17(4) (Гадаад харилцан хамааралтай этгээдтэй холбоотой мэдэгдэл)

- Японы хяналт шалгалтын байцаагч хамгийн түрүүнд энэ хүснэгтийг үздэг !!!
 - Энэ хүснэгтийг авч үзсэнээр, өндөр орлого бүхий гадаад харилцан хамааралтай этгээдийг зорилтот бүлэг болгодог.
 - Татварын байгууллага нь энэ хүснэгтээр мэдээллийн сан үүсгэн хянах замаар дунд хугацааны ерөнхий хандлага төлөвийг тодорхойлдог.
 - Энэхүү хүснэгтийг ҮШ баримтжуулалтын тогтолцоо нэвтрэхээс өмнө Японы татварын байгууллагаас татвар төлөгчөөр татварын тайландаа тусгуулж ирсэн бөгөөд **Маш шалгарсан арга юм.!!!**
 - Хүснэгтийн зорилго: **Төв ба охин компанийн ашгийн байдлыг тодорхойлох (⇒ Энэ нь хамгийн чухал !!!)**
 - Хүснэгтийн агуулга:
 - Төв компанийн (эсхүл охин компани) танилцуулга, борлуулалтын хэмжээ, үйл ажиллагааны ашиг**
 - Төв компани ба охин компанийн хоорондын ажил гүйлгээний байдал, үнийн дүн
1. Бараа материалаарх хөрөнгийн худалдах, худалдан авах үнэ
 2. Үзүүлсэн ажил, үйлчилгээний үнэ хөлс
 3. Биет бус хөрөнгийн ажил гүйлгээний үнэ төлбөр
 4. Зээлийн хүүгийн төлбөр

★ҮШ-ийн хяналт шалгалтанд хамрагдах хуулийн этгээдийг сонгох 1
(Хүснэгт 17(4)-ээс олж авсан мэдээлэлд үндэслэн)

- Дараах тохиолдолд сонгогдох магадлалтай:
- Гадаад харилцан хамааралтай этгээдийн үйл ажиллагааны ашгийн түвшин нь хяналт шалгалтанд хамрагдах ААН-ээс өндөр байх
- Гадаад харилцан хамааралтай этгээдийн үйл ажиллагааны ашгийн түвшин нь адил төрлийн үйл ажиллагаа эрхлэгчийнхээс өндөр байх
- Гадаад харилцан хамааралтай этгээдийн борлуулалтын хэмжээ жил бүр өссөн байх
- Гадаад харилцан хамааралтай этгээд нь үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг байж, хяналт шалгалтанд хамрагдагчид эрхийн шимтгэл төлөөгүй байх

★ҮШ-ийн хяналт шалгалтанд хамрагдах хуулийн этгээдийг
сонгох 2
(нээлттэй мэдээлэлд үндэслэн)

- Дараах тохиолдолд сонгогдох магадлалтай:
- Хяналт шалгалтанд хамрагдах хуулийн этгээд алдагдалтай байгаа
- Үнэт цаасны тайлангийн «Хамаарал бүхий компанийн нөхцөл байдал» хэсэгт бичигдсэн охин компани нь Хүснэгт 17(4)-т тусгагдаагүй.
- Сонин хэвлэл дээр «ОО улсад үйлдвэрлэл хийх охин компани байгуулсан» «Гадаад дах охин компанийн үйл ажиллагаа сайн байгаа» «Төв компани нь гадаад дах охин компаниа дэмжиж ажилладаг» гэсэн мэдээлэл гарсан.

★ ҮШ-ийн хяналт шалгалтанд хамрагдах хуулийн этгээдийг сонгох 3

(Татварын ердийн хяналт шалгалтын мэдээлэлд үндэслэн)

- ААН-д хийх ердийн хяналт шалгалтаар дараах бодит байдлыг илрүүлсэн тохиолдолд ҮШ-ийн хяналт шалгалтанд хамруулах ААН-ээр сонгогдох магадлалтай.
- Гадаад дах охин компанидаа бага хүүтэй зээл олгосон, эсхүл зээлийн батлан даалт хийсэн бол.
- Гадаад дах охин компани нь тухайн улсын татварын байгууллагаас татварын ногдуулалт хийгдсэн бол.
- Охин компанид томилолтоор ажиллагсдын зардлыг бүх үнийн дүнгээр төв компани хариуцдаг бол
- Гүйцэтгэлийн үр дүн муутай байгаа гадаад дах охин компанидаа тусламж үзүүлэх зорилгоор, маш хямдаар түүхий эд экспортолдог бол.

★ ҮШ-ийн баримтжуулалтын агуулга (Мастер файл)

- ҮШ-ийн баримтжуулалтын тогтолцоог 2016 онд нэвтрүүлсэн.
- 1) **Мастер файл (Үйл ажиллагааны тайлан) гаргах үүрэгтэн**
2-оос дээш гишүүн компанитай бөгөөд тайлант оны өмнөх жилийн нийт орлого 100 тэрбум иенээс дээш групп компани
- 2) **Мастер файлд бичигдэх зүйлс**
«Үйл ажиллагааны байдал» «Чиг үүрэг•эрсдэл» «Биет бус хөрөнгө, группийн доторх санхүүжилт, харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний үнийг тогтоох арга»
«АРА (урьдчилсан үнийн гэрээ)»-тэй холбоотой асуудлуудын талаар
- 3) **Тайлангийн хэл**
Тайланг Япон ба Англи хэлээр бэлтгэнэ. (Гадаадын татварын байгууллагад гарган өгөх Англи хэл дээрх мастер файлыг ашиглах боломжтой)

★ҮШ-ийн баримтжуулалтын агуулга (CbC тайлан)

- 1) **Улс улсаарх тайлан (CbC/Country by Country) тайлан гаргах үүрэгтэй этгээд**
2-оос дээш гишүүн компанитай бөгөөд тайлант оны өмнөх жилийн нийт орлого 100 тэрбум иенээс дээш групп компани
- 2) **Улс улсаарх тайланд тусгах зүйлс**
Гишүүн компани тус бүрийн үйл ажиллагаа эрхэлдэг улс, бүс нутагт хамаарах тоон мэдээлэл, борлуулалтын хэмжээ, төлсөн татварын дүн, үндсэн хөрөнгө, ажиллагсдын тоо, үндсэн үйл ажиллагаа гэх мэт
- 3) **Тайлангийн хэл**
Зөвхөн англи хэл (Улс улсаарх тайлангийн тухайд, гадаадын татварын байгууллагатай мэдээлэл харилцан солилцохоор төлөвлөдөг)

★ҮШ-ийн баримтжуулалтын агуулга (локал файл LF)

- 1) **Локал файл гаргах үүрэгтэй этгээд**
Дотоодын хуулийн этгээд ба гадаад харилцан хамааралтай этгээд хоорондын ажил гүйлгээний үнийн дүн 5 тэрбум иенээс дээш (биет бус хөрөнгийн ажил гүйлгээ нь 300 сая иенээс дээш)байх дотоодын ААН
- 2) **Улс улсаарх-д тусгах зүйлс**
Сунгасан гарын үнийг (ALP) тооцоход шаардлагатай мэдээлэл
➔Мастер файл нь «ерөнхий танилцуулга» бөгөөд Улс улсаарх тайлан нь «Нэгдсэн тоон мэдээлэл» болох тул тухайлсан харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний бодит үнийг тооцоход хангалтгүй бөгөөд энд Локал файлын ач холбогдол оршино. !!!
- 3) **Тайлангийн хэл**
Тайланг ямар хэл дээр бэлтгэхийг заадаггүй. Гэхдээ, гадаад хэл дээр гарган өгсөн тайлангийн орчуулгыг татварын байгууллагаас шаардах эрхтэй.

★ Локал файл дээр ажиллах (Татвар төлөгчийн ҮША-ийг авч үзэх)

Баримтжуулалтын 3 бичиг баримтын дотроос, ялангуяа локал файл дээр төвлөрч ажилладаг бөгөөд учир нь татвар төлөгчийн хүсэлт гаргасан ҮША-ийн талаар энд тайлбарласан байдаг.

Татвар төлөгчийн ҮША нь зохистой эсэхийн талаар сайтар хянаана.

ҮШ-ийн баримтлах чиглэл 2-5(2)

「Хуулийн этгээд нь сунгасан гарын үнийг тооцоолдог тохиолдолд энэхүү тооцооны бичиг баримтад үндэслэн сунгасан гарын үнэ тооцоолох боломжтой эсэх, энэ бичиг баримтаас өөр зүйл нэмж гаргуулах шаардлагатай эсэхийг тодорхойлно.」

Татварын хяналт шалгалтын байцаагч нь хангалтгүй гэж үзвэл татвар төлөгчийн гарган өгсөн бичиг баримтаас өөр, сунгасан гарын үнэ тооцоход шаардлагатай бичиг баримтыг шаардана.

★ Локал файлийг авч үзэхэд анхаарах 5 зүйлс

- Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний мэдээлэл
- Бодит үнийн мэдээлэл
- Ашиг хуваах аргын талаарх мэдээлэл
- Ажил гүйлгээнүүдийн мэдээлэл
- Зөрүүгийн тохиргооны мэдээлэл

ҮШ-ийн ажлын байран дах шалгалтанд анхаарах зүйлс 1 (Үйл ажиллагааны ашгийн түвшин)

- Гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагааны ашгийн түвшин нь бэлтгэл буюу урьдчилсан судалгааны шатанд тодорхойгүй байсан бол ажлын байран дах шалгалтын үед хамгийн эхэнд асууж тодруулах хэрэгтэй!

Жишээ

Монголын охин компанийн үйл ажиллагааны ашгийн түвшин 3%

Гадаадын ААН-ын зөвхөн Монголын охин компанитай хийсэн ажил гүйлгээнд хамаарах үйл ажиллагааны ашгийн түвшин 20% (Охин компаниас төв компанийн үйл ажиллагааны ашгийн түвшинг асууж тодруулна)

➔ Монголын охин компанийн орлого гадаадын ААН-д шилжиж байгаа нь тодорхой байна. !

ҮШ-ийн ажлын байран дах шалгалтанд анхаарах зүйлс 2 (Биет бус хөрөнгө ба ҮША)

- Жишээлбэл, Монголын охин компани уул уурхайн олборлолтын эрхийн хүрээнд патентын хэлбэрээр биет бус хөрөнгөтэй бол гадаадын төв компани нь ямар нэг хэлбэрийн биет бус хөрөнгөтэй байдаг. Хоёр тал биет бус хөрөнгөтэй байгаа тохиолдолд,
 - ➔ ҮША-ээр RPSM-ыг эхлээд авч үзэх хэрэгтэй!
- RPSM-ийг ашиглахаар шийдсэн бол охин компани ба төв компанийн биет бус хөрөнгийг нарийвчилан судлах хэрэгтэй. R&D зардал ба сурталчилгааны зардал
- Q Яагаад?
- Бүтээгдэхүүний үнэ тодорхой бол CUP арга, Монголын охин компани биет бус хөрөнгөгүй бол TNMM эсхүл PS аргыг ашиглах боломжтой.

ҮШ-ийн ажлын байран дах шалгалтанд анхаарах зүйлс 3 (TNMM ба мэдээллийн сан)

- Жишээлбэл, Монголын охин компани нь уул уурхайн олборлолтын эрхийн хүрээнд патентын хэлбэрээр биет бус хөрөнгө эзэмшдэггүй бөгөөд төв компани болох гадаадын хуулийн этгээд нь биет бус хөрөнгөтэй эсэх нь мэдэгдэхгүй байгаа тохиолдолд энэхүү харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээнд ямар ҮША ашиглах вэ?
➔Энэ тохиолдолд TNMM-ийг авч үзэх хэрэгтэй. Гэхдээ **TNMM-д хамаарах хуулийн этгээд нь биет бус хөрөнгөгүй байх нөхцөлтэй.**
- Ажлын байранд хийх шалгалтын үед TNMM-ийг ашиглахаар шийдсэн бол охин компанийн үйл ажиллагааны ашгийн түвшинг зөвөөр тооцно. Монголын охин компани болох тул Монгол Улсын доторх (биет бус хөрөнгөгүй)хуулийн этгээдийн (ТЕГ-ын эрдэс баялгийн хэлтэс)мэдээллээс үйл ажиллагааны ашгийн түвшинг тооцно. (дундаж утга)
- Гадаадын төв компани нь биет хөрөнгөгүй тохиолдолд, үйл ажиллагааны ашгийн түвшинг мэдээллийн сангаас тооцоолсон ч болно. Мэдээллийн сангийн ашиглалтын үндсийг нийлүүлэгч компаниудын сургалтаар дамжуулан суралцах хэрэгтэй.
- Бүтээгдэхүүний үнэ тодорхой бол CUP арга, Монголын охин компани нь ашигт малтмал экспортлогч бол CP аргыг ашиглах боломжтой.

**Олон улсын татвар ногдуулалтын тусгай сургалт
болон давтан сургалтын хөтөлбөр**

(2019.3.18 - 3.22)

	3/18	3/19	3/20	3/21	3/22
	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
	Нийт байцаагч нарт		Давтан сургалт (япон улсад зохион байгуулсан сургалтад хамрагдаагүй байцаагч нарт)		
09:00-12:00	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (case study)	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (case study)	Япон улсад зохион байгуулсан сургалтад хамрагдсан байцаагч нарын тайлан сургалт	Япон улсад зохион байгуулсан сургалтад хамрагдсан байцаагч нарын тайлан сургалт	Давтан сургалт
	Тажино, Ишигуро	Тажино, Ишигуро	Байцаагч нар	Байцаагч нар	Кодера
13:00-16:00	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (case study)	Үнэ шилжилтийн татварын тогтолцоо (case study)	Япон улсад зохион байгуулсан сургалтад хамрагдсан байцаагч нарын тайлан сургалт	Япон улсад зохион байгуулсан сургалтад хамрагдсан байцаагч нарын тайлан сургалт	Нэгтгэсэн хэлэлцүүлэг
	Тажино, Ишигуро	Тажино, Ишигуро	Байцаагч нар	Байцаагч нар	Кодера, Тажино


Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийн жагсаалт

№	Нэрс	Харьяа нэгж
1	Ч.Эрдэнэчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУАБ
2	Х.Сувд-Эрдэнэ	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
3	Б.Ариунчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
4	Н.Билгүүн	ТЕГ-ын Төрийн захиргааны удирдлагын газрын ТУБ
5	Н.Жаргалцэцэг	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
6	Ж.Цэрэнцоо	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
7	А.Сувдаа	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
8	Г.Энхжин	ТЕГ-ын Татварын орлогын газрын ТУБ
9	Ц.Баярмаа	ТЕГ-ын Дотоод аудитын газрын ТУБ
10	Ш.Ундраа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
11	Б.Батчимэг	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
12	С.Гүнжинлхам	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
13	С.Төгсжаргал	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУАБ
14	Ц.Дэлгэрмаа	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
15	Г.Бямбасүрэн	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
16	Д.Батжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУАБ
17	П.Отгонсүрэн	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ

18	Н.Болорчимэг	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
19	Н.Мөнхдаваа	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
20	Н.Хандхүү	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
21	Б.Төгсжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
22	Ш.Энхжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
23	Ё.Мөнхбат	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
24	Б.Уранцэцэг	УТОХГ-ын Эрсдэл, статистикийн хэлтсийн ТУБ
25	Г.Банзрагч	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
26	Х.Алтанхүү	УТОХГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
27	О.Цэнд-Аюуш	НТГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтэс
28	Ж.Эрдэнэбүрэн	НТГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
29	Ч.Лхамрагчаа	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
30	Л.Даваасүрэн	БЗД-ын Татварын хэлтсийн ТУБ
31	Д.Солонго	СБД-ын Татварын хэлтсийн ТУБ
32	С.Наранбаатар	Дорнод аймгийн Татварын хэлтсийн ТУБ
33	Д.Наранцэцэг	Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн дарга
34	С.Дүүбаяр	Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн ТУБ



TP Case Study



March 18-19, 2019
Prof. Hideaki ISHIGURO
Prof. Mikio TAJINO

1

Хичээлийн агуулга, арга барил


Үнэ шилжилттэй холбоотой нийт 8 жишээ байгаа бөгөөд эдгээр дээр багаар ажиллах болно.

Жишээ тус бүрийн ажил гүйлгээний зураглалыг ашиглан, «Урьдчилсан нөхцөл»-ийг сайтар уншаад, «Асуулт»-д хариулах.

Багаараа ойлголтоо нэгтгэн ярилцаад, санал нэгдсэн хариултыг бэлтгэн жишээ тус бүрээр нийтэд тайлбарлана.

2

Case 1



Case 1


【Урьдчилсан нөхцөл】

1. Японы Р компани нь усан онгоц үйлдвэрлэгч бөгөөд 10 жилийн өмнө далайн тээвэр эрхлэх S охин компанийг Х улсад байгуулсан.
2. Р компани нь S компанитай хийсэн усан онгоц үйлдвэрлэлийн гэрээний дагуу А усан онгоцыг үйлдвэрлэн S компанид шилжүүлэн өгсөн.
3. Мөн, Р компани нь Х улсад байх хөндлөнгийн Т компанитай усан онгоц үйлдвэрлэх гэрээ байгуулан, В усан онгоцыг зэрэгцүүлэн үйлдвэрлэж Т компанид шилжүүлэн өгсөн.
4. В усан онгоц нь А усан онгоцтой харьцуулаад, тоног төхөөрөмжийн тал дээр ялгаатай боловч, хэлбэр хэмжээ, бүтэц, функцын хувьд нэг төрөл юм.

【Асуулт】

1. Р ба S компанийн хооронд А усан онгоцын үнэ шилжилтийн хяналт шалгалт хийх тохиолдолд, эхлээд ямар ТРМ-ийг авч үзэх вэ.
2. Сонгосон ТРМ-ийг ашиглан ALP-ийг тооцохдоо, ямар асуудлыг авч үзэх шаардлагатай вэ.

Case 2



5

Case 2

【Урьдчилсан нөхцөл】


1. Японы Р компани нь тоног төхөөрөмжийн үйлдвэрлэн, борлуулагч компани бөгөөд 10 жилийн өмнө тоног төхөөрөмжийн деталь үйлдвэрлэдэг S охин компанийг Х улсад байгуулсан.
2. S компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд санхүүжилт шаардлагатай болсон.
3. Р компани ба S компанийн хооронд мөнгөн хэрэглээний зээлийн гэрээ байгуулж, Х улсын валютаар S компанид санхүүжилт хийсэн. (Япон иенээр 1 тэрбум иенийг 10 жилийн хугацаатай, 2% хүүтэйгээр)
4. Жилийн 2%-ийн хүү нь Р компани Японы банкнаас иенээр зээл авахад тавигдах хамгийн хөнгөлөлттэй нөхцөл (Prime rate) бөгөөд Х улсын банкны зээлийн хүүтэй харьцуулаад маш бага.
5. S компани нь мөнгөн хэрэглээний зээлийн гэрээний дагуу, жил бүр Р компанид жилийн хүү болох 2%-тай дүйцэх төлбөрийг Х улсын валютаар төлдөг.

【Асуулт】

1. Р компани ба S компанийн хооронд байгуулсан мөнгөн хэрэглээний зээлийн гэрээнд үнэ шилжилтийн ямар асуудал байгаа болох. Мөн эхлээд ямар TRM-ийг авч үзэх хэрэгтэй вэ.
2. Сонгосон TRM-ийг ашиглах тохиолдолд, ALP болгон юуг авах нь зохистой вэ.

6

Case 3



7

Case 3

【Урьдчилсан нөхцөл】


1. Японы Р компани нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэн, борлуулагч компани бөгөөд 1 жилийн өмнө санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг S охин компанийг Х улсад байгуулсан.
2. Р компанийн зээлжих зэрэглэл [АА] боловч, S компанийн зээлжих чадвар бага бөгөөд бие даан бонд гарган, санхүүжилт бүрдүүлэх боломжгүй.
3. Иймд, S компани бонд гарган, еврогийн зах зээлээс санхүүжилт (инээр 10 тэрбум) болгохын тулд Р компаниар баталгаа гаргуулсан.
4. S компаниас Р компанид баталгааны хураамж төлөөгүй.

【Асуулт】

1. Р компани ба S компанийн хоорондын баталгааны ажил гүйлгээнд үнэ шилжилтийн ямар асуудал байна вэ. Хамгийн эхлээд ямар ТРМ-ийг авч үзэх хэрэгтэй вэ.
2. Сонгосон ТРМ-ийг ашиглах тохиолдолд, ALP болгон юуг авах нь зохистой вэ.

8

Case 4



9

Case 4

【Урьдчилсан нөхцөл】


1. Японы Р хуулийн этгээд нь электроникийн деталь болох А болон В бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд нь 10 жилийн өмнө А бүтээгдэхүүнийг борлуулах S охин компанийг X улсад байгуулсан.
2. Р компани нь S компанид А бүтээгдэхүүнийг худалдаж, S нь үүнийг X улсад байх хөндлөнгийн цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид борлуулдаг.
3. Р компани нь X улсын хөндлөнгийн цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид В бүтээгдэхүүнийг шууд борлуулдаг.
4. В бүтээгдэхүүн нь А бүтээгдэхүүнтэй нэг төрлийнх биш боловч, хэлбэр хэмжээ, бүтэц, функцийг хувьд төстэй юм.
5. В бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ нь А бүтээгдэхүүний 10-ны 1(10%)

【Асуулт】

1. Р ба S хоорондын А бүтээгдэхүүний ажил гүйлгээн дээр үнэ шилжилтийн хяналт шалгалт хийсэн тохиолдолд, ямар ТРМ-ийг авч үзэх вэ. Энэ тохиолдолд, ямар хуулийн этгээдийг хянах компаниар (Tested Party) сонгох нь зүйтэй вэ.
2. Сонгосон ТРМ-ийг ашиглан ALP тооцоходоо, ямар зүйлийг авч үзэх шаардлагатай вэ.

10

Case 5



11

Case 5

【Урьдчилсан нөхцөл】


1. Японы Р хуулийн этгээд нь электроникийн эд анги болох А болон В бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд нь 10 жилийн өмнө А бүтээгдэхүүнийг борлуулах S охин компанийг Сингапур улсад байгуулсан.
2. Р компани нь S компанид А бүтээгдэхүүнийг борлуулж, S нь энэхүү бүтээгдэхүүнийг Азийн гуравдагч цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид худалддаг.
3. Р компани нь S-ийг байгуулж байсан үеэс, Хонконгийн хөндлөнгийн этгээдийн салбар болох Y компани ба Z компанид В бүтээгдэхүүнийг борлуулж ирсэн ба эдгээр 2 компани нь энэхүү бүтээгдэхүүнийг Азийн хөндлөнгийн цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид нийлүүлдэг.
4. В бүтээгдэхүүн нь А-тай нэг төрлийн бүтээгдэхүүн биш боловч, хэлбэр хэмжээ, бүтэц, функцын тал дээр төстэй.

【Асуулт】

1. Р ба S хоорондын А бүтээгдэхүүний ажил гүйлгээн дээр үнэ шилжилтийн хяналт шалгалт хийсэн тохиолдолд, ямар ТРМ-ийг авч үзэх вэ. Энэ тохиолдолд, ямар хуулийн этгээдийг хянах компаниар (Tested Party) сонгох нь зүйтэй вэ.
2. Сонгосон ТРМ-ийг ашиглан ALP тооцоходоо, ямар зүйлийг авч үзэх шаардлагатай вэ.

12

Case 6



13

Case 6

【Урьдчилсан нөхцөл】


1. Японы Р хуулийн этгээд нь салхивчийн тоног төхөөрөмж үйлдвэрлэн борлуулдаг бөгөөд эд анги үйлдвэрлэгч S1 ба S2 охин компанийг Х улсад байгуулсан.
2. Р компани нь S1 ба S2 компанийн үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмжийг түрээслэхийн хамт, эдгээр компаниудтай тухайн тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотой техникийн зааварчилгаа өгөх гэрээ байгуулсан.
3. Р компани нь гэрээний дагуу S1 ба S2 компаниудад тус бүр нэг техникийн зөвлөхийг томилон 1 жилийн хугацаатайгаар зааварчилгаагаар хангасан.
4. Гэрээнд техникийн зааварчилгааг үнэгүй хийхээр заасан байдаг.

【Асуулт】

1. Р компани болон S1 ба S2 компанийн хоорондын техникийн зааварчилгааны гэрээнд үнэ шилжилтийн ямар асуудал байна вэ. Үзүүлсэн үйлчилгээтэй (зааварчилгаа) холбоотой үнэ шилжилтийн хяналт шалгалт хийх тохиолдолд, ямар ТРМ-ийг авч үзэх вэ.
2. Сонгосон ТРМ-ийг ашиглан ALP-ийг тооцохдоо, ямар асуудлыг анхаарч авч үзэх хэрэгтэй вэ.

14

Case 7



15

Case 7

【Урьдчилсан нөхцөл】

1. Японы Р хуулийн этгээд нь жижиг оврын мотор болох А бүтээгдэхүүнийг импортлон бөөнөөр худалдаалдаг бөгөөд 10 жилийн өмнө А бүтээгдэхүүнийг Японд экспортлох S охин компанийг Х улсад байгуулсан.
2. S нь Х улсын мотор үйлдвэрлэгчээс А бүтээгдэхүүнийг худалдан авч, Р компанид экспортлон, Р нь үүнийг хөндлөнгийн хэд хэдэн үйлдвэрлэгчид нийлүүлдэг.
3. Р нь татварын байгууллагын үнэ шилжилтийн хяналт шалгалтын үед, S-тэй хийсэн ажил гүйлгээтэй холбоотой бодит үнэ тооцоход шаардлагатай материалыг гарган өгөөгүй, хамтран ажиллаагүй.
4. Татвараас А бүтээгдэхүүний ажил гүйлгээтэй харьцуулагдах боломжтой В бүтээгдэхүүний гуравдагч этгээдтэй хийсэн ажил гүйлгээ байгааг тогтоосон.
5. В бүтээгдэхүүн нь А-тай нэг төрлийн бүтээгдэхүүн биш боловч, хэлбэр хэмжээ, бүтэц, функцийн тал дээр төстэй. Гэхдээ В бүтээгдэхүүний ажил гүйлгээтэй холбоотой мэдээлэл нээлттэй биш.

【Асуулт】

1. Р ба S компанийн хооронд борлуулагдаж буй А бүтээгдэхүүний үнэ шилжилтийн хяналт шалгалт хийх тохиолдолд, Японы татварын байгууллага хэрхэн ажиллах вэ. Мөн Р компанид татвар ногдуулах тохиолдолд ямар TRM-ийг ашиглаж, аль хуулийн этгээдийг Tested Party болгох вэ.
2. Сонгосон TRM-ийг ашиглан, ALP-ийг тооцох тохиолдолд, PLI болгон юуг ашиглах вэ.

16

Case 8



17

Case 8

【Урьдчилсан нөхцөл】

1. Японы Р компани нь хагас дамжуулагч үйлдвэрлэн борлуулагч бөгөөд 10 жилийн өмнө А бүтээгдэхүүнийг борлуулах S компанийг Х улсад байгуулсан.
2. Р компани нь S компанид хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн патент болон ноухауг ашиглах зөвшөөрөл өгч, S компаниас ашиглалтын хураамж (Royalty) авдаг.
3. А бүтээгдэхүүн нь Р компанийн патент, үйлдвэрлэлийн менежментийн болон борлуулалтын ноухауг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн юм.
4. S компани нь Х улсад түүхий эд худалдан авч, А бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, Х улсын доторх хөндлөнгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчдэд нийлүүлдэг.
5. Р компани ба S компанийн хооронд бараа материалаарх хөрөнгийн худалдах, худалдан авах ажил гүйлгээ байхгүй.

【Асуулт】

1. Р компани нь S компаниас авах роялти дээр үнэ шилжилтийн хяналт шалгалт хийх тохиолдолд, ямар ТРМ-ийг авч үзэх вэ.
2. Сонгосон ТРМ-ийг ашиглан, ALP-ийг хэрхэн тооцох вэ.


18

Монгол Улсын ашигт малтмалын олборлолт RPSM ашиглах жишээ

ЛСА төслийн зөвлөх Кодера

1

Ажил гүйлгээний зураглал ТР хяналт шалгалт эхлэх үед,
харилцан хамааралтай ААН хоорондын үйл ажиллагааны
ашгийн түвшингийн харьцуулалт хийх нь хамгийн чухал



2

Үнэ шилжилтэд гарч болох асуудлуудыг НЭГТГЭСЭН ЖИШЭЭ 1

- Өмнөговь аймаг байрлах Х улсын Биг Экс ХХК(ВХ компани)-ийн 100%-ийн хөрөнгө оруулалттай Монгол Улсын Литле Экс ХХК (LX компани) нь ашигт малтмалын олборлолт хийдэг.
- KODERA байцаагч нь LX-д хийсэн урьдчилсан шалгалтаар LX-ийн ВХ-тэй хийсэн борлуулалтын хэмжээ 400, мөн LX-ийн үйл ажиллагааны ашиг 40 болохыг тогтоосон. Гэхдээ, ВХ-ийн энэ талаарх мэдээлэл тодорхойгүй байсан. LX-ийн харилцагч нь ВХ-ээс өөр компани байхгүй.
- Ажлын байранд хийсэн хяналт шалгалтаар LX компанийн санхүү хариуцсан ажилтнаас энэ талаар тодруулга авахад, ВХ-ийн нийт үйл ажиллагаатай хамааралтай тоо, өөрөөр хэлбэл, дэлхий даяарх борлуулалт 1000, үйл ажиллагааны ашиг нь нэгдсэн байдлаар 10 гэдгээс өөр хариулт өгөөгүй.
- Байцаагчаас TP нь дэлхий дахины жишиг болсон зүйл хэмээн LX-ийн санхүүгийн ажилтанд ойлгуулсны дараа, ВХ-ийн LX-д хамаарах борлуулалт 300 бөгөөд үйл ажиллагааны ашиг нь 60 гэж тодруулсан тайлбар хийсэн.

3

Үнэ шилжилтэд гарч болох асуудлуудыг НЭГТГЭСЭН ЖИШЭЭ 2

- KODERA байцаагч, ажлын байранд хийсэн хяналт шалгалтаар, LX ба ВХ-д биет бус хөрөнгө байгаа эсэхийг тодорхойлоход, LX ба ВХ-ийн R&D зардал нь тус бүр 40, 20 болох нь тодорхой болсон.
- Байцаагч энэ хүртэлх процессоор Монголын LX ба Х улсын ВХ-ын хооронд **TPM-ыг ашиглах** санаа төрсөн.
- ТЕГ-ын мэдээллийн сангаас биет бус хөрөнгө бүхий хэд хэдэн гуравдагч хуулийн этгээдийн үйл ажиллагааны ашгийн түвшинг статистик аргаар тооцох боломжтой болохыг мэдэж байсан тул мэдээллийн сангаас компаниудын үйл ажиллагааны ашгийн хувийг LX нь 6.25%, ВХ нь 5% гэж тогтоосон. Энэхүү арга нь цорын ганц TPM биш боловч, харилцан хамааралтай компаниудын аль аль нь биет бус хөрөнгөгүй тохиолдолд, Японд ч их хэрэглэгддэг TPM болохыг KODERA байцаагч, мэддэг байсан.

4

Үнэ шилжилтэд гарч болох асуудлуудыг нэгтгэсэн жишээ 3

- Ажлын байранд хийсэн шалгалтын үеэр байцаагч энэ тохиолдолд тодорхой нэг ТРМ-ээр татвар ногдуулахаар шийдсэн. LX-ын гарган өгсөн ТР баримтжуулалтын нэг болох локал файлаар LX компани нь СР аргыг сонгосон байсан.
- Татвар ногдох орлогын үнийн дүнг явцын байдлаар LX-д мэдэгдэхэд, үйлдвэрлэл, импортын үйл ажиллагаа эрхэлдэг тул локал файльд ашигласан СР аргыг ашиглах ёстой гэсэн байр сууриа илэрхийлсэн.
- Гэвч, KODERA байцаагч, СР аргыг ашиглахад харьцуулагдах ажил гүйлгээ байх шаардлагатай бөгөөд LX-тэй адил төрлийн ашигт малтмалын олборлолт хийдэг, биет бус хөрөнгө бүхий ажил гүйлгээ олдохгүй хэмээн LX компанитай санал зөрөлдсөн.
- Байцаагч эцсийн байдлаар, LX компанийн тайлагнасан орлого дээр 25 орлого нэмж татвар ногдуулсан.

5

Үнэ шилжилтэд гарч болох асуудлуудыг нэгтгэсэн жишээ 4

- KODERA байцаагч энэхүү 25 орлогод татвар ногдуулахдаа, үнэ шилжилтийн татвар ногдуулалт болох тул давхар татварын гэрээний дагуу харилцан тохиролцоог харилцагч улстай хийхгүй бол давхар татвар ногдуулалтыг шийдвэрлэх боломжгүй болохыг LX компанид тайлбарласан. Мөн, гомдол гаргах, нэхэмжлэл гаргах процедурын талаар тайлбарласан.
- LX компани нь ТР татвар ногдуулалттай санал нэгдэхгүй байгаа бөгөөд харилцан тохиролцооны аргыг сонгож энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр, ВХ компанитай нэг зэрэг харилцан тохиролцооны хүсэлт гаргасан.
- Гэвч энэхүү тохиролцоо бүтээгүй. Х улсад ТР татвар ногдуулалттай холбоотой нийцүүлэх тохиргооны зүйл заалт байхгүй тул Монгол улсын ТЕГ2аас Х улстай тохиролцооноос татгалзсан. Татварын гэрээнд зохицуулалтын заалт байгаа боловч, Х улсын дотоодын хуульд заалт байхгүйгээс, тохиролцоо хийсэн тохиолдолд ч Монгол улсын татвар ногдох орлогыг бууруулах гэсэн Х улсын нийцүүлэх тохиргоог хэрэгжүүлэх боломжгүй байх эрсдэл байна гэж үзсэн.

6

Үнэ шилжилтэд гарч болох асуудлуудыг нэгтгэсэн жишээ 5

- Харилцан тохиролцоогоор асуудлыг шийдвэрлэх боломжгүй байсан тул LX компаниас Монгол Улсын татварын маргаан таслах зөвлөлд хандсан.
- Гэвч, маргаан таслах зөвлөлөөс, ТЕГ-ын татвар ногдуулалтыг зөв гэсэн шийдвэр гаргасан.
- LX компаниас энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй хэмээн шүүхэд нэхэмжлэл гаргасан. ВХ компанийн LX-тэй харьцах тоон үзүүлэлт (үйл ажиллагааны ашгийн түвшин) алдаатай байгаа бөгөөд татвар ногдох орлогыг бууруулах (татвар ногдох орлогын 50%) нэхэмжлэлийг шүүхэд гаргаж, ялсан ба ТЕГ ч энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрснөөр энэ асуудал шийдэгдсэн.

7

Үнэ шилжилтэд гарч болох асуудлуудыг нэгтгэсэн жишээ 6 (асуулт)

- Локал файлиар LX компани CP аргыг сонгосон тул байцаагч зөвхөн энэ ТРМ -ыг авч үзэх ёстой бус уу.
- KODERA байцаагчийн ашигласан арга юу болох.
- KODERA байцаагч нь SG&A expense, FOB • CIF зэрэг харьцуулагдах боломжийн дагуух зөрүүний тохиргоо хийгээгүй бус уу.
- Эхний татвар ногдох орлого 25-ийн тооцооны агуулгыг нарийвчилан үзүүлнэ үү.
- Харилцан тохиролцоогоор яагаад үнэ шилжилтийн давхар татвар ногдуулалт шийдвэрлэгдэх вэ.
- Энэ тохиолдолд яагаад харилцан тохиролцоо амжилттай болоогүй вэ.
- Шүүхийн нэхэмжлэлээр 50% буурсан тул татварын байгууллага яах ёстой вэ.
- Шүүхийн шийдвэрээр үнийн дүн буурсан тул LX компанийн хувьд “happy” болсон бус уу.

8

ТР хяналт шалгалтын процесс 1

- 1 Бэлтгэл судалгаа (байцаагч өөрийн ажлын байрандаа хийх)
Татварын тайланг шалгах ➔ Гадаад ажил гүйлгээ байгаа эсэх
★ АРА (Урьдчилсан үнийн гэрээ) байгаа эсэх (Япон)
★ Хавсралт 17(4)-ыг шалгах ➔ ★ Хяналт шалгалтанд хамруулах ААН-ыг сонгох (Япон)
★ ТР баримтжуулалт (документаци) –ыг авч үзэх ➔ ялангуяа локал файлийг авч үзэх
★ Биет бус хөрөнгө байгаа эсэх, агуулгыг хянах ➔ ТРМ-ыг авч үзэх (best method)

9

ТР хяналт шалгалтын процесс 2

- 2 Ажлын байранд хийх шалгалт Эхэн шат
Компани дээр байрлан, гадаад ажил гүйлгээний зураглалыг гаргуулж, тайлбар авна.
Байцаагч өөрийн зураглалыг хийж, ОУ-ын ажил гүйлгээний талаар нэгдсэн ойлголт авна.
Хамааралтай ажил гүйлгээний асуудлыг тодорхойлох ➔ ТРМ-ыг тогтох
Харьцуулагдах ажил гүйлгээг сонгох ➔ Мэдээллийн сан ашиглах
comparability буюу харьцуулагдах байдлыг хянах
Зөрүүгийн тохиргоог тооцох ➔ Татвар ногдох орлогыг тооцох
- 3 Ажлын байранд хийх шалгалт Дунд шат
Татвар төлөгчид явцыг танилцуулах ➔ татвар төлөгчтэй маргаантай асуудлуудын (ТРМ, зөрүүний тохиргоо гэх мэт) талаар хэлэлцэх
- 4 Ажлын байранд хийх шалгалт Төгсгөлийн шат
Залруулгын агуулгыг татвар төлөгчид тайлбарлах
Татвар ногдуулалтын дараах татвар төлөгчийн авах арга хэмжээ, эрхийн талаар зөвлөгөө өгөх (харилцан тохиролцоо, арбитрагийн шүүх, маргаан таслах зөвлөл, шүүхэд нэхэмжлэл гаргах) Харилцагч талын улсад нийүүлэх тохиргооны тогтолцоо байдаг эсэхийг тодруулах

10

ТР хяналт шалгалтын процесс 3

харилцан тохиролцоо, маргаан таслах, шүүхийн НЭХЭМЖЛЭЛ

• **Татвар төлөгчийн хүсэлтээр хийх харилцан тохиролцоо**

Татварын гэрээний дагуу давхар татвар ногдуулалтаас сэргийлэх зорилгоор гадаад харилцан хамаарал бүхий этгээдийн оршин суух улстай хэлэлцээр хийх **⇒ Санал нэгдсэн үнийн дүнгээр харилцагч улс нийцүүлэх тохируулга хийнэ.**

Харилцагч улсын тухайд, дотоодын хуулинд нь нийцүүлэх тохиргоо хийх боломжгүй байвал санал нэгдэхэд хүндрэлтэй (Татварын гэрээний заалтыг дангаар ашиглах нь хангалттай бус) **⇒ Монгол улсад нийцүүлэх тохиргооны заалт байдаггүй тул, харилцагч улс ТР татвар ногдуулсан тохиолдолд, харилцан тохирч санал нэгдэхээс татгалзах магадлалтай тул Цаашид зайлиггүй энэ талаар хуулиндаа тусгах шаардлагатай. !!!**

• **Татвар төлөгч гомдол гаргах**

Хэчнээн жил болоод ч харилцан тохиролцоогоор санал нэгдэх боломжгүй байгаа тохиолдолд, Япон Улсын хувьд, татвар төлөгч нь дотоодын хуулийн дагуу гомдол гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Харилцан тохиролцоо эхлэхтэй зэрэгцүүлэн татвар төлөгч гомдол гаргадаг ба маргаан таслах зөвлөл нь харилцан тохиролцооны явцтай уялдуулан, гомдол барагдуулалтыг түр зогсоодог. Нэхэмжлэлийн тухайд, маргаан таслах зөвлөлийн шийдвэр, процедурын дагуу хийгддэг.

11

ТР бэлтгэл ажлын гол асуудал 1

(Үйл ажиллагааны ашгийн түвшин)

- Монголын хяналт шалгалтын байцаагч нь компани дээр очиж шалгалт хийхийн өмнө, өөрийн ажлын байранд бэлтгэл судалгаа хийх ба хяналт шалгалтанд хамруулах ААН-ыг харилцан хамааралтай этгээд хоорондын үйл ажиллагааны ашгийн түвшинг харьцуулах замаа сонгох шаардлагатай. (гадаадын ААН-ын үйл ажиллагааны ашгийн түвшин бэлтгэл судалгааны шатанд тодорхой бус байгаа бол ажлын байранд хийх шалгалтын хамгийн эхэнд тодруулга хийх хэрэгтэй.)

Жишээлбэл,

Монголын охин компанийн үйл ажиллагааны ашгийн түвшин 3%

Гадаадын ААН-ын зөвхөн Монголын охин компанитай хийсэн ажил гүйлгээнд хамаарах үйл ажиллагааны ашгийн түвшин 20%

⇒ Монголын охин компанийн орлого гадаадын ААН-д шилжиж байгаа нь тодорхой байна. !

12

ТР бэлтгэл ажлын гол асуудал 2 (Биет бус хөрөнгө ба ТРМ)

- Жишээлбэл, Монголын охин компани уул уурхайн олборлолтын эрхийн хүрээнд патентын хэлбэрээр биет бус хөрөнгөтэй бол гадаадын төв компани нь ямар нэг хэлбэрийн биет бус хөрөнгөтэй байдаг. Хоёр тал биет бус хөрөнгөтэй байгаа тохиолдолд,
➔ТРМ-ээр RPSM-ыг эхлээд авч үзэх хэрэгтэй. !
- Бараа бүтээгдэхүүний үнэ тодорхой бол CUP арга, Монгол талын охин компанид биет бус хөрөнгө байхгүй бол TNMM, эсхүл PS аргыг авч үзэх боломжтой.

13

★АРА(Advanced Pricing Agreement) Урьдчилсан үнийн гэрээ байгаа эсэх

- Урьдчилсан үнийн гэрээний тогтолцооны тухайд, татвар төлөгчийн хүсэлтээр, гадаад харилцан хамааралтай этгээдтэй хийх ажил гүйлгээтэй холбоотой бодит үнэ тооцох арга болон тодорхой агуулгыг татварын байгууллагаас урьдчилан баталгаажуулах тогтолцоо юм.
- Энэхүү тогтолцооны хүрээнд татвар төлөгч ААНОАТ-ын тайлангаа сэтгэл амраар гаргах ба нөгөө талаас татварын байгууллагаас үнэ шилжилтийн хяналт шалгалт хийхгүйгээр үнэ шилжилтийн татварын тогтолцоог зохистойгоор хэрэгжүүлэх боломжоор хангагддаг.
- Урьдчилсан үнийн гэрээний хамрах хугацаанд үнэ шилжилтийн татварын хяналт шалгалт хийдэггүй.

14

★ Хавсралт хүснэгт 17(4)(Гадаад харилцан хамааралтай этгээдтэй холбоотой мэдэгдэл)

- Японы хяналт шалгалтын байцаагч хамгийн туруунд энэ хүснэгтийг үздэг. !!!
- Энэ хүснэгтийг авч үзсэнээр, өндөр орлого бүхий гадаад харилцан хамааралтай этгээдийг зорилтот бүлэг болгодог.
- Татварын байгууллага нь энэ хүснэгтээр мэдээллийн сан үүсгэн хянах замаар дунд хугацааны ерөнхий хандлага төлвийг тодорхойлдог.
- Энэхүү хүснэгтийг ТР баримтжуулалтын тогтолцоо нэвтрэхээс өмнө, Японы татварын байгууллагаас татвар төлөгчөөр татварын тайландаа тусгуулж ирсэн бөгөөд Маш шалгарсан арга юм.!!!
- Хүснэгтийн зорилго: Төв ба охин компанийн ашгийн байдлыг тодорхойлох (⇒ Энэ нь хамгийн чухал !!!)
- Хүснэгтийн агуулга:
Төв компанийн (эсхүл охин компани) танилцуулга, борлуулалтын хэмжээ, үйл ажиллагааны ашиг
Төв компани ба охин компанийн хоорондын ажил гүйлгээний байдал, үнийн дүн
 1. Бараа материалаарх хөрөнгийн худалдах, худалдан авах үнэ
 2. Үзүүлсэн ажил, үйлчилгээний үнэ хөлс
 3. Биет бус хөрөнгийн ажил гүйлгээний үнэ төлбөр
 4. Зээлийн хүүгийн төлбөр

15

★ ТР хяналт шалгалтанд хамрагдах хуулийн этгээдийг сонгох 1 (Хүснэгт 17(4)-ээс олж авсан мэдээлэлд үндэслэн)

- Дараах тохиолдолд сонгогдох магадлалтай:
- Гадаад харилцан хамааралтай этгээдийн үйл ажиллагааны ашгийн түвшин нь хяналт шалгалтанд хамрагдах ААН-ээс өндөр байх
- Гадаад харилцан хамааралтай этгээдийн үйл ажиллагааны ашгийн түвшин нь адил төрлийн үйл ажиллагаа эрхлэгчийнхээс өндөр байх
- Гадаад харилцан хамааралтай этгээдийн борлуулалтын хэмжээ жил бүр өссөн байх
- Гадаад харилцан хамааралтай этгээд нь үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг байж, хяналт шалгалтанд хамрагдагчид роялти төлөөгүй байх

16

★ТР хяналт шалгалтанд хамрагдах хуулийн этгээдийг сонгох 2 (нээлттэй мэдээлэлд үндэслэн)

- Дараах тохиолдолд сонгогдох магадлалтай:
- Хяналт шалгалтанд хамрагдах хуулийн этгээд алдагдалтай байгаа
- Үнэт цаасны тайлангийн «Хамаарал бүхий компанийн нөхцөл байдал» хэсэгт бичигдсэн охин компани нь Хүснэгт 17(4)-т тусгагдаагүй.
- Сонин хэвлэл дээр «ОО улсад үйлдвэрлэл хийх охин компани байгуулсан» «Гадаад дахь охин компанийн үйл ажиллагаа сайн байгаа» «Төв компани нь гадаад дахь охин компаниа дэмжиж ажилладаг» гэсэн мэдээлэл гарсан.

17

★ ТР хяналт шалгалтанд хамрагдах хуулийн этгээдийг сонгох 3 (Энгийн татварын хяналт шалгалтын мэдээлэлд үндэслэн)

- ААН-д хийх энгийн хяналт шалгалтаар дараах бодит байдлыг илрүүлсэн тохиолдолд, ТР хяналт шалгалтанд хамруулах ААН-ээр сонгогдох магадлалтай.
- Гадаад дахь охин компанидаа бага хүүтэй зээл олгосон, эсхүл зээлийн батлан даалт хийсэн бол.
- Гадаад дахь охин компани нь тухайн улсын татварын байгууллагаас татварын ногдуулалт хийгдсэн бол.
- Охин компанид томилолтоор ажиллагсдын зардлыг бүх үнийн дүнгээр төв компани хариуцдаг бол
- Гүйцэтгэлийн үр дүн муутай байгаа гадаад дахь охин компанидаа тусламж үзүүлэх зорилгоор, маш хямдаар түүхий эд экспортолдог бол.

18

★TP баримтжуулалтын агуулга (Мастер файл)

• TP баримтжуулалтын тогтолцоог 2016 онд нэвтрүүлсэн.

1) Мастер файл (Үйл ажиллагааны тайлан) гаргах үүрэгтэн

2-оос дээш гишүүн компанитай бөгөөд тайлант оны өмнөх жилийн нийт орлого 100 тэрбум иенээс дээш групп компани

2) Мастер файльд бичигдэх зүйлс

「Үйл ажиллагааны байдал」 「Чиг үүрэг・эрсдэл」 「Биет бус хөрөнгө, группын доторх санхүүжилт, харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний үнийг тогтоох арга」 「АРА(урьдчилсан үнийн гэрээ)」-тэй холбоотой асуудлуудын талаар

3) Тайлангийн хэл

Тайланг Япон ба Англи хэлээр бэлтгэнэ. (Гадаадын татварын байгууллагад гарган өгөх Англи хэл дээрх MF-ийг ашиглах боломжтой)

19

★TP баримтжуулалтын агуулга (CbC тайлан)

1) CbC(Country by Country) тайлан гаргах үүрэгтэн

2-оос дээш гишүүн компанитай бөгөөд тайлант оны өмнөх жилийн нийт орлого 100 тэрбум иенээс дээш групп компани

2) CbC тайланд тусгах зүйлс

Гишүүн компани тус бүрийн үйл ажиллагаа эрхэлдэг улс, бүс нутагт хамаарах тоон мэдээлэл, борлуулалтын хэмжээ, төлсөн татварын дүн, үндсэн хөрөнгө, ажиллагсдын тоо, үндсэн үйл ажиллагаа гэх мэт

3) Тайлангийн хэл

Зөвхөн англи хэл (CbC тайлангийн тухайд, гадаадын татварын байгууллагатай мэдээлэл харилцан солилцохоор төлөвлөдөг)

20

★ TP баримтжуулалтын агуулга (локал файл LF)

1) LF гаргах үүрэгтэн

Дотоодын хуулийн этгээд ба гадаад харилцан хамааралтай этгээд хоорондын ажил гүйлгээний үнийн дүн 5 тэрбум иенээс дээш (биет бус хөрөнгийн ажил гүйлгээ нь 300 сая иенээс дээш) байх дотоодын ААН

2) СбС-д тусгах зүйлс

Сунгасан гарын үнийг (ALP) тооцоход шаардлагатай мэдээлэл

➔ MF нь [ерөнхий танилцуулга] бөгөөд СбС тайлан нь [Нэгдсэн тоон мэдээлэл] болох тул тухайлсан харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний бодит үнийг тооцоход хангалтгүй бөгөөд энд LF-ийн ач холбогдол оршино. !!!

3) Тайлангийн хэл

Тайланг ямар хэл дээр бэлтгэхийг заадаггүй. Гэхдээ, гадаад хэл дээр гарган өгсөн тайлангийн орчуулгыг татварын байгууллагаас шаардах эрхтэй.

21

★ Локал файл дээр ажиллах (Татвар төлөгчийн ТРМ-ийг авч үзэх)

Баримтжуулалтын 3 бичиг баримтын дотроос, ялангуяа локал файл дээр төвлөрч ажилладаг бөгөөд учир нь татвар төлөгчийн хүсэлт гаргасан ТРМ-ийн талаар энд тайлбарласан байдаг.

Татвар төлөгчийн ТРМ нь зохистой эсэхийн талаар сайтар хянаана.

ТР баримтлах чиглэл 2-5(2)

[Хуулийн этгээд нь сунгасан гарын үнийг тооцоолдог тохиолдолд, энэхүү тооцооны бичиг баримтад үндэслэн сунгасан гарын үнэ тооцоолох боломжтой эсэх, энэ бичиг баримтаас өөр зүйл нэмж гаргуулах шаардлагатай эсэхийг тодорхойлно.]

Татварын хяналт шалгалтын байцаагч нь хангалтгүй гэж үзвэл, татвар төлөгчийн гарган өгсөн бичиг баримтаас өөр, сунгасан гарын үнэ тооцоход шаардлагатай бичиг баримтыг шаардана.

22

★ Локал файлийг авч үзэхэд анхаарах 5 зүйлс

- Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний мэдээлэл
- Бодит үнийн мэдээлэл
- Ашиг хуваах аргын талаарх мэдээлэл
- Ажил гүйлгээнүүдийн мэдээлэл
- Зөрүүгийн тохиргооны мэдээлэл

23

ТР ажлын байран дахь шалгалтанд анхаарах зүйлс 1 (Үйл ажиллагааны ашгийн түвшин)

- Гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагааны ашгийн түвшин нь бэлтгэл буюу урьдчилсан судалгааны шатанд тодорхойгүй байсан бол ажлын байран дахь шалгалтын үед хамгийн эхэнд асууж тодруулах хэрэгтэй!

Жишээ

Монголын охин компанийн үйл ажиллагааны ашгийн түвшин 3%

Гадаадын ААН-ын зөвхөн Монголын охин компанитай хийсэн ажил гүйлгээнд хамаарах үйл ажиллагааны ашгийн түвшин 20% (Охин компаниас төв компанийн үйл ажиллагааны ашгийн түвшинг асууж тодруулна)

➡ Монголын охин компанийн орлого гадаадын ААН-д шилжиж байгаа нь тодорхой байна. !

24

ТР ажлын байран дахь шалгалтанд анхаарах зүйлс 2 (Биет бус хөрөнгө ба ТРМ)

- Жишээлбэл, Монголын охин компани уул уурхайн олборлолтын эрхийн хүрээнд патентын хэлбэрээр биет бус хөрөнгөтэй бол гадаадын төв компани нь ямар нэг хэлбэрийн биет бус хөрөнгөтэй байдаг. Хоёр тал биет бус хөрөнгөтэй байгаа тохиолдолд,
 - ➔ ТРМ-ээр RPSM-ыг эхлээд авч үзэх хэрэгтэй. !
- RPSM-ийг ашиглахаар шийдсэн бол охин компани ба төв компанийн биет бус хөрөнгийг нарийвчилан судлах хэрэгтэй. R&D зардал ба сурталчилгааны зардал
- Q Яагаад?
- Бүтээгдэхүүний үнэ тодорхой бол CUP арга, Монголын охин компани биет бус хөрөнгөгүй бол TNMM, эсхүл PS аргыг ашиглах боломжтой.

25

ТР ажлын байран дахь шалгалтанд анхаарах зүйлс 3 (TNMM ба мэдээллийн сан)

- Жишээлбэл, Монголын охин компани нь уул уурхайн олборлолтын эрхийн хүрээнд патентын хэлбэрээр биет бус хөрөнгө эзэмшдэггүй бөгөөд төв компани болох гадаадын хуулийн этгээд нь биет бус хөрөнгөтэй эсэх нь мэдэгдэхгүй байгаа тохиолдолд, энэхүү харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээнд ямар ТРМ ашиглах вэ?
 - ➔ Энэ тохиолдолд TNMM-ийг авч үзэх хэрэгтэй. Гэхдээ, TNMM-д хамаарах хуулийн этгээд нь биет бус хөрөнгөгүй байх нөхцөлтэй.
- Ажлын байранд хийх шалгалтын үед TNMM-ийг ашиглахаар шийдсэн бол охин компанийн үйл ажиллагааны ашгийн түвшинг зөвөөр тооцно. Монголын охин компани болох тул Монгол Улсын доторх (биет бус хөрөнгөгүй) хуулийн этгээдийн (ТЕГ-ын эрдэс баялгийн хэлтэс) мэдээллээс үйл ажиллагааны ашгийн түвшинг тооцно. (дундаж утга)
- Гадаадын төв компани нь биет хөрөнгөгүй тохиолдолд, үйл ажиллагааны ашгийн түвшинг мэдээллийн сангаас тооцоолсон ч болно. Мэдээллийн сангийн ашиглалтын үндсийг нийлүүлэгч компаниудын сургалтаар дамжуулан суралцах хэрэгтэй.
- Бүтээгдэхүүний үнэ тодорхой бол CUP арга, Монголын охин компани нь ашигт малтмал экспортлогч бол CP аргыг ашиглах боломжтой.

26

2019 оны Япон Улсын үнэ шилжилтийн татварын ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧИЛЭЛТ

**2019 оны 3 сарын 22
ЛСА төслийн зөвлөх
Кодера Тошинари**

1

Японы татварын тогтолцооны өөрчлөлтийн талаар

- Япон улсад татварын тогтолцооны өөрчлөлтийг жил бүр тогтмол хийдэг.
- Олон улсын татварын хувьд ч бие даасан байдлаар жил бүр шинэчилэлт хийгддэг
- Өөрчлөлтийн агуулга нь интернет, номын сангаар хэн ч авах боломжтой нээлттэй байдаг
- Сангийн яамны хариуцсан ажилтан, татварын шинэчилэлтийн үзэл баримтлалаас эхлээд, зорилго, өөрчлөлтийн агуулгыг нарийвчилан тайлбарладаг тул энэхүү тайлбарыг судлахад л хангалттай байдаг.

- ➡иймд,

Монгол Улсын татварын тогтолцооны цаашдын шинэчилэлтийг хийхдээ, Японы олон улсын татварын тогтолцооны өөрчлөлт шинэчилэлтийн арга барилаас суралцах нь хуулийн талаарх ойлголт маш сайжирна.

2

Гарчиг

- 2019 оны Үнэ шилжилтийн татварын хамгийн сүүлийн шинэчилэлт

2019 онд гадаадын охин компанитай нэгдсэн татвар ногдуулалтын тогтолцооны шинэчилэлт, хүүгээр ашиг бууруулах тогтолцооны шинэчилэлт, санхүүгийн дансны мэдээллийг ердийн журмаар мэдээлэл харилцан солилцох улс орнуудыг нэмэх, Токиогийн олимптой холбоотой татвар ногдуулалтын тусгай заалтуудын шинэчилэлт нэмж хийгдсэн.

3

Үнэ шилжилтийн татварын хамгийн сүүлийн шинэчилэлт Q&A

- Q1 Үнэ шилжилтийн татварын тогтолцооны тухайд, 「BEPS төсөл」-ийн тунхаглалын дагуу шинэчилэлт хийнэ гэдэг нь ямар агуулгатай болох.
- Q2 Үнэ шилжилтийн татварын тогтолцооны шинэчилэлтийн агуулга нь юу болох.
- Q3 Гол тайлбар: Шинэ TRM
 - ➔ DCF аргыг ашиглах
 - ➔ Орлогод нийцүүлэх жишгийг ашиглах
- Q4 Гол тайлбар: Зөрүүний тохиргоо хийх аргыг сайжруулах
 - ➔ Статистикийн кварталын аргыг ашиглах

4

Q1 Үнэ шилжилтийн татварын тогтолцооны тухайд, «BEPS төсөл»-ийн тунхаглалын дагуу шинэчилэлт хийнэ гэдэг нь ямар агуулгатай болох.

BEPS тунхаглал

Биет бус хөрөнгийн ажил гүйлгээнд харьцуулагдах ажил гүйлгээ олдохгүй тохиолдолд,

➔ DCF аргаар биет бус хөрөнгийн сунгасан гарын үнийг (ALP) тооцно.

➔ DCF арга :

BEPS-ийн тунхаглалаар ➔ OECD үнэ шилжилтийн талаарх удирдамжийг шинэчилсэн (6-р бүлэг)

Биет бус хөрөнгийн ажил гүйлгээнд үнэлгээ хийхэд хүндрэлтэй тохиолдолд,

➔ Ажил гүйлгээний үед, урьдчилсан байдлаар зөв үнэлгээ хийхэд хүндрэлтэй бол, эхний үнэ тооцох жишиг болох төсөөлөл ба бодит үр дүн зөрүүтэй байна. Иймд, татварын байгууллагаас эхний үнийг зохистой тооцоолоогүй гэж үзээд, бодит үр дүнгээс хөөн эхний үнийг дахин үнэлэх боломжтой. (Орлогд нийцүүлэх жишиг)

5

Q2 Үнэ шилжилтийн татварын тогтолцооны шинэчилэлтийн агуулга нь юу болох.

(1) TPM (Сунгасан гарын үнэ тооцох арга)-ыг нэмсэн

➔ Сунгасан гарын үнэ тооцох аргууд дээр **DCF(Discounted cash flow)** аргыг нэмсэн.

(2) Үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийн ажил гүйлгээтэй холбоотой үнийн тохиргооны арга хэмжээг нэвтрүүлсэн.

➔ Үнэлэхэд хүндрэлтэй биет бус хөрөнгийн ажил гүйлгээний тухайд, төсөөлөл ба бодит үр дүн зөрсөн тохиолдолд, татварын байгууллага үр дүнд үндэслэн үнэлгээ хийнэ. (Гэхдээ, давтан үнэлгээ нь эхний үнэлгээний 20%-аас хэтрэх тохиолдолд)

(3) Биет бус хөрөнгийн тодорхойлолт

➔ Биет хөрөнгө ба санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгө бөгөөд бие даасан бизнес эрхлэгчдийн хооронд шилжүүлэх, түрээслэх тохиолдолд төлбөр төлөгддөг зүйл

(4) TP татвар ногдуулалтын залруулгын хугацаа ➔ 6 жилээс 7 жил болгосон.

(5) Харьцуулагдах ажил гүйлгээтэй холбоотой зөрүүний тохиргоо хийхдээ, статистик аргыг ашиглахыг зөвшөөрсөн.

➔ Квартал аргыг ашиглах

(6) ➔ 2020 оны 4 сарын 1-нээс хойших тайлант хугацаанд ашиглах

6

Q3 Гол тайлбар: DCF аргыг ашиглах

- Сунгасан гарын үнэ ашиглах аргын тухайд, OECD-ын үнэ шилжилтийн удирдамжийн хүрээнд, харьцуулагдах ажил гүйлгээ олох боломжгүй биет бус хөрөнгийн ажил гүйлгээний үнийг тооцохдоо DCF аргыг ашиглаж болохоор нэмж оруулсан.
- ➔ ингэснээр, сунгасан гарын үнэ тооцоход шаардлагатай бичиг баримтыг гарган өгөөгүй тохиолдолд, **жишиг татвар ногдуулалтыг тооцох аргууд дээр**, татварын байцаагч, гадаад ажил гүйлгээнээс олж мэдэх боломжтой мэдээлэл дээр үндэслэн, DCF аргаар тооцсон үнийг сунгасан гарын үнэ гэж үзэх аргыг нэмж оруулсан.

7

DCF арга 1 (өнөөгийн үнэ цэнэ)

- Үндсэн ухагдахуун: өнөөгийн үнэ цэнэ
- Ирээдүйд олж авах мөнгөн дүн C -ийн өнөөгийн үнэ цэнэ = «өнөөгийн үнэ цэнэ» (PV)
- $PV = C / (1 + r)^n$ r нь хорогдуулалтын хувь
- Жишээлбэл, хүү нь (засгийн газрын бондын хүү) 2% бол, нэг жилийн дараа засгийн газраас 100 иен авна гэвэл, энэхүү 100 иений өнөөгийн үнэ цэнэ (PV) нь хүүг хорогдуулалтын хувиар болгон авбал,
- $PV = 100 / 1.02 = 98.04$ иен

8

DCF арга 2 (ирээдүйн CASH FLOW)

- Үндсэн ухагдахуун: Ирээдүйн мөнгөн гүйлгээний урсгалын өнөөгийн үнэ цэнэ=хөрөнгийн үнэ
➔ мөнгөн гүйлгээний урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцох арга = DCF арга
- Хөрөнгө нь 1 жил, 2 жил, 3 жил...n жилийн дараа $C_1, C_2, C_3, \dots, C_N$ мөнгөн урсгалыг бүрдүүлнэ гэж үзье. Энэ үеийн эрсдэлийг (хорогдуулалтын хувь)-ийг r гээд DCF аргаар хөрөнгийн үнийг тооцвол,
- $PV = C_1/(1+r)^1 + C_2/(1+r)^2 + C_3/(1+r)^3 + \dots + C_N/(1+r)^n$
- Жишээлбэл, жилийн байрны түрээсийн орлого 3.5 сая иен, засвар үйлчилгээний үнэ 500 мянган иен бол 10 жилийн дараа буулгах төлөвлөгөөтэй байрны үнэ цэнэ нь хорогдуулалтын хувийг 5% гэсэн тохиолдолд
- $PV = 300/1.05 + 300/1.05^2 + \dots + 300/1.05^{10} = 23,165$ мян. иен

9

Шинэчилэлт хийгдэх магадлалтай ажил гүйлгээ (оюуны өмчийг шилжүүлэх ажил гүйлгээ)



10

Японы толгой компанийн байр суурь

- Японы толгой компани дараах байр суурьтай байна

Г Энэхүү ажил гүйлгээ нь оюуны өмчийг шилжүүлэхээр хязгаарлагдаж байгаа ба үүнийг ашиглан бүтээгдэхүүн гаргах нь амжилттай болох эсэх нь тодорхой бус тул манай тооцоогоор 800 мянган иенээр шилжүүлэх нь зохистой үнэ гэж үзэж байна.]

➔ Гэвч, хийсэн бүтээгдэхүүн нь гайхалтай сайн борлогдсон тул Ирландын охин компани 100,000,000 иений орлогыг тусгасан.

➔ Ирланд нь татварын хувь хэмжээ багатай улс болох тул Японы толгой компани дээр орлогыг тусгаснаас, Ирландад байх охин компани дээр орлогыг тусгах нь нийт групп компанийн хувьд татварын хэмнэлт хийж байна.

11

Японы татварын байгууллагад тулгарах асуудал

- Японы татварын байгууллагад тулгарах асуудал

Г Бодит байдал дээр Японы толгой компани бүтээгдэхүүн гаргах нь амжилтанд хүрэхийг урьдчилан мэдэж байсан юм биш байгаа. Мэдсээр байж, 800 мянган иен гэсэн хямд үнээр оюуны өмчөө шилжүүлсэн биш үү. Оюуны өмчийн ирээдүйн үнэ цэнэ талаас хараад, шилжүүлэх үнэ нь 100,000,000 иен байх нь зохистой байсан юм биш байгаа.]

- Японы татварын байгууллагын толгойны өвчин

Г Энэ Японы толгой компани ба Ирландын охин компанийн хувьд харьцуулагдах ажил гүйлгээ байхгүй.]

➔ Үнэхээр тийм байна. Харьцуулагдах ажил гүйлгээ байсан бол оюуны өмчийн ажил гүйлгээ гэж хэлэхгүй л дээ. Одоо яах вэээе !!!!! (гэж толгойгоо гашилгана)

12

BEPS-ийн онолын дагуу, OECD удирдамжаар шийдвэрлэх: Орлогод нийцүүлэх жишиг

- Орлогод нийцүүлэх жишиг гэдэг нь тодорхой нөхцөлд, оюуны өмчийг шилжүүлсэн үнийг, дараа гарах үр дүнгээс хамааруулан залруулан тооцох гэсэн татвар ногдуулалтын шинэ арга
- (Америк, Германд ашиглагдаж байгаа)
- Энэ жишээн дээр [Оюуны өмчийн эрх Ирландын охин компанид шилжсэн боловч, тухайн биет бус хөрөнгийн хөгжүүлэлт, сайжруулалт, хамгаалалт, ашиглалттай холбоотой үүрэг хариуцлагыг охин компани хүлээхгүй байгаа, эсхүл энэхүү эрхийг ашигласан бизнесийн эрсдэлийг хүлээхгүй байгаа тохиолдолд, охин компанид үл нийцэх орлогыг тусгах боломжгүй] гэсэн дүрмийг тогтоосон.
- Мөн, [Бодит байдал дээр хөгжүүлэлтийн үүргийг болон эрсдэлийг хүлээж буй Японы толгой компани дээр орлогыг шилжүүлэн тусгана] гэсэн дүрмийг тогтоосон.

13

Q4 Гол тайлбар: Статистик квартал аргыг ашиглах

- Харьцуулагдах ажил гүйлгээний ашгийн түвшинд тулгуурлсан ТРМ-тэй холбоотой зөрүүний тохиргооны тухайд, тоон үзүүлэлтээр тооцоход хүндрэлтэй зөрүү гараад тохируулга хийх боломжгүй байх тохиолдолд, статистик квартал аргаар зөрүүний тохируулга хийх боломжтой.
- Статистик квартал арга гэдэг нь харьцуулагдах ажил гүйлгээний ашгийн түвшингийн дэс дарааллаар 4 хэсэгт хуваан, дээд хязгаарын 25% ба доод хязгаарын 25%(эдгээрийг хэвийн бус утга гэж үзнэ.)-ийг хассан дээд ба доод хязгаарын утгаас бүрдэх интервалын хүрээнд сунгасан гарын үнийг тооцох арга юм.

14

Кварталын арга 1 Сондгой тоон үзүүлэлт

- 50,54,62,62,67,71,78,80,82,86,87 гэсэн 11 тоон үзүүлэлт байгаа бол

★Тоон үзүүлэлтийг багаас нь их рүү нь жагсааж, эхний ба сүүлийн хагас хуваана.

- Эхний хагас: 50,54,62,62,67 → голын 62 гэсэн тоо нь эхний квартал
- Сүүлийн хагас: 78,80,82,86,86 → голын 82 гэсэн тоо нь 3-р квартал
- Яг голын тоо нь 71 → 2-р квартал (Голын тоо, медиан)

★Кварталын хүрээ=3-р квартал—1-р квартал=82—62=20

15

Кварталын арга 1 Тэгш тоон үзүүлэлт

- 50,54,62,62,67,71,78,80,82,86 гэсэн 10 тоон үзүүлэлт байгаа тохиолдолд,

★Тоон үзүүлэлтийг багаас нь их рүү нь жагсааж, эхний ба сүүлийн хагас хуваана.

- Эхний хагас: 50,54,62,62,67 → голын 62 гэсэн тоо нь эхний квартал
- Сүүлийн хагас: 1,78,80,82,86 → голын 80 гэсэн тоо нь 3-р квартал
- Яг голын 2 тооны дундаж утга нь $(67+71)/2 = 69$ →
- 69 нь 2-р квартал (Голын тоо, медиан)

★Кварталын хүрээ=3-р квартал—1-р квартал=80—62=18

16

Японы үнэ шилжилтийн
талаарх шүүхийн шийдвэрийн
жишээ
2019 оны 3 сарын 22

ЛСА зөвлөх

Кодера Тошинари

1

Япон Улсын татварын маргаан таслах газрын
үнэ шилжилтийн талаар гаргасан шийдвэр

Шийдвэр 1. Технологийн лицензийн ажил гүйлгээ (CUP)

Шийдвэр 2 Технологийн лицензийн ажил гүйлгээ (CUP)

Шийдвэр 3 Үйлдвэрлэл, худалдаа, биет бус хөрөнгө (RPSM)

Шийдвэр 4 Үйлдэрлэл, худалдааны лиценз (RPSM)

Шийдвэр 5 Лиценз, хагас боловсруулсан бүтээгдэхүүний худалдаа
(RPSM)


Шийдвэр 6 Олон улсын худалдаа (RPSM)

2

Шүүхийн шийдвэрийн жишээ 1

Ажил гүйлгээний зураг

Хяналтын доорх
ажил гүйлгээ



3

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

- Татварын байгууллагын арга хэмжээ
- Харилцан хамааралгүй этгээд хоорондын жолооны хүрд үйлдвэрлэх лицензийн ажил гүйлгээг харьцуулагдах ажил гүйлгээгээр сонгож, **харьцуулагдах үнийн аргатай** адилтгах аргаар татвар ногдуулна.
- Гол маргасан асуудлууд
- Татварын байгууллага харьцуулагдах үнийн аргатай адилтгах аргаар татвар ногдуулж байгаа бөгөөд гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хооронд төстэй шинж чанар байгаа эсэх.
- ➔ Нэхэмжлэгч тал нь төстэй шинж чанар байхгүй байна гэж эсэргүүцсэн
- Төстэй шинж чанар байхгүй тохиолдолд, зөрүүний тохируулга хийх шаардлагатай бус уу?

4

Шүүхээс бодит байдлыг тодруулан(лицензийн ажил гүйлгээний талаар)гаргасан шийдвэр

- Технологийн асуудлын тухайд, Хяналтын доорх ажил гүйлгээнд жолооны хүрд, жолооны аппарат, усны насос хамаарч байгаа ба харьцуулагдах ажил гүйлгээ нь зөвхөн жолооны хүрд байсан боловч, роялти нь аль аль нь адилхан 3% байсан.
- Газар нутгийн хувьд, Хяналтын доорх ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээ нь АНУ ба Солонгост гэсэн ялгаатай улс орныг сонгосон боловч, АНУ-ын автомашины эд ангийн үйлдвэрлэлийн 200 гаруй мэдээллийн 40%-ийн роялти нь борлуулалтын 3%, Солонгост ч 60% нь адилхан 3% байсан.
- Гэрээ хийсэн хугацааны тухайд, Хяналтын доорх ажил гүйлгээг 1989 оны 11 сард, харьцуулагдах ажил гүйлгээг 1990 оны 12 сард хийсэн байгаа боловч, энэ салбарын роялти хувь нь энэ хугацааны туршид ихэнхдээ 3% байсан.

5

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Хяналтын доорх ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хооронд адил төстэй шинж чанар байна.

Зөрүүний тохируулга хийх шаардлагагүй.


- Шалтгаан ?

6

Шүүхийн шийдвэрийн жишээ 2

Ажил гүйлгээний зураг

Хяналтын доорх ажил
гүйлгээ



7

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

- Татварын байгууллагын арга хэмжээ
- Харьцуулагдах үнийн аргатай дүйцэх ба адилтгах аргаар татвар ногдуулна.
- Харьцуулагдах ажил гүйлгээ болох 23 гэрээний дотроос 18-ын роялти 3% байж таарч байгаа ба салбарын жишиг роялтийн хувь хэмжээ 3% гэж тодорхойлогдсон тул, роялтийг 3% гэж тооцоонд ашигласан.
- Гол маргаантай асуудлууд
- Татварын байгууллага нь харьцуулагдах үнийн аргатай адилтгах аргаар татвар ногдуулж байгаагийн тухайд, Хяналтын доорх ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээ нь адил төстэй шинж чанартай юу гэсэн асуулт гарч байна.
- ➔ Нэхэмжлэгч тал нь төстэй шинж чанар байхгүй байна гэж эсэргүүцсэн
- Төстэй шинж чанар байхгүй тохиолдолд, зөрүүний тохируулга хийх шаардлагатай бус уу?

8

★Харьцуулагдах үнийн аргатай дүйцэх арга ба адилтгах арга

- Шүүхийн тайлбар
- Г Харьцуулагдах ажил гүйлгээний сонголтын тухайд, хамрах хүрээг өргөтгөж, адил төстэй биет бус хөрөнгийн ажил гүйлгээтэй адилтгах байдлаар сунгасан гарын үнийг тооцох арга гэж үзсэн.]

9

Шүүхээс бодит байдлыг тодруулан(лицензийн ажил гүйлгээний талаар)гаргасан шийдвэр

- Харьцуулагдах 23 ажил гүйлгээний зөвхөн 18-ийн хувьд 3% байна.
- Нэхэмжлэгчээс гадаад харилцан хамааралтай этгээдэд өгч байгаа эд анги үйлдвэрлэхтэй холбоотой технологийн мэдээлэл нь харьцуулагдах ажил гүйлгээ хоорондын технологийн мэдээллээс ялгаатай байна.
- Хяналтын доорх ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хэлбэр ялгаатай байна.
- Дээрх нөхцөл байдлаас 3% гэж тогтоох шалтгаан хангалтгүй байна.
- Гэхдээ, татварын байгууллагын сонгосон харьцуулагдах ажил гүйлгээ нь аль аль нь 2%-аас дээш байна.
- Мөн, Хяналтын доорх ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хувьд, тээврийн хэрэгслэлийн хөдөлгүүр ба удирдлагын эд анги хэмээн үйл ажиллагааны хувьд адил байна.

10

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Хяналтын доорх ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хооронд адил төстэй шинж чанар байна.

Зөрүүний тохируулга хийх шаардлагагүй.


Роялтийн хувьд 2% байхад болно.

- Шалтгаан?

11

Шүүхийн шийдвэрийн жишээ 3 Ажил гүйлгээний зураг

Хяналтын доорх ажил
гүйлгээ



Биет бус хөрөнгөтэй
холбоотой 3 ажил гүйлгээ

12

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

Татварын байгууллагын арга хэмжээ

- Электрон эд ангийн худалдаа, биет бус хөрөнгийн ажил гүйлгээнд үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулах.
- Гол маргаантай асуудал
 1. Гадаад харилцан хамааралтай этгээдээс ноогдол авдаг тул ТР татвар ногдуулах шаардлагагүй эсэх.
➔ нэхэмжлэгч тал нь ТР татвар ногдуулалт шаардлагагүй гэж эсэргүүцсэн
 2. CUP, RP, CP үндсэн 3 аргыг ашиглах боломжтой «нэг ажил гүйлгээ» юм биш үү?
➔ нэхэмжлэгч тал «нэг ажил гүйлгээ» гэж байгаа.
 3. Ажил гүйлгээ тус бүрээр үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглах уу?
➔ нэхэмжлэгч тал нь ажил гүйлгээ тус бүрээр үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглана гэж байгаа
 4. Үндсэн ашиг тооцоход харьцуулагдах ААН-ыг зохистой сонгосон эсэх.
➔ нэхэмжлэгч тал харьцуулагдах ААН-ын сонголт дээр хэсэгчилсэн алдаа байна гэж үзсэн.
 5. R&D зардлыг гадаад харилцан хамааралтай этгээд даасан байхад яагаад нэхэмжлэгчийн хуваарилалтын индикатороор авч үзсэн болох.
➔ нэхэмжлэгч нь гадаад харилцан хамааралтай этгээдийн даасан зардлыг энэ этгээдийн хуваарилалтын индикатороор авах ёстой гэж үзсэн.

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 1

1. Манай улсын ТР татварын тогтолцоонд гадаад харилцан хамааралтай этгээдээс ноогдол ашиг хуваарилсан бол ТР татварын тогтолцоог ашиглахгүй гэсэн заалт байхгүй.
2. Үндсэн 3 арга ба адилтгах аргыг ашиглах боломжтой «нэг ажил гүйлгээ» биш.
3. Нэхэмжлэгч ба гадаад харилцан хамааралтай этгээд нь тус бүртээ чухал биет бус хөрөнгөтэй байхаас гадна, энэ 3 ажил гүйлгээ нь харилцан уялдаатай байна.

Иймд, нэхэмжлэгч ба гадаад харилцан хамааралтай этгээдийн үйл ажиллагааны ашгийн нийлбэрт үндэслэн, нийт ажил гүйлгээг хамруулан үлдэгдэл ашгийн аргыг ашиглах нь зохистой.

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 2

4. Үндсэн ашгийг тооцох тохиолдолд, харьцуулагдах ААН нь

「Адил төрлийн үйл ажиллагаа эрхэлж, зах зээл, үйл ажиллагааны цар хүрээ адил төстэй бөгөөд, чухал биет бус хөрөнгөгүй хуулийн этгээдийг харьцуулагдах ААН-ээр сонгох шаардлагатай. 」

Харьцуулагдах ААН-ээс дараах тохиолдолд хасна:

- 1) Санхүүгийн тайлангийн тоон үзүүлэлтийн өөрчлөлт ихтэй.
- 2) Ашиг алдагдлын мэдээлэл зөвхөн богино хугацаанд гарсан ААН

15

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 3

5. Гадаад харилцан хамааралтай этгээдүүдийн биет бус хөрөнгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

1) Зөвхөн хуулийн хүрээний эзэмшлийн эрх биш

2) Биет бус хөрөнгийг бий болгоход холбогдогч талуудын оруулсан хувь нэмрийг тооцох

3) Биет бус хөрөнгийг бий болгохтой холбоотой шийдвэр гаргалт, үйлчилгээ үзүүлэх, зардал даах, эрсдлийн удирдлагад холбогдогч талуудын үүрэг хариуцлага хэр байсан зэрэг нэгдсэн байдлаар авч үзэх

4) Гадаад харилцан хамааралтай этгээд эрдэм шинжилгээний сэдэв тогтооход оролцож, хөгжүүлэлтийн явцад эрсдэл үүрэлцсэн байх.

5) Иймд, гадаад харилцан хамааралтай этгээдийн даасан R&D нь нэхэмжлэгч тал болох Японы ААН бус тухайн гадаадын этгээдийн хуваарилалтын индикатор болно.

16

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Татварын байгууллага үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан нь хуулийн хүрээнд байна.


Гадаад харилцан хамааралтай этгээдийн даасан R&D-ийн зардал нь нэхэмжлэгчийн хуваарилалтын хүчин зүйл биш байна.

- Шалтгаан?

17

Шүүхийн шийдвэрийн жишээ 4 Ажил гүйлгээний зураг

Хяналтын доорх ажил гүйлгээ



18

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

- **Татварын байгууллагын арга хэмжээ**
- Үйлдвэрлэл, худалдааны лицензийн ажил гүйлгээнд (Биет бус хөрөнгийн ашиглалтын зөвшөөрлийн ажил гүйлгээ) үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан.
- **Гол маргаантай асуудал**
Үлдэгдэл ашиг хуваах аргын хуваарилалтын хүчин зүйл юу болох.

19

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр

1. Нэхэмжлэгч нь дотоод ажил гүйлгээг харьцуулагдах ажил гүйлгээгээр авч, [Харьцуулагдах үнийн аргатай адилтгах арга]-ыг хэрэглэхийг шаардсан.
2. Дотоод ажил гүйлгээ ба гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний хувьд, ашиглалтын зөвшөөрлийн биет бус хөрөнгө нь адил төрөл болно.
3. Гэхдээ, ашиглалтын зөвшөөрөлтэй холбоотой нөхцөл шалгуур нь ялгаатай.
1)Ашиглалтын зөвшөөрлийн эхлэх хугацаа, 2)Хугацаа, 3)Ашиглалтын зөвшөөрлийн нөхцөл, 4)Зөвшөөрөлд мэргэжилтэн дагалдан томилогдох эсэх, 5)Ашиглахаар зөвшөөрөгдсөн борлуулалтын бүс нутаг нь гэрээнд ч, бодит байдал дээр ч ялгаатай.
4. Эдгээр нь сунгасан гарын үнэ ALP(роялтийн хувь)-д нөлөөлнө.
5. Нэхэмжлэгч нь эдгээр нь ALP-д нөлөөлөхгүй гэдгийг нотлоогүй байна.
6. Татварын байгууллага, хуваарилалтын хүчин зүйлээр, биет бус хөрөнгийг бүрдүүлэх ажлыг хариуцсан нэгжийн ажилтны, өөрөөр хэлбэл, [хэтэрсэн хүний нөөцийн зардал](= жилийн хүний нөөцийн зардал — холбогдох үйлдвэрлэлийн дундаж хүний нөөцийн зардал)-ыг авсан нь бодитой байна.

20

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Татварын байгууллага үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан нь хуулийн хүрээнд байна.


Нэхэмжлэгч талын тавьж буй дотоод ажил гүйлгээ нь харьцуулагдах ажил гүйлгээ болохгүй.

- Шалтгаан?

21

Шүүхийн шийдвэрийн жишээ 5 Ажил гүйлгээний зураг

Хяналтын доорх ажил гүйлгээ



22

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

Татварын байгууллагын арга хэмжээ

- Лицензийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний худалдаанд үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан.

Гол маргаантай асуудлууд

1. Лицензийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний худалдааны ажил гүйлгээг тус тусад нь авч үзэх ёстой эсэх.
⇒Татвар төлөгч нь тусдаа ажил гүйлгээ гэж үзэж байгаа.
2. Харьцуулагдах үнийн аргатай адилтгах аргыг ашиглах ёстой эсэх.
⇒Татвар төлөгчөөс энэ аргыг хэрэглэхийг шаардаж байгаа.
3. Үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглах ёстой эсэх.

23

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 1

1. Хагас боловсруулсан бүтээгдэхүүнд, лицензээр үйлдвэрлэх ноухаугийн нэг хэсэг шингэсэн байгаа. Мөн, лиценз эзэмшигч гадаад харилцан хамаарал бүхий этгээд нь энэхүү бүтээгдэхүүнийг нэхэмжлэгчээс худалдан авахыг үүрэг болгож байгаа. Иймд, хагас боловсруулсан бүтээгдэхүүний ажил гүйлгээнд ч биет бус хөрөнгийн ашиглалтын зөвшөөрлийн үнийн төлбөрийг авч байгаа гэж үзэхээр байгаа тул, лицензийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний худалдааны ажил гүйлгээ нь нэгдсэн зүйл гэж үзээд ALP-ийг тооцох боломжтой.
2. Эдгээр ажил гүйлгээний хувьд, 1)Биет бус хөрөнгө нь адил төрөл, гэхдээ 2)Ашиглалтын зөвшөөрлийн патент ба «технологийн мэдээлэл»-ийн хамрах хүрээ ялгаатай. 3)Лицензийн бүтээгдэхүүний бүтэц ялгаатай. 4)Борлуулалт ба зах зээлийн нөхцөл байдал ялгаатай. Иймд, эдгээр 2 ажил гүйлгээнд адил төстэй шинж чанар байхгүй байна.
⇒Иймд харьцуулагдах үнийн аргатай адилтгах аргыг ашиглахгүй.

24

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 2

3. Үндсэн ашгийг тооцоолохдоо, харьцуулагдах ажил гүйлгээг сонгохын тухайд

Нэхэмжлэгч: Гадаад харилцан хамааралтай этгээд нь нарийн, том оврын тоног төхөөрөмж шаардлагагүй байхад, татварын байгууллагаас SIC кодоор том оврын тоног төхөөрөмжийн ААН болон өөр бараа бүтээгдэхүүн бүхий ААН-ыг харьцуулагдах ААН-ээр сонгосон байна.

Шүүх:

- 1)Татварын байгууллагын сонгосон SIC код бодитой бус байна.
- 2)Үлдэгдэл ашиг хуваах арга нь үйл ажиллагааны ашгийн түвшинг ашигладаг тул, нийт ашгийн хувьтай харьцуулаад, ажил гүйлгээний (бүтээгдэхүүн) зөрүүний нөлөөлөлд орох нь бага.

25

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр 3

4. Үлдэгдэл ашиг хуваах аргын хуваарилалтын хүчин зүйлийн тухайд, Нэхэмжлэгч тал: Гадаад харилцан хамаарал бүхий этгээд нь 24 цагийн турш асуудалд хариулт өгөх нэгжтэй бөгөөд энэ нь биет бус хөрөнгийг бий болгоход ихээхэн хувь нэмрээ оруулсан.

Шүүх: Энэ нэгжийн үйл ажиллагаа нь туслах чанартай.

5. Үлдэгдэл ашиг хуваах аргын хуваарилалтын хүчин зүйлийн тухайд, Татварын байгууллага: Нэхэмжлэгчийн хуулийн нэгжийн зардал ч хуваарилалтын хүчин зүйл болно.

Шүүх: Хуулийн нэгжийн зардалд, харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ажил гүйлгээтэй холбоотой зардал бас орсон байгаа тул, үүнийг хуваарилалтын хүчин зүйлийн зардлаас хасч тооцох нь зүйтэй.

26

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан


- Дүгнэлт

Татварын байгууллага үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан нь хуулийн хүрээнд байна. Гэхдээ, татварын байгууллагын хуваарилалтын хүчин зүйлийн нэг хэсэг алдаатай байгаа тул энэ хэсгээр хязгаарлан, татварын байгууллагын авсан арга хэмжээг хүчингүйд тооцох.

- Шалтгаан?

27

Шүүхийн шийдвэрийн жишээ 6 Ажил гүйлгээний зураг (Global trading)



28

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

Татварын байгууллагын арга хэмжээ

- Global trading-д үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулах

Гол маргаантай асуудлууд

1. Үндсэн 3 арга, эсхүл дүйцэх ба адилтгах аргыг ашиглах боломжтой эсэх.
2. Үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглах боломжтой эсэх.

29

Шүүхээс бодит байдлыг тодруулан гаргасан шийдвэр

1. Харьцуулагдах ажил гүйлгээг олоогүй тул үндсэн 3 аргатай адилтгах ба дүйцэх аргыг ашиглах боломжгүй.
2. Энэ тохиолдолд, ашгийн анхдагч хуваарилалт дахь үндсэн ашиг гэж үзэж болохоор ашгийн тухайд, худалдаа ба эрсдлийн удирдлагын үйл ажиллагаатай харьцуулаад ашиг олох үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр багатай үйл ажиллагаа байна.

Хоёрдогч ашгийн хуваарилалтын хүрээнд үлдэгдэл ашгийг бүрдүүлж байгаа нь 1)Худалдааны үйл ажиллагаа, 2)Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа байна.

30

Шүүхийн дүгнэлт ба шалтгаан

- Дүгнэлт

Татварын байгууллага үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан нь хуулийн хүрээнд байна. Борлуулагчийн хүний нөөцийн зардал ба хөрөнгө бүрдүүлэх өртгийг хуваарилалтын хүчин зүйл болгох.

- Шалтгаан?

31

Японы үнэ шилжилтийн жишээний гол асуудлууд

- Жишээ 1 Үйл ажиллагааны дахин зохион байгуулалтын жишээ (RP)
- Жишээ 2 RPSM үндсэн ашиг, харьцуулагдах ААН-ын жишээ (RPSM)
- Жишээ 3 Жишиг татвар ногдуулалтын жишээ (жишиг татвар ногдуулалт)


32

1 Японы охин компанийн үйл ажиллагааг дахин зохион байгуулсан жишээ

- Анхны хэлбэр



- Зохион байгуулалтын дараа (ТР хяналт шалгалт хийх үед)



33

Харьцуулагдах ААН-ын асуудалтай тал

- Татварын байгууллага нь RP аргаар (Дүйцүүлэх ба адилтгах арга) татвар ногдуулсан боловч, сонгосон харьцуулагдах ажил гүйлгээ нь Японы охин компанийн зохион байгуулалтын өмнөх хэлбэртэй төстэй бөгөөд шинэчлэлтийн дараах хэлбэрээс ялгаатай.
- Анхны хэлбэр нь дамжуулан борлуулалтын ажил гүйлгээ байсан бол шинэ хэлбэр нь үйлчилгээ үзүүлэх
- Татварын байгууллагын сонгосон харьцуулагдах ажил гүйлгээний хувьд ч шинэ хэлбэрийн охин компанийн адилаар «Агуулахын үлдэгдлийн эрсдэл» байдаггүй тул харьцуулагдах боломжтой гэж үзсэн.




34

Үйл ажиллагааны өөрчлөлтийн асуудал ба BEPS-ийн санал

- Энэ тохиолдол нь BEPS-ийн нийтлэг жишээ
- Бие даасан ААН –ын хооронд бол энэхүү гадаад хяналттай ажил гүйлгээтэй адил үйлчилгээ үзүүлэх ажил гүйлгээг хийдэггүй.
- Иймд, давж заалдах шатны шүүхээс, чиг үүрэг ба эрсдэл талаас нь харвал, татварын байгууллагын сонгосон харьцуулагдах ААН ба Японы ААН-ыг харьцуулах боломжгүй гэж үзсэн. (анхан шатны шүүх харьцуулагдах боломжтой гэж үзсэн)
- BEPS-ээр ийм тохиолдолд, дараах 2 байдлаар авч үздэг.
- ① PS аргыг ашиглах (энд, ашиг хуваах хүчин зүйлсийн асуудал байна)
- ② Шинэ хэлбэрийн Японы ААН-ыг гадаад харилцан хамааралтай этгээдийн PE гэж үзэх ➔ OECD загвар гэрээний 5-р зүйлийн PE тодорхойлолтын өргөжүүлсэн санал

35

Х автомашины компанийн TP татвар ногдуулалт Ажил гүйлгээний зураг



36

Татварын байгууллагын арга хэмжээ, гол маргасан асуудлууд

Татварын байгууллагын арга хэмжээ

- Бараа материалаарх хөрөнгө болох 2 дугуйтын ажил гүйлгээнд үлдэгдэл ашиг хуваах аргаар татвар ногдуулсан.
- Энэ ТРМ-ийн дотроос харьцуулагдах ажил гүйлгээний нийт зардал үйл ажиллагааны ашгийн түвшний дундаж утгыг Бразил талын үндсэн ашгийн хувь болгодог [Нийт зардал үйл ажиллагааны ашгийн түвшний арга]-ыг ашигласан.
- Энэ үндсэн ашгийн хувь \times [Гадаад харилцан хамааралтэй этгээдийн нийт зардал—гадаад харилцан хамааралтай этгээдийн гаргасан чухал биет бус хөрөнгийн үнэ цэнийн индикатор болох зардал]= Бразилийн гадаад харилцан хамааралтай этгээдийн үндсэн ашиг болно.

Гол маргаантай асуудал

1. Энд байх олон ажил гүйлгээ нь [нэг ажил гүйлгээ] болох уу?
2. Үлдэгдэл ашиг хуваах аргыг ашиглах нь татварын хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй юу?
3. Үндсэн ашиг тооцоход гадаад харилцан хамааралтай этгээд ба харьцуулагдах ААН-ыг харьцуулах боломж байна уу?

➔ 3 нь хамгийн гол маргаантай асуудал !!!

37

Хамгийн чухал асуудал: RPSM-ийн хүрээнд, суурь ашгийг тооцохдоо, харьцуулагдах ААН-ЫН СОНГОЛТЫГ ЗӨВ ХИЙСЭН ЭСЭХ.

- RPSM-ийн эхний алхам: Суурь ашгийг тооцох
 - ➔ харьцуулагдах боломж бүхий ААН-ыг сонгох
- Энэ жишээн дээр татварын байгууллага нь Манаусын чөлөөт бүсийн гадна байх Сан Паулогийн ойролцоох ААН-ыг сонгосон.
- Шүүх нь [Бразилийн гадаад харилцан хамааралтай этгээдийн үйл ажиллагааны ашгийн ихэнхийг Манаусын татварын хөнгөлөлтөөс үүдэлтэй гэж үзнэ. Иймд энэ бүсийн гадна байгаа ААН нь энэхүү гадаад харилцан хамааралтай этгээдтэй харьцуулагдах боломжгүй] гэж үзсэн.

38

Үйл ажиллагааны ашгийн түвшингийн (OMR)харьцуулалт(жишээ)

- Японы толгой компанийн Бразил дахь охин компанитай хийх ажил гүйлгээний OMR : 7%
 - Бразил дахь охин компанийн Японы толгой компанитай хийх ажил гүйлгээний OMR : 20%
 - Бразилийн охин компанийн байгаа Манаусын чөлөөт бүсэд харьяалагдах Бразилийн ААН-ын OMR-ын дундаж : 18%
 - Манаусын гаднах ААН-ын OMR-ын дундаж : 6%
- ↓
- Q Хэрвээ, татварын байгууллага нь, Манаусын бүс доторх ААН-ыг RPSM-ийн суурь ашгийн тооцоонд Бразилийн охин компанийн харьцуулагдах ААН-ээр сонговол яах вэ.
 - A Суурь ашгаас хэтрэх үлдэгдэл ашиг бараг үүсэхгүй байсан.

39


Жишээний тайлбар: Сато өмгөөлөгчийн санал бодол

- [Манаус нь Бразилийн эдийн засгийн төв болох Сан Паулогоос хол Амазоны ай савд байрлах хот юм. Энд гадаадын ААН-ыг татахын тулд Үндсэн хуулийн хүрээнд чөлөөт бүс болгон, татварын хөнгөлөлт эдлүүлдэг ба энд дурьдсан ААН-ээс гадна хэд хэдэн ААН энэхүү бүсэд байрладаг. Энэ бүсийн ААН-ын хувьд, Сан Паулогийн OMR(Operating Margin Ratio)-ийг адил гэж үзэх нь үнэхээр боломжгүй]
- [Энэ утгаараа энэхүү шийдвэр нь үнэ шилжилтийн татварын тогтолцоо талаасаа ч шүүхийн шийдвэр талаасаа ч чухал жишээ болсон шийдвэр байсан.]


40

Жишээ 3 Жишиг татвар ногдуулалт

1999 оны 11 сараас өмнө



1999 оны 12 сараас хойш



41

Үнэ шилжилтийн хяналт шалгалт

- Татварын байгууллага нь А компанид хяналт шалгалт хийж, худалдан авалтын үнэ 2 дахин нэмэгдсэнийг тогтоосон.
- Татварын албаны дарга нь А компаниас хуулийн дагуу санхүүгийн бичиг баримт ба энэ удаагийн ажил гүйлгээний үнэ тооцохтой холбоотой үндэслэл болох бичиг баримтыг шаардсан боловч гаргаж өгөөгүй.
- Иймд, холбоотой ажил гүйлгээ хийдэг тухайн салбарын төстэй үйл ажиллагаа явуулдаг 3 ААН-ыг хаалттай мэдээллийн дагуу сонголт хийн, Татварын тусгай арга хэмжээний тухай хуулийн 66-4-7-ийн дагуу тооцсон үнийг ALP(бодит үнэ) хэмээн залруулга хийх арга хэмжээ авсан.
- А компани нь жишиг татвар ногдуулалтын нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрөхгүй, тооцсон бодит үнийг зохистой бус хэмээн үзэж, авсан арга хэмжээг хүчингүй болгохыг шаардсан.

42

Токио хотын шүүхийн 2011 оны 12 сарын 1-ний шийдвэрийн ач холбогдол

- ТР татвар ногдуулалт бөгөөд жишиг татвар ногдуулалтыг анх удаа хүлээн зөвшөөрсөн.
- «Татварын тусгай арга хэмжээний тухай хуулийн 66-р зүйлийн 4⑥(одоогийн ⑧⑨) заалтын зорилго нь хяналтын доорх ажил гүйлгээний бодит үнэ тооцох үндэслэл болох нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг татвар төлөгчөөс гаргуулах үйлдлийг баталгаажуулах явдал.»
- «Хамтран ажиллаагүй тохиолдолд, татварын байгууллага ямар ч арга хэмжээ авахгүй орхих нь ТР татварын тогтолцооны тэгш шударга байдлыг хангах боломжгүй болох тул жишиг татвар ногдуулалтын тогтолцоог бүрдүүлсэн.»
- «...татвар төлөгчид тухайн үед байхгүй байсан ч шинээр бэлтгэн гаргаж өгөх боломжгүй биш, ...тухайн бичиг баримтыг гарган өгөөгүй бол жишгээр татвар ногдуулалт хийх нөхцөл бүрдэнэ. »
- «Үйл ажиллагааны төрөл адил байхыг хатуу шаардахгүй.»
- «Мөн, ⑥(одоогийн ⑧⑨) заалтаар, адил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ыг сонгох тохиолдолд, харилцан хамааралтай ажил гүйлгээ эрхэлж буй ААН-ыг оруулахгүй байх талаар заалт байхгүй.»

43

ТР жишиг татвар ногдуулалт (ТАХТХ66-4⑥(одоогийн⑧⑨)заалтын хураангуй)

- ТЕГ, хуулийн этгээдийг харьяалах татварын албаны байцаагч нь хуулийн этгээдийн тайлант хугацаанд хамаарах хяналтын доорх ажил гүйлгээтэй холбоотой бөгөөд Сангийн яамны тушаалд Бодит үнэ тооцоход шаардлагатай бичиг баримт хэмээн заасан зүйл, эсхүл хуулбарыг гарган өгөхийг шаардах тохиолдолд,
- Хуулийн этгээд тэдгээрийг яаралтай гарган өгөх, эсхүл гарган өгөөгүй бол татварын албаны дарга дараах аргаар тооцоо хийсэн үнийн дүнг бодит үнэ хэмээн үзэж, хуулийн этгээдийн тухайн тайлант хугацааны орлогын үнийн дүн, эсхүл зарлагыг залруулга хийх боломжтой.
- Хуулийн этгээдийн хяналтын доорх ажил гүйлгээтэй адил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үйл ажиллагааны цар хүрээ, агуулга нь төстэй байх ажил гүйлгээний нийт борлуулалтын ашгийн түвшин, эсхүл хууль тогтоомжоор үүнтэй дүйцэх хувь хэмжээ хэмээн тогтоосон хувь хэмжээнд суурилсан арга

44

Олон улсын татвар ногдуулалтын гүнзгий шатны сургалт

(2019.08.26 – 2019.08.30)

	8/26/2019	8/27/2019	8/28/2019	8/29/2019	8/30/2019
	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
Үдээс өмнө (9:00-12:00)	(Өмнөх шалгалт) Үнэ шилжилтийн хяналт шалгалтын зөрүүгийн тохируулга	Үнэ шилжилтийн татвар ногдуулалтын жишээндээр суралцах (Зөрүүгийн тохируулгын жишээ)	Үнэ шилжилтийн татвар ногдуулалтын жишээндээр суралцах (Зөрүүгийн тохируулгын жишээ)	Үнэ шилжилтийн татвар ногдуулалтын жишээндээр суралцах (Зөрүүгийн тохируулгын жишээ)	Асуулт хариулт
	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино
Үдээс хойш (13:00-16:00)	(Өмнөх шалгалт) Үнэ шилжилтийн хяналт шалгалтын зөрүүгийн тохируулга	Үнэ шилжилтийн татвар ногдуулалтын жишээндээр суралцах (Зөрүүгийн тохируулгын жишээ)	Үнэ шилжилтийн татвар ногдуулалтын жишээндээр суралцах (Зөрүүгийн тохируулгын жишээ)	Нэгдсэн хэлэлцүүлэг (Дараах шалгалт)	Асуулт хариулт
	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино, Ишигүро	Тажино

Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийн жагсаалт

№	Нэрс	Харьяа нэгж
1	Ч.Эрдэнэчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУАБ
2	Х.Сувд-Эрдэнэ	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
3	Б.Ариунчимэг	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
4	Н.Жаргалцэцэг	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
5	Ж.Цэрэнцоо	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
6	А.Сувдаа	ТЕГ-ын Татвар төлөгчтэй харилцах газрын ТУБ
7	Г.Энхжин	ТЕГ-ын Татварын орлогын газрын ТУБ
8	Ц.Баярмаа	ТЕГ-ын Дотоод аудитын газрын ТУБ
9	Ш.Ундраа	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
10	Н.Туул	ТЕГ-ын Сургалтын төвийн ТУБ
11	Б.Батчимэг	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
12	С.Гүнжинлхам	ТЕГ-ын Татварын үйлчилгээний төвийн ТУБ
13	С.Төгсжаргал	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУАБ
14	Ц.Дэлгэрмаа	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
15	Г.Бямбасүрэн	УТОХГ-ын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн ТУБ
16	Д.Батжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУАБ
17	П.Отгонсүрэн	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
18	Н.Болорчимэг	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
19	Н.Мөнхдаваа	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
20	Н.Хандхүү	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
21	Б.Төгсжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ
22	Ш.Энхжаргал	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ

23	Ё.Мөнхбат	УТОХГ-ын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн ТУБ
24	Б.Уранцэцэг	УТОХГ-ын Эрсдэл, статистикийн хэлтсийн ТУБ
25	Г.Банзрагч	УТОХГ-ын Татварын орлогын хэлтсийн ТУБ
26	Х.Алтанхүү	УТОХГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
27	О.Цэнд-Аюуш	НТГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтэс
28	Ж.Эрдэнэбүрэн	НТГ-ын Захиргааны хэлтсийн ТУБ
29	Ч.Лхамрагчаа	ЧД-ын Татварын хэлтсийн ТУБ
30	Л.Даваасүрэн	БЗД-ын Татварын хэлтсийн ТУБ
31	Д.Солонго	СБД-ын Татварын хэлтсийн ТУБ
32	С.Наранбаатар	Дорнод аймгийн Татварын хэлтсийн ТУБ
33	Д.Наранцэцэг	Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн дарга
34	С.Дүүбаяр	Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн ТУБ
35	Б.Ариунгэрэл	ТЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ТУБ
36	Л.Мөнхтуул	ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газрын ТУБ
37	Ц.Ишжамц	УТОХГ-ын Татварын хяналт шалгалтын хэлтсийн ТУБ

Comparability Adjustments

Харьцуулагдах байдлын тохируулга

August 26-30, 2019
Prof. Hideaki ISHIGURO
Prof. Mikio TAJINO

1

Гарчиг

I Зөрүүний тохируулга (Comparability Adjustments)

II Кэйс дээр ажиллах

III Асуулт, хариулт

2

I Харьцуулагдах байдлын тохируулга (Comparability Adjustments)

3

1. Үнэ шилжилтийн хяналт шалгалтын дэс дараалал

(1) Хяналт шалгалтанд хамрагдах ААН-ыг сонгох

Local File –ийг ашиглан хяналт шалгалтанд хамрагдах ААН-ыг сонгох

(2) Бэлтгэл хяналт шалгалт

Тухайн салбарын талаарх мэдээлэл болон санхүүгийн мэдээллийг судлах

(3) Хяналт шалгалтыг эхлүүлэх

Хяналтын доорх ажил гүйлгээний бодит байдлыг тодруулах г.м

(4) Асуудал бүхий ажил гүйлгээг тусгайлан авч үзэх

Хүлээх үүрэг, оролцоо, эрсдэлийг авч үзэхийн хамт, ТРМ ба шалгах ААН-ыг тодорхойлох.

(5) Харьцуулагдах ажил гүйлгээг сонгох

① Дотоод харьцуулагдах ажил гүйлгээ

② Гадаад харьцуулагдах ажил гүйлгээ (ААН) •••Нээлттэй мэдээллийн санг ашиглах

Харьцуулагдах байдлын шинжилгээ (тоон ба чанарын шинжилгээ), **зөрүүний тохируулга**



4

1. Үнэ шилжилтийн хяналт шалгалтын дэс дараалал(үргэлжлэл)

(6) ALP тооцох

- ① Харьцуулагдах ажил гүйлгээ, ТРМ-ийг ашиглах
- ② ALP (ашгийн түвшин) хэд хэд байгаа тохиолдолд, ...Интервал(Range)-ыг ашиглах

(7) Татвар төлөгчтэй санал солилцох

Татвар төлөгчийн тавьж буй асуудлын агуулгыг авч үзэх

(8) Үнэ шилжилтийн татвар ногдуулалт

Баг дотроо эцсийн хэлэлцүүлэг хийх, дүгнэлт гаргах

(9) Татвар төлөгчдөд зааварчилгаа өгөх

Харилцан тохироо, гомдол маргаан гаргах



5

2. Харьцуулагдах байдлын 5 хүчин зүйлс (OECD TPG para 1.36)

(1) Ажил гүйлгээний гэрээний нөхцөл

(2) Холбогдох талуудын хэрэглэж буй хөрөнгө, хүлээх эрсдэл, гүйцэтгэх үүрэг, ажил гүйлгээний нөхцөл байдал, салбарын үйл ажиллагаа

(3) Шилжүүлэх хөрөнгө, үзүүлэх үйлчилгээний онцлог

(4) Холбогдох талууд ба холбогдох талуудын үйл ажиллагаа явуулах зах зээлийн эдийн засгийн нөхцөл байдал

(5) Холбогдох талуудын үйл ажиллагааны стратеги



6

3. Зөрүүний тохиргооны талаар

(1) Зөрүүний тохиргооны зорилго

Тохируулга хийснээр, харьцуулагдах байдлыг (үр дүнгийн найдвартай байдал) дээшлүүлэх.

(2) Зөрүүний тохиргоо хийх шаардлагатай эсэх

Хяналтын доорх ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний хооронд үнэ, эсхүл ашгийн түвшинд материаллаг нөлөө үзүүлэх зөрүү байгаа бөгөөд тодорхой түвшний үнэн зөв тохируулга хийх боломжтой байх үед хэрэгжүүлнэ.

① Зөрүү байгаа боловч, үнэ эсхүл ашгийн түвшинд нөлөөлөхгүй тохиолдолд,

➔ **Зөрүүний тохируулга шаардлагагүй**

② Үнэ эсхүл ашгийн түвшинд нөлөө бүхий зөрүү байгаа боловч, тодорхой түвшний зөв тохируулгыг хийх боломжгүй тохиолдолд,

➔ **Харьцуулагдах байдалд асуудал байна.**

7

3. Зөрүүний тохиргооны талаар

(1) Харьцуулагдах гэдэг нь харьцуулж буй нөхцөл байдлуудын хоорондын зөрүү байхгүй, хэрвээ байгаа бол энэ нь тухайн шалгаж буй нөхцөлд материаллаг нөлөө үзүүлэхгүй, эсхүл энэхүү зөрүүг арилгахын тулд үнэн зөв тохируулга хийх боломжтой байхыг хэлнэ. (TPG Заалт 3.47)

(2) Зөрүүний тохируулгыг хийснээр үр дүнгийн найдвартай байдал нэмэгдэх тохиолдолд(зөвхөн энэ тохиолдолд)авч үзэх нь зүйтэй. (OECD TPG Заалт 3.50)

(3) Харьцуулагдах байдлын тохируулгыг зөвхөн харьцуулалтад материаллаг нөлөө үзүүлэхүйц зөрүүгийн хувьд хийх нь тохиромжтой. Татвар төлөгчийн оролцсон хяналтын доорх ажил гүйлгээ болон гуравдагч талын харьцуулагдах зүйлсийн хооронд зарим ялгаа үргэлж гардаг. Зөрүү нь харьцуулалтын найдвартай байдалд материаллаг нөлөө үзүүлэхээргүй тохиолдолд, зөрүүгийн тохируулга хийхгүй байсан ч харьцуулалт зохистой байх магадлалтай. Гэвч, харьцуулагдах байдлын үндсэн хүчин зүйлсийн тухайд, олон тооны тохируулга хийх шаардлагатай байх нь энэхүү гуравдагч талын хооронд хийгдсэн ажил гүйлгээ нь үнэн хэрэгтэй хангалттай түвшинд харьцуулалт хийх боломжгүй байгааг харуулж байна. (TPG Заалт 3.51)

8

4. Зөрүүний төрөл (жишээ)

(1) Ажил гүйлгээтэй холбоотой зөрүү

- ① Бараа материалаарх хөрөнгийн төрөл, үйлчилгээний агуулга
- ④ Гэрээний нөхцөл
- ② Ажил гүйлгээний шатлал(бөөний, жижиглэн г.м)
- ⑤ Ажил гүйлгээний хугацаа
- ③ Ажил гүйлгээний хэмжээ

(2) Холбогдох талуудтай холбоотой зөрүү

- ⑥ Гүйцэтгэх үүрэг
- ⑧ Ашиглах биет бус хөрөнгө
- ⑦ Хүлээх эрсдэл
- ⑨ Үйл ажиллагааны стратеги, ня-бо бүртгэлийн чиглэл

(3) Зах зээлтэй холбоотой зөрүү

- ⑩ Зах зээлд нэвтэрсэн хугацаа
- ⑪ Төрийн хязгаарлалт
- ⑫ Зах зээлийн нөхцөл байдал



9

5. Зөрүүний тохируулга хийх жишээ

(1) Худалдааны нөхцөлийн ялгаа

Олон улсын ажил гүйлгээний хүрээнд худалдааны CIF(тээвэр, даатгал орсон) болон FOB(усан онгоцон дээр хүлээлцэх) нөхцөл их хэрэглэгддэг боловч, энэ нөхцөлийн ялгаа нь үнэд нөлөөлөх тохиолдолд, зөрүүний тохируулга шаардлагатай.

Худалдааны нөхцөлийн зөрүүний тухайд, харьцуулагдах ажил гүйлгээ нь хяналтын доорх ажил гүйлгээтэй адил худалдааны нөхцөлөөр хийгдсэн гэвэл, бүтээгдэхүүний үнэ хэд болох вэ гэдэг талаас нь тохируулгыг хийнэ.

(2) Төлбөрийн нөхцөлийн ялгаа

Энгийн худалдааны ажил гүйлгээний тухайд, бүтээгдэхүүний төлбөрийн хугацаа урт байгаа бол тухайн хугацааны хүүгийн хэмжээгээр бүтээгдэхүүний үнэ өсөх ба төлбөрийн нөхцөлийн ялгаа нь үнэд нөлөө үзүүлэхээр бол тохируулга хийх шаардлагатай.

Төлбөрийн нөхцөлийн ялгааны тухайд, харьцуулагдах ажил гүйлгээ нь хяналтын доорх ажил гүйлгээтэй адил төлбөрийн нөхцөлөөр хийгдсэн гэвэл, бүтээгдэхүүний үнэ хэд болох вэ гэдэг талаас нь тохируулгыг хийнэ.

10

5. Зөрүүний тохируулга хийх жишээ

(3) Ажил гүйлгээний хэмжээний зөрүү

Энгийн худалдааны ажил гүйлгээний хүрээнд, тоо хэмжээ их байх тусам хямдрах, буцаалт хийх тохиолдол байдаг бөгөөд эдгээр нь бүтээгдэхүүний үнэд нөлөө үзүүлэх тохиолдолд, зөрүүний тохиргоо хийх шаардлагатай.

Жишээлбэл, харьцуулагдах ажил гүйлгээний гэрээний нөхцөлд тоо хэмжээнээс хамаарсан хямдрал, буцаалтын нөхцөл байгаа тохиолдолд, хяналтын доорх ажил гүйлгээний тоо хэмжээг харьцуулагдах ажил гүйлгээний нөхцөлд нийцүүлэн тохируулга хийнэ.

(4) Чиг үүргийн зөрүү

Чиг үүргийн ялгаатай бөгөөд энэ нь ашгийн түвшинд нөлөө үзүүлэх тохиолдолд тохируулга хийх шаардлагатай.

Жишээлбэл, чиг үүргийн (сурталчилгаа гэх мэт) зөрүүнээс үүсэх нөлөөллийг хяналтын доорх ажил гүйлгээ ба харьцуулагдах ажил гүйлгээний холбогдогч талуудын төлсөн зардлын дүнгээр тооцох боломжтой болон энэхүү зөрүү нь ашгийн түвшинд үзүүлэх нөлөөг санхүүгийн өгөгдлөөс хасах боломжтой тохиолдолд, тохируулгыг хийх хэрэгтэй.

11

5. Зөрүүний тохируулга хийх жишээ

(5) Бараа материалаарх хөрөнгийн үнэлгээ хийх аргын зөрүү

Бараа бүтээгдэхүүний үнэ хэт өсөх (Inflation)эсхүл унасан (Deflation) тохиолдолд, бараа материалаарх хөрөнгийн үнэлгээ хийх аргын ялгаа нь ашгийн түвшинд нөлөө үзүүлэх тул зөрүүний тохируулга хийх шаардлагатай.

Жишээлбэл, бүтээгдэхүүний үнэ өсөж байгаа тохиолдолд, LIFO(сүүлд авснаа, эхэлж зарлагдах арга) аргыг ашигласан тохиолдолд, FIFO(эхэлж авсныг, эхэлж зарлагдах арга) аргатай харьцуулаад бараа материалаарх хөрөнгө нь харьцангуй багаар, борлуулалтын өртөг харьцангуй ихээр тусгагддаг тул ашгийн түвшин буурна. Шалгах ААН-ын ашиглаж буй үнэлгээний аргыг харьцуулж буй ААН-д нийцүүлэн тохируулгыг хийнэ.

【Жич】FIFO/LIFO ба борлуулалтын өртгийн хамаарал

	FIFO	LIFO
Үнийн өсөлт (Inflation)	Бараа материалаарх хөрөнгө: их Борлуулалтын өртөг: бага	Бараа материалаарх хөрөнгө: бага Борлуулалтын өртөг: их
Үнийн бууралт (Deflation)	Бараа материалаарх хөрөнгө: бага Борлуулалтын өртөг: их	Бараа материалаарх хөрөнгө: их Борлуулалтын өртөг: бага

5. Зөрүүний тохируулга хийх жишээ

(6) Ажлын капиталын зөрүү (OECD TPG para 3.49)

Г(2)-ийн төлбөрийн нөхцөлийн зөрүүг хэсэгт дурьдсанчилан, барааны төлбөрийн хугацааны зөрүү нь үнэд нөлөө үзүүлдэг. Гэхдээ, нээлттэй мэдээллээр энэхүү зөрүүг тодорхойлоход хүндрэлтэй бөгөөд тохируулга хийх аргын тухайд, Г Ажлын капиталын тохируулга (Working Capital Adjustment) J(жич) гэж нэрлэгддэг аргаар тохируулга хийнэ.

Ажлын капиталын тохируулга нь тайлан баланс дээр ① борлуулалтын авлага, ② худалдан авалтын өглөг, ③ бараа материалаарх хөрөнгийн 3 дансанд тусгагддаг. Шалтгааныг доор тодруулав:

① Борлуулалтын авлагын тохируулга

Барааны төлбөрийг цуглуулах хугацаа нь урт байвал, хүүтэй дүйцэх хэмжээгээр үнийг өсгөн борлуулдаг тул төлбөрийг цуглуулах хугацаа урт байх тусам үнэ өсөж, ашгийн түвшин бас өсдөг. Үнэд үзүүлэх нөлөөг борлуулалтын авлагын хувиар (тайлант хугацааны дундаж борлуулалтын авлага ÷ борлуулалт) тооцох боломжтой.

② Худалдан авалтын өглөгийн тохируулга

Борлуулалтын авлагатай адил байдлаар тооцох ба худалдан авалтын өглөгийн хувьд, төлбөрийн хугацаа урт байх тусам худалдан авалтын үнэ өсөж, ашгийн түвшин буурна. Үнэд үзүүлэх нөлөөг худалдан авалтын өглөгийн хувиар (тайлант хугацааны дундаж худалдан авалтын өглөг ÷ борлуулалтын өртөг) тооцох боломжтой.

(жич) Ажлын капиталын тохируулгыг хөрөнгийн нэгтгэсэн тохируулга (Asset Intensity Adjustment) гэж нэрлэх тохиолдол байдаг.

13

5. Зөрүүний тохируулга хийх жишээ

(6) Ажлын капиталын зөрүү

③ Бараа материалаарх хөрөнгийн тохируулга

Ер нь агуулахын үлдэгдэл ихтэй байх нь дараах давуу талтай бөгөөд ашгийн түвшинг нэмэгдүүлдэг гэж үздэг.

- 1) Нийлүүлэгчээс их хэмжээгээр худалдан авалт хийх тул хямдрал (Volume Discount) эдэлнэ.
- 2) Харилцагчийнхаа их хэмжээтэй захиалгыг түргэн нийлүүлэх боломжтой тул нэмэлт өгөөж (Premium) хүртэнэ.

Нөгөө талаас, агуулахын үлдэгдэл их байх нь борлогдохгүй үлдэгдэлтэй байх тохиолдол бас байдгыг анхаарч, болгоомжтой ашиглах хэрэгтэй. Үнэд үзүүлэх нөлөөг бараа материалаарх хөрөнгийн хувь хэмжээгээр (тайлант хугацааны дундаж бараа материалаарх хөрөнгө ÷ борлуулалт) тооцох боломжтой.

(Тохируулгад ашиглах хүүгийн хувь)


Тохируулгад богино хугацаат хүүг ашиглана. Борлуулалтын авлага ба худалдан авалтын өглөгийн үнийн дүнд хүүтэй дүйцэх үнийн дүнг оруулан тооцсон байдаг тул энэ үнийн дүнг хасах шаардлагатай. Тохируулгад Г хүүгийн хувь / (1 + хүүгийн хувь) J-ийг ашиглана. Нөгөө талаас, бараа материалаарх хөрөнгөд хүүтэй дүйцэх үнийн дүн ордоггүй ба энэхүү хөрөнгө нь өөрөө ашгийг бий болгодог гэж үздэг тул хүүгийн хувийг тэр чигт нь хэрэглэдэг.

14

5. Зөрүүний тохируулга хийх жишээ

(6) Ажлын капиталын зөрүү

【Тооцооны жишээ】



А. Тохируулгын үнийн дүнг тооцох арга

$$\text{Борлуулалтын авлагын тохируулга} = \left(\frac{\text{Avg. ARt}}{\text{Sale t}} - \frac{\text{Avg. ARc}}{\text{Sale c}} \right) \times \text{Sale c} \times \frac{i}{1+i}$$

В. Тохируулгын түвшинг (%) тооцох арга

$$\text{Борлуулалтын авлагын тохируулга} = \left(\frac{\text{Avg. ARt}}{\text{Sale t}} - \frac{\text{Avg. ARc}}{\text{Sale c}} \right) \times \frac{i}{1+i}$$

Avg. ARt: шалгагдах ААН-ын тайлант хугацааны дундаж борлуулалтын авлага
Avg. ARc: харьцуулагдах ААН-ын тайлант хугацааны дундаж борлуулалтын авлага
Sale t: шалгагдах ААН-ын борлуулалт Sale c: Харьцуулагдах ААН-ын борлуулалт i: Хүүгийн хувь

15

5. Зөрүүний тохируулга хийх жишээ

(7) Квартил арга (OECD TPG para 3.57)

Өмнө дурьдсанчилан зөрүүний тохиргоо хийсэн ч тоон үзүүлэлтээр тодорхойлох боломжгүй зөрүү байгаад, энэхүү зөрүү нь ашгийн түвшинд үзүүлэх нөлөө бага бол квартил аргыг ашиглах нь үр нөлөөтэй.

Квартил арга гэдэг нь харьцуулагдах боломжийг нэмэгдүүлэх статистик арга бөгөөд өгөгдлийг багаас нь жагсаан 4 тэнцүү хэсэгт хуваан, дээд ба доод хязгаарын 25% доторх өгөгдлийг устган, үлдсэн өгөгдлөөр интервал үүсгэн шинжилгээ хийх арга юм. Энэхүү хүрээг квартил интервал (Inter-quartile Range) гэдэг.

Квартил арга нь харьцуулагдах ААН-ын ашгийн түвшинг, ашгийн түвшний шалгуур үзүүлэлт (PLI) болгон ашигладаг үнэ шилжилт тооцох аргыг (TRM) ашиглах тохиолдолд, харьцуулагдах ААН-ын тоо нь тодорхой тооноос давсан (багадаа 8 компаниас илүү) үед ашигладаг.

Квартил аргаар шинжилгээ хийхэд, шалгагдах ААН-н ашгийн түвшин нь харьцуулагдах ААН-ын ашгийн түвшнээр үүсгэсэн квартил интервалын доод хязгаараас дээш байвал үнэ шилжилтийн хувьд асуудалгүй гэж үздэг. Нөгөө талаас, энэхүү доод хязгаараас доош байвал, энэхүү квартил интервалын дундаж (Median) хүртэл тохируулга хийх нь их тохиолддог.


16

5. Зөрүүний тохируулга хийх жишээ

(7) Квартил арга


【Ашиглах жишээ (IRS хэлбэр)】

А. Өгөгдлийн тоо 11(сондгой) бол



$11 \div 4 = 2.75$ хэмээн хуваагдахгүй тул бутархай хэсгийг хаяж 2 гэх ба өгөгдлийн дээд, доод хэсгээс 2 компанийг хасна.

В. Өгөгдлийн тоо 12(тэгш) бол



$12 \div 4 = 3$ хэмээн хуваагдах тул өгөгдлийг дээд, доод гэсэн 2 хэсэгт хуваан, тус бүрийн медианыг дээд ба доод хязгаар болгоно.

17

II Жишээн дээр ажиллах



18

Жишээн дээр хэрхэн ажиллах талаар


Багаар үнэ шилжилтийн жишээн дээр ажиллах ба нийт 7 жишээ байгаа.

Суралцагсад жишээ тус бүрийн ажил гүйлгээний зураглал дээр ажиллан, «Урьдчилсан нөхцөл»-ийг уншиж, «Асуулт»-д хариултыг бэлдэнэ.

Багийн дотроо хариултыг ярилцаж, багийн хариултыг бэлтгэх ба бүх жишээн дээр баг тус бүр танилцуулга хийнэ.

19

Case 1 Ажил гүйлгээний зураглал



20

Case 1 Худалдааны нөхцөлийн зөрүү

【Урьдчилсан нөхцөл】


1. X улсын P компани нь A бүтээгдэхүүн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө A бүтээгдэхүүнийг худалдаалах S охин компанийг Монгол улсад байгуулсан.
2. P компани нь S компанид A бүтээгдэхүүнийг \$100,000(худалдааны нөхцөл:FOB) нэгж үнээр худалдаж, S компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн 100 гаруй ААН-д борлуулдаг.
3. P компани нь S компанийг байгуулахаас өмнө, Монгол улс дахь салбар болох Т компанид A бүтээгдэхүүнийг \$100,000(худалдааны нөхцөл:CIF) нэгж үнээр худалдаж, Т компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн борлуулагчдад худалддаг.
4. P компани-S компани хоорондын ажил гүйлгээ ба P компани-Т компани хоорондын ажил гүйлгээний тухайд, худалдааны нөхцөлөөс бусад нөхцөлүүд адил бөгөөд ажил гүйлгээний тоо хэмжээнд ч их зөрүү байхгүй.
5. P компани нь Т компанид A бүтээгдэхүүнийг борлуулах үеийн усан тээврийн нэгж үнэ 4%, усан тээврийн даатгалын хувь 0.5% болно.

【Асуулт】

1. S компанид хийсэн үнэ шилжилтийн хяналт шалгалтаар P компани-Т компани хоорондын A бүтээгдэхүүний ажил гүйлгээг харьцуулагдах ажил гүйлгээгээр сонгон, CUP аргыг ашиглах тохиолдолд, ямар зөрүүний тохируулга хийх вэ.
2. A бүтээгдэхүүний ALP хэд вэ.

21

Case 2 Ажил гүйлгээний зураглал



22

Case 2 Төлбөрийн нөхцөлийн зөрүү

【Урьдчилсан нөхцөл】


1. X улсын P компани нь A бүтээгдэхүүн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө A бүтээгдэхүүнийг худалдаалах S охин компанийг Монгол улсад байгуулсан.
2. P компани нь S компанид A бүтээгдэхүүнийг \$100,000(төлбөрийн нөхцөл: 30 хоног) нэгж үнээр худалдаж, S компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн 100 гаруй ААН-д борлуулдаг.
3. P компани нь S компанийг байгуулахаас өмнө, Монгол улс дахь салбар болох Т компанид A бүтээгдэхүүнийг \$100,000(төлбөрийн нөхцөл: 120 хоног) нэгж үнээр худалдаж, Т компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн борлуулагчдад худалддаг.
4. P компани-S компани хоорондын ажил гүйлгээ ба P компани-Т компани хоорондын ажил гүйлгээний тухайд, төлбөрийн нөхцөлөөс бусад нөхцөлүүд адил бөгөөд ажил гүйлгээний тоо хэмжээнд ч их зөрүү байхгүй.
5. P компанийн хувьд санхүүгийн байгууллагаас хэрэглэх ашиглалтын хүү (Usance Rate) жилийн 5% байна.

【Асуулт】

1. S компанид хийсэн үнэ шилжилтийн хяналт шалгалтаар P компани-Т компани хоорондын A бүтээгдэхүүний ажил гүйлгээг харьцуулагдах ажил гүйлгээгээр сонгон, CUP аргыг ашиглах тохиолдолд, ямар зөрүүний тохируулга хийх вэ.
2. A бүтээгдэхүүний ALP хэд вэ.

23

Case 3 Ажил гүйлгээний зураглал



24

Case 3 Ажил гүйлгээний тоо хэмжээний зөрүү

【Урьдчилсан нөхцөл】


1. X улсын P компани нь A бүтээгдэхүүн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө A бүтээгдэхүүнийг худалдаалах S охин компанийг Монгол улсад байгуулсан.
2. P компани нь S компанид A бүтээгдэхүүнийг \$10,000 нэгж үнээр худалдаж, S компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн 100 гаруй ААН-д борлуулдаг.
3. P компани нь S компанийг байгуулахаас өмнө, Монгол улс дахь салбар болох Т компанид A бүтээгдэхүүнийг \$10,000 нэгж үнээр худалдаж, Т компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн борлуулагчдад худалддаг.
4. P компани-Т компани хоорондын ажил гүйлгээний тухайд, жилийн ажил гүйлгээний тоо хэмжээ 1,000 ширхэгийг давсан тохиолдолд, энэхүү давсан тоо ширхэгийн хувьд 10%-ийн буцаан олголт хийх нөхцөл тусгагдсан. Бусад нөхцөлүүд P компани-S компани хоорондын ажил гүйлгээний нөхцөлтэй адил.
5. 2018 оны байдлаар S компани 1,250 ширхэг, Т компани 1,500 ширхэг А бүтээгдэхүүнийг P компаниас худалдан авсан.

【Асуулт】

1. S компанид хийсэн үнэ шилжилтийн хяналт шалгалтаар P компани-Т компани хоорондын А бүтээгдэхүүний ажил гүйлгээг харьцуулагдах ажил гүйлгээгээр сонгон, CUP аргыг ашиглах тохиолдолд, ямар зөрүүний тохируулга хийх вэ.
2. 2018 оны байдлаарх А бүтээгдэхүүний ALP хэд вэ.

25

Case 4 Ажил гүйлгээний зураглал



26

Case 4 Чиг үүргийн зөрүү

【Урьдчилсан нөхцөл】

1. X улсын P компани нь A бүтээгдэхүүн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө A бүтээгдэхүүнийг худалдаалах S охин компанийг Монгол улсад байгуулсан.
2. P компани нь S компанид A бүтээгдэхүүнийг худалдаж, S компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн 100 гаруй ААН-д борлуулдаг.
3. S компани нь Монгол улсын дотор A бүтээгдэхүүний сурталчилгаа хийдэггүй ба борлуулалтын дараах үйлчилгээ (засвар үйлчилгээ, сэлбэг солих гэх мэт) хийдэггүй. (Монгол улсад A бүтээгдэхүүний сурталчилгааг P компани хийдэг)
4. Монгол улсын ААН болох T компани нь бие даасан салбар байдлаар, X улсын хөндлөнгийн этгээд болох Y компаниас C бүтээгдэхүүнийг импортлон, Монгол улсын хөндлөнгийн жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
5. T компани нь Монгол улсад C бүтээгдэхүүний сурталчилгааг хийхийн хамт, энэхүү бүтээгдэхүүний борлуулалтын дараах үйлчилгээг төлбөртэйгээр хийдэг.
6. A ба C бүтээгдэхүүнүүд хэлбэр, хэмжээ, бүтэц, функцийн хувьд ялгаатай боловч, аль аль нь үйлдвэрлэлд зориулсан тоног төхөөрөмж юм.
7. 2018 оны байдлаар S компани ба T компанийн ашиг алдагдлын тайлан дараах байдалтай болно.

27

Case 4 Ашиг алдагдлын тайлан (2018 оны байдлаар)

(нэгж: US\$)


	S компани	T компани
Борлуулалт	1,200,000	2,000,000
(үүнээс борлуулалтын дараах үйлчилгээний орлого)	(0)	(80,000)
Борлуулалтын өртөг	700,000	1,000,000
(үүнээс борлуулалтын дараах үйлчилгээний зардал)	(0)	(30,000)
Борлуулалтын нийт ашиг	500,000	1,000,000
Борлуулалтын зардал, ерөнхий захиргааны зардал	452,000	850,000
(Үүнээс сурталчилгааны зардал)	(0)	(20,000)
Үйл ажиллагааны ашиг	48,000	150,000

【Асуулт】

1. S компанид хийх үнэ шилжилтийн хяналт шалгалтаар, T компанийг харьцуулагдах ААН-ээр сонгон, TNMM аргыг ашиглах тохиолдолд, ямар зөрүүгийн тохиргоо хийх вэ.
2. Зөрүүгийн тохиргооны үр дүнд, 2018 оны байдлаарх T компанийн борлуулалтын ашгийн түвшин (ОМ) хэдэн % болох вэ.

28

Case 5 Ажил гүйлгээний зураглал



29

Case 5 Бараа материалаарх хөрөнгийн үнэлгээний аргын ялгаа

【Урьдчилсан нөхцөл】

1. X улсын Р компани нь А бүтээгдэхүүн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө А бүтээгдэхүүнийг худалдаалах S охин компанийг Монгол улсад байгуулсан.
2. Р компани нь S компанид А бүтээгдэхүүнийг худалдаж, S компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн 100 гаруй ААН-д борлуулдаг.
3. Монгол улсын ААН болох Т компани нь бие даасан салбар байдлаар, X улсын хөндлөнгийн этгээд болох Y компаниас С бүтээгдэхүүнийг импортлон, Монгол улсын хөндлөнгийн жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
4. А ба С бүтээгдэхүүнүүд хэлбэр, хэмжээ, бүтэц, функцийн хувьд ялгаатай боловч, аль аль нь үйлдвэрлэлд зориулсан тоног төхөөрөмж юм.
5. Бараа материалаарх хөрөнгийн үнэлгээний аргын тухайд, S компани нь LIFO(сүүлд авснаа, эхэлж зарлагдах арга) аргыг, Т компани нь FIFO(эхэлж авснаа, эхэлж зарлагдах арга) аргыг ашигладаг.
6. 2018 оны байдлаарх Т компанийн борлуулалтын өртөгтэй холбоотой өгөгдлийг дараах хүснэгтээр үзүүлэв.

30

Case 5 Борлуулалтын өртөгтэй холбоотой өгөгдөл

(Т компани : 2018 оны байдлаар)

(нэгж: US\$)


С бүтээгдэхүүн	FIFO	LIFO-г ашигласан тохиолдолд
Тайлант хугацааны эхний бараа материалаарх хөрөнгийн үлдэгдэл	20,500	21,000
Тайлант хугацааны эцсийн бараа материалаарх хөрөнгийн үлдэгдэл	11,000	19,500
Борлуулалтын өртөг	340,000	?

【Асуулт】

1. S компанид хийх үнэ шилжилтийн хяналт шалгалтаар, Т компанийг харьцуулагдах ААН-ээр сонгон, TNMM аргыг ашиглах тохиолдолд, бараа материалаарх хөрөнгийн үнэлгээний ямар аргын зөрүүгийн тохиргоо хийх вэ.
2. 2018 оны байдлаарх тохируулгын дараах Т компанийн борлуулалтын өртгийг 2 аргаар тооцож, үйл ажиллагааны ашгийг нэмэгдүүлэх, эсхүл бууруулах тохируулгын үнийн дүнг тооцно уу.

31

Case 6 Ажил гүйлгээний зураглал



32

Case 6 Ажлын капиталын зөрүү

【Урьдчилсан нөхцөл】

1. Х улсын Р компани нь А бүтээгдэхүүн борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө А бүтээгдэхүүнийг худалдаалах S охин компанийг Монгол улсад байгуулсан.
2. Р компани нь S компанид А бүтээгдэхүүнийг худалдаж, S компани нь Монгол улсын доторх хөндлөнгийн жижиглэнгийн 100 гаруй ААН-д борлуулдаг.
3. Монгол улсын ААН болох Т компани нь бие даасан салбар байдлаар, Х улсын хөндлөнгийн этгээд болох Y компаниас С бүтээгдэхүүнийг импортлон, Монгол улсын хөндлөнгийн жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
4. А ба С бүтээгдэхүүнүүд хэлбэр, хэмжээ, бүтэц, функцийн хувьд ялгаатай боловч, аль аль нь үйлдвэрлэлд зориулсан тоног төхөөрөмж юм.
5. S компани ба Т компанийн ажлын капиталын (борлуулалтын авлага, худалдан авалтын өглөг, бараа материалаарх хөрөнгө) түвшин эрс ялгаатай ба эдгээр зөрүүгийн тохиргоо хийх нь харьцуулагдах байдлыг сайжруулахад үр нөлөөтэй.
6. 2018 оны байдлаар, S компани ба Т компанийн борлуулалт, ажлын капитал, санхүүгийн өгөгдлийг дараах хүснэгтээр үзүүлэв.
7. 2018 оны байдлаарх S компанийн банкнаас зээлжих хүүгийн түвшин 5% байна.

33

Case 6 Санхүүгийн өгөгдөл (2018 он)

(нэгж : US\$)


	S компани	T компани
Борлуулалт	1,800,000	2,000,000
Үйл ажиллагааны ашиг	72,000	100,000
Борлуулалтын ашгийн түвшин (ОМ)	4%	5%
Борлуулалтын авлага (эхний үлдэгдэл)	420,000	150,000
" (тайлант хугацааны эцсийн үлдэгдэл)	480,000	170,000
Худалдан авалтын өглөг (эхний үлдэгдэл)	390,000	125,000
" (тайлант хугацааны эцсийн үлдэгдэл)	330,000	115,000
Бараа материалаарх хөрөнгө (эхний үлдэгдэл)	550,000	180,000
" (тайлант хугацааны эцсийн үлдэгдэл)	530,000	220,000

【Асуулт】

1. S компанид хийх үнэ шилжилтийн хяналт шалгалтаар С бүтээгдэхүүний ажил гүйлгээг харьцуулагдах ажил гүйлгээгээр сонгон, TNMM аргыг ашиглах тохиолдолд, ажлын капиталын зөрүүний ямар тохиргоо хийх вэ.
2. Зөрүүний тохиргооны үр дүнд, 2018 оны байдлаарх Т компанийн борлуулалтын ашгийн түвшин (ОМ) хэдэн хувь болох вэ.

34

Case 7 Ажил гүйлгээний зураглал



35

Case 7 Квартил арга


【Урьдчилсан нөхцөл】

1. X улсын хуулийн этгээд болох Р компани нь А бүтээгдэхүүнийг борлуулдаг компани бөгөөд 10 жилийн өмнө, А бүтээгдэхүүнийг худалдах охин компани S-ийг Монгол улсад байгуулсан.
2. Р компани нь S компанид А бүтээгдэхүүнийг нийлүүлж, S компани нь үүнийг Монгол Улсад байх 100-аад хөндлөнгийн жижиглэнгийн худалдаачдад борлуулдаг.
3. Монгол улсад S компанитай адил чиг үүрэг бүхий бие даасан 9 компани байдаг.
4. Энэхүү 9 компанийн борлуулдаг бүтээгдэхүүнүүд төрөл бүр бөгөөд А бүтээгдэхүүнээс хэлбэр хэмжээ, бүтэц, функцээр ялгаатай боловч, бүгд үйлдвэрлэлд зориулсан тоног төхөөрөмж юм.
5. Монгол Улсын ТЕГ-ын хяналт шалгалтын байцаагч Q нь S компанид үнэ шилжилтийн хяналт шалгалт хийхдээ, эдгээр 9 компанийг харьцуулагдах ААН-ээр, S компанийг шалгагдах ААН-ээр сонгон TNMM аргыг ашиглахаар төлөвлөсөн.
6. Q нь эдгээр 9 компанийг сайтар судлахад, борлуулалтын ашгийн түвшинд (ОМ) нөлөөлөхүйц зөрүү хэд хэд байгааг тогтоосон.
7. Иймд, Q нь Case1-ээс Case 6-д гарсан аргуудыг дараалан ашиглаж, тэдгээрийн дотроос ач холбогдол өндөртэй байх зөрүүний тохируулга хийсэн. Гэвч, тоон үзүүлэлтээр илэрхийлэх боломжгүй жижиг зөрүүний тухайд, тохируулга хийх чадаагүй.
8. 2018 оны байдлаарх S компани ба зөрүүний тохируулга хийсний дараах 9 компанийн ОМ-ийг дараах хүснэгтэд үзүүлэв.

36

Case 7 Харьцуулагдах ААН ба S компанийн ОМ (2018 он)

Но.	Харьцуулагдах ААН	ОМ (%)
1	D компани	6.39
2	E компани	5.88
3	F компани	5.36
4	G компани	4.84
5	H компани	4.62
6	I компани	3.79
7	J компани	2.83
8	K компани	2.31
9	L компани	$\Delta 0.45$
-	S компани	2.18



【Асуулт】

1. Квартил интервал ба мэдианыг олно уу.
2. 2018 оны тухайд, S компанид үнэ шилжилтийн татвар ногдуулалтыг хийх ёстой эсэх. Мөн, татвар ногдуулсан тохиолдолд, хэдэн %-ийн ОМ-ийг ашиглах вэ.

37

III Асуулт, хариулт



38

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

Олон улсын татвар ногдуулалтыг хэрэгжүүлэх

бүтэц бүрэлдэхүүний талаарх судалгааны тайлан

**Монгол улсын Олон улсын татварын удирдлага,
хяналт шалгалтын өнөөгийн байдал болон бүтэц бүрэлдэхүүнийг сайжруулах
зөвлөмж**

2018 оны 7 сар
ЛСА төслийн мэргэжилтэн
Кодера Тошинари

Монгол улсын олон улсын татварын удирдлага, хяналт шалгалтын өнөөгийн байдал болон бүтэц бүрэлдэхүүнийг сайжруулах талаарх зөвлөмжийг хүргэж байна.

Хүний нөөцийн хязгаарлагдмал нөхцөл байдалд, боловсон хүчнийг тасралтгүй бэлтгэн, салбараар мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэхгүйгээр, байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, татварын онолыг, хяналт шалгалт хийх практик ур чадварыг бүрдүүлэх боломжгүй юм. Бүтэц зохион байгуулалтын хувьд ч, хяналт шалгалт хийх чадварын хувьд ч “Салбар тус бүрээр мэргэшсэн байцаагчийг бэлтгэх” гэдэг асуудлыг энэхүү зөвлөмжийн гол санаа болгон хүргэж байна.

1. Олон улсын татварын бүтэц бүрэлдэхүүн болон Олон улсын татварын хяналт шалгалт

ТЕГ-ын газар хэлтсүүдийн олон улсын татварын удирдлагын бүтэц бүрэлдэхүүн болон олон улсын татвар ногдуулалтын хяналт шалгалтын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлын талаарх зөвлөмж

(Өнөөгийн байдал)

ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар нь мэдээлэл харилцан солилцох, харилцан тохиролцоо, олон улсын татварын бодлого төлөвлөлт, татварын удирдлагын талаарх нийт асуудлыг хариуцан ажилладаг. Хяналт шалгалттай холбоотой үйл ажиллагааг ТЕГ-ын Хяналт шалгалт, арга зүйн газар хариуцан ажилладаг бөгөөд олон улсын татвар ногдуулалтын хяналт шалгалтын асуудлаар татварын албадыг удирдлага арга зүйгээр хангах чиг үүргийг ч энэхүү газар хариуцдаг. Том ААН-үүдийн хяналт шалгалтыг Улсын төсвийн орлого хяналтын газар хариуцдаг бөгөөд ТЕГ-ын Хуулийн хэрэгжилтийг хангах газарт бас олон улсын татвар хариуцсан байцаагч ажилладаг. Түүнчилэн ТЕГ-ын Сургалтын төвийн хувьд ч хуулийн шинэчилэл, олон улсын татварын сургалтуудаа илүү сайжруулахаар ажиллаж байна.

(Газар хэлтсүүдийн тулгамдсан асуудалд өгөх зөвлөмж)

(1) ТЕГ-ын ТУХАГ (Японы ҮТЕГ-ын Удирдлагын хэлтэс, Олон улсын татварын тасагтай дүйцнэ)

ТЕГ-ын ТУХАГ-т 2016 оны 1 сараас Бодлогын хэрэгжилт, олон улсын татвар

хариуцсан хэсэг шинээр бий болсноор олон улсын татварын хяналт шалгалтын тогтолцоо, энэ талаарх мэдлэг, онолын ойлголт бодит биелэлээ олж эхэлсэн гэж хэлж болно.

ТУХАГ-ын хувьд одоогоор А) Татварын удирдлага В) Хууль эрх зүйн орчныг сайжруулах С) Хамтын ажиллагаа хариуцсан үндсэн 3 хэсэгт хуваагдан ажиллаж байна. А) нь ТУАБ-1, ТУБ-3, В) нь ТУАБ-1, ТУБ-2, С) ТУАБ-1, ТУБ-4 гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Гэхдээ харилцан тохиролцоо хариуцсан мэргэжилтэн байхгүй байгаа нь асуудалтай тал юм. Дээрх С)-г хариуцсан байцаагчийн ажил үүргээс тусад нь салган бие даасан байцаагчаар хариуцуулах нь зүйтэй бөгөөд үнэ шилжилт, харилцан тохиролцоо нь татварын гэрээнд үндэслэн бодит байдал дээр гадаад улс оронтой хэлэлцээр хийдэг тул мэргэжлийн ур чадвар шаардлагатай. Үүнээс гадна ТЕГ-аас татварын хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн санал болон бусад мэдээллийг Сангийн яаманд цаг тухайд нь хүргэж, мэдээлэл харилцан солилцох ажлыг хариуцсан Ерөнхий асуудал хариуцсан нэгжийг шинээр байгуулах талаар судалж үзэх шаардлагатай. ТУХАГ дангаар бус, хуулийн хэрэгжилтийн шатанд татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байгааг бусад газар хэлтсүүд, тухайлбал ХШАЗГ, УТОХГ, ХХХГ, Сургалтын төвийн байр сууринаас харсан саналуудыг харгалзан нэгдсэн санал гаргаж, Сангийн яаманд хүргэх чиг үүрэг бүхий дээр дурьдсан нэгж зайлшгүй хэрэгтэй бөгөөд энэ нэгжээр дамжуулан олон улсын татварын шинэчилэлтэй холбоотой саналуудыг нэгтгэдэг болох нь чухал юм.

Дүгнэж хэлэхэд ТУХАГ-т харилцан тохиролцоо хариуцсан мэргэшсэн байцаагчийг ажиллуулах, Сангийн яамтай харьцах асуудлыг хариуцсан нэгжийг бий болгох талаар судалж үзэх шаардлагатай.

Нөгөөтэйгүүр, мэдээлэл харилцан солилцох бүтэц бүрэлдэж байна. ЛИСА төслийн зүгээс доорх байдлаар дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд энэхүү мэдээлэл харилцан солилцох бүтцийг цаашид ч үргэлжлүүлэх шаардлагатай.

- 1) ЛИСА-гийн хэрэгжүүлж буй олон улсын татварын сургалтын үр дүнд, мөн зөвлөмжийн дагуу ТЕГ нь олон улсын татварын хэрэгцээ шаардлагыг ухамсарлан, ТУХАГ-ыг үйл ажиллагааг төрөлжүүлэн мэргэшүүлэх бүтцийг хэрэгжүүлж байна.
- 2) ЕОI (мэдээлэл харилцан солилцох)-ийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд хариуцсан тасаг бий болгох талаар зөвлөмж өгсөн. Үүний үр дүнд, 2016 оны 1 сард ТУХАГ-т мэдээлэл харилцан солилцох асуудал хариуцсан хэсэг бий болж, 1 байцаагч хариуцан ажиллах болсон.
- 3) Түүнчилэн мэдээлэл харилцан солилцох асуудал хариуцсан ажилтны үйл ажиллагааг үр дүнтэй болгох үүднээс ХШАЗГ, Эрсдлийн удирдлагын хэлтэс, Мэдээлэл статистикийн хэлтсүүд үйл ажиллагааныхаа талаар хоорондоо санал

солилцох боломжоор хангах хэрэгтэй гэсэн зөвлөмж өгсөний дагуу, харилцан хамааралтай чиг үүрэг бүхий газар хэлтсүүд шаардлагатай үедээ уулзаж санал солилцож, мэдээллээ хуваалцах болсон.

- 4) Мэдээлэл харилцан солилцох асуудал хариуцсан ажилтанд, Татварын албадын дарга нарт мэдээлэл харилцан солилцох талаар мэдээлэл хүргэх хэрэгтэй гэсэн зөвлөмж өгсөний үр дүнд ТУХАГ-ын даргаас албан тоотыг Татварын албаны дарга нарт хүргүүлж, Улаанбаатар хотын татварын албадад мэдээлэл харилцан солилцох тогтолцооны талаар танилцуулга хийсэн.
- 5) Өнөөдрийг хүртэл зохион байгуулсан мэдээлэл харилцан солилцохтой холбоотой сургалтын үр дүнд ТЕГ нь 2017 оны 2 сарын байдлаар дотоодын харилцан хамаарал бүхий 27 албан байгууллагатай гэрээ, журам, санамж бичиг байгуулаад байна.
- 6) Дээрх үйл ажиллагааны үр дүнд мэдээлэл харилцан солилцох хүсэлтийн тоо 2014 онд Оросоос 3, Унгар 1, Украин 1, 2015 оны байдлаар Орос 3, Хятад 1, Малайз 1 гэсэн байдлаар нэмэгдсээр байгаа ба мэдээлэл харилцан солилцоо хариуцсан нэгж байгуулагдсаны дараа Оростой 4 удаа мэдээлэл харилцан солилцсон байна. Энэ асуудлаар үргэлжлүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2015 оноос хойшхи мэдээлэл харилцан солилцсон тооны хувьд, 2015 онд 10 удаа, 2016 онд 3 удаа, 2017 онд 8 удаа мэдээлэл харилцан солилцсон бөгөөд 2018 оны байдлаар 2 удаа мэдээлэл харилцан солилцсон байна.

(2) ТЕГ-ын Хяналт шалгалт арга зүйн газар (Япон улсын УТЕГ-ын ААНОАТ-ын хэлтэс, Орлогын албан татварын хэлтэс, хэрэглээний татварын хэлтэс-тэй дүйцнэ.)

ТЕГ-ын ХШАЗГ-т салбараар ангилсан хэсэг байдаггүй. Бүтэц бүрэлдэхүүний хувьд ТУАБ 1, ТУБ 8 байна. ХШАЗГ-ын 8 байцаагч нь ААНОАТ зэрэг татварын төрлөөр хуваагдан хяналт шалгалт хийдэг. Татварын төрлөөр хуваагдан хяналт шалгалт хийж буй байцаагч нь Олон улсын татварын асуудлаа давхар хариуцан ажилладаг болохоор олон улсын татвараар мэргэшсэн байцаагч байдаггүй.

Гэхдээ ХШАЗГ-т Олон улсын татварын хяналт шалгалтын мэргэжлийн хэсэг байх шаардлагатай. Олон улсын татвар хариуцсан ажилтанг хяналт шалгалтын гол цөм болох энэхүү газарт ажиллуулаагүйгээс дараах асуудал гарах магадлалтай. 1-т, Татварын албадыг олон улсын татварын хяналт шалгалтын талаарх удирдлага арга зүйгээр зохистой хангаж ажиллах боломжгүй болох (Татварын албадын дарга нарт заавар зааварчилгаа өгөх боломжгүй), 2-т, УТОХГ-ын олон улсын татвартай холбоотой томоохон хяналт шалгалтын ажил дээр хамтран үр дүнтэйгээр ажиллах боломжгүй болно. Татварын албадыг хяналт шалгалтын улирдлага арга зүйгээр ханган ажилладаг ХШАЗГ нь том ААН-ын татварын хяналт шалгалт хариуцан ажилладаг УТОХГ-тай

олон улсын татварын хяналт шалгалтын асуудлаар харилцан санал солилцохгүйгээр татвар ногдуулалтын бодит байдлыг зохистой бүрдүүлэх боломжгүй юм.

Мөн татварын албадын хяналт шалгалтын тасгийн хувьд ч салбараар хуваагддаггүй бөгөөд энэ нь дор дурдах УТОХГ-тай адилхан асуудал юм. Хяналт шалгалтын байцаагч нь нэг жилийн ажил үүргийнхээ хугацаанд аль болох ижил эсхүл ижил төрлийн салбарт хяналт шалгалт хийх нь тухайн салбарын онцлог, мэдлэгийг үр дүнтэйгээр эзэмшиж, тухайн салбарын хяналт шалгалтад илүү мэргэшинэ. Иймд, ХШАЗГ-т Олон улсын татварын хяналт шалгалтын мэргэшсэн тасгийг бий болгох шаардлагатай гэж бодож байна.

Татварын албадын тухайд, хүний нөөцийн хязгаарлагдмал бүтэцтэй хэдий ч томоохон татварын албадад аль болох салбарчилсан татварын хяналт шалгалтын тасгийг бий болгох, жижиг татварын албадад ядаж, үйл ажиллагааны чиглэлээр ялган татварын байцаагчийг томилж, үйл ажиллагааны чиглэл нь ижилхэн ААН-үүдийн хяналт шалгалтыг нэгтгэн хариуцуулах нь үр дүнтэй байх талтай.

Япон улсад ААНОАТ-ын хэлтэс, ОАТ-ын хэлтэс, Хэрэглээний татварын хэлтэс зэргээр хуваагдсан бүтцийн хувьд ч хэлтэс тус бүр олон улсын татварын онол, хяналт шалгалтын асуудлыг судалдаг. Япон улсын энэ бүтцийг бий болгоосой гэж хүсч байна. Олон улсын татвар ногдуулалтын асуудал цаашид илүү нарийн түвэгтэй болох хандлагатай байгаа тул ААНОАТ-ын олон улсын татвар ногдуулалт, ОАТ-ын олон улсын татвар ногдуулалт, хэрэглээний татварын олон улсын татвар ногдуулалт гэдэг шиг татварын төрлөөр нь олон улсын татварыг онолын талаас нь авч үзэх шаардлага үүснэ.

(3) УТОХГ (Япон улсын УТЕГ-ын Хяналт шалгалтын хэлтэс, БНТГ-ын хяналт шалгалтын хэлтэстэй дүйцнэ.)

УТОХГ нь Захиргааны хэлтэс (хэлтсийн дарга болон байцаагч 5), Хяналт шалгалтын хэлтэс (хэлтсийн дарга болон байцаагч 32), Татварын орлогын хэлтэс (хэлтсийн дарга болон байцаагч 14), Татвар төлөгчтэй харилцах хэлтэс (хэлтсийн дарга болон байцаагч 9), Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтэс (хэлтсийн дарга болон байцаагч 7) , Эрсдэл, статистикийн хэлтэс (хэлтсийн дарга болон байцаагч 5) тэй.

Шинээр байгуулагдсан Эрдэс, баялаг олон улсын татварын хэлтэс нь Монгол улсын онцлог бүхий ашигт малтмалтай холбоотой ажил ① олон улсын байгууллагатай ажиллах, ② хуулийн төсөл боловсруулах, ③ татварын гэрээ, ④ мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой ажлуудыг хариуцдаг.

Чиг үүргийг дэлгэрэнгүй тайлбарлавал, дараах ажлуудыг хариуцдаг.

① Эрдэс баялаг, уул уурхайн салбарын албан татварын бодлого, албан татварын болон ашигт малтмалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Америкийн нэгдсэн улсын төрийн сан

зэрэг гадаад орны болон олон улсын банк, санхүүгийн байгууллагын ажлын хэсэг, төслийн багтай хамтран ажиллах, дээрх асуудлаар холбогдох саналыг боловсруулан Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газарт хүргүүлэх

- ② Эрдэс баялгийн олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, төсөвт төлөх албан татвар, эрх зүйн орчны талаар хийсэн судалгааны үндсэн дээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах болон түүнийг боловсронгуй болгох санал боловсруулан Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар хүргүүлэх;
- ③ Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай тэмцэх Засгийн газар хоорондын хэлэлцээр болон бусад олон улсын татварын асуудал, Хөрөнгө оруулалтын гэрээ, Тогтвортой байдлын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээ хэлэлцээрийг судлах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газраас чиглэл авч ажиллах
- ④ Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн хайгуулын ажлын судалгааг боловсруулах, нэгтгэх, ашиглах, мэдээллийн санг үүсгэх, баяжуулах

УТОХГ-ын Хяналт шалгалтын хэлтэс нь

- A. НӨАТ-ын баталгаажуулалтын хэсэг
- B. Уул уурхай
- C. Барилга, банк
- D. Жижиглэнгийн болон бөөний худалдаа гэсэн 4 хэсэгт хуваагдан хяналт шалгалт

хийдэг ба хяналт шалгалтын хэлтэст 1 ТУАБ болон 32 ТУБ ажилладаг.

Үүнээс гадна дотроо,

- Үнэт цаасны компанийн хяналт шалгалт - Банк хариуцсан хэсэг
- Үйлдвэрлэл, мэдээлэл харилцаа холбоо, тээвэр, худалдаа, үл хөдлөх хөрөнгө, зочид буудал, ресторан, эмчилгээ, халамжийн ААН-ын хяналт шалгалт-Жижиглэнгийн ба бөөний худалдаа хариуцсан хэсэг
- Олон улсын татвар – Тус бүрийн хэсэг нь хариуцдаг.

Энд онцлон хэлэхэд барилга болон банкныг нэг хэсэгт хариуцаж хяналт шалгалт хийхийн тухайд, энэ хоёр салбар нь өөр хоорондоо хэтэрхий ялгаатай учир хяналт шалгалтын байцаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшихэд хүндрэлтэй байхаар байна. Япон улсад, нэг хэлтэс газарт үйл ажиллагааны чиглэл нь ялгаатай ААН-үүдийг хариуцуулах тохиолдол байдаг ч аль болох адил төстэй байх үйл ажиллагааг сонгодог. Мөн жижиглэнгийн болон бөөний худалдааны хэсэгт маш олон төрлийн үйл ажиллагааны чиглэл орсон байгаа нь асуудал бөгөөд төрөл бүрийн

чиглэлийн хяналт шалгалтыг хийх нь тухайн байцаагчийн хувьд ч салбараар мэргэшсэн хяналт шалгалтын ур чадвар бүрдэхэд хүндрэлтэй.

Япон улсад, барилгын салбарт үйл ажиллагаа (болон ижил төрлийн жишээ нь барилгын суурь тавих) явуулдаг томоохон компаниудын хяналт шалгалтыг байцаагч нэг жилийн хугацаанд хариуцан ажилладаг. Ингэснээр, тухайн байцаагч нь барилгын салбарын талаар илүү мэдлэг, чадвартай болохын зэрэгцээ тухайн салбарын онцлогт тохирсон хяналт шалгалт хийхэд мэргэшиж, үр дүнтэй хяналт шалгалтын тогтолцоо бүрэлдэнэ. Ялангуяа томоохон ААН-үүдэд хяналт шалгалт хийх үед тухайн салбар, үйл ажиллагааны чиглэлийн талаарх хангалттай мэдлэггүй бол хяналт шалгалтыг зохих түвшинд хийж чадахгүй тул хяналт шалгалтад хамрагдаж буй ААН талд давуу тал үүсэх болно. Япон улсад 2 жилийн хугацаатайгаар боловсон хүчний сэлгээг хийдэг бөгөөд тухайн салбарыг өөр шинэ байцаагч хариуцан ажиллах болдог. Нэг байцаагч 10 жил нэг салбар, үйл ажиллагааны чиглэлийг хариуцан хяналт шалгалт хийх боломжгүй тул тухайн салбар дахь авилга хээл, хахууль гэсэн асуудлууд гардаггүй.

Иймээс Монгол улсын ТЕГ нь бүтэц бүрэлдэхүүний хувьд салбар салбараарх тасгуудыг цаашид бий болгох талаар судлаж үзэх хэрэгтэй.

Түүнчлэн салбар, үйл ажиллагааны чиглэл бүрт дотоодын татварын хяналт шалгалт, олон улсын татварын хяналт шалгалт гэсэн 2 талаас хяналт шалгалтын судалгааг хэрэгжүүлж, судалгааны тэмдэглэл, материалуудыг хадгалах нь тухайн албан тушаалд очсон байцаагчийн хяналт шалгалт хийх чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой учир бүх тасаг, хэлтсүүд нь салбараар ялгасан хяналт шалгалт хийсэн мэдээлэл, тэмдэглэлээ хадгалж байх хэрэгтэй. Мөн тухайн салбарын онцлог болон хяналт шалгалт хийх гол чухал асуудлуудыг нэгтгэх хэрэгтэй.

Банк хариуцсан хяналт шалгалтын хэсэг нь энэ талын хяналт шалгалтын мэдлэг, чадвараа дээшлүүлэх шаардлагатай. Одоогийн тогтолцоогоор банкинд хяналт шалгалт хийх нь хүндрэлтэй боловч хяналт шалгалт хийх чадварыг нэмэгдүүлэх шаардлага ирээдүйд зайлшгүй тулгарна. Татвар төлөгчийн банкны дансыг хяналт шалгалтын байцаагч газар дээр нь буюу банкин дээр очиж л шалгаж, тодруулахгүй бол ямарч үр дүн гарахгүй.

Салбараар ялгаатай хяналт шалгалт хийх болон банкны хяналт шалгалтын ур чадвар сайжирвал Япон улсын ҮТЕГ-ын Мөрдөн шалгах хэлтэс шиг албадан хяналт шалгалт хийх багийг ирээдүйд бий болгох боломжтой болно. Ялангуяа мөрдөн шалгах хэсэг нь банкинд шалгалт хийж чадахгүй бол хяналт шалгалт хийсэн болохгүй.

Гэхдээ олон улсын татвар нь тус тусын хэсгээ хариуцан өөрөөр хэлбэл салбар тус бүрээр нь олон улсын татвараа хариуцаж ажиллах нь зохистой. ТЕГ-ын хүний нөөц талаас бодвол 100 байцаагчийг олон улс болон дотоодын гэж хуваахаас илүү олон байцаагчид хамтран мэдлэг чадвараа ашигласан хяналт шалгалтыг хийлгэх үүднээс нэг салбарыг хэд хэдэн байцаагч хариуцаж дотоодын болон олон улсын хяналт шалгалтыг

нэгэн зэрэг хийж дотоодын хяналт шалгалт дуусвал, олон улсын хяналт шалгалтаа үргэлжлүүлэн хийдэг байдлаар явах нь илүү тохиромжтой. УТОХГ-ын хяналт шалгалтын байцаагчийн тоо олон биш тул олон улсын татварын мэдлэгийг Сургалтын төвөөр дамжуулан олгох нь тийм ч хэцүү асуудал биш. Өөрөөр хэлбэл олон улс болон дотоодын хяналт шалгалтыг хийж чадах боловсон хүчинг бэлтгэх нь нэг их хүндрэлтэй асуудал биш юм. Мөн олон улсын тал дээр ч салбараар мэргэшсэн хяналт шалгалтын байцаагчийг бэлтгэгдэх давуу талтай.

(4) ТЕГ-ын Хуулийн хэрэгжилтийг хангах газар (Япон улсад ҮТЕГ, БНТГ, Татварын алба тус бүрт Хууль эрх зүйн хяналт шалгалтын хэсэг байдаг)

ХХХГ-т олон улсын татвар хариуцсан ТУАБ 1, ТУБ 1 байдаг. Мөн татварын хуулийн хэрэгжилт талаасаа авч үзвэл, Маргаан таслах зөвлөлд олон улсын татварын мэргэжилтэнг байлгаж, Япон улсын хуулийн тасаг шиг Татварын асуудлаар шүүхэд гарсан нэхэмжлэлийг шийдвэрлэхийн тулд улсын прокурортой хамтран ажилладаг хэсгийг цаашдаа байгуулах нь зүйтэй.

(5) ТЕГ-ын сургалтын төв (Япон улсын ҮТЕГ, Татварын дээд сургуультай дүйцнэ)

Сургалтын төв нь чанартай, үр дүнтэй сургалт явуулах зорилт тавин хичээнгүйлэн ажиллаж байна. Цаашид ашигт малтмалын салбараар ялгаатай сургалтыг зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзэж байна. Түүнчилэн, ирээдүйд хуулийн төсөл боловсруулах, сайжруулах ажил хариуцсан ажилтанд зориулсан хууль эрх зүйн онолын сургалтыг бас зохион байгуулаасай гэж хүсч байна. Хууль тогтоомжийн хувьд нарийн мэдлэгтэй, удирдан зохион байгуулах чадвартай сургалтын төвийн даргын цаашдын бодлогод найдлага тавьж байна.

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

Олон улсын татвар ногдуулалтын тогтолцоог

бүрдүүлэх талаарх санал зөвлөмж

MOF & GDT WG

Хуулийн зүйл заалтын талаар

10 сарын 13-ны ажлын хэсгийнхэнтэй уулзсан 3 дах уулзалтын
дараах нэмэлт тайлбар

Кодера Тошинари

СЭДЭВ

1. Харилцан хамаарал бүхий этгээдийн тодорхойлолт
(Зурагт тайлбар Slide No.14-22)
2. CFC татварын тогтолцооны сайжруулалт
(Пассив орлогын татвар ногдуулалтын шалтгаан
Slide No.44-46)
(★ Үнэ шилжилтийн татварын тогтолцоо, хүснэгт 17(4) Хавсралт
Slide No.49)
3. Бодит байдлын жишиг үзүүлэлтийн тодорхойлолт
4. Биет бус хөрөнгө ба дотоод эх үүсвэртэй орлого
(★ Гадаадын ААН-д татвар ногдуулах харилцаа: Зурагт тайлбар, Хавсралт
Slide No.71)

Харилцан хамаарал бүхий этгээдийн тодорхойлолт

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд (ТАХТХ 66-5-2)

- Энэ зүйл дэх “харилцан хамаарал бүхий этгээдэд төлсөн хүүгийн хэмжээ” гэдэг нь харилцан хамаарал бүхий этгээдэд төлсөн хүүгийн (компанийн төлсөн зээлийн хүү (адилтгах төрлийн хүү гэж ЗГ-ын тогтоолоор тодорхойлсон хүүг оролцуулан), зардал эсхүл алдагдал) дотроос тодорхой бонд худалдан авах ажил гүйлгээ (өмнөх Зүйлийн (5)(viii) хэсэгт заасан бонд буцаан худалдан авах ажил гүйлгээ) зэрэгт холбогдох хэмжээ хэмээн ЗГ-ын тогтоолд зааснаас бусад хэмжээг хэлэх бөгөөд тухайн харилцан хамаарал бүхий этгээдийн татвар ногдох орлогод тооцогдохгүй.

(Special Taxation Measures Law 66-5-2)

- (2) The term “amount of interest, etc. paid to related persons” in this article means the amount that is other than an amount prescribed by Cabinet Order as an amount pertaining to a specified bond repurchasing trading, etc. (meaning the specified bond repurchasing trading, etc. referred to in paragraph (5)(viii) of the preceding Article), which is part of the amount of interests, etc. (meaning interests on indebtedness paid by the corporation (including those prescribed by Cabinet Order as interests of similar nature) and expenses or losses prescribed by Cabinet Order; hereinafter the same applies in this Article) that are paid to related persons, etc. of the corporation concerned (related persons, etc. mean persons listed below; hereinafter the same applies in this paragraph, paragraph (4)(ii) and paragraph (9)(i)(b)) (excluding the amount of interests, etc. paid to consolidated corporation) and is not included in income subject to tax (meaning that prescribed by Cabinet Order as income to become a tax base for income tax or corporation tax on the said related person, etc. falls under, an individual or corporation; the same applies in paragraph (4)(ii) of the said related person, etc.;

(Special Taxation Measures Law 66-5-2)

- (2)-1

A corporation having a special relation prescribed by Cabinet Order such as the relation with the said corporation that either corporation directly or indirectly holds 50 percent or more of the total number or total amount of issued stocks or investments (excluding stocks or investment of an issuing corporation held by the issuing corporation, hereinafter referred to in this item as “issued stocks, etc.”) of the other corporation, or an individual having a special relation prescribed by Cabinet Order such as the relation that the individual directly or indirectly holds 50 percent or more of the total amount of the issued stocks, etc. of the said corporation, and

- (2)-2

A person providing funds for the said corporation and persons prescribed by Cabinet Order as a person having a certain relation with the provision of the said fund.

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд ба тухайлсан гуравдагч этгээдийн талаарх тодорхойлолт (ТАХТХ 66-5-2)

• (2)-1

ЗГ-ын тогтоолоор онцгой харилцаатай этгээд гэж тодорхойлогдсон компани эсхүл хувь хүн, тухайлбал нөгөө компанийнхаа нийт гаргасан хувьцааны болон оруулсан хөрөнгийн (үүнд өөр компанийн эзэмшилд буй хувьцаа эсхүл хөрөнгө оруулалтыг оруулахгүй) 50 болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл шууд бус хэлбэрээр эзэмшдэг компани, эсхүл уг компанийн нийт гаргасан хувьцааны болон оруулсан хөрөнгийн 50 болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл шууд бус хэлбэрээр эзэмшдэг хувь хүн,

(2)-2

Тухайн компанид санхүүгийн дэмжлэг үзүүлж буй этгээд болон ЗГ-ын тогтоолоор уг дэмжлэгийг үзүүлэх тодорхой харилцаатай этгээд гэж тодорхойлогдсон этгээд.

Кодера зөвлөхийн санал (「Харилцан хамааралтай этгээд」-ийн талаар)

- Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамаарал бүхий этгээдийн тодорхойлолт нь үнэ шилжилтийн татварын тогтолцоонхтой адил төстэй байна.
 - Үнэ шилжилтийн татварын тогтолцоо ба өндөр хүүгийн татварын тогтолцооны 「Харилцан хамаарал бүхий этгээд」-ийн нийтлэг тал
 1. Төв ба охин компанийн харилцаатай гадаадын ААН (50% дээш эзэмшилтэй)
 2. Ах дүү хамаарал бүхий гадаадын ААН (Нэг этгээд 50%-аас дээш хувь эзэмшдэг)
 3. Хяналтын харилцаа бүхий гадаадын ААН
 - Удирдлага давхардан үүрэг гүйцэтгэдэг
 - Үйл ажиллагааны ихэнх хэсгийг эзлэх ажил гүйлгээ хамааралтай
 - Үйл ажиллагааны санхүүжилтын ихэнх хэсгийн зээл, баталгаа гаргах
- ※Гэхдээ, үнэ шилжилтийн тогтолцооны харилцан хамаарал бүхий этгээд нь зөвхөн хуулийн этгээд байна. Хувь этгээд харилцан хамаарал бүхий этгээд болохгүй.

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд (ЗГТ 39-13-2) :

- 8-р заалт
- Хуулийн 66-5-2-т заасан нөгөө хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны болон оруулсан хөрөнгийн (үүнд өөр компанийн эзэмшилд буй хувьцаа эсхүл хөрөнгө оруулалтыг оруулахгүй) 50 болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл шууд бус хэлбэрээр эзэмшдэг **хуулийн этгээд**, эсхүл бусад хуульд заасан тусгай харилцааны тухайд, дараах харилцааг ойлгоно.

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд (ЗГТ 39-13-2)

- 8-р заалт
- Нөгөө компанийнхаа нийт гаргасан хувьцааны болон оруулсан хөрөнгийн (үүнд өөр компанийн эзэмшилд буй хувьцаа эсхүл хөрөнгө оруулалтыг оруулахгүй) 50 болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл шууд бус хэлбэрээр эзэмшдэг харилцаа
- **Хоёр компанийн** нийт гаргасан хувьцааны болон оруулсан хөрөнгийн 50 болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл шууд бус хэлбэрээр **нэг адил этгээд эзэмшдэг** (тухайн этгээд нь хувь хүн байгаа тохиолдолд, тухайн хувь этгээд ба энэхүү этгээдтэй ААНОАТ хуулийн хэрэгжүүлэх аргачилалын 4-1-т заасан тусгай харилцаа бүхий хувь этгээд) тохиолдолд, эдгээр хоёр компанийн хоорондын харилцаа (Өмнөх заалтад заасан харилцаанд хамаарах зүйлсийг оруулахгүй) (2)-1

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд (ЗГТ 39-13-2): Хяналтан доор байх харилцаа

- **8-р заалт**
- Дараах бодит нөхцөл байдал болон адил төстэй нөхцөл байдалд хоёр хуулийн этгээдийн нэг нь нөгөөгийнхөө үйл ажиллагааны чиглэлийг бүрэн болон хэсэгчилэн **шийдвэр гаргах харилцаатай байх.** (Өмнөх 2-т заасан харилцаанд хамаарах зүйлсийг оруулахгүй)
- Нэг талын хуулийн этгээдийн удирдлагын талаас илүү, эсвэл төлөөлөх эрх бүхий удирдлага нь нөгөө талын хуулийн этгээдэд давхар ажилладаг, эсвэл ажиллаж байсан байх.
- Тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны дийлэнх нь нөгөө хуулийн этгээдтэй хийх ажил гүйлгээнээс хамааралтай байх.
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтын ихэнхийг нөгөө хуулийн этгээдээс зээлж, эсвэл энэхүү хуулийн этгээдийн батламжлалаар санхүүжилтээ бүрдүүлсэн байх.

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд (ЗГТ 39-13-2):

- **10-р заалт:** Хуулийн 66-5-2-2-т заасан нөгөө компанийнхаа нийт гаргасан хувьцааны болон оруулсан хөрөнгийн (үүнд өөр компанийн эзэмшилд буй хувьцаа эсхүл хөрөнгө оруулалтыг оруулахгүй) 50 болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл шууд бус хэлбэрээр эзэмшдэг **хувь этгээд**, эсхүл бусад хуульд заасан тусгай харилцааны тухайд, дараах харилцааг ойлгоно.
- **Хувь этгээд нь (Тухайн хувь этгээдтэй ААНОАТ-ын хуулийн хэрэгжүүлэх аргачилалын 4-1-т заасан тусгай харилцаатай хувь этгээдийг оруулна.) тухайн хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны болон оруулсан хөрөнгийн 50 болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл шууд бус хэлбэрээр эзэмшдэг байх харилцаа**
- Хуулийн этгээд ба хувь этгээд нь дараах бодит нөхцөл байдал болон адил төстэй нөхцөл байдалд тухайн хувь этгээд нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг бүрэн болон хэсэгчилэн шийдвэр гаргах харилцаатай байх. (Өмнөх заалтад хамаарах харилцааг оруулахгүй)
- Тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны дийлэнх нь тухайн хувь этгээдтэй хийх ажил гүйлгээнээс хамааралтай байх.
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтын ихэнхийг тухайн хувь этгээдээс зээлж, эсвэл энэхүү хувь этгээдийн батламжлалаар санхүүжилтээ бүрдүүлсэн байх.

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд (ЗГТ 39-13-2):

- **11-р заалт.** Өмнөх 1-д заасан Хувь этгээд нь тухайн хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны болон оруулсан хөрөнгийн 50 болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл шууд бус хэлбэрээр эзэмшдэг эсэхийг тодорхойлохдоо, шууд эзэмших хувьцааны ЭЗЭМШЛИЙН ХУВЬ (Хувь этгээдийн эзэмших хуулийн этгээдийн хувьцааны тоо эсвэл үнийн дүнгийн тухайн хуулийн этгээдийн гаргасан нийт хувьцааны тоо ба үнийн дүнд эзлэх хувь хэмжээг хэлнэ.) ба шууд бус эзэмшлийн хувьцааны хувийн нийлбэрээр тооцно.

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд (ЗГТ 39-13-2):

12-р заалт.


- Өмнө заасан шууд бус хувьцааны эзэмшлийн хувь гэдэг нь дараах заалт бүрт хамаарах ангилалд заасан хувь хэмжээг хэлнэ. (хэд хэдэн заалтад хамаарах тохиолдолд, нийлбэр хувь хэмжээгээр тооцно)
- Өмнө заасан тухайн хуулийн этгээдийн ААНБОАТ-ын хуулийн 2-14-т заасан хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн (Цаашид Г Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд, Гэх) гаргасан нийт хувьцаа ба үнийн дүнгийн 50-аас дээш хувийг өмнө заасан **ХУВЬ ЭТГЭЭД** эзэмшиж байгаа тохиолдолд, хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшиж буй тухайн хуулийн этгээдийн нийт хувьцааны тоо ба үнийн дүнд эзлэх хувь хэмжээ (Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд нь хоёроос дээш байгаа бол тус бүрт тооцсон хувь хэмжээний нийлбэрээр тооцно)

Өндөр хүүгийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээд (ЗГТ 39-13-2):

- 12-р заалт
- Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч аж ахуйн нэгжтэй (Өмнөх заалтад хамаарах хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг оруулахгүй.) болон мөн заалтад заасан хувь этгээдтэй гаргасан хувьцааны эзэмшлээр дамжуулан харилцан холбоотой, эсвэл хоёроос дээш хуулийн этгээд (Цаашид «Хөрөнгө оруулалтын харилцан холбоотой хуулийн этгээд» гэх) дунд нь оролцсон тохиолдолд, (хөрөнгө оруулалтын холбоотой хуулийн этгээд ба хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн тус тусын гаргасан хувьцааны тоо ба үнийн дүнгийн 50-аас дээш хувийг тухайн хувь этгээд ба хөрөнгө оруулалтын холбоотой хуулийн этгээд (гаргасан нийт хувьцааны тоо ба үнийн дүнгийн 50-аас дээш хувийг тухайн хувь этгээд эсвэл бусад хөрөнгө оруулалтын холбоотой хуулийн этгээд эзэмшдэг байх тохиолдлоор хязгаарлана) эзэмшдэг байх тохиолдлоор хязгаарлан) тухайн хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн эзэмших хувьцааны тоо ба үнийн дүнгийн, тухайн хуулийн этгээдийн нийт хувьцаа ба үнийн дүнд эзлэх хувь хэмжээ (Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд нь 2-оос их байгаа тохиолдолд, тус тусийн хувьцааны хувь хэмжээний нийлбэр хувь хэмжээгээр тооцно.)


Харилцан хамааралтай ААН: Хувьцаа эзэмшихтэй холбоотой харилцаа

- ТАХТХ-ийн ЗГТ-ын 39-13-2^⑧ -ын 1-ийн жишээ А




Харилцан хамааралтай ААН: Хувьцаа эзэмшихтэй холбоотой харилцаа

ТАХТХ-ийн ЗГТ-ын 39-13-2⑧ -ын 1-ийн жишээ В




Харилцан хамааралтай ААН: Хувьцаа эзэмшихтэй холбоотой харилцаа

• ЗГТ-ын 39-13-2⑧ -ын 1-ийн жишээ С



Харилцан хамааралтай ААН: Хувьцааны эгч дүү харилцаа

- ЗГТ-ын 39-13-2(8) -ын 2-ийн жишээ



※ Хувь хүнд онцгой харилцаатай хувь хүн (хамаатан садан гм) хамаарна.

Харилцан хамааралтай ААН: Бодит хяналт доор байх харилцаа


- ЗГТ-ын 39-13-2(8) -ын 3-ын жишээ



- Дараах бодит байдалд үндэслэн ААН 2-ын үйл ажиллагааны чиглэлийг Бодит хяналт доор байх харилцаа гэж үзнэ
- ① ААН 1 нь ААН 2-руу ажилтан томилдог
- ② ААН 2-ын ажил гүйлгээний дийлэнх хувь нь ААН 1-ээс хамааралтай байх
- ③ ААН 2-ын зээлийн дийлэнх хувийг ААН 1-ээс авсан байх

Харилцан хамааралтай хувь хүн: Хувьцаа эзэмшихтэй холбоотой харилцаа


- ЗГТ-ын 39-13-2 ⑩ -ын 1-ийн жишээ А



※ Хувь хүнд онцгой харилцаатай хувь хүн (хамаатан садан гм) хамаарна.

Харилцан хамааралтай хувь хүн: Хувьцаа эзэмшихтэй холбоотой харилцаа


- ЗГТ-ын 39-13-2 ⑩ -ын 1-ийн жишээ В



※ Хувь хүнд онцгой харилцаатай хувь хүн (хамаатан садан гм) хамаарна.

Харилцан хамааралтай хувь хүн: Хувьцаа эзэмшихтэй холбоотой харилцаа

- ЗГТ-ын 39-13-2 (10) -ын 1-ийн жишээ С



※Хувь хүнд онцгой харилцаатай хувь хүн (хамаатан садан гм) хамаарна.

Харилцан хамааралтай хувь хүн: Бодит хяналт доор байх харилцаа

- ЗГТ-ын 39-13-2 (10) -ын 2-ын жишээ



- Дараах бодит байдалд үндэслэн ААН-ийн үйл ажиллагааны чиглэлийг Бодит хяналт доор байх харилцаа гэж үзнэ
- ①ААН-ийн ажил гүйлгээний дийлэнх хувь нь хувь хүнээс хамааралтай байх
- ②ААН-ийн зээлийн дийлэнх хувийг хувь хүнээс авсан байх

※Хувь хүнд онцгой харилцаатай хувь хүн (хамаатан садан гм) хамаарна.

Өндөр хүүгийн татварын тогтолцооны тухайлсан гуравдагч этгээд (ЗГТ 39-13-2):

- **13-р заалт**

Хуулийн 66-5-2-2-т заасан этгээдэд дараах этгээд хамаарна.

- Хуулийн этгээдтэй харилцан хамаарал бүхий этгээд нь гуравдагч этгээдээр дамжуулан тухайн хуулийн этгээдэд хөрөнгө оруулсан болох нь тогтоогдсон бол тухайн гуравдагч этгээд
- Хуулийн этгээдтэй харилцан хамаарал бүхий этгээд нь гуравдагч этгээдэд тухайн хуулийн этгээдийн өглөгтэй холбоотой баталгаа гаргаснаар, тухайн гуравдагч этгээд нь энэхүү хуулийн этгээдэд хөрөнгө оруулсан болох нь тогтоогдсон гуравдагч этгээд;

Өндөр хүүгийн татварын тогтолцооны тухайлсан гуравдагч этгээд (ЗГТ 39-13-2):

- **13-р заалт**

- Хуулийн этгээдтэй харилцан хамаарал бүхий этгээдээс тухайн хуулийн этгээдэд өгсөн бонд (харилцан хамаарал бүхий этгээдийн гаргасан баталгаанд үндэслэн гуравдагч этгээдээс тухайн хуулийн этгээдэд өгсөн бондыг оруулна.) нь **өөр гуравдагч этгээдэд барьцаа болон өгөгдөж бондын үнэт цаасны арилжаанд (Хуулийн 42-2-1-д заасан) орж, эсвэл бэлэн мөнгөний барьцаат бондын арилжаагаар (Хуулийн 66-5-8-д заасан) зээлдүүлэх замаар тухайн өөр гуравдагч этгээд нь тухайн хуулийн этгээдэд хөрөнгө оруулсан болох нь тогтоогдсон тохиолдолд, энэхүү гуравдагч этгээд ба өөр гуравдагч этгээдүүд;**

Кодера зөвлөхийн санал (「Тухайлсан гуравдагч этгээд」 1)

- ЗГ тогтоолын 39-13-2(13)-1-ийн тохиолдол
- Гуравдагч этгээдээр дамжуулсан харилцан хамаарал бүхий этгээдийн хөрөнгө оруулалт (санхүүжилт)



Кодера зөвлөхийн санал (「Тухайлсан гуравдагч этгээд」 2)

- ЗГ тогтоолын 39-13-2(13)-2-ийн тохиолдол
- Харилцан хамаарал бүхий этгээдийн өрийн баталгаанд үндэслэн гуравдагч этгээдийн хийсэн хөрөнгө оруулалт (санхүүжилт)



Кодера зөвлөхийн санал (「Тухайлсан гуравдагч этгээд」 3-①)

- ЗГ тогтоолын 39-13-2(13)-3-ийн тохиолдол (а)
- Харилцан хамааралтай этгээд эсвэл гуравдагч этгээдээс зээлсэн бондыг өөр гуравдагч этгээдэд шилжүүлж, эсвэл зээлэх замаар хөрөнгө оруулалт (санхүүжилт) хийх



Кодера зөвлөхийн санал (「Тухайлсан гуравдагч этгээд」 3-②)

- ЗГ тогтоолын 39-13-2(13)-3-ийн тохиолдол (в)
- Харилцан хамааралтай этгээд эсвэл гуравдагч этгээдээс зээлсэн бондыг өөр гуравдагч этгээдэд шилжүүлж, эсвэл зээлэх замаар хөрөнгө оруулалт (санхүүжилт) хийх



**Өндөр хүүгийн татварын тогтолцооны
харилцан хамаарал бүхий этгээд
(ЗГТ 39-13-2):**

- 14-р заалт:
- Хуулийн 66-5-2-ийн заалтыг ашиглах тохиолдолд, энэхүү этгээд тус зүйлийн 1-р заалтад хамаарах хуулийн этгээдтэй харилцан хамаарал бүхий этгээд болох эсэхийг тодорхойлохдоо, энэхүү хуулийн этгээдийн тайлант жил бүрийн эцсийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

2. CFC татварын тогтолцоо

2017 оны СФС татварын тогтолцооны ШИНЭЧИЛЭЛТ

- Гадаадын охин компанийн нэгдсэн татварын тогтолцооны (татварын диваажингийн тогтолцоо) талаарх өргөн хүрээтэй шинэчилэлтийг хийсэн.
- Энэхүү татварын тогтолцоо нь дотоодын аж ахуйн нэгж, татварын хувь хэмжээ багатай улс орон руу орлогоо шилжүүлэх замаар дотоодод төлөх ААН-ын орлогын татварын ачааллаа үл зохих байдлаар бууруулахаас сэргийлэх зорилгоор, тодорхой шалгуур нөхцөлд нийцэх гадаадын охин компанийн орлогыг, дотоодын аж ахуйн нэгжийн (гадаадын охин компанийн хувьцаа эзэмшигч) орлогод нэгтгэн дотоодод татвар ногдуулах тогтолцоо юм.

Өнөөг хүртэлх СФС татварын тогтолцоо

- Японы байнгын оршин суугч, дотоодын аж ахуйн нэгж нь шууд ба шууд бус байдлаар 50-аас дээш хувийг эзэмшдэг гадаадын аж ахуйн нэгжийг «Гадаад хамаарал бүхий компани» гэдэг.
- Компанийн татварын ачааллын хувь 20%-аас бага байх энэхүү гадаад хамаарал бүхий компани нь татварын хувь хэмжээ багатай улс оронд байрлаж байгаа тохиолдолд, «Тухайлсан гадаад охин компани» хэмээн тодорхойлж, энэ татварын тогтолцоонд хамааруулж үзнэ.
- Гэхдээ, бие даасан байдлаар үйл ажиллагаа эрхлэх бодитой компанийг энэхүү татварын тогтолцоонд хамруулахгүй байхын тулд дөрвөн «Үл хамааруулах жишиг» үзүүлэлтийг тогтоосон.
- Энэ 4 жишиг үзүүлэлтийн аль нэгд нийцэхгүй байх тухайлсан охин компанийн тухайд, бүх орлогыг Японы төв компанийн орлогод нийлүүлэн татвар ногдуулна.
- Шалгуур үзүүлэлтийг бүгдийг хангаж байгаа тохиолдолд, зөвхөн «Хөрөнгийн шинжтэй орлого»-оор хязгаарлан татвар ногдуулалт хийнэ.

Босго (Trigger) татварын хувь хэмжээг халсан

- Өмнөх татварын тогтолцоонд, татварын ачааллын хувь нь 20%-аас дээш байгаа тохиолдолд 「Тухайлсан охин компани」 болохгүй бөгөөд CFC татварын тогтолцоонд хамруулдаггүй байсан.
- Энэ「20%」 нь 「Босго татварын хувь хэмжээ」 хэмээн нэрлэгдэж, тухайн тогтолцооны босго болж, ихээхэн ач холбогдолтой байсан.
- Гэвч, эдийн засгийн бодитой бус цаасан компанийн тухайд, татварын ачааллын хувь хэмжээ 20%-аас дээш байсан ч тухайн тогтолцоонд хамруулахгүй байх нь асуудалтай гэж үзсэн.
- Иймээс босго хувь хэмжээг халсан.

Аж ахуйн нэгжийн талаарх шинэ ухагдахууныг нэвтрүүлсэн

- 「Цаасан компани」「Cash box」гэсэн аж ахуйн нэгжийн талаарх шинэ ухагдахууныг тодорхойлж, эдгээр аж ахуйн нэгжид хамаарах нэгтгэсэн татвар ногдуулалтын тогтолцоог бүрдүүлсэн.
- Шинэ тогтолцооны хүрээнд, татварын ачаалал нь 20%-аас их байсан ч цаасан компани байгаа тохиолдолд, нийт орлогод нэгтгэсэн татвар ногдуулалт хийнэ.
- Цаасан компани биш гадаадын хамаарал бүхий аж ахуйн нэгжийн тухайд, 「Эдийн засгийн үйл ажиллагааны жишиг」(өмнөх тогтолцооны хүрээний 4 үл хамруулах жишиг)-ийг хангах эсэхийг хянаж үзнэ.
- Энэхүү эдийн засгийн үйл ажиллагааны жишиг үзүүлэлтүүдийн аль нэгийг хангахгүй тохиолдолд, энэ гадаад хамаарал бүхий компанийн нийт орлогыг Япон дахь төв компанийн орлогод нэгтгэн татвар ногдуулах бөгөөд энэ нь хуучин тогтолцоотой адил байна.
- Нөгөө талаас, эдийн засгийн үйл ажиллагааны жишиг үзүүлэлтийг бүгдийг хангаж байгаа тохиолдолд, тодорхой 「орлого」-оор хязгаарлан нэгтгэсэн татвар ногдуулалтад хамруулна.
- Энэхүү орлогын хамрах хүрээ нь өмнөх тогтолцооны хөрөнгийн шинжтэй орлогын хамрах хүрээтэй харьцуулаад ихээхэн өргөжсөн.
- Шинэ тогтолцоо нь гадаад хамаарал бүхий компанийн 2018 оны 4 сарын 1-нээс эхлэх санхүүгийн жилээс хэрэгжиж эхэлнэ.

Q Шинэ татварын тогтолцооны цаасан компани?

- Цаасан компани гэдэг нь?
- Тодруулбал, дараах зүйлсийн алинд ч тохирохгүй гадаадын хамаарал бүхий компанийг хэлнэ.

1. Бодит байдлын жишиг үзүүлэлт

Гол үйл ажиллагааг явуулахад шаардлагатай байх оффис, дэлгүүр, үйлдвэр болон бусад тогтсон байгууламж бүхий гадаад хамааралтай компани

2. Хяналтын доор байх жишиг

Толгой оффисын байрлах улсад үйл ажиллагааны хяналт, удирдлагыг өөрсдөө хийдэг гадаад хамаарал бүхий компани

- Татварын байгууллагын ажилтан нь дотоодын аж ахуйн нэгжээс, гадаад хамаарал бүхий компани нь дээрх жишиг шалгуурыг хангаж байгааг нотлох бичиг баримтыг гарган өгөхийг шаардсан тохиолдолд, тухайн ажилтны заасан хугацаанд шаардсан материалыг гарган өгөөгүй бол гадаад хамаарал бүхий компани нь дээрх нөхцөлийг хангаагүй гэж үзнэ.

Гадаад хамаарал бүхий компанийг тодорхойлох: Хяналтын доор байх жишгийг нэвтрүүлэх ба эзэмших хувьцааны хувийг тооцох аргыг сайжруулах

Q Хөрөнгийн холбоогүй боловч, гэрээний харилцаагаар охин компанийг хяналтынхаа доор байлгадаг тохиолдол, шууд бус хяналтын доор байлгахтай хэрхэн ажиллах?

A Байнгын оршин суугч болон дотоодын хуулийн этгээд нь нийт үнийн дүнгээр 50%-аас илүү хувийг шууд ба шууд бусаар эзэмшиж байвал гадаад хамаарал бүхий компани гэж үзнэ.

Мөн, дотоодын хуулийн этгээд нь гадаадын хуулийн этгээдийн үлдэгдэл хөрөнгийг бүгдийг нэхэмжлэх эрх бүхий харилцаатай бол гадаад хамаарал бүхий хуулийн этгээд гэж үзнэ.

Харилцан хамааралгүйн жишгийг шинэчилсэн

Q Гуравдагч этгээдийг дунд нь оруулж Г харилцан хамааралгүйн жишгийг J хэлбэрийн хувьд хангах тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

A Харилцан хамааралгүй этгээд хоорондын ажил гүйлгээний тухайд, тухайн ажил гүйлгээнд хамаарах зүйл нь харилцан хамааралтай этгээдэд шилжих нь тодорхой байгаа тохиолдолд, харилцан хамааралтай этгээд хооронд шууд хийгдсэн ажил гүйлгээ гэж үзнэ.

Японы CFC татварын тогтолцооны 3 сайжруулалт

- Энэхүү сайжруулалт нь эдийн засгийн бодит байдалд тулгуурласан татвар ногдуулалт хийх хэрэгтэй хэмээн үзэж буй BEPS төслийн эцсийн тайлангийн үзэл баримтлалд нийцүүлсэн.
- Өнөөгийн хүчин төгөлдөр тогтолцооноос чухал ач холбогдол бүхий сайжруулалт хэмээн дараах 3 сайжруулалтыг хийсэн.
- Шинэ тогтолцоо нь гадаад хамаарал бүхий компанийн 2018 оны 4 сарын 1-нээс эхлэх санхүүгийн жилээс хэрэгжиж эхэлнэ.

Сайжруулалт

Хуучин CFC тогтолцооны асуудалтай тал

- Өнөөгийн CFC татварын тогтолцоонд босго татварын хувь хэмжээний тестээр компанийг нэгтгэсэн татвар ногдуулалт хамруулах эсэхийг шийддэг тул гадаад хамаарал бүхий компанийн татварын ачаалал босго татварын хувиас (20%) дээш байвал эдийн засгийн бодитой үйл ажиллагаагүй байсан ч нэгтгэсэн татвар ногдуулалтад хамруулдаггүй нь асуудал болсон.

Энэ асуудлыг шийдвэрлэсэн

- Босго татварын хувь хэмжээгээр шалгуур болгон CFC татварын тогтолцоонд хамруулахгүй болгох бус ①Цаасан компани, ②Cash box, ③ Хар жагсаалтад орсон улс оронд байрлах компанийн тухайд, татварын ачаалал 30%-д хүрэхгүй байгаа тохиолдолд, нэгтгэсэн татвар ногдуулалтад хамруулах тогтолцоог нэвтрүүлэн дараах байдлаар тодорхойлсон:

Сайжруулалт 1

- ① Цаасан компани = татварын ачаалал нь «30% хүртэл» байгаа тохиолдолд нэгтгэсэн татвар ногдуулалтад хамруулна.
- Дараах шаардлагын аль нэгийг хангахгүй гадаад хамаарал бүхий компанийг цаасан компани гэж үзнэ.
- Бодит байдлын жишиг: Голлох үйл ажиллагааг явуулахад шаардлагатай оффис зэрэг тогтсон байгууламжтай байх.
- Хяналтын доор байх жишиг: Толгой оффисын байрлах улсад үйл ажиллагааны менежмент, хяналт, удирдлагыг өөрсдөө хийдэг байх.

Сайжруулалт 2

- ② Cash box = татварын ачаалал нь «30% хүртэл» байгаа тохиолдолд нэгтгэсэн татвар ногдуулалтад хамруулна.
- Гадаад охин компани нь «Санхүүгийн охин компани^(жич)» болох тохиолдол.
- Жич) Санхүүгийн охин компани гэдэг нь толгой оффисын байрлах улсын хууль тогтоомжийн дагуу банкны үйл ажиллагаа эрхэлдэг гадаад хамаарал бүхий компани бөгөөд тухайн улсад удирдлага ба ажилтнууд нь энэхүү үйл ажиллагааг зохистойгоор хэрэгжүүлэхэд шаардлагатай байх ажил үйлчилгээг гүйцэтгэдэг.

Санхүүгийн охин компани биш байх тохиолдолд «Cash box»-ийг хэрхэн тодорхойлох арга

Үйлдвэрлэлийн охин компани зэрэг санхүүгийн охин компанийн шалгуурт нийцэхгүй компанийн тухайд, дараах (a) ба (b)-ийн аль нэгийг хангах гадаад хамаарал бүхий компанийн Cash box гэж тодорхойлдог.

(a)
Пассив орлогын нийт үнийн дүн > 30%
Нийт хөрөнгийн дүн

(b)
Үнэт цаас, зээл, биет бус хөрөнгийн дүн > 50%
Нийт хөрөнгийн дүн

Нэгтгэсэн тооцонд хамаарах пассив орлого

- ① Хүү
- ② Ноогдол
- ③ Үнэт цаасны зээлийн үнэ
- ④ Үнэт цаас шилжүүлсний ашиг, алдагдал
- ⑤ Дериватив арилжааны ашиг, алдагдал
- ⑥ Гадаад валютын ханшийн зөрүүний ашиг алдагдал
- ⑦ ①-ээс ⑥-тай төстэй орлого
- ⑧ Биет хөрөнгийн зээлийн үнэ
- ⑨ Биет бус хөрөнгийн ашиглалтын хураамж
- ⑩ Биет бус хөрөнгө шилжүүлсний ашиг, алдагдал
- ⑪ Бүх төрлийн гэнэтийн ашиг

Пассив орлогын нэгтгэсэн татвар ногдуулалт

Гадаад хамаарал бүхий компанид хамаарна гэж тодорхойлох

↓ yes

Татварын ачааллын хувь хэмжээ 30%-аас бага байна уу ?

↓ yes

Онцгой харилцаа бүхий гадаад компанид хамаарахгүй

↓ no

Татварын ачааллын хувь хэмжээ нь 20%- аас бага

↓ yes

Эдийн засгийн үйл ажиллагааны жишгийг хангах

↓ yes

Хэсэгчлэн гадаад хамаарал бүхий компани гэгдэх

↓ yes

Компанийн нэгжийн нэгтгэсэн татвар ногдуулалт хийгдэхгүй

↓ yes

Пассив орлогын тогтмол нэгтгэсэн татвар ногдуулалт

2010 оны татварын тогтолцооны сайжруулалт болох хөрөнгийн шинжтэй орлогын (Пассив орлого) татвар ногдуулалтын шалтгаан

- Тухайлсан гадаад охин компани нь Үл хамруулах жишгийг хангаж байлаа ч тодорхой хөрөнгийн шинжтэй орлоготой (пассив орлого) тохиолдолд бага үнийн дүнтэй орлогыг үл хамруулах жишгийг хангаж байгаагаас бусад тохиолдолд тухайн хөрөнгийн шинжтэй орлого нь нэгтгэсэн татвар ногдуулалт хийгдэх орлого болно.
- Татвар ногдуулалтын шалтгаан
- Татвар ногдуулалт багатай улсад хөрөнгийн менежментийн орлогоор ашиг хийх гэсэн татвараас зайлсхийх явдлаас сэргийлэхийн тулд

2017 оны татварын тогтолцооны сайжруулалтаар пассив орлогод татвар ногдуулах болсон шалтгаан (Пассив орлогын хүрээг тэлэх)

- 2010 оны татварын тогтолцооны сайжруулалтаар нэвтрүүлсэн хөрөнгийн шинжтэй орлогын нэгтгэсэн татвар ногдуулалтын тогтолцоонд хөрөнгийн шинжтэй орлого гэж тодорхойлогдох орлогын хүрээ нь хязгаарлагдмал байсан тул энэхүү тодорхойлолтын дагуу татвар ногдуулалтад хамрагдах ААН олон байгаагүй.
- Иймд шинэ тогтолцоогоор өөрөө үйл ажиллагаа явуулаагүй ч олох боломжтой орлогыг пассив орлого гэж үзэн, хэсэгчилэн татвар ногдуулах хүрээг тэлсэнээр татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх бодлогыг улам чангатгасан.
- Өөрөөр хэлбэл 2017 оны сайжруулалтаар пассив орлогын хувьд татвараас зайлсхийх магадлалтай гэж үзэн хэсэгчилэн нэгтгэсэн татвар ногдуулалтад хамрагдах орлогын хүрээг нэлээд тэлж өгсөн.

Сайжруулалт 3

- ③ Хар жагсаалтад улсад байрлах аж ахуйн нэгж = татварын ачаалал нь 「30% хүртэл」 байгаа тохиолдолд нэгтгэсэн татвар ногдуулалтад хамруулна.
- Татвартай холбоотой мэдээлэл солилцоонд хамтран ажилладаггүй улс орон, бүс нутаг хэмээн Сангийн сайдын заасан улс орон, газар нутагт төв оффис байх гадаад хамаарал бүхий компани.

Гадаад хамаарал бүхий компанитай холбоотой санхүүгийн тайланг хавсаргах

- Дотоодын аж ахуйн нэгж нь гадаад хамаарал бүхий компанийн санхүүгийн тайланг татварын тайландаа хавсаргах.
- ① Татварын ачааллын хувь хэмжээ 20%-аас бага байх гадаад хамаарал бүхий аж ахуйн нэгж (Эдийн засгийн үйл ажиллагааны жишгийг хангах гадаад хамаарал бүхий аж ахуйн нэгж хамаарна)
- ② Татварын ачааллын хувь хэмжээ 20%-аас бага байх цаасан компанийн санхүүгийн тайлан

(Жич) Үнэ шилжилтийн татварын ТОГТОЛЦООНЫ ХҮСНЭГТ 17(4) (Хавсралт)

- Үнэ шилжилтийн татварын тогтолцооны хувьд 2003 оны шинэчлэлээр жилийн эцсийн тайланд хүснэгт 17(4)-ийг хавсаргахаар болсон. Үнэ шилжилтийн татварын тогтолцооны хүрээнд гадаад харилцан хамаарал бүхий ААН-тэй компани нь тухайн харилцан хамаарал бүхий гадаад ААН-ийн үйл ажиллагааны ашгийн хувийн мэдээлэл болон үнэ шилжилтийн ажил гүйлгээнд хамаарах ТРМ (үнэ шилжилтийг тодорхойлох арга) –ыг жилийн эцсийн тайлангийн хүснэгтэд оруулж өгөхөөр болсон.
- Хуулбарыг хавсаргав.

**3. Бодит байдлын жишиг үзүүлэлтийн
тодорхойлолт: Бодит хяналтын жишиг,
удирдлагын хяналтын жишиг, менежментийн
хяналтын газрын зарчим, бодит хяналтын доор
байх харилцаа**

1. Бодит хяналтын жишиг (CFC сайжруулалт)

Гадаад хамаарал бүхий компанийг тодорхойлохдоо, дотоодын хуулийн этгээд нь гадаадын хуулийн этгээдийн үлдэгдэл хөрөнгийг бүгдийг нэхэмжлэх эрх бүхий харилцаатай бол гадаад хамаарал бүхий хуулийн этгээд гэж үзнэ.

2 Удирдлагын хяналтын жишиг (Control criteria) 1

(ТАХТХ 40-7③、66-6③, ЗГ66-6-16)

Гадаад охин компанийн татварын нэгтгэн тооцохтой холбоотой хуучин тогтолцооны хүрээнд энэхүү тогтолцоонд хамруулахгүй байх шалгуур үзүүлэлтүүдийн нэг.

Байнгын оршин суугч ба дотоодын аж ахуйн нэгжтэй холбоотой тухайлсан гадаадын охин компани нь толгой оффисын байрлах газарт үйл ажиллагааны удирдлага, хяналтыг өөрсдөө бие даан хийдэг байх шаардлагыг хангах.

Энэ тохиолдолд, байнгын оршин суугч ба дотоодын аж ахуйн нэгжтэй холбоотой тухайлсан гадаадын охин компани нь толгой оффисын байрлах газарт үйл ажиллагааны удирдлага, хяналтыг өөрсдөө бие даан хийдэг эсэхийг дараах 4 шалгуур үзүүлэлтээр тодорхойлно.

2 Удирдлагын хяналтын жишиг (Control criteria) 2

- Тухайлсан гадаад охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал ба ТУЗ
- Удирдах ажилтны хувиар чиг үүргээ гүйцэтгэх газар байх
- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, хадгалах газар байх
- Бусад шалгуур

Жишээлбэл,

① Тухайлсан охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь толгой оффисын байрлах улсаас өөр газарт болдог байх,

② Тухайлсан охин компани нь үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулахдаа, байнгын оршин суугч ба дотоодын хуулийн этгээдтэй зөвлөлдөж, саналыг авдаг байсан ч, зөвхөн энэ шалтгаанаар тухайн охин компани нь үйл ажиллагааны удирдлага, хяналтаа өөрсдөө бие даан хийдэггүй гэж тодорхойлоход хангалтгүй.

3 Менежментийн хяналтын газрын зарчим

(Central management and control)

Дотоодын хуулийн этгээд ба гадаадын хуулийн этгээдийг ангилан тодорхойлох жишиг үзүүлэлтийн нэг бөгөөд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь бодитойгоор нэгдсэн хяналтад байгаа газрыг тухайн хуулийн этгээдийн байрлах байршил гэж үзэх зарчим.

Менежментийн хяналтын газрын зарчмыг Европын ихэнх улс оронд ашигладаг.

Ашиглах: Толгой компанийн байрлах газрын зарчим

4. Бодит хяналтын доор байх харилцаа **(Substantive affiliated relationship) (TP)**

- Үнэ шилжилтийн татварын тогтолцооны хүрээнд, гадаад харилцан хамаарал бүхий этгээд болох гадаадын хуулийн этгээд нь тухайн хуулийн этгээдтэй тусгай харилцаатай байх нэг хэлбэр бөгөөд хуулийн хүрээнд дараах 3 харилцааг авч үздэг:
 1. Гадаадын харилцан хамаарал бүхий хуулийн этгээдийн удирдлагын талаас илүү, эсвэл төлөөлөх эрх бүхий удирдлага нь нөгөө талын хуулийн этгээдэд давхар ажилладаг, эсвэл ажиллаж байсан байх.
 2. Тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны дийлэнх нь нөгөө хуулийн этгээдтэй хийх ажил гүйлгээнээс хамааралтай байх.
 3. Хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтын ихэнхийг нөгөө хуулийн этгээдээс зээлж, эсвэл энэхүү хуулийн этгээдийн батламжлалаар санхүүжилтээ бүрдүүлсэн байх.

4 Биет бус хөрөнгө ба дотоод эх үүсвэртэй орлого

Биет бус хөрөнгө ба дотоод эх үүсвэртэй орлого

Q Уул уурхайтай холбоотой биет бус хөрөнгө бүхий Японы хуулийн этгээдийн гадаад дахь төв компанийг тухайн улсдаа өөр хуулийн этгээдэд худалдан борлуулахад үүсэх ашгийг Японы дотоод эх үүсвэртэй орлого хэмээн үзэх боломжтой байх заалтыг оруулахын тулд яавал дээр вэ? Энэхүү төв компани нь Японд төлөөний газаргүй болно.

1. Гадаадын ААН-д аж ахуйн нэгжийн татвар ба суутган татвар ногдуулах талаар авч үзнэ.
2. Иргэний хууль, нягтлан бодох бүртгэлийн талаасаа «Хөрөнгө»-ийг авч үзэх, ААНОАТ хуулиас бусад татварын хуулийн хүрээнд «Хөрөнгө»-ийг авч үзэх шаардлагатай.
3. ААНОАТ хуулийн 138-2-т дотоодод байгаа «Хөрөнгө»-д тухайн биет бус хөрөнгө хамаарах эсэхийг авч үзнэ. Орж байгаа тохиолдолд, ААНОАТ-ын хуулийн 141-2-оор төлөөний газаргүй гадаадын хуулийн этгээдэд татвар ногдуулалт хийнэ.

Mining License

- I think Mining License is not an intangible asset.
- Because the license is just administrative license.
- Everybody can get the license.
- No need to have special scientific technique.

1. Гадаадын хуулийн этгээдэд татвар ногдуулах эсэхийг авч үзэх (PE-тэй&PE-гүй тохиолдол)

(1) Гадаадын төв компанийг худалдах нь охин компанийн хөрөнгийг борлуулж байгаа хэрэг бус болох тул ААНОАТ хуулийн 138-3-т 「Дотоодод байх хөрөнгийг шилжүүлэх」-тэй холбоотой асуудал биш бөгөөд мөн зүйлийн 2-т заасан 「Дотоодод байх хөрөнгийг ашиглах, эзэмших」-тэй холбоотой асуудал юм.

(2) Охин компанийн эзэмшлийн биет бус хөрөнгө нь энэхүү зүйлийн 2-т заасан 「Хөрөнгө」-д хамаарах уу гэдгийг тодорхойлохдоо ААНОАТ хуулийг хэрэгжүүлэх аргачилалын 177-р зүйлийг ашиглах.

(3) Гадаадын төв компани нь төлөөний газаргүй тул төлөөний газаргүй гадаадын ААН-д татвар ногдуулах ААНОАТ хуулийн 141-р зүйлийг барина.

(4) Төлөөний газартай бол орлогыг PE-д хамаатуулах(ААНОАТ141-1)

PE байхгүй бол PE-д хамаатуулахгүй дотоод эх үүсвэртэй орлого гэж үзнэ. (ААНОАТ141-1)

2 Иргэний хууль, компанийн хууль ба нягтлан бодох бүртгэлийн хүрээний 「Хөрөнгө」

1. Иргэний хуульд「зүйл」гэдэг нь биет зүйлийг заадаг тул ААНОАТ хуульд заасан биет бус хөрөнгө энэхүү заалтад хамаарахгүй тул Иргэний хуулийн 「Хөрөнгө」гэдэг ухагдахууныг тэр чигт нь ашиглах боломжгүй.

2. Компанийн хуулийн заалтаар орлого олох хөрөнгө хэмээн зөвшөөрөгдөнө.

3. Нягтлан бодох бүртгэлийн тухайд, ашиг сонирхолын харилцаатай талуудын мэдээллийг нээлттэй болгох зарчмаас үүдэлтэйгээр 「Хөрөнгө」-ийн ухагдахуун бүрэлдсэн гэж үзнэ.

4. Гэхдээ, гадаадын ААН-д татвар ногдуулахдаа, орлогыг татвар ногдуулах зүйл гэж үзэх тул, орлогыг үүсгэх эх үүсвэр юу болох гэдэг талаасаа харж 「Хөрөнгө」 ухагдахууныг авч үзэх ёстой. Иймд, Компанийн тухай хууль ба нягтлан бодох бүртгэлийн хүрээний 「Хөрөнгө」ухагдахууныг тэр чигээр нь орлого үүсэх эх үүсвэр болох хөрөнгө гэж ашиглах боломжгүй.

C1 ААНОАТ хуулиас бусад «Хөрөнгө»-ийн ухагдахуун

- Өв залгамжлалын хуулиар хөрөнгийг «Мөнгөөр илэрхийлэх боломжтой эдийн засгийн үнэ цэнэ бүхий зүйл» гэж тодорхойлдог.
- Хэрэглээний татварын хуулиар хөрөнгийг нэмүү өртөг байгаа эсэх талаасаа ажил гүйлгээнд хамаатуулах эсэхийг шийддэг.
- Орлогын татварын хуулиар хөрөнгийг авч үзэхдээ, тухайн хөрөнгийн эрхийн ухагдахууныг авч үздэг ба хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, газрын түрээсийн эрх, биет бус хөрөнгийн эрх, зөвшөөрөлтэй холбоотой эрхийг өргөн хүрээтэйгээр авч үздэг.

Corporation Tax Art.138①(1)

- The term “domestic source income in this Part means those listed in the following:

(1)Income to be attributed, in the case where a foreign corporation carries on a business through a permanent establishment and if the said permanent establishment were a person who is independent of the said foreign corporation in carrying on business, to the said permanent establishment, taking into consideration of circumstance such as functions performed by the said permanent establishment, assets used at the said permanent establishment, and internal transactions between the said permanent establishment and head office, etc. of the foreign corporation (meaning the head office, a branch, a factory and others prescribed by Cabinet order as a similar place of business that are other than the said permanent establishment; the same applies in the next paragraph and paragraph (2) of the next Article)(including income from the transfer of the said permanent establishment);

ААНОАТ хуулийн 138-2 ба 138-3

138-2 Дотоодод байх хөрөнгийн ашиглалт, эзэмшлээс үүсэх орлого (Орлогын татварын хуулийн 161-1-8-аас 10 заалт, 13-аас 16 заалт (Дотоод эх үүсвэр бүхий орлого)-д хамаарах зүйлийг оруулахгүй)

138-3 Дотоодод байх хөрөнгийг бусдад шилжүүлснээс үүсэх орлого хэмээн хуулиар заасан зүйлс

Corporation Tax Art.138①(2)(3)

(2)Income arising from the management or possession of assets that exist in the State (excluding income that falls under income listed in items (8) to (11) and (13) to (16) of paragraph (1) of Art. 161 (Domestic source income) of the Income Tax Act);

(3) Income prescribed by Cabinet Order as a gain derived from the transfer of assets that exists in the State;

ААНОАТ 138-4,5,6

4. Дотоодод хуулиар заасан үйлчилгээг (хүний үзүүлэх үйлчилгээ) үйл ажиллагааны голлох чиглэл болгодог ААН-ын энэхүү үйлчилгээг үзүүлсний төлбөр байдлаар олох орлого

5. Дотоодод байх үл хөдлөх хөрөнгө, дотоодод байх үл хөдлөх хөрөнгөд хамаарах эрх, Ашигт малтмалын хуулиар (Шёова 25 оны хуулийн 291) заасан ашигт малтмалын эрхийн түрээс, (газар дээрх эрх ба ашиглалтын эрх, эсвэл ҮХХ, ҮХХ-ийн эрх зэрэг бүгд хамаарах), Уул уурхайн хуульд (Шёова 25 оны хуулийн 219)заасан ашигт малтмалын ордын эрх, эсвэл Орлогын хуулийн 2-1-3(Тодорхойлолт)-д заасан байнгын оршин суугч, эсвэл дотоодын ААН-д усан онгоц, нисэх онгоц түрээслэх үнэ

6. Өмнөх заалтуудад зааснаас бусад хуулиар орлогын эх үүсвэр нь дотоодод байгаа хэмээн заасан зүйлс

3-2 ААНОАТ хуулийн 138-р зүйлийн тайлбар

- Японд төлөөний газаргүй гадаадын хуулийн этгээд нь Япон дахь охин компанийн уул уурхайтай холбоотой биет бус хөрөнгө нь үнэ цэнэ бүхий гэдэг шалтгаанаар өндөр үнээр өөр хуулийн этгээдэд худалдагдсан. Тухайн ашгийг, 138-2 орлогын дотроос «Хөрөнгийн ашиглалт, эзэмшилээс үүссэн орлого» хэмээн татвар ногдуулж болох эсэхийг авч үзэх.
- Энэ тохиолдолд, орлогын «Хөрөнгө»-ийг хэрхэн тайлбарлахаас ихээхэн хамаарна.
- Үүний тулд ААНОАТ хуулийн дагалдах журмын 177 зүйлийг ашиглана.
- Гэвч, Slide 56-д тайлбарласанчилан Монгол улсын охин компанийн хөрөнгө нь Mining license бол энэ нь 138-2-д заасан орлогод хамаарахгүй. Mining license –ийг өндөр үнэ цэнэ бүхий биет бус хөрөнгө гэж үзэхгүй учраас.

3-3 Art.177 of Corp.Tax Law Cabinet Order

- Art.177 ①
- Income arising from the management or possession of assets listed in the following is included in the domestic source income listed in Art. 138①(2).
- (1) Government Bond or Local Bond in the Public Bond prescribed in Art.2 ①(9) (Definition) or Bond issued by domestic corporation and promissory note listed in the Art.2①(15) of Financial product trading Law.
- (2) Loan credit to the Resident prescribed in Art. 2①(3)except the resident's business
- (3)Right to get insurance and distribution of surplus fund on the basis of the life insurance contract concluded through the business office, office, and equivalent to those or agent concluding the contract in State, old postal life insurance, nonlife insurance contract, and other contract similar to those prescribed in Art.30 (1) Cabinet Order of Income tax law.
- Art.177②
- The interest prescribed in Art. 283 Cabinet Order of Income Tax Law (Loan interest on domestic business) is not included in domestic source income listed in Art. 138 ①(2).

3-4 ААНОАТ хуулийн дагалдах журмын 177-р зүйлийн тайлбар

- ААНОАТ хуулийн дагалдах журмын 177-р зүйл нь нэлээд дэлгэрэнгүй бөгөөд энэд нийцэх тохиолдолд 「Хөрөнгө」-ийн хамрах хүрээ ихээхэн өргөн болно.
- Иймд орлого нь шууд бий болох эх үүсвэр хэмээн үзэх 138-2 орлогын 「Хөрөнгө」гэсэн ухагдахуунд үндэслэн, татвар ногдох орлого нь дотоодод үүссэн тохиолдолд, татварын хууль талаасаа хөрөнгийг хэрхэн авч үзэх гэдэг талаасаа хөрөнгийн заалтыг оруулна.
- Ийм байдлаар илэрхийлэгдсэн зүйл нь хөрөнгийн эрхийг хамрах бөгөөд, тухайлбал, хөдлөх хөрөнгө, ҮХХ, оюуны өмчийн эрх, зөвшөөрөл гэх мэт байна.

3-5 ААНОАТ хуулийн 141-р зүйлийн 2

- 141-р зүйл: Гадаадын ААН-д тайлант хугацаа тутмын орлогод ногдуулах ААН-ын орлогын татварын жишиг нь дараах байдлаар заасан дотоод эх үүсвэртэй орлоготой холбоотой үнийн дүн байна.
 - ❖ РЕ-тэй гадаад хуулийн этгээд: санхүүгийн жилд хамаарах дотоод эх үүсвэртэй орлого
 - ❖ 138-1-1 (дотоод эх үүсвэртэй орлого)-д заасан дотоод эх үүсвэртэй орлого
 - ❖ 138-1-2-оос 6 хүртэл заалтад заасан дотоод эх үүсвэртэй орлого (тус зүйлийн 1-т заасан дотоод эх үүсвэртэй орлогод тохирох зүйлийг оруулахгүй)
 - ❖ РЕ-гүй гадаад хуулийн этгээд: санхүүгийн жилд хамаарах 138-1-2-оос 6 хүртэлх дотоод эх үүсвэртэй орлого

Дүгнэлт (177-р зүйлийг сайжруулах шаардлага)

- ААНОАТ хуулийн дагалдах журмын 177-р зүйлтэй адил заалт байгаа гэдэг нь нөхцөл болно.
- ААНОАТ хуулийн дагалдах журмын 177-р зүйлд хөрөнгийн жагсаалтыг зааж өгсөн байдаг ч одоогийн байдлаар санхүүтэй холбоотой заалтууд голлодог.
- ААНОАТ хуулийн дагалдах журмын 177-р зүйлд, ашигт малтмалтай холбоотой биет бус хөрөнгийн заалтыг оруулах шаардлагатай.

Гадаадын ААН-д татвар ногдуулах харилцаа

- Гадаадын ААН-д татвар ногдуулах: Зурагт тайлбар, Хуулбарыг хавсаргав
- 2014 оны сайжруулалтаар РЕ-тэй эсэхээс шалтгаалан гадаадын ААН-ийн орлогод хамаарах ААНОАТ хуулийн татвар ногдуулах орлогыг дахин ангилсан.
- РЕ-д хамаарах орлогын хувьд дотоодын ААН-тэй адилхан авч үзэхээр болсон.

Тухайн улсад ямар хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаагаас хамааруулан үзвэл:

- ① РЕ-тэй гадаадын ААН: ААНОАТ хуулийн 138-р зүйлийн ①-1-д заасан дотоодын эх үүсвэртэй орлого (ААНОАТХ-ийн 141-А)
ААНОАТ хуулийн 138-р зүйлийн ①-2 оос 6-д заасан дотоодын эх үүсвэртэй орлого (138-р зүйлийн ①-1д заасан орлого хамаарахгүй) (ААНОАТХ-ийн 141-Б)
- ② РЕ-гүй гадаадын ААН: Үйл ажиллагааны жил тус бүрийн ААНОАТХ-ийн 138-р зүйлийн ①-2 оос 6-д заасан дотоодын эх үүсвэртэй орлого (ААНОАТХ-ийн 141-В)

GAAR **Монгол улс** **Загвар зүйл заалт**

2017 оны 10 сарын 20

Санал 1: Mongolian GAAR in General Tax Law model

Article. 18.1

- General Tax Law

Art.18 General Regulation for Prevention of Tax Evasion/GAAR

18.1 The tax administration shall take appropriate measures against tax evasion through misuse of any tax reduction and exemption policy and the corporate structure, misuse of the intergovernmental agreements and reduction of taxable income on the basis of tax arrangement without bona fide commercial objectives through relations with any other country ~~with lower tax rates than Mongolia.~~

1) Bona fide –ийг нэмсэн шалтгаан

Арын “бага татварын хувь хэмжээ” гэсэн хэсгийг хассан. Учир нь зүгээр л “reduction” гээд бичихээр цаанаа ямар ч асуудалгүй “reduction” шиг харагдаж байна.

Иймд энэ заалтын суурь болгож Хятад улсын татварын хуулийн зүйл заалтыг оруулж, асуудалтай “reduction” болгосон.

Хятад улсын ААНОТ хуулийн 47-р зүйлд заасан “without bona fide commercial objectives”- ийг нэмж өглөө. Ингэвэл “жинхэнэ зорилгогүй” tax arrangement (Зохион байгуулалттай ажил гүйлгээ) –д үндэслэсэн татвар ногдох орлогыг бууруулах болно.

2

2) “Бага татварын хувь хэмжээтэй улс” гэдгийг хассан шалтгаан

1. Бусад улс орнууд GAAR-ын зүйл заалтдаа бага татварын хувь хэмжээтэй улс орны талаар зааж оруулаагүй байдаг.
2. Татвараас зайлсхийхийн тулд татварын хувь хэмжээ бага улс орнуудыг дунд нь хавчуулан ашиглах, эсвэл ийм байдлаар ашиглахгүй байх гэсэн янз бүрийн тохиолдол байдаг учраас энэ заалтыг тухайлан онцлон оруулахгүй байсан нь дээр.
3. Мөн татварын хувь хэмжээ (%) өөрчлөгддөг учир хувь хэмжээ (%) -д ач холбогдол өгөхгүй байсан нь дээр.

3

Санал 2: Хятад улсын ААНОТ-ын хуулиас санаа авч боловсруулсан загвар заалт model Article. 18.1.1

- 18.1.1 (referring to Art.47 of Corporate Income Tax Law in China)

~~If an enterprise enters into any business tax arrangement without bona fide commercial objectives~~ economic substance and business purpose

~~that results in reduced taxable revenue or income, the tax authority is entitled to~~ **shall** make adjustments based on appropriate ~~reasonable~~ methods.

economic substance and business purpose-ийг ашигласан шалтгаан

- Common law- Нийтлэг эрх зүйн зарчим business purpose (Үйл ажиллагааны зорилго) & economic substance (Эдийн засгийн агуулга), Хятад улсын GAAR зарчмын “хэлбэрээс илүү агуулгыг нь анхаарах” (substance over form) & эдийн засгийн хувьд зохистой бизнесийн үйл ажиллагааны зорилго (reasonable commercial purpose), Америкийн ESD (Economic Substance Doctrine)-аас санаа авсан.

4

Санаа авах: Хятад улсын ААНОТ-ын хуулийн 47-р зүйл

Art. 47

If an enterprise enters into any business arrangement without bona fide commercial objectives that results in reduced taxable revenue or income the tax authority is entitled to make adjustments based on reasonable methods.

5

Санал 3: Model Article. 18.1 .2

18.1.2

In the case that taxpayer's intention of tax arrangement is to look for defects of provisions of tax law or to reduce the tax burden for tax avoidance, the tax authority shall take appropriate measures against those tax arrangements.

- taxpayer's intention-ийг заалтад оруулсан шалтгаан

УК-ийн урвуулан ашиглах (abusive) талаарх 3 дах шалгуур үзүүлэлтийг ашигласан.

“③ Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээ нь татварын хуулийн цоорхойг илрүүлэх зорилготой хийгдсэн үү?” Урвуулан ашиглах (abusive) талаарх 3-н шалгуур үзүүлэлтийг ашигласан.

Герман улсын GAAR 42-р зүйлийн ④ (Субъектив хүчин зүйл) “Татвар төлөх үүрэг бүхий этгээд нь татварын ачааллыг бууруулах зорилготой тохиолдолд” – ийг ашигласан.

6

Хувийн эрх зүйн зүгээс авч үзэх нь

18.1.3. The arrangement is deemed to be sham or fictitious based on Mongolian Civil law or other laws and orders, the tax authority shall take appropriate measures against those tax arrangements.

- Sham, fictitious-ийг оруулсан шалтгаан

sham-ийг Common law- Нийтлэг эрх зүйн зарчим болон Бельги улсын GAAR-аас, fictitious -ийг Хонконгийн GAAR болон Монгол улсын Иргэний хуулийн 56-р зүйлээс авсан.

- Mongolian Civil law –ийг оруулсан шалтгаан

- Япон улсын Токиогийн их сургуулийн профессор Наказатогийн “Хувийн эрх зүйн бүтцийн тайлбар” болон Герман улсын **1934 оны Татварт тохируулга хийх хууль (хуучин GAAR) 6-р зүйлийн ①**-д “Иргэний хуульд заасан гэрээ, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг урвуулан ашигласнаар татвар төлөх үүргээс зайлсхийх эсхүл хэт бууруулах боломжгүй”-г ашигласан.

- Монгол улсын Иргэний хууль 56-р зүйл

56.1 A transaction shall be deemed void if:

56.12 made fictitiously;

7

GAAR-тай холбоотой санаа авах зүйлс

8

Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм (GAAR)

- GAAR (General Anti-Avoidance Rules)-ийн онцлог
- Дотоодын хуулиар зохицуулах, татвар ногдуулах байгууллагын хувьд татвараас зайлсхийхийн эсрэг хууль тогтоомж.
- Зөвхөн татварын хувьд давуу байдал эдлэхийг зорилгоо болгосон ажил гүйлгээний тухайд татварын байгууллагыг энэхүү давуу эрхийг түдгэлзүүлэх боломжоор хангах заалт. Татвар ногдуулалтын хамрах хүрээ өргөн бөгөөд орлогын татвар, ААНОТ, өв залгамжлалын татвараас гадна бусад татварын төрөлд хэрэглэдэг ерөнхий зарчим.
- GAAR-ийг дэлхийн 24 улсад нэвтрүүлсэн бөгөөд G20-ийн дотор GAAR-гүй улс нь Япон, БНСУ, Индонези, Саудын Араб, Мексик, Аргентин, Орос, Турк гэсэн 8 улс байдаг.

9

★GAAR 2 Япон улсын GAAR

Түдгэлзүүлэх заалт

- Хэт өндөр хүүгийн татварын тогтолцоо, Нимгэн капиталын татварын тогтолцоо, LOB (Тусгайлан хязгаарласан заалт)

Япон улсын GAAR

- ААНОТ-ын ачааллыг зохисгүйгээр багасгах “үр дүн” –д хүргэсэн бөглөөн хуулийн этгээдийн “үйлдэл” эсвэл “тооцоолол”-ыг түдгэлзүүлж, энгийн үйлдэл, тооцоололд шилжүүлэн засч татвар ногдуулах тухай “Үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх хязгаарлалт хийх заалт” байдаг.
- Гэр бүлийн компанийн хооронд хийсэн үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт (Дайны өмнөх үеэс)
- Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотой хийсэн хооронд хийсэн үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт (2001 он)
- Татварын нэгтгэсэн тайлан гаргах үед толгой болон охин компани хоорондын тооцооллын үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт (2002 он)
- Компания дараа үедээ залгамжлуулахтай холбогдуулан хийсэн үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт (2009 он)

10

★GAAR-ийн үндэслэл болох хууль

Америк хэлбэр

- IRC 7701-р зүйл(о). Эдийн засгийн агуулгын зарчим (Economic Substance Doctrine : ESD)

Герман хэлбэр

- Татварын ерөнхий хуулийн 42-р зүйл (Татвараас зайлсхийхийг түдгэлзүүлэх заалт)

Англи хэлбэр

- 2013 оны Санхүү, төсвийн хуулийн 207-р зүйл (Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээ, урвуулан ашиглахыг тодорхойлох)

Бельги хэлбэр

- GAAR арга (Хувийн эрх зүй дэх Sham transaction)

Франц хэлбэр

- Татварын процессийн хуулийн 64-р зүйл (Хувийн эрх зүй дэх эрх урвуулан ашиглах)

Хятад хэлбэр

- ААН-ын орлогын татварын хууль 47-р зүйл (Эдийн засгийн агуулгын зарчим ба эдийн засгийн хувьд зохистой байх бизнесийн зорилго)

★GAAR-аас бусад татвараас зайлсхийхийн эсрэг арга ХЭМЖЭЭ

- ① Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм
GAAR
- ② Татвараас зайлсхийхийн эсрэг онцгой дүрэм
SAAR: Specific Anti-Tax Avoidance Rule
жиш: Японд гэр бүлийн компанийн хооронд хийсэн үйлдэл, тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх заалт: (ААНТ-ын хууль 132-р зүйл)
- ③ Тухайлсан зорилго бүхий татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм
TAAR : Targeted Anti-Avoidance Rule)
жиш: татвараа нэгтгэн төлөлт, байгууллагын зохион байгуулалтын өөрчлөлт, PE-д хамаатуулах орлоготой холбоотой тооцоог түдгэлзүүлэх, хязгаарлалт хийх
- ④ Жишээгээр шийтгэх хуулиар тогтоосон аксиом (Doctrine)

12

★Нийтлэг эрх зүйн татвараас зайлсхийх үйлдлийг түдгэлзүүлэх зарчим (Англо- Америк хандлага)

- ① business purpose (үйл ажиллагааны зорилго)
- ② step transaction (шаталсан ажил гүйлгээ)
- ③ substance over form (хэлбэрээс илүү агуулгыг нь анхаарах зарчим)
- ④ sham transaction (дүр эсгэсэн ажил гүйлгээ)
- ⑤ economic substance (эдийн засгийн агуулга)

13

★Америк улсын GAAR:IRC 7701 зүйлийн (o). 2010 оны хууль

- ESD (Economic Substance Doctrine): Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм болох GAAR-ийг шинээр гаргаж ирсэн бус Нийтлэг эрх зүйн үзэл дээр үндэслэсэн.
- ESD-ийн нөхцөл болон тодорхойлолт
 - ① Тухайн ажил гүйлгээ нь *дотоодын орлогын татвараас гадна бодит талаас татвар төлөх үүрэгтэй этгээдийн* эдийн засгийн нөхцөл байдлыг өөрчилж байх (объектив нөхцөл)
 - ② Татвар төлөх үүрэгтэй этгээд нь тухайн ажил *гүйлгээний хувьд дотоодын орлогын татвараас өөр* бодит зорилготой байх (Субъектив нөхцөл)

14

★Англи улсын GAAR(2013 оны GAAR-ийн заалт: Урвуулан ашиглахаас сэргийлэх онцгой арга хэмжээний заалт ➡Татвараас зайлсхийхээс сэргийлсэн заалт биш!)

Нотлох хариуцлага: Татварын байгууллага

Татгалзах нөхцөл: Урвуулан ашиглахыг (Abusive) тодорхойлох шалгуур (←avoidance (зайлсхийх) биш)

- ① Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээний бодит үр дүн нь татварын хуулийн үзэл баримтлалын зарчимтай нийцэж байгаа эсэх?
- ② Энэхүү үр дүнд хүрэх процесс нь тодорхой эсвэл хэвийн бус шат дамжлагыг багтаадаг эсэх?
- ③ Зохион байгуулалттай ажил гүйлгээ нь татварын хуулийн цоорхойг хайн ашигласан эсэх?

GAAR-т хамруулах тодорхойлолтын шалгуур: Давхар сорил

- ① Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээ нь зохистой үйл ажиллагаа мөн эсэх?
- ② Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ ажил гүйлгээний талаар зохистой шийдвэр гаргах боломжтой эсэх?

15

★ Хятад улсын хэлбэр 1 (2008 оноос GAAR-ийг нэвтрүүлсэн)

Хятад улс GAAR-ийг 2008 оноос нэвтрүүлсэн.

GAAR нь the last resort (хамгийн сүүлд нэвтрүүлсэн тогтолцоо) юм. ҮШ-ийн татварын тогтолцоо (1991 онд анх), Татварын диваажинтай холбоотой татварын тогтолцоо (2008 онд анх)-уудын тусгайлсан заалтаар татвараас зайлсхийх ажил гүйлгээг түдгэлзүүлж чадахгүй байх үед GAAR ашиглах болсон. Тусгайлсан заалтын давуу байдал.

① Хуулийн үндэслэл: ААНОТ-ын хуулийн 47-р зүйл (2008 оны 1 сард нэвтрүүлсэн)

• “ААН-ийн татвар ногдох орлогын хамрах хүрээний тухайд, орлогын үнийн дүн нь тухайн ААН-ийн үйл ажиллагааны бодит зорилго байхгүй ажил гүйлгээнүүдийн (arrangements) үр дүнд буурах тохиолдолд, татварын байгууллагаас зохих арга ашиглан залруулга хийх эрхтэй.”

• Татвараас зайлсхийх зарчим (Дагалдах журмаар зааж өгсөн)

• ① Хэлбэрээс илүү агуулгыг нь анхаарах зарчим (substance over form)

• ② Эдийн засгийн зохистой үйл ажиллагааны зорилго (reasonable commercial purpose)

② Хятад улсын татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм (General Anti-Avoidance Rule)

Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийн хяналтын хууль (туршилт) (Administrative Measures on the General Anti-Avoidance Rule (Trial)) (2014 оны 12 сарын 2 өдөр) (Татварын ерөнхий газрын 32-р дугаар тушаал. Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийн хяналтын хууль (туршилт) –ийг зарлаж 2015 оны 2 сарын 1 өдрөөс хэрэгжсэн.

Энэ хяналтын хууль нь Татварын арга хэмжээний үндсэн хууль юм.

16

★ Хятад улсын хэлбэр 2 (Англи хэл дээр байгаа)

• Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийн хяналтын хууль (туршилт) (Administrative Measures on the General Anti-Avoidance Rule (Trial)) (2014 оны 12 сарын 2 өдөр)

• 1-р Бүлэг. Нийтлэг үндэслэл

Art.1: GAAR –ын хяналтыг хийхийн тулд GAAR-ыг хэрэгжүүлэх удирдлагын бодлого, чиглэлийг БНХАУ-ын ААНОТ-ын хууль, Улсын татвар хураалтын тухай хууль болон түүний дагалдах журамд нийцүүлэн боловсруулна.

Art.2: Татвараас зайлсхийх арга нь ААНОТ-ын хуулийн 47-р зүйл болон давуу эрх, ашиг эдлэх зорилго бүхий арилжааны зорилгогүй, татвараас зайлсхийх схемтэй холбоотой хууль хэрэгжүүлэх аргачлалын 120-р зүйлийн Тусгай татвар ногдуулалтын зохицуулалтын дагуу явагдана.

Art.3: “Татварын хувьд давуу байдал” гэдэг нь ААН-ийн татвар төлөх боломжит дүнг бууруулах, хасалт хийх, хойшлуулахтай холбоотой зүйл.

Art.4: Олон улсын татвараас зайлсхийх схем нь дараах онцлогтой.

1) Цорын ганц, эсхүл гол зорилго нь татварын татварын хувьд давуу байдал эдлэхэд орших

2) Татварын давуу эрх, ашгийг татварын хуулийн зорилгын хүрээнд зөвшөөрөгдөх боловч эдийн засгийн бодит байдалтай нийцэхгүй ажил гүйлгээг ашиглан олсон байх.

17

★ Хятад улсын хэлбэр 3 (Англи хэл дээр байгаа)

- Art.5 : *Эдийн засгийн агуулгын зарчмын үүднээс Татварын байгууллага нь зохистой арилжааны зорилго болон эдийн засгийн агуулга бүхий бусад ижил төрлийн ажил гүйлгээтэй харьцуулах, тэдгээрийн талаарх мэдээллийг ашиглах замаар доорх татвар ногдуулалтын тусгай зохицуулалтыг хийдэг.*
- 1) Ажил гүйлгээг бүхэлд нь эсвэл хэсэгчилэн өөрчлөх
- 2) *Татварын зорилгын хүрээнд ажил гүйлгээнд оролцогчийг авч үзэхгүй байх, эсвэл тэдгээрийг нэг ижил байгууллага гэж үзэх.*
- 3) Холбогдох орлого, буурсан дүн, татвар ногдуулалтын шалтгаан, гадаадад төлсөн албан татварын хасалт, ажил гүйлгээ хийсэн этгээд хоорондын ашгийн хуваарилалт
- 4) Бусад зохистой арга барил

18

★ Хятад улсын хэлбэр 4 (Англи хэл дээр байгаа)

- Art.6
- Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхийдөө Үнэ шилжилт, Зардал хуваах, CFC татварын тогтолцоо, Нимгэн капиталжуулалтын татварын тогтолцоо гм тусгайлсан заалтууд GAAR-аас илүү ашиглагддаг.
- Түүнчилэн татвараас зайлсхийхийн эсрэг Татварын гэрээний beneficial ownership (Жинхэнэ эзэмшигчийн зарчим), LOB (limitation on benefit) (Тусгай заалт)-ийн заалтууд GAAR-аас илүү давуу байдалтайгаар ашиглагддаг.

19

★Герман улсын GAAR

•Татварын ерөнхий хуулийн 42-р зүйл (Татвараас зайлсхийхээс түдгэлзүүлэх заалт)

➔GAAR-ын тухай заалт болох АО 42-р зүйл нь ажил гүйлгээний хэлбэрийг сонгох боломжийн талаарх хуулийн заалтыг урвуулан ашиглах замаар татварын хууль тогтоомжоос зайлсхийх боломжийг хаадаг. Мөн урвуулан ашигласан тохиолдолд ажил гүйлгээний эдийн засгийн агуулгыг харгалзан бодит байдлыг тусгасан ажил гүйлгээний хэлбэрээс үүсэх татварт хамаарах нэхэмжлэх эрх үүснэ гэсэн заалттай.

Герман улсын GAAR-ийн түүх 1

1871 он Германы эзэнт гүрэн байгуулагдсанаар Татварын хуулийн бүтэц бий болсон.

1918 он Дэлхийн 1-р дайн дууссан.

1919 он Рейхийн татварын ерөнхий хууль (Reichsadgabenordnung (RAO))

4-р зүйл (Эдийн засгийн агуулгыг харгалзан үзэх арга : wirtschaftliche Betrachtungsweise)

“Татварын хуулийг тайлбарлахдаа хуулийн зорилго, эдийн засгийн ач холбогдол болон бусад харилцаа хоорондын хөгжилд тулгуурлах ёстой.”

(Хуулийн тайлбарын зарчмыг тогтоосон заалт)

➔Энэхүү Эдийн засгийн агуулгыг харгалзан үзэх арга нь 1977 онд хүчингүй болсон.

Герман улсын GAAR-ийн түүх 2

1919 он Рейхийн Татварын ерөнхий хууль (Reichsadgabenordnung (RAO))

5-р зүйлийн ① (GAAR)

“Иргэний хуульд заасан гэрээ, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг урвуулан ашигласнаар татвар төлөх үүргээс зайлсхийх эсхүл хэт бууруулах боломжгүй.”

1933 он Нацист засаглал бий болсон

1934 он Татварын тогтолцооны шинэчлэл

Татварт тохируулга хийх хуулийг бий болгох (steueranpassungsgesetz)

1919 он Татварын ерөнхий хуулийн 4-р зүйлийг Татварын зохицуулалтын хуулийн 1-р зүйл рүү шилжүүлсэн.

22

Герман улсын GAAR-ийн түүх 3

1934 он Татварт тохируулга хийх тухай хууль (steueranpassungsgesetz) ⇒ GAAR

6-р зүйл

①-р заалт

“Иргэний хуульд заасан гэрээ, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг урвуулан ашигласнаар татвар төлөх үүргээс зайлсхийх эсхүл хэт бууруулах боломжгүй”

②-р заалт

Гурвуулан ашигласан тохиолдолд эдийн засгийн нөхцөл байдал, бодит байдалд нийцүүлсэн хуультай адил байдлаар татварыг хураана.](Тайлбар: татвараас зайлсхийх нь тодорхойлогдсон үед хуулийн хэлбэрт оруулж, татвар ногдуулах харилцаа үүсэхийг зааж өгөх.)

⇒ энэ хууль нь 1976 онд хүчингүй болсон ч 6-р зүйлийг Татварын ерөнхий хуулийн (Abgabenordnung) 42-р зүйл (AO42-р зүйл)-д оруулж өгсөн.

23

Герман улсын GAAR-ийн үндэс

- Англи, Америкийн GAAR: Жишээгээр шийтгэх хуулиар тогтоосон, Татвараас зайлсхийхийн эсрэг хандлага
- Франц, Нидерландын GAAR: Хувийн эрх зүйн эрхийг урвуулан ашиглах зарчмыг ашигласан хандлага
- Герман нь эдгээрээс өөр хандлагыг баримталдаг.

Герман улсын GAAR-ийн хөгжлийн үе шат

- ① Татварын хуулийн тайлбарын зарчмыг зааж өгсөн Эдийн засгийн шинжилгээний арга нь 1919 оны Рейхийн татварын ерөнхий хуулийн 4-р зүйлд орсон.
- ② Энэ хуулийн тайлбарын зарчмыг хувийн эрх зүйд жуульд тодорхойлоогүй.
- ③ Эдийн засгийн шинжилгээний арга нь хүчингүй болсон бөгөөд одоо АО 42-р зүйл нь Татвараас зайлсхийхийн эсрэг заалт юм.

24

Германы шүүхийн жишээн дээрх GAAR-ийг ашиглах жишиг: Ажил гүйлгээний үл зохист байдал + татвараас зайлсхийх зорилго бүхий байх

- ① (Ажил гүйлгээний үл зохист байдал: Кодера)
Татвар төлөгчийн сонгосон ажил гүйлгээний хуулийн хэлбэр нь зохистой бус бөгөөд адил нөхцөл байдалд гуравдагч этгээд байсан бол тухайн ажил гүйлгээг хийхгүй байхаар бол энэхүү ажил гүйлгээг зохистой бус гэж үзнэ.
- ② (Татвар ногдуулалтын хувьд давуу харилцаа: Кодера)
Татвар төлөгчийн сонгосон ажил гүйлгээний хэлбэр нь зохистой ажил гүйлгээтэй харьцуулахад татвар ногдуулалтын хувьд давуу байх тохиолдол.
- ③ (Зохистой байдал: Кодера)
Хэлбэрийн сонголтыг зохистой гэж үзэх боломжгүй тохиолдол.
- ④ (Субъектив хүчин зүйлс)
Татвар төлөгчийн субъектив хүчин зүйлийн тухайд, хийх гэж байгаа үйлдэл нь татварын ачааллыг бууруулах зорилготой байх тохиолдол.

25

Германы татварын албаны GAAR ашигласан GL

① (Хуулийн бүтцийг сонгох: Кодера)

Гарах эдийн засгийн үр дүн нь зохистой бус байхаар хуулийн бүтцийг сонгосон.

② (Татварын үр ашиг: Кодера)

Энгийн тохиолдолд олох боломжгүй татварын үр ашгийг асуудалтай тухайн ажил гүйлгээгээр олсон байх.

③ (Татварын үр ашиг 2: Кодера)

Татварын хувьд олсон үр ашиг нь энгийн тохиолдолд олж авах боломжгүй зүйл байх.

④ (Арилжааны зохистой шалтгаан: Кодера)

Татвар төлөгч нь хийгдсэн ажил гүйлгээний талаар арилжаанд хамаарах татвараас гадна бусад үндэслэл шалтгаан байгаагаа нотлон харуулж чадахгүй байх.

26

Герман улс GAAR-ийн шүүхийн жишээ Delaware хэрэг 1

- Холбооны санхүүгийн шүүх (Bundesfinanzhof: BFH) 2002 оны 5 сарын 20 өдрийн шийдвэр

Бодит байдал

- Америкийн групп компанийн удирдлага дор байдаг бие даасан ААН нь Америкийн Delaware мужид Америкийн охин компани байгуулсан.
- Бие даасан ААН нь Америкийн охин компанид хөрөнгө оруулахын тулд Герман улсын банкнаас зээл авсан.
- Бие даасан ААН нь тухайн зээлийн хүүг зардлаас хасдаг байсан.
- Охин компанийн зорилго нь Америкийн компанийн групптэй холбоотой ААН-д туршилтын судалгааны хөрөнгө оруулах юм.
- ААН нь оффис болон утас, факстай бөгөөд нягтлан хийдэг цагийн ажилтантай байсан.

27

Герман улс GAAR-ийн шүүхийн жишээ Delaware хэрэг 2

Германы хуулийн татварын үр ашиг

- ① ААН рүү оруулсан хөрөнгө оруулалтын эх үүсвэр болох зээлийн хүү нь хасагдах зардал болно. (Герман улсын хүүгийн хувь нь Америкийн хүүнээс өндөр учир давуу талтай байсан.)
- ② Германд Ногдол ашигт татвар ногдуулдаггүй.

Ногдол ашгийн хувьд:

Оршин суугч ААН нь өөр оршин суугч ААН-ээс авах ногдол ашигт эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээ, хугацаанаас үл хамааран 2001 оны 1 сарын 1-ээс хойшхи үйл ажиллагааны жилээс эхлэн татвар ногдуулахгүй болсон. Гэвч ногдол ашгийн 5% нь татвар ногдохгүй орлогод хамаарах нууц зардал гэж үзэн зардалд тооцохгүй болсон. Оршин суугч ААН-ийн гадаадын ААН-ээс авч буй ногдол ашгийн хувьд ч оршин суугч ААН-ээс авч буй ногдол ашигтай адил гэж үзэн татвар ногдуулахгүй ч ногдол ашгийн 5%-тай дүйцэх хэмжээний үнийн дүнг хасагдах зардалд тооцдоггүй.

28

Герман улс GAAR-ийн шүүхийн жишээ Delaware хэрэг 3

Холбооны санхүүгийн шүүх (Bundesfinanzhof:BFH) 2002 оны 5 сарын 20 өдөр шүүхийн шийдвэрийн агуулга

Шүүх нь:

- Америкийн охин компани нь бодитой орших ААН гэдэг нь эргэлзээтэй гэж тодорхой дурьдаагүй. ➔Өөрөөр хэлбэл Америкийн охин компани нь бодитой ААН.
- Энэ схем нь урвуулан ашигласан гэдэгт хамаарахгүй.

Энэ схемийн утга

Германы ААН нь Америктай холбоотой компанид шууд хөрөнгө оруулалтын зээл олговол тухайн зээлийн хүү бий болох бөгөөд Германы хуулиар татвар ногдуулах болно. Иймд Америкийн охин компанийг байгуулаад ногдол ашгийн хэлбэрээр хөрөнгөө Герман руу оруулсан.

29

Герман улс 2008 оны GAAR-ийн шинэчлэл

- “Урвуулан ашиглах ухагдахууныг тодорхой болгох”
 - Шинэчилсэн хуулийн 3 онцлог
- ① Татварын зохистой бус төлөвлөлт нь урвуулан ашиглалтыг бий болгоно.
 - ➔ Хуулийн үндэслэлгүй бол татварын зохистой төлөвлөлт болгон залруулга хийж татвар ногдуулах.
 - ② Татвар төлөгч урвуулан ашигласан гэж тодорхойлохын эсрэг тухайлсан төлөвлөлт нь бизнесийн зохистой зорилго бүхий болохыг харуулж эсэргүүцэх боломжтой.
 - ③ GAAR нь тухайлсан заалтыг ашиглахад дэмжлэг болно.
 - ➔ Сонгосон хуулийн оронд зохих хуулийг ашиглахаар тогтож, тэр нь татвар ногдуулалтын суурь болно.

30

Улс орнуудын GAAR-ийн тодорхойлолтын түлхүүр үгс-1

- ЕХ-ны GAAR-ийн түлхүүр үг ➔ Зохицуулалт (arrangement)
- Ирланд ➔ Татвараас зайлсхийх ажил гүйлгээ (tax avoidance transaction)
- Англи ➔ Татварын зохицуулалт (tax arrangement)
- Энэтхэг ➔ зохицуулалт (arrangement)
- Австрали ➔ Схем & Татварын хувьд давуу байдал (scheme & tax benefit)
- Канад ➔ Татвараас зайлсхийх ажил гүйлгээ (avoidance transaction)
- Сингапур ➔ Зохицуулалт (arrangement)

31

Бусад улс орнуудын GAAR-ийн тодорхойлолтын түлхүүр үгс 2

- Шинэ Зеланд ➔ Татвараас зайлсхийх зохион байгуулалттай ажил гүйлгээ (tax avoidance arrangement)
- Хонконг ➔ Ажил гүйлгээ, зохиомол, хуурамч үйлдэл, холбоотой этгээд (transaction, artificial, fictitious, the relevant person)
- Өмнөд Африк ➔ Татвараас зайлсхийсэн, үл зөвшөөрөгдөх ажил гүйлгээ (impermissible tax avoidance transaction)

32

1. Европын Холбооны-ны GAAR-ийн нэр томъёо болон түдгэлзүүлэх нөхцөл

- Нэр томъёо : artificial arrangement
- Нөхцөл : Зохиомол үйлдлийг (artificially) тодорхойлох 5 шалгуур үзүүлэлт

33

2. Англи улсын GAAR-ийн нэр томъёо болон ТҮДГЭЛЗҮҮЛЭХ НӨХЦӨЛ

- Нэр томъёо : tax arrangements abusive (урвуулан ашиглахад чиглэсэн татварын зохицуулалт)
- Нөхцөл : Урвуулан ашиглахыг (abusive) тодорхойлох 3 шалгуур үзүүлэлт
 - ① Татварын зохицуулалтын бодит үр дүн нь татварын хуулийн үзэл баримтлалын зарчимтай нийцэж байгаа эсэх?
 - ② Энэхүү үр дүнд хүрэх процесс нь тодорхой, эсхүл хэвийн бус шат дамжлагыг багтаадаг эсэх?
 - ③ Татварын зохицуулалт нь татварын хуулийн цоорхойг хайх зорилготой хийгдэж байгаа эсэх?

34

3. Хятад улсын GAAR-ийн нэр томъёо болон ТҮДГЭЛЗҮҮЛЭХ НӨХЦӨЛ

- Нэр томъёо : arrangement & business purpose (зохицуулалт&үйл ажиллагааны зорилго)
- Нөхцөл : Тодорхойлох 2 шалгуур үзүүлэлт
 - ① Хэлбэрээс илүү агуулгыг нь анхаарах зарчим (substance over form)
 - ② Эдийн засгийн хувьд зохистой үйл ажиллагааны зорилго (reasonable commercial purpose)

35

МОНГОЛ УЛСЫН GAAR-ийн заалт (Төсөл)

Art.18 General Regulation for Prevention of Tax Evasion/GAAR

18.1 The tax administration shall take appropriate measures against tax evasion through misuse of any tax reduction and exemption policy and the corporate structure misuse of the intergovernmental agreements and reduction of taxable income through relations with any country with lower tax rates than Mongolia.

18.2 The regulation for prevention of tax evasion shall be approved by the Government.

36

★МОНГОЛ УЛСЫН GAAR заалтын асуудалтай тал

Q Хятад улсын GAAR-ийн заалт дээр үндэслэсэн үү?

Q GAAR нь General Anti-Avoidance Rule? Or General Anti-Abusive Rule?

(Англи улсын хэлбэрийн abusive юм уу?)

Q GAAR-ийн чухал түлхүүр үг болох (Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ) орсон байгаа юу?

Q Татвараас зайлсхийх зорилготой гэх түлхүүр үг байхгүй юм уу?

Q Corporate structure гэдэг нь юу вэ?

Q Inter-governmental Agreements гэдэг нь юу вэ ?

Q “any country with lower tax rates” биш улстай ч гэсэн GAAR хэрэглэгдэх юм биш үү?

37

GAAR-ийн талаарх санал Ерөнхий

- Гол улсуудын GAAR-ийн тухай заалт дээр үндэслэж загвар зүйл заалтыг боловсруулах
(Хятад, Хонконг, Англи, Герман, Франц, Америк, Бельги, Австрали гм)
- Нийтлэг эрх зүйн зарчмаас санаа авч ашиглах
- Монгол улсын Иргэний хуулиас санаа авч ашиглах

38

Санал: Хятад улсын GAAR-ийн үндсэн заалтыг НЭМЭХ

Монгол улсын GAAR-ын төсөлд нэмээд Хятад улсын GAAR-ийн үндэс болсон ААНОТ-ын хуулийн 47-р зүйлийн заалттай адил заалтыг Ерөнхий дүрэм гэж оруулж өгвөл сайн байна.

- Хятад улсын ААНОТ-ын хуулийн 47-р зүйл
- “ААН-ын татвар ногдох орлогын хамрах хүрээний тухайд, орлогын үнийн дүн нь тухайн ААН-ын үйл ажиллагааны зохистой зорилго байхгүй ажил гүйлгээнүүдийн (arrangements) үр дүнд буурах тохиолдолд, татварын байгууллагаас зохих арга ашиглан тохируулга хийх эрхтэй”

Хятад улсын журамд заасан доорх үгнүүдээс бас санаа авах боломжтой.

- ① Хэлбэрээс илүү агуулгыг нь анхаарах зарчим (substance over form)
- ② Эдийн засгийн хувьд зохистой үйл ажиллагааны зорилго (reasonable commercial purpose)

39

Кодера-аас өгсөн төслийн 3-н гол асуудал

- ① Хятад улсын ААНОТ-ын хуулийн 47-р зүйлийг загвар GAAR-ийн ерөнхий дүрмийн зүйл заалтад оруулах.
- ② Энэ зүйл заалтад бусад орнуудын GAAR-ийн онцлог, Нийтлэг эрх зүйн зарчим, Монгол улсын Иргэний хуулийн 56-р зүйлийн void transaction (хүчин төгөлдөр бус ажил гүйлгээ)-ний агуулгыг нэмж өгөх.
- ③ Цаашид дагалдан гарах журамд юу оруулах талаар судалж үзэх.
Одооноос бэлдэх.

40

Бусад улсын GAAR-ийн хуулийн чухал асуудлууд (Англи)

- Англи: 2013 оны Санхүү, төсвийн тухай хуулийн 5-р дэд хэсэг (206-р зүйлээс 215-р зүйл) Санхүү, төсвийн тухай хуулийн (206-р зүйлээс 215-р зүйл) Scheerle 43

Түдгэлзүүлэх нөхцөл: Урвуулан ашиглахыг (abusive) тодорхойлох 3 шалгуур үзүүлэлт (←avoidance (зайлсхийх) биш)

- ① Татварын зохицуулалттай ажил гүйлгээний бодит үр дүн нь татварын хуулийн үзэл баримтлалын зарчимтай нийцэж байгаа эсэх?
- ② Энэхүү үр дүнд хүрэх процесс нь тодорхой эсвэл хэвийн бус шат дамжлагыг багтаадаг эсэх?
- ③ Татварын зохицуулалттай ажил гүйлгээ нь татварын хуулийн цоорхойг хайх зорилготой байгаа эсэх?

41

Бусад улсын GAAR-ийн хуулийн чухал асуудлууд (Америк)

Америк: Дотоодын төсвийн тухай хуулийн 7701-р зүйл (o). ESD (Economic Substance Doctrine)

① Тухайн ажил гүйлгээ нь *дотоодын орлогын татвараас гадна бодит талаас татвар төлөх үүрэгтэй этгээдийн* эдийн засгийн нөхцөл байдлыг өөрчилж байх (объектив нөхцөл)

② Татвар төлөх үүрэгтэй этгээд нь тухайн ажил *гүйлгээний хувьд дотоодын орлогын татвараас өөр* бодит зорилготой байх (Субъектив нөхцөл)

42

Бусад улсын GAAR-ийн хуулийн чухал асуудлууд (Герман 1)

Герман: 1919 он Рейхийн Татварын ерөнхий хуулийн 5-р зүйл, 1934 оны Татварт тохируулга хийх тухай хуулийн 6-р зүйл (GAAR)

- “①-р заалт: Иргэний хуульд заасан гэрээ, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг урвуулан ашигласнаар татвар төлөх үүргээс зайлсхийх эсхүл хэт бууруулах боломжгүй.”
- Эдгээр нь одоо хүчингүй болсон.

43

Герман улсын одоо мөрдөгдөж буй GAAR-ийн заалт нь Татварын ерөнхий хуулийн АО (Abgabenordnung) 42-р зүйл (Герман улс 2)

① (Ажил гүйлгээний үл зохист байдал: Кодера)

Татвар төлөгчийн сонгосон ажил гүйлгээний хуулийн хэлбэр нь зохистой бус бөгөөд харилцан хамааралгүй гуравдагч этгээдтэй адил нөхцөл байдалд тухайн ажил гүйлгээг хийхээргүй болох нь тодорхой бол энэхүү ажил гүйлгээг зохистой бус ажил гүйлгээ гэж үзнэ.

② (Татвар ногдуулалтын давуу харилцаа: Кодера)

Татвар төлөгчийн сонгосон хэлбэр нь зохих ёсоор хийгдсэн ажил гүйлгээтэй харьцуулахад татвар ногдуулалт талаасаа давуу бөгөөд ашигтай байх тохиолдол

③ (Зохист байдал: Кодера)

Хэлбэрийн сонголтыг зохистой гэж үзэхээргүй байх тохиолдол

④ (Субъектив хүчин зүйлүүд)

Татвар төлөгчийн үйлдэл нь татварын ачааллаа бууруулах, хөнгөвчлөх зорилготой байх тохиолдол

Бусад улсын GAAR-ийн хуулийн чухал асуудлууд (Бельги)

- Бельги: 2012 он. GAAR-ийн хуулийн шинэчлэл
- Хөрш улс болох Нидерландад батлагдсан хууль бус, шүүхийн шийдвэрийн жишээ дээр гаргасан хуулиар тогтоосон “Эрх урвуулан ашиглах онол”-ыг татвараас зайлсхийхийн эсрэг ашиглаж байгаа хэдий ч Бельги улсын хувьд Хувийн эрх зүйн (Private law) хүрээнд хийгдсэн ажил гүйлгээг хүндэтгэн үзэж Татварын хуулинд ч үүнийг хүлээн зөвшөөрнө гэсэн зарчимтай.
- Бельгийн дээд шүүх нь Эрх урвуулан ашиглах, эдийн засгийн бодит байдлын онолыг хориглосон.
- Шүүх нь ажил гүйлгээг зохиомол (sham transaction) эсэхийг тодорхойлно.
- Татварын байгууллага нь доорх асуудлыг нотолсон бол татвараас зайлсхийсэн гэж үзнэ.

① sham transaction

② Татвар төлөх үүрэгтэй этгээдийн татвараас зайлсхийх үйлдэл, зорилго

Бусад улсын GAAR-ийн хуулийн чухал асуудлууд (Хонконг)

- Хонконг: IRO (Inland Revenue Ordinance) 61-р зүйл (түдгэлзүүлэх ажил гүйлгээ болон арга хэмжээ) 1947 оны заалт
- “Үнэлгээ хариуцсан хүн (assessor) нь татварын ачааллыг бууруулах эсвэл багасгана гэж үзсэн ажил гүйлгээ нь зохиомол (artificial) эсвэл хуурамч (fictitious) байх, эсвэл хөрөнгийн борлуулалт нь бодит байдал дээр хийгдээгүй гэж үзвэл тухайн ажил гүйлгээ эсвэл борлуулалтыг хүлээн зөвшөөрөхгүй байх боломжтой бөгөөд энэ тохиолдолд татвар төлөх үүрэг бүхий этгээд нь нөхөн татвар төлөх болно”

46

Бусад улсын GAAR-ийн хуулийн чухал асуудлууд (Франц)

- Франц, Нидерланд аль аль нь эрхийн хэрэгжилт болон эрхээ урвуулан ашиглах гэсэн Хувийн эрх зүйн зарчмыг ашиглах боломжтой.

Франц: 1941 он

- GAAR Татварын процессын тухай хууль (French code of tax proceedings) 64-р зүйл

① Ажил гүйлгээг *үнэн зөв богон засах боломжтой* бол энэхүү ажил гүйлгээ нь дүр эсгэсэн ажил гүйлгээнд (sham) хамаарна.

② Ажил гүйлгээ нь дүр эсгэсэн биш боловч хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй, татвар төлөх үүрэг бүхий этгээд нь ердийн ажил гүйлгээ байсан тохиолдолд ногдох ёстой байсан татвараас зайлсхийх, эсвэл татвараа бууруулах зорилгоор энэхүү ажил гүйлгээг хийсэн бол энэ нь Эрхээ урвуулан ашиглах (fraus legis)-ийн дагуу хуулийг урвуулан ашиглахад хамаарна

47

Бусад улсын GAAR-ийн хуулийн чухал асуудлууд (Австрали)

- 2013 оны 6 сар Орлогын татвар ногдуулалтын хууль (Income tax Assessment) GAAR-ийн зүйл заалтыг шинэчилсэн
- 177 D-р зүйл: GAAR-ийг ашиглах шаардлага
- ① 177 A-р зүйл: Схем (Зохицуулалттай ажил гүйлгээ (arrangement) гм) байх
- ② 177 C-р зүйл: Схемийг хэрэгжүүлснээр татвар ногдуулах орлого багасч, татварын хасалт хийгдэх тохиолдол байх
- ③ Схем-д оролцогч этгээдийн зорилго нь татварын хувьд давуу байдал эдлэхэд орших.

48

★ Ерөнхий хуулийн татвараас зайлсхийхийн эсрэг зарчим (Англо-Америк хандлага)

- ① business purpose (үйл ажиллагааны зорилго)
- ② step transaction (шаталсан ажил гүйлгээ)
- ③ substance over form (Хэлбэрээс илүү агуулгыг нь анхаарах зарчим)
- ④ sham transaction (дүр эсгэсэн ажил гүйлгээ)
- ⑤ economic substance (эдийн засгийн агуулга)

49

Монгол улсын Иргэний хуулийн 56-р зүйл (Хүчингүй ажил гүйлгээ)

- 56.1 A transaction shall be deemed void if :
- 56.1.2 made fictitiously

Монгол улсын GAAR санаа авах гол асуудлууд

Дээрх судалгааны үр дүнд дараах зүйлсийг Монгол улсын татварын ерөнхий хуулийн 18-р зүйлд оруулах GAAR-ийн ерөнхий дүрмийн гол асуудал гэж үзэв.

- Зориуд хэсэгчилж зохицуулсан ажил гүйлгээ нь Татварын хуулийн цоорхойг хайх зорилготой байх (2013 оноос Санхүү, төсвийн тухай хуулийн 5-р дэд хэсэг) (UK)
- Эдийн засгийн агуулга (ESD: Economic Substance Doctrine) (USA)
- Хятад улсын GAAR-ийн үндсэн зарчим (Эдийн засгийн агуулгын зарчим, Эдийн засгийн хувьд зохистой үйл ажиллагааны зорилго)
- Sham transaction & Эрх урвуулан ашиглах (Франц) (Нийтлэг эрх зүйн зарчим)
- Sham transaction (Бельги) (Нийтлэг эрх зүйн зарчим)
- Fictitious transaction (Хонконг)
- Иргэний хуулийн хэлбэр болон бүрдэх боломжийг урвуулан ашиглах (Хуучин Герман)

Татварын ерөнхий хууль, ААНОАТ-ын хуульд өгөх санал

Кодера Тошинари
2018 оны 8 сарын 27

Өөрчлөгдсөн гол зүйл заалтууд (Хавсралт мат) 1 (Үнэ шилжилтээс бусад)

ТЕХ 15-р зүйл ①-⑨ хэсэг (Татвараас зайлсхийхийн эсрэг арга хэмжээ)

ААНОАТ 4-р зүйл 1.7a-j (Эх үүсвэр)

ААНОАТ 6-р зүйл ①-⑩ хэсэг (Төлөөний газар)

ААНОАТ 14-р зүйл ①-④ хэсэг (Хэт өндөр хүүгийн татварын тогтолцоо)

ААНОАТ 23-р зүйл ①-⑩ хэсэг (Гадаадад төлсөн татварыг хасах)

ХХОАТ 24-р зүйл ①-④ хэсэг (Гадаадад төлсөн татварыг хасах)

ААНОАТ 31-р зүйл ①-⑩ хэсэг (CFC татварын тогтолцоо)

Өөрчлөгдсөн гол зүйл заалтууд (Хавсралт мат) 2 (Үнэ шилжилт)

ТЕХ 6-р зүйл (ТР нэр томъёо)

16-р зүйл (Харилцан тохиролцох журам)

26-р зүйл (Харилцан хамааралтай этгээд)

36-р зүйл (ТР-ийн үндсэн чиглэл)

37-р зүйл (ТР-ийн баримтжуулалт)

38-р зүйл (ТР хяналт шалгалт)

39-р зүйл (ТРМ)

ТЕХ 27-р зүйл (ТР баримтжуулалт : Улс улсаарх тайлан)

GAAR-ийн тодорхойлолт (Татвараас зайлсхийх гол асуудал нь Tax arrangement)

18-р зүйл

(1). Татвараас зайлсхийх үйлдлийн тодорхойлолт

Татвар төлөгч доорх 1 эсхүл 2 үйлдлийг хамтад нь хэрэгжүүлж байвал татварын албаны дарга үүнийг татвараас зайлсхийх үйлдэл гэж үзэн энэ зүйлд үндэслэн татвар ногдуулалтын тохируулгыг хийнэ.

1. Татвар төлөгч нь эдийн засгийн бодит агуулгагүй мөн бизнесийн зорилгогүй татвараас зайлсхийх ажил гүйлгээ явуулж байх.
2. Татвар төлөгч нь тухайн татвараас зайлсхийх ажил гүйлгээнд үндэслэсэн татвараас зайлсхийх схемээр татварын давуу байдал хүртэж байх.

(2). Татвар ногдуулалтын тохируулга

1. Татварын албаны дарга (1)-д заасан татвараас зайлсхийх үйлдэл гэж хүлээн зөвшөөрвөл татвар төлөгчийн тухайн татвараас зайлсхийх замаар татварын хувьд хүртсэн татварын давуу байдлыг түдгэлзүүлэх эрхтэй болно.
2. Татварын албаны дарга дээрх 1-д заасан эрхийн хүрээнд тухайн татвараас зайлсхийх үйлдэлд татвар ногдуулж болно.

GAAR-ийн тодорхойлолт (Татвараас зайлсхийх гол асуудал нь Tax arrangement)

(3) Татвараас зайлсхийх схем

1. Санал нэгдэхийг суурь болгосон
 - Тодорхой эсэх, хууль ёсны үйл ажиллагаа эсэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхээс үл хамааран зохицуулалттай ажил гүйлгээ, хэлцэл, тогтолцоо, ойлголцол, амлалт, үйл ажиллагаа зэргийг хэлнэ.
 2. Төсөөлөлд суурилсан
 - Төлөвлөгөө, санал, **үйл хөдлөл**, аливаа үйлдэл зэргийг хэлнэ.
- (Австралийн ОАТ-ын хуулийн 177А зүйлээс санаа авав.)

(4) Татвараас зайлсхийх үйлдлээр татварын давуу байдал хүртэх

1. Татвараас зайлсхийх схемийг хэрэгжүүлсэнээр татвар ногдох орлого буурсан
 2. Схемийг хэрэгжүүлээгүй байсан бол хүлээн зөвшөөрөх боломжгүй хасалт хийгдсэн
- Жишээ нь: алдагдлыг хойшлуулах, алдагдлыг урагшлуулах (алдагдлыг өмнөх ашигтай ажилласан жилд шилжүүлж, төлсөн ААНОАТ-ын буцаан олголт авах), **гадаад улсад төлсөн татварын хасалт, суутган татвар, татварын чөлөөлөлт зэрэг**
- (Австралийн ОАТ-ын хуулийн 177С зүйлийн 1-р заалтаас санаа авав.)

Татварын ерөнхий хуульд үнэ шилжилтийн татварын тогтолцооны тодорхойлолтыг оруулах

Үнэ шилжилтийн татварын тогтолцоо гэдэг нь,

- Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4-1
- Хуулийн этгээд нь тайлант жилийн хугацаанд тухайн хуулийн этгээдтэй харилцан хамаарал бүхий гадаад улсын хуулийн этгээдтэй хөрөнгө худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх болон бусад ажил гүйлгээ хийсэн бол, энэхүү гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээний тухайд, хуулийн этгээдийн гадаадын харилцан хамаарал бүхий хуулийн этгээдэд төлсөн төлбөр ба хүлээн авсан төлбөрийн дүн нь бие даасан ААН хоорондын үнээс давах, эсвэл дутуу байх тохиолдолд, тухайн хуулийн этгээдийн тайлант жилийн орлоготой холбоотой ААНОАТ хууль ба ААНОАТ-тай холбоотой бусад хууль эрх зүйн заалтуудын тухайд, энэхүү гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээг бие даасан ААН хоорондын үнээр хийгдсэн гэж үзнэ.

Ерөнхий хуулийн татварын хяналт шалгалтын бүлэгт бодит үнэ тооцох аргыг зааж өгөх нь хангалтгүй.

Шалтгаан: Татвар төлөгчид буруу ойлголт өгнө.

Үнэ шилжилттэй холбоотой заалтыг зөвхөн татварын хяналт шалгалтын хэсэгт оруулснаар, татвар төлөгч энэхүү тогтолцоо нь татварын байгууллагад хамаарах асуудал гэж буруу ойлгон, хуулийн хэрэгжилт ба хяналт шалгалт хийхэд саад учруулна.

Үнэ шилжилтийн баримтжуулалтын (documentation) тогтолцоотой холбоотойгоор татвар төлөгч өөрөө харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээнийхээ талаар бодит үнээр хийгдсэн болохыг нотлох үүрэг хүлээх ба энэ тохиолдолд бодит үнэ тодорхойлох арга, үнэ шилжилтийн тогтолцооны асуудал татвар төлөгчид ч маш их хамааралтай юм.

- Татварын ерөнхий хуульд бодит үнэ тодорхойлох аргуудын тодорхойлолт оруулах (TPM: Transfer Pricing Method)

- ★ TPM(Үнэ шилжилтийг (бодит үнэ)тооцох арга)-д дараах тодорхойлолтыг оруулах

- ★ Харьцуулагдах үнийн арга (Харьцуулагдах үнийн арга нь зохих залруулгыг хийсний үндсэн дээр адил төрлийн бараа, ажил, үйлчилгээний зах зээлийн чөлөөт үнэтэй харьцуулалт хийх арга юм)

- ★ Дамжуулан борлуулах үнийн арга (Дамжуулан борлуулах үнийн арга нь борлуулагчаас бие даасан хамааралгүй худалдан авагчдад борлуулсан барааны үнийг (дамжуулан борлуулах үнэ) анхдагч борлуулагчийн ердийн ашгийн нэмэгдлийн дүнгээр бууруулж тооцсон үнийг ашиглах арга юм.

- ★ Өртөг дээр нэмэх арга (бараа үйлчилгээний нийлүүлэгчээс зарцуулсан өртгийн дүнг тооцсоны үндсэн дээр анхдагч нийлүүлэгчийн борлуулалт болон борлуулагчийн худалдан авалтын ердийн ашгийн харьцаанд үндэслэн тооцсон өртгийн нэмэгдлийг нэмж тооцох арга юм)

- ★ ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшин тодорхойлох арга (харилцан хамаарал бүхий гадаад ажил гүйлгээний үнийг харьцуулагдах ажил гүйлгээний цэвэр ашгийн харьцаанд үндэслэн тооцох арга юм)

- ★ Ажил гүйлгээний ашиг хуваах арга (харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хамтран гүйцэтгэсэн ажил гүйлгээний ашгийг тухайн орлого бий болоход гаргасан талууд тус бүрийн зардал гм хүчин зүйлсийг харгалзан хуваах арга юм.)

Үнэ шилжилтийн татварын тогтолцоо : Best method rule

Японы Тусгай арга хэмжээний тухай хууль 66-4-2

- Бие даасан ААН хоорондын үнэ гэдэг нь гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ нь бараа материалаарх хөрөнгийг борлуулах, эсвэл худалдан авах ажил гүйлгээ юу, эсвэл бусад төрлийн ажил гүйлгээ юу гэдгээс хамаарч, дараах аргуудын дотроос, ажил гүйлгээний агуулга, холбогдогч талуудын гүйцэтгэх үүрэг болон бусад нөхцөл байдлыг тооцож, энэхүү ажил гүйлгээ нь бие даасан ААН хооронд энгийн нөхцөлөөр хийгдсэн тохиолдолд төлөгдөх ёстой бодит үнийг тооцоход хамгийн зохистой байх аргыг сонгон тооцсон үнийг хэлнэ.
- CUP арга, RP арга, CP арга, PS арга, TNMM

Үнэ шилжилтийн татварын баримтжуулалтын тогтолцооны талаар Ерөнхий хуульд тусгах

1. Улс улсаарх тайлан

Үндэстэн дамнасан групп компанийн толгой компани болох дотоодын ААН нь тухайн групп компанийн үйл ажиллагаа явуулдаг улс тус бүрээр гаргасан орлого, тайлант хугацааны татварын өмнөх ашиг, төлөх татварын дүн болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан тайланг толгой компанийн тайлант хугацааны эцсийн өдрийн дараагийн өдрөөс тооцон 1 жилийн дотор цахим тайлан (e-tax) хэлбэрээр татварын албаны даргад гарган өгөх үүрэгтэй.

2. Үйл ажиллагааны тайлан

Үндэстэн дамнасан групп компанийн бүтцэд орж буй дотоодын ААН нь тухайн групп компанийн бүтэц, үйл ажиллагааны агуулга, санхүүгийн байдал бусад шаардлагатай мэдээллийг тусгасан тайланг толгой компанийн тайлант хугацааны эцсийн өдрийн дараагийн өдрөөс тооцон 1 жилийн дотор цахим тайлан (e-tax) хэлбэрээр татварын албаны даргад гарган өгөх үүрэгтэй.

Үнэ шилжилтийн татварын баримтжуулалтын тогтолцооны талаар Ерөнхий хуульд тусгах

3. Бодит үнэ тооцоход шаардлагатай бичиг баримт (локал файл)

Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээ хийсэн ААН нь тухайн ажил гүйлгээний бодит үнийг тооцоход шаардлагатай бичиг баримтыг (цахим хэлбэрийг оруулна) татварын тайлан тушаах хугацаа хүртэл бэлтгэсэн байх үүрэгтэй.

Локал файльд тусгах бичиг баримт

- Харилцан хамааралтай этгээдүүдийн чиг үүргийн нарийн шинжилгээ ба хүлээх эрсдэл
- Хамгийн зохистой байх ТРМ ба сонгосон шалтгаан
- Хараат бус ААН-ын харилцан хамаарал бүхий этгээдийн санхүүгийн мэдээлэл
- Зөрүүгийн тохиргоо

Үнэ шилжилтийн нийцүүлэх тохируулга хийх заалтыг шинээр оруулах

(Олон улсын татварын гэрээнд үндэслэн санал нэгдэж залруулга хийх тусгай заалт)

- Сангийн сайд болон тухайн харилцагч улсын эрх бүхий газар, хэлтэс нь олон улсын татварын гэрээний дагуу санал нэгдсэнээр, Монгол улсын ААН-ийн санхүүгийн жилүүдийн орлогын дүнгээс хасалт хийгдсэн тохиолдолд тухайн ААН-ээс ирүүлсэн залруулгын нэхэмжлэлд үндэслэн Татварын албаны дарга нь санал нэгдсэн агуулгын дагуу тооцоолол хийгдэх орлогын дүнд засвар оруулж болно
- Залруулгын нэхэмжлэл: Татвар төлөгч нь орлогын дүнг бууруулах зэргээр төлсөн татвараа буцаан авах талаар улсад хүсэлт гаргах.

Залруулгын нэхэмжлэлийн талаар шинэ заалт оруулах

1. Татварын гэрээнд үндэслэсэн харилцан тохирох журмын үр дүнд эхний тайлангаас өөрөөр санал нэгдсэн бол татвар төлөгч санал нэгдсэн өдрийн дараагийн өдрөөс тооцож 2 сарын дотор залруулгын нэхэмжлэл гаргах боломжтой.
 2. Татвар ногдуулах газар нь харилцан тохирох саналд үндэслэн залруулга оруулах тохиолдолд ердийн залруулга хийх боломжит хугацаанаас урт буюу 5 жил хүртлэх хугацаанд залруулга хийх боломжтой.
- Доогуураа зураастай хэсгийг Монголын тал судлаж байж шийдэх.

Гадаад харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээнд хамаарах татвар төлөлтийн ХӨНГӨЛӨЛТ

- Дотоодын ААН нь татварын гэрээний заалтад үндэслэн ТЕГ-ын даргад хүсэлт гаргасан тохиолдолд Татварын албаны дарга нь, хүсэлтийн дагуу залруулга оруулж төлөхөөр болсон ААНОАТ, Орон нутгийн албан татварын дүн болон торгуулийг татвар төлөгчийн хүсэлт дээр үндэслэн татвар төлөх эцсийн хугацаанаас тооцон, харилцагч улсын эрх бүхий газар, хэлтэстэй санал нэгдсэний дагуу залруулга хийгдсэн өдрийн дараагийн өдрөөс хойш нэг сар хүртэлх хугацаанд (“татвар төлөх хөнгөлөлтийн хугацаа” гэдэг) татвар төлөлтийн хөнгөлөлт үзүүлж болно. Гэвч тухайн хүсэлт гаргасан этгээд улсын татварын өртэй бол энд хамаарахгүй.
- Татварын албаны дарга өмнөх хэсэгт заасан татвар төлөлтийн хөнгөлөлт үзүүлэх тохиолдолд тухайн хөнгөлөлтөд хамаарах үнийн дүнтэй дүйцэх барьцааг гаргуулна.

BEPS-ээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээнд нэгдэх хэрэгтэй.

BEPS-ээс сэргийлэх арга хэмжээ гэж юу болох

1 Албан ёсны нэр

- Албан ёсны нэр: BEPS-ээс урьдчилан сэргийлэхийн тулд татварын гэрээний арга хэмжээг хэрэгжүүлэх олон талт гэрээ
- Англиар: Mutual Convention to implement Tax Treaty Related Measures to prevent BEPS
- Хураангуй: Mutual Instrument (MLI)
- Утга: BEPS үйл ажиллагааны 15 төлөвлөгөөнд үндэслэн батлагдсан олон талт гэрээ
- Зорилго: Улс хоорондын татварын гэрээнүүд өөр хоорондоо харилцан адилгүй, зөрүүтэй байдаг тул бүх татварын гэрээнүүдэд тогтсон нэг түвшинд татвараас зайлсхийхийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд хугацаа ихээхэн шаардагддаг учир зорилгоо хэрэгжүүлэхийн тулд олон талт гэрээнд нэгдэн орох нь тохиромжтой гэж үзсэн.
- 2017 оны 6 сарын 7 өдөр нэгдэн орсон улс (68) хүсэлтээ илэрхийлсэн улс (8)
- Гэрээний бүтэц: 39 зүйл

2 Япон улс нэгдэн орсон (2017 оны 6 сарын 8 өдөр)

ААНОАТ-ын хуульд өгөх санал

ААНОАТ-ын хуульд бодит үнэ тодорхойлох арга ТРМ-ын талаар Ерөнхий хуульд тусгаснаас илүү нарийвчилсан тодорхойлолт оруулах

Харьцуулагдах үнийн арга (CUP арга)

Бараа материалаарх хөрөнгө ба адилтгах хөрөнгийн талаар хийгдсэн гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээний үнийг тогтохдоо, энэхүү гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээний үе шат, тоо хэмжээ болон бусад нөхцөл нь адил байдлаар бие даасан хамааралгүй худалдагч, худалдан авагч хооронд хийгдсэн ажил гүйлгээний (харьцуулах ажил гүйлгээний үе шат, тоо хэмжээ болон бусад нөхцөлийн хувьд ялгаа байгаа бол энэхүү зөрүүний тохиргоог хийсний дараах үнэ) үнээр тооцох арга юм.

Дамжуулан борлуулах үнийг арга (RP арга)

Гадаад харилцан хамааралтай ажил гүйлгээнд хамаарах хөрөнгийн борлуулагчаас бие даасан хамааралгүй худалдан авагчдад борлуулсан барааны үнийг (дамжуулан борлуулах үнэ) анхдагч борлуулагчийн ердийн ашгийн нэмэгдлийн дүнгээр бууруулж тооцсон үнийг ашиглах арга юм.

Өртөг дээр нэмэх арга (CP арга)

Бараа үйлчилгээний нийлүүлэгчээс зарцуулсан өртгийн дүнг тооцсоны үндсэн дээр анхдагч нийлүүлэгчийн борлуулалт болон борлуулагчийн худалдан авалтын ердийн ашгийн харьцаанд үндэслэн тооцсон өртгийн нэмэгдлийг нэмж тооцох арга юм

Ашиг хуваах арга (PS арга)

Ажил гүйлгээний ашиг хуваах арга (харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хамтран гүйцэтгэсэн ажил гүйлгээний ашгийг тухайн орлого бий болоход гаргасан талууд тус бүрийн зардал гм хүчин зүйлсийг харгалзан хуваах арга юм.)

1. Харьцуулагдах ашиг хуваах арга

Гадаад харилцан хамаарал бүхий ажил гүйлгээнд хамаарах бараа материалаарх хөрөнгөтэй адил төрлийн ба төстэй хөрөнгийг бие даасан хамааралгүй этгээд борлуулан олох орлогын (ГХарьцуулагдах ажил гүйлгээ Лгэнэ)хуваарилалтын харьцаагаар ААН ба гадаад хамаарал бүхий этгээдэд хамаарна гэж үзэж тооцох арга

2. Оролцооны түвшнээр ашиг хуваах арга

Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хамтран гүйцэтгэсэн ажил гүйлгээний ашгийг тухайн орлого бий болоход гаргасан талууд тус бүрийн зардал гм хүчин зүйлсийг харгалзан хуваах арга юм

Үнэ шилжилтийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээдийн тодорхойлолтын дутууг гүйцээх

Гадаад харилцан хамаарал бүхий этгээд: Гадаадын хуулийн этгээд бөгөөд тухайн хуулийн этгээдтэй онцгой харилцаа бүхий этгээд

1. Хоёр хуулийн этгээдийн аль нэг нь нөгөөгийнхөө гаргасан хувьцаа, оруулсан хөрөнгийн хэмжээ, үнийн дүнгийн 100-ны 50-аас дээшийг шууд ба шууд бусаар эзэмшдэг байх,
2. Хоёр хуулийн этгээдийн гаргасан хувьцаа, хөрөнгө оруулалтын 100-ны 50-аас дээш тоо хэмжээ, үнийн дүнгээр нэг этгээд шууд ба шууд бусаар эзэмшдэг бол энэхүү хоёр хуулийн этгээд хоорондын харилцаа (эгч дүүгийн харилцаа)

Үнэ шилжилтийн татварын тогтолцооны харилцан хамааралтай этгээдийн тодорхойлолтын дутууг гүйцээх

3. Дараах тохиолдолд, нэг ААН нь нөгөө ААН-ын үйл ажиллагааны чиглэлийг бүрэн ба хэсэгчилэн бодит байдал дээр шийдэх эрх бүхий харилцаа гэж үзнэ (Удирдлагыг хавсран гүйцэтгэх, үйл ажиллагаа, хөрөнгийн нэлээд хамааралтай гэх мэт (Бодит хяналтын харилцаа))
- Нэг хуулийн этгээд нь нөгөө хуулийн этгээдийн 2-ны 1, эсхүл хоёр хуулийн этгээдийн удирдлагыг нэг этгээд хавсран гүйцэтгэдэг, эсхүл аль нэг хуулийн этгээдийн удирдлага, ажилтан байсан этгээд байх.
 - Хуулийн этгээдийн үйл ажиллагааны ихэнх хэсэг нь нөгөө хуулийн этгээдтэй хийх ажил гүйлгээнээс хамааралтай байх.
 - Хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн ихэнхийг нөгөө хуулийн этгээдээс зээлж, эсхүл энэхүү хуулийн этгээдээс баталгаа гаргуулан олж авсан байх

Өндөр хүүгийн татварын тогтолцоо ба нимгэн капиталын татварын тогтолцоог зэрэгцүүлэн үлдээх нь зүйтэй.

Өндөр хүүгийн тогтолцоог шинээр оруулсныг өндрөөр үнэлж байна. Одоогийн нимгэн капиталын татварын тогтолцоог ч бас авч үлдэх шаардлагатай.

- Япон Улсын татварын тогтолцоонд нимгэн капиталын татварын тогтолцоо ба өндөр хүүгийн татварын тогтолцоог зэрэгцүүлэн хэрэгжүүлдэг. Учир нь аль аль нь хүүгийн төлбөрийг зардалд тусгахад хязгаарлалт хийдэг заалт боловч, хязгаарлалт хийх шалгуур, жишиг, хөрөнгө ба орлого гэсэн ялгаатай хүчин зүйлсийг заадаг тул энэхүү 2 аргыг зэрэгцүүлэн хэрэглэх нь онолын хувьд давуу талтай. Японд нимгэн капиталын хүрээнд татвар ногдуулах боломжгүй тохиолдолд, өндөр хүүгийн татварын тогтолцоог ашиглан ногдуулалт хийх тогтолцоог бүрдүүлсэн байдаг. Эсрэгээр нь ашиглах бас боломжтой.
- Германд зөвхөн өндөр хүүгийн татварын тогтолцоотой, Францад зөвхөн нимгэн капиталын татварын тогтолцоо ба тэнцвэргүй. АНУ-д хөрөнгө, өр төлбөрийн харьцаа 1.5:1 бол өндөр хүүгийн татварын тогтолцоонд хамруулдаггүй.

Гадаад улсад ногдуулан төлсөн татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох тогтолцооны хүрээнд заасан хязгаараас давсан болон зөрүүтэй үнийн дүнг хойшлуулан тооцохыг хүлээн зөвшөөрөхгүй бол давхар татвар ногдуулалт шийдвэрлэгдэхгүй.

Хасалтын хязгаарт хүрээгүй дүн: Тайлант хугацаанд хасалтад хамаарах гадаад улсын аж ахуйн нэгжийн орлогын татварын хэмжээ нь тухайн жилийн хасалтын хязгаарт хүрэхгүй байгаа тохиолдолд, энэхүү зөрүүний үнийн дүнг хэлнэ.

Хасалтын хязгаарыг давсан үнийн дүн: Тайлант хугацаанд хасалтад хамаарах гадаад улсын аж ахуйн нэгжийн орлогын татварын хэмжээ нь тухайн жилийн хасалтын хязгаарын нийт дүнгээс давсан тохиолдолд, энэхүү давсан үнийн дүнг хэлнэ.

Дээрх тохиолдлуудад, 3 жилээр хойшлуулан тооцохыг зөвшөөрдөг.

Дотоодын хуулийн этгээдийн үйл ажиллагааны жилдээ төлсөн гадаад улсын татварын үнийн дүнг:

1. Эхлээд тухайн жилийн дотоодод төлөх ёстой ААНОАТ-аас хасалт хийнэ.
2. Ингээд хасалт хийх боломжгүй бол орон нутгийн татвараас хасалт хийнэ.
3. Ингээд ч хасалт хийх боломжгүй бол дараах арга хэмжээг авдаг:
 - Тухайн тайлант жилээс өмнөх 3 жилийн хугацаанд 「Хасалтын хязгаарт хүрэхгүй үнийн дүн」байгаа бол, хойшлуулан тооцох үнийн дүнгээр хязгаарлан, хамгийн хуучин тайлант жилээс дэс дараалан хасалт хийнэ.
 - Мөн, тухайн тайлант жилд 「Татварын хасалтын хязгаарт хүрэхгүй үнийн дүн」үүссэн бол, тухайн жилээс өмнөх 3 жилийн доторх тайлант жилд үүссэн 「Хасалтын хязгаарлалтаас давсан дүн」-гээс хойшлуулсан гадаад улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дотроос, тухайн жилд хойшлуулсан дүн байгаа тохиолдолд, энэ дүнгээс эхлэн зөрүүг тооцож, энэхүү зөрүүгээр хязгаарлан, хамгийн хуучин тайлант жилээс дэс дараалан хасалт хийнэ.

Татварын диваажингийн талаарх заалтыг шинээр оруулах шаардлагатай.

2017 онд Японы татварын хуульд өөрчлөлт оруулсан.

1. Татвар төлөх үүрэгтэн ба гадаадын хамаарал бүхий ААН

Гадаадын хамаарал бүхий ААН-ын хувьцааны 10-аас дээш хувийг шууд ба шууд бус байдлаар эзэмшдэг, эсхүл бодит хяналтад байгаа тохиолдолд татварын диваажингийн тогтолцоонд хамруулж үздэг.

Энд гадаадын хамаарал бүхий ААН гэдэгт гадаадын ААН-ын гаргасан нийт хувьцааны 50-аас дээш хувийг дотоодын хуулийн этгээд эзэмшдэг, эсхүл бодит хяналтад байгаа ААН-ыг ойлгоно.

Татварын диваажингийн талаарх заалтыг шинээр оруулах шаардлагатай.

2. Тухайлсан гадаадын охин компани (татварын ачааллын хувиас хамааруулан чөлөөлөх)

Гадаадын хамаарал бүхий ААН-д тухайлсан хамаарал бүхий гадаадын ААН гэсэн ангилал байдаг ба энд цаасан компани орно. Энэ тухайлсан гадаад хамаарал бүхий ААН-ын тухайд, нэгдсэн татвар ногдуулалтад хамруулах ба татварын ачааллын хувь хэмжээ нь 30-аас дээш хувьтай бол нэгдсэн татвар ногдуулалт хийхгүй.

3. Эдийн засгийн үйл ажиллагааны шалгуур ба хамрагдах гадаад хамаарал бүхий компани (татварын ачааллын хувиас хамааруулан чөлөөлөх)

Тухайлсан гадаад хамаарал бүхий ААН-ын тухайд, эдийн засгийн үйл ажиллагааны шалгуурт нийцээгүй тохиолдолд, нэгдсэн татвар ногдуулалтад хамруулна.

★Эдийн засгийн үйл ажиллагааны шалгуур: Охин компани тухайн улсад үйл ажиллагаа эрхлэх нь эдийн засгийн үндэслэлтэй эсэхийг тодорхойлно.

4. Эдийн засгийн үйл ажиллагааны шалгуурт нийцэж байсан ч, ноогдол ашиг, хүү зэрэг орлого нь нэгдсэн татвар ногдуулалтад хамрагдана.

Гадаадын хуулийн этгээдийн дотоод эх үүсвэртэй орлогын заалтыг цэгцлэх.

Япон Улсын ААНОАТ-ын дотоод эх үүсвэртэй орлогын дүрэм:

1. РЕ-д хамаатуулах орлого
2. РЕ-д хамаарахгүй орлого
 - Дотоодод байх хөрөнгийн ашиглалт, эзэмшихтэй холбоотой орлого: Хүү, ноогдол, ашиглалтын хураамж гэх мэт ➔ Зөвхөн суутган татвар хураана (ААНОАТ-т хамаарахгүй)
 - Дотоодод байх хөрөнгийг шилжүүлсний орлого: ҮХХ-ийг шилжүүлэх, дотоодын хуулийн этгээдийн гаргасан хувьцааг шилжүүлсний орлого ➔ ААНОАТ ногдуулна
 - Дотоодод хүний үзүүлэх үйлчилгээний орлого: Киноны жүжигчин, өмгөөлөгч, шинжлэх ухааны ажилтны үзүүлэх үйлчилгээ ➔ ААНОАТ ногдуулна
 - Дотоодын ҮХХ-ийн түрээсийн орлого: Олборлох эрхийн түрээс, ашигт малтмалын хуулийн заалтын дагуух эрхэд хийх төлбөр ➔ ААНОАТ ногдуулна
 - Бусад дотоод эх үүсвэртэй орлого: Дотоод үйл ажиллагаанд авах даатгалын мөнгө, тэтгэмж, хөрөнгийн бэлэглэлээс олох орлого, нөхөн төлбөрийн орлого ➔ ААНОАТ ногдуулна”

Гадаадын хуулийн этгээдийн дотоод эх үүсвэртэй орлогын заалтыг цэгцлэх

Орлогын татварын суутган тооцохын тухайд,
Төлөөний газартай эсэхээс үл хамаарч,

ААНОАТ-ын хуулийн төлөөний газарт хамаатуулах орлого, хамаатуулахгүй орлогын ангилалаас үл хамаарч,

Орлогын татварын хуулийн дотоод эх үүсвэртэй орлогын тодорхойлолтод нийцэх тохиолдолд, суутган татвар тооцно.

Японы дотоод эх үүсвэртэй орлогын заалт

- 3-р бүлэг Гадаадын хуулийн этгээдийн ААНОАТ, 1-р бүлэг Дотоод эх үүсвэртэй орлого, 138-1 заалт
- 1 дугаар: Гадаадын хуулийн этгээд нь төлөөний газраар дамжуулан үйл ажиллагаа явуулсан тохиолдолд, тухайн төлөөний газар нь тухайн гадаадын хуулийн этгээдээс хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулдаг бол, төлөөний газрын хүлээж буй үүрэг, хэрэглэж буй хөрөнгө, төлөөний газар ба гадаадын хуулийн этгээдийн төв байгууллага хоорондын дотоод ажил гүйлгээ болон бусад нөхцөл байдлыг тооцож, тухайн төлөөний газарт хамаатуулах орлого.
- ★Ийм байдлаар, 「Төлөөний газарт хамаарах орлого」 -ыг гадаадын хуулийн этгээдийн хамгийн эхний 「Дотоод эх үүсвэртэй орлого」 хэмээн Монгол Улсын хуульд тусгах нь зүйтэй. Гадаадын хуулийн этгээдийн 「Дотоод эх үүсвэртэй орлого」 -ын талаар заах тул 「Төлөөний газаргүй бол татвар ногдохгүй」 гэсэн OECD загвар гэрээний 7-1-ийн зарчим, 「АОАзарчим」 -ын мөн зүйлийн 2-ын зарчимд нийцүүлэх талаасаа ч Японы 138-1 зүйлтэй адил “Дотоод эх үүсвэртэй орлогын талаарх ерөнхий зарчмын заалтыг оруулах шаардлагатай.”

- 2 дугаар: Дотоодод байх хөрөнгийг ашиглах, эзэмшихтэй холбоотой олох орлого
- 3 дугаар: Дотоодод байх хөрөнгийг шилжүүлэхтэй холбоотой олох орлого хэмээн хуулиар заасан орлого
- 4 дугаар: Хуулиар заасан хүний үзүүлэх үйлчилгээг голлон эрхэлдэг хуулийн этгээдийн тухайн үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой төлбөр
- 5 дугаар: Дотоодод байгаа ҮХХ, дотоодод байх ҮХХ-д хамаарах эрх, чулуу олборлох тухай хуулийн заалтын дагуу олборлох эрхийг ашиглуулах, Уул уурхайн хуулийн заалтын дагуу олгогдох эрх
- 6 дугаарт: Дээрх дугааруудад зааснаас бусад, эх үүсвэр нь дотоодод байх орлого хэмээн хуулиар заасан зүйлс

★ Японы ААНОАТ-ын хуульд, дээрх 6 төрлийн дотоод эх үүсвэртэй орлогыг заахын хамт, нарийвчилсан асуудлуудыг дагалдах журмуудад заасан байдаг. Дээрх 1 дугаарын хувьд, төлөөний газарт хамаарах орлого, 2-6-ын хувьд төлөөний газарт хамаарахгүй орлого юм.

Төлөөлөгч төлөөний газрын талаар заалт оруулах

Японы ААНОАТ хуулийн 2-р зүйл (Тодорхойлолт)

2-р зүйл (Гадаадын хуулийн этгээд): Дотоодын хуулийн этгээдээс бусад хуулийн этгээдийг хэлнэ.

2-р зүйлийн 12-18 (Төлөөний газар: PE)

- Гадаадын хуулийн этгээдийн дотоодод байх салбар, үйлдвэр, бусад үйл ажиллагаа явуулах тогтсон байршил бөгөөд хууль тогтоомжид заасан зүйлс
- Гадаадын хуулийн этгээдийн дотоодод байх барилгын талбай (Гадаадын хуулийн этгээд дотоодод барилгын үйл ажиллагаа (Барилга, угсралт, бусад үйл ажиллагаа, эсхүл энэхүү үйл ажиллагааг удирдах, зааварчилах зэрэг үйлчилгээг нэгээс дээш жилээр эрхэлснийг хэлнэ)эрхлэх газрыг хэлэх ба тухайн гадаадын хуулийн этгээдийн дотоодод байх энэ барилгын үйл ажиллагааг оруулах)
- Гадаадын хуулийн этгээдийг дотоодод төлөөлөн гэрээ хийх эрх бүхий этгээд болон бусад хуулиар заасан дүйцэх этгээд (энэ заалт нь Монголын хуулийн хүрээнд ААНОАТ-ын хуулийн 63-р зүйлд бага зэрэг тусгагдсан байгаа боловч, 「Төлөөлөгч төлөөний газар」 гэж нэрлэгддэг чухал ухагдахуун болох тул нарийвчилан тусгах шаардлагатай. Энэ заалт байхгүй бол төлөөний газарт хийх хяналт шалгалт хуулийн хувьд бүрэн хийгдэх боломжгүй болно.

Төлөөлөгч төлөөний газрын талаар

★Төлөөлөгч төлөөний газар нь иргэн ба хуулийн этгээд байх тохиолдол байх ба гадаадын хуулийн этгээдээс бизнесийн үйл ажиллагааны зааварчилгаа авдаг иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсад ашиг олсон бол энэхүү орлого нь дотоод эх үүсвэртэй орлого гэж үзэн, Монгол улс гадаадын хуулийн этгээдэд ААНОАТ ногдуулах боломжтой болох тогтолцоо юм. OECD загвар гэрээний 5-5-5,6 зүйлд заасан байдаг.

★Гадаадын хуулийн этгээдээс хамааралтайгаар бизнесийн үйл ажиллагааны зааварчилгаа авдаг төлөөлөгчийг «хамааралтай төлөөлөгч» гэдэг ба төлөөний газрын татвар ногдуулалт хийгдэх ба тухайлсан гадаад хуулийн этгээдээс зааварчилгаа авдаггүй төлөөлөгчийг «Бие даасан төлөөлөгч» гэх ба төлөөний газрын татвар ногдуулалт хийхгүй.

★Төлөөний газар нь дээрх тодорхойлолтоос «Гадаад хуулийн этгээд» -ийн «Төлөөний газар» юм. Гэхдээ, дотоодын хуулийн этгээд гадаадад төлөөний газартай байдаг ба нарийвчилсан асуудлуудыг дагалдах журамд тусгадаг.

- (Жич)
- OECD загвар гэрээний 5-р зүйл (PE)
- 5-р зүйлийн 5 (Хамааралтай төлөөлөгчийн заалт)
- «...ААН-ыг төлөөлж үйл ажиллагаа эрхлэх этгээд нь татварын гэрээтэй улсад, тухайн ААН-ын нэр дээр гэрээ хэлцэл хийх эрхтэй бөгөөд энэхүү эрхээ давтамжтайгаар хэрэгжүүлдэг тохиолдолд, энэхүү ААН-ыг татварын гэрээт улсад тухайн ААН-ыг төлөөлөн гүйцэтгэж буй энэ этгээдийн бүхий л үйл ажиллагааны хүрээнд төлөөний газартай гэж үзнэ.....»]

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

**Татварын өр барагдуулах, шаардахтай
холбоотой судалгааны тайлан**

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

Хураалт хариуцсан мэргэжилтэн

Косака Мицүрү

Күмакүра Шигэо

2017.12.15

**ТАТВАРЫН ӨР БА ӨР БАРАГДУУЛАЛТЫН НӨХЦӨЛ
БАЙДЛЫН ТАЛААР**

1. Татварын өр барагдуулалтын өнөөгийн байдал

1.1 Татварын өр барагдуулалтын үндсэн ухагдахуун

Татварын өр гэдэг нь хуулийн хугацаанд төлөгдөөгүй бөгөөд шаардах хуудас (Татвар төлөх мэдэгдэл) хүргэгдсэн татварыг хэлэх бөгөөд татварын өртэй татвар төлөгчийг “Татварын өртэй этгээд” хэмээн нэрлэдэг. Татварын өр үүсэх шалтгааны тухайд, тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал болон татвар төлөгчийн мөнгө санхүүгийн байдал зэрэг олон зүйлээс шалтгаалдаг тул татварын байгууллага нь татварын өртэй этгээдийн бизнесийн үйл ажиллагаа, амьжиргааны байдал, хөрөнгийн эзэмшил зэрэг бодит байдлыг зөв тодорхойлсны үндсэн дээр хуульд нийцүүлэн зохих арга хэмжээг авах шаардлагатай болдог.

Хуулийн хэрэгжилтийг тэгш шударгаар, үр өгөөжтэйгээр хангаж ажиллахын тулд зөвхөн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь хангалттай бус бөгөөд хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай юм. Бодит байдал дээр хязгаарлагдмал боловсон хүчний болон санхүүгийн нөөцийн хүрээнд татварын өр барагдуулалтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд үнийн дүн өндөртэй, санаатай болон бусад хуримтлагдсан, насжилт ихтэй яаралтай арга хэмжээ авах шаардлагатай татварын өрүүдийн тухайд, хэрэгжилтийн хяналтыг чангатган, татварын өр үүссэн шалтгааныг тодруулах, өр барагдуулалтын чиглэлийг тодорхойлоход чиглэгдсэн судалгаа шалгалтыг гүнзгий хийж, ажлын ачааллыг зорилготойгоор чиглүүлэн ажиллах шаардлагатай.

Нөгөө талаас, бага үнийн дүнтэй, шинээр үүссэн татварын өрийн тухайд, ажлын ачааллын хуваарилалтыг зохистой хийн, бага хүн хүчээр үр бүтээлтэй ажиллах (аль болох олон татварын өртэй этгээдтэй харьцаж, татвар төлүүлэх) шаардлага тулгардаг. Ийм байдлаар, шинээр үүссэн татварын өр ба хуучин хуримтлагдсан өр барагдуулалтын ажлын тэнцвэртэй байдлыг хангах, үнийн дүн өндөртэй болон багатай татварын өрийн тэнцвэртэй байдал, татварын төрөл тус бүрээрх тэнцвэртэй байдал, татварын алба ба ТЕГ-ын удирдлага арга зүйгээр хангах асуудлын тэнцвэртэй байдлыг тооцон, олон төрлийн зорилтыг нэгэн зэрэг хангахад чиглэсэн жигд ажлын ачааллын хуваарилалт чухлаар тавигддаг.

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

1.2 Монгол улсын татварын өрийн нөхцөл байдал

2014, 2015, 2016 оны 3 жилийн хугацаанд татварын өрийн үлдэгдлийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

(Татварын өрийн нөхцөл байдал)

(нэгж : % 1 тэрбум төгрөг)

	2014 он	2015 он	2016 он
A Шинээр үүссэн ногдлын дүн	2,229.8	(108.2) 2,412.0	(89.1) 2,148.5
B Шинээр үүссэн татварын өр	226.4	(153.4) 347.3	(71.6) 248.6
(B÷A) Өр үүсэлтийн хувь	10.2	14.4	11.6
C Өмнөх оны хойшлогдсон үнийн дүн	611.4	(137.7) 841.9	(82.6) 695.0
D(B + C) Барагдуулбал зохих өрийн дүн	837.8	(141.9) 1,189.2	(79.3) 943.6
E Барагдуулсан өр	399.2	(123.8) 494.2	(69.1) 341.3
(E÷D) Өрийн барагдуулалтын хувь	47.6	41.6	36.2
F Тайлант оны хойшлогдсон дүн (Өрийн үлдэгдэл)	438.6	(158.5) 695.0	(86.7) 602.3

【Тайлбар】

(1) Шинээр үүссэн ногдлын дүн

Ойрын 3 жилийн татвар хураахаар тогтсон ногдлын дүнгийн тухайд, 2014 онд 2,229.8 тэрбум төгрөг, 2015 онд 2,4120 тэрбум төгрөг (өмнөх онтой харьцуулаад 108.2%), 2016 онд 2,1485 тэрбум төгрөг (өмнөх онтой харьцуулаад 89.1%) болж, сүүлийн жилийн хувьд буурсан үзүүлэлттэй байна.

(2) Шинээр үүссэн болон барагдуулбал зохих өрийн дүн

Ойрын 3 жилийн шинээр үүссэн болон барагдуулбал зохих өрийн дүнгийн тухайд, 2014 онд 2,264 тэрбум төгрөг, 2015 онд 3,473 тэрбум төгрөг (өмнөх онтой харьцуулаад 153.4%), 2016 онд 2,486 тэрбум төгрөг (өмнөх онтой харьцуулаад 71.6%) болж, сүүлийн жилийн хувьд ойролцоогоор 30%-аар буурсан үзүүлэлттэй байна. Мөн шинээр үүссэн болон өмнөх оны хойшлогдсон

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

дүнгийн нийлбэрээр тооцогдох барагдуулбал зохих татварын өрийн дүнгийн тухайд, 2014 онд 837.8 тэрбум төгрөг, 2015 онд 1 их наяд 189.2 тэрбум төгрөг (өмнөх жилтэй харьцуулаад 141.9%), 2016 онд 943.6 тэрбум төгрөг (өмнөх жилтэй харьцуулаад 79.3%) болсон байна.

(3) Барагдуулсан өр ба татварын өрийн үлдэгдэл

Ойрын 3 жилийн барагдуулсан татварын өрийн үнийн дүн нь 2014 онд 399.2 тэрбум төгрөг, 2015 онд 494.2 тэрбум төгрөг (өмнөх жилтэй харьцуулаад 123.8%), 2016 онд 341.3 тэрбум төгрөг (өмнөх жилтэй харьцуулаад 69.1%) болсон ба 2015 оны хувьд татварын барагдуулалт сайн хийгдсэн боловч, 2016 оны тухайд 30%-аар буурсан үзүүлэлттэй байна. Мөн, татварын өрийн үлдэгдлийн тухайд, 2014 онд 438.6 тэрбум төгрөг, 2015 онд 695.0 тэрбум төгрөг (өмнөх жилтэй харьцуулаад 158.5%), 2016 онд 602.3 тэрбум төгрөг (өмнөх жилтэй харьцуулаад 86.7%) болсон байна.

(4) Дүгнэлт

Татвар хураах ногдлын дүн, шинээр үүссэн татварын өрийн дүн, барагдуулбал зохих татварын өр, барагдуулсан татварын өр болон татварын өрийн үлдэгдлийн үзүүлэлтүүдээс харахад, өмнөх жилийнхээ үзүүлэлттэй харьцуулаад 30%-50%-аар өссөн 2015 оны үзүүлэлттэй харьцуулахад 2016 онд 20%-30%-аар буурч татварын өрийн хэмжээ буурсан байна. 2016 оны байдлаар татварын өрийн үлдэгдэл буурсан боловч, барагдуулсан татварын өрийн дүн нь өмнөх жилтэй харьцуулаад 30% буюу 150 тэрбум төгрөгөөр буурсан байгаа нь татварын өр хуримтлагдах хандлага байгааг илэрхийлж байгаа тул цаашид өр барагдуулалтын хэрэгжилтийн бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн орчны сайжруулалтаар дамжуулан тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

(2) Татварын өрийн дүнгийн байдал (шатлалаар)

<2016 оны татварын өрийн байдлын шатлал >

(нэгж: ТТ тоо, сая төгрөг, %)

	Аймгийн хэмжээнд		Нийслэлийн хэмжээнд (1хог 9 дүүрэг)		УТОХГ		Нийлбэр			
	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Харьцуулалт	Татварын өрийн дүн	Харьцуулалт
	1-999,999	64,290	5,024	65,511	9,716	23	5	129,824	83.9	14,746
1,000,000-2,999,999 төг	2,191	3,760	7,848	13,927	12	25	10,051	6.5	17,712	1.6
3,000,000-9,999,999 төг	1,353	7,423	6,214	34,492	24	158	7,591	4.9	42,074	3.9
10,000,000-49,999,999 төг	758	16,527	4,490	96,683	59	1,622	5,307	3.4	114,832	10.6
50 саяас 99,999,999 төг	132	8,917	793	55,482	44	3,256	969	0.6	67,655	6.2
100 саяас дээш өргэй ТТ	119	57,264	735	276,164	161	497,458	1,015	0.7	830,885	76.3
Нийт дүн	68,843	98,915	85,591	486,464	323	502,525	154,757	100.0	1,087,904	100.0

【Тайлбар】

(Эх үүсвэр: ТЕГ)

Татварын өрийн дүн 999,999 төгрөгөөс бага татвар төлөгчид нийт өргэй татвар төлөгчдийн 83.9%-ийг эзэлж, аймаг ба хотын татварын албад тус бүр тал үнийн дүнгээр хамаарч байгаа боловч, үнийн дүнгийн эзлэх хэмжээ дөнгөж 1.4% байна. Нөгөө талаас, 100 саяас дээш өргэй ТТ-ийн тоо нийт өргэй татвар төлөгчийн 0.7% эзэлж байгаа боловч, үнийн дүнгээр 76.3%-ийг эзэлж байгаа бөгөөд үүний дотроос 60% нь УТОХГ-т хамаарч байна.

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

(3) Татварын өрийн нөхцөл байдал (татварын төрлөөр)

< 2016 оны байдлаарх улсын болон орон нутгийн татварын өрийн байдал >

(2016.12.31-ний байдлаар)

(нэгж : сая төгрөг %)

Ангилал	Хойшлогдсон		Тайлант он		Нийт дүн			
	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Хувь	Өрийн дүн	Хувь
(Улсын татвар)								
ААНОАТ	12,561	43,441	26,433	281,919	38,994	62.8	325,360	39.9
НӨАТ	9,164	161,529	13,568	195,638	22,732	36.6	357,167	43.8
Онцгой татвар(тамхи, согтууруулах ундаа)	33	2,471	41	15,168	74	0.2	17,666	2.2
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	100	44,515	127	55,808	227	0.3	100.357	12.2
Бусад	24	15,726	0	0	24	0.1	15.726	1.9
Нийт дүн					62,051	100.0	816,276	100.0
(Орон нутгийн татвар)								
ХХОАТ	14,011	24,515	28,960	62,937	37,954	38.3	87,450	75.9
(Суутган)	(11,040)	(24,360)	(28,949)	(62,930)	(34,982)		(87,290)	
Орлогыг тодорхойлох боломжгүй иргэдийн орлого	282	8	3	0	285	0.3	8	0
ҮХХ-ийн татвар	7,303	6,769	9,102	11,904	12,229	12.3	18,673	16.2
Улсын тэмдэгтийн хураамж	20	323	102	1,003	114	0.1	1,326	1.2
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	48	1,300	105	478	139	0.1	1,777	1.5
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар	9,631	1,520	32,284	4,395	38,914	39.2	5,915	5.1
Газрын ҮХХ-ийн татвар	6,680	17	4,201	2	9,578	9.7	20	0.1
Нийт дүн					99,213	100.0	115,169	100.0
(жич) торгууль, алдангийг тооцоогүй.								

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

(Анхаарах)

Улсын татвар, орон нутгийн татварын нийт дүнд хамаарах татварын өртэй этгээдийн тооны тухайд, давхардсан тоогоор илэрхийлсэн. (Нэг ижил татварын өртэй этгээд нь хойшлогдсон татварын өр, ногдуулсан татварын өрийн аль алинд хамаарах, эсвэл хэд хэдэн төрлийн татварын өртэй байх тохиолдол байдаг тул.)

【Тайлбар】

Татварын төрөл тус бүрээр татварын өрийг харвал, улсын татварын хувьд, ААНОАТ (62.8%), НӨАТ(36.6%)-ийн татварын өртэй этгээд ихэнх хувийг эзэлж (нийт татварын өртэй этгээдийн 99%), үнийн дүнгээр ч энэхүү татварын төрлүүд нь нийт өрийн 83%-ийг эзэлж байна. Орон нутгийн татварын тухайд, суутган татварыг оруулаад ХХОАТ-ын тухайд, татварын өртэй этгээдийн тоо (38.3%) болон үнийн дүнгээр (75.9%) хамгийн өндөр байгаа ба автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татварын өртэй этгээдийн тоо ч (39.2%) нэлээд өндөр байна.

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

(5) Тагварын өр, дууу үлдэгдлийн насжилтын байдал
 < Тагварын өрийн насжилтын байдал (2017.8.1-ний байдлаар) >

2017.08.01-ний өдрийн байдлаар	Үзүүлэлт	Татварын өр, дууу үлдэгдлийн насжилтын мэдээ										УЛОХ			Нийслэлийн дүн			Татварын өр, дууу үлдэгдэл, тайлангийн төрөл			Аймгийн дүн			Мянган төгрөг							
		Татварын өр, дууу үлдэгдэл, тайлангийн төрөл		Нийт		Эзлэх хувийн		Татварын өр, дууу үлдэгдэл, тайлангийн төрөл		ХШ		ХШ		Татварын өр, дууу үлдэгдэл, тайлангийн төрөл		ХШ		ХШ		Татварын өр, дууу үлдэгдэл, тайлангийн төрөл		ХШ		ХШ		Татварын өр, дууу үлдэгдэл, тайлангийн төрөл		ХШ		ХШ	
		Тайлан	ХШ	Бүгд	ХШ	Бүгд	жин	Тайлан	ХШ	Бүгд	ХШ	Бүгд	Тайлан	ХШ	Бүгд	Тайлан	ХШ	Бүгд	Тайлан	ХШ	Бүгд	Тайлан	ХШ	Бүгд	Тайлан	ХШ	Бүгд	Тайлан	ХШ	Бүгд	
2017	Татварын өр, дууу үлдэгдлийн нийт дүн	126,619	6,767	123,123	100.0	301	79	238	73,738	4,642	74,365	52,580	2,036	55,520	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6		
	Дүн	826,194,937.1	139,820,399.2	966,015,336.2	100.0	315,468,952.7	52,656,283.0	368,125,235.7	421,438,681.2	79,562,334.8	501,021,016.0	89,287,303.2	2,036	55,520	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6		
	ас	826,194,937.1	90,313,785.8	916,508,722.9	94.9	315,468,952.7	34,487,748.1	349,956,700.7	421,438,681.2	51,485,634.2	472,924,315.4	89,287,303.2	2,036	55,520	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6	89,287,303.2	7,561,761.4	96,849,064.6		
2018	Татвар төлөгчийн төс	49,586	1,489	50,864	39.7	202	46	112	27,189	687	27,876	22,195	756	23,200	22,195	756	23,200	22,195	756	23,200	22,195	756	23,200	22,195	756	23,200	22,195	756	23,200		
	Дүн	424,298,138.5	59,231,796.5	483,529,935.1	50.1	233,276,374.3	38,272,237.8	271,548,612.1	154,832,686.2	18,536,719.9	173,369,406.1	36,189,078.0	2,422	838.8	38,611,916.8	36,189,078.0	2,422	838.8	38,611,916.8	36,189,078.0	2,422	838.8	38,611,916.8	36,189,078.0	2,422	838.8	38,611,916.8	36,189,078.0	2,422	838.8	
	ас	424,298,138.5	39,011,020.9	463,309,159.4	50.6	233,276,374.3	24,001,943.7	257,278,318.0	154,832,686.2	14,153,648.2	168,986,334.4	36,189,078.0	2,422	838.8	37,044,507.0	36,189,078.0	2,422	838.8	37,044,507.0	36,189,078.0	2,422	838.8	37,044,507.0	36,189,078.0	2,422	838.8	37,044,507.0	36,189,078.0	2,422	838.8	
2019	Татвар төлөгчийн төс	51,014	1,271	52,285	40.8	52	10	61	30,342	604	30,946	20,620	657	20,910	20,620	657	20,910	20,620	657	20,910	20,620	657	20,910	20,620	657	20,910	20,620	657	20,910		
	Дүн	145,064,082.0	14,828,616.7	159,892,698.7	16.6	31,390,282.1	1,190,541.2	32,580,823.3	90,708,411.7	12,423,766.2	103,132,177.9	22,965,388.3	1,214	289.3	24,179,677.6	22,965,388.3	1,214	289.3	24,179,677.6	22,965,388.3	1,214	289.3	24,179,677.6	22,965,388.3	1,214	289.3	24,179,677.6	22,965,388.3	1,214	289.3	
	ас	145,064,082.0	9,968,751.4	155,032,833.5	16.9	31,390,282.1	1,091,697.0	32,481,979.0	90,708,411.7	7,902,395.5	98,610,807.4	22,965,388.3	1,214	289.3	23,940,047.0	22,965,388.3	1,214	289.3	23,940,047.0	22,965,388.3	1,214	289.3	23,940,047.0	22,965,388.3	1,214	289.3	23,940,047.0	22,965,388.3	1,214	289.3	
2020	Татвар төлөгчийн төс	22,569	1,567	24,136	17.4	22	6	28	14,289	1,311	15,600	8,258	250	8,465	8,258	250	8,465	8,258	250	8,465	8,258	250	8,465	8,258	250	8,465	8,258	250	8,465		
	Дүн	83,049,522.6	23,167,527.3	106,217,049.9	11.0	22,709,511.8	6,406,762.9	29,116,274.7	46,958,415.1	16,189,837.2	63,148,252.3	13,381,595.7	570	927.2	13,952,522.9	13,381,595.7	570	927.2	13,952,522.9	13,381,595.7	570	927.2	13,952,522.9	13,381,595.7	570	927.2	13,952,522.9	13,381,595.7	570	927.2	
	ас	83,049,522.6	11,849,727.7	94,899,250.3	10.4	22,709,511.8	3,065,671.4	25,775,183.2	46,958,415.1	8,439,920.5	55,398,335.6	13,381,595.7	570	927.2	13,725,731.4	13,381,595.7	570	927.2	13,725,731.4	13,381,595.7	570	927.2	13,725,731.4	13,381,595.7	570	927.2	13,725,731.4	13,381,595.7	570	927.2	
2021	Татвар төлөгчийн төс	16,059	899	16,958	13.0	12	8	18	12,158	591	12,749	3,889	300	4,125	3,889	300	4,125	3,889	300	4,125	3,889	300	4,125	3,889	300	4,125	3,889	300	4,125		
	Дүн	50,921,758.2	12,908,083.9	63,829,842.1	6.6	8,404,099.4	2,576,554.2	10,980,653.6	34,947,829.8	9,219,407.4	44,167,237.2	7,569,829.0	1,112	122.3	8,681,951.3	7,569,829.0	1,112	122.3	8,681,951.3	7,569,829.0	1,112	122.3	8,681,951.3	7,569,829.0	1,112	122.3	8,681,951.3	7,569,829.0	1,112	122.3	
	ас	50,921,758.2	8,795,764.9	59,717,523.1	6.5	8,404,099.4	2,512,271.0	10,916,370.3	34,947,829.8	5,500,849.3	40,448,679.0	7,569,829.0	1,112	122.3	8,352,473.7	7,569,829.0	1,112	122.3	8,352,473.7	7,569,829.0	1,112	122.3	8,352,473.7	7,569,829.0	1,112	122.3	8,352,473.7	7,569,829.0	1,112	122.3	
2022	Татвар төлөгчийн төс	8,525	1,489	10,014	6.4	6	3	8	5,900	1,277	7,177	2,619	209	2,792	2,619	209	2,792	2,619	209	2,792	2,619	209	2,792	2,619	209	2,792	2,619	209	2,792		
	Дүн	51,653,804.5	11,441,879.3	63,095,683.8	6.5	7,881,060.2	1,659,347.3	9,540,407.5	38,040,146.7	9,075,620.4	47,115,767.1	5,732,597.5	706	911.7	6,439,909.9	5,732,597.5	706	911.7	6,439,909.9	5,732,597.5	706	911.7	6,439,909.9	5,732,597.5	706	911.7	6,439,909.9	5,732,597.5	706	911.7	
	ас	51,653,804.5	8,094,758.9	59,748,563.4	6.5	7,881,060.2	1,265,325.4	9,146,385.6	38,040,146.7	6,411,420.7	44,451,567.5	5,732,597.5	706	911.7	6,150,610.3	5,732,597.5	706	911.7	6,150,610.3	5,732,597.5	706	911.7	6,150,610.3	5,732,597.5	706	911.7	6,150,610.3	5,732,597.5	706	911.7	
2023	Татвар төлөгчийн төс	9,773	416	10,189	7.0	3	3	5	8,550	331	8,881	1,220	82	1,278	1,220	82	1,278	1,220	82	1,278	1,220	82	1,278	1,220	82	1,278	1,220	82	1,278		
	Дүн	21,063,145.5	4,937,968.3	26,001,103.7	2.7	715,183.3	392,175.9	1,107,359.3	17,984,872.1	3,511,592.5	21,496,464.6	2,363,090.1	1,034	189.8	3,397,279.9	2,363,090.1	1,034	189.8	3,397,279.9	2,363,090.1	1,034	189.8	3,397,279.9	2,363,090.1	1,034	189.8	3,397,279.9	2,363,090.1	1,034	189.8	
	ас	21,063,145.5	2,831,500.6	23,894,646.1	2.6	715,183.3	392,175.9	1,107,359.3	17,984,872.1	1,785,870.1	19,770,742.1	2,363,090.1	1,034	189.8	3,016,544.7	2,363,090.1	1,034	189.8	3,016,544.7	2,363,090.1	1,034	189.8	3,016,544.7	2,363,090.1	1,034	189.8	3,016,544.7	2,363,090.1	1,034	189.8	
2024	Татвар төлөгчийн төс	3,900	1,069	4,969	3.8	1	1	2	2,600	1,001	3,601	1,299	67	1,348	1,299	67	1,348	1,299	67	1,348	1,299	67	1,348	1,299	67	1,348	1,299	67	1,348		
	Дүн	14,716,541.9	4,181,422.7	18,897,964.6	2.0	8,083,763.8	27,431.5	8,111,195.3	6,165,317.8	3,836,812.5	10,002,130.3	467,460.3	317	178.7	784,639.0	467,460.3	317	178.7	784,639.0	467,460.3	317	178.7	784,639.0	467,460.3	317	178.7	784,639.0	467,460.3	317	178.7	
	ас	14,716,541.9	2,743,549.5	17,460,091.4	1.9	8,083,763.8	27,431.5	8,111,195.3	6,165,317.8	3,836,812.5	10,002,130.3	467,460.3	317	178.7	663,515.4	467,460.3	317	178.7	663,515.4	467,460.3	317	178.7	663,515.4	467,460.3	317	178.7	663,515.4	467,460.3	317	178.7	
2025	Татвар төлөгчийн төс	7,572	959	8,531	8.0	1	1	1	6,307	884	7,191	1,264	75	1,331	1,264	75	1,331	1,264	75	1,331	1,264	75	1,331	1,264	75	1,331	1,264	75	1,331		
	Дүн	12,739,607.0	2,208,561.3	14,948,168.3	1.5	2,498,329.7	-	2,498,329.7	9,948,526.1	2,099,780.1	12,048,306.2	292,751.3	108	781.2	401,532.5	292,751.3	108	781.2	401,532.5	292,751.3	108	781.2	401,532.5	292,751.3	108	781.2	401,532.5	292,751.3	108	781.2	
	ас	12,739,607.0	1,652,941.1	14,392,548.1	1.6	2,498,329.7	-	2,498,329.7	9,948,526.1	1,584,076.6	11,532,602.7	292,751.3	108	781.2	361,615.8	292,751.3	108	781.2	361,615.8	292,751.3	108	781.2	361,615.8	292,751.3	108	781.2	361,615.8	292,751.3	108	781.2	
2026	Татвар төлөгчийн төс	9,215	1,171	10,386	7.7	2	2	3	6,603	1,087	7,690	2,610	82	2,677	2,610	82	2,677	2,610	82	2,677	2,610	82	2,677	2,610	82	2,677	2,610	82	2,677		
	Дүн	22,668,336.9	6,914,553.2	29,582,890.1	3.1	510,348.																									

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

【Тайлбар】

- А Татварын өр, дутуу үлдэгдлийн нийт дүн нь (2012 оноос өмнөх үзүүлэлтээр 2% орчмоор барагдуулалт хийгдэж байсан) 2017-ны хувьд, 2018 оны 2 сарын тайлагналтаар тодорхой хэмжээгээр барагдуулалт хийгдэх байх гэж таамаглаж байгаа ба одоогийн байдлаар 50.1%-ийг эзэлж байна. 2016 онд 16.6%, 2015 онд 11.0%-ийг эзэлж, ойрын 3 жилийн туршид 77.7%-ийг эзэлж байна.
- Мөн, татварын өртэй этгээдийн тухайд, ойрын 3 жилийн хувь хэмжээгээр 2017 онд 28.0%, 2016 онд 28.5%, 2015 онд 17.4% хэмээн нийт татварын өртэй этгээдийн 73.9%-ийг эзэлж байна.
- В Ойрын 3 жилийн татварын өртэй этгээдийн тоо ба өрийн үлдэгдэл өндөр байгаагийн тухайд, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал 2012 он хүртэл өсөлттэй байснаа, ойрын 3 жилд хурдацтай буурч, татвар төлөгчдийн санхүүгийн байдалд хүндрэл учирсан нь гадаад хүчин зүйл болсон гэж үзэж байна.
- С Нөгөө талаас, шинээр үүссэн татварын өрийн хэмжээний өсөлттэй харьцуулаад татварын өр барагдуулалтын арга хэмжээний хэрэгжилт хоцрогдолтой байгаа ба бага үнийн дүнтэй татварын өрийн тухайд, 2016 онд байгуулсан өр дуудах төв байгуулан барагдуулалт хийж байгаа боловч, шинээр үүсэх өрийн хурдацыг гүйцэхгүй, мөн үнийн дүн өндөртэй татварын өрийн талаар авч буй арга хэмжээ хангалтгүй байгаа талууд ажиглагдаж байна. Цаашид, өндөр үнийн дүнтэй татварын өрийн тухайд, нийт бүтцийн хүрээнд, тухайлан ач холбогдол өгч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал, удирдлагын хүрээнд татварын өр дээр авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлж, удирдлага арга зүйгээр ханган, хариуцсан ажилтан нэг бүрийн ажил үүргийг тодорхой болгон, зааварчилах шаардлага тулгараад байна.

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

2. Татварын өр барагдуулалтын нөхцөл байдал

2.1 Ойрын хугацааны татварын өр барагдуулалтын байдал

2016 оны өр барагдуулалт (2016 оны 12 сарын 31-ны байдлаар)

(нэгж : сая төгрөг)

Ангилал		өссөн дүнгээр			
		Урд оны татварын өр		Тайлант оны дутуу	
		ТТ тоо	Өрийн дүн	ТТ тоо	Өрийн дүн
Барагдуулбал зохих татварын өр, дутуу үлдэгдэл (шүүхэд шилжсэнээс бусад)	Тайлангаар	77,093	532,968	247,187	2,079,411
	Хяналт шалгалтаар	5,561	74,299	3,290	75,583
А : Нийт дүн		82,654	607,267	250,477	2,154,994
В : (А-аас барагдуулсан)		61,0	327,97	205,92	1,964,86
		53	5	7	9
С : (А – В)Барагдуулбал зохих		21,6	279,29	44,550	190,125
		01	2		
(Өр барагдуулалтын байдал)					
Мэдэгдэх хуудас хүргүүлсэн		12,873	379,093	9,172	198,848
Татвар төлөгчид хүргүүлсэн мэдэгдэх хуудасны гүйцэтгэл		6,006	138,442	4,627	70,704
Харилцах дансны зарлагын гүйлгээ хаасан		3,507	124,476	2,054	57,084
Харилцах дансны зарлагын гүйлгээ хасны гүйцэтгэл		1,563	46,804	1,291	37,031
Эд хөрөнгө, цалин хөлснөөс гаргуулах мэдэгдэх хуудас		30	146	16	14
Эд хөрөнгө, цалин хөлснөөс татварын өр гаргуулсан гүйцэтгэл		20	6	1	0.2
Эд хөрөнгө барьцаалсан		28	2,146	6	135
Эд хөрөнгө барьцаалж төсөвт төвлөрүүлсэн		19	828	2	23
Эд хөрөнгө битүүмжилсэн		62	4,556	18	569
Эд хөрөнгө битүүмжилэн төсөвт төвлөрүүлсэн		40	1,072	18	189
Шүүхэд нэхэмжилсэн		401	20,328	49	424
Шүүхийн шийдвэрээр төсөвт төвлөрүүлсэн		91	2,857	19	11

(Эх үүсвэр: ТЕГ)

【Тайлбар】

- (1) Татварын өр барагдуулалтад хамрагдах этгээдэд мэдэгдэх хуудас хүргүүлэхийн тухайд, өмнөх оны хойшлогдсон өрийн хувьд 60%, тайлант оны хувьд дөнгөж 21%-тай байна.
- (2) Өр барагдуулалтын процессийн хувьд ихэнх тохиолдолд банкны харилцах дансны зарлагын гүйлгээг хаах (өмнөх оны хойшлогдсон 3.507, тайлант оны

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

2,054) хэлбэртэй байгаа бөгөөд цалин хөлснөөс гаргуулсан 46 тохиолдол, эд хөрөнгө барьцаалан гаргуулсан 34 тохиолдол, эд хөрөнгө битүүмжилсэн 80 тохиолдол гэх мэт маш цөөхөн байна.

- (3) Шүүхэд нэхэмжлэл гаргасан 450 тохиолдол (өмнөх оноос хойшлогдсон 401, тайлант оны 49) байгаагаас татвараа барагдуулсан 110(өмнөх оноос хойшлогдсон 91, тайлант оны 19)тохиолдол буюу 23%-аас хэтрэхгүй байгаа нь татварын өрийн хуримтлал үүсч байгааг илэрхийлж байна.

2.2 Авч буй арга хэмжээ

- (1) Бага болон өндөр үнийн дүнтэй, хүндрэлтэй татварын өр дээр ажиллах

Өнөөг хүртэл бага ба өндөр үнийн дүнтэй болон барагдуулахад хүндрэлтэй татварын өр дээр нийт бүтцийн хэмжээгээр нэгдсэн арга хэмжээ авч байгаагүй боловч, сүүлийн үед хязгаарлагдмал боловсон хүчний болон төсвийн хүрээнд татварын өр барагдуулалтын үйл ажиллагааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлуудыг хийж эхлээд байна.

- А. Бага үнийн дүнтэй татварын өр дээр ажиллах

Бага үнийн дүнтэй татварын брийн тухайд, үүссэн даруйд нь барагдуулалтыг үр дүнтэйгээр хийх зорилгоор 2016 оны 3 сард татварын өр дуудах төвийг нээн ажиллуулж байна.

- В. Өндөр үнийн дүнтэй болон барагдуулахад хүндрэлтэй татварын өр дээр ажиллах

- (А) Монгол Улсын татварын ерөнхий хуулиар, татвар төлөгч хуулийн этгээд нь төв компанийн хаяг байршлаар, хувь этгээд нь амьдран суугаа хаяг байршлын харьяаллаар татварын албадад бүртгэгддэг. Нөгөө талаас, ТЕГ-ын журмаар, татвар төлөгчийн борлуулалтын орлогын үнийн дүнгээс хамааруулан, УТОХГ ба Нийслэлийн татварын газар, дүүргийн татварын албадад хуваарилан харьяалагддаг тогтолцоотой.

УТОХГ нь зөвхөн том татвар төлөгчдийн 300-400 улсын татварын өрийг, Нийслэлийн татварын газар нь 2017 оны 1 сараас дунд хэмжээний татвар төлөгч 1200 хариуцан ажиллаж байна.

- (В) Иймд иргэн ба аж ахуйн нэгж дээр татварын өр үүссэн тохиолдолд, тухайн татварын өрийн үнийн дүнгээс үл хамааран харьяа татварын албад хариуцаж татварын өр барагдуулалтыг хийдэг.
- (С) Татварын орлогын газар нь барагдуулахад хүндрэлтэй татварын өрийн асуудлаар татварын албадыг удирдлага арга зүйгээр хангаж ирсэн боловч, бага болон өндөр үнийн дүнтэй татварын өрийн талаар нийт бүтцийг

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

хамруулсан дорвитой арга хэмжээ авалгүйгээр ирсэн байна. 2017 оноос барагдуулахад хүндрэлтэй татварын өр дээр ихээхэн анхаарч, хүндрэлийн шалтгааныг 7 ангилан, ангилал тус бүрээр өр барагдуулах чиглэлийг тодорхойлсны үндсэн дээр удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна.

【Барагдуулахад хүндрэлтэй татварын өрийн 7 төрөл】

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлд шилжсэн татварын өр
- Иргэний шүүхэд нэхэмжилсэн татварын өр
- Татварын өртэй этгээд нас барсан, өв залгамжлагчгүй, эсвэл татварын өртэй хуулийн этгээдийн удирдлага нас барсан
- Татварын өртэй этгээдийн хаяг байршил тодорхой болох нь шүүхээр тогтоогдсон
- 2007 оны аж ахуйн нэгжийн бүртгэлийн шинэчилэлт хийгдээгүй татварын өр
- Татварын өрийн үлдэгдэлтэйгээр Улсын бүртгэлийн газраас татан буулгалт хийгдсэн тохиолдол
- НӨАТ-ын падааны ашиглалтын талаар шүүхээр маргаж буй тохиолдол

(D) Татварын орлогын газар нь 2017 оны 9 сард хоёр дүүргийн татварын албанд компьютерийн шинэчилэлт хийн, татвар хураалт хариуцсан ажилтнуудын чиг үүргийг сайжруулах, татварын өр барагдуулалтын бүтэц зохион байгуулалтыг шинэчилэх, өндөр үнийн дүнтэй болон барагдуулахад хүндрэлтэй татварын өр дээр ажиллах хэсгийг байгуулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

【Гол өөрчлөлтүүд】

Гол гарсан өөрчлөлтүүдийг дараах байдлаар үзүүлэв: (“Хавсралт 1”, “Хавсралт 2”-ийг үзнэ үү)

- Хариуцсан ажил үүрэг гүйцэтгэх байцаагчдын тоонд өөрчлөлт оруулах
- Татварын өр барагдуулалт хариуцсан ажилтнуудыг дотор нь өндөр үнийн дүнтэй болон хүндрэлтэй татварын өр хариуцсан хэсэг ба энгийн татварын өр хариуцсан хэсэгт хуваан тус бүрт хэсгийн ахлагчийг томилж, удирдлагад нь ажиллуулах.
- Өндөр үнийн дүнтэй болон хүндрэлтэй татварын өр хариуцсан ажилтнаар аль болох туршлагатай, өр барагдуулалтын ажил гүйцэтгэх чадвар бүхий хүнийг сонгох (Татварын албадын боловсон хүчний ажлын туршлагыг ажилласан жилээр ялган харвал, аймгийн татварын

Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

албадад 3-4 байцаагч, дүүргийн татварын албадад 10 орчим байцаагч хуваарилагдсан байна. Хавсралт 3)

(2) 2018 оны үйл ажиллагааны стратеги


<Татварын сегментжүүлсэн удирдлага>

- А. 2018 оноос эхлэн ТЕГ нь сегментийн хэлбэрээр татварын удирдлагыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь татвар төлөгчийн үйлчилгээ, татвар төлөгчдийг сургах талаас нь харж, бүртгэлээс эхлээд тайлагналт, татварын хяналт шалгалт, татвар төлөлтийн зөвлөлгөө өгөх (татварын өрийн асуудал ороод) гэсэн 4 талт асуудлыг хамруулж байгаа болно. Тухайлбал, татвар төлөгчийг борлуулалтын хэмжээгээр том, дунд, жижиг болон бичил гэсэн 4 сегментэд ангилж, ангилал тус бүрээр татвар төлөгчийн хяналт удирдлагыг хэрэгжүүлнэ.
- В. Тодруулбал, борлуулалтын хэмжээгээр нь 50 сая төгрөг хүртэл, 50-1.5 тэрбум төгрөг, 1.5 тэрбумаас 5 тэрбум төгрөг, 5 тэрбумаас дээш гэж ангилж, том татвар төлөгчдийг УТОХГ, дунд татвар төлөгчдийг дүүргийн татварын албад ба нийслэлийн татварын газар хариуцахаар хуваарилсан.


Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

(Хавсралт материал 1)

Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс




Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс



Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

(Хавсралт материал 2)



Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь төсөл

(Хавсралт материал 3)

Ажилтны ажилласан жилийн тайлан / хураангуй /							
							10/4/2017
№	Алба газар, хэлгэс тасаг	5 хүртэл жил	6-10 жил	11-15 жил	16-20 жил	21-ээс дээш жил	Нийт
1	Архангай	11	7	4	3	2	27
2	Баян-Өлгий	16	3	1	3	2	25
3	Баянхонгор	9	2	5	2	7	25
4	Булган	14	1	0	1	7	23
5	Говь-Алтай	5	7	3	3	6	24
6	Дорноговь	10	3	3	3	3	22
7	Дорнод	16	3	2	1	3	25
8	Дундговь	10	5	2	1	1	19
9	Завхан	6	4	4	3	10	27
10	Өвөрхангай	15	8	2	4	1	30
11	Өмнөговь	19	3	3	1	1	27
12	Сүхбаатар	12	3	3	1	1	20
13	Сэлэнгэ	19	8	3	3	4	37
14	Төв	14	7	5	3	4	33
15	Увс	15	6	2	4	2	29
16	Ховд	20	5	2	2	1	30
17	Хөвсгөл	17	8	1	5	1	32
18	Хэнтий	8	6	7	2	5	28
19	Дархан-Уул	15	8	4	0	1	28
20	Орхон	18	5	1	1	2	27
21	УТӨХГ	8	4	2	0	1	15
22	НТГ	39	6	4	1	1	51
23	Нийслэлийн төсвийн татварын орлогын тасаг	0	0	3	0	0	3
24	Хан-Уул	9	4	7	2	2	24
25	Баянзүрх	48	35	3	5	5	96
26	Сүхбаатар дүүрэг	60	9	15	10	4	98
27	Баянгол	75	15	6	5	3	104
28	Багануур	3	2	2	1	0	8
29	Багахангай	2	0	0	1	0	3
30	Налайх	8	3	3	0	1	15
31	Говьсүмбэр	0	2	0	1	0	3
32	Сонгинохайрхан	45	25	4	3	1	78
33	Чингэлтэй	14	15	4	3	3	39
34	ТЕГ-ын ТОГ, Өр дуудах төв	5	5	2	4	5	21
	Нийт	585	227	112	82	90	1,096

Эх үүсвэр: ТЕГ, Орлогын газар

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

Өр дуудах төвийн үйл ажиллагааны нөхцөл байдал

ба шийдвэрлэх асуудлууд

ХУРААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХҮҮД

Косака Мицүрү

Күмакүра Шигео

2019.11.30

**ӨР ДУУДАХ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ЦААШИД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ (2019 ОНЫ 11 САР)**

I. Өр дуудах төвийн үйл ажиллагааны байдал

1. Эхэнд

Өр дуудах төв нь татвар хураалтын зардлыг багасгах, татварын өрийн хэмжээг бууруулах зорилгоор Монгол Улсын хүсэлтийн дагуу нэвтрүүлсэн төв бөгөөд 2016 оны 3 сараас үйл ажиллагааг эхлүүлсэнээс хойш 3 жил 8 сарын хугацаа өнгөрч өнөөдрийг хүрээд байна.

Төслийн хүрээндэх өр дуудах төвийн зорилго бол “Өр дуудах төвийн үйл ажиллагаа эхэлснээс хойшхи барагдуулсан өрийн тоо өснө” гэдэг зорилго тавьсан бөгөөд үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хувьд “Өр дуудах төвийн чиг үүрэг, хамруулах татварын өрийн дүнг (өрийн үнийн дүнгийн дээд хязгаарыг оруулаад) эргэн авч үзнэ” гэж зааж өгсөн тул өнөөдрийг хүртэл үйл ажиллагааг үр дүнтэй байлгахын тулд санал зөвлөмж өгч ажиллаж ирсэн.

2. Үйл ажиллагааны замнал

(1) Энэхүү төв нь Улаанбаатар хотын 9 дүүргийн татварын албаны “Шинээр үүссэн бага үнийн дүнтэй татварын өр”-ийг утсаар шаардах үйл ажиллагааг автоматжуулан (Компьютер ашиглан хамрагдах татвар төлөгчийг сонгон, автоматаар дуудлага хийн, дуудлагын үр дүнг нэгтгэн тооцоолж, яриаг хураах г.м үйл ажиллагааг явуулдаг (цаашид “автомат дуудлагын систем” гэх)), операторуудыг (цаашид “ОР” гэх) нэг дор төвлөрүүлж цөөн хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллан, өр үүсэх эхний шатанд нь шинээр үүсч буй татварын өрийг үр дүнтэйгээр шийдвэрлэснээр татварын албад үнийн дүн өндөр болон санаатай хэргүүдэд илүү цаг зарцуулан, нийт татварын өрийг барагдуулахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор 2016 оны 3 сард байгуулагдсан.

(2) Үйл ажиллагааг эхлүүлсэнээс хойш ойролцоогоор 1 жилийн хугацаанд Улаанбаатар хотын 6 дүүргийн татварын алба, 2 аймгийн татварын албад туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

2017 оны 4 сард Монгол улсын татварын хуулиар заасан татварын тайлант

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

хугацаа болон төлөх эцсийн хугацаа зэрэгтэй уялдуулсан өөрсдийн үйл ажиллагааны чиглэлийг (цаашид “шинэ үйл ажиллагааны чиглэл¹” гэх) боловсруулж, энэхүү чиглэл дээрээ үндэслэн үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Ингэснээр өр дуудах төв болон татварын албаны ажил үүргийн хуваарилалт нь тодорхой болохын зэрэгцээ татварын албатай илүү ойр мэдээлэл солилцох болж, үр дүнтэйгээр өр дуудах боломжтой болсон.

(3) Өр дуудах төвд хамруулах татварын төрөл нь ААНОАТ, ХХОАТ, НӨАТ байх бөгөөд эдгээр татварын төрлөөр ногдол², өртэй татвар төлөгчид³ байна (сонгогдсон татвар төлөгчид дээрх гурван татварын төрлөөс гадна өөр татварын өр байгаа тохиолдолд нийлүүлэн сануулдаг). Дуудах өрийн дүн 1 сая төгрөгөөс доош байхаар тогтоож өгсөн.

Өнөөдрийг хүртэл шинэ үйл ажиллагааны чиглэлд үндэслэн өр дуудах ажиллагааг хэрэгжүүлж байна.

3. Өр дуудах ажиллагааны гүйцэтгэл болон үнэлгээ

- 2016 оноос хойшхи жил бүрийн гүйцэтгэлийг Хүснэгт (1)-ээр харууллаа. Гүйцэтгэлд өгөх үнэлгээг (2)-оос харна уу.

(1) Жил тус бүрээрх гүйцэтгэлийн байдал

¹ Шинэ үйл ажиллагааны чиглэлийн гол онцлог нь ① төвд байрших татварын төрөл нэмэгдсэн, ② төвд байрших шалгуур үзүүлэлтийг тодорхой болгосон, ③ үйл ажиллагааны зааврыг хүргүүлсэн, ④ татварын албанд буцаагдсан хэргүүдийн мэдээллийг шинэчлэх асуудлыг түргэсгэсэн зэрэг юм.

① Өмнө нь Өр дуудах төвд зөвхөн ААНОАТ-ыг байршуулж байсан бөгөөд 2016 оны өрийн нөхцөл байдлаас шалтгаалан ААНОАТ, НӨАТ, ХХОАТ гэсэн 3 татварын төрөл болгож нэмсэн нь хэдийгээр өр дуудах хуваарийн хяналтыг хийхэд улам хүндрэлтэй болох хэдий ч ирээдүйн өр дуудах үйл ажиллагаа, өр дуудах төвийн зорилгод нийцсэн шаардлагатай арга хэмжээ байсан.

② Өр дуудах төвд байрших шалгуур үзүүлэлт бүхий 3 нөхцлийг (Шинээр үүссэн байх, 3 татварын төрлийн өр байх, татварын төрөл тус бүрийн өрийн хэмжээ 1 сая төгрөгөөс доош байх) тодорхой болгож, мөн бусад татварын өртэй нь хамт дуудах асуудлыг тодорхой болгож өгсөнөөр төвд байрших татварын дүн багасч, шийдвэрлэх асуудлын тоо ч буурах учир татвар төлөгчдийн сонголтыг хийхэд улам амар болж үйл ажиллагаа үр дүнтэй байхад нөлөөлнө. Түүнчлэн өр дуудах төвийг байгуулсан зорилготой нийцэж байгаа юм.

③ “Хамтран ажиллах тухай заавар”-ыг татварын албадад хүргэж төвд байрших шалгуур үзүүлэлт, татварын албадтай мэдээлэл харилцан солилцох талаар мэдэгдсэнээр хамтын ажиллагаа сайжрахын зэрэгцээ нэг татвар төлөгчийг өр дуудах төв болон татварын албанд давхар дуудахгүйн үүднээс салгах асуудлыг тодорхой болгох зэргээр маш чухал үүрэг гүйцэтгэлээ.

④ Буцаагдаж байгаа ногдол өрүүдийн мэдээллийг түргэн хянаж шинэчлэх нь томоохон асуудал болж байна. Ийм үед татварын албадтай хамтран ажиллаж, шийдвэрлэх хугацаа болон үйл ажиллагааны дарааллыг тогтоож өгсөнөөр буцаагдах хэргүүдийг хурдан хугацаанд шинэчлэж чадах бөгөөд өр дуудах ажил үр дүнтэй болоход ихээхэн хувь нэмэр оруулна.

² Ногдолтой татвар төлөгч: Сар бүр эсхүл улирал тутамд татвар төлөх хугацаа нь болдог татварыг хугацаанд нь төлөөгүй татвар төлөгч

³ Өртэй татвар төлөгч: Хуулиар тогтоосон эцсийн хугацаа нь хэтэрсэн татвараа төлөөгүй татвар төлөгч

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

(нэгж : ААН, 1 сая Тг, %, удаа, хүн)

Дуудлага хийсэн хугацаа	Хүлээн авсан ААН (А)	Төлөх амлалт өгсөн (В)	Амлалт өгсөн хувь (В/А)	Нийт өр ногдлын дүн (С)	Барагдуулсан өр ногдлын дүн (D)	Барагдуулалтын хувь (D/С)	Нийт дуудсан дуудлагын тоо	ОР-ийн тоо
2016 оны (3 сар - 12 сар)	23,201	13,745	59.2	10,695	6,405	59.9	31,302	8
2017 он (1 жил)	50,389	31,706	62.9	12,215	7,459	61.1	39,930	8
2018 он (1 жил)	54,927	36,461	66.4	13,221	8,244	62.4	69,665	8
2019 он (1 сар - 10 сар)	42,503	26,486	62.3	9,682	5,946	61.4	44,245	8
Нийт	171,020	108,398	63.4	45,813	28,054	61.2	185,142	32

(2) Жил тус бүрийн үйл ажиллагааны гүйцэтгэлд өгөх үнэлгээ

Үйл ажиллагаагаа эхлүүлсэн 2016 оны 3 сараас хойшхи жил бүрийн дуудлагын гүйцэтгэлээс харвал хүснэгт 1-дээр үзүүлсэнчлэн дуудлага хийхээр хүлээн авсан ААН, төлөх амлалт өгсөн ААН-ийн тоо, нийт өр ногдлын дүн, барагдуулсан дүн, дуудлагын тоо тус бүр жил бүр нэмэгдэж байна (2016 оны хувьд үйл ажиллагаагаа эхлүүлсэн он бөгөөд туршилтын байдлаар дуудлага хийж байсан. Нийт дуудлага хийсэн хугацаа нь 9 сар юм. 2019 оны хувьд дуудлага хийсэн хугацаа нь 1 сарын 1-нээс 10 сарын 31 хүртлэх 10 сарын хугацааг хамарсан тул дэлгэрэнгүй тоон үзүүлэлтийг (жич) хэсгээс харна уу.). Төлөх амлалт өгсөн хувь 2017 онд 62.9%, 2018 онд 66.4% болж нэмэгдсэн байгаа бөгөөд дуудлагын үр дүн сайжирч байна.

Мөн түүнчлэн татварын дүнгээс үзвэл өр дуудах төвөөр дамжуулан барагдуулсан өр ногдлын дүн 2019 оны 10 сарын байдлаар 28 тэр бум төгрөгт хүрч, дуудлага хийхээр хүлээн авсан ААН-ийн тоотой харьцуулахад барагдуулсан өр ногдлын дүнгийн хувь нь 2017 онд 61.1%, 2018 онд 62.4% болж тогтсон төлөлтийн хувиа хангаж байгаа нь үр дүнтэй дуудлага хийгдэж байна гэж дүгнэж болохоор байна.

(Жич) 2016 оны 3 сараас 2017 оны 3 сар хүртлэх дуудлагын гүйцэтгэл болон шинэ үйл ажиллагааны чиглэлд үндэслэн хэрэгжүүлсэн 2017 оны 4 сараас 2019

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

оны 10 сар хүртлэх дуудлагын гүйцэтгэлийг дэлгэрэнгүй орууллаа.

① 2016 оны 3 сараас 2017 оны 3 сар хүртлэх дуудлагын гүйцэтгэл

Үйл ажиллагааг эхлүүлсэнээс хойш 2017 оны 3 сар хүртлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувьд (2016 оны 3 сар нь туршилтын дуудлага учир 12 сар), Улаанбаатар хотын 6 дүүргийн татварын алба, 3 аймгийн татварын албаны 22,577 ААН-д дуудлага хийсэн.

Үүний үр дүнд 10,505 ААН нь өрөө барагдуулж, татвар төлөх амлалт өгсөн байгаа бөгөөд дуудлага хийхээр хүлээн авсан 22,577 ААН-тэй харьцуулахад 46.5%-тай байна (цаашид “төлөх амлалтын хувь” гэх).

Мөн татвар төлөхөд хүндрэлтэй ААН, утасны дугаарын мэдээлэл буруу эсхүл холбогдох боломжгүй гм шалтгаанаар татварын албанд буцаагдсан ААН 12,072 байгаа бөгөөд дуудлага хийхээр хүлээн авсан ААН-ийн тоотой харьцуулахад 53.5%-тай байна (Цаашид “буцаагдсан хувь” гэх).

Татварын алба тус бүрийн гүйцэтгэлийн байдлыг дараах хүснэгтээр харуулав.

(Татварын алба тус бүрийн гүйцэтгэл)

(нэгж: ААН, %)

Татварын албаны нэр	Дуудлага хийсэн нийт тоо	Төлөлт хийгдсэн, Амлалт өгсөн		Татварын алба руу буцаагдсан					
		Тоо	Харьцуулалт	Мэдээлэл буруу	Харьцуулалт	Холбогдоогүй	Харьцуулалт	Хүндрэлтэй	Харьцуулалт
Сүхбаатар	4,975	1,589	31.9	1,048	21.1	1,807	36.3	531	10.7
Баянзүрх	3,637	1,673	50.0	813	22.4	802	22.0	349	9.6
Сонгинохайрхан	2,974	1,675	56.3	455	15.3	616	20.7	228	7.7
Хан-Уул	2,640	1,289	48.8	420	15.9	650	24.6	281	10.7
Баянгол	4,009	2,117	52.8	746	18.6	720	18.0	426	10.6
Чингэлтэй	3,543	1,793	50.6	566	16.0	892	25.2	292	8.2
Ховд	180	39	21.7	62	34.4	56	31.1	23	12.8
Баянхонгор	95	48	50.5	14	14.7	25	26.3	8	8.5
Орхон	524	282	53.8	103	19.7	122	23.3	17	3.2
Нийт	22,577	10,505	46.5	4,227	18.7	5,690	25.2	2,155	9.6

(Анхаарах) Төлөлт хийгдсэн, амлалт өгсөн тооны хувьд төлөх ёстой төлбөрийнхөө нэг хэсгийг нь төлсөн ААН мөн орж байгаа.

② 2017 оны 4 сараас 2018 оны 11 сар хүртлэх дуудлагын үр дүн

Үйл ажиллагааны шинэ чиглэлд үндэслэн өр дуудаж эхэлсэн 2017 оны 4

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

сараас 2018 оны 11 сар хүртэлх нийт 20 сарын хугацаанд 100,649 ААН байршиж үүний 72,088 ААН рүү утсаар дуудлага хийсэн.

Үүний үр дүнд төлөх амлалтын хувь 63.6%, төлөхөд хүндрэлтэй зэрэг шалтгаанаар амлалт авч чадаагүй 1530 ААН нь 2.1%-тай байна.

Түүнээс гадна, өртэй татвар төлөгчтэй холбоо барьж чадаагүй 24,697 ААН байснаас, утасны дугаарын мэдээлэл буруу 7,350 ААН (10.2%), мөн утсаа аваагүйгээс холбогдож чадаагүй 17,347 ААН (24.1%) байна.

(2017 оны 4 сараас 2018 оны 11 сар хүртлэх дуудлагын гүйцэтгэл) (нэгж: ААН, %)

Дуудлага хийсэн нийт тоо	Төлөлт хийгдсэн, Амлалт өгсөн		Татварын алба руу буцаагдсан					
	Тоо	Харьцуулалт	Мэдээлэл буруу	Харьц уулалт	Холбогдоогүй	Харьц уулалт	Хүндрэлтэй	Харьцуулалт
72,088	45,861	63.6	7,350	10.2	17,347	24.1	1,530	2.1

(Анхаарах) Төлөлт хийгдсэн, амлалт өгсөн тооны хувьд төлөх ёстой төлбөрийнхөө нэг хэсгийг нь төлсөн ААН мөн орж байгаа.

③ 2018 оны 12 сараас 2019 оны 10 сар хүртлэх дуудлагын гүйцэтгэл

Дуудлага хийхээр хүлээн авсан 45,462 ААН –ээс 40,897 ААН-д утсаар дуудлага хийсэн.

Үүний үр дүнд төлөх амлалтын хувь 73.2%, төлөхөд хүндрэлтэй зэрэг шалтгаанаар амлалт авч чадаагүй ААН нь 1.5%-тай (626) байна.

Түүнээс гадна, өртэй татвар төлөгчтэй холбоо барьж чадаагүй 9,533 ААН байснаас, утасны дугаарын мэдээлэл буруу 1,786 ААН, татварын үнийн дүн нь алдаатай 826 ААН, мөн утсаа аваагүйгээс холбогдож чадаагүй 7,737 ААН байна.

(2018 оны 12 сараас 2019 оны 10 сар хүртлэх дуудлагын гүйцэтгэл) (нэгж: ААН, %)

Дуудлага хийсэн нийт тоо	Төлөлт хийгдсэн, Амлалт өгсөн		Татварын алба руу буцаагдсан					
	Тоо	Харьцуулалт	Мэдээлэл буруу	Харьц уулалт	Холбогдоогүй	Харьц уулалт	Хүндрэлтэй	Харьцуулалт
40,897	29,912	73.2	2,622	6.4	7,737	18.9	626	1.5

(Анхаарах) 1. Төлөлт хийгдсэн, амлалт өгсөн тооны хувьд төлөх ёстой төлбөрийнхөө нэг хэсгийг нь төлсөн ААН мөн орж байгаа.

2. “Мэдээлэл буруу” хэсгийн хувьд утасны дугаар нь буруу 1786 ААН-ээс гадна өр ногдлын дүн нь алдаатай буюу татварын албанд засвар оруулах хүсэлт гаргасан 826 ААН багтсан болно.

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

4. Шинэ үйл ажиллагааны чиглэлд үндэслэн хэрэгжүүлсэн дуудлагын гүйцэтгэлд өгөх үнэлгээ

(1) Татвар төлөх амлалтын хувь

Үйл ажиллагааг эхлүүлсэн 2016 оны 3 сараас хойш 2017 оны 3 сар хүртэлх гүйцэтгэл болон үйл ажиллагааны чиглэлийг шинэчилсэн 2017 оны 4 сараас 2018 оны 11 сар хүртэлх гүйцэтгэл, 2018 оны 12 сараас 2019 оны 9 сар хүртэлх гүйцэтгэлийг харьцуулбал эхний нэг жилийн нийт дуудлагын тоо 22,577 ААН байсан бол 2017 оны 4 сараас хойшхи жил хагасын хугацаандах дуудлага 72,088 ААН болж, эхний 1 жилийнхээс 3.2 дахин их дуудлага хийгдсэн байна. Үүний дотор төлөх амлалт авсан хувь нь 45.6%-аас 63.6% болж түүнчлэн сүүлийн 10 сарын хугацааны амлалтын хувь 73.2% байна.

(2) Татварын албаруу буцаах хувь

Татварын алба руу буцаасан ААН-ийн тооны хувьд утасны дугаар буруугаас татварын албаруу буцаагдсан хувь 18.7%-аас 10.2%, 6.4% хүртэл буурч, барагдуулах боломжгүй гэсэн шалтгаанаар буцсан ААН-ийн хувь 9.6%-аас 2.1% , 1.5% хүртэл болж буурсан байна.

(3) Үнэлгээ

Ийм сайн үзүүлэлт гарч байгаа нь өр дуудах шалгуурыг 3 үзүүлэлттэй (шинээр үүссэн байх, заасан 3 татварын төрлөөр өртэй байх, нийт татварын өрийн хэмжээ 1 сая төгрөгөөс доош байх) болгож дуудлагын хүрээг өргөсгөж үр дүнтэй өр дуудах ажлыг хэрэгжүүлсэнтэй салшгүй холбоотой. Мөн татварын албатай амжилттай хамтран ажиллан, утасны дугаар буруугаас буцаагдсан ААН-ийн мэдээллийг түргэн шуурхай нягталж чадсаны үр дүнд татварын алба руу буцаагдах ААН-ийн тоо буурч дээр нь дуудлагын төвийн байцаагчид 3 жил гаруй хугацаанд ажилласан туршлагатай болж өртэй татвар төлөгчид тайлбарлах арга болон төлөлт хийхэд нөлөөлөх ойлгуулах чадвар нь нэмэгдсээр байгаа нь төлөлт хийх боломжгүй гэх татвар төлөгчдийн тоог бууруулахад ихээхэн нөлөөлсөн гэж үзэж байна.

II. Цаашид хэрэгжүүлэх ажил

1. Автомат дуудлагын системийг нэвтрүүлэх

Автомат дуудлагын систем нь, автоматаар дуудлага хийх функц, татвар төлөгчийг сонгох функц, дуудлагын үр дүнг нэгтгэн тооцоолох функц, яриаг хураах хяналтын функц, мэдээлэл боловсруулах функц гм функцуудтэй учир энэ системийг ашигласнаар цаг хугацаа ихээр зарцуулж буй ажлыг хураангуйлах боломжтой. Ингэснээр илүүдэл бичиг цаасны ажилд зарцуулж буй цаг хугацааг

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

дуудлага хийх ажилд зарцуулж чадвал өр дуудах төвдээр хүлээн авах ААН-ийн тоог ч ихээр нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Системийн хөгжүүлэлт болон сайжруулалтын ажиллагаа дараах байдалтай хэрэгжиж байна.

(1) Дуудлагын чиглэл болон систем хөгжүүлэлтийн одоогийн байдал

2016 оны 3 сараас хойш эрсдэл удирдлагын газраас авсан тайлангийн мэдээлэлд үндэслэн “ТАХАСТ” (татварын бүртгэлийн дата) програмыг ашиглан байцаагч нар гар аргаар өр дуудаж, үр дүнг шивж оруулан, мэдээллийг нэгтгэх байдлаар ажиллагааг хэрэгжүүлж байсан бөгөөд үндсэн ажил болох өр дуудах ажилд зарцуулах цагийг дуудлагын үр дүнг бичиж тэмдэглэх зэрэг дотоод ажилд зарцуулж байсан.

(2) ТЕГ-ын мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэх ажил

2018 оны 1 сараас “TRIPS” (Татварын нэгдсэн хяналтын систем) нэгдсэн системийн шинэчлэлийг эхлүүлж, 2019 оны 3 сараас “ТАИС” (Tax Administration Information System- Татварын нэгдсэн мэдээллийн систем) нэгдсэн системийг ашиглаж эхлээд байна. (хэсэгчлэн засвар хийгдэж байгаа) “ТАИС” нэгдсэн мэдээллийн системээс өртэй татвар төлөгчийн мэдээллийг хялбар авах боломжтой болж, татвар төлөгчийг сонгох нь ч хялбар болсон хэдий ч автомат дуудлагын системийн шаардлагатай функцууд ороогүй байсан. Иймд өр дуудах төв 2019 оны 10 сараас автомат дуудлагын системтэй уялдуулсан функцийг ашиглах үүднээс автомат дуудлагын систем хөгжүүлэлт хийх компанитай хамтран ажиллаж байна.

(3) Автомат дуудлагын системийг ашиглалтанд оруулах хугацаа

Өмнөх (2)-г хэлсэнчлэн ТЕГ нь автомат дуудлагын системийн хөгжүүлэлтийн ажлыг тасралтгүй үргэлжлүүлсээр байгаа хэдий ч хэзээ ашиглаж эхлэх нь тодорхойгүй байна.

2. Байрших татвар төлөгчийн тухайд

Өр дуудах төвийн чадамж, ногдол өр ихээр үүсэх хугацаа, татварын орлогын хувь хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлөх байдал гм олон талаас харж төвд харьяалах татварын алба, байрших татвар төлөгч, үнийн дүн зэргийг сонгон үр дүн хамгийн өндөр байх талаас нь бодолцож тохиромжит аргыг сонгох хэрэгтэй.

(Анхаар) Өртэй татвар төлөгчдийн татварын дүнгийн шатлалын байдлаас (“2018 оны татварын үнийн дүнгээр ангилсан татварын өрийн хүснэгт” хавсралт 2-г харна уу) харвал тодорхой байгаачлан 999,999 төгрөгөөс доош үнийн дүнгийн өртэй татвар төлөгчдийн тоо нийт өртэй татвар төлөгчдийн 83.9%-ийг эзэлж байгаагийн 42.6% нь аймагт, 57.3% нь нийслэлд (Нийслэл болон 9 дүүргийн татварын алба) төвлөрч байна. Мөн

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

түүнчлэн цаашид үнийн дүнгийн дарааллаар, өр ногдлын үнийн дүн өндөртэй татвар төлөгчдийн дотор тодорхой татварын дүн хүртэлх өр, дутуу ногдлыг тогтмол дуудаж шаардах ажлыг өр дуудах төвд байршуулж хэрэгжүүлэх боломжийн талаар судалж үзэх хэрэгтэй гэж үзэж байна.

3. Ажлын гүйцэтгэлийн байдлын талаар

Өр дуудах ажил нь энгийн ажил хэдий боловч нэг өдөрт олон татвар төлөгчтэй (өртэй татвар төлөгч) харьцаж, заримдаа гомдол гарах тохиолдол ч байх бөгөөд стрессдэх магадлал өндөртэй ажил юм. Операторуудын хувьд амралтын цаг, сэтгэл санаагаа сэргээх цаг хангалттай байх шаардлагатай бөгөөд өдөр, долоо хоногоор сэлгэн ажиллуулах зэргээр эрүүл мэндийн тал дээр анхаарч ажилтнуудын стресс хуримтлагдахгүй байх үүднээс ажлын орчин нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай.

4. Операторуудын тоог нэмэгдүүлэх

Төвд байрших татвар төлөгчдийн тоотой харьцуулахад Операторуудын тоо хүрэлцэхгүй байгаа нь тодорхой байгаа бөгөөд төвд байрших татварын албадуудыг өргөжүүлэх үүднээс цаашид операторуудын тоог нэмэх аль эсхүл цагийн ажилчдыг ажиллуулах талаар судлаж үзэх шаардлагатай.

5. Буцаагдсан хэргүүдийг шийдвэрлэх талаар

Төвд байрших татвар төлөгчийн мэдээлэл буруу байгаа хэргүүдийн хувьд үйл ажиллагааны шинэ чиглэлийн хүрээнд харьяа татварын алба хоорондын ажиллагааны дүрэм болон асуудлыг шийдвэрлэх хугацааг зааж өгсөнөөр үйл ажиллагаа сайжирч, жигдэрч байна. Гэхдээ өр дуудах төвийн үндсэн ажил болох өр дуудах ажлыг бууруулах, муудгахгүй байх талаас үйл ажиллагаагаа явуулах нь зүйтэй гэж үзэж байна.


6. Утсаар хариулт өгөхийн талаар

Одоогийн байдлаар утсаар хариулт өгөх ажлыг хариуцсан ажилтан томилогдоогүй тул аль завтай нь хариулт өгөх байдалтай байгаа ба хариултад цаг хугацаа, ажиллагаа их орохын дээр өр дуудах ажил завсардах, ажлын үр өгөөж буурах шалтгаан болж байна.


Цаашид утсаар хариулт өгөх ажил хариуцсан ажилтан томилох, сэлгээ хийх зэргээр арга хэмжээ авах шаардлагатай байна.

Ногдол, өр дуудах төвийн үйл ажиллагааны урсгал

(Хавсралт 1)



“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл



“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

Хавсралт 2

<2017, 2018 оны татварын өрийн дүн /шагталаар > (Дээд: 2018 он, Доод: 2017 он)

(Нэгж: ААН-ийн тоо, сая төгрөг, %)

	Аймаг		Нийслэлийн хэмжээнд		УТӨХГ		Нийт дүн				
	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Харьцуу лалт	Өрийн дүн	Харьцуу лалт	Харьцуу лалт
1-999'999 ₮ өртэй	64,290	5,025	65,511	9,716	23	5	129,824	83.9	14,746	83.9	1.1
1'000'000-2'999'999 ₮ өртэй	67,840	7,809	91,206	18,698	58	17	159,104	81.9	26,524	81.9	1.4
3'000'000-4'999'999 ₮ өртэй	2,191	3,760	7,848	13,927	12	25	10,051	6.5	17,712	6.5	2.9
5'000'000-9'999'999 ₮ өртэй	2,824	5,818	12,895	27,144	29	66	15,748	8.1	33,028	8.1	7.0
10'000'000-49'999'999 ₮ өртэй	1,353	7,423	6,214	34,492	24	15.8	7,591	4.9	42,074	4.9	3.9
50'000'000-99'999'999 ₮ өртэй	1,620	10,203	9,015	59,895	69	482	10,704	5.5	70,579	5.5	83.7
	758	16,527	4,490	96,683	59	1,622	5,307	3.4	114,832	3.4	100.0
	813	21,240	5,409	145,026	111	3,523	6,333	3.3	168,789	3.3	
	132	8,917	793	55,482	44	3,256	969	0.6	67,655	0.6	
	122	9,363	1,028	77,945	55	5,525	1,205	0.6	92,833	0.6	
	119	57,264	735	276,194	161	497,458	1,015	0.7	830,885	0.7	
	133	83,039	929	1,136,408	150	795,532	1,212	0.6	2,014,978	0.6	
100'000'000 ₮ -ээс дээш	68,843	98,915	85,591	486,464	323	502,525	154,757	100.0	1,087,904	100.0	
Нийт дүн	73,352	137,472	120,482	1,465,116	472	805,145	194,306	100.0	2,407,731	100.0	

【Тайлбар】 (ТЕГ, ОГ)

2018 оны нийслэлийн хэмжээнд 999,999 төгрөгөөс доош өртэй татвар төлөгчдийн тоо (65,551) 2017 оны татвар төлөгчийн тоотой харьцуулахад (91,206) ойролцоогоор 30% аар буурч, 1 сая төгрөгөөс 2,99 сая хүртлэх татвар төлөгчийн тоо (7,848) нь 2017 оны татвар төлөгчийн тоотой харьцуулахад (12,895) ойролцоогоор 37%-аар буурсан байна.

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

Татварын албадын дотоод ажлын тайлан

ХУРААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХҮҮД

Косака Мицүрү

Күмакүра Шигэо

2019.11.30

ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДОТООД АЖЛЫН ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР

I Өнөөдрийг хүртэл

Татварын албаны дотоод ажлын үр ашигтай байдлыг сайжруулах талаарх төслийн зорилго бол “Үйл ажиллагааны гарын авлагыг нийслэлийн туршилтын дүүргүүдэд ашиглан тандалт хийнэ” юм. Эхлээд туршилт хийхээр болсон Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс болох 2 татварын хэлтсүүдэд очин дотоод ажлын нөхцөл байдлыг судалсан (жич “хоёр хэлтсийн татвар хураалтын үйл ажиллагааны талаар” харна уу.). Судалгааны үр дүнд “дотоод ажлыг гүйцэтгэхэд ашигладаг компьютер хуучирч, үйлдэл хийх хурд удаан учир ажил удаашралтай байдаг”, “Ажилчдын тоотой харьцуулахад компьютерийн тоо хүрэлцээгүй” гэх нөхцөл байдалтай байгааг олж мэдсэн бөгөөд дотоод ажлын гүйцэтгэлийг сайжруулахад юуны түрүүнд компьютерийг шинэчлэх асуудал нэн яаралтай гэдгийг ойлгосон. Ингээд 2017 оны 9 сард дээрх 2 татварын хэлтэст тус бүр 40 болон 32 компьютер нийт 72 компьютерийг нийлүүлж үүнтэй зэрэгцэн хураалтын тасаг нэгжийн үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлын талаар зөвлөмж өгсөн.

Үүний дараагаар татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга (цаашид “хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” гэх) гарах магадлал өндөр болохын зэрэгцээ хууль шинэчлэгдсэний дараагаар дотоод бүтэц, хэрэгжүүлэх ажил үүрэг одоогийнхоос өөрчлөгдөх хандлагатай байсан тул тухайн үед хэрэгжүүлж байсан чиг үүргийн зөвлөмжийн ажлыг түр зогсоон, үүний оронд “Өр барагдуулах ажиллагааны гарын авлага” болон “маягтуудын эмхэтгэл” боловсруулах ажилд илүү түлхүү анхаарал хандуулж ажилласан.

2019 оны 3 сард хуулийн шинэчилсэн найруулгын төсөл УИХ-аар батлагдан гүйцэтгэлийн бие даасан эрх, татвар төлөх хоёрдогч үүргийн тогтолцоог нэвтрүүлсэнээр татвар хураалтын ажилд ихээхэн өөрчлөлт орж байгаа тул татвар хураалтын үйл ажиллагааг саадгүй хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай “Өр барагдуулах ажиллагааны гарын авлага”, “Маягтуудын эмхэтгэл”-ийг боловсруулан дуусгаж энэ оны 8 сард Татварын ерөнхий газарт хүлээлгэн өгсөн (II –ын “цаашид” хэсгээс харна уу.).

Ингээд татвар хураах нэгжийн дотоод ажил, систем ашиглалтын журам гм-ийг

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

багтаасан “дотоод ажлын гүйцэтгэлийн журам” гэх үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулах талаар судалсан боловч ТЕГ-ын татварын нэгдсэн удирдлагын системийг бүхэлд нь шинэчилж байсан бөгөөд үйл ажиллагааны гүйцэтгэлийн журам эцсийн байдлаар гараагүй байсан тул энэхүү ажлыг зогсоосон (жич 2 “дотоод ажлын үр дүнтэй байдлыг хэрэгжүүлэх системийн шинэчлэл” харна уу).

(Жич)

1 Татварын албадын татвар хураах үйл ажиллагааны өнөөгийн байдал

(1) Татвар хураах үйл ажиллагааны өнөөгийн байдал

① Татвар хураалтын нэгжийн хуучин бүтэц

Өмнө нь хоёр татварын алба аль аль нь ажлын чиг үүргээр хуваарилсан нэгжийн бүтэцгүй байсан бөгөөд хураалтын байцаагч нар 500-аад орчим татвар төлөгч (ААН)-ийг хуваан хариуцаж тайлан, төлөлтийн байдал гм-ийг компьютер дээр хянангаа өр барагдуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байсан.

② Нэгжийн бүтцийн өөрчлөлт

Чингэлтэй болон Сонгинохайрхан татварын хэлтэст компьютер нийлүүлсэнээр 2018 оноос хураалтын нэгжийн үйл ажиллагаа сайжирч 2019 оноос “сегментийн арга”-аарх өр барагдуулах ажиллагааг нэвтрүүлсэн. Энэ оны 2 сараас 5 сар хүртэл туршилтаар хэрэгжүүлж, 2019 оны 9 сараас нийслэлийн 6 дүүргийг хамруулан сегментийн аргын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

③ Чиг үүргийн бүтэц болон байцаагчдын тоо

【Хэрэгжүүлэх ажил】

Хоёр татварын алба дараах нэгжийн бүтэцтэй байна.

«1» Өмнөх авлагын удирдлагын нэгж, өөрөөр хэлбэл, татвар төлөгчийн хаяг, утасны дугаар гм үндсэн мэдээллийн хяналт, тэмдэглэх, тайлан, төлөлт, буцаалт, суутган гм авлагын хяналт, мэдээллийн санд бүртгэх ажил, мөн татварын орлогын төлөвлөгөөг татвар төлөгч, татварын төрөл, төсөв тус бүрээр хуваарилсан холбогдох мэдээллийн санд бүртгэх, холбогдох төрийн байгууллага болон арилжааны банктай хамтарч ажиллах.

«2~4» Сегментчилэн хувааж, өр барагдуулах ажлыг (өр, дутуу ногдолтой татвар төлөгчид татвар төлөх мэдэгдэл боловсруулж хүргүүлэх, хөрөнгийн судалгаа, банкиндах хөрөнгө, цалингаас гаргуулах, барьцаа, хөнгөлөлт, битүүмжлэл болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хүсэлт гаргах ажиллагаа болон эдгээртэй хамааралтайгаар татвар төлөгчийн хувийн хэрэг, мэдээллийн санд бүртгэх ажил) борлуулалтын хэмжээгээр дараах 3 хэсэгт хуваасан байна.

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

- 2-р сегмент : Борлуулалт нь 50 сая төгрөг хүртлэх ААН, хувиараа бизнес эрхлэгч бүхий өртэй татвар төлөгчид (өр дуудах төвөөс буцаж ирсэн ААН хамаарна) өр барагдуулах ажиллагааг хэрэгжүүлэх, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллаж, тайланг гаргадаггүй этгээдийг олж илрүүлэх, бүртгүүлэх ажлыг хариуцна.
- 3-р сегмент : Борлуулалт нь 50 сая төгрөгнөөс 1.5 тэр бум төгрөг хүртлэх ААН, хувиараа бизнес эрхлэгч бүхий өртэй татвар төлөгчид (өр дуудах төвөөс буцаж ирсэн ААН хамаарна) өр барагдуулах ажиллагааг хэрэгжүүлэх, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллаж, тайланг гаргадаггүй этгээдийг олж илрүүлэх, бүртгүүлэх ажлыг хариуцна.
- 4-р сегмент : Борлуулалт нь 1.5 тэр бум төгрөгнөөс 5 тэр бум төгрөг хүртлэх ААН, хувиараа бизнес эрхлэгч бүхий өртэй татвар төлөгчид өр барагдуулах ажиллагааг хэрэгжүүлэх, тайланг гаргадаггүй этгээдийг олж илрүүлэх, бүртгүүлэх ажлыг хариуцах түүнчлэн тусгай тэмдэгийг борлуулах хянах, архины төрлийн үйлдвэрүүдийг хянах ажлыг хариуцдаг.

«5» Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хамааралтай хэрэг, маргаан таслах зөвлөл болон шүүхэд нэхэмжлэл гаргах хэргийг хариуцах

«6» Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл, орлогын бүтэц, өр хураалтын чиглэлээр судалгаа хийн тайлан гаргах ажлыг хариуцах

«7» Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, автотээврийн хэрэгслийн агаарын бохирдлын болон зам ашигласны төлбөрийг хураах ажлыг хариуцан, холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах.

«8» Татварын нэгдсэн систем /НӨАТУС/-д бүртгэгдээгүй татвар төлөгчийг олж илрүүлэн бүртгэл хамруулах чиглэлээр татвар төлөгчтэй харилцах асуудал хариуцсан нэгжтэй хамтран ажиллах

Чингэлтэй татварын хэлтэст 6 болон 8-р хэсэгт заасан ажлыг хариуцсан байцаагч байдаггүй.

【Байцаагчдын тоо】

Энэ удаагийн нэгжийн бүтцийн өөрчлөлтөөр хоёр татварын хэлтсийн байцаагчдын тоо буурсан байна. Чингэлтэй дүүрэг 41 ажилтнаас 28 ажилтан, Сонгинохайрхан дүүрэг 34 ажилтнаас 17 ажилтан болж буурсан байна. Ялангуяа татварын өр барагдуулах ажил хариуцдаг байцаагч тус бүр 34 ажилтнаас 23 ажилтан, 24 ажилтнаас 10 ажилтан болж ихээр цөөрсөн байна.

Байцаагчдын тоо буурсан нь компьютер шинэчлэгдэн, тоо нэмэгдсэнээр үр бүтээмжтэйгээр ажиллах нөхцөл бүрдэж, түүнчлэн бүтцийн өөрчлөлт

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

хийгдсэнээр үйл ажиллагаа сайжирч, үр дүнтэйгээр өр барагдуулах ажлыг хэрэгжүүлэх боломжтой болсон нь нэг шалтгаан нь болсон боловчуу гэж бодож болохоор байна.

④ Сегментийн аргын анхаарах шаардлагатай тал

Татварын ерөнхий газар 2019 оны 9 сараас нийслэлийн дүүргүүдэд сегментчилэлийн дагуух өр барагдуулах ажлыг эхэлсэн хэдий боловч өрийн үлдэгдэлтэй ААН-ийн тоо, татварын дүн, үйл ажиллагааны цар хүрээ хоорондын хамаарал, тохиромжит байцаагчдыг томилсон эсэх талаар хэд хэдэн асуудал байна гэж харж байна.

Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны цар хүрээ болон татварын өр хооронд тодорхой хэмжээний харилцан хамаарал байх боломжтой хэдийч яг ямар харилцан хамаарал вэ гэдгийг тодорхойлоход хүндрэлтэй.

Иймд нэгжид хариуцах ААН-ийн тоо, байцаагчдын тоо, татвар хураах чадвар гм-ийг хэрхэн нийцүүлэн хамгийн тохиромжит томилгоог хийх вэ гэдэг нь хүндрэлтэй асуудал байх болов уу гэж бодож байна.

Цаашид сегмент тус бүрийн татварын өрийн дүнгийн шатлалаарх мэдээлэлд үндэслэн хариуцах ААН-ийн тоо, ажиллах байцаагчдын тоо, татвар хураах чадвар гм-ийг харгалзан үзэж илүү үр дүнтэй өр барагдуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд уян хатан байдлаар арга хэмжээг авах шаардлагатай гэж бодож байна.

2018 оны татварын өрийн дүнгийн шатлалаарх мэдээллийг хавсралтаас харна уу.

(2) Үйл ажиллагааны хуваарилалтын бүтэц

Татварын албаны татвар хураах үйл ажиллагааны хуваарилалтын талаар дараах хүснэгтээр харуулав.

	Чингэлтэй	Сонгинохайрхан
Татвар хураалтын байцаагчдын тоо	28 байцаагч (41 байцаагч)	17 байцаагч (34 байцаагч)
Авлагын удирдлагын үйл ажиллагаа хариуцдаг байцаагчдын тоо	3	2
(Өр барагдуулах үйл ажиллагаа хариуцдаг байцаагчдын тоо)	23 (34 байцаагч)	10 (24 байцаагч)
Бичил сегмент	7	3
Жижиг сегмент	13	4
Дунд сегмент	3	3
Маргаан, шүүхийн нэхэмжлэх хариуцсан байцаагч	1	1
Татварын орлогын төлөвлөгөө, тайлан хариуцсан байцаагч	-	1
Автотээврийн татвар хариуцсан байцаагч	1	1
Бусад	-	Мэдээлэл судалгаа хариуцсан ажилтан 2 байцаагч

(Анхаар) 1. Мэдээлэл судалгаа хариуцсан ажилтан нь ТЕГ, нийслэлийн татварын газраас өгсөн зааварчилгааны дагуу судалгаа болон тайлан хийдэг.

2. Хаалт доторх тоо нь өмнөх тооны тоог зааж байгаа болно.

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

(3) Үр дүнтэй барагдуулалтын тоо болон татварын орлогын дүн

Хоёр татварын хэлтсийн 2017 он, 2018 оны үр дүнтэй барагдуулалтын тоо¹ болон татварын орлогын дүнг хавсралт 1, хавсралт 2 –оор харуулав.

2017 он болон 2018 оны гүйцэтгэлийг харьцуулбал, Чингэлтэй татварын хэлтсийн үр дүнтэй барагдуулалтын тоо, татварын орлого аль аль нь буурсан байгаа хэдий ч Сонгинохайрхан татварын хэлтсийн хувьд өмнөх оноос сайжирсан гүйцэтгэлтэй байна.

Хоёр татварын хэлтсийн гүйцэтгэлийн үр дүнд бүтцийн өөрчлөлт, татварын нэгдсэн удирдлагын системийн шинэчлэлтийн ажил давхардсанаас гадна өөр бусад шалтгаан нөлөөлсөн гэж үзэж байна.

2 Дотоод ажлын үр өгөөжтэй байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх системийн шинэчлэл

(1) Татварын нэгдсэн удирдлагын системийн шинэчлэл

Татварын ерөнхий газар Азийн хөгжлийн банк (「Asian Development Bank」) -ны дэмжлэгтэйгээр 2018 оны 1 сараас татварын нэгдсэн удирдлагын системийг бүхэлд нь шинэчлэх ажлыг эхлүүлж, өнөөдрийг хүртэл ашиглаж байсан “ТАХАСТ”, “ТАХРАУМЕНТ”, “Debt Management” системүүдийг нэгтгэж 2019 оны 3 сараас татвар хураалтын үйл ажиллагааг хянах боломжтой хураалтын системийг ашиглаж эхлээд байна.

(2) Хураалтын системийн талаар

Энэхүү систем нь татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгад тулгуурлан хөгжүүлэгдсэн бөгөөд төлөлтийг шаардах систем (өртэй татвар төлөгчид “нэхэмжлэх” (битүүмжлэлийн урьдчилсан нөхцөл болох “шаардах хуудас”-тай дүйцнэ.)-ийг автоматаар мэйлээр илгээх систем) болон өр барагдуулах систем (битүүмжлэлийн дараах өр барагдуулах үйл ажиллагаатай хамааралтай акт үйлдэх, гүйцэтгэлийн бүртгэл хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх систем) гэсэн хоёр программаас бүрдэж байна.

Систем ашиглалтанд орсноор өр барагдуулах дотоод ажлын ихэнх хэсэг нь програмчлагдаж гар аргаар хийх ажил ихээхэн багасах тул өр барагдуулах ажил илүү үр дүнтэй байна гэж таамаглаж байна.

II Цаашид

ТЕГ нь татварын нэгдсэн удирдлагын системийг бүхэлд нь шинэчлэн дуусгаж, мөн

¹ “Үр дүнтэй барагдуулалт” гэдэг нь банкин дах дансны зарлагын гүйлгээг хаах, цалин болон бусад мөнгөн хөрөнгөнөөс гаргуулах, барьцаа авах, дуудлага худалдаа, битүүмжлэх зэрэг шат дараалсан өр барагдуулах үйл ажиллагааг хэлнэ (мэдэгдэх хуудас хүргүүлэх ажил нь өр барагдуулах үйл ажиллагааны урьдчилсан нөхцөл боловч өр барагдуулах үйл ажиллагаанаас өөр шинж чанартай тул хассан.).

Үр дүнтэй барагдуулалтын тоо их байх нь өр барагдуулах ажиллагааг сайн хэрэгжүүлж байгаагийн илэрхийлэл юм.

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

татварын хууль энэ жил батлагдсан учир 2020 оны 1 сараас хуулийн хэрэгжилт эхлэхтэй холбогдуулан цаашид өр барагдуулалтын хэрэгжилтийн бүтэц, байгууллагаын бүтэц зохион байгуулалтыг сайжруулж, татвар хураалтын дотоод ажлын үр бүтээмжтэй байдлыг улам сайжруулна гэж найдаж байна.

(Жич) Хуулийн шинэчилсэн найруулга болон үйл ажиллагааны гарын авлага

1 Хуулийн шинэчлэл

2019 оны 3 сард Хуулийн шинэчилсэн найруулга УИХ-аар батлагдан олон нийтийн хэлэлцүүлэг хийж, ТЕГ-ын даргын тушаалыг боловсруулах гм 2020 оны 1 сарын 1-ний хуулийн хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлуудыг зохион байгуулж байна.

2 Өр барагдуулах үйл ажиллагааны гарын авлага

2019 оны 8 сар хүртэл шинэчилсэн хуулийн хэрэгжилтэд зориулан ТЕГ-ын даргын тушаалаас гадна өр барагдуулах ажиллагаанд нэн шаардлагатай ажил болох хөрөнгийн хяналт шалгалт, битүүмжлэл, мөнгөн хөрөнгөнд шилжүүлэх, хуваарилалт хийх, татвар төлөх хоёрдогч үүргийн тайлбарыг нэгтгэсэн гарын авлагын төсөл боловсруулж, үүнтэй дагалдан гарах маягтуудыг мөн адил боловсруулж ТЕГ-т хүлээлгэн өгсөн.

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

Хавсралт 1 Татварын өрийн үлдэгдэл, гүйцэтгэсэн процесс ажиллагаа

Чингэлтэй дүүрэг

(Нэгж: тоо, 100 сая төгрөг)

	Өмнөх оны		Тайлант оны		Нийт	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
Татварын өрийн дүн	539.2	823.3	1,569.5	177.0	2,108.7	1,000.3
Татварын өртэй ТТтоо	4,993	5,053	4,636	5,355	9,629	10,408
Татварын өр барагдуулалтын гүйцэтгэл						
Мэдэгдэх хуудас (шаардах хуудас) хүргүүлсэн						
Тоо	1,276	1,436	735	803	2,011	2,239
Үнийн дүн	335.7	440.4	195.7	188.7	531.4	629.1
А Харилцах дансны зарлагын гүйлгээ хаасан						
Тоо	527	360	196	138	723	498
Үнийн дүн	191.7	191.9	84.2	47.0	275.9	238.9
В Эд хөрөнгөөс						
Тоо	2	0	0	0	2	0
Үнийн дүн	0.7	0	0	0	0.7	0
С Барьцаат гэрээ байгуулсан						
Тоо	9	1	8	0	17	1
Үнийн дүн	5.3	0.5	2.0	0	7.3	0.5
Д Дуудлага худалдаа хийсэн						
Тоо	0	0	0	0	0	0
Үнийн дүн	0	0	0	0	0	0
Е Хөрөнгө битүүмжилсэн						
Тоо	3	0	1	0	4	0
Үнийн дүн	1.1	0	0.1	0	1.2	0
Ғ Шүүхээр нэхэмжлэл хийгдсэн өр						
Тоо	21	42	2	0	23	42
Үнийн дүн	21.2	27.0	1.2	0.1	22.4	27.1
Үр дүнтэй барагдуулалтын тоо (А+В+С+Д+Е+Ғ) болон дүн	562 220.0	403 219.4	207 87.5	183 47.0	769 307.5	586 266.4

【Тайлбар】

- ① Өмнөх оны татварын өрийн үр дүнтэй барагдуулалтын мэдээлэл 2017 онд 562 ААН, 22 тэр бум төгрөг байсан бол 2018 онд 404 ААН, 21.94 тэр бум төгрөг болж, ААН-ийн тоо буурсан хэдий ч барагдуулсан үнийн дүн ойролцоо байна. Тайлант оны хувьд 2017 онд 207 ААН, 8.75 тэр бум төгрөг байснаас 2018 онд 183 ААН, 4.7 тэр бум төгрөг болж буурсан байна.
- ② Урьд оны мэдээллээс үзвэл 2018 оны шүүхээр нэхэмжлэл хийгдсэн ААН-ийн тоо болон үнийн дүн аль аль нь өссөн үзүүлэлттэй байна.
- ③ Дуудлага худалдааг 2017 он, 2018 онд хэрэгжүүлээгүй байна.

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

Хавсралт 2 Татварын өрийн үлдэгдэл, гүйцэтгэсэн процесс ажиллагаа

Сонгинохайрхан дүүрэг

(Нэгж: тоо, 100 сая төгрөг)

	Өмнөх оны		Тайлант оны		Нийт	
	2017 年	2018 年	2017 年	2018 年	2017 年	2018 年
Татварын өрийн дүн	362.8	454.6	945.8	1,010.4	1,308.6	1,465
Татварын өртэй ТТгоо	12,501	14,746	17,278	54,663	29,779	69,409
Татварын өр барагдуулалтын гүйцэтгэл						
Мэдэгдэх хуудас хүргүүлсэн						
Тоо	1,879	3,415	715	289	2,594	3,704
Үнийн дүн	210.5	455.9	66.0	46.3	276.5	502.2
А Харилцах дансны зарлагын гүйлгээ хаасан						
Тоо	580	1,882	95	0	675	1,882
Үнийн дүн	106.5	357.2	5.7	0	112.2	357.2
В Эд хөрөнгөөс						
Тоо	0	0	0	0	0	0
Үнийн дүн	0	0	0	0	0	0
С Барьцаат гэрээ байгуулсан						
Тоо	0	0	0	0	0	0
Үнийн дүн	0	0	0	0	0	0
Д Дуудлага худалдаа хийсэн						
Тоо	0	0	0	0	0	0
Үнийн дүн	0	0	0	0	0	0
Е Хөрөнгө битүүмжилсэн						
Тоо	0	9	0	0	0	9
Үнийн дүн	0	10.5	0	0	0	10.5
Ф Шүүхээр нэхэмжлэл хийгдсэн өр						
Тоо	2	32	0	0	2	32
Үнийн дүн	20.8	47.2	0	0	20.8	47.2
Үр дүнтэй барагдуулалтын тоо (А+В+С+D+E+F) болон дүн	582 127.3	1923 414.9	95 5.7	0 0	677 133.0	1,923 414.9

【Тайлбар】

- ① Өмнөх оны татварын өрийн үр дүнтэй барагдуулалтын тоо болон үнийн дүн нь 2017 онд 582 ААН, 12.73 тэр бум төгрөг байсан бол 2018 онд 1923 ААН, 41,49 тэр бум төгрөг болж өссөн байна. Түүнчлэн 2018 онд 9 ААН-ийн хөрөнгийн битүүмжлэл хийж, 1.05 тэр бум төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Нөгөөтэйгүүр тайлант онд өр барагдуулалтын гүйцэтгэл хийгдээгүй байна.
- ② Нийтэд нь үзвэл үр дүнтэй барагдуулалтын дүн болон тоо нь 2017 онд 677 ААН, 13.3 тэрбум төгрөг байсан бол 2018 онд 1923 ААН, 41.49 тэрбум болж өссөн байна.
- ③ Эд хөрөнгөөс барагдуулах, хөрөнгө барьцаалах, дуудлага худалдааг 2017 он, 2018 онд хэрэгжүүлээгүй байна.
- ④ Тайлант оны өртэй татвар төлөгчдийн тоо маш ихээр өссөн байна.

“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төсөл

(Хавсралт)

< 2018 оны татварын өрийн дүн /шаглалаар >

(Нэгж: ААН-ийн тоо, сая төгрөг, %)

	Аймаг		Нийслэлийн хэмжээнд		УТӨХГ		Нийт дүн				
	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Өрийн дүн	ТТ-ийн тоо	Өрийн дүн	Харьцуулагч	Өрийн дүн	Харьцуулагч
1-999'999 ₮ өртэй	64,290	5,025	65,511	9,716	23	5	129,824	14,746	83.9	1.4	
1'000'000-2'999'999 ₮ өртэй	2,191	3,760	7,848	13,927	12	25	10,051	17,712	6.5	1.6	
3'000'000-9'999'999 ₮ өртэй	1,353	7,423	6,214	34,492	24	15.8	7,591	42,074	4.9	3.9	
10'000'000-49'999'999 ₮ өртэй	758	16,527	4,490	96,683	59	1622	5,307	114,832	3.4	10.5	
50'000'000-99'999'999 ₮ өртэй	132	8,917	793	55,482	44	3,256	969	67,655	0.6	6.2	
100'000'000 ₮ -ээс дээш	119	57,264	735	276,164	161	497,458	1,015	830,885	0.7	76.4	
Нийт дүн	68,843	98,915	85,591	486,464	323	502,525	154,757	1,087,904	100.0	100.0	

[Тайлбар]

999,999 төгрөгнөөс доош өртэй татвар төлөгчдийн тоо (12,984) нийт татвар төлөгчдийн 83.9%, 2,99 сая хүртлэх татвар төлөгчийн тоог (10,051) хамруулбал 90.4%-ийг эзэлж байна.

(ТЕГ, ОГ)

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хийсэн зүйлс

**Татвар хураалттай холбоотой гарын авлага,
материал**



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТАТВАР ХУРААЛТЫН ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР, 2020

ХОЛБОГДОХ ТАТВАРЫН ХУУЛЬ
ДАГАЛДАХ ЖУРМУУД

1. Татварын ерөнхий хууль.....	4
2. ААНОАТ-ын хууль.....	81
3. ХХОАТ-ын хууль.....	116
4. Өргэй татвар төлөгчийн хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журам.....	134
5. Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журам.....	142
6. Татварын өр төлөх хугацааг хөнгөлөх журам (төсөл).....	149
7. Татварын өрийг татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс гаргуулах үйл ажиллагааны журам (төсөл).....	160

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 03 сарын 22 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

I ХЭСЭГ ЕРӨНХИЙ АНГИ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын Татварын алба /цаашид “Татварын алба” гэх/, татвар төлөгч болон энэ хуулийн дагуу татварын албаны өмнө үүрэг хүлээсэн бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Татварын хууль тогтоомж

- 2.1. Татварын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

- 3.1. Энэ хууль нь татвар төлөгч, татварын алба болон татварын хууль тогтоомжийн дагуу түүнийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээдэд хамаарна.
- 3.2. Энэ хуулиар зохицуулаагүй, эсхүл энэ хуульд зааснаас өөрөөр татварын бусад хуульд заасан бол тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан татварын хуулийн зүйл, хэсэг, заалт давуу үйлчилнэ.

3.3. Энэ хуулийн 3.2-т заасны дагуу тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хууль, зүйл, хэсэг, заалтыг тодорхойлох боломжгүй бол аль сүүлд батлагдсан хууль, хуулийн зүйл, хэсэг, заалтыг баримтална.

4 дүгээр зүйл.Татвар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох

4.1. Доор дурдсанаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй:

4.1.1. хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтворжуулах;

4.1.2. чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг Чөлөөт бүсийн тухай хуулиар тогтоож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг татварын холбогдох хуулиар зохицуулах.

4.2. Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна.

5 дугаар зүйл.Татварын үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. зайлшгүй байх;

5.1.2. тодорхой байх;

5.1.3. шударга байх;

5.1.4. үр ашигтай байх.

6 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

6.1. Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

6.1.1. “ажил гүйлгээний ашиг хуваах арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний ашгийг тухайн ажил гүйлгээнд оролцсон харилцан хамаарал бүхий талуудад эдийн засгийн үндэслэлтэй хуваарилж, түүнтэй харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний ашгийн түвшинтэй харьцуулан тухайн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;

6.1.2. “ажил гүйлгээний цэвэр ашгийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшний үзүүлэлтүүдийг түүнтэй харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшний

- үзүүлэлтүүдтэй харьцуулан тухайн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;
- 6.1.3. “ажлын өдөр” гэж долоо хоногийн Бямба, Ням гараг болон нийтээр тэмдэглэх баярын өдрөөс бусад өдрийг;
- 6.1.4. “албадан гүйцэтгэх ажиллагаа” гэж шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, барьцааны эрхээс барьцаа гаргуулах, татвар төлөгчтэй холбоотой дампуурлын хэрэг үүсгэх, татварын өр хураах үйл ажиллагааг;
- 6.1.5. “албан татвар” гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;
- 6.1.6. “бодит үнэ тодорхойлох зарчим” гэж харилцан хамааралтай этгээд хооронд хийсэн ажил гүйлгээний нөхцөл татварын зорилгоор түүнтэй харьцуулж болох бие даасан ажил гүйлгээний нөхцөлөөс ялгаатай байгаагаас татварын суурь багассан бол тухайн ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлж, татварын ногдолд тохируулга хийхийг;
- 6.1.7. “үнэ шилжилтийн тохируулга хийх арга” гэж бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу харилцан хамаарал бүхий этгээд хооронд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;
- 6.1.8. “групп” гэж санхүүгийн тайлагналын зорилгоор нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, эсхүл аль нэг аж ахуйн нэгжийн хувьцаа хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдах үед нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, өмчлөл болон удирдлагын хувьд хамааралтай аж ахуйн нэгжүүдийг;
- 6.1.9. “дамжуулан борлуулах үнийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний нийт ашгийн түвшинг түүнтэй борлуулалтын орлогын хувьд харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний нийт ашгийн түвшинтэй харьцуулан тухайн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;
- 6.1.10. “дотоод харьцуулалт хийх ажил гүйлгээ” гэж татвар төлөгчийн харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээ болон бие даасан этгээдтэй хийсэн ажил гүйлгээг;
- 6.1.11. “жишиг үнийн арга” гэж татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаа, орлого, зарлагын болон бусад бодит тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлохыг, тийм татвар төлөгч байхгүй бол татварын алба өөрт байгаа мэдээллийг үндэслэн татварын ногдлыг тодорхойлохыг;

- 6.1.12. “итгэмжлэгдсэн төлөөлөгч” гэж татвар төлөгчийн эрх ашгийг итгэмжлэл болон гэрээний үндсэн дээр төлөөлж, татварын албатай харилцах эрх, үүрэг бүхий итгэмжлэгдсэн этгээдийг;
- 6.1.13. “нөхөн ногдуулалт” гэж энэ хуульд заасны дагуу гүйцэтгэсэн татварын хяналт шалгалтын дүнд үндэслэн татварын албанаас тодорхойлсон татварын дүнг;
- 6.1.14. “нөхөн ногдуулалтын акт” гэж татварын албанаас тодорхойлсон нөхөн ногдуулалт, торгууль, алдангийн дүнг тусгасан татвар төлөгчид хүргүүлэх баримт бичгийг;
- 6.1.15. “нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт” гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд зааснаар албан татвар суутган төлөгчийн татварын ногдуулалт, төлөлтийг татварын алба хянан, баталгаажуулсан баримт бичгийг;
- 6.1.16. “оршин суугчийн гэрчилгээ” гэж татвар төлөгчийг тухайн татварын жилд тус улсын оршин суугч татвар төлөгч мөн болохыг нотолж тухайн улсын татварын албанаас тогтсон загварын дагуу үйлдсэн баримт бичгийг;
- 6.1.17. “өртөг дээр нэмэх арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний нийт ашгийн түвшинг түүнтэй зардлын бүтцийн хувьд харьцуулагдах бие даасан ажил гүйлгээний нийт ашгийн түвшинтэй харьцуулан тухайн хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөл, үнийг тодорхойлохыг;
- 6.1.18. “татварын схем” гэж татварын ашиг хүртэх үндсэн зорилгоор хэрэгжүүлэх татвараас зайлсхийх үйл ажиллагааг;
- 6.1.19. “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг;
- 6.1.20. “татвар төлөгч” гэж татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэг бүхий этгээд, эсхүл суутган төлөгчийг;
- 6.1.21. “татвар төлөгчийн гэрчилгээ” гэж татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас татвар төлөгчид олгосон, татвар төлөгчийн дугаартай, татварын төрлийн мэдээллийг тусгасан тусгай нууцлалын кодоор баталгаажсан, цахим болон цаасан баримт бичгийг;
- 6.1.22. “татвар төлөгчийн дугаар” гэж татварын албанаас татвар төлөгчид олгосон татвар төлөгчийн бүртгэлийн нэгдсэн системийн дахин давтагдашгүй дугаарыг;
- 6.1.23. “татвар төлөхөөс зугтах” гэж татвар төлөгч татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл нуух зорилгоор татварын хууль тогтоомж зөрчих үйлдэл, эс үйлдэхүйг;

- 6.1.24. “татвараас зайлсхийх” гэж татварын ногдлыг бууруулах, татварын суурь багасгах, эсхүл алдагдлыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан нөхцөлийг бүрдүүлж байгаа татвар төлөгчийн үйлдлийг;
- 6.1.25. “татварын алба” гэж татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагч, хураагчийг;
- 6.1.26. “татварын акт” гэж татварын улсын байцаагчийн үйлдсэн нөхөн ногдуулалтын акт, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, татварын буцаан олголтын актыг;
- 6.1.27. "татварын буцаан олголтын акт" гэж татварын албаны үндэслэлгүйгээр илүү хураасан мөнгөн дүнд алданги тооцож олгоход үйлдэх баримт бичгийг;
- 6.1.28. “татварын жил” гэж тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааг;
- 6.1.29. “татварын тайлан” гэж татварын албанаас баталсан маягтын дагуу татвар төлөгчийн бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан татварын суурь, албан татвар, төлбөр, хураамжийн ногдлын хэмжээг тодорхойлж, тайлагнах хуудсыг;
- 6.1.30. “татварын улсын байцаагч” гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээн авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг;
- 6.1.31. “татварын өр хураах зардал” гэж татварын өр барагдуулах үйл ажиллагаанд хамаарах хөрөнгийн битүүмжлэл, суутгалын хүсэлт, битүүмжилсэн хөрөнгийн хадгалалт, тээвэрлэлт, дуудлага худалдаа явуулах, үнэт цаас болон биет бус хөрөнгийн эрхийг хураах, хуваарилахтай холбоотой гарсан зардлыг;
- 6.1.32. “татварын хялбаршуулсан горим” гэж татварын бүртгэл, ногдуулалт, хувь хэмжээ, тайлагнал, төлөлтийн тусгайлсан үйл ажиллагааны нийлбэр цогцыг;
- 6.1.33. "татварын суурь" гэж тодорхой дүн, эсхүл хувиар татварын ногдлыг тодорхойлох орлого, хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаарын, хөрсний, усны бохирдлыг мөнгөөр илэрхийлсэн дүн, эсхүл биет нэгжийг;

- 6.1.34. “татварын цахим баримт бичиг” гэж татварын хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр боловсруулсан, хадгалсан, илгээсэн, хүлээн авсан, цахим гарын үсгээр баталгаажсан баримт бичгийн иж бүрдлийг;
- 6.1.35. “тодорхой бизнесийн зорилгогүй татварын үйлдэл” гэж төлөх татварын хэмжээг багасгах, татвар төлөхөөс зайлсхийх болон татвар төлөх хугацааг хойшлуулсан ажил гүйлгээ хийх, төлөвлөн гүйцэтгэх татвар төлөгчийн үйлдлийг;
- 6.1.36. “төлбөр” гэж төрийн өмчийн газар, газрын хэвлий, байгалийн баялаг, ой, ургамал, рашаан, ашигт малтмал, газрын тосны нөөц, агаар, ус, хөрс ашигласны, бохирдуулсны, ан амьтан агнасны төлөө аливаа этгээдээс авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;
- 6.1.37. “харьцуулагдах байдлын шинжилгээ” гэж харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний нөхцөлийг харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийсэн ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулан ялгаатай хүчин зүйлсийн нөлөө, зөрүүг арилгаж үнэн зөв залруулга хийх шинжилгээний аргыг;
- 6.1.38. “харьцуулагдах бие даасан үнийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний үнэ болон үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийг түүнтэй харьцуулагдах, бие даасан ажил гүйлгээний үнэ болон үнэд нөлөөлөгч хүчин зүйлстэй харьцуулан тодорхойлохыг;
- 6.1.39. "хураагч" гэж татварын улсын байцаагчийн нөхөн ногдуулалт хийх, хяналт шалгалт хийхээс бусад чиг үүргийг хэрэгжүүлж байгаа татварын албаны ажилтныг;
- 6.1.40. “хураамж” гэж төрийн байгууллагаас аливаа этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;
- 6.1.41. “хүндэтгэн үзэх шалтгаан” гэж:
- 6.1.41.а. эмнэлгийн өвчтөний гар картад бичигдсэн бөгөөд лаборатори болон багажийн шинжилгээгээр эмчлүүлэх шаардлагатай нь нотлогдож, эмч, эмнэлгийн байгууллагын гаргасан магадлагаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа;
 - 6.1.41.б. эмч, эмнэлгийн байгууллагын гаргасан магадлагаагаар энэ хуулийн 6.1.41.а-д заасны дагуу эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөнийг асарсан;
 - 6.1.41.в. хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан;

- 6.1.41.г. хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон;
- 6.1.41.д. хуульд заасан эрх бүхий этгээдээс албан ёсоор зарласныг нотолсон галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл /усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт/ зэрэг шалтгааныг;
- 6.1.42. “хяналтад байгаа ажил гүйлгээ” гэж харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээг;
- 6.1.43. “бие даасан ажил гүйлгээ” гэж харилцан хамааралгүй этгээд хооронд хийсэн ажил гүйлгээг;
- 6.1.44. “цахим гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.1, 4.1.2-т заасныг;
- 6.1.45. “эдийн засгийн өгөөж олох” гэж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, зардал хэмнэх, хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал, хугацааг багасгах замаар ашиг буюу ашигт ажиллагааг дээшлүүлсэн байхыг;
- 6.1.46. “эсэргүүцэл үзүүлсэн” гэж татварын улсын байцаагч, хураагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэж эсэргүүцсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, айлгасан, сүрдүүлсэн санаатай үйлдэл, эс үйлдлийг;
- 6.1.47. “этгээд” гэж хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага болон тэдгээртэй адилтгах иргэний харилцаанд оролцогчийг;
- 6.1.48. “эцсийн эзэмшигч” гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ТАТВАР

7 дугаар зүйл. Монгол Улсын татвар

7.1. Монгол Улсын татвар нь албан татвар, төлбөр, хураамж /цаашид “татвар” гэх/-аас бүрдэнэ.

7.2. Монгол Улсын татвар нь доор дурдсан төрөлтэй байна:

- 7.2.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;
- 7.2.2.гаалийн албан татвар;
- 7.2.3.нэмэгдсэн өртгийн албан татвар;
- 7.2.4.онцгой албан татвар;
- 7.2.5.автобензин, дизелийн түлшний албан татвар;
- 7.2.6.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;
- 7.2.7.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр;
- 7.2.8.агаарын бохирдлын төлбөр;
- 7.2.9.улсын тэмдэгтийн хураамж;
- 7.2.10.ус бохирдуулсны төлбөр;
- 7.2.11.газрын тосны нөөц ашигласны төлбөр;
- 7.2.12.газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр;
- 7.2.13.хувь хүний орлогын албан татвар;
- 7.2.14.үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;
- 7.2.15.малын тоо толгойн албан татвар;
- 7.2.16.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;
- 7.2.17.ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;
- 7.2.18.газрын төлбөр;
- 7.2.19.галт зэвсгийн албан татвар;
- 7.2.20.нийслэл хотын албан татвар;
- 7.2.21.нохойны албан татвар;
- 7.2.22.өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар;
- 7.2.23.хог хаягдлын үйлчилгээний хураамж;
- 7.2.24.байгалийн ургамал ашигласны төлбөр;
- 7.2.25.усны нөөц ашигласны төлбөр;
- 7.2.26.рашаан ашигласны төлбөр;
- 7.2.27.ойн нөөц ашигласны төлбөр;
- 7.2.28.ан амьтны нөөц ашигласны төлбөр;
- 7.2.29.түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.

7.3. Тодорхой төрлийн татварын харилцааг энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.

8 дугаар зүйл.Татварын хувь, хэмжээг тогтоох

- 8.1. Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.
- 8.2. Энэ хуулийн 7.2.2, 7.2.3, 7.2.4, 7.2.6, 7.2.8, 7.2.10, 7.2.11, 7.2.18, 7.2.25, 7.2.27-д заасан татварын хувь, хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан Засгийн газар тогтоож болно.
- 8.3. Энэ хуулийн 7.2.13, 7.2.14, 7.2.15, 7.2.16, 7.2.17, 7.2.20, 7.2.21, 7.2.24, 7.2.26, 7.2.28, 7.2.29-д заасан татварын хувь, хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.
- 8.4. Энэ хуулийн 7.2.23-т заасан татварын хувь, хэмжээг Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон тохиолдолд тогтоосон хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.
- 8.5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар, мөн хуулийн 6.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.

9 дүгээр зүйл.Татвар ногдох зүйл

- 9.1. Татвар ногдох зүйлд орлого, хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаарын, хөрсний, усны бохирдол зэрэг зүйл хамаарна.
- 9.2. Татвар ногдох зүйлийг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан тогтооно.

10 дугаар зүйл.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

- 10.1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт дараах хэлбэртэй байна.
 - 10.1.1.ногдуулсан татварыг хорогдуулах;
 - 10.1.2.татварын хувь, хэмжээг бууруулах;
 - 10.1.3.тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх;
 - 10.1.4.татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;
 - 10.1.5.татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;
 - 10.1.6.татварын хууль тогтоомжид заасан бусад.
- 10.2.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулах бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11 дүгээр зүйл.Татварын хялбаршуулсан горим

- 11.1.Татварын алба, татвар төлөгч татварын хялбаршуулсан горимыг ашиглаж болно.
- 11.2.Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгч нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна.
- 11.3.Хуульд өөрөөр заагаагүй бол татварын хялбаршуулсан горимыг зөвхөн татварын жилээр тооцох бөгөөд тухайн татварын жилийн дундуур уг горимоос шилжихийг хориглоно.
- 11.4.Татварын хялбаршуулсан горимыг хэрэгжүүлэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ

12 дугаар зүйл.Татвар төлөгчийн эрх

- 12.1.Татвар төлөгч дараах эрх эдэлнэ:
 - 12.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөгчийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхтэй холбогдсон мэдээлэл, зөвлөгөө, чиглэл, татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам, аргачлал, маягтыг татварын алба, татварын улсын байцаагчаас авах;
 - 12.1.2.татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх;
 - 12.1.3.хууль тогтоомжийн дагуу татвар төлөх хугацааг сунгуулах;
 - 12.1.4.илүү төлсөн татварыг буцаан авах, суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах;
 - 12.1.5.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, төлөөлүүлэх, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах;
 - 12.1.6.татварын албанаас гаргасан татварын акт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор захиргааны болон шүүхийн журмаар гомдол гаргах;
 - 12.1.7.татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;
 - 12.1.8.татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг татварын алба, татварын улсын байцаагчаас шаардах, татварын албаны хууль бус шийдвэр, үйлдлийн улмаас учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;

- 12.1.9. татварын алба, татварын улсын байцаагчийн хууль бус ажиллагаа болон шийдвэрт холбогдох гомдлыг түүнийг шууд захирдаг болон дээд шатны албан тушаалтанд, түүнчлэн шүүхэд гаргах. Ийнхүү гомдол гаргасан нь ногдуулсан татвар, торгууль, алдангийг төлөхийг зогсоох үндэслэл болохгүй;
- 12.1.10. татварын хууль тогтоомжоор ногдсон үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн итгэмжлэгдсэн нягтлан бодогч, татварын зөвлөхийн туслалцаа, зөвлөгөө авах;
- 12.1.11. хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулсан татварыг тогтворжуулсан хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх;
- 12.1.12. хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 12.2. Татварын алба энэ хуулийн 12.1.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор хяналт шалгалтад хамруулах эрсдэлийн үнэлгээний нарийвчилсан үзүүлэлтийг татвар төлөгчид мэдээлэхгүй.

13 дугаар зүйл. Нууцлалын баталгаа

- 13.1. Татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх, эсхүл хувийн зорилгоор ашиглах байдлаар задруулахыг хориглоно.
- 13.2. Татварын алба, татварын улсын байцаагч, татварын албаны бусад ажилтан болон татварын албанд ажиллаж байсан этгээд, татварын албаны хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаанд хөндлөнгийн гэрчээр оролцсон хүн нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн татвар төлөгчийн мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд доор дурдсан албан тушаалтанд татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно:
- 13.2.1. татварын хууль тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа татварын улсын байцаагч;
- 13.2.2. татварын хууль тогтоомж зөрчсөн зөрчил, гэмт хэргийг бүртгэх шалгах, хянах, шийдвэрлэх үүрэг хүлээсэн хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгчид зөвхөн уг зөрчил, гэмт хэрэгт холбогдох асуудлаар;
- 13.2.3. олон улсын гэрээний дагуу харилцан мэдээлэл солилцох зорилгоор томилогдсон буюу сонгогдсон эрх бүхий албан тушаалтанд гэрээтэй холбоотой мэдээлэл солилцох асуудлаар.
- 13.3. Татвар төлөгч зөвшөөрсөн, эсхүл хууль болон сонгон шалгаруулалтын шаардлагаар олон нийтэд мэдээлэх татвар төлөгчийн нэр, дугаар, төлсөн

татварын мэдээлэл, статистикийн зорилгоор татварын албанд нэгтгэсэн нэгдсэн тайлан, мэдээ энэ хуулийн 13.1-д хамаарахгүй.

13.4.Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.

13.5.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нууц мэдээллийн санд нэвтрэх эрхтэй татварын улсын байцаагчийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр томилох бөгөөд түүний нууц мэдээллийн санд нэвтрэх, ашиглах үйлдэл бүртгэлтэй байна.

14 дүгээр зүйл.Татвар төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих

14.1.Татвар төлөх үүрэг дараах тохиолдолд дуусгавар болно:

14.1.1.тухайн төрлийн татварын өрийг төлж дууссан;

14.1.2.бусад татварын илүү төлөлтийг тухайн төрлийн татварын өрд суутган тооцсон;

14.1.3.татвар төлөгч тухайн төрлийн татвараас хуулиар чөлөөлөгдсөн;

14.1.4.тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсон, уг хуулийн дагуу ногдуулах татварын өрийг төлж дууссан;

14.1.5.нас барсан болон нас барсанд тооцсон татвар төлөгч хувь хүн нь өв залгамжлагчгүй, эсхүл өвлүүлэх хөрөнгөгүй нь шүүхээр тогтоогдсон.

14.2.Хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд татан буулгах комисс, дампуурсан тохиолдолд хэрэг гүйцэтгэгч төлөөгүй татварыг хуулийн этгээдийн хөрөнгөөс хуульд заасан журмаар гаргуулж холбогдох төсөвт төлнө.

14.3.Хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөх замаар өөрчлөн байгуулсан тохиолдолд татвар ногдуулалт, төлөлттэй холбогдсон эрх, үүрэг өөрчлөн байгуулагдсаны үр дүнд бий болсон хуулийн этгээдэд шилжинэ.

14.4.Хуулийн этгээдийг тусгаарлах, хуваах замаар өөрчлөн байгуулсан тохиолдолд татвар ногдох зүйл, хуваарилагдсан хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн татвар ногдох үүрэг тэдгээрт шилжинэ.

14.5.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийг энэ хуулийн дагуу эрсдэлтэй гэж тооцсон тохиолдолд татварын хяналт шалгалтад хамруулна.

14.6.Нас барсан болон нас барсанд тооцсон хувь хүний татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх өв залгамжлагчид нь өвлөсөн хөрөнгөд ногдох хэмжээгээр шилжих бөгөөд үүнд татварын торгууль хамаарахгүй.

15 дугаар зүйл.Татварын хөөн хэлэлцэх хугацаа

- 15.1.Татварын нөхөн ногдуулалт хийх, алданги, торгууль ногдуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, алдагдал шилжүүлэх, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хөөн хэлэлцэх хугацаа 4 жил байх бөгөөд Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа татварын хууль тогтоомжид хамаарахгүй.
- 15.2.Татвар, алданги, торгуулийн өр төлөх болон энэ хуулийн 12 дугаар бүлэгт заасан татварын өр хураах журам, түүнчлэн татвар төлөгчид гаргасан хүсэлтийнх нь дагуу төлсөн татварыг буцаан олгохтой холбогдсон харилцаанд энэ хуулийн 15.1-д заасан хугацаа хамаарахгүй.
- 15.3.Энэ хуулийн 15.1-д заасан хугацааг дараах байдлаар тоолно:
- 15.3.1.тайлант жилийн эцэст нэг удаа гаргаж, татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд уг тайланг гарган, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;
- 15.3.2.тайланг сар, улирлаар гаргаж татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд тухайн жилийн 12 дугаар сарын буюу жилийн эцсийн тайлан гаргаж, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;
- 15.3.3.борлуулалт хийгдсэнээс хойш тодорхой хугацааны дотор татвар төлөхөөр хуульд заасан татварын төрөл болон суутгаж төлдөг татварын хувьд тухайн төрлийн татварын тайланг гарган, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;
- 15.3.4.тайлан гаргахгүй төлдөг татварын хувьд тухайн төрлийн татварын хуульд заасан татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс.
- 15.4.Татвар төлөгч татварын асуудлаар маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан бол тогтоол гарах хүртэл, шүүхэд гомдол гаргасан, эсхүл хууль хяналтын байгууллагаар хянан шалгагдаж байгаа бол эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаагаар татварын хөөн хэлэлцэх хугацаа тасалдана.
- 15.5.Татварын алба үнэ шилжилтийн тохируулга хийх зорилгоор гадаад улсын татварын албанаас мэдээлэл гаргуулах хүсэлт гаргасан өдрөөс хүсэлтийн хариу ирсэн өдөр хүртэлх хугацаагаар татварын хөөн хэлэлцэх хугацааг тасалдсанд тооцно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТАТВАРААС
ЗАЙЛСХИЙХИЙН ЭСРЭГ ЕРӨНХИЙ ДҮРЭМ

16 дугаар зүйл.Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм

16.1.Татварын хяналт шалгалтын үеэр доор дурдсан нөхцөл бүрдсэн нь тогтоогдсон боловч хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэн татварыг нөхөн ногдуулах боломжгүй бол Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эрхтэй байна:

16.1.1.татвар төлөгч нь дангаараа, эсхүл бусад этгээдтэй хамтран татварын схем зохион байгуулсан;

16.1.2.энэ хуулийн 16.1.1-д заасан татварын схемийн хүрээнд тухайн татвар төлөгч татвараас зайлсхийх замаар татварын ашиг хүртсэн.

16.2.Татвар төлөгч нь энэ хуулийн 16.1-д заасан хэлбэрээр татвараас зайлсхийж татварын ашиг хүртсэн бол татварын алба татвар төлөгчийн татварын ногдлын хэмжээг дээр дурдсан татварын схемийг ашиглаагүй, эсхүл татварын ашиг хүртээгүй байх нөхцөлөөр дахин тодорхойлж татварын ногдолд залруулга хийнэ.

16.3.Татвар төлөгч энэ хуулийн 16.1.1, 16.1.2-т заасан үйлдлийг бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлсэн бол уг хамтарсан этгээдийн татварын ногдлыг уг нөхцөлөөр дахин тодорхойлж, залруулга хийнэ.

16.4.Татварын алба энэ хуульд заасны дагуу залруулга хийсэн бол холбогдох татварыг нөхөн ногдуулна.

16.5.Нөхөн ногдуулалтыг энэ хуулийн 15.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаанд багтаан эхлүүлэх бөгөөд нөхөн ногдуулалтын хамрах хугацаа нь энэ хуулийн 16.3, 16.4-т зааснаар татварын ногдлыг тодорхойлсноос өмнөх 4 жилийг хамаарна.

16.6.Энэ хуулийн 16.1.1-д заасан татварын схемийг ашиглан дараах үр дүнд хүрсэн бол энэ хуулийн 16.1.2-т заасан татварын ашиг хүртсэнд тооцно:

16.6.1.татварын суурийг бууруулах буюу татвараас чөлөөлөгдөх орлого, татварын хөнгөлөлт, суутган тооцоолол, татвар ногдох орлогоос хасагдах зардлыг бүртгэлийн аргаар өөрчлөх;

16.6.2.татвар төлөх үүргийг хойшлуулах;

16.6.3.татвар төлөх үүргийг хойшлуулснаар үүсэх давуу байдал олж авах;

16.6.4.чөлөөлөгдөх орлого, эсхүл татвар ногдохгүй орлогын хэмжээг нэмэгдүүлэх замаар татвар ногдох орлогыг бууруулах;

16.6.5.татвар ногдох орлогод татвар ногдуулахгүй байх.

16.7.Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эсэхийг Эрсдэлийн удирдлагын хороо шийдвэрлэх бөгөөд хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар:“Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм” гэж олон улсын татварын харилцаанд нийтлэг ашиглагддаг “General Anti-Avoidance Rule”-ийг ойлгоно.

17 дугаар зүйл.Харилцан тохирох журам

- 17.1.Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн харилцан тохирох журмыг хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 17.2.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улстай харилцан тохирох журмын асуудлаар олон улсын гэрээ байгуулаагүй гадаад улсын татвар төлөгчид энэ хуулийн 17.1 дэх хэсэг хамаарахгүй.
- 17.3.Татварын харилцан тохирох журмыг Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, нэгдэн орсон олон улсын байгууллагаас тавигдах шаардлагад нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18 дугаар зүйл.Гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам

18.1.Энэ зүйлд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

18.1.1.“мэдээллийг автоматаар солилцох” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хүрээнд гадаад улсын оршин суугч этгээдийн талаарх хэлэлцэн тохирсон мэдээллийг аливаа урьдчилсан хүсэлтгүйгээр тогтмол, тодорхой хугацааны давтамжтай хэлэлцэн тохирогч талууд хоорондоо солилцохыг;

18.1.2.“мэдээлэл” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор доор дурдсаны аль нэг, эсхүл бүгдийг нь агуулсан үйл баримт, тайлан, баримт, бүртгэл, дансны мэдээллийг;

18.1.2.а.банк, санхүүгийн байгууллага, тэдгээрээс томилогдсон этгээд, хөрөнгө итгэмжилсэн этгээд, зуучлагч болон батлан даах чадвар бүхий этгээдийн мэдэлд байгаа баримт, тайлан, бүртгэл, дансны мэдээллийг;

18.1.2.б.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, нөхөрлөл болон бусад этгээдэд хамааралтай үйл баримт, тайлан, баримт, бүртгэл, дансны мэдээллийг;

18.1.2.в.хамтын хөрөнгө оруулалтын сангийн хувьд хувьцаа, хувь оролцоо, нэгж эрх болон бусад ашиг сонирхлын тухай мэдээллийг, итгэлцлийн сангийн хувьд төлбөр тооцоо гүйцэтгэгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, болон өгөөж хүртэж байгаа этгээдийн талаарх мэдээллийг.

18.1.3.“санхүүгийн байгууллага” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор тодорхойлсон банк, банк бус санхүүгийн,

- кастодиан, хадгаламж, хөрөнгө оруулалтын болон даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнээс бусад этгээдийг;
- 18.1.4.“тал” гэж Хэлэлцээрт оролцогч талыг;
- 18.1.5.“хэлэлцээр” гэж Монгол Улсаас бусад улстай байгуулсан татварын зорилгоор мэдээлэл солилцох, түүний дотор автоматаар мэдээлэл солилцох олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцыг;
- 18.1.6.“хүсэлт” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хүрээнд аль нэг тал нөгөө талдаа гаргасан өргөдлийг;
- 18.1.7.“хүсэлт гаргагч улс” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хүрээнд мэдээлэл авах хүсэлт гаргаж байгаа улсыг;
- 18.1.8.“цахим мэдээлэл” гэж энэ хуулийн 18.13-т заасан цахим аргаар боловсруулж хадгалсан бичлэгийг;
- 18.1.9.“эрх бүхий этгээд” гэж Монгол Улсын хувьд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эсхүл түүний томилсон эрх бүхий этгээд, гадаад улсын хувьд хэлэлцээрийн хүрээнд тодорхойлсон хэлэлцэн тохирогч талын томилсон эрх бүхий этгээдийг;
- 18.1.10.“эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээр” гэж энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хэлэлцээрийн зүйл, заалтыг тайлбарлах, тодруулах зорилгоор хэлэлцэн тохирогч талуудын томилсон эрх бүхий этгээд хооронд байгуулсан хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээрийг.
- 18.2.Монгол Улсаас бусад улстай байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээд нь гадаад улсын эрх бүхий этгээдтэй зөвхөн татварын асуудлаар энэ хуулийн 18.1.2-т заасан мэдээлэл харилцан солилцоно.
- 18.3.Энэ хуулийн 18.1.9-д заасан эрх бүхий этгээд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 18.3.1.энэ хуулийн 18.1.6-д заасан хүсэлтийг биелүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:
- 18.3.1.а.аливаа этгээдээс тайлан, дансны мэдээллийг авах;
- 18.3.1.б.энэ хуулийн 18 дугаар зүйл болон хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл хүсэх этгээдэд холбогдох мэдээлэл болон нотлох баримтыг цуглуулан авч, хүргүүлэх;
- 18.3.1.в.баримт материалыг хүргүүлэх;
- 18.3.1.г.энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан мэдээлэл харилцан солилцох болон гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээд нь энэ хуулийн 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлд заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх;
- 18.3.1.д.шаардлагатай бусад арга хэмжээ.

- 18.3.2.энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн дагуу хэлэлцэн тохирогч талуудтай татварын зорилгоор энэ хуулийн 18.1.2-т заасан мэдээлэл солилцох, мэдээлэл автоматаар солилцох, эрх бүхий этгээд хооронд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх;
- 18.3.3.энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хүрээнд үүсэж болох зардлыг тодорхойлж, аливаа хүсэлтэй холбогдуулан гарах зардлыг тооцоолж тэнцвэртэй хуваарилах;
- 18.3.4.энэ хуулийн 18.1.5-д заасан хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор бусад улсын эрх бүхий этгээдтэй эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрийг байгуулж, тэдгээртэй хамтран ажиллах журмыг батлах;
- 18.3.5.энэ зүйлд заасан бусад чиг үүрэг.
- 18.4.Эрх бүхий этгээд нь тухайн улстай байгуулсан хэлэлцээрийн нөхцөлийн дагуу хүсэлт гаргагч улсад туслалцаа үзүүлж ажиллана.
- 18.5.Энэ хуулийн 18.1.6-д заасан хүсэлтийг хүлээн авсны дараа эрх бүхий этгээд энэ зүйл болон холбогдох хэлэлцээрт нийцүүлэн хүсэлтийг биелүүлнэ.
- 18.6.Эрх бүхий этгээд шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 18.1.7-д заасан хүсэлт гаргагч улсаас хүсэлтийн талаар нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 18.7.Эрх бүхий этгээд нь хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр энэ хуулийн 18.1.2-т заасан мэдээлэл болон аливаа этгээд, санхүүгийн байгууллагын эзэмшил, хяналтад байгаа шаардлагатай бусад мэдээллийг татварын зорилгоор ашиглах эсэхээс үл хамаарч энэ хуульд заасан мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр санхүүгийн байгууллагаас авч, хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.
- 18.8.Энэ хуулийн 18.7-д заасан мэдэгдэлд дараах мэдээллийг тусгаж болно:
- 18.8.1.мэдээлэл ирүүлэх хугацаа;
- 18.8.2.баримтын эх хувь, эсхүл түүний хуулбарыг авах эсэх талаар эрх бүхий этгээдээс шаардсан хэлбэр;
- 18.8.3.баримтыг албан ёсоор баталгаажуулах эсэх.
- 18.9.Эрх бүхий этгээдийн хүсэлтийг үндэслэн энэ хуулийн 18.1.2-т заасан мэдээллийг гэрчийн мэдүүлэг хэлбэрээр авч болно.
- 18.10.Энэ хуулийн 18.8.1-д заасан хугацаа хуанлийн 14 хоногоос хэтрэхгүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл эрх бүхий этгээд уг хугацааг өөрөөр тогтоож болно.
- 18.11.Эрх бүхий этгээд нь энэ хуулийн 18.7-д заасан мэдээллийг хадгалж, хувилж, хуулбарлаж болно.
- 18.12.Хууль зүйн давуу байдлаар олж авсан мэдээллийг энэ хуулийн 18.7-д заасан мэдэгдлээр гаргуулахыг хориглоно.

- 18.13.Мэдэгдлийн хүрээнд авсан мэдээлэл цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа бол түүний агуулгыг өөрчлөлгүйгээр бичгэн хэлбэрт оруулж дахин боловсруулна.
- 18.14.Эрх бүхий этгээд ирүүлсэн хүсэлтийг холбогдох хэлэлцээрт нийцэхгүй болохыг тогтоосон бол хүсэлтээс татгалзаж, энэ талаар хүсэлт гаргагч улсад нэн даруй мэдэгдэнэ.
- 18.15.Хүсэлтээс татгалзсан бол эрх бүхий этгээд болон хүсэлт гаргагч улсын зүгээс холбогдох хэлэлцээрт заасны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.
- 18.16.Баримт бичиг болон мэдэгдлийг холбогдох этгээдэд биечлэн, шуудангаар, эсхүл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон хэлбэрээр хүргүүлж болно.
- 18.17.Эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрийн хүрээнд мэдээлэл автоматаар солилцох зорилгоор эрх бүхий этгээд нь шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд, тодорхой хэлбэрт нийцүүлж ирүүлэхийг энэ хуулийн 18.1.3-т заасан байгууллагаас шаардаж болно.
- 18.18.Энэ хуулийн 18.17-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран дараах журмыг баталж, мөрдүүлж болно:
- 18.18.1.тайлан, мэдээлэл ирүүлэх шаардлагатай санхүүгийн байгууллагуудыг тодорхойлох;
- 18.18.2.тайлагнах шаардлагатай мэдээлэл, цахим мэдээллийн агуулга, загвар;
- 18.18.3.тайлагнах мэдээллийн иж бүрдэл, нарийвчлал зэргийг заасан стандарт;
- 18.18.4.мэдээлэл харилцан солилцох хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам;
- 18.18.5.мэдээллийн нууцлал, хадгалах үйл ажиллагааг зохицуулсан журам;
- 18.18.6.энэ хуулийн 18.15-д заасныг болон автоматаар мэдээлэл харилцан солилцохтой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн журам.
- 18.19.Татварын албаны мэдээллийн нууцлалтай холбоотой харилцаанд энэ хуулийн 13 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.20.Энэ хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй эсхүл хэрэгжүүлж байсан этгээд нь энэ хуулийн 18 дугаар зүйл болон хэлэлцээрийн хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд зөвхөн энэ хууль болон хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор мэдээллийг ашиглаж болно.
- 18.21.Татварын алба нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээдийн олж авсан мэдээллийг ашиглаж болно.
- 18.22.Энэ хуульд заасны дагуу мэдээллийг хүсэлтээр болон автоматаар солилцох зорилгоор нууц мэдээллийг эрх бүхий этгээдэд хүргүүлсэн бол уг үйлдэлтэй

- холбогдуулж мэдээлэл задруулсан үндэслэлээр бусад хуулиар хариуцлага хүлээлгэхгүй.
- 18.23.Энэ хуулийн 18.22-т заасны дагуу мэдээлэл өгч байгаа этгээдийн үйлдэл нь уг асуудлаар бусад этгээдтэй байгуулсан нууцлалын баталгааг зөрчсөн үйлдэл болохгүй бөгөөд энэ үйлдэлд тухайн этгээд болон түүний ажил олгогчид хариуцлага хүлээлгэхгүй.
- 18.24.Аливаа этгээд нь хууль зүйн давуу байдлаар олж авсан мэдээллээ бусдад задруулж иргэний болон эрүүгийн хэрэгт холбогдсон бол энэ хуулийн 18.22-т заасан хамгаалалтад хамаарахгүй.
- 18.25.Эрх бүхий этгээд, эсхүл түүний эрх олгосон этгээд нь энэ хуульд заасан албан үүргээ зохих журмын дагуу гүйцэтгэх явцад хийсэн үйлдэл, эс үйлдлийн улмаас хохирол учруулсан нь уг этгээдэд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.
- 18.26.Энэ зүйлийн заалтууд нь бусад хууль тогтоомжоор зохицуулж байгаа мэдээллийн нууцлалтай холбоотой хязгаарлалтаас үл хамааран давуу эрхтэй үйлчилнэ.
- 18.27.Энэ хууль болон хэлэлцээрийн заалтууд нь бусад хууль тогтоомжийн заалттай зөрчилдөж байгаа тохиолдолд энэ хууль болон хэлэлцээрийн заалтууд давуу эрхтэй үйлчилнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТАТВАРЫН НОГДЛЫГ ТОДОРХОЙЛОХ, ТАТВАР ХУРААХ ЗОРИЛГООР ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АЖИЛЛАГАА

19 дүгээр зүйл.Татварын ногдлыг тодорхойлох, татвар хураах зорилгоор хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаа

- 19.1.Татварын улсын байцаагч татварын ногдлыг тодорхойлох болон татвар хураах зорилгоор татвар төлөгчийн байр агуулахад нэвтрэн орж мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх зэрэг нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх эрхтэй.
- 19.2.Татварын улсын байцаагч энэ хуулийн 19.1-д заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэхдээ татварын улсын байцаагчийн үнэмлэхээ үзүүлж, үйл ажиллагааны зорилгыг тайлбарлана.
- 19.3.Энэ зүйлд заасан татварын улсын байцаагчийн хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаанд татвар төлөгч хүч хэрэглэж, эсхүл зохион байгуулалттайгаар эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага Цагдаагийн албаны тухай хуулийн 15.1.7-д заасны дагуу дэмжлэг үзүүлнэ.

19.4.Энэ хуулийн 19.1-д заасан байр агуулахад нэвтрэн орж мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийхтэй холбогдсон журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

19.5.Энэ хуулийн 19.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

20 дугаар зүйл. Байр, агуулахад нэвтрэн орох

20.1.Татварын улсын байцаагч нь татвар төлөгчийн орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйл болон татвартай холбогдолтой мэдээ, судалгаа, бусад баримтыг хадгалж байгаа, нэвтрэн орохыг хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээний газар, албан байр, агуулах, зооринд нэвтрэн орж, ажлын зураг авалт, үзлэг хийх, тооллого явуулах, баримт бичиг, эд хөрөнгийг түр хугацаагаар хураах, хяналт шалгалтын ажил хийх эрхтэй.

20.2.Татварын улсын байцаагч мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах зорилгоор байр, агуулахаас гадна татвар төлөгчийн орлого, зарлага, ажил гүйлгээний мэдээлэл бүхий компьютер, техник хэрэгсэл, программ хангамжид нэвтрэн орох эрхтэй.

20.3.Энэ хуулийн 20.1-д заасан үйл ажиллагааг татвар төлөгчийн аль байр, агуулахад хийхийг удирдамжид тодорхой тусгаж харьяалах татварын албаны албан томилолтоор гүйцэтгэнэ.

20.4.Гадаад орны дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын байр, дархан эрх, эрх ямба бүхий албан тушаалтны ажлын байранд энэ хуулийн 20.1-д заасан ажиллагаа явуулахыг хориглоно.

21 дүгээр зүйл. Мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах

21.1.Татварын алба мэдээ, мэдээлэл, баримт цуглуулахад дараах журмыг баримтална:

21.1.1.татварын албаны шаардсан мэдээ, мэдээлэл, баримтыг эх хувиар түр хугацаагаар гаргуулахдаа тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулах;

21.1.2.шаардлагатай тохиолдолд мэдээ, мэдээлэл, баримтыг хуулбарлах, гэрэл зураг, дүрс, дууны болон бусад бичлэгээр баримтжуулах;

21.1.3.тайлбар, лавлагааг бичгээр гаргуулах, эсхүл ярилцлага хийсэн бол тэмдэглэл үйлдэж, холбогдох этгээдээр гарын үсэг зуруулах;

21.1.4.энэ хуулийн 21.1.1, 21.1.2, 21.1.3-т заасантай адилтгах бусад мэдээ, мэдээлэл, баримт гаргуулах.

21.2.Татварын алба татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай магадлагаа, баримтын хуулбар, мэдээ, судалгаа, дансны хуулга, холбогдох

бусад баримт бичиг, мэдээллийг татвар төлөгч, түүнтэй харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авна.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан мэдээ, мэдээлэл, баримтыг хуулбарлах, баримтжуулахад бусдын техник хэрэгслийг ашигласан бол хөлсийг нь зах зээлийн, эсхүл харилцан тохиролцсон үнээр татварын алба төлнө.

21.4.Татварын алба татвар төлөгчийн борлуулалт, худалдан авалт, хүний нөөц, техникийн үйлчилгээ, хоршсон үйлдвэрлэл, үйл ажиллагаанд ашигласан үнэ, төлбөр, хураамж, гэрээ хэлцэл зэрэг мэдээ, мэдээлэл, баримтыг гаргуулахаар татвар төлөгч болон түүнтэй хамтран үйл ажиллагаа явуулсан гуравдагч этгээдээс шаардах эрхтэй.

21.5.Татварын алба мэдээ, мэдээлэл баримт цуглуулах зорилгоор татвар төлөгчтэй харилцаа бүхий гуравдагч этгээдээс дараах журмаар мэдээлэл гаргуулж болно:

21.5.1.мэдээлэл агуулж байгаа байр агуулах, баримт материал, компьютер зэрэгт бүрэн нэвтрэх;

21.5.2.мэдээлэл болон баримт бичгийг шаардах;

21.5.3.тодорхой газар болон хугацаанд мэдээлэл авахаар дуудан ирүүлэх.

22 дугаар зүйл. Үзлэг хийх

22.1.Татварын алба үзлэг хийхэд дараах журмыг баримтална:

22.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай, 18 насанд хүрсэн, ашиг сонирхлын зөрчилгүй, татвар төлөгч, татварын алба, татварын улсын байцаагчтай захирах, захирагдах ёсны харилцаагүй хөндлөнгийн гэрчийг байлцуулах;

22.1.2.үзлэгт хамрагдаж байгаа бичиг баримт, эд хөрөнгийн эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, хэрэв боломжгүй бол тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулах;

22.1.3.үзлэг явуулсан тухай тэмдэглэл үйлдэж оролцсон болон байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулах, хэрэв гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.

22.2.Үзлэгт хамрагдах зүйлийн өмчлөл, эзэмшлийн ялгааг үл харгалзан Татварын алба, татварын улсын байцаагч нь үзлэг хийх эрхтэй.

22.3.Татварын алба үзлэг хийх явцад татвар хураалт, хяналт шалгалтад ашиглах мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах эрхтэй.

23 дугаар зүйл. Тооллого явуулах

23.1.Татварын алба тооллого явуулахад дараах журмыг баримтална:

- 23.1.1.бараа, эд хөрөнгө, бэлэн мөнгөний тооллого хийхдээ татвар төлөгч болон түүний хууль ёсны төлөөлөгч, нягтлан бодогч, эсхүл тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулж, тооллогын бүртгэл, тэмдэглэл үйлдэх;
- 23.1.2.тооллогын бүртгэл, тэмдэглэлд тооллого хийсэн татварын улсын байцаагч болон тооллого явуулахад байлцсан бусад хүмүүс гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.
- 23.2.Татварын алба тооллого хийх явцад татвар хураалт, хяналт шалгалтад ашиглах мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах эрхтэй.

24 дүгээр зүйл.Ажлын зураг авалт хийх

- 24.1.Татварын алба ажлын зураг авалт хийхэд дараах журмыг баримтална:
- 24.1.1.татвар төлөгчийн төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, орлого, зардлыг тогтоох зорилгоор ажлын зураг авалтыг урьдчилан мэдэгдэж, эсхүл мэдэгдэхгүйгээр хийх;
- 24.1.2.ажлын зураг авалтад холбогдох мэргэжилтэн оролцуулж, шаардлагатай хэмжих хэрэгсэл ашиглах;
- 24.1.3.ажлын зураг авалтын тооцоо дүгнэлт хийж, тэмдэглэл үйлдэх, уг тэмдэглэлд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулах, гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.

II ХЭСЭГ ТАТВАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ
ЗУРГАДУГААР БҮЛЭГ
ТАТВАР ТӨЛӨГЧИЙГ БҮРТГЭХ, ТАТВАР НОГДУУЛАХ, ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ

25 дугаар зүйл.Татвар төлөгчийн бүртгэл

- 25.1.Татварын хуулиар татвар төлөх, эсхүл татвар суутгах үүрэг бүхий этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлнэ.
- 25.2.Дараах хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэж татвар төлөгчийн дугаар олгоно:
- 25.2.1.Монгол Улсын иргэн;
- 25.2.2.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.5-д заасан гадаадын иргэн.
- 25.3.Татвар төлөгчийг бүртгэхдээ энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.
- 25.4.Татвар төлөгчийг бүртгэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулна.
- 25.5.Оршин суугч бус этгээдийг түүний оршин суугчийн гэрчилгээг үндэслэн бүртгэнэ.

26 дугаар зүйл.Татвар төлөгчийг бүртгэх нийтлэг журам

- 26.1.Энэ хуулийн 25.1-д заасан татвар төлөх үүрэг бүхий этгээдийг татварын алба татвар төлөгчөөр татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.
- 26.2.Татварын алба бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээллийг үндэслэн шинээр байгуулагдсан, бүртгэгдсэн этгээдийг бүртгэн, татвар төлөгчийн дугаар, гэрчилгээ олгож хувийн хэргийг үүсгэнэ.
- 26.3.Татвар ногдох зүйлийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, эсхүл татвар ногдох зүйл бүхий этгээд, татвар төлөгчид олгосон болон өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээллийг бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээлэл, эсхүл татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн татварын алба тухай бүр татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.
- 26.4.Татвар төлөгч нь татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл, түүний өөрчлөлт, энэ хуулийн 26.2, 26.3-т заасан мэдээллийг 7 хоногийн дотор татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд өөрөө бүртгүүлэх, эсхүл татварын албанаас мэдэгдсэнээр мөн хугацаанд баталгаажуулах үүргийг хүлээж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлнэ.
- 26.5.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд байгаа татвар төлөгчийн мэдээлэл тухайн татвар төлөгчид нээлттэй байх ба мэдээллийн үнэн зөвийг татвар төлөгч хариуцна.

- 26.6.Энэ хуулийн 26.3, 26.4-т заасан мэдээллийг татварын алба бусад хөндлөнгийн мэдээлэлд үндэслэн өөрчлөх шаардлагатай гэж үзвэл татвар төлөгчид мэдэгдэх бөгөөд татвар төлөгч энэ хуулийн 26.4-т заасан хугацаанд баталгаажуулна. Татвар төлөгч баталгаажуулаагүй тохиолдолд эрсдэлтэй гэж үзэн хувийн хэрэгт бүртгэх бөгөөд хяналт шалгалт хийх үндэслэл болно.
- 26.7.Татвар төлөгчийн бүртгэлийн журмыг татварын болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.
- 26.8.Монгол Улсын хуулийн этгээд нь гадаад улсад байгуулсан салбар, төлөөлөгчийн болон төлөөний газрыг татварын албанд бүртгүүлэх үүрэгтэй.
- 26.9.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч Монгол Улсын иргэн нь гадаад улсад байгуулсан хуулийн этгээдийн нэр, хаягийг тухайн татварын жилд багтаан татварын албанд мэдэгдэх үүрэгтэй.
- 26.10.Ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээд өөрийн эцсийн эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албанд бүртгүүлнэ.
- 26.11.Ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч өөрийн эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн тухай мэдээллийг шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор харьяалах татварын албанд бүртгүүлнэ.
- 26.12.Энэ хуулийн 26.11-д заасныг үл харгалзан, өөрийн болон эцсийн эзэмшигчийн хувьцаа гадаад, дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг бол ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч өөрийн эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн тухай мэдээллийг татварын албанаас баталсан маягтын дагуу тухайн жилийн 07 дугаар сарын 20-ны өдөрт багтаан, жилийн эцсийн мэдээллийг дараагийн татварын жилийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харьяалах татварын албанд бүртгүүлнэ.

27 дугаар зүйл.Харилцан хамааралтай этгээд

- 27.1.Нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой доор дурдсан этгээдийг хоорондоо харилцан хамааралтай этгээд гэж үзнэ:
- 27.1.1.татвар төлөгчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, хүүхэд, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ болон эхнэр /нөхөр/, хамтран амьдрагч, тэдгээрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү;
- 27.1.2.энэ хуулийн 6.1.8-д заасан группт хамаарах этгээд;

- 27.1.3.хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд;
- 27.1.4.ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй этгээд;
- 27.1.5.хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар эзэмшдэг аж ахуйн нэгж;
- 27.1.6.ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй аж ахуйн нэгж;
- 27.1.7.энэ хуулийн 27.1.1-д заасан этгээдийн шууд болон шууд бус эзэмшил дэх энэ хуулийн 27.1.3, 27.1.4, 27.1.5, 27.1.6-д заасан харилцаа бүхий этгээд;
- 27.1.8.энэ хуулийн 27.1-д заасан этгээд, тэдгээрийг томилох эрхтэй этгээд, тэдгээрийн эрх, үүргийг шилжүүлэн хүлээж авсан этгээд, эсхүл тэдгээрийг төлөөлөхөөр сонгогдсон этгээд;
- 27.1.9.энэ хуулийн 27.1-д заасан этгээд болон харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжийн салбар, төлөөний газар зэрэг;
- 27.1.10.Монгол Улсад оршин суугч татвар төлөгчийн татвар ногдуулах орлогыг бууруулах, алдагдлыг өсгөх үндсэн зорилгоор харилцаа тогтоосон этгээд;
- 27.1.11.энэ хуулийн 27.1-д заасантай адилтгах бусад этгээд.
- 27.2.Хувь нийлүүлэгчид шууд болон шууд бусаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны шийдвэр гаргахад нэгдмэл байр суурьтай оролцохоор хэлцэл байгуулж, уг хэлцлийн үндсэн дээр шийдвэр гаргадаг бол тухайн хувь нийлүүлэгч этгээдийг энэ хуулийн 27.1.3, 27.1.4, 27.1.5, 27.1.6-д заасан хувь, оролцооны хувьд нэг этгээд гэж үзнэ.
- 27.3.Шууд бус оролцоог тодорхойлохдоо шууд оролцооны хувиудын үржвэрээр тодорхойлно. Шууд оролцоо нь 50 хувиас дээш байвал 100 хувийн оролцоотой гэж үзнэ.

28 дугаар зүйл.Татвар ногдуулалт, төлөлт

- 28.1.Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө.
- 28.2.Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт

бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.

- 28.3.Татвар төлөгч анхан шатны баримт бүрдүүлээгүй болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд холбогдоогүйгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгүй, эсхүл татвар ногдуулах орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардлыг тодорхойлохдоо бодит бус үнэ хэрэглэсэн тохиолдолд татварын алба татварын ногдлыг жишиг үнийн, эсхүл үнэ шилжилтийн тохируулга хийх аргаар тодорхойлж, холбогдох татварыг ногдуулна.
- 28.4.Татвар төлөгч татвар ногдох эд хөрөнгө, эрхийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн болон шилжүүлж авсан тухай баримтыг шилжүүлсэн тухай бүрд татварын албанд гаргаж өгөх үүрэгтэй.
- 28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.
- 28.6.Татвар ногдуулах, суутган авах, төсөвт төлөх үүргийг хуулиар хүлээсэн этгээдэд үүргээ гүйцэтгэснийх нь төлөө хөлс төлөхгүй.
- 28.7.Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.
- 28.8.Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө.
- 28.9.Татвар ногдуулалт, төлөлтэй холбогдсон харилцааг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулна.
- 28.10.Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан заавар, аргачлал, маягт, дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

29 дүгээр зүйл.Татварын тайлан үйлдэх, тушаах

29.1.Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. Татвар төлөгч дараах үүргийг хүлээнэ:

29.1.1.анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх;

29.1.2.татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ гаргаж, тогтоосон хугацаанд татварын албанд хүргүүлэх;

- 29.1.3.суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах;
- 29.1.4.татварын тайлантай холбоотой баримт, мэдээллийг гадаад хэл дээр үйлдсэн бол монгол хэл дээр орчуулах бөгөөд ийнхүү орчуулахтай холбогдсон зардлыг татвар төлөгч өөрөө хариуцах;
- 29.1.5.татвар төлөгч болон түүний баримтыг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх үүрэг хүлээсэн этгээд нь уг баримт, бүртгэлийг татвар төлөх хөөн хэлэлцэх хугацаа дуустал Монгол Улсын нутаг дэвсгэрт хадгалах;
- 29.1.6.татварын тайланд тусгах, бүртгэх төлбөр тооцоо гадаад валютаар хийгдсэн тохиолдолд тухайн гүйлгээ хийсэн өдрийн Монголбанкны албан ханшаар тооцож төгрөгөөр илэрхийлэх.
- 29.2.Татварын тайлан тушаах, татвар төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол татвар төлөх, тайлагнах хугацаа адил байна.
- 29.3.Татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа долоо хоног бүрийн Бямба, Ням гараг, нийтээр тэмдэглэх баярын өдөртэй давхацсан тохиолдолд түүний өмнөх ажлын өдөр нь татвар төлөх, тайлагнах эцсийн өдөр байна.
- 29.4.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга шаардлагатай тохиолдолд тайлан хүлээн авах хугацааг 7 хоног хүртэлх хугацаагаар сунгаж болох бөгөөд энэ тухайгаа олон нийтэд урьдчилан мэдэгдэнэ.
- 29.5.Хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч татварын тайлан тушаах үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд уг татварын тайлан нь түүнийг тухайн төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах үндсэн баримт болно.
- 29.6.Татварын тайланд эрх бүхий албан тушаалтан, татвар төлөгч хувь хүн, эсхүл түүний хууль ёсны болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, уг тайланг гаргасан буюу гаргахад оролцсон этгээд гарын үсэг зурна.
- 29.7.Цахим хэлбэрээр татварын албанд илгээсэн татварын тайланг цахим гарын үсгээр баталгаажуулсан байх бөгөөд баталгаажуулаагүй тохиолдолд цаасан хэлбэрээр тушаана.
- 29.8.Цахим баримтыг тодорхойлох, түүнд тавих шаардлагыг тогтоох, цахим баримтыг хадгалах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

30 дугаар зүйл.Татварын тайлан хүлээн авах, тайлангийн боловсруулалт хийх

- 30.1.Татварын алба татвар төлөгч татварын тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд тушааж, татвараа үнэн зөв ногдуулж, төлж байгаа эсэхэд хяналт тавина.

- 30.2.Татварын алба тайланг хүлээн авахдаа татвар төлөгч татварын ногдуулалт, төлөлтийг үнэн зөв тодорхойлсон эсэхийг дараах байдлаар хянан, боловсруулалт хийнэ:
- 30.2.1.тайланг батлагдсан маягт, зааврын дагуу засваргүй үйлдэж, татвар төлөгч болон холбогдох бусад этгээд гарын үсэг болон тамга, тэмдэг дарж баталгаажуулсан, эсхүл цахимаар холбогдох журмын дагуу илгээсэн эсэх;
- 30.2.2.тайланг хуулиар тогтоосон хугацаанд тушаасан эсэх;
- 30.2.3.тайлангийн хавсралт баримт мэдээлэл бүрэн эсэх;
- 30.2.4.хуулийн этгээдийн хувьд нягтлан бодох бүртгэл, хувь хүний хувьд орлого, татварын бүртгэлийн дэвтэр болон холбогдох бусад баримтыг үндэслэн тайлангаа гаргасан эсэх;
- 30.2.5.нягтлан бодох бүртгэл болон татварын тайлангийн үзүүлэлтүүд хоорондоо тохирч байгаа эсэх;
- 30.2.6.татварын тайлан хоорондын үзүүлэлтийн дүн болон тайланд хавсаргасан баримт, мэдээллийн дүн тайлагнасан дүнтэй тохирч байгаа эсэх, тооцооны алдаа байгаа эсэх;
- 30.2.7.тайланд тусгасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэн тооцож, тодорхойлсон эсэх;
- 30.2.8.тайланд тусгасан татварын тооцооны үлдэгдэл болон тухайн тайлангийн хугацаанд төлсөн татварын дүн татварын албаны бүртгэлтэй тохирч байгаа эсэх;
- 30.2.9.тухайн тайлангийн хугацаанд хамаарах татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн хөндлөнгийн мэдээлэл татварын тайлангийн мэдээлэлтэй тохирч байгаа эсэх.
- 30.3.Татварын алба энэ хуулийн 30.2-т заасны дагуу тайланг хянах бөгөөд мэдээлэл зөрүүгүй тохиолдолд тайланг хүлээж авах бөгөөд шаардлагатай тохиолдолд анхан шатны болон холбогдох бусад баримтыг шаардаж болно.
- 30.4.Татварын алба энэ хуулийн 30.2-т заасны дагуу тайланг хянаж мэдээллийн зөрүү илэрвэл илрүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор мэдээллийн зөрүүг залруулах шаардлагыг татвар төлөгчид хүргүүлнэ.
- 30.5.Татвар төлөгч энэ хуулийн 30.4-т заасан шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан шаардлагад заасан зөрүүг арилгаж, залруулсан тайланг тушаах үүрэгтэй бөгөөд татварын алба тайланг хүлээн авна.
- 30.6.Татвар төлөгч шаардлагыг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай тайлбараа цахимаар, эсхүл бичгээр гаргаж, энэ хуулийн 30.5-д заасан хугацаанд багтаан татварын албанд ирүүлнэ.

- 30.7.Энэ хуулийн 30.6-д заасны дагуу татвар төлөгчөөс ирүүлсэн тайлбарыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан тайланг хүлээн авна.
- 30.8.Энэ хуулийн 30.6-д заасан тайлбарыг хугацаанд нь ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тайлбар нь үндэслэлгүй гэж үзвэл татварын алба холбогдох мэдээллийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх бөгөөд энэ нь тайлангийн хугацаанд хамаарах татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой асуудалд татварын хяналт шалгалт хийж тайлангийн ногдлыг тодорхойлох үндэслэл болно.
- 30.9.Тайлангийн боловсруулалт хийх хугацаанд тайланг хүлээн аваагүй нь алданги тооцохгүй байх үндэслэл болохгүй.
- 30.10.Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.
- 30.11.Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, тайлан нөхөх заавар, зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

31 дүгээр зүйл.Татварын тайланд залруулга хийх

- 31.1.Татвар төлөгч татварын тайланг дараагийн татварын жилд багтаан залруулж болно.
- 31.2.Хэрэв татвар төлөгч татварын тайлангийн ногдлыг бууруулах залруулга хийх бол уг залруулгыг нотлох анхан шатны болон холбогдох бичиг баримтын хамт залруулсан тайланг ирүүлнэ.
- 31.3.Татварын алба залруулсан тайланг хүлээн авахдаа энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 31.4.Татварын хяналт шалгалт хийхээр татвар төлөгчид мэдэгдсэнээс хойш энэ хуулийн 31.1-д заасан тайлангийн залруулгыг хийхгүй.
- 31.5.Татвар төлөгчийн хүсэлтээр тайланд залруулга хийсэн нь хуульд заасан хугацаанд төлөөгүй татварын алдангиас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 31.6.Тайлангийн ногдлыг бууруулах залруулга хийсэн нь түүнийг хийхээс өмнө тооцсон алдангийн хэмжээг өөрчлөх үндэслэл болохгүй.

ДОЛДУГААР БҮЛЭГ ТАТВАРЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

32 дугаар зүйл.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

- 32.1.Татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна. Татварын алба чиг үүргээ хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор мэдээллийн систем, технологийг ашиглах бөгөөд тэдгээрийн нууцлал, найдвартай байдлыг бүрэн хангаж ажиллана.
- 32.2.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан дараах зориулалттай байна:
- 32.2.1.татвар төлөгч болон татварын тайлан, ногдуулалт, төлөлт, татварын өрийг бүртгэх, хяналт тавих;
 - 32.2.2.татварын хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэх;
 - 32.2.3.татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдүүлэх;
 - 32.2.4.татварын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
 - 32.2.5.татвар төлөгчдөд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах;
 - 32.2.6.татварын албаны үйл ажиллагаанд болон татвар төлөгчид учирч болох эрсдэлийг тодорхойлох;
 - 32.2.7.татварын удирдлага, түүний дотор мэдээллийн удирдлагын зардлыг багасгах, хөнгөн шуурхай, үр ашигтай, ил тод тайлагналыг хангах.
- 32.3.Татварын алба холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн бусад байгууллагын болон гадаад, дотоод мэдээллийн эх үүсвэрийг ашиглаж болно.
- 32.4.Татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг бүртгэх, баяжуулах, түүний аюулгүй байдал, мэдээлэл ашиглалтад хяналт тавьж ажиллана.

33 дугаар зүйл.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөглөх

- 33.1.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд дараах мэдээлэл хамаарна:
- 33.1.1.татвар төлөгчийн бүртгэл, түүний өөрчлөлтийн мэдээлэл;
 - 33.1.2.татвар, алданги, торгуулийн бүртгэл;
 - 33.1.3.татварын тайлан, мэдээ, цахим төлбөрийн баримтын системийн мэдээлэл;
 - 33.1.4.татварын улсын байцаагчийн үйлдсэн баримт бичиг, түүний биелэлтийн мэдээлэл;
 - 33.1.5.татварын Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийн мэдээлэл;
 - 33.1.6.татварын зөрчил, маргааныг хянаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн мэдээлэл;
 - 33.1.7.холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээлэл;
 - 33.1.8.хууль, журмын дагуу төрийн мэдээллийн нэгдсэн сангаас авсан мэдээлэл;
 - 33.1.9.хөндлөнгийн мэдээлэл;

- 33.1.10. татварын хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичиг;
 - 33.1.11. татварын албаны хүний нөөц, төсөв, хөрөнгийн мэдээлэл;
 - 33.1.12. татварын өр, өр барагдуулалт, хураалтын үйл ажиллагааны мэдээлэл.
- 33.2. Татварын алба нь энэ хуулийн 33.1.2-г заасан бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөх бөгөөд татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдол, хөнгөлөлт, чөлөөлөлт, алданги, торгууль, тэдгээрийн төлөлт, өрийг анхан шатны баримтад үндэслэн татварын бүртгэлд бүрэн тусгана.
- 33.3. Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах, ашиглалтад хяналт тавих журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

34 дүгээр зүйл. Бусад байгууллагаас мэдээлэл гаргуулах, хамтран ажиллах

- 34.1. Татварын алба татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийг татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэл, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах бөгөөд энэ хуулийн 34.3, 34.4, 34.5, 34.6, 34.7, 34.8, 34.9, 34.10, 34.11, 34.12, 34.13, 34.14, 34.15, 34.16, 34.17, 34.18, 34.19, 34.20, 34.21, 34.22, 34.23, 34.24, 34.25, 34.26, 34.27-д заасан байгууллага, албан тушаалтан татварын албанд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, татварын зорилгоор хамтран ажиллах үүрэг хүлээнэ.
- 34.2. Байгууллага, албан тушаалтан татварын албаны хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор энэ хуулийн 34.3, 34.4, 34.5, 34.6, 34.7, 34.8, 34.9, 34.10, 34.11, 34.12, 34.13, 34.14, 34.15, 34.16, 34.17, 34.18, 34.19, 34.20, 34.21, 34.22, 34.23, 34.24, 34.25, 34.26, 34.27-д заасан мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлэх бөгөөд хугацааг тусгайлан өөрөөр заагаагүй бол сар бүрийн 10-ны өдрийн дотор татварын албанд тогтмол мэдээлэх үүрэг хүлээнэ.
- 34.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага татвар төлөгчид хамааралтай санхүүгийн тайлангийн мэдээлэл, гадаадын санхүүжилттэй төсөл арга хэмжээ, төрийн сангийн зарцуулалтын мэдээлэл, тусгай зөвшөөрлийн мэдээллийг тухай бүр татварын албанд хүргүүлнэ.
- 34.4. Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.4.1. татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр;
 - 34.4.2. татвар төлөгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллагад

- шинээр төлбөр тооцоо, хадгаламжийн болон бусад төрлийн данс нээсэн, эсхүл өмнө нээсэн дансанд өөрчлөлт, хөдөлгөөн хийлгэсэн бол энэ тухай мэдээллийг тухай бүр;
- 34.4.3. татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн.
- 34.5. Цагдаагийн байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.5.1. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон өөрт байгаа хувь хүний нууцад үл хамаарах мэдээ, судалгааг татварын албаны хүсэлтээр;
- 34.5.2. галт зэвсэг эзэмшигчийн болон галт зэвсгийн шилжилт хөдөлгөөн, хасалтын талаарх мэдээлэл, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдан авах, улсын хилээр нэвтрүүлэх, зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийг;
- 34.5.3. гэрээт харуул хамгаалалтын тусгай зөвшөөрлийн мэдээллийг;
- 34.5.4. жолооч бэлтгэх авто сургууль, курсын болон жолоодох эрхийн бүртгэлийн мэдээллийг;
- 34.5.5. татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг.
- 34.6. Цагдаагийн байгууллага татвар төлөхөөс зугтаж, оргон зайлсан татвар төлөгчийн хаягийг тогтоох, эрэн сурвалжлахад татварын албатай хамтарч ажиллана.
- 34.7. Гаалийн байгууллага нь татвар төлөгчийн дугаарыг гаалийн мэдүүлэгт тусгуулж, тухайн татвар төлөгчийн экспорт, импортын үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлнэ.
- 34.8. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.8.1. Монгол Улсын иргэний улсын бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- 34.8.2. Монгол Улсад бүртгэлтэй эд хөрөнгийн эрхийн улсын дэлгэрэнгүй бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээлэл;
- 34.8.3. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл, өөрчлөлттэй холбоотой мэдээлэл.
- 34.9. Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ.

- 34.10.Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.10.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суугаа хаяг, Монгол Улсын хилээр орсон, гарсан хугацааны болон түүнийг урьсан этгээдийн мэдээлэл, мөн хөрөнгийн баталгааны мэдээллийг;
- 34.10.2.гадаадын хөрөнгө оруулалттай төрийн бус байгууллагын бүртгэл, өөрчлөлтийн талаарх мэдээллийг.
- 34.11.Төрийн захиргааны төв, орон нутгийн бусад байгууллага, тэдгээрийн удирдах албан тушаалтан дараах үүрэг хүлээнэ:
- 34.11.1.татварын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулж, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- 34.11.2.хяналт шалгалт хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь албан үүргээ биелүүлэх явцад татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээлэл олж мэдсэн, илрүүлсэн бол уг мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлэх;
- 34.11.3.тусгай зөвшөөрлийн бүртгэл, өөрчлөлтийн мэдээлэл, нөөц хөрөнгө болон сангуудаас олгосон санхүүжилтийн мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлэх;
- 34.11.4.татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, шаардлагатай бусад мэдээллээр татварын албыг хангаж, хамтран ажиллах.
- 34.12.Хөрөнгийн бирж дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.12.1.хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчийн тархалтын тухай мэдээлэл;
- 34.12.2.хувьцаат компанийн хувьцааны борлуулалтын талаарх мэдээлэл.
- 34.13.Санхүүгийн зохицуулах хороо дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.13.1.тус хорооноос олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг тухай бүр;
- 34.13.2.үнэт цаасны арилжааны мэдээллийг тухай бүр;
- 34.13.3.тус хороонд бүртгэлтэй санхүүгийн зах зээлд ажиллах эрх бүхий иргэний бүртгэл, дэлгэрэнгүй мэдээлэл.
- 34.14.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.14.1.үнэт цаасны бүртгэл, өөрчлөлтийн болон төлбөр тооцооны мэдээлэл;
- 34.14.2.төвлөрсөн хадгаламжийн дансны өөрчлөлтийн мэдээлэл;

- 34.14.3.хувьцаат компаниудын ногдол ашгийн олголтын мэдээлэл.
- 34.15.Ашигт малтмал, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.15.1.ашигт малтмал болон газрын тосны чиглэлээр холбогдох мэдээлэл;
- 34.15.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчтэй холбоотой болон стратегийн ач холбогдол бүхий ордын мэдээлэл.
- 34.16.Улсын хил хамгаалах байгууллага татварын албаны хүсэлтийн дагуу Монгол Улсын хилээр нэвтэрсэн иргэний талаарх мэдээллийг гаргаж, хүргүүлнэ.
- 34.17.Авто тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Монгол Улсын автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, түүний өөрчлөлтийн талаарх мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ.
- 34.18.Автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага татварын албаны автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажилд дэмжлэг үзүүлж, хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулна.
- 34.19.Монголбанк дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.19.1.алт тушаалтын мэдээлэл, зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг тухай бүр;
- 34.19.2.мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй холбогдох татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг, татварын хууль тогтоомж зөрчихтэй холбоотойгоор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдийн 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг татварын албатай байгуулах мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах гэрээний дагуу.
- 34.20.Сорьцын улсын хяналтын алба алт тушаалт болон бусад шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлнэ.
- 34.21.Нотариат болон гэрээ, хэлцлийг бүртгэх чиг үүрэг бүхий бусад этгээд татвар ногдох зүйлтэй холбоотой гэрээ, хэлцэл, гүйлгээ хийгдсэн талаарх мэдээллийг гаргаж татварын албанд хүргүүлнэ.
- 34.22.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газрын төлбөр төлөгчийн, газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийн бүртгэл, газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн болон газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулалттай холбоотой мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албатай харилцан мэдээлэл солилцоно.
- 34.23.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн

- дэлгэрэнгүй мэдээллийг татварын албанд тухай бүр цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 34.24.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг татварын албанд тухай бүр цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 34.25.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ:
- 34.25.1.хуульд заасан чиг үүргийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, худалдан авах ажиллагаанд оролцсон хувь хүн, хуулийн этгээдийн мэдээлэл, төсөвт өртөг, гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- 34.25.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.
- 34.26.Барилга хот байгуулалт, газар, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ.
- 34.27.Төрийн байгууллага, төр, орон нутгийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шаардлагатай мэдээллийг татварын албаны шаардсан даруйд гаргаж, хүргүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ТАТВАРЫН АЛБАНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

35 дугаар зүйл.Татварын албаны эрсдэлийн удирдлага

- 35.1.Татварын алба нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад татварын харилцаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 35.2.Татварын алба нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:
- 35.2.1.Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд татварын алба өмнөө тавьсан зорилгодоо хүрэх, түүний хэрэгжилтийг хангахад хамгийн бага эрсдэлтэй байхад чиглэх;
- 35.2.2.эрсдэлийн удирдлага нь нэгдмэл, тасралтгүй байх;
- 35.2.3.эрсдэлийн удирдлага нь байгууллагын төлөвлөлт, шийдвэр гаргалтын нэг хэсэг болох;

- 35.2.4.эрсдэлийн удирдлага нь байгууллагын нөөцийн үр ашигтай зөв хуваарилалт, хэмнэлттэй байдлыг бий болгоход чиглэх.
- 35.3.Татварын албаны эрсдэлийн удирдлага гэж татварын харилцаанд оролцогчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үйлдэл, эс үйлдэл, нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлон шинжлэх, шалтгаан нөхцөлийг нь тогтоох, үнэлэх, улмаар шийдвэрлэх оновчтой арга замыг сонгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн тасралтгүй, цогц үйл ажиллагааг хэлнэ.
- 35.4.Татварын алба нь эрсдэлийн удирдлагын арга хэмжээг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:
- 35.4.1.нөхцөл байдлыг тодорхойлох;
 - 35.4.2.эрсдэлийг тодорхойлж, бүртгэх;
 - 35.4.3.эрсдэлийг үнэлэх, шинжлэх;
 - 35.4.4.эрсдэлийг удирдах ба хяналтын арга хэмжээг тодорхойлох;
 - 35.4.5.эрсдэлийн удирдлагын үйл явцыг хянах.
- 35.5.Татварын албаны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь татварын хууль тогтоомжийн хүрээнд татварын албаны удирдлага, мэргэжил арга зүйн үйл ажиллагаанд ашиглагдах тооцооллын цахим системд тулгуурласан үйл ажиллагааны иж бүрдэл юм.
- 35.6.Энэ хуулийн 35.4.3-т заасан эрсдэлийн үнэлгээ, шинжилгээг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн хийнэ.
- 35.7.Эрсдэл тооцох шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, өөрчлөх, хүчингүй болгох талаар хэлэлцэх, татварын албаны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, бууруулах, хэрэгжилтийг нь хянах, эрсдэлийн шинжилгээний үр дүнтэй танилцах ажлыг хэрэгжүүлэх, энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын хороо ажиллана.
- 35.8.Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны даргын тушаалаар томилж, чөлөөлөх бөгөөд уг хороонд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулна.
- 35.9.Эрсдэлийн үнэлгээ, шинжилгээнд ашиглагдах шалгуур үзүүлэлтийг татварын хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох бөгөөд Эрсдэлийн удирдлагын хороогоор хэлэлцүүлсний үндсэн дээр, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.
- 35.10.Энэ хуулийн 35.4.3-т заасан эрсдэлийн үнэлгээ, шинжилгээний үр дүнг үндэслэн татварын хяналт, шалгалтад хамруулах татвар төлөгчийг сонгоно.

35.11.Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны журмыг эрсдэлийн удирдлагын стандартад нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

36 дугаар зүйл.Татварын ногдлыг тодорхойлох боломжгүй байх

36.1.Татвар төлөгчийн татварын ногдлыг үнэн зөв тодорхойлох боломжгүй тохиолдолд татварын алба татвар төлөгчийн татварын ногдлыг жишиг үнийн аргаар тооцоолж, нөхөн ногдуулалтын акт үйлдэнэ.

36.2.Татварын алба дараах үндэслэлээр татварын ногдлыг өөрт байгаа мэдээлэлд үндэслэн жишиг үнийн аргаар тодорхойлно:

36.2.1.татвар төлөгч хуульд заасны дагуу тайлан, бүртгэл хөтлөөгүй;

36.2.2.татвар төлөгч тайлан, бүртгэлийг дутуу буюу буруу хөтөлсөн;

36.2.3.татвар төлөгчийн тайлан, бүртгэл алдагдсан буюу устсан;

36.2.4.татвар төлөгчийн татварын тайлангийн үзүүлэлт нь санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй харьцуулахад татварын ногдол дутуу тодорхойлогдсон нь илт байгаа;

36.2.5.татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдоогүй.

36.3.Татварын ногдлыг жишиг үнийн аргаар тодорхойлох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37 дугаар зүйл.Үнэ шилжилтийн ерөнхий зарчим

37.1.Хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөлийг бие даасан ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулахад орлого, ашиг болон татварын суурьд нөлөөлөх үзүүлэлтүүд нь ялгаатай бөгөөд үүнээс хамаарч татварын суурь буурсан бол уг буурсан дүнгийн зөрүүгээр татварын суурийг нэмэгдүүлж, холбогдох татварыг нөхөн ногдуулна.

37.2.Хяналтад байгаа ажил гүйлгээнд хамаарах татварын суурь нь түүнтэй харьцуулагдах бие даасан ажил гүйлгээнд хамаарах татварын сууриас багагүй байна.

37.3.Энэ хуулийн 37.2-т зааснаар хяналтад байгаа ажил гүйлгээний татварын суурийг тодорхойлохдоо уг ажил гүйлгээтэй харьцуулагдаж болох бие даасан ажил гүйлгээний нөхцөлтэй нийцэж байгаа эсэхийг дараах байдлаар тогтооно:

37.3.1.ажил гүйлгээний үнэ, нөхцөл;

37.3.2.ажил гүйлгээ хийх бодит шаардлага байсан эсэх;

37.3.3.талууд харилцан хүлээсэн үүргээ биелүүлсэн, эсхүл бодит ажил гүйлгээ хийгдсэн эсэх.

37.4.Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн гэрээний нөхцөл болон бодит гүйцэтгэлийн хооронд зөрүү үүссэн тохиолдолд гэрээний талуудын оролцоо,

чиг үүрэг, гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгө, хүлээсэн эрсдэл зэрэг бодит гүйцэтгэлийг харгалзан татварын суурьт тохируулга хийнэ.

38 дугаар зүйл. Үнэ шилжилтийн тайлан

38.1. Үнэ шилжилтийн тайланг дараах байдлаар ангилна:

38.1.1. үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайлан;

38.1.2. дотоод үнэ шилжилтийн тайлан;

38.1.3. ерөнхий үнэ шилжилтийн тайлан;

38.1.4. улс бүрээр тайлан.

38.2. Татвар төлөгч хяналтад байгаа ажил гүйлгээний мэдээллийг хадгалах, тайлагнах үүрэг хүлээнэ.

38.3. Татвар төлөгч татварын хяналт шалгалт хийхээс өмнө болон хийгдэх үед үнэ шилжилтийн тайлантай холбогдох татварын албаны шаардсан нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгнө.

38.4. Татвар төлөгч үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайланг жилийн эцсийн татварын тайлангийн хамт харьяалах татварын албанд хүргүүлнэ.

38.5. Дотоод үнэ шилжилтийн тайлан дараах мэдээллийг агуулна:

38.5.1. Монгол Улсад байрладаг татвар төлөгч, эсхүл төлөөний газрын бизнесийн үйл ажиллагаа болон бизнесийн стратеги, бодлогын талаарх мэдээлэл;

38.5.2. хяналтад байгаа ажил, гүйлгээний харьцуулагдах байдлын шинжилгээ хийхэд шаардагдах мэдээлэл, харьцуулагдах боломжтой бие даасан ажил гүйлгээний мэдээлэл, ашигласан үнэ шилжилтийн аргачлал болон холбогдох бусад мэдээлэл;

38.5.3. Монгол Улсад байрладаг татвар төлөгчтэй холбогдох ажил, гүйлгээний санхүүгийн мэдээлэл;

38.5.4. энэ хуулийн 38.9-д заасан журамд шаардагдах бусад мэдээлэл.

38.6. Ерөнхий үнэ шилжилтийн тайлан дараах мэдээллийг агуулна:

38.6.1. групп болон группийн оролцогчдын хувьцаа, хувь оролцооны шууд болон шууд бус эзэмшлийн бүтэц;

38.6.2. групп болон группийн оролцогчдын үйл ажиллагаа явуулж байгаа газар зүйн байрлал;

38.6.3. бизнесийн үндсэн үйл ажиллагаа, борлуулалт, худалдан авалт, нийлүүлэлтийн суваг, нэмүү өртөг үүсгэхэд ашиглагдаж байгаа голлох хөрөнгө, групп болон группийн оролцогчдын үйл ажиллагааны чиг үүрэг, хүлээх эрсдэл, тухайн санхүүгийн жилд гарсан бүтцийн өөрчлөлтөд нөлөөлсөн томоохон ажил гүйлгээний мэдээлэл;

- 38.6.4.групп болон группийн оролцогчдын эзэмшиж байгаа биет бус хөрөнгө, тэдгээрийн эзэмшлийн бүтэц, биет бус хөрөнгөтэй холбогдуулан баримталж байгаа үнэ шилжилтийн бодлого;
- 38.6.5.групп болон группийн оролцогчдын хооронд хийгдсэн санхүүгийн ажил гүйлгээ болон үүнтэй холбогдуулан баримталж байгаа үнэ шилжилтийн бодлого;
- 38.6.6.групп, түүний оролцогчид, эсхүл тухайн татвар төлөгчийн санхүүгийн болон татварын асуудлаар баримталж байгаа бодлого, бусад улсын татварын албатай байгуулсан нэг болон хоёр талт үнэ урьдчилан тохиролцох гэрээний мэдээлэл;
- 38.6.7.харилцан хамааралтай этгээдийн энэ хуулийн 38.6.1, 38.6.2, 38.6.3, 38.6.4, 38.6.5, 38.6.6-д заасантай адилтгах болон энэ хуулийн 38.9-д заасан журамд шаардагдах мэдээлэл.
- 38.7.Улс бүрээр тайлан гаргах этгээд, тайлагнах нарийвчилсан харилцааг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар зохицуулна.
- 38.8.Дараах татвар төлөгч энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан тайланг жилийн эцсийн татварын тайлангийн хамт харьяалах татварын албанд хүргүүлнэ:
- 38.8.1.өмнөх татварын жилд зургаа болон түүнээс дээш тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон;
- 38.8.2.группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд үйл ажиллагаа нь тусгагддаг бөгөөд өмнөх татварын жилд нэгтгэсэн санхүүгийн тайлангаар тус групп нь зургаа болон түүнээс дээш тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон;
- 38.8.3.гадаадын хөрөнгө оруулалттай.
- 38.9.Энэ хуулийн 38.1-д заасан үнэ шилжилтийн тайлан тус бүрийн маягтын загвар, түүнийг нөхөх заавар, тайлагнах нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, жишиг баримт бичгүүдэд нийцүүлэн татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

39 дүгээр зүйл. Үнэ шилжилтийн тохируулга хийх

- 39.1.Татвар төлөгч нь үнэ шилжилтийн тайлан гаргаагүй, эсхүл татварын ногдлоо дутуу тодорхойлж тайлагнасан бол татварын алба нь үнэ шилжилтийн үндсэн тохируулга хийж, татварыг нөхөн ногдуулж, хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.
- 39.2.Татварын алба энэ хуулийн 39.1-д заасан үндсэн тохируулгыг хийхээс гадна хувь хүний орлогын албан татвар болон аж ахуй нэгжийн орлогын албан

татварын зорилгоор тохируулгын үр дүнд бий болсон үнийн зөрүүг ногдол ашиг гэж үзэж хоёрдогч тохируулгыг хийнэ.

40 дүгээр зүйл. Үнэ шилжилтийн тохируулга хийх аргачлал

40.1. Үнэ шилжилтийн тохируулга хийхэд дараах аргыг ашиглана:

40.1.1. харьцуулагдах бие даасан үнийн арга;

40.1.2. дамжуулан борлуулах үнийн арга;

40.1.3. өртөг дээр нэмэх арга;

40.1.4. ажил гүйлгээний цэвэр ашгийн арга;

40.1.5. ажил гүйлгээний ашиг хуваах арга;

40.1.6. энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан үнэ шилжилтийн ерөнхий зарчимд нийцсэн бусад арга.

40.2. Татварын алба энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан үнэ шилжилтийн тохируулгыг хийхдээ энэ хуулийн 40.1-д заасан аргаас хамгийн тохиромжтой гэж үзсэн аргыг ашиглах бөгөөд доор дурдсан нөхцөлийг харгалзан бодит үнэ тодорхойлох зарчимд үндэслэн тогтооно:

40.2.1. хяналтад байгаа ажил гүйлгээний онцлог;

40.2.2. энэ хуулийн 37.3-т заасан нөхцөл;

40.2.3. бие даасан гүйлгээтэй харьцуулж болохуйц бодит мэдээлэл, нөхцөл;

40.2.4. хяналтад байгаа болон бие даасан ажил гүйлгээний харьцуулагдах түвшин.

40.3. Хяналтад байгаа ажил гүйлгээнд тохируулга хийх аргыг сонгоход уг аргын давуу болон сул талыг харьцуулах замаар энэ хуулийн 40.1-д заасан аргыг дангаар, эсхүл хослуулж ашиглана.

40.4. Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

40.5. Татварын хууль тогтоомж болон энэ хуулийн 40.4-т заасан журмаар зохицуулаагүй, энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичигтэй зөрчилдөөгүй тохиолдолд татварын алба үнэ шилжилтийн тохируулга хийхдээ “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан Үнэ шилжилтийн зөвлөмж”-ийг ашиглаж болно.

40.6. Татвар төлөгч нь үл мэдээлэгч улсын жагсаалтад байгаа улсын хуулийн этгээдтэй хяналтад байгаа ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн, эсхүл энэ хуулийн 39.1-д заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл үнэ шилжилтийн тайланг буруу мэдээлсэн тохиолдолд татварын алба дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 40.6.1. татвар төлөгчтэй харьцуулагдах өөр бусад татвар төлөгчийн нээлттэй мэдээлэлд үндэслэн, эсхүл татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас сонгож харьцуулах замаар нөхөн ногдуулалт хийх;
- 40.6.2. татвар төлөгчийн мэдээллийг задруулахгүйгээр түүний ажил гүйлгээний үнийг харьцуулалт хийх зорилгоор авч болох бөгөөд энэ тохиолдолд уг этгээдийн мэдээллийг нууцална.
- 40.7. Энэ хуулийн 40.6-д заасан үл мэдээлэгч улс, бүс нутгийн жагсаалтад Монгол Улстай татварын зорилгоор мэдээлэл солилцдоггүй болон эрсдэлтэй татварын тогтолцоотой улс, бүс нутгийг хамруулах бөгөөд энэхүү жагсаалтыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор, жагсаалтад өөрчлөлт орсон бол ажлын 10 өдрийн дотор татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага албан ёсны цахим хуудсаараа нийтэд мэдээлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ

41 дүгээр зүйл. Татварын хяналт шалгалт

- 41.1. Татвар төлөгч татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг татварын алба хянан шалгана.
- 41.2. Татварын алба татварын хяналт шалгалтыг ерөнхий болон тусгай удирдамж, томилолттой хийх бөгөөд бүрэн, эсхүл хэсэгчилсэн хэлбэрээр олон улсын жишиг, хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.
- 41.3. Татвар төлөгчийн эрсдэлд үндэслэн хялбаршуулсан хяналт шалгалт хийж болно.
- 41.4. Татварын алба эрсдэлд, эсхүл татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгана.
- 41.5. Татварын хяналт шалгалт хийх талаар татвар төлөгчид ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
- 41.6. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь татвар төлөгчийн улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа орлогын хэмжээ, татварын төрөл, үйл ажиллагааны чиглэлийг харгалзан хяналт шалгалтын харьяаллыг тогтоож болно.
- 41.7. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зорилгоор татварын албанаас хэрэгжүүлэх дараах ажиллагаа энэ хуулийн 41.5-т хамаарахгүй:
- 41.7.1. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;

- 41.7.2. татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон эсэхэд хяналт тавих;
- 41.7.3. цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, олгох, илгээх, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавих.
- 41.8. Татварын алба нь татварын улсын байцаагчийн мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлага, ашиг сонирхлын зөрчилд өртөхгүй байх нөхцөлийг харгалзан татварын хяналт шалгалтыг зохион байгуулж, томилгоо хийж, удирдамжийг батална.
- 41.9. Татварын хяналт шалгалтыг хоёр болон түүнээс дээш татварын улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэнэ.
- 41.10. Татварын алба нь татварын хяналт шалгалт хийх зорилгоор дараах эрх хэмжээг хэрэгжүүлэх эрхтэй:
- 41.10.1. татвар төлөгч болон түүний харилцагч этгээдийг үндэслэл бүхий шалтгаанаар дуудан ирүүлж, тайлбар авах;
- 41.10.2. энэ хуулийн 5 дугаар бүлэгт заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх;
- 41.10.3. татварын болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, данс бүртгэл, санхүүгийн бусад баримт болон татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй холбоотой тайлбар, лавлагаа гаргуулан авах.
- 41.11. Татварын алба, татварын улсын байцаагч хяналт шалгалт хийхдээ дараах ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно:
- 41.11.1. энэ хуулийн 41.4-т зааснаас бусад үндэслэлээр хяналт шалгалт хийх;
- 41.11.2. татварын улсын байцаагч татвартай холбогдсон эрүү, захиргааны хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр оролцох.
- 41.12. Татвар төлөгч нь татварын хяналт шалгалтад дараах эрх, үүрэгтэй байна:
- 41.12.1. эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах, нотолгоо, үндэслэл гаргах;
- 41.12.2. татвар ногдуулалт, төлөлт, татварын хяналт шалгалтын явц, үр дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;
- 41.12.3. татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгч, татварын хяналт шалгалтад хамрагдах.
- 41.13. Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталж, мөрдүүлнэ.

42 дугаар зүйл. Нөхөн ногдуулалтын акт

- 42.1.Татварын улсын байцаагч энэ хуулийн 16.2, 16.3, 36.1, 37.1, 41.1-д заасан үндэслэлээр нөхөн ногдуулалтын акт, эсхүл илтгэх хуудас үйлдэх бөгөөд нөхөн ногдуулалтын акт нь тэмдэглэх, тогтоох хэсгээс, илтгэх хуудас нь тэмдэглэх хэсгээс бүрдэнэ.
- 42.2.Нөхөн ногдуулалтын актаар татвар төлөгчийн татварын ногдлыг нэмэгдүүлэх, эсхүл бууруулах өөрчлөлт хийх бөгөөд ногдол бууруулсан зөрүүг нөхөн ногдуулалтын акт үйлдсэн татварын жилийн татварын үлдэгдлийн тооцоололд оруулан тооцно.
- 42.3.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудас нь нэгдсэн бүртгэл, дугаартай байх бөгөөд хавсралтын хамт хүчинтэй байна.
- 42.4.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудаст хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагч гарын үсэг зурж, хариуцсан нэгжийн дарга хянан баталгаажуулж гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 42.5.Татварын алба, татварын улсын байцаагч нь албан ёсны маягтад эцэслэн баталгаажуулаагүй нөхөн ногдуулалтын актыг татвар төлөгчид урьдчилан танилцуулахгүй.
- 42.6.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гардуулж, гардуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ.
- 42.7.Татвар төлөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг энэ хуулийн 42.6-д заасан хугацаанд гардуулах боломжгүй, эсхүл гардан аваагүй бол татварын алба уг хугацаа өнгөрснөөс хойш 7 хоногийн дотор татвар төлөгчийн хувийн хэрэгт бүртгүүлсэн хаягт шуудангаар илгээнэ.
- 42.8.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг энэ хуулийн 42.7-д заасны дагуу илгээсэн өдрөөс хойш Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасан хугацаанд гардуулсанд тооцно.

43 дугаар зүйл.Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргах

- 43.1.Татвар төлөгч нөхөн ногдуулалтын актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхгүй бол нөхөн ногдуулалтын актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 46.1-д заасан Маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж болно.
- 43.2.Татвар төлөгч энэ хуульд заасан хугацаанд нөхөн ногдуулалтын актыг гардан аваагүй нь шүүхийн болон захиргааны журмаар гомдол гаргах хугацааг хуульд заасан журмын дагуу тоолохгүй байх үндэслэл болохгүй.
- 43.3.Татвар төлөгч энэ хуулийн 43.1-д заасны дагуу гомдол гаргасан нь ногдуулсан татвар, алданги, торгууль төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.

43.4.Татварын алба нь татварын улсын байцаагчийн үйлдсэн нөхөн ногдуулалтын акт болон шийтгэлийн хуудсын биелэлтийг хангуулахад хяналт тавин ажиллана.

44 дүгээр зүйл.Татварын хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэх

44.1.Татварын хяналт шалгалтыг хийх явцад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил илэрсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

45 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хяналт шалгалт

45.1.Татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хүсэлтийг харьяа татварын алба хүлээн авч, хянаж шалган, баталгаажуулж, саналыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгжид шилжүүлнэ.

45.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгж нь энэ хуулийн 45.1-д заасан саналыг хүлээн авч нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянан шалгаж, баталгаажуулсан акт үйлдэнэ.

45.3.Татвар төлөгч энэ хуулийн 45.2-т заасан шийдвэрийг зөвшөөрөхгүй бол энэ хуулийн 46.1-д заасан Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛ

46 дугаар зүйл.Маргаан таслах зөвлөл

46.1.Татварын албаны дэргэд татвар төлөгчөөс энэ хуулийн 6.1.26-д заасан татварын акттай холбогдуулан гаргасан гомдол, Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т заасан хүсэлтийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Татварын маргаан таслах зөвлөл /цаашид “Маргаан таслах зөвлөл” гэх/ ажиллана.

46.2.Маргаан таслах зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэнэ.

46.3.Энэ хуулийн 46.1-д заасны дагуу татвар төлөгчийн гаргасан гомдлыг харьяаллын дагуу татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл тус тус шийдвэрлэнэ.

- 46.4.Маргаан таслах зөвлөл нь ес, эсхүл 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.
- 46.5.Маргаан таслах зөвлөлийг тухайн байгууллагын удирдлагатай зөвшилцсөний үндсэн дээр дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:
- 46.5.1.аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд нутгийн захиргааны байгууллага, татварын албаны төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл;
- 46.5.2.татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд татварын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын албаны төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл.
- 46.6.Маргаан таслах зөвлөлийн гишүүн нь нягтлан бодогч, санхүүч, эдийн засагч, эсхүл эрх зүйч мэргэжилтэй, мэргэжлээрээ гурваас дээш жил ажилласан туршлагатай байна.
- 46.7.Маргаан таслах зөвлөлийн дэргэд татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор татварын асуудлаар дүн шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий хараат бус магадлагч ажиллах бөгөөд магадлагч нь тухайн шатны татварын албаны дарга томилсон татварын улсын байцаагчийн эрхтэй этгээд байна.
- 46.8.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь татварын улсын байцаагчийн эрхтэй байх бөгөөд түүнийг Маргаан таслах зөвлөлийн даргын санал болгосноор тухайн шатны татварын албаны дарга томилно.
- 46.9.Аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилж, чөлөөлнө.

47 дугаар зүйл.Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах, шийдвэрлэх

- 47.1.Татвар төлөгч, эсхүл түүний эрх олгосон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөх татварын актыг гардаж авснаас хойш энэ хуулийн 43.1, 72.4-т заасан хугацаанд харьяалах Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах эрхтэй.
- 47.2.Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

- 47.3.Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг урьдчилж төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.
- 47.4.Маргаан таслах зөвлөл, шүүх татвар төлөгчийн нөхөн ногдуулалтын актад гаргасан гомдол, нэхэмжлэлийг ханган эцэслэн шийдвэрлэсний үр дүнд энэ хуулийн 47.3-т заасны дагуу урьдчилан төлсөн татварын дүнгээс татвар төлөгчид буцаан олгох асуудлыг энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 47.5.Энэ хуулийн 47.1-д заасан гомдлыг дараах харьяаллын дагуу шийдвэрлэнэ:
- 47.5.1.аймаг, нийслэлийн татварын албанд харьяалагдах татвар төлөгчийн гомдлыг тухайн аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл;
- 47.5.2.том татвар төлөгч хариуцсан нэгжид харьяалагдах татвар төлөгчийн гомдлыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөл.
- 47.6.Маргаан таслах зөвлөл нь холбогдох татварын акт, ирүүлсэн гомдол, хүсэлт болон бусад баримт бичиг, мэдээллийг хянаж, 3 хоногийн дотор харьяаллыг тогтоож, харьяаллын бус бол маргааныг холбогдох Маргаан таслах зөвлөлд энэ хуулийн 47.5-т заасан харьяаллын дагуу шилжүүлнэ.
- 47.7.Маргаан таслах зөвлөлийн хуралдаан нь бүх гишүүний гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцогдоно.
- 47.8.Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 47.9.Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 46.1-д заасан гомдлыг татвар төлөгчийн гомдлын хүрээнд хянан шалгаж, шийдвэр гаргана.
- 47.10.Маргаан таслах зөвлөл нь татварын актаар баталгаажуулсан дүнг өөрчлөх, хүчингүй болгох, хэвээр үлдээх, түдгэлзүүлж татварын албанд буцаах шийдвэрийн аль нэгийг гаргах бөгөөд уг шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.
- 47.11.Маргаан таслах зөвлөл гомдлыг хэлэлцэх явцад доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсвэл 3 хүртэл сарын хугацаагаар актыг дахин шалгуулахаар дээд шатны татварын албанд буцааж, гомдол бүхий нөхөн ногдуулалтын актыг нэг удаа түдгэлзүүлж болно:
- 47.11.1.илрүүлсэн татварын актыг бичилтийн болон тооцооны алдаа нь тухайн татварын актыг нөхөн ногдуулалт, торгууль, алдангийн нийт дүнг нэмэгдүүлэх;

- 47.11.2.гомдлын нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, асуудлыг дутуу шийдвэрлэсэн бөгөөд нэмж тодруулах зүйлийн цар хүрээ нь маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн.
- 47.12.Татварын алба шинэ акт гаргах бол өмнө гаргасан нөхөн ногдуулалтын акт хүчингүй болох бөгөөд энэ хуулийн 47.11-д заасан хугацаанд шинэ акт гаргаагүй бол Маргаан таслах зөвлөл асуудлыг дахин хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 47.13.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь маргаан таслах зөвлөлийн хэлэлцсэн асуудал болон гаргасан шийдвэрийн үндэслэлийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж, зөвлөлийн шийдвэрийг татвар төлөгч, татварын улсын байцаагч, магадлагч зэрэг хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хувийн мэдээллийг таних боломжгүйгээр цахим хуудсаар мэдээлнэ.
- 47.14.Маргаан таслах зөвлөл нь маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, татварын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргаж, татварын албанд хүргүүлэх эрхтэй.
- 47.15.Маргаан таслах зөвлөл нь татвар төлөгчийн гомдол гаргаснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг шийдвэрлэж, уг шийдвэрийг маргааны оролцогч талуудад гардуулна.
- 47.16.Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 47.15-д заасан шийдвэр гаргах хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.
- 47.17.Маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан татвар төлөгч нь энэ хуулийн 47.15, 47.16-д заасан хугацаанд магадлагч татварын улсын байцаагчийн шаардсан нотлох баримтыг ирүүлээгүй бол ирүүлсэн нотлох баримтын хүрээнд гомдлыг хянан шийдвэрлэнэ.
- 47.18.Маргаан таслах зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвхөн шүүхийн шийдвэрээр өөрчилнө.
- 47.19.Татвар төлөгч нь Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандах эрхтэй.
- 47.20.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасантай адилтгах шалтгаанаар Маргаан таслах зөвлөл татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх боломжгүй бол татварын актыг хэлэлцэхийг түдгэлзүүлж болно.
- Тайлбар: “тооцооны алдаа” гэж татварын актад бичигдсэн тоон илэрхийллийг арифметик, оронгийн гэх мэт илт тооцооны алдаа гаргасан байхыг ойлгоно.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТ, ТАТВАРЫН ӨР

48 дугаар зүйл.Татвар ногдуулалт, төлөлтийн бүртгэл

- 48.1.Татварын алба нь татвар, торгууль, алдангийн ногдуулалт, төлөлтийг татвар төлөгч бүрээр бүртгэнэ.
- 48.2.Татварын алба нь татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдуулалт, төлөлт, хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын өрийг татварын тайлан болон шийтгэлийн хуудас, татварын актад үндэслэн бүртгэнэ.
- 48.3.Татварын хяналт шалгалтын үр дүнд тайлангийн ногдол буурсан тохиолдолд татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлтийг хийнэ.
- 48.4.Татварын орлого бүртгэх, орлогын данснаас татвар хооронд суутган тооцох журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

49 дүгээр зүйл.Татварыг буцаан олгох, суутган тооцох

- 49.1.Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг доор дурдсан дарааллын дагуу шийдвэрлэнэ:
 - 49.1.1.буцаан олгох;
 - 49.1.2.тухайн хугацаанд төлбөл зохих бусад татварт суутган тооцох;
 - 49.1.3.татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох.
- 49.2.Татвар төлөгч татварын өртэй бол энэ хуулийн 49.1-д заасан дарааллыг үл харгалзан татварын өрийг түрүүлж суутган тооцно.
- 49.3.Татварыг суутган тооцохдоо энэ хуулийн 52.1-д заасан дарааллыг баримтална.
- 49.4.Илүү төлсөн татварыг буцаан олгох харилцааг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулж болно.
- 49.5.Илүү төлсөн татварыг суутган тооцсон бол татварын алба энэ тухай татвар төлөгчид мэдэгдэнэ.
- 49.6.Энэ хуулийн 49.1.1-д заасан буцаан олголт нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.
- 49.7.Татварын алба татварын хөнгөлөлт, илүү төлөлтийг хуулийн дагуу буцаан олгох зориулалттай харилцах данстай байх бөгөөд данс хөтлөх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

50 дугаар зүйл.Татварын өр

- 50.1.Доор дурдсан хугацаанд төлөөгүй татвар, алданги, торгууль /цаашид “татварын өр” гэх/-ийг татварын өрд тооцно:

- 50.1.1. татвар төлөгчийн татварын тайлангаар тодорхойлсон татварын хувьд татварын хууль, тогтоомжид зааснаар татвараа төлж, тайлагнасан байх ёстой өдөр;
 - 50.1.2. тайлан боловсруулалтаар болон татвар төлөгчийн хүсэлтээр хийсэн залруулгын тайлангаар тодорхойлсон татварын хувьд залруулгын тайлан хүлээн авсан өдөр;
 - 50.1.3. нөхөн ногдуулалтын акт, шийтгэлийн хуудсаар тогтоосон татвар, алданги, торгуулийн хувьд уг шийдвэрийг гардуулснаас хойш ажлын 15 өдөр;
 - 50.1.4. татварын хууль тогтоомжоор тайлагнадаггүй татварын хувьд татварын хууль тогтоомжоор татвараа төлсөн байх ёстой өдөр.
- 50.2. Нөхөн ногдуулалтын актыг Маргаан таслах зөвлөл, шүүхийн шийдвэрээр эцэслэн тогтоосон тохиолдолд энэ хуулийн 50.1.3-г заасан өрийн хэмжээг уг шийдвэрийг үндэслэн өөрчилнө.

51 дүгээр зүйл. Татварын нэхэмжлэх

- 51.1. Татварын алба энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан татварын өрийг төлүүлэхээр татварын нэхэмжлэх /цаашид “нэхэмжлэх” гэх/-ийг татвар төлөгчид хүргүүлэх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:
- 51.1.1. татвар төлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
 - 51.1.2. татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;
 - 51.1.3. нэхэмжлэх хүргүүлсэн хугацаа;
 - 51.1.4. татвар ногдох зүйл, татварын өр төлөх үндэслэл;
 - 51.1.5. татварын өр, алдангийн хэмжээ, татварын өр төлөх эцсийн хугацаа;
 - 51.1.6. татварын өр төлөх газар, дансны нэр, дансны дугаар;
 - 51.1.7. нэхэмжлэхийг татвар төлөгчид хүргүүлснээс хойш ажлын 10 хүртэл өдөрт багтаан татварын өрийг төлөх тухай шаардлага;
 - 51.1.8. татварын албанаас зайлшгүй гэж үзсэн бусад шаардлага.
- 51.2. Татварын алба нэхэмжлэхийг татварын өр үүссэн хугацаанаас хойш ажлын 30 өдөрт багтаан татвар төлөгчид хүргүүлнэ.

52 дугаар зүйл. Татварын өр төлөх дараалал

- 52.1. Татварын өрийг доор дурдсан дарааллаар барагдуулна:
- 52.1.1. татварын үндсэн өр;
 - 52.1.2. алданги;
 - 52.1.3. торгууль.

53 дугаар зүйл. Татвар төлөх хугацааны хөнгөлөлт

- 53.1. Доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсэж татвар төлөгч татварын өрийг төлөх боломжгүй болох нь тогтоогдсон бол татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн харьяа татварын алба татвар төлөх хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар сунгаж хөнгөлөлт үзүүлж болно:
- 53.1.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан гамшиг болон үер, газар хөдлөлт, гал түймэрт өртсөн;
- 53.1.2. Энэ хуулийн 6.1.41.а, 6.1.41.б-д заасан хүндэтгэн үзэх шалтгааны улмаас татвар төлөгч хувь хүний хувьд өмнөх жилийн татвар ногдох орлогоос илүү хэмжээтэй эмчилгээний зардал гаргасан;
- 53.1.3. татвар төлөгч эрхэлж байгаа үйл ажиллагаагаа зогсоосон;
- 53.1.4. татвар төлөгчийн үйл ажиллагаанд 3 жил дараалан их хэмжээний алдагдал хүлээж, төлбөрийн чадвар муудсан.
- 53.2. Татвар төлөгч энэ хуулийн 53.1-д заасан хөнгөлөлтийн хугацаанд татварын өрийг төлөх боломжгүй хүндэтгэн үзэх нөхцөл үүссэн тохиолдолд татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн харьяалах татварын алба хугацааг дахин сунгаж болно. Сунгах хугацаа нь анхны хөнгөлөлтийг оруулан нийт 2 жилээс илүүгүй байна.
- 53.3. Татварын өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлэхэд дараах зарчим баримтална:
- 53.3.1. татвар төлөх хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өрийн дүн нь 10.0 сая төгрөгөөс доош, эсхүл хөнгөлөх хугацаа нь 3 сар хүртэлх татварын өрд барьцаа хөрөнгө шаардахгүй бөгөөд бусад тохиолдолд сунгасан хугацаанд хамаарах алдангийн хэмжээг оруулсан дүнгээс багагүй хэмжээний барьцаа хөрөнгийг шаардана;
- 53.3.2. барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгө, Засгийн газрын үнэт цаас байх ба барьцаалах ажиллагааг Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг баримтлан хэрэгжүүлнэ;
- 53.3.3. энэ хуулийн 53.3.1-д заасан барьцааны оронд бусад этгээдийн батлан даалтыг ашиглаж болно;
- 53.3.4. татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтэд хөрөнгийн байдал, санхүүгийн чадавхыг тэмдэглэн, түүнд үндэслэн гаргасан хөнгөлөлтийн хугацаанд татварын өр төлөх хуваарийг тусгана.
- 53.4. Татварын өр төлөх хугацааг хөнгөлсөн бол хөнгөлөлтийн хугацаанд тухайн татварын өрийг хураах энэ хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй.
- 53.5. Энэ хуулийн 53.1, 53.2-т заасны дагуу татварын өр төлөх хугацааг хөнгөлсөн тохиолдолд хөнгөлөлтийн хугацаанд тооцох алдангийг 20 хувиар хөнгөлнө.
- 53.6. Энэ хуулийн 53.1, 53.2-т зааснаар татвар төлөгч сунгасан хугацаанд эрсдэлтэй татвар гэж үзэх нөхцөл байдал үүссэн, эсхүл хуваарийн дагуу татварын өрийг төлөөгүй, барьцааны зүйлийг өөрчлөхийг зөвшөөрөөгүй болон түүний дараа

гарах нөхцөл байдлын өөрчлөлт нь хөнгөлөлтийг үргэлжлүүлэхэд зохистой бус гэж үзсэн тохиолдолд татварын албаны дарга хөнгөлөлтийг цуцалж, барьцааны зүйлээс татварын өрийг гаргуулна.

53.7.Энэ хуулийн 53.6-д заасны дагуу хөнгөлөлтийг цуцалсан тохиолдолд эхний ээлжид үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас зэрэг татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг гаргуулах бөгөөд уг хөрөнгөөс гаргуулж хүрэлцэхгүй тохиолдолд батлан даагчаас татварын өрийг гаргуулах зарчим баримтална.

53.8.Батлан даагчаас татварын өрийг гаргуулахдаа энэ хуулийн 58.1, 58.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг хүргүүлнэ. Батлан даагч нь батлан даасан үүрэгт хамаарах татварыг мэдэгдэх хуудсанд заасан хугацаанд төлөөгүй бол энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу нэхэмжлэх хүргүүлнэ. Батлан даагч тухайн нэхэмжлэхэд заасан хугацаанд татварын өрийг төлөөгүй бол татварын өр хураах ажиллагааг эхлүүлнэ.

53.9.Татварын өр төлөх хугацааны хөнгөлөлтийг зөвшөөрсөн болон цуцалсан талаар татварын албаны даргын шийдвэрийг өртэй татвар төлөгчид ажлын 10 өдрийн дотор мэдэгдэнэ.

53.10.Татварын өр төлөх хугацааг хөнгөлөх журам, энэ үйл ажиллагаатай холбогдох маягтын агуулга, загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

54 дүгээр зүйл.Эрсдэлтэй татварыг урьдчилан хураах үйл ажиллагаа

54.1.Доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсэж, татвар төлөгч татвараа төлөхгүй нь тодорхой болсон тохиолдолд ногдол нь тодорхой татварыг татварын алба урьдчилан хурааж болно:

54.1.1.татвар төлөгчийн хөрөнгөд энэ хуулийн 6.1.4-т заасан албадан гүйцэтгэх үйл ажиллагаа эхэлсэн;

54.1.2.татвар төлөгч татан буулгах шийдвэр гаргасан;

54.1.3.татвар төлөгч Монгол Улсад оршин суух хаяггүй болсон;

54.1.4.татвар төлөгч хууль бус үйлдлээр татвар төлөхөөс зугтах, эсхүл зугтахыг оролдох, татварын буцаан олголт авах, эсхүл авахыг оролдох, залилангийн шинжтэй үйлдлээр хөрөнгө шилжүүлэх, санаатайгаар дампуурах зэргээр татварын өр хураах үйл ажиллагаанаас зугтах, эсхүл зугтахыг оролдсон.

54.2.Энэ хуулийн 54.1-д заасны дагуу татварыг ажлын 3 өдөрт багтаан төлүүлэхээр урьдчилан нэхэмжлэх хуудас хүргүүлнэ.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ ТАТВАРЫН ӨР ХУРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

55 дугаар зүйл.Татварын өр хураах үйл ажиллагаа

- 55.1.Татварын алба дараах тохиолдолд татварын өр хураах үйл ажиллагааг эхлүүлнэ:
- 55.1.1.татвар төлөгчөөс болон татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өрийг нэхэмжлэхэд заасан хугацаанд бүрэн төлөөгүй;
 - 55.1.2.татвар төлөгч энэ хуулийн 54.2-т заасан урьдчилан нэхэмжлэх хуудас болон энэ хуулийн 53 дугаар зүйлээр тогтоосон хугацаанд татвараа бүрэн төлөөгүй;
 - 55.1.3.өв залгамжлагчаас татварын өрийг нэхэмжлэхэд заасан хугацаанд татвараа бүрэн төлөөгүй;
 - 55.1.4.татвар төлөх хугацаанаас хойш нэхэмжлэх хүлээн авсан татвар төлөгчид энэ хуулийн 54.1-д заасан нөхцөл байдал үүссэн.
- 55.2.Татварын алба татварын өрийг хураах үйл ажиллагааг дараах дарааллын дагуу хэрэгжүүлнэ:
- 55.2.1.нэхэмжлэх хүргүүлэх;
 - 55.2.2.татварын өрийг үл маргах журмаар гаргуулах;
 - 55.2.3.бэлэн мөнгө хураах;
 - 55.2.4.хөрөнгө болон авлага битүүмжлэх;
 - 55.2.5.битүүмжилсэн хөрөнгийг хураах;
 - 55.2.6.битүүмжлэн хураасан хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх;
 - 55.2.7.орлогыг хуваарилах;
- 55.3.Татварын өрийг бүрэн хураах зорилгоор энэ хуулийн 55.2-т заасан ажиллагааг давхардуулан явуулж болно.

56 дугаар зүйл.Татварын давуу эрхийн зарчим

- 56.1.Энэ хуулийн 56.2, 56.3, 56.4, 56.5, 56.6, 56.7-д зааснаас бусад тохиолдолд татварыг аливаа авлагаас түрүүлж гаргуулна.
- 56.2.Татвар төлөгчийн хөрөнгөд энэ хуулийн 6.1.4-т заасан албадан гүйцэтгэх үйл ажиллагаа явуулж, хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн тохиолдолд тухайн мөнгөн хөрөнгөөс татварын алба татварын өрийг гаргуулах хүсэлт гаргасан бол татварын өрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бүртгэгдсэн дараалал үл харгалзан тухайн үйл ажиллагааны зардлын дараа хураана.
- 56.3.Татвар төлөгчийн хөрөнгийг татварын өр хураах үйл ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлсэн бол тухайн мөнгөн хөрөнгөөс татвар хураах шууд зардлыг энэ хуулийн 56.4, 56.5.3, 56.6, 56.7-д заасныг үл харгалзан бусад татвар болон авлагаас түрүүлж хураана.

- 56.4.Онцгой албан татвар болон автобензин, дизелийн түлшний албан татвар ногдох зүйлийг албадан гүйцэтгэх ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлсэн бол тухайн мөнгөн хөрөнгөөс шилжүүлгийн дүнд үүссэн онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татварыг энэ хуулийн 56.5, 56.6, 56.7-д заасныг үл харгалзан бусад татвар болон авлагаас түрүүлж хураана.
- 56.5.Татварын өр хураах үйл ажиллагаагаар хийсэн битүүмжлэлд хамаарах хоёр болон түүнээс дээш татварын албанд бүртгэлтэй татвар төлөгчийн татварын өрийг дараах байдлаар хураана:
- 56.5.1.тухайн татварын өрийг хураах зорилгоор хөрөнгө битүүмжилсэн бол битүүмжлэлд хамаарах татварыг суутгуулах хүсэлт гаргасан бусад татварын өрөөс түрүүлж;
- 56.5.2.хэд хэдэн суутгуулах хүсэлт гаргасан татварын өрийн хувьд хүсэлт гаргасан дарааллаар татварын өрийг түрүүлж;
- 56.5.3.татвар төлөгч татвар төлөх хугацааг хөнгөлүүлж, хөрөнгө барьцаалсан бол энэ хуулийн 56.5.1, 56.5.2-т заасныг үл харгалзан барьцаанд хамаарах татварыг бусад татварын өрөөс түрүүлж.
- 56.6.Татвар төлөгчийн барьцаа, ипотекийн барьцаа зэрэг гуравдагч этгээдээс давуу эрхтэйгээр шаардах эрхтэй хөрөнгөөс татварын өрийг гаргуулах тохиолдолд татварын өрийг эдгээр авлагын дараа хураана.
- 56.7.Бүртгүүлэх боломжгүй барьцаа, эсхүл бүртгэл хийгдээгүй ч түрүүлж авах шаардах эрхийн хувьд албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад нотолсон тохиолдолд энэ хуулийн 56.6-д заасан давуу эрх үйлчилнэ.
- 56.8.Энэ хуулийн 56.7-д заасан этгээд нь баримт нотолгоо гаргаагүй бол энэ хуульд заасан давуу эрхийг эдлэхгүй.
- 56.9.Бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах, тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой бол энэ хуульд заасныг үл харгалзан татвар, авлагаас түрүүлж уг хохирлыг барагдуулна.

57 дугаар зүйл.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд

- 57.1.Өртэй татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг хураахад уг хөрөнгө хүрэлцэхгүй нь тогтоогдсон бөгөөд татварын өр үүссэн хуулийн хугацаанаас нэг жилийн өмнөх өдрөөс хойш хугацаанд тухайн өртэй татвар төлөгч хөрөнгөө үнэгүй, эсхүл хэт бага үнээр бусдад шилжүүлсэн, бусдаас авах авлагаа хүчингүй болгож бусад этгээдэд ашигтай байдлыг бий болгосон бол шилжүүлж авсан хөрөнгө, хүчингүй болгосон авлагын хэмжээгээр тухайн этгээд татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд болно.

58 дугаар зүйл.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өр хураах нийтлэг журам

- 58.1.Татвар төлөгчийн татварын өрийг төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өрийг гаргуулахаар тухайн этгээдэд доор дурдсан агуулга бүхий мэдэгдэх хуудас хүргүүлнэ:
- 58.1.1.өртэй татвар төлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 58.1.2.татварын өр үүссэн хугацаа, татварын төрөл, татварын өрийн дүн, татвар төлөх эцсийн хугацаа;
- 58.1.3.татварын өр төлөх газар, дансны нэр, дансны дугаар.
- 58.2.Энэ хуулийн 58.1.2-т заасан татварын өр төлөх эцсийн хугацаа нь мэдэгдэх хуудас хүргүүлснээс хойш ажлын 20 өдөр байна.
- 58.3.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд энэ хуулийн 58.1.2-т заасан хугацаанд төлөөгүй бол татварын алба эрсдэлтэй татварыг урьдчилан хураах үйл ажиллагааг явуулахаас бусад тохиолдолд нэхэмжлэх хүргүүлнэ.
- 58.4.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдэд энэ хуулийн 53, 54 дүгээр зүйл нэгэн адил үйлчилнэ.
- 58.5.Хөрөнгийн үнэ цэнэ огцом буурах магадлалтайгаас бусад тохиолдолд татварын өрийг өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийн хөрөнгөөс татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлж болохгүй.
- 58.6.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс өртэй татвар төлөгчийн татварын өрийг гаргуулсан бол тухайн өртэй татвар төлөгчөөс нэхэмжлэх эрхтэй.
- 58.7.Татварын өрийг татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс гаргуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

59 дүгээр зүйл.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох

- 59.1.Татварын улсын байцаагч татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг дараах аргаар тогтооно:
- 59.1.1.хөрөнгийн байдлын талаар асуулга явуулах;
- 59.1.2.татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн хөрөнгийн байдлыг тогтоох;
- 59.1.3.энэ хуулийн 5 дугаар бүлэгт заасан татварын албанаас хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаа явуулах;
- 59.1.4.хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтыг гуравдагч этгээдийн мэдээлэл, лавлагаанд үндэслэн тогтоох.

- 59.2.Энэ хуулийн 59.1.1-д заасны дагуу дараах этгээдэд асуулга явуулж, шаардлагатай тохиолдолд тухайн этгээдийн хөрөнгийн талаарх бичиг баримтыг шалгаж болно:
- 59.2.1.өртэй татвар төлөгч;
- 59.2.2.өртэй татвар төлөгчийн хөрөнгийг эзэмшигч гуравдагч этгээд, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гэж үзэх хангалттай шалтгаан бүхий гуравдагч этгээд;
- 59.2.3.өртэй татвар төлөгчтэй авлага, эсхүл өглөгийн харилцаатай этгээд, өртэй татвар төлөгчийн хөрөнгийг авсан гэж үзэх хангалттай шалтгаан бүхий этгээд;
- 59.2.4.өртэй татвар төлөгчийн хувь нийлүүлсэн, хөрөнгө оруулсан хуулийн этгээд.
- 59.3.Энэ хуулийн 59.1.3-т заасан нийтлэг ажиллагааг явуулахдаа энэ хуулийн 19.4-т заасан журмыг баримтална.
- 59.4.Энэ хуулийн 59.1.4-т заасан хөрөнгийн талаарх мэдээлэл, лавлагааг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагаас гаргуулж авна.
- 59.5.Татварын улсын байцаагч татварын өр хураах үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд өртэй татвар төлөгчийн оршин суугаа газар болон тухайн хөрөнгийг нуусан байж болзошгүй газарт үзлэг хийж болно.
- 59.6.Татварын улсын байцаагч үзлэг хийх явцад татварын өртэй этгээд болон гуравдагч этгээдээр хаалга, сейф, бусад агуулах савыг нээлгүүлэх, татвар төлөгч уг ажиллагааг хийхээс татгалзсан тохиолдолд татварын улсын байцаагч шаардлагатай арга хэмжээг авч нээж болно.

60 дугаар зүйл.Хөрөнгө битүүмжлэх

- 60.1.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх гэснийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49.1-д заасан утгаар ойлгох бөгөөд барьцааны эрхгүй хөрөнгөөс эхлэн битүүмжлэх зарчим баримтална.
- 60.2.Энэ хуулийн 60.1-д заасан барьцааны эрхгүй хөрөнгөөс татварын өрийг хурааж хүрэлцэхгүй тохиолдолд барьцааны эрхтэй хөрөнгийг битүүмжилж болно.
- 60.3.Гуравдагч этгээдийн шаардах эрхтэй хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд тухайн гуравдагч этгээдээс татварын албанд ирүүлсэн хүсэлтийг үндэслэн өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг татварын өрийг хураах боломжтой, түргэн борлогдох болон гуравдагч этгээдийн эрхийн үйлчлэлгүй хөрөнгөөр сольж болно.
- 60.4.Татварын алба татварын өр хураах зардал бага байх, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгийг түрүүлж битүүмжлэх замаар татварын өрийг хураана.

- 60.5.Татварын өр хураахад шаардлагатайгаас бусад хөрөнгийг битүүмжилж болохгүй.
- 60.6.Битүүмжлэх хөрөнгийн үнийн дүн нь битүүмжлэх болон татварын өр хураах зардал, тухайн татварын өрөөс өмнө хураагдах барьцааны эрх бүхий гуравдагч этгээдэд төлөх өрийн нийлбэр дүнд хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хөрөнгийг битүүмжлэхгүй.
- 60.7.Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжилсэн бол битүүмжлэх актыг үйлдэнэ. Битүүмжилсэн хөрөнгө нь хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, банкн дахь данс, авлага, шаардах эрх бүхий биет бус хөрөнгө байгаа тохиолдолд битүүмжлэх акт, мэдэгдэх хуудсын хуулбарыг өртэй татвар төлөгчид хүргүүлнэ.
- 60.8.Өртэй татвар төлөгч татварын өрөө бүрэн барагдуулсан, эсхүл энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдэлсэн тохиолдолд татварын алба хөрөнгийг битүүмжлэх актыг хүчингүй болгоно.
- 60.9.Хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах журмыг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49, 50, 51, 52, 53, 54, 56 дугаар зүйлд заасныг жишиг болгон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- Тайлбар:“шаардах эрх бүхий биет бус хөрөнгө” гэж банк, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоонд оруулсан хөрөнгө, хувьцаа худалдах, худалдан авахаар брокер, дилерт өгсөн захиалга зэрэг хамаарна.

61 дүгээр зүйл.Битүүмжлэхийг хориглох хөрөнгө, орлого

61.1.Дараах хөрөнгийг битүүмжлэхийг хориглоно:

- 61.1.1.өртэй татвар төлөгч, түүний гэр бүлийн гишүүдийн өдөр тутмын хэрэглээний хувцас, хэрэглэл;
- 61.1.2.өртэй татвар төлөгчийн байнга амьдран суугаа зөвхөн нэг орон сууц болон өртэй татвар төлөгчийн хүйтний улиралд хэрэглэж байгаа түлээ, түлш;
- 61.1.3.газар тариалан, мал аж ахуй, гар урлал эрхэлдэг этгээдийн хувьд амьжиргааны эх үүсвэр болдог үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, эд зүйлс, тоног төхөөрөмж, мал, малын тэжээл;
- 61.1.4.гамшиг, аюулт үзэгдэл, осол, онцгой нөхцөл байдлын улмаас үзүүлж байгаа тусламж, тэтгэлэг, хандив;
- 61.1.5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж;
- 61.1.6.донорын олговор;

61.1.7.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээний хүрээнд олгосон тусламж, дэмжлэг.

61.2.Удаан хадгалах боломжгүй, түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн, хуучирч элэгдэн хэрэгцээ хангахгүй болсон эд зүйлийг битүүмжлэхгүй.

61.3.Өртэй татвар төлөгчийн хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасыг гэр бүлийн гишүүн, харилцан хамааралтай этгээдээс бусад гуравдагч этгээд эзэмшдэг бөгөөд тухайн гуравдагч этгээд нь шилжүүлэхээс татгалзсан тохиолдолд битүүмжлэхгүй.

62 дугаар зүйл.Хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаас битүүмжлэх, бэлэн мөнгө хураах, татварын өр гаргуулах

62.1.Хөдлөх эд хөрөнгө, үнэт цаасыг битүүмжлэхдээ татварын улсын байцаагч тухайн хөрөнгийг татварын албаны мэдэлд авч хэрэгжүүлнэ. Битүүмжлэлийн үйлчлэл нь татварын улсын байцаагч хөрөнгийг татварын албаны мэдэлд авснаар үүснэ.

62.2.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох үед бэлэн мөнгө илэрсэн тохиолдолд татварын өрөөс илүүгүй хэмжээгээр хураан авч нэн даруй татварын орлогын дансанд шилжүүлнэ. Шилжүүлсэн мөнгөн дүнгийн хэмжээгээр тухайн татвар төлөгчөөс татварын өрийг хураасан гэж үзнэ.

62.3.Үнэт цаас битүүмжилсэн тохиолдолд татварын алба тухайн үнэт цаасыг борлуулж татварын өрийг хурааж болно. Үнэт цаасыг борлуулсан орлогын хэмжээгээр өртэй татвар төлөгчөөс татварын өрийг хураасан гэж үзнэ.

62.4.Татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг хурааж хүрэлцэхгүй бол татвар төлөгчийн гуравдагч этгээдэд эзэмшүүлсэн хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасыг татварын албаны мэдэлд авна.

62.5.Энэ хуулийн 62.4-т заасныг хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдэд хөрөнгийг ажлын 5 өдрийн дотор шилжүүлэх тухай бичгээр үүрэг болгож энэ тухай өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

62.6.Энэ хуулийн 62.5-д заасны дагуу гуравдагч этгээд хөрөнгийг шилжүүлээгүй тохиолдолд татварын улсын байцаагч тухайн хөдлөх эд хөрөнгө, үнэт цаасыг битүүмжилж болно.

62.7.Энэ хуулийн 62.4-т заасан гуравдагч этгээд нь өртэй татвар төлөгчтэй гэрээ байгуулсан түрээсийн эрх, үнэгүй түрээслэх эрх болон бусад хөдлөх хөрөнгийг ашиглах, эсхүл ашиг орлого олох эрхэд суурилсан эзэмшлийн эрхтэй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл гэрээг цуцлахгүйгээр гурван сараар хязгаарлан тухайн хөдлөх хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох хоёр нөхцөлөөс аль нэгийг нь сонгох боломжтой.

62.8.Татварын алба шаардлагатай тохиолдолд битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг өртэй татвар төлөгч, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гуравдагч этгээдэд хадгалуулж болно. Хадгалсан газар нь энэ хуулийн 62.1-д зааснаас үл хамааран лацдах, олон нийтэд мэдээлсэн болон бусад битүүмжлэл тодорхойлох аргаар битүүмжилсэн болохыг илэрхийлсэн тохиолдолд битүүмжлэл үйлчилж эхэлсэн гэж үзнэ.

62.9.Энэ хуулийн 62.8-д заасны дагуу битүүмжилсэн хөрөнгийг хадгалуулсан тохиолдолд татварын өр хураахад хүндрэл үүсэхгүй нь тодорхой бол татвар төлөгчид уг хөрөнгийг ашиглах, эсхүл ашиг орлого олохыг зөвшөөрч болно.

62.10.Татварын улсын байцаагч үнэт цаасыг битүүмжлэх актыг тухайн үнэт цаасыг арилжих, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд хүргүүлж гүйцэтгэнэ.

Тайлбар: “мэдэлд авах” гэж татварын алба татварын өртэй этгээдийн хөрөнгийн өмчлөл, эзэмшлийг өөрчлөхгүйгээр тухайн хөрөнгийг захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрхийг хязгаарлан битүүмжилсэн тухай тэмдэглэгээ үйлдэх арга хэмжээг ойлгоно.

63 дугаар зүйл.Татварын өрийг үл маргах журмаар гаргуулах

63.1.Үл маргах журмаар татвар төлөгчийн банкн дахь дансыг битүүмжлэх, татварын өрийг гаргуулахад дараах журмыг баримтална:

63.1.1.татварын улсын байцаагч татварын өрийг өртэй татвар төлөгчийн банкн дахь мөнгөн хөрөнгөөс хураах тухай битүүмжлэх мэдэгдэх хуудсыг татварын албаны даргаар батлуулан харилцагч банканд хүргүүлэх;

63.1.2.энэ хуулийн 63.1.1-д заасан битүүмжлэх мэдэгдэх хуудсанд өртэй татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар, битүүмжилсэн мөнгөн хөрөнгийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар, харилцагч банкны нэр, хаяг, татварын өр хураах үндэслэл, татварын өрийн дүн, зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоох тухай заах;

63.1.3.битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан даруйд банк битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд өртэй татвар төлөгчийн нэг буюу түүнээс дээш дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс татварын өрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх;

63.1.4.банкн дахь мөнгөн хөрөнгө нь татварын өрийг төлөхөд хүрэлцэхээргүй бол уг данснаас төлөгдөх шүүхийн шийдвэрээр төлөх үүрэг бүхий авлагыг хамруулсан бусад зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож, тухайн данснаас татварын өрийг битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд шилжүүлэх.

64 дүгээр зүйл. Авлага битүүмжлэх, татварын өр гаргуулах

- 64.1. Авлага битүүмжлэх ажиллагааг өртэй татвар төлөгчид өглөгтэй гуравдагч этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлж хэрэгжүүлнэ. Авлага битүүмжлэх ажиллагаа авлага битүүмжлэх мэдэгдэх хуудсыг гуравдагч этгээдэд хүргүүлснээр эхэлнэ.
- 64.2. Авлагыг нийт дүнгээр нь битүүмжлэх боловч татварын өр авлагаас бага тохиолдолд хэсэгчлэн битүүмжилж болно.
- 64.3. Цалин хөлс, болон тэдгээртэй адилтгах байнгын орлогыг битүүмжлэх ажиллагаа битүүмжилсний дараа орж ирэх орлогоос хураавал зохих татварын өрийг бүрэн хураах хүртэл хугацаанд үргэлжилнэ.
- 64.4. Татварын улсын байцаагч авлага битүүмжлэхдээ шаардлагатай тохиолдолд холбогдох бичиг баримтыг хурааж болно.
- 64.5. Татварын улсын байцаагч татварын өрийг битүүмжилсэн авлагаас гаргуулан хураах эрхтэй.
- 64.6. Цалин хөлс /цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого хамаарна/-ийг битүүмжлэхэд дараах журмыг баримтална:
- 64.6.1. татварын улсын байцаагч татварын өрийг өртэй татвар төлөгчийн цалин хөлснөөс гаргуулахын тулд цалин хөлсийг олгох үүрэгтэй хувь хүн, хуулийн этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлэх;
- 64.6.2. битүүмжлэх мэдэгдэх хуудсанд өртэй татвар төлөгчийн нэр, хаяг, битүүмжлэгдсэн цалин хөлсийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар, татвар төлөгчид цалин хөлсийг олгох хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хаяг, татварын өрийн дүн, төлбөр хийх хуваарь, битүүмжлэх мэдэгдэх хуудсыг гардуулсан огноог тус тус заах;
- 64.6.3. битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан хувь хүн, хуулийн этгээд нь цалин хөлсийг олгох өдөр төлбөрийн хуваарийн дагуу татварын өрийг суутгаж, суутгал хийснээс хойш ажлын 3 өдрийн дотор битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд шилжүүлэх;
- 64.6.4. татварын өрийг шүүхийн шийдвэрээр төлөх үүрэгтэй авлагыг хамруулсан бусад авлагаас түрүүлж шилжүүлэх;
- 64.6.5. өртэй татвар төлөгч ажлаас чөлөөлөгдсөн, эсхүл халагдсан бол ажлын 7 өдрийн дотор татварын өрд суутгасан дүн болон өртэй татвар төлөгчийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг татварын албанд хүргүүлэх;
- 64.6.6. цалин хөлснөөс татварын өрийг гаргуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 63.2-т заасныг баримтална.

64.7.Авлага битүүмжилсэн хугацаанд өртэй татвар төлөгч гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулах, дуусгавар болгохыг хориглоно.

65 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх, татварын өр гаргуулах

65.1. Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох харилцааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

65.1.1. үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэхдээ өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудас хүргүүлэх бөгөөд битүүмжлэх ажиллагаа нь тухайн битүүмжлэлийн хуудсыг өртэй татвар төлөгчид хүргүүлснээр эхлэх;

65.1.2. татварын алба үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилсэн талаар бүртгэх байгууллагад бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг битүүмжлэлийн хуудас хүргүүлэхээс өмнө хийсэн бол энэ хуулийн 65.1.1-д заасныг үл хамааран бүртгүүлснээр битүүмжлэх ажиллагаа үүсэх;

65.1.3. татвар төлөгч битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох боломжтой боловч үл хөдлөх эд хөрөнгийн үнэ цэнийг огцом бууруулах магадлалтай үйлдэл хийх гэж байгаа нь тогтоогдсон тохиолдолд татварын алба тухайн үл хөдлөх хөрөнгийн ашиглалт болон ашиг олох үйл ажиллагааг хязгаарлаж болох бөгөөд энэ нь битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах болон ашиг орлого олох эрхтэй гуравдагч этгээдэд мөн хамаарах.

65.2. Агаарын хөлгийг битүүмжлэх, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн агаарын хөлгийг түр зогсоох ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

65.2.1. агаарын хөлгийг битүүмжлэхдээ энэ хуулийн 65.1.1, 65.1.2-т заасныг баримтлах;

65.2.2. нислэг үйлдэхэд бэлэн байгаа агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийг татварын албаны шийдвэрээр түр хугацаагаар зогсоох;

65.2.3. татварын өр хураах үйл ажиллагаанд шаардлагатай бол битүүмжилсэн агаарын хөлгийг хамгаалах, хадгалах арга хэмжээг авах;

65.2.4. энэ хуулийн 65.2.3-т заасан арга хэмжээг битүүмжлэлийн хуудас хүргүүлэхээс өмнө авсан бол тухайн арга хэмжээг авах үед битүүмжлэх ажиллагааг эхлэх;

65.2.5. татварын албаны даргын шийдвэрээр агаарын хөлгийг битүүмжилсэн, эсхүл энэ хуулийн 65.2.2-т заасны дагуу зогсоосон агаарын хөлгийг хүндэтгэн үзэх шалтгаантай бол хөдөлгөх зөвшөөрөл олгох.

65.3.Автомашин, барилгын тоног төхөөрөмжийн битүүмжлэх ажиллагаа, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хөдөлгөх, ашиглах ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

65.3.1.улсын бүртгэлд бүртгэлтэй автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэхдээ энэ хуулийн 65.1.1, 65.1.2-т заасныг баримтлах;

65.3.2.автомашин, барилгын тоног төхөөрөмж битүүмжлэхэд энэ хуулийн 65.2.3, 65.2.4-т заасныг дагаж мөрдөх;

65.3.3.татварын албаны шийдвэрээр автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх бөгөөд энэ тохиолдолд өртэй татвар төлөгч тухайн хөрөнгийг татварын албаны мэдэлд шилжүүлэх;

65.3.4.энэ хуулийн 65.3.3-т заасны дагуу автомашин, барилгын тоног төхөөрөмжийг татварын албаны мэдэлд шилжүүлсэн тохиолдолд энэ хуулийн 62.1, 62.4, 62.5, 62.6, 62.7, 62.8-д заасныг дагаж мөрдөх;

65.3.5.татварын алба энэ хуулийн 65.3.3-т заасны дагуу мэдэлдээ авсан автомашин, барилгын тоног төхөөрөмжийг өртэй татвар төлөгч болон тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гуравдагч этгээдэд хадгалуулж болох бөгөөд лацдах, олон нийтэд мэдэгдэх аргыг хэрэглэх зэргээр автомашин, барилгын тоног төхөөрөмжийг татварын алба мэдэлдээ авсныг тодорхой болгох;

65.3.6.Татварын алба энэ хуулийн 65.3.3, 65.3.5-д заасны дагуу мэдэлдээ авсан, эсхүл хадгалуулсан автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хүндэтгэн үзэх шалтгаантай бол ашиглуулахыг зөвшөөрөх.

Тайлбар:“агаарын хөлөг хадгалах, хамгаалах” гэж тухайн агаарын хөлгийг нислэг үйлдэх боломжгүй болгож байрлуулах, эсхүл агаарын хөлгийн бүртгэлийн баримт бичиг бусад хөдөлгөөнд оролцоход шаардагдах бичиг баримтыг хураан авахыг хэлнэ.

66 дугаар зүйл.Биет бус хөрөнгө битүүмжлэх

66.1.Биет бус хөрөнгийн хувьд гуравдагч этгээд ашиглаагүй тохиолдолд уг хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

66.1.1.патентын эрх, зохиогчийн эрх болон бусад гуравдагч этгээд ашиглаагүй хөрөнгийг битүүмжлэхдээ өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудсыг хүргүүлэх бөгөөд битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь тухайн битүүмжлэлийн хуудсыг өртэй татвар төлөгчид хүргүүлснээр эхлэх;

66.1.2.татварын албаны даргын шийдвэрээр хөрөнгийн эрхийг шилжүүлэх зорилгоор бүртгүүлэх шаардлагатай хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд холбогдох байгууллагад бүртгүүлэх;

- 66.1.3.энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд 66.1.1-д заасныг үл харгалзан 66.1.2-т заасан битүүмжлэх ажиллагааг бүртгүүлснээр битүүмжлэлийн үйлчлэл үүсэх;
- 66.1.4.захиран зарцуулах эрхийн хязгаарлалтыг бүртгүүлэх шаардлагатай хөрөнгийн битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь энэ хуулийн 66.1.1, 66.1.3-т зааснаас үл хамааран бүртгүүлэхэд үүсэх.
- 66.2.Биет бус хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн ашиглаж байгаа уг хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:
- 66.2.1.хэвлэх эрх, хувьцаа болон бусад гуравдагч этгээдийн ашиглаж байгаа хөрөнгийг битүүмжлэхдээ гуравдагч этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудсыг хүргүүлэх бөгөөд битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь тухайн битүүмжлэх мэдэгдэх хуудсыг гуравдагч этгээдэд хүргүүлснээр эхлэх;
- 66.2.2.энэ хуулийн 66.2.1-д заасан хөрөнгийг шилжүүлэх зорилгоор бүртгүүлэх шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 66.1.2, 66.1.3-т заасныг баримтлах.

67 дугаар зүйл.Татварын өр хураахаар бусад байгууллагад суутгах хүсэлт гаргах

- 67.1.Татвар төлөгчийн хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагаагаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа эхлүүлсэн бол татварын алба тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа байгууллагад татварын өрийг суутгах хүсэлтийг хүргүүлнэ. Суутгах хүсэлт хүргүүлснээр тухайн татвар төлөгчид болон хөрөнгийн барьцаалсан эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.
- 67.2.Татвар төлөгчид татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар, гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүй өөр хөрөнгөтэй, тухайн хөрөнгөөс татварын өрийг хураах боломжтой болох нь тогтоогдвол татварын алба суутгах хүсэлтийг гаргахгүй.

68 дугаар зүйл.Битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа

- 68.1.Татвар төлөгч нөхөн ногдуулалтын актад гомдол гаргасан бол эцсийн шийдвэр гарах хүртэл хугацаанд энэ хуулийн 63 дугаар зүйлд зааснаас бусад тухайн татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг эхлүүлэхгүй.
- 68.2.Татвар төлөгч өөрийн ногдуулсан татвараа хуульд заасан хугацаанд нь төлөөгүйн улмаас үүссэн татварын өр, хуульд заасан хугацаанд гомдол гаргаагүй нөхөн ногдуулалтын актын өр, эсхүл нөхөн ногдуулалтын актад гаргасан гомдлын дагуу төлөхөөр Маргаан таслах зөвлөл болон шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн татварын өрийг татварын алба битүүмжилсэн

хөрөнгө, энэ хуулийн 53.6, 53.7, 53.8-д заасан барьцааны зүйлээс Иргэний хуулийн холбогдох заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаа зохион байгуулж, эсхүл энэ хуульд заасан журмын дагуу шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлнэ.

68.3.Татварын алба энэ хуулийн 68.2-т заасан хөрөнгийн дуудлага худалдааны үнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу тогтооно.

68.4.Тухайн татвар төлөгч болон татварын улсын байцаагч, татварын албаны ажилтан мөнгөн хэлбэрт шилжүүлэх хөрөнгийг шууд болон шууд бус байдлаар худалдан авах эрхгүй.

68.5.Шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг дараах нөхцөлд явуулна:

68.5.1.тухайн хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулахад тохиромжгүй, эсхүл түргэн гэмтэж муудахаар байх;

68.5.2.Хөрөнгийн биржид бүртгэлтэй хөрөнгийг тухайн өдрийн зах зээлийн үнээр борлуулах бүрэн боломжтой байх;

68.5.3.дуудлага худалдааг хоёр удаа зохион байгуулсан боловч оролцогч байхгүй, худалдах үнэ нь дуудлага худалдааны анхны үнэд хүрэхгүй, эсхүл худалдан авагч төлбөр төлөх хугацаандаа төлбөрөө төлөөгүйгээс худалдан авах шийдвэрээ цуцалсан байх.

68.6.Дуудлага худалдаагаар болон шууд гэрээгээр борлуулсан хөрөнгийн орлого нь татварын өрийг хураахад хүрэлцэхээргүй бол татвар төлөгч уг татварын өрийн үлдсэн хэсгийг төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.

68.7.Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

69 дүгээр зүйл.Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг хуваарилах

69.1.Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгийг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:

69.1.1.татварын алба битүүмжилсэн хөрөнгийн борлуулсан орлогын дүн болон үнэт цаас, авлага, эсхүл биет бус хөрөнгийн битүүмжлэлийн дагуу гуравдагч этгээдээс хүлээн авсан мөнгөн хөрөнгийг /цаашид “шилжүүлсэн мөнгөн хөрөнгө” гэх/ битүүмжлэлтэй татвар, суутгах хүсэлт гаргасан татвар, битүүмжилсэн хөрөнгийн барьцаат эрх, ипотекийн эрх, түрүүлж авах давуу эрхийн дагуу барьцаалагдсан авлагад хуваарилах;

- 69.1.2.битүүмжилсэн мөнгөн хөрөнгө болон суутгалын хүсэлтээр хүлээн авсан мөнгөн хөрөнгийг тухайн битүүмжлэл, эсхүл суутгалын хүсэлтэд хамаарах татварт шилжүүлэх;
- 69.1.3.энэ хуулийн 69.1.1, 69.1.2-т заасны дагуу хуваарилсан мөнгөн хөрөнгөөс үлдсэн тохиолдолд тухайн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг өртэй татвар төлөгчид олгох;
- 69.1.4.шилжүүлсэн мөнгөн хөрөнгө нь энэ хуулийн 69.1.1-д заасан татвар болон бусад авлагын нийт үнийн дүнд хүрэлцэхгүй бол энэ хуульд заасан татварын давуу эрхийн зарчим, Иргэний хууль болон бусад хуульд заасан дараалал, үнийн дүнг тогтоон хуваарилах;
- 69.1.5.энэ хуулийн 69.1.1, эсхүл 69.1.2-т заасны дагуу татварын хуваарилалт хийгдсэн мөнгөн хөрөнгийг татвар, алданги, торгуульд хуваарилахдаа энэ хуульд заасан татварын өр барагдуулах дарааллыг баримтлах.
- 69.2.Авлагатай этгээдээс татварын албанд гаргасан хүсэлтийг дараах байдлаар хянана:
- 69.2.1.энэ хуулийн 69.1.1-д заасан авлагатай этгээд хөрөнгө худалдах шийдвэр гаргахаас өмнө татварын албанд хандан авлагын хүсэлт гаргах;
- 69.2.2.татварын алба энэ хуулийн 69.2.1-д заасан авлагын хүсэлтийг хүлээн авч, нягтлах бөгөөд бүртгэгдсэн барьцаат авлагын эрх, ипотекийн зээлийн эрх, түрүүлж авах давуу эрх болон бүртгэх боломжгүй барьцаа, эсхүл түрүүлж авах давуу эрх нь мэдэгдэж байгаа этгээд авлагын хүсэлт гаргаагүй тохиолдолд татварын албаны дарга тухайн авлагын хэмжээг тодорхойлох;
- 69.2.3.энэ хуулийн 69.1.1-д заасан битүүмжилсэн хөрөнгийн барьцаат эрх, ипотекийн зээлийн эрх, түрүүлж авах давуу эрхийн дагуу барьцаалагдсан авлагын хувьд энэ хуулийн 69.2.2-т заасан авлагаас бусад авлагатай этгээд хөрөнгө худалдан борлуулах шийдвэр гаргах хүртэл авлагын хэмжээтэй холбоотой хүсэлт гаргаагүй бол тухайн авлагатай этгээдэд хуваарилахгүй байх.
- 69.3.Хуваарилалтын тооцооллын акт үйлдэх, шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг олгохдоо дараах байдлаар хэрэгжүүлнэ:
- 69.3.1.Татварын алба энэ хуулийн 69.1-д заасны дагуу хуваарилахдаа хууль тогтоомжийн дагуу хуваарилах авлага, энэ хуулийн 69.2.2-т заасны дагуу татварын албаны тодорхойлсон дүн, энэ хуулийн 69.3.2-т заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан хуваарилалтын тооцооллын акт үйлдэн, түүний хуулбарыг мөнгөн хөрөнгийг шилжүүлснээс хойш ажлын гурван өдөрт багтаан авлагын хүсэлт гаргасан этгээд болон энэ хуулийн 69.2.2-т

заасны дагуу авлагын хэмжээг тодорхойлсон авлагатай этгээд, өртэй татвар төлөгчид хүргүүлэх;

69.3.2.шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг авлагатай этгээдэд олгох хугацааг хуваарилалтын тооцооллын актын хуулбарыг хүргүүлснээс хойш ажлын долоон өдрийн дараагийн өдөр гэж үзэх;

69.3.3.татварын алба шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн хуваарилалтын тооцооллын актын хугацааг үндэслэн олгох.

69.4.Хуваарилалтын тооцооллын акттай холбоотой санал, гомдлыг шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг олгохоос өмнө гаргаж болно.

70 дугаар зүйл.Татварын өр хураах үйл ажиллагааг шилжүүлэх

70.1.Татварын алба битүүмжилбэл зохих хөрөнгө болон битүүмжилсэн хөрөнгө нь тухайн албаны харьяаллын бус байвал тухайн хөрөнгө байршиж байгаа татварын албанд татварын өр барагдуулах үйл ажиллагааг шилжүүлж болно.

70.2.Татварын алба битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай бол бусад татварын албанд татварын өр барагдуулах үйл ажиллагааг шилжүүлж болно.

70.3.Энэ хуулийн 70.1, 70.2-т заасны дагуу шилжүүлсэн тохиолдолд шилжүүлэн авсан татварын алба энэ тухай өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

71 дүгээр зүйл.Бусад хууль тогтоомжид заасан эрх хязгаарлах болон түдгэлзүүлэх арга хэмжээ авах

71.1.Татварын алба энэ хуульд заасан татварын өрийг хураах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө татварын өрийн хэмжээнээс хамаарч татвар төлөгчид сануулах байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг авч болно.

71.2.Доор дурдсан нөхцөл нэгэн зэрэг бий болсон тохиолдолд татварын алба татварын өртэй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татварын өрөө төлж дуустал Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байхаар эрх бүхий байгууллагад хандах эрхтэй:

71.2.1.татварын өртэй этгээдэд татварын өр барагдуулах хөрөнгө, авлагагүй;

71.2.2.татварын өрийн хэмжээ нь 20 сая төгрөг ба түүнээс дээш байх.

71.3.Энэ хуулийн 71.1-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

72 дугаар зүйл.Татварын албаны үндэслэлгүй илүү хураасан мөнгөн хөрөнгө

- 72.1.Нөхөн ногдуулалтын актыг хүчингүй болгосон буюу өөрчилсний улмаас бүрэн буюу хэсэгчлэн буцаан олгох татвар, торгууль, алдангийг татварын буцаан олголтын актаар баталгаажуулна.
- 72.2.Энэ хуулийн 72.1-д заасан актаар баталгаажуулснаас хойш ажлын 30 өдрийн дотор илүү төлсөн татварыг буцаан олгоно.
- 72.3.Энэ хуулийн 72.1-д заасан мөнгөн хөрөнгийг татвар төлөгч зөвшөөрвөл энэ хуулийн 49.1.2, 49.1.3-т заасан журмаар шийдвэрлэх бөгөөд энэ нь тухайн илүү төлөлтийн дүнд энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу алданги тооцохгүй байх үндэслэл болохгүй.
- 72.4.Энэ хуулийн 72.1-д заасан буцаан олгох дүнг татвар төлөгч эс зөвшөөрвөл татварын буцаан олголтын актыг гардан авснаас хойш Маргаан таслах зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргаж болно.

73 дугаар зүйл.Алданги

- 73.1.Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт, эсхүл татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварт тус тус алданги тооцох бөгөөд тухайн татварын жилд мөрдөх алдангийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн татварын жилийн 1 дүгээр сард багтаан дараах зарчмыг үндэслэн тогтооно:
- 73.1.1.татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дунджаас 20 хувиар илүү байхаар;
- 73.1.2.татварын албанаас үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дундаж байхаар.
- 73.2.Алданги тооцох хугацааг доор дурдсанаар тодорхойлно:
- 73.2.1.татварын хууль тогтоомжид заасны дагуу тухайн татварыг төлбөл зохих өдрөөс түүнийг төлсөн өдрийг хүртэлх хоногийн тоогоор;
- 73.2.2.Татварын албаны илүү хураасан энэ хуулийн 73.1-д заасан мөнгөн хөрөнгийг хураасан өдрөөс эхлэн түүнийг буцаан олгох шийдвэр гарсан өдөр хүртэлх хоногийн тоогоор.
- 73.3.Татварын алданги, торгуульд алданги тооцохгүй.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБАНЫ ТОГТОЛЦОО

74 дүгээр зүйл.Монголын татварын алба

- 74.1.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.
- 74.2.Монголын татварын алба нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын газар, хэлтэс, тасаг, татварын улсын байцаагч, хураагчаас бүрдэнэ.
- 74.3.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь том татвар төлөгчтэй харилцах, хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологи, сургалт, татварын үйлчилгээ хариуцсан харьяа нэгжтэй байж болно.
- 74.4.Татварын алба нь өөрийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, татварын болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 74.5.Татварын алба нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

75 дугаар зүйл.Татварын албаны чиг үүрэг

- 75.1.Татварын алба дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 75.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах;
 - 75.1.2.татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 75.1.3.төсвийн орлогыг бүрдүүлэх.
- 75.2.Татварын алба нь татвар төлөгчийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хүндэтгэн, татвар ногдуулах, төлөх, тайлагнах үйл ажиллагаатай холбогдуулан түүнийг хууль тогтоомжийн дагуу мэдээллээр хангаж, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.
- 75.3.Энэ хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу татвар төлөгчид хүргүүлсэн зөвлөмжийг доод шатны татварын алба нь хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөмж гаргасан этгээдээс зохих тодруулгыг авч болно.
- 75.4.Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн татварын мэргэшсэн зөвлөхийн туслалцаа, зөвлөгөө авах эрхтэй.
- 75.5.Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх харилцааг Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.
- 75.6.Татварын алба татварын хууль, тогтоомжийг олон нийтэд танин мэдүүлэх зорилгоор татварын хууль тогтоомж, заавар, аргачлалын талаар сургалт зохион байгуулна.

75.7.Татварын алба цахим хуудсандаа татварын хууль тогтоомжийг байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтийг хамарсан сурталчилгаа, сургалт, мэдээллийн нэвтрүүлэг зохион байгуулах, нийтлэл гаргана.

75.8.Татварын алба бүх нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

76 дугаар зүйл.Татварын албаны үйл ажиллагааны зарчим, эрх үүрэг, хориглох зүйл

76.1.Татварын алба нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

76.1.1.хууль дээдлэх;

76.1.2.бусдын нөлөөнд үл автах;

76.1.3.татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, түүнийг хэрэгжүүлэх боломжийг хангах, тэдэнд итгэл үзүүлэх;

76.1.4.доод шатны байгууллага нь дээд шатны байгууллагадаа шууд захирагдах.

76.2.Хувь хүн, хуулийн этгээд, албан тушаалтан татварын алба, татварын улсын байцаагчаас хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.

76.3.Татварын алба, татварын улсын байцаагч энэ хуулийн 76.2-т заасныг зөрчсөн этгээдийн талаар холбогдох байгууллагад гомдол гаргаж, учирсан хохирлыг барагдуулахаар шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

76.4.Татварын алба, татварын улсын байцаагчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

76.5.Хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон асуудлаар бусдын өмнө үүрэг хүлээхийг хориглоно.

76.6.Татварын алба бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон ажиллах бөгөөд татварын алба энэ үүргээ хэрэгжүүлэхгүй бол татвар төлөгч хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй.

76.7.Татварын алба, татварын улсын байцаагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, тэдэнд итгэл үзүүлэн ажиллана.

76.8.Татварын алба, татварын улсын байцаагч, хураагч нь хуульд заасны дагуу татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх, татварын ногдлыг тодорхойлох, татвар төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбоотойгоос бусад асуудлаар татвар төлөгчийн үйл ажиллагаанд оролцохгүй.

76.9.Татварын улсын байцаагч, хураагч нь хувийн зорилгоор татвар төлөгчтэй холбогдож түүнд аливаа хэлбэрээр зөвлөгөө өгөх, нягтлан бодох бүртгэл

хөтлөх, тайланг гаргах, аудит хийх, татвараас зайлсхийхэд туслах, шаардахыг хориглоно.

77 дугаар зүйл.Татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх

77.1.Татварын алба нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

77.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, аймаг, нийслэлийн татварын газар, хэлтэс татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, дүүргийн татварын хэлтэс, сумын татварын хэлтэс, тасаг, татварын улсын байцаагч, хураагч нь аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн удирдлага доор тус тус ажиллана.

77.3.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүх шатны татварын албаны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлага, төсөв хөрөнгөөр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

77.4.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 183.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.

77.5.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

77.6.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг санхүү, эдийн засаг, эсхүл нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй иргэнийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.

77.7.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь татварын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-г зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

77.7.1.татварын алба, татварын улсын байцаагчийн бүрэн эрхийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалт болон төсөв хөрөнгөөр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах;

77.7.2.татварын хууль тогтоомжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэг мөр дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

77.7.3.энэ хууль болон татварын бусад хууль тогтоомжоор олгосон эрхийн хүрээнд тушаал гаргах, нийтээр дагаж мөрдөх журам, заавар, аргачлал, акт, маягтын загварыг баталж мөрдүүлэх, зөвлөмж гаргах;

77.7.4.татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх;

- 77.7.5. татварын хууль тогтоомжийн төсөл боловсруулахад оролцох, тэдгээрийг татварын албанаас хэрэгжүүлэх арга, хэлбэр, боломжийн талаарх саналаа бэлтгэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;
- 77.7.6. орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын хэлэлцээрийн төсөлд санал бэлтгэж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;
- 77.7.7. татварын алба, улсын байцаагчийн шийдвэрийг хуулийн хүрээнд хянан үзэж, шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл өөрчлөх, хүчингүй болгох;
- 77.7.8. татварын албаны ажилтныг шилжүүлэх, сэлгэж ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах;
- 77.7.9. татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн татварын албаны ажилтныг томилох, чөлөөлөх;
- 77.7.10. татварын албаны дотоод хяналтыг хэрэгжүүлэх;
- 77.7.11. хууль тогтоомжид заасны дагуу татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;
- 77.7.12. татварын улсын байцаагчийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах;
- 77.7.13. татварын албаны төсөв, хөрөнгийг захиран зарцуулах;
- 77.7.14. татварын албыг гадаад, дотоодод болон шүүх, арбитраж төлөөлөх;
- 77.7.15. Татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулж, батлах.
- 77.8. Сумын татварын ажилтныг тухайн аймгийн татварын албаны дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх бөгөөд тухайн ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах эрхтэй байна.
- 77.9. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд татварын улсын ерөнхий байцаагч нь энэ хуулийн 77.7.3, 77.7.4, 77.7.8, 77.7.13, 77.7.15-д зааснаас бусад 77.7 дахь хэсэгт заасан бүрэн эрхээс нийслэл, аймаг, дүүргийн татварын албаны удирдлагад тушаалаар шилжүүлж болно.
- 77.10. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын эзгүйд түүнийг дэд дарга орлоно.

78 дугаар зүйл. Татварын хууль тогтоомж хэрэгжүүлэх зөвлөмж

- 78.1. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга энэ хуулийн 77.7.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд татварын алба үйл ажиллагаандаа заавал дагаж мөрдөх доор дурдсан зөвлөмжийг гаргаж болно:
- 78.1.1. татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн, эсхүл татварын албаны санаачилгаар татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмж;

- 78.1.2.Маргаан таслах зөвлөл, шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн асуудлыг улсын хэмжээнд нэг мөр хэрэгжүүлэх зөвлөмж.
- 78.2.Татварын алба татвар төлөгч, төрийн болон бусад этгээдийн нууцад хамаарснаас бусад мэдээллийг агуулсан олон нийтэд нээлттэй зөвлөмжийн цахим сантай байна. Зөвлөмж гарснаас хойш 10 өдрийн дотор цахим санд нийтэлнэ.
- 78.3.Энэ хуулийн 78.1.1-д заасан хүсэлтийг дараах тохиолдолд татварын улсын ерөнхий байцаагч хүлээн авахаас татгалзаж болно:
- 78.3.1.татвар төлөгч нь татварын хяналт шалгалтад хамрагдаж байгаа, эсхүл татварын хяналт шалгалт хийх талаар мэдэгдсэн;
- 78.3.2.татварын алба нь хүсэлтэд дурдсан асуудлаар зөвлөмж гаргаж байсан;
- 78.3.3.татварын албаны чиг үүрэгт үл хамаарах асуудлаар хүсэлт гаргасан;
- 78.3.4.татвар төлөгч татварын асуудлаар Маргаан таслах зөвлөл, шүүхэд гомдол гаргасан, эсхүл татвар төлөгчтэй холбоотой хэрэг хууль хяналтын байгууллагаар хянан шалгагдаж байгаа;
- 78.3.5.татвараас зайлсхийх, зугтах зорилготой асуудлыг тусгасан;
- 78.3.6.хөрөнгө оруулалтын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ, тогтворжуулалтын гэрчилгээтэй холбоотой татварын харилцааг тусгасан;
- 78.3.7.харилцан хамааралтай этгээд тогтоолгох болон үнэ шилжилтийн тохируулга, үнэ шилжилтийн тайлантай холбогдсон харилцааг тусгасан;
- 78.3.8.энэ хуулийн 78.7-д заасан журмаар тогтоосон шаардлага хангаагүй.
- 78.4.Зөвлөмж нь хуульд нийцээгүй болон энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй бол татварын улсын ерөнхий байцаагч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бүрэн буюу хэсэгчлэн хүчингүй болгож болно. Хүчингүй болгосон тухай хүсэлт гаргасан татвар төлөгч болон олон нийтэд мэдэгдэнэ.
- 78.5.Зөвлөмжид туссан асуудлаар татварын хууль тогтоомжид өөрчлөлт орсон бол түүнийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс зөвлөмжийг хүчингүйд тооцно.
- 78.6.Зөвлөмжөөр татвар төлөгчийн тухайлсан ажил, гүйлгээг татварын тайланд тусгах аливаа дүн, татварын ногдлын хэмжээг баталгаажуулахгүй.
- 78.7.Энэ зүйлийн зөвлөмж авах хүсэлтэд тавигдах шаардлага, хүсэлтийн маягт, зөвлөмжийн маягт, зөвлөмжийг хүчингүй болгох, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

79 дүгээр зүйл.Татварын алба, татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичиг

- 79.1.Татварын албанаас татвар хураах, хяналт тавих, татварын шалгалт хийхтэй холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гаргасан шийдвэрийг мэдэгдэл, шаардах хуудас, битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас, нөхөн ногдуулалтын акт, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, илтгэх хуудас, тэмдэглэл, татварын буцаан олголтын акт, нэхэмжлэх, урьдчилан нэхэмжлэх хуудас, мэдэгдэх хуудас, шаардлага, суутгалын хүсэлт, хуваарилалтын тооцооллын акт, зарлан дуудах хуудас, битүүмжлэх мэдэгдэх хуудас, зөвлөмж болон татварын албаны үйлдэх бусад баримт бичиг үйлдэн баталгаажуулна.
- 79.2.Энэ хуулийн 79.1-д заасан баримт бичигт түүнийг үйлдсэн албан тушаалтны нэр, гарын үсэг, гаргасан шийдвэр, тухайн шийдвэрийг гаргах үндэслэл, биелүүлэх хугацаа, баримт бичгийг гардуулсан он, сар, өдрийг тусгана.
- 79.3.Энэ хуулийн 79.1-д заасан баримт бичгийг татвар төлөгчид биечлэн гардуулсан болон түүний оршин байгаа, эсхүл ажиллаж байгаа газрын хаягаар шууданд хийснээр, эсхүл цахимаар илгээснээр уг баримт бичгийг татвар төлөгчид гардуулсанд тооцох бөгөөд татвар төлөгчийн оршин байгаа газрыг холбогдох бүртгэх байгууллагад хамгийн сүүлд бүртгүүлсэн хаягаар тодорхойлно.
- 79.4.Энэ хуулийн 79.1-д заасан баримт бичгийг дараах үндэслэл, журмын дагуу үйлдэнэ:
- 79.4.1.татвар төлөгч болон бусад этгээдийг дуудан ирүүлэхэд мэдэгдэл бичих бөгөөд түүнд татвар төлөгчийн болон татварын улсын байцаагчийн нэр, гарын үсэг, татварын албанд ирэх хугацаа, уг мэдэгдэл үйлдсэн болон гардуулсан он, сар, өдрийг тусгах;
- 79.4.2.татварын хууль тогтоомжийг зөрчихөд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах зорилгоор шаардах хуудас бичих бөгөөд түүнд шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, зөрчлийн тухай тэмдэглэл, зөрчил гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгааныг арилгаж, хариу өгөх хугацаа, уг шаардах хуудсыг үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгах;
- 79.4.3.татвар төлөгчид хууль тогтоомжийн дагуу татварыг нөхөн ногдуулж хариуцлага хүлээлгэх, алданги тооцоход нөхөн ногдуулалтын акт үйлдэх бөгөөд түүнд хяналт шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, зөрчлийн тухай тэмдэглэл, шийдвэрлэсэн үндэслэл, уг актыг үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгах;
- 79.4.4.татварын хяналт шалгалтаар татварын хууль тогтоомж зөрчөөгүй нь тогтоогдвол илтгэх хуудас үйлдэх бөгөөд түүнд шалгалт хийсэн

- холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч, татвар төлөгч гарын үсэг зурж, үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгах;
- 79.4.5. татварын алба бүрэн эрхийнхээ хүрээнд татвар төлөгчийн байр, агуулахад үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх, хөрөнгө битүүмжлэх, ярилцлага хийх, нөхөн ногдуулалтын актыг гардуулахдаа тэмдэглэл үйлдэх ба түүнд хяналт шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, тэмдэглэл үйлдсэн он, сар, өдөр, татвар төлөгчийн хаягийг тодорхой тусгаж, шаардлагатай гэж үзвэл тэмдэглэл үйлдэхэд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулах;
- 79.4.6. татварын албаны үндэслэлгүйгээр илүү хураасан мөнгөнд алданги тооцож татвар төлөгчид олгоход татварын буцаан олголтын акт үйлдэж, түүнд буцаан олгох дүнг тогтоосон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, мөнгөн дүн, алданги тооцсон хугацаа, тооцсон алдангийн дүн, илүү төлсөн мөнгө, алдангийг тусгах;
- 79.4.7. татварын алба татвар төлөгчийн татварын өрийг төлүүлэхээр нэхэмжлэх, урьдчилан нэхэмжлэх хуудас, татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд, батлан даагчаас гаргуулахдаа мэдэгдэх хуудас, татварын өрийг үл маргах журмаар болон авлагаас гаргуулахдаа битүүмжлэх мэдэгдэх хуудас бичих бөгөөд түүнд татварын өрийн хэмжээ, төлөх эцсийн хугацаа, татварын өрийг төлөх банкны данс болон татвар төлөгчийн харилцах банк болон дансны дугаар, татвар төлөгчийн болон татвар төлөгчийн нэрийн өмнөөс татварын өрийг төлөх хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, гарын үсэг, үйлдсэн болон гардуулсан он, сар, өдөр зэрэг энэ хуульд заасан мэдээллийг тусгах;
- 79.4.8. татварын алба энэ хуулийн 30 дугаар зүйлийг хэрэгжүүлэхээр шаардлага үйлдэх бөгөөд түүнд шаардлага бичсэн шалтгаан, нөхцөл, татвар төлөгчийн, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн болон шаардлага үйлдсэн улсын байцаагчийн нэр, гарын үсэг, үйлдсэн болон гардуулсан он, сар, өдрийг бичих;
- 79.4.9. татварын өрийг татвар төлөгчийн хөрөнгөөс гаргуулахдаа энэ хуульд заасны дагуу битүүмжлэх акт болон битүүмжлэлийн хуудас үйлдэнэ. Битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудаст татварын өрд хамаарах татварын тайлант хугацаа, татварын төрөл, төлөх хуулийн хугацаа болон хэмжээ, битүүмжилсэн хөрөнгийн нэр төрөл, тоо, шинж чанар, байршил, өртэй татвар төлөгчийн нэр, хаягийг тусгах;

- 79.4.10. өртэй татвар төлөгчийн хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагаагаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа эхлүүлсэн байгууллагад татварын өрийг суутгуулахаар суутгалын хүсэлтийг хүргүүлэх бөгөөд түүнд өртэй татвар төлөгчийн нэр, хаяг, суутгуулах татварын тайлант хугацаа, татварын төрөл, төлөх хуулийн хугацаа, хэмжээ, суутгалын хүсэлтэд хамаарах албадан гүйцэтгэлээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг эхлүүлсэн хөрөнгийн нэр төрөл, тоо, шинж чанар болон хаягийг тусгах;
- 79.4.11. татварын өр хураах зорилгоор татвар төлөгчийн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг хуваарилахад хуваарилалтын тооцооллын акт үйлдэх бөгөөд түүнд татвар төлөгчийн нэр, хаяг, хуваарилбал зохих нийт мөнгөн хөрөнгө, битүүмжлэлд хамаарах татварын дүн, хуваарилах дараалал, хуваарилах мөнгөн дүн, авлагын хүсэлт гаргасан этгээдийн нэр, хаяг, авлагын хэмжээ, хуваарилах дараалал, хуваарилах мөнгөн дүн, хуваарилалтыг олгох хугацааг тусгах;
- 79.4.12. татварын хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид уг зөрчлийг дахин гаргуулахгүй байх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж үйлдэх бөгөөд түүнд татварын төлөгчийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, хүргүүлсэн он, сар өдрийг тусгах;
- 79.4.13. татварын хяналт шалгалтад шаардагдах магадлагаа, баримтын хуулбар, банкны гүйлгээний хуулга болон эдгээртэй адилтгах нотлох баримтыг татвар төлөгчтэй харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, санхүүгийн байгууллагаас гаргуулан авах зорилгоор зарлан дуудах хуудас үйлдэж, татвар төлөгчид хүргүүлэх бөгөөд түүнд татвар төлөгчийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, хүргүүлсэн он, сар өдрийг тусгах.
- 79.5. Татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичгийн загварыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.
- 79.6. Энэ хуулийн 79.4-т заасан баримт бичгийг батлагдсан загварын дагуу дахин давтагдахгүй нэгдсэн дугаартайгаар ашиглах бөгөөд татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд заавал бүртгэнэ.
- 79.7. Татварын алба, татварын улсын байцаагч нь энэ зүйлд заасан баримт бичгийн хэвлэмэл хуудас, маягтыг зөвшөөрөлгүй хэвлэн ашиглах, хүчингүй буюу хуурамч хуудас хэрэглэх, зориулалт бусаар ашиглахыг хориглоно.
- 79.8. Татвар төлөгч нь энэ зүйлд заасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

80 дугаар зүйл. Татварын улсын байцаагчийн эрхийн баталгаа

- 80.1.Татварын улсын байцаагчийн цалин хөлс нь Төрийн албаны тухай хуулийн 57.2.2-т зааснаас гадна ажлын үр дүнгийн шагнал болон хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ.
- 80.2.Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Төсвийн тухай хуульд нийцүүлэн батална.
- 80.3.Татварын улсын байцаагчид доор дурдсан цол олгож болно:
- 80.3.1.татварын жинхэнэ зөвлөх;
 - 80.3.2.татварын итгэмжит зөвлөх;
 - 80.3.3.татварын зөвлөх.
- 80.4.Татварын улсын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хувцас, хэрэглэлээр хангагдсан байна.
- 80.5.Татварын улсын байцаагч хувцас, хэрэглэл хэрэглэх, цол, түүний нэмэгдэл олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

81 дүгээр зүйл.Татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх

- 81.1.Татварын алба болон татварын улсын байцаагчийн гаргасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад шийдвэрийн талаар татвар төлөгч нь захиргааны журмаар дараах харьяаллаар гомдол гаргаж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй:
- 81.1.1.татварын улсын байцаагчийн үйлдсэн татварын актаас бусад шийдвэртэй холбогдсон гомдлыг тухайн байцаагчийг шууд харьяалах татварын албаны даргад;
 - 81.1.2.татварын албаны шийдвэрийн талаарх гомдлыг түүний дээд шатны татварын албаны даргад;
 - 81.1.3.татварын улсын байцаагчийн үйлдсэн татварын акттай холбогдсон гомдлыг харьяаллын дагуу Маргаан таслах зөвлөлд;
 - 81.1.4.Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй холбогдсон гомдлыг шүүхэд.
- 81.2.Энэ хуулийн 81.1.1, 81.1.2-т заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл татвар төлөгч нь гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

82 дугаар зүйл.Төлөх татварын хэмжээг бууруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага

- 82.1.Татвар төлөгч нь татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл татвар ногдох зүйлийг нуух зорилгоор татвар ногдуулаагүй буюу

татварын ногдлыг бууруулсан бол татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, дараах хэмжээгээр торгоно:

82.1.1.төлбөл зохих татварын дүнг 50 хүртэл хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын дүнгийн 30 хувиар;

82.1.2.төлбөл зохих татварын дүнг 50 ба түүнээс дээш хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар.

82.2.Өмнө нь татварын албаны хяналт шалгалтаар илрүүлж нөхөн ногдуулалтын актаар тогтоосон энэ зүйлд заасан зөрчлийг давтан үйлдвэл, тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.

83 дугаар зүйл.Татвар суутгах үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага

83.1.Суутгавал зохих татвараа суутгаагүй, эсхүл суутган авсан боловч төлж, тайлагнаагүй суутган төлөгч нь уг татварыг нөхөн төлөх үүрэгтэй.

83.2.Энэ хуулийн 83.1-д заасан этгээдийг нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 40 хувиар торгоно.

83.3.Өмнө нь татварын албаны хяналт шалгалтаар илрүүлж нөхөн ногдуулалтын актаар тогтоосон энэ зүйлд заасан зөрчлийг давтан үйлдвэл, тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.

84 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага

84.1.Дараах үйлдэл, эс үйлдлийн улмаас төсөвт төлөх татварын хэмжээг бууруулсан буюу төлөөгүй бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно:

84.1.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх шаардлагыг хангасан боловч гэрчилгээ авалгүйгээр бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, түүнчлэн ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн;

84.1.2.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн хувь хүн, хуулийн этгээд үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй;

84.1.3.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулсан боловч уг татварыг төсөвт төлөөгүй;

84.1.4.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлээгүй этгээд бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, түүнчлэн ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд тэдгээрт албан татвар ногдуулсан боловч түүнийг төсөвт төлөөгүй;

84.1.5.төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулах, эсхүл буцаан авах татварын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын падаан, төлбөрийн баримтын мэдээллийг зөрүүтэй гаргасан, эсхүл падаан, төлбөрийн баримтыг үйлдээгүй.

84.2.Өмнө нь татварын албаны хяналт шалгалтаар илрүүлж нөхөн ногдуулалтын актаар тогтоосон энэ зүйлд заасан зөрчлийг давтан үйлдвэл, тухайн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татварын дүнгийн 50 хувиар торгоно.

85 дугаар зүйл.Татварын улсын байцаагчийн хариуцлага

85.1.Татварын улсын байцаагч, хураагчийн үйлдсэн доор дурдсан зөрчилд холбогдуулж Захиргааны ерөнхий хуулийн 105, 106, 107 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ:

85.1.1.татварын хууль тогтоомжоор хамгаалагдсан татвар төлөгчийн мэдээллийн нууцыг задруулсан;

85.1.2.энэ хуульд заасан албан тушаалын эрхээ хэтрүүлсэн, эсхүл үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй.

85.2.Татварын улсын байцаагч, хураагчийн энэ хуулийн 85.1-д заасан зөрчлийн улмаас татвар төлөгчид хохирол учруулсан бол уг хохирлыг гэм буруутай албан хаагч хариуцна.

86 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

86.1.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 03 сарын 22 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль тогтоомж

2.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /цаашид “албан татвар” гэх/-ын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь Монгол Улсад байрладаг болон Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн орлогод албан татвар ногдуулах харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг;

- 4.1.2.“биет бус хөрөнгө” гэж Иргэний хуулийн 84.5-д заасан эдийн бус хөрөнгийг;
- 4.1.3.“гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит ашиг, алдагдал” гэж гадаад валют худалдах, худалдан авах болон гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өглөгийн тооцоог барагдуулах ажил, гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүгийн ашиг, алдагдлыг;
- 4.1.4.“гадаад улсаас олсон орлого” гэж энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгч, төлөөний газрын энэ хуулийн 4.1.6, 4.1.7-д зааснаас бусад орлого;
- 4.1.5.“ёслол, хүндэтгэлийн арга хэмжээний зардал” гэж аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд бизнесийн харилцаа шинээр тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зочид, төлөөлөгчдийг хүлээн авахад зарцуулсан тээврийн зардал, хүлээн авалт, зочид буудал, зоогийн газрын зардал болон орчуулагчийн хөлс;
- 4.1.6.“Монгол Улсад олсон орлого” гэж албан татвар төлөгчийн Монгол Улсад олсон энэ хуулийн 7.4-т заасан орлогыг;
- 4.1.7.“Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого” гэдэгт албан татвар төлөгчийн дараах орлогыг хамааруулна:
- 4.1.7.а.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн шууд болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараанд Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, төлөөний газраас олгосон орлого;
- 4.1.7.б.энэ хуулийн 5.5.2-т заасан гадаадын аж ахуйн нэгжийн Монгол Улсад зохион байгуулсан урлаг, соёл, спортын болон бусад арга хэмжээнээс олсон орлого;
- 4.1.7.в.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчөөс Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид олгосон ногдол ашгийн орлого;
- 4.1.7.г.төрийн болон нутгийн захиргааны байгууллага, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, төлөөний газраас Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид олгосон, шилжүүлсэн энэ хуулийн 9.4-т заасантай холбогдох хүүгийн орлого;
- 4.1.7.д.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улс дахь эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа хөрөнгө, тэдгээртэй холбоотой эрх борлуулсан, шилжүүлсэн, түрээслүүлснээс олсон орлого;
- 4.1.7.е.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчөөс Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид олгосон эрхийн шимтгэлийн орлого, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгө түрээслүүлсэн, ашиглуулсан болон ашиглах эрхийн орлого,

- санхүүгийн түрээсийн хүүгийн орлого, техникийн, удирдлагын, зөвлөхийн болон бусад үйлчилгээний орлого;
- 4.1.7.ж.төлөөний газраар дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид тухайн төлөөний газраас шилжүүлсэн орлого;
- 4.1.7.з.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн төлөөний газрын эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа хөрөнгө, тэдгээртэй холбоотой эрх борлуулсан, шилжүүлснээс олсон орлого;
- 4.1.7.и.төлөөний газрын үйл ажиллагаанд ашиглагдах хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулсан, түрээслэснээс олсон Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн орлого;
- 4.1.7.к.энэ хуулийн 4.1.7.а-4.1.7.и-д заасантай адилтгах бусад орлого.
- 4.1.8.“суутган төлөгч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.19-д заасныг;
- 4.1.9.“үл хөдлөх эд хөрөнгө” гэж Иргэний хуулийн 84.3, 86.2-т заасныг;
- 4.1.10.“хайгуулын зардал” гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.6, Газрын тосны тухай хуулийн 4.1.8-д заасан болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа эрхлэхтэй шууд холбогдон гарсан баримтаар нотлогдох зардал;
- 4.1.11.“харилцан хамааралтай этгээдүүд” гэж Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасныг;
- 4.1.12.“эрх эзэмшигч” гэж ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, газар ашиглах, эзэмших эрхийг хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу эзэмшдэг этгээдийг.

5 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгч

- 5.1. Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл орлого олоогүй боловч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байна.
- 5.2. Албан татвар төлөгчийг Монгол Улсад байрладаг, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч гэж ангилна.
- 5.3. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчид дараах аж ахуйн нэгж хамаарна:
- 5.3.1.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж;
- 5.3.2.удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж.
- 5.4. Энэ хуулийн 5.3.2-т заасан удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгжид доор дурдсан шалгуураас гурав болон түүнээс дээш нөхцөлийг хангасан гадаадын хуулийн этгээд хамаарна:

- 5.4.1. хувьцаа эзэмшигч, эсхүл өөрийн төлөөллөөрөө дамжуулан хувьцаа эзэмшигчийн эрх, үүргээ шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг хувьцаа эзэмшигчдийн 50-иас дээш хувь нь Монгол Улсад оршин суудаг;
 - 5.4.2. тухайн татварын жилийн өмнөх дараалсан дөрвөн жилд хувьцаа эзэмшигчдийн хурлын нийт тооны 50-иас дээш хувь нь Монгол Улсад зохион байгуулагдсан;
 - 5.4.3. нягтлан бодох бүртгэл, санхүүгийн баримтыг Монгол Улсад хадгалдаг;
 - 5.4.4. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, эсхүл өөрийн төлөөллөөрөө дамжуулан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүргээ шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг этгээдийн 25-аас доошгүй хувь нь Монгол Улсад оршин суудаг;
 - 5.4.5. нийт борлуулалтын орлогын 60-аас доошгүй хувийг Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олдог.
- 5.5. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид дараах аж ахуйн нэгж хамаарна:
- 5.5.1. өөрийн төлөөний газраар дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж;
 - 5.5.2. энэ хуулийн 5.5.1-д зааснаас бусад хэлбэрээр Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж.

6 дугаар зүйл. Төлөөний газар

- 6.1. Энэ хуулийн 5.5.1-д заасан албан татвар төлөгчийн үйл ажиллагааг Монгол Улсад бүрэн болон хэсэгчлэн явуулж байгаа нэгжийг төлөөний газарт хамааруулна.
- 6.2. Энэ хуулийн 6.1-д заасан төлөөний газарт дараах нэгжийг хамруулна:
 - 6.2.1. аж ахуйг удирдан явуулдаг газар;
 - 6.2.2. салбар, тасаг;
 - 6.2.3. сургалт, семинар явуулдаг, үзэсгэлэн худалдаа эрхэлдэг газар;
 - 6.2.4. агуулах, худалдаа, үйлчилгээний газар;
 - 6.2.5. уурхай, газрын тос буюу байгалийн хийн цооног, уурхай буюу ашигт малтмал олборлодог газар;
 - 6.2.6. үйлдвэр;
 - 6.2.7. энэ хуулийн 6.1-д хамаарах бусад газар, нэгж, байр.
- 6.3. Үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 90 ба түүнээс дээш хоногийн хугацаанд үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт буюу суурилуулалтын объект, тэдгээртэй холбоотой барилгын болон хяналтын үйл ажиллагаа эрхлэх нэгжийг төлөөний газарт тооцно.
- 6.4. Үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног өөрийн ажиллагчид болон өөр бусад хөлсний ажилтнаар Монгол Улсад байрладаг албан

- татвар төлөгчид техникийн, зөвлөхийн, удирдлагын, хяналтын болон бусад үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг төлөөний газарт тооцно.
- 6.5. Энэ хуулийн 6.3, 6.4-т заасан хугацааг ижил төрлийн, эсхүл харилцан холбоотой ажил, үйлчилгээ хийж гүйцэтгэхэд зарцуулах нийт хугацаагаар тооцно.
- 6.6. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн нэрийн өмнөөс Монгол Улсад дараах үйл ажиллагаа явуулдаг этгээдийг төлөөний газарт тооцно:
- 6.6.1. бараа, бүтээгдэхүүнийг хадгалдаг, борлуулдаг, нийлүүлдэг;
- 6.6.2. биечлэн гэрээ байгуулдаг, эсхүл Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн гэрээний гол нөхцөлийг өөрчлөхгүйгээр тухайн гэрээ байгуулах ажлыг удирдан зохион байгуулдаг.
- 6.7. Дараах шинжийн аль нэгийг агуулсан гэрээг энэ хуулийн 6.6.2-т заасан гэрээнд тооцно:
- 6.7.1. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн нэрээр байгуулагдах;
- 6.7.2. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн өмчилдөг, эсхүл өмчилдөггүй боловч ашиглах, эзэмших эрхтэй хөрөнгийг шилжүүлэх, эсхүл тухайн хөрөнгийг ашиглах, эзэмших эрхийг бусдад шилжүүлэх;
- 6.7.3. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн үйлчилгээг үзүүлэх.
- 6.8. Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7-д заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч нь бусад этгээдээр дамжуулан Монгол Улсад давхар даатгалаас бусад хэлбэрийн даатгалын хураамж авдаг буюу эрсдэлийн даатгал хийдэг бол түүнийг Монгол Улсад төлөөний газартай гэж үзнэ.
- 6.9. Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын хэлэлцээрт “Төлөөлөгчийн газар” гэснийг энэ хуульд заасан төлөөний газартай адилтгаж үзнэ.
- 6.10. Төлөөний газрын тайлангийн маягт болон төлөөний газрыг бүртгэх, бүртгэлээс хасах, албан татвар төлөх, тайлагнах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР НОГДОХ ОРЛОГО

7 дугаар зүйл. Албан татвар ногдох орлого

- 7.1. Энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон, түүнчлэн гадаад улсаас олсон орлогод албан татвар ногдоно.
- 7.2. Энэ хуулийн 5.5.1-д заасан албан татвар төлөгч өөрийн төлөөний газраараа дамжуулан тухайн татварын жилд төлөөний газрын үйл ажиллагаатай холбогдон

Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно.

7.3. Энэ хуулийн 5.5.2-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно.

7.4. Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:

7.4.1. үйл ажиллагааны орлого;

7.4.2. хөрөнгийн орлого;

7.4.3. хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

7.4.4. бусад орлого.

7.5. Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдөх орлогыг хасаж тооцно.

8 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлого

8.1. Үйл ажиллагааны дараах орлогод албан татвар ногдоно:

8.1.1. бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого;

8.1.2. төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаанаас олсон орлого;

8.1.3. техникийн, удирдлагын, зөвлөхийн болон бусад үйлчилгээний орлого;

8.1.4. үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого;

8.1.5. энэ хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.4-т заасантай адилтгах бусад орлого.

8.2. Энэ хуулийн 6.4, 8.1.3-т заасан “техникийн үйлчилгээний орлого” гэдэгт шинэ технологи нэвтрүүлэх, хөдөлмөр, техникийн аюулгүй ажиллагааны болон үйлдвэрлэл, ажил, үйлчилгээнд мөрдөх хөдөлмөр зарцуулалтын норм, материал, түүхий эдийн зарцуулалтын хэмжээг тооцож тогтоосон баримт бичгийг бэлтгэж боловсруулах, нийгэм, эдийн засгийн судалгаа явуулах, аудитын үйлчилгээ үзүүлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, засвар үйлчилгээ, дээж сорьцын шинжилгээ хийх, инженер, техникийн ажиллагчдыг сургах, дадлагажуулах, мэргэжил дээшлүүлэхтэй холбогдсон ажил, үйлчилгээнээс олсон орлогыг хамааруулна.

8.3. Энэ хуулийн 6.4, 8.1.3-т заасан “удирдлагын үйлчилгээний орлого” гэдэгт аж ахуйн үйл ажиллагаа /үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ/-г үр ашигтай хэвийн явуулахад нь туслалцаа үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж өөрийн мэргэжилтнийг гэрээгээр буюу харилцан тохиролцож ажиллуулсны үр дүнд олсон орлогыг хамааруулна.

8.4. Энэ хуулийн 6.4, 8.1.3-т заасан “зөвлөхийн үйлчилгээний орлого” гэдэгт аж ахуйн нэгжид менежмент, маркетинг, зах зээл, хөрөнгө оруулалтын орчин, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үе шатны талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, баримт бичиг боловсруулах зэрэг ажил, үйлчилгээ үзүүлснээс олсон орлогыг хамааруулна.

8.5. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар үйл ажиллагааны орлогод тооцогдох хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого олох үйл ажиллагаа эрхэлдэг албан татвар төлөгчийн дээр дурдсан орлогыг энэ хуулийн 8.1.1-д заасан орлогод тооцно.

9 дүгээр зүйл.Хөрөнгийн орлого

9.1. Хөрөнгийн дараах орлогод албан татвар ногдоно:

9.1.1.хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого;

9.1.2.эрхийн шимтгэлийн орлого;

9.1.3.ногдол ашгийн орлого;

9.1.4.хүүгийн орлого.

9.2. Энэ хуулийн 9.1.2-т заасан эрхийн шимтгэлийн орлогод дараах төлбөр хамаарна:

9.2.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

9.2.2.Патентийн тухай хуульд заасны дагуу шинэ бүтээл, бүтээгдэхүүн болон ашигтай загвар ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

9.2.3.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд заасны дагуу барааны тэмдэг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

9.2.4.Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу технологи дамжуулсны төлбөр;

9.2.5.үйлдвэр, худалдаа, шинжлэх ухааны туршилттай холбоотой мэдээллийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

9.2.6.үйлдвэр, худалдаа, шинжлэх ухааны туршилтын тоног төхөөрөмжийг ашигласны болон ашиглах эрхийн төлбөр;

9.2.7.энэ хуулийн 9.2.1, 9.2.2, 9.2.3, 9.2.4, 9.2.5, 9.2.6-д заасантай адилтгах бусад эрх ашигласны болон ашиглах эрхийн төлбөр.

9.3. Энэ хуулийн 9.1.3-т заасан ногдол ашгийн орлогод хувьцаа эзэмшил, нөхөрлөлийн буюу хамтран ажиллах гэрээнээс олсон мөнгөн болон мөнгөн бус орлого, ашгийн хувь, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг гэж үзэх бусад орлого хамаарна.

9.4. Энэ хуулийн 9.1.4-т заасан хүүгийн орлогод барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн хөрөнгөд оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өр, өглөг, харилцах болон хадгаламжийн данс, баталгаа, батлан даалт, зээл, зээллэг, бонд, өрийн хэрэгсэл болон тэдгээрийн урамшуулал зэрэгтэй шууд холбогдуулан зээлдэгчээс олгосон орлого, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүүгийн орлого гэж үзэх бусад орлого хамаарна.

10 дугаар зүйл.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого

10.1. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод дараах орлого хамаарна:

- 10.1.1.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;
- 10.1.2.төрийн байгууллагаас олгосон эрх борлуулсан, шилжүүлсний орлого;
- 10.1.3.хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого;
- 10.1.4.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т зааснаас бусад биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого.

10.2. Энэ хуулийн 10.1.4-т заасан биет бус хөрөнгө борлуулсны орлогод энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т зааснаас бусад биет бус хөрөнгө өмчлөх, ашиглах, эзэмших эрхээ бусдад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого хамаарна.

11 дүгээр зүйл.Бусад орлого

11.1. Энэ хуулийн 7.4.4-т заасан орлогод дараах орлогыг хамааруулна:

- 11.1.1.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдээс авсан хүү, анз /торгууль, алданги/, учирсан хохирлын улмаас авсан нөхөн төлбөр;
- 11.1.2.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаанаас хожсон орлого;
- 11.1.3.тухайн татварын жилд төлөөний газраас өөрийн толгой компанид шилжүүлсэн ашиг;
- 11.1.4.гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит орлого;
- 11.1.5.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.11, Газрын тосны тухай хуулийн 11.1.4, 12.5-д заасны дагуу буцаан олгосон мөнгөн хөрөнгө;
- 11.1.6.даатгалын нөхөн төлбөр.

12 дугаар зүйл.Албан татвар ногдох орлогыг хүлээн зөвшөөрөх

12.1. Албан татвар төлөгч дараах нөхцөлд орлогыг хүлээн зөвшөөрнө:

- 12.1.1.барааг илгээсэн, эсхүл ачуулснаар;
- 12.1.2.ажлыг гүйцэтгэлийн хувиар;
- 12.1.3.үйлчилгээний орлогыг хүлээж авсан, эсхүл гэрээ, хэлцэлд заасан нөхцөлийг хангаснаар;
- 12.1.4.бусад орлогыг бодитоор хэрэгжсэн, орлого орсон тухай бүр.

12.2. Албан татвар төлөгч бараа, ажил, үйлчилгээ солилцсон тохиолдолд бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан өдрөөр албан татвар ногдох орлогыг хүлээн зөвшөөрнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР НОГДОХ ОРЛОГООС ХАСАГДАХ ЗАРДАЛ

13 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тавигдах шаардлага

13.1. Дараах нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно:

13.1.1. тухайн татварын тайлант хугацаанд хамаарсан байх;

13.1.2. албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх;

13.1.3. зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх;

13.1.4. доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх:

13.1.4.а. энэ хуулийн 5.5.2-т зааснаас бусад албан татвар төлөгчийн үзүүлсэн ажил, үйлчилгээний зардал;

13.1.4.б. хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгө худалдан авахтай холбогдон гарах зардал.

13.1.5. зардлыг тухайн үйл ажиллагаа эрхэлж байгаа албан татвар төлөгч төлсөн, эсхүл төлөхөөр тайлагнасан байх.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан нөхцөлийг хангасан зардлыг доор дурдсан хязгаар, нөхцөлтэйгөөр албан татвар ногдох орлогоос хасна:

13.2.1. албан татвар, төлбөр, хураамж нь төсөвт төлөхөөр тайлагнасан байх;

13.2.2. албан томилолтын зардал нь төрийн албан хаагчдын албан томилолтын зардлыг хоёр дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх;

13.2.3. банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгөд хэвийн зээлийн үлдэгдэлд байгуулсан сангийн хөрөнгө хамаарахгүй байх;

13.2.4. Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгахад гарсан зардал нь холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байх;

13.2.5. ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал нь тухайн татварын жилд Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ болон контракт байгуулан ажиллаж байгаа ажиллагчдад олгосон цалингийн зардлын нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байх;

- 13.2.6. Даатгалын тухай хуулийн 4.1.2-г заасан даатгагчаас бусад этгээдийн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;
- 13.2.7. Даатгалын тухай хуулийн 4.1.2-г заасан даатгагчийн харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;
- 13.2.8. урсгал засварын зардал нь сэлбэг хэрэгслийн зардлыг багтаасан байх бөгөөд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 2 хувь, бусад хөрөнгийн хувьд үлдэгдэл өртгийн 5 хувиас хэтрэхгүй бөгөөд үүнээс хэтэрсэн урсгал засварын зардлыг их засварын зардалд тооцох;
- 13.2.9. цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, түүнтэй адилтгах орлогод нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар ногдуулж, суутгасан байх;
- 13.2.10. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод хувь хүний орлогын албан татвар ногдуулж, суутгасан байх;
- 13.2.11. хүүгийн зардлын хувьд энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлсон байх;
- 13.2.12. албан татвар суутгах орлого олгосон тохиолдолд холбогдох албан татварыг суутган тайлагнасан байх.
- 13.3. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших болон шилжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг тухайн тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд жил тутам ижил хэмжээгээр үйл ажиллагааны зардалд оруулан хасаж тооцно.
- 13.4. Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч, гэрээлэгчийн байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын зардалд хуримтлуулах мөнгөн хөрөнгийг тухайн тусгай зөвшөөрөл хүчинтэй байх хугацаанд жил тутам ижил хэмжээгээр үйл ажиллагааны зардалд оруулан хасаж тооцно.
- 13.5. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч албан татвар ногдох орлогоос хасагдах зардлыг энэ хуулийн 26.9, 26.10, 26.11, 26.12, 26.13-т заасны дагуу тайлан тус бүрээр тооцно.

14 дүгээр зүйл. Албан татвар ногдох орлогоос хасаж тооцох хүүгийн зардал

- 14.1. Энэ хуулийн 9.1.4-т заасан орлогыг бусдад олгохтой холбогдон гарсан хүүгийн зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

- 14.2. Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн нийт ажил гүйлгээний энэ хуулийн 14.1-д заасан хасагдах зардлын хэмжээ нь тайлант хугацааны нийт борлуулалтын орлогоос хүү, элэгдэл, хорогдлоос бусад энэ хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан зардлыг хассан дүнгийн 30 хувиар хязгаарлагдана.
- 14.3. Энэ хуулийн 14.2-т заасныг үл харгалзан хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг гурав дахин нэмэгдүүлснээс илүү хэмжээний тухайн хөрөнгө оруулагчийн зээлд төлсөн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй бөгөөд түүнийг тухайн хөрөнгө оруулагчийн ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.
- 14.4. Энэ хуулийн 14.3-т заасан “өмнө нь оруулсан хөрөнгө оруулалт” гэдэгт хөрөнгө оруулагч этгээдээс энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа худалдан авах, хувь нийлүүлэх замаар оруулсан хөрөнгө оруулалтыг хамааруулна.
- 14.5. Банкны тухай хуулийн 6.1.1, 6.1.2 болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид энэ хуулийн 14.2-т заасан хязгаарлалт хамаарахгүй.
- 14.6. Албан татвар төлөгчийн хувьцаа эзэмшдэг Монгол Улсад байнга оршин суугч хувь хүнээс авсан зээлийн хүүгийн зардлыг тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй.
- 14.7. Энэ хуулийн 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5 дахь хэсэг нь төлөөний газарт мөн адил хамаарна.

15 дугаар зүйл. Албан татвар ногдох орлогоос хасагдах бусад зардал

- 15.1. Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцож болно:
- 15.1.1. бараа, материалын хэвийн хорогдол;
 - 15.1.2. эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл;
 - 15.1.3. энэ хуулийн 16.1.8-д зааснаас бусад төсөвт төлөхөөр тайлагнасан албан татвар, төлбөр, хураамж;
 - 15.1.4. мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын орчныг бүрдүүлэх, дадлагын газрыг тоног төхөөрөмжөөр хангах, дадлагын байрыг засварласан зардал;
 - 15.1.5. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 11.5, 18 дугаар зүйлд заасан багш нарыг дадлагажуулсан зардал;
 - 15.1.6. өөрийн захиалгаар мэргэжилтэн бэлтгүүлэх зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад үзүүлсэн санхүүгийн дэмжлэг;

- 15.1.7.хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэний үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив;
 - 15.1.8.спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив;
 - 15.1.9.мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд өгсөн хандив, хөрөнгө;
 - 15.1.10.агаарын бохирдлыг бууруулах зорилгоор өгсөн хандив;
 - 15.1.11.банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө;
 - 15.1.12.хадгаламж, зээлийн хоршооны зээлийн эрсдэлийн санд, бусад үйл ажиллагаа эрхэлдэг хоршооны болзошгүй эрсдэлээс хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө;
 - 15.1.13.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч, гэрээлэгчийн байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, холбогдох төрийн байгууллагаас нээсэн тусгай сан, төрийн сан болон Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө;
 - 15.1.14.Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан хязгаарт багтаан Ахмадын санд хуримтлуулсан зардал.
- 15.2. Энэ хуулийн 15.1.1-д заасан хорогдлын хэмжээг Засгийн газар батална.

16 дугаар зүйл.Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал

- 16.1. Дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасахгүй:
- 16.1.1.энэ хуулийн 13.1, 13.2-г заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй зардал;
 - 16.1.2.түрээслэгчийн түрээсийн хөрөнгийн үндсэн төлбөр;
 - 16.1.3.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс бусдад төлсөн төлбөр, хүү, торгууль, анз;
 - 16.1.4.ажиллагчид болон харилцагч байгууллага, хувь хүнд зориулсан амралт зугаалга, түүнтэй адилтгах бусад зардал;
 - 16.1.5.харилцан хамааралтай этгээдэд борлуулсан хөрөнгийн гарз;
 - 16.1.6.төлөөний газрын өөрийн толгой компанид шилжүүлсэн хүүгийн төлбөр, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний төлбөр, эрхийн шимтгэлийн төлбөр, техникийн, удирдлагын, зөвлөхийн болон бусад үйлчилгээний төлбөр;
 - 16.1.7.энэ хуульд заасан албан татвараас чөлөөлөгдөх орлого олохтой холбогдон гарсан зардал;

- 16.1.8.нийслэл хотын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн төсөвт төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар болон энэ хуулийн дагуу бусад этгээдийн олсон орлогоос суутган авсан татвар;
- 16.1.9.гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус алдагдал;
- 16.1.10.барааны дахин үнэлгээний нэмэгдүүлсэн зөрүү;
- 16.1.11.банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээл;
- 16.1.12.энэ хуулийн 15.1.6, 15.1.7, 15.1.8, 15.1.9, 15.1.10-т зааснаас бусад хандив, тусламжийн зардал.

17 дугаар зүйл.Элэгдэл, хорогдол тооцох

17.1. Албан татвар төлөгчийн нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл, хорогдлыг дараах байдлаар тооцно:

№	Хөрөнгийн бүлэг	Ашиглах нийт хугацаа /жилээр/	
		Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд	Бусад
1	Барилга байгууламж, газрын тохижилт	40	25
2	Машин, механизм, техник, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	10	
3	Компьютер, дагалдах тоног төхөөрөмж, программ хангамж	2	
4	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./	Хүчин төгөлдөр байх хугацаанд	
5	Бусад хөрөнгө	10	

- 17.2. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл хэсгийн дүнд элэгдэл, хорогдол тооцохгүй.
- 17.3. Хөрөнгийн элэгдэл, хорогдлыг шулуун шугамын аргаар байгуулна.
- 17.4. Эргэлтийн бус хөрөнгийг худалдан авах, барих, угсрах, тээвэрлэх болон тээвэрлэлттэй холбоотой даатгуулах зардлыг тухайн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох үнэлгээнд оруулж тооцно.
- 17.5. Энэ хуулийн 13.2.8-д заасан их засварын зардлыг уг хөрөнгийн үлдэгдэл өртөг дээр нэмж тооцох бөгөөд уг хөрөнгийг ашиглах үлдсэн хугацааны туршид элэгдэл, хорогдол тооцно.
- 17.6. Элэгдэл, хорогдол тооцох хөрөнгийн тодорхой хэсэг нь албан татвар ногдох орлого олоход ашиглагдаж байвал элэгдэл, хорогдлыг тухайн хэсэгт хувь тэнцүүлэн тооцож, албан татвар ногдох орлогоос хасна.
- 17.7. Эргэлтийн хөрөнгө, газар, бараа, материалын нөөц, уран зураг, гар урлал, эртний эдлэл, үнэт эдлэл, эдгээртэй адилтгах бусад эд хөрөнгөд элэгдэл, хорогдол тооцохгүй.
- 17.8. Албан татвар төлөгч барилга байгууламж болон бусад хөрөнгийг хамтад нь худалдаж авсан тохиолдолд худалдан авсан үнийн дүнг худалдаж авсан хөрөнгө тус бүрд хуваарилна. Барилга байгууламжийг буулгаж тухайн газарт шинэ барилга байгууламж барих зорилгоор худалдаж авсан тохиолдолд тухайн барилга байгууламжийг буулгах зардал болон худалдан авсан үнийн дүнг барилгын өртөгт шингээж тооцно.
- 17.9. Албан татвар төлөгч өмчилж байгаа элэгдэл, хорогдол тооцох хөрөнгөө албан татвар ногдох орлого олох зорилгоор ашиглахаа бүрмөсөн зогсоовол уг хөрөнгийг үлдэгдэл өртөг, зах зээлийн үнийн аль их үнээр худалдан борлуулсан гэж үзэж албан татвар ногдуулна.
- 17.10. Түрээслэгчийн ашиглах эрхтэй хөрөнгийн нийт үнийг гэрээний хугацаанд төлөх түрээсийн төлбөрийн нийлбэр дүнгээр тооцож, гэрээний хугацаагаар элэгдэл байгуулна.
- 17.11. Албан татвар төлөгчийн тухайн улиралд шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг дараагийн сарын эхний өдрөөс эхлэн тооцно.
- 17.12. Барилга угсралтын шатанд байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгө болгон бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж эхэлсэн өдрийн дараагийн сарын эхний өдрөөс эхлэн элэгдэл, хорогдлыг байгуулна.
- 17.13. Ашигт малтмал болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч, Газрын тосны тухай хуульд заасан гэрээлэгч аж ахуйн нэгж нь хайгуулын зардал, тусгай зөвшөөрлийн төлбөр, тусгай зөвшөөрөл эзэмших болон худалдах, шилжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг

хуримтлуулан хайгуул үнэлгээний хөрөнгөөр бүртгэж, уурхай болон талбайн ашиглалтын хугацаанд элэгдэл, хорогдол байгуулна.

- 17.14. Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8-д заасан тусгай сан, Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан данс, Цөмийн энергийн тухай хуулийн 28.9-д заасан санд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг энэ хуулийн 17.13-т заасан хайгуул үнэлгээний хөрөнгөд тооцно.
- 17.15. Энэ хуулийн 17.1-д заасан “газрын тохижилт” гэдэгт уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой овоолго бэлтгэх зардал орохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ

18 дугаар зүйл. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

- 18.1. Албан татвар төлөгчийн татварын жилийн албан татвар ногдуулах орлогод албан татварыг ногдуулна.
- 18.2. Энэ хуулийн 8.1.1, 8.1.3, 8.1.4, 8.1.5, 9.1.1, 11.1.1, 11.1.4-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс энэ хуульд заасан зардлыг хасаж албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж, уг орлогоос энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан шилжүүлэн тооцох алдагдлыг хасаж тухайн жилийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.
- 18.3. Хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан, шилжүүлсэн үнээс уг хувьцаа, үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.
- 18.4. Энэ хуулийн 8.1.2-т заасан албан татвар ногдох орлогын нийт дүнгээс уг орлогыг олохтой холбогдон гарсан энэ хуулийн 13.1-д заасан нөхцөлийг хангасан зардал, хонжворт олгосон мөнгөн хөрөнгө болон барааны үнийг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.
- 18.5. Энэ хуулийн 10.1.4-т заасан биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг уг хөрөнгийн борлуулсан, шилжүүлсэн орлогоос хөрөнгийн үлдэгдэл өртгийг хасаж тодорхойлно.
- 18.6. Дараах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдох тухайн орлогын төрөл тус бүрийн нийт дүнгээр тооцно:
- 18.6.1. эрхийн шимтгэлийн орлого;
 - 18.6.2. ногдол ашгийн орлого;
 - 18.6.3. хүүгийн орлого;
 - 18.6.4. үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

- 18.6.5.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаанаас хожсон орлого;
- 18.6.6.тухайн татварын жилд төлөөний газраас өөрийн толгой аж ахуйн нэгжид шилжүүлсэн ашиг;
- 18.6.7.энэ хуулийн 11.1.5, 11.1.6-д заасан орлого;
- 18.6.8.энэ хуулийн 6.10-т заасан журмын дагуу бүртгүүлсэн төлөөний газраас бусад Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн энэ хуулийн 4.1.6, 4.1.7, 8.3-т заасан орлого.
- 18.7. Энэ хуулийн 10.1.2-т заасан эрх борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо тухайн эрхийн үнэлгээнээс доор дурдсан баримтаар нотлогдох зардлуудыг хасаж тодорхойлно:
- 18.7.1.төрийн байгууллагаас эрх олгосон тохиолдолд эрх авахтай холбогдон төрийн байгууллагад төлсөн баримтаар нотлогдох төлбөр, хураамж;
- 18.7.2.бусдаас худалдаж, шилжүүлж авсан тохиолдолд хэлцлийн дагуу худалдах, шилжүүлэн авахад төлсөн, шилжүүлсэн баримтаар нотлогдох төлбөр.
- 18.8. Газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлоход энэ хуулийн 30.6-д заасан аргачлалыг баримтална.
- 18.9. Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол ногдол ашгийн албан татвар ногдуулах орлогыг албан татвар төлөгчийн эзэмшиж байгаа хувьцаа болон хувь нийлүүлсэн хөрөнгөд хувь тэнцүүлэн хуваарилсан орлогын дүнгээс уг хувьцаа болон хөрөнгийг анх худалдан авсан үнийг хасаж тодорхойлно.
- 18.10. Банк, банк бус санхүүгийн байгууллагын зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах, хадгаламж зээлийн хоршооны зээлийн эрсдэлийн сангийн албан татвар ногдох орлогоос хасагдсан зээлийг эргүүлэн төлсөн бол ийнхүү төлөгдсөн зээлийн дүнд энэ хуульд заасны дагуу албан татвар ногдуулна.
- 18.11. Даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн даатгалын үйл ажиллагааны нийт орлогоос эрх бүхий төрийн байгууллагаас баталсан дүрэмд заасны дагуу тухайн жилд байгуулсан нөөцийн сан болон үйл ажиллагааны зардлыг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.
- 18.12. Төлөөний газрын албан татвар ногдуулах орлогыг энэ хуульд заасны дагуу Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн албан татвар ногдуулах орлоготой ижил зарчмаар тодорхойлох бөгөөд төлөөний газар байснаар албан татвар ногдуулах орлогыг бууруулан тодорхойлох үндэслэл болохгүй.

19 дүгээр зүйл.Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох

- 19.1. Албан татвар ногдох нийт орлогоос энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан зардлыг хасаж, зардлын илүү гарсан хэсгийг татварын тайлангаар гарсан алдагдал /цаашид “алдагдал” гэх/ гэнэ.
- 19.2. Харьяалах татварын албаар баталгаажуулсан ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан дөрвөн жил бүр албан татвар ногдуулах орлогын нийт дүнгийн 50 хувиар хязгаарлан хасаж тооцно.
- 19.3. Татварын дараалсан дөрвөн жилийн хугацаанд хасагдаагүй үлдсэн болон тухайн татварын жилд энэ хуулийн 19.2-т заасан хязгаараас хэтэрсэн алдагдлын дүнг цаашид албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцохгүй.
- 19.4. Нэгээс илүү татварын жилд алдагдал гарсан тохиолдолд алдагдал гарсан жилийн дарааллаар албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.
- 19.5. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгжийн гадаад улс дахь төлөөний газрын алдагдлыг Монгол Улс дахь аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй.
- 19.6. Энэ хуулийн 13.5-д заасны дагуу тооцоход гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохдоо ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч албан татвар төлөгчийн хувьд энэ хуулийн 26.9, 26.10, 26.11, 26.12, 26.13-т заасныг баримтална.
- 19.7. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаа дууссан, цуцлагдсан, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгсөн тохиолдолд алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохдоо энэ хуулийн 19.6-д заасныг мөрдөхгүй.
- 19.8. Иргэний хууль, Компанийн тухай хууль, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу нэгдэх, нийлэх, тусгаарлах хэлбэрээр аж ахуйн нэгж өөрчлөн байгуулагдсан тохиолдолд хасагдаагүй үлдсэн алдагдлын дүнг цаашид албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцохгүй.
- 19.9. Энэ хуулийн 19.1-д заасан алдагдалд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх татварын жилийн татварын тайлангаар гарсан болон татварын албаны баталгаажуулаагүй алдагдал хамаарахгүй.
- 19.10. Чөлөөт бүсэд хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн татварын тайлангаар гарсан алдагдлыг бүтээн байгуулалтын ажил дуусаж, зорилтот үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа эхэлсэн жилийн дараагийн дараалсан татварын дөрвөн жилд албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцно.

- 19.11. Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, баталгаажуулах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ

20 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ

- 20.1. Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасны дагуу тодорхойлоход 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.
- 20.2. Албан татвар төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна:
- 20.2.1. энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.7, 18.7-д заасан орлогод 10 хувиар;
 - 20.2.2. энэ хуулийн 18.6.4-т заасан албан татвар ногдуулах орлогод 2 хувиар;
 - 20.2.3. энэ хуулийн 18.6.5-д заасан орлогод 40 хувиар;
 - 20.2.4. энэ хуулийн 18.6.6, 18.6.8-д заасан орлогод 20 хувиар;
 - 20.2.5. ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй /Үүнд энэ хуулийн 4.1.12, 30.1-д заасан этгээд мөн хамаарна./ Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл, нэгж эрх худалдан авсан албан татвар төлөгчийн хүүгийн орлогод 5 хувиар;
 - 20.2.6. Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 5 хувиар;
 - 20.2.7. энэ хуулийн 20.1-д заасныг үл харгалзан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар.
- 20.3. Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн тухайд тогтворжуулах гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтворжуулсан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

21 дүгээр зүйл. Албан татвараас чөлөөлөх

21.1. Албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:

- 21.1.1. Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;
- 21.1.2. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д заасан ногдол ашиг;
- 21.1.3. Ирээдүйн өв санд улсын төсвөөс хуваарилсан орлого, сангийн хөрөнгө оруулалтын орлого;
- 21.1.4. Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн 18.6.2, 20.1-д заасан орлого;
- 21.1.5. Зээлийн батлан даалтын байгууллагын хуульд заасан үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого;
- 21.1.6. Хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлого;
- 21.1.7. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс Засгийн газарт хуваарилсан ногдол ашиг;
- 21.1.8. Энэ хуулийн 21.1.4-г заасан орлого олсон албан татвар төлөгч өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас гадаадад шилжүүлэх орлого;
- 21.1.9. Боловсролын тухай хуулийн 12.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1-д заасан байгууллагын үйл ажиллагааны орлого;
- 21.1.10. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой олсон аж ахуйн үйл ажиллагааны орлого;
- 21.1.11. Холбооны гишүүдээс цуглуулсан Сууц өмчлөгчдийн холбооны дүрэмд заасан үйлчилгээний хөлсний орлого болон Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 6.1.7-д заасан санд төвлөрүүлсэн хөрөнгө;
- 21.1.12. Гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучилсны үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого.

22 дугаар зүйл. Албан татварын хөнгөлөлт

22.1. Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд тусгасан, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, энэ хуулийн 20.2.7-д зааснаас бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө:

- 22.1.1. ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах;
- 22.1.2. согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;
- 22.1.3. газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулах.
- 22.2. Энэ хуулийн 22.1-д заасан албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгчийн жилийн эцсийн татварын тайлангаар тодорхойлон, энэ хуульд заасан хугацаанд төлсөн албан татвараас буцаан олгох замаар эдлүүлж, энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу буцаан олгоно. Буцаан олголтыг энэ хуулийн 28.4.2, 28.4.3-т заасан хугацааг үл харгалзан жилийн эцсийн тайлан хүргүүлэх эцсийн хугацаанаас хойш ажлын 30 өдрийн дотор олгоно.
- 22.3. Энэ хуулийн 20.2.7, 22.1-д тухайн албан татвар төлөгч хамаарах эсэхийг тодорхойлохдоо албан татвар ногдох орлогын дүнг тухайн албан татвар төлөгч болон тухайн татварын жилд түүнтэй ажил гүйлгээ хийсэн харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тооцно.
- 22.4. Энэ хуулийн 20.2.7, 22.1-д заасны дагуу албан татвар төлж, тайлагнах аж ахуйн нэгж энэ хуулийн 22.5-д заасан хөнгөлөлтийг эдлэхгүй.
- 22.5. Дараах орлогод албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:
- 22.5.1. аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа нь тухайн орон нутагт бүртгэлтэй, орон нутгийн татварын албатай харьцдаг, ажлын байр бий болгож /нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан/ байгаа энэ хуулийн 5.3.1-д заасан албан татвар төлөгчийн тухайн аймаг, сумын нутаг дэвсгэр дээр явуулсан үйл ажиллагаанаас олсон энэ хуулийн 7.4.1-д заасан албан татвар ногдох орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар;
- 22.5.2. нийт 25-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн ажиллагчдын гуравны хоёр ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийн орлогод ногдох тухайн төрлийн албан татварыг;
- 22.5.3. байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод ногдох албан татварыг;

- 22.5.4.улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг;
- 22.5.5.Биеийн тамир, спортын тухай хуулийн 26.2-т заасан стандартыг хангасан спортын барилга байгууламж, спортын заал, талбай, дэд бүтцийг барьж байгуулсан аж ахуйн нэгж тухайн спортын барилга байгууламж, спортын заал, талбайг ашиглаж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд ашиглалтын үйл ажиллагаанаас олсон 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;
- 22.5.6.хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон уг аж ахуйн нэгжийн орлогод ногдох албан татварыг;
- 22.5.7.чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;
- 22.5.8.чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;
- 22.5.9.тодорхой нутаг дэвсгэрийн усны нөөцийг нэмэгдүүлэх, усны найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор байгалийн усны чанарыг сайжруулах, гол, горхийг нөхөн сэргээх арга хэмжээг санхүүжүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн арга хэмжээнд зарцуулсан хэмжээний орлогод ногдох албан татварыг;
- 22.5.10.доор дурдсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар:
- 22.5.10.а.үр тариа, төмс, хүнсний ногоо;
- 22.5.10.б.сүү;
- 22.5.10.в.жимс, жимсгэнэ;

22.5.10.г.тэжээл, тэжээлийн ургамал;

22.5.10.д.эрчимжсэн тахианы аж ахуйд үйлдвэрлэсэн мах, махан бүтээгдэхүүн.

22.6. Энэ хуулийн 22.5.3, 22.5.4-т заасан техник, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална.

22.7. Тайлант хугацаанд албан татварын хөнгөлөлтийг тухайн орлогод ногдуулан энэ хуульд заасан хугацаанд төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй.

22.8. Энэ хуулийн 22.5.1-д дараах салбар хамаарахгүй:

22.8.1.ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул хийх, ашиглах, цөмийн энергийн чиглэлийн үйл ажиллагаа;

22.8.2.согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, импортлох;

22.8.3.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, худалдах, импортлох;

22.8.4.газрын тосны бүтээгдэхүүн импортлон, эсхүл дамжуулан худалдах;

22.8.5.ярианы үйлчилгээ эрхлэх;

22.8.6.эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, түгээх;

22.8.7.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх;

22.8.8.авто зам, замын байгууламжийг барих, засварлах.

23 дугаар зүйл.Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцох

23.1. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татвараас хасаж тооцно.

23.2. Дараах тохиолдолд гадаад улсад төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцохгүй:

23.2.1.гадаад улсад ногдуулан төлсөн боловч буцаан авах боломжтой;

23.2.2.гадаад улсад ногдуулан төлсөн албан татварын хүү, торгууль, алданги;

23.2.3.Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу албан татвар ногдуулахгүй орлогод ногдуулан төлсөн албан татвар.

23.3. Энэ хуулийн 23.1-д заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээг дараах шалгуураар тооцсон дүнгийн аль багаар нь тооцно:

23.3.1.албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татварын дүн;

23.3.2.гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар ногдох орлогод Монгол Улсын татварын хуулийн дагуу ногдуулсан тохиолдолд төлбөл зохих албан татварын дүн.

- 23.4. Энэ хуулийн 23.3.2-г заасан дүнг тухайн татварын жилд албан татвар төлөгчийн албан татвар ногдуулан төлсөн гадаад улс бүрээр тусад нь тооцно.
- 23.5. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар тухайн албан татвар төлөгчийн Монгол Улсад төлбөл зохих албан татварын дүнгээс илүү гарсан татварыг буцаан олгохгүй бөгөөд цаашид шилжүүлэн тооцохгүй.
- 23.6. Энэ хуулийн 23.1-д заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээг баталгаажуулахдаа гадаад улсын эрх бүхий байгууллагад тайлагнасан татварын тайлан, татварын ногдол, төлөлтийг нотолсон тус байгууллагын албан бичиг, тус байгууллагын үйлдсэн татвар төлснийг нотлох баримт, тодорхойлолтыг үндэслэнэ.
- 23.7. Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээг харьяалах татварын алба баталгаажуулна.
- 23.8. Энэ хуулийн 23.1-д заасан гадаад улстай Монгол Улсын татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харилцан мэдээлэл солилцох эрх зүйн боломжтой байх бөгөөд эдгээр улсуудын жагсаалтыг жил бүрийн сүүлийн улиралд, жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 10 өдөрт багтаан татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шинэчлэн зарлана.
- 23.9. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд бүртгүүлсэн аж ахуйн нэгж энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу гадаад улсад ногдуулсан албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцохгүй.
- 23.10. Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцуулах хүсэлт гаргах, тооцооны маягтын загвар батлах, баталгаажуулах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР СУУТГАХ, ТӨСӨВТ ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ, БУЦААН ОЛГОХ

24 дүгээр зүйл. Албан татварыг суутган төлөх

- 24.1. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.4, 18.6.5, 18.6.7, 18.6.8-д заасан орлогод ногдох албан татварыг суутган төлөгч ногдуулж, суутгана.
- 24.2. Энэ хуулийн 18.6.6-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулах албан татварыг төлөөний газар ногдуулж, суутгана.
- 24.3. Энэ хуулийн 5.5.1-д заасан татвар төлөгч өөрийн төлөөний газрын үйл ажиллагаатай холбогдох орлогыг Монгол Улсад байрладаггүй этгээдэд

шилжүүлсэн тохиолдолд тухайн төлөөний газар холбогдох албан татварыг ногдуулж, суутгана.

24.4. Энэ хуулийн дагуу суутган төлөгчийг тодорхойлох боломжгүй тохиолдолд албан татвар ногдуулах орлого олсон этгээд нь албан татварыг өөрөө тодорхойлж ногдуулна.

24.5. Суутган ногдуулсан албан татварыг ажлын 10 өдрийн дотор төсөвт шилжүүлнэ.

25 дугаар зүйл. Албан татварыг өөрөө тодорхойлон ногдуулж, төсөвт төлөх

25.1. Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваарийг үндэслэн харьяалах татварын алба тухайн татварын жилд энэ хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан төлөх албан татварын сар, улирлын хуваарийг албан татвар төлөгчид хүргүүлнэ.

25.2. Энэ хуулийн 25.1-д заасан урьдчилан тодорхойлсон хуваарийн дагуу сар бүр төлөх татвараа сар бүрийн 25-ны дотор, улирлын эцэст хийсэн тооцооны дагуу татвараа дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцэст хийсэн эцсийн тооцооны дагуу татвараа дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор төсөвт төлнө.

25.3. Төр нь өмчдөө ногдох ашиг болон хувьцааны ногдол ашгийг бүрэн буюу хэсэгчлэн төсөвт дайчлах эрхтэй бөгөөд хэмжээг нь тухайн жилийн Төсвийн тухай хуулиар тогтооно.

26 дугаар зүйл. Албан татварыг тайлагнах

26.1. Өмнөх татварын жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг ба түүнээс дээш бол уг албан татвар төлөгч тухайн татварын жилийн улирлын татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

26.2. Татварын өмнөх жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг хүртэл энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд бүртгүүлээгүй албан татвар төлөгч тухайн татварын жилийн эхний хагас жилийн татварын тайланг 07 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, харьяалах татварын албанд хүргүүлнэ.

26.3. Энэ хуулийн 26.1, 26.2-г заасан албан татвар ногдуулах жилийн орлогыг тодорхойлохдоо албан татвар төлөгчийн зөвхөн тухайн тайлант жилийн өмнөх татварын жилд тайлагнасан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээнд үндэслэнэ.

26.4. Албан татвар төлөгч холбогдох татварын тайланг жилийн эхнээс өссөн дүнгээр гаргана.

- 26.5. Албан татвар төлөгч холбогдох татварын тайланд энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу суутган ногдуулсан татварын тайланг хавсаргана.
- 26.6. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид орлого олгосон суутган төлөгч нь хувь хүн бол энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу суутган ногдуулсан татварын тайланг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу тайлагнах албан татварын тайланд хавсаргана.
- 26.7. Тайланг жилд үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгч энэ хуулийн 26.2-т заасны дагуу татварын тайлан гаргана.
- 26.8. Албан татвар төлөгч үйл ажиллагаа эрхлээгүй тухай тайлан гаргасан жилийн дараагийн татварын жилээс эхлэн жилд нэг удаа дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.
- 26.9. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь энэ хуулийн дагуу тухайн татварын жилд тусгай зөвшөөрөл тус бүрд хамаарах татварын тайланг тус тус гаргаж, албан татварын тооцоо хийнэ.
- 26.10. Доор дурдсан нөхцөлийг нэгэн зэрэг хангасан тохиолдолд энэ хуулийн 26.9-д заасан тайланг нэгтгэн гаргаж болно:
- 26.10.1. албан татвар төлөгчийн эзэмшил дэх тусгай зөвшөөрөл бүхий талбай хоорондоо хиллэдэг бол;
- 26.10.2. ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувьд ашиглах бүтээгдэхүүний нэр төрөл ижил бол.
- 26.11. Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг энэ хуулийн 26.10-т заасны дагуу нэгтгэн тайлагнахгүй.
- 26.12. Энэ хуулийн 26.10-т заасны дагуу татварын тайланг дараагийн татварын жилд нэгтгэн гаргах тухай хүсэлтийг тухайн татварын жилийн 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.
- 26.13. Энэ хуулийн 26.12-т заасан хүсэлтийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 30 хоногийн дотор хянан, хүсэлтийг баталгаажуулах эсэх талаар хариу мэдэгдэнэ.
- 26.14. Энэ хуулийн 24.4-т заасны дагуу тодорхойлон ногдуулсан албан татварыг албан татвар төлөгч энэ хуульд заасан хугацаанд тайлагнана.

27 дугаар зүйл. Улс бүрээр үнэ шилжилтийн тайлан гаргах

- 27.1. Энэ хуульд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
- 27.1.1. “Групп” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.8-д заасныг;

- 27.1.2.“Группийн оролцогч” гэж дараах нөхцөлийн аль нэгийг хангасан этгээдийг:
- 27.1.2.а.үндэстэн дамнасан группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд үйл ажиллагаа нь тусгагддаг, эсхүл группийн бүрэлдэхүүн дэх аж ахуйн нэгжийн хувьцаа хөрөнгийн биржээр нээлттэй худалдагдах үед нэгтгэсэн санхүүгийн тайланд үйл ажиллагаа нь тусгагддаг;
- 27.1.2.б.өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, ач холбогдлоосоо шалтгаалан үндэстэн дамнасан группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хамаардаггүй;
- 27.1.2.в.санхүү болон татварын тайлагнал, дотоод удирдлага, зохион байгуулалт, хяналтын зорилгоор бие даан санхүүгийн тайлан гаргадаг, энэ хуулийн 27.1.2.а, 27.1.2.б-д заасан аж ахуйн нэгжийн төлөөний газрыг.
- 27.1.3.“нэгтгэсэн санхүүгийн тайлан” гэж үндэстэн дамнасан группийн оролцогчдын хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага болон мөнгөн урсгал зэрэг мэдээллүүдийг нэгтгэн, нэг аж ахуйн нэгжийн нэгэн адил нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу боловсруулсан санхүүгийн тайланг;
- 27.1.4.“Олон улсын татварын хэлэлцээр” гэж татварын зорилгоор мэдээлэл солилцох тухай Монгол Улсын бусад улстай байгуулсан татварын хэлэлцээр, татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх зорилго бүхий олон улсын гэрээ, эсхүл хоёр улсын хооронд автоматаар болон хүсэлтээр мэдээлэл харилцан солилцох асуудлыг тусгасан олон улсын гэрээг;
- 27.1.5.“системийн саатал” гэж эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрт заасан үүргийг хэлэлцээрт зааснаас бусад шалтгаанаар хэрэгжүүлэхээс түдгэлзсэн, эсхүл Монгол Улсад байрладаг группийн оролцогч группийн улс бүрээр үнэ шилжилтийн тайлан /цаашид “улс бүрээр тайлан” гэх/-г Монгол Улсад тогтмол ирүүлээгүй нөхцөл байдлыг;
- 27.1.6.“тайлагнах үүрэггүй үндэстэн дамнасан групп” гэж группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 1.7 их наяд төгрөгөөс доош борлуулалтын орлого олсон үндэстэн дамнасан группийг;
- 27.1.7.“тайлагнагч этгээд” гэж үндэстэн дамнасан группийн өмнөөс улс бүрээр тайлан гаргах үүрэгтэй группийн оролцогчийг ойлгох бөгөөд үндэстэн дамнасан группийн толгой этгээд, томилогдсон тайлагнагч этгээд, эсхүл энэ хуулийн 27.2.2-т заасан этгээдийг;
- 27.1.8.“томилогдсон тайлагнагч этгээд” гэж энэ хуулийн 27.2.2-т заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд үндэстэн дамнасан группийн толгой этгээдийн

- нэрийн өмнөөс улс бүрээр тайлан гаргах зорилгоор томилогдсон группийн оролцогчийг;
- 27.1.9.“үндэстэн дамнасан групп” гэж дараах нөхцөлийн аль нэгийг хангасан группийг:
- 27.1.9.а.группийн хоёр ба түүнээс дээш оролцогч нь татварын зорилгоор өөр улс, бүс нутагт байрладаг, эсхүл группийн оролцогч өөрийн төлөөний газраар дамжуулан өөр улс, бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг;
- 27.1.9.б.тайлагнах үүрэггүй энэ хуулийн 27.1.6-д заасан группээс бусад.
- 27.1.10.“үндэстэн дамнасан группийн санхүүгийн жил” гэж үндэстэн дамнасан группийн толгой этгээдийн санхүүгийн тайлан хамрах хугацааг;
- 27.1.11.“үндэстэн дамнасан группийн тайлагнах санхүүгийн жил” гэж улс бүрээр үнэ шилжилтийн тайлангийн хамрах хугацааг;
- 27.1.12.“үндэстэн дамнасан группийн толгой этгээд” гэж дараах шаардлагыг хангасан группийн оролцогчийг:
- 27.1.12.а.үндэстэн дамнасан группийн нэг буюу түүнээс дээш оролцогчдыг шууд болон шууд бусаар голлон эзэмшдэг бөгөөд татварын зорилгоор байрладаг улс, бүс нутагтаа группийн нэгтгэсэн санхүүгийн тайланг тушаах үүрэгтэй, эсхүл группийн оролцогчийн хувьцаа хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдах үед нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй;
- 27.1.12.б.энэ хуулийн 27.1.12.а-д зааснаас бусад группийн оролцогч шууд болон шууд бусаар группийн нэг буюу түүнээс дээш оролцогчдыг голлон эзэмшдэггүй;
- 27.1.13.“Эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээр” гэж доор дурдсаныг ойлгох:
- 27.1.13.а.олон улсын татварын хэлэлцээрийн талуудаас томилсон эрх бүхий этгээд хооронд байгуулах хэлэлцээр;
- 27.1.13.б.улс бүрээр тайлан харилцан солилцох үүрэг хүлээлгэсэн хэлэлцээр.
- 27.2. Дараах албан татвар төлөгч улс бүрээр тайланг үндэстэн дамнасан группийн санхүүгийн жилийн сүүлийн өдрөөс хойш 12 сарын хугацаанд багтаан харьяалах татварын албанд хүргүүлнэ:
- 27.2.1.Монгол Улсад татварын зорилгоор байрладаг үндэстэн дамнасан группийн толгой этгээд;
- 27.2.2.доор дурдсан нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд татварын зорилгоор Монгол Улсад байрладаг үндэстэн дамнасан группийн толгой этгээд бус группийн оролцогч:

- 27.2.2.а.үндэстэн дамнасан группийн толгой этгээд нь татварын зорилгоор байрладаг улс, бүс нутгийн хуулийн дагуу улс бүрээр тайлан боловсруулах, тайлагнах үүрэг хүлээдэггүй;
- 27.2.2.б.үндэстэн дамнасан группийн толгой этгээдийн татварын зорилгоор байрладаг улс, бүс нутаг нь Монгол Улстай олон улсын татварын хэлэлцээр байгуулсан боловч энэ хуулийн 27.2-т заасан хугацаанд эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээр байгуулагдаагүй;
- 27.2.2.в.үндэстэн дамнасан группийн толгой этгээдийн татварын зорилгоор байрладаг улс, бүс нутагт системийн саатал гарсныг харьяалах татварын алба Монгол Улсад байрладаг үндэстэн дамнасан группийн оролцогч этгээдэд мэдэгдсэн.
- 27.2.3.энэ хуулийн 27.2.2-т зааснаар хоёр ба түүнээс дээш үндэстэн дамнасан группийн оролцогч улс бүрээр тайлан гаргах үүрэг хүлээх тохиолдолд тэдгээрийн харьяалагдах үндэстэн дамнасан группийн толгой этгээд аль нэг этгээдийг тайлагнагч этгээдээр сонгож болох бөгөөд сонгогдсон тохиолдолд тухайн сонгогдсон оролцогч этгээд.
- 27.3. Энэ хуулийн 27.2.3-т заасны дагуу сонгосон бол энэ тухайгаа сонгогдсон оролцогч этгээд харьяалах татварын албанд тухайн жилийн эцсийн татварын тайлан хүргүүлэх хугацаанд багтаан мэдэгдэж, бүртгүүлнэ.
- 27.4. Энэ хуулийн 27.2.2-т заасныг үл харгалзан, дараах нөхцөлүүд нэгэн зэрэг хангагдсан тохиолдолд Монгол Улсад татварын зорилгоор байрладаг группийн оролцогч этгээд нь харьяалах татварын албанд улс бүрээр тайлан гаргахгүй:
- 27.4.1.энэ хуулийн 27.2.2.а, 27.2.2.б, 27.2.2.в-д заасан нөхцөлөөс аль нэгийг нь хангасан;
- 27.4.2.үндэстэн дамнасан групп нь улс бүрээр тайланг томилогдсон тайлагнагч этгээдээр дамжуулан тайлагнасан;
- 27.4.3.томилогдсон тайлагнагч этгээд нь түүний татварын зорилгоор байрладаг улс, бүс нутгийн татварын албанд энэ хуулийн 27.2-т заасан хугацаанд багтаан улс бүрээр тайланг гаргасан;
- 27.4.4.томилогдсон тайлагнагч этгээдийн татварын зорилгоор байрладаг улс, бүс нутгийн хуулиар улс бүрээр тайланг энэ хуулийн 27.5-д заасан шаардлагад нийцүүлэн гаргахыг шаарддаг;
- 27.4.5.энэ хуулийн 27.2-т заасан хугацаанд томилогдсон тайлагнагч этгээдийн татварын зорилгоор байрладаг улс, бүс нутаг нь эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрийг Монгол Улстай байгуулсан;

- 27.4.6. томилогдсон тайлагнагч этгээдийн татварын зорилгоор байрладаг улс, бүс нутаг нь Монгол Улсын татварын албанд системийн саатал гарсан тухай мэдэгдээгүй;
- 27.4.7. группийн оролцогч этгээд татварын зорилгоор байрладаг улс, бүс нутагт томилогдсон тайлагнагч этгээд гэдгээ тухайн улс, бүс нутгийн хуулийн шаардлагын дагуу мэдэгдсэн бөгөөд энэ хуулийн 27.7.2-т заасны дагуу тус мэдэгдэл харьяалах татварын албанд хүргэгдсэн;
- 27.5. Улс бүрээр үнэ шилжилтийн тайлан дараах мэдээллийг агуулна:
- 27.5.1. үндэстэн дамнасан группийн үйл ажиллагаа явуулж байгаа улс орон бүрт олсон орлого, татварын өмнөх ашиг /алдагдал/, төлсөн орлогын албан татвар, орлогын албан татварын өр, хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн, хуримтлагдсан ашиг, ажиллагчдын тоо, мөнгө болон түүнтэй адилтгах зүйлсээс бусад хөдлөх, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой нэгдсэн мэдээлэл;
- 27.5.2. үндэстэн дамнасан группийн оролцогч нэг бүрийн албан татвар төлөгчийн дугаар, татварын зорилгоор оршин суугч улсын мэдээлэл, хэрэв бүртгүүлсэн болон татварын зорилгоор оршин суугч улсууд нь ялгаатай бол эдгээр группийн оролцогч бүрийн аль улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан талаарх мэдээлэл, группийн оролцогч бүрийн бизнесийн үндсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
- 27.6. Улс бүрээр тайлан гаргах маягт, журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.
- 27.7. Албан татвар төлөгч доор дурдсан үүрэг хүлээнэ:
- 27.7.1. Монгол Улсад татварын зорилгоор байрладаг үндэстэн дамнасан группийн оролцогч этгээд нь үндэстэн дамнасан группийн толгой этгээд, эсхүл томилогдсон тайлагнагч этгээд эсэх талаар тухайн жилийн эцсийн татварын тайлан хүргүүлэх хугацаанд багтаан мэдэгдэх;
- 27.7.2. үндэстэн дамнасан группийн оролцогч этгээд нь үндэстэн дамнасан группийн толгой этгээд, эсхүл томилогдсон тайлагнагч этгээд биш бол тайлагнагч этгээдийн албан татвар төлөгчийн дугаар, татварын зорилгоор байрладаг улс, бүс нутгийн тухай мэдээллийг тухайн жилийн эцсийн татварын тайлан хүргүүлэх хугацаанд багтаан харьяалах татварын албанд мэдэгдэх.
- 27.8. Татварын алба улс бүрээр тайланг татварын эрсдэл тооцох, статистик, тооцоо судалгааны зорилгоор ашиглах бөгөөд уг тайланд үндэслэн үнэ шилжилтийн тохируулга хийхгүй.

- 27.9. Татварын алба улс бүрээр тайланд туссан мэдээллийн нууцлалыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон холбогдох стандартын дагуу нууцлан хадгална.
- 27.10. Энэ хуулийн 27.2.2 дахь заалтыг Монгол Улсын татварын байгууллага албан ёсоор гадаад улсын татварын албатай мэдээллийг автоматаар харилцан солилцож эхлэх боломжтой өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

28 дугаар зүйл. Албан татварын буцаан олголт

- 28.1. Албан татвар төлөгч, суутган төлөгчийн энэ хуулийн 26.1, 26.2-т заасны дагуу хүргүүлсэн тайлангаар гарсан албан татварын илүү, дутуу төлөлтийн тооцооллыг харьяалах татварын алба дараах журмын дагуу нягталж, эцсийн тооцоо хийнэ:
- 28.1.1. татварын жилд албан татвар төлөгчид буцаан олгох татварын хэмжээ нь энэ хуулийн 22.7-д зааснаар хязгаарлагдах;
 - 28.1.2. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан хөнгөлөлтийг албан татвар төлөгч энэ хуулийн 22.7-д заасан хязгаарт багтаан өөрөө сонгон эдлэх;
 - 28.1.3. албан татвар төлөгч энэ хуульд заасан хөнгөлөлтийг хэсэгчлэн эдлэхгүй байх;
 - 28.1.4. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан тухайн татварын жилийн хөнгөлөлтийг дараагийн татварын жилд шилжүүлэн эдлүүлэхгүй байх.
- 28.2. Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар нь төлбөл зохих албан татварын хэмжээнээс бага тохиолдолд харьяалах татварын алба албан татвар төлөгчид мэдэгдэж, эцсийн тооцоог хийнэ.
- 28.3. Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар төлбөл зохих албан татварын хэмжээнээс давсан тохиолдолд илүү гарсан дүнг Татварын ерөнхий хуулийн 49.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 28.4. Энэ хуулийн 28.3-т заасан илүү гарсан дүн буюу албан татвар төлөгчийн буцаан авах илүү төлсөн татварыг дараах журмаар буцаан олгоно:
- 28.4.1. буцаан олголтыг төрийн сангийн дансаар дамжуулан албан татвар төлөгчид буцаан олгох;
 - 28.4.2. буцаан олгох татварын хэмжээг харьяа татварын алба энэ хуулийн 26.1, 26.2-т заасан тайлан хүргүүлэх хугацаанаас хойш ажлын 20 өдөрт багтаан хянан тодорхойлж, төрийн сангийн нэгжид хүргүүлэх;
 - 28.4.3. энэ хуулийн 28.4.2-т заасан буцаан олголтыг дараагийн татварын жилийн 2 дугаар улиралд багтаан олгох.
- 28.5. Энэ хуулийн 28.4-т заасан албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон

харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

- 28.6. Буцаан олгох албан татвар нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн жилд улсын төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 30 хувиас хэтрэхгүй байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙЛСАН ТАТВАРЫН ХАРИЛЦАА

29 дүгээр зүйл. Татварын хялбаршуулсан горим

- 29.1. Өмнөх татварын жилийн тайлангаар баталгаажсан борлуулалтын нийт орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс бага бол тухайн албан татвар төлөгч тухайн татварын жилийн 3 дугаар улиралд багтаан хүсэлт гаргасныг харьяалах татварын алба бүртгэж авсан тохиолдолд дараагийн татварын жилээс эхлэн тухайн албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.
- 29.2. Татварын хялбаршуулсан горим ашиглах албан татвар төлөгч нь татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна.
- 29.3. Дараах албан татвар төлөгч энэ хуулийн 29.1-д заасан хүсэлт гаргахгүй:
- 29.3.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгүүлсэн албан татвар төлөгч;
 - 29.3.2. доор дурдсан үйл ажиллагаа эрхэлдэг албан татвар төлөгч:
 - 29.3.2.а. ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах;
 - 29.3.2.б. согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох;
 - 29.3.2.в. тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;
 - 29.3.2.г. газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулах.
- 29.4. Энэ хуулийн 29.1-д заасан хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.
- 29.5. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд хүсэлт гаргаж бүртгүүлсэн албан татвар төлөгчийн өмнөх жилүүдийн татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохгүй.
- 29.6. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд хүсэлт гаргаж бүртгүүлсэн албан татвар төлөгч Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан

нөхцөл, шаардлагын дагуу нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгч болсон өдрөөс эхлэн хялбаршуулсан горимоос гарна.

- 29.7. Энэ хуулийн 29.3.2-т заасан үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн өдрөөс эхлэн хялбаршуулсан горимоос гарна.
- 29.8. Энэ хуулийн 29.6, 29.7-д зааснаас бусад тохиолдолд энэ зүйлийн дагуу татварын албанд хүсэлт гаргаж бүртгүүлсэн албан татвар төлөгч татварын жилийн дундуур хялбаршуулсан горимоос гарахгүй.
- 29.9. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу тодорхойлсон албан татвар ногдуулах орлогод 1 хувиар албан татвар ногдуулна.
- 29.10. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу албан татвар төлж, тайлагнах аж ахуйн нэгж энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан чөлөөлөлт, 22 дугаар зүйлд заасан хөнгөлөлт эдлэхгүй бөгөөд энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу гадаад улсад ногдуулан төлсөн татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцохгүй.
- 29.11. Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваарийг үндэслэн харьяалах татварын алба тухайн татварын жилд энэ хуулийн 29.9-д заасны дагуу ногдуулан төлөх албан татварын сарын хуваарийг албан татвар төлөгчид хүргүүлнэ.
- 29.12. Энэ хуулийн 29.11-д заасан урьдчилан тодорхойлсон хуваарийн дагуу улирал бүр төлөх татвараа дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тооцооны дагуу татвараа дараа оны 02 дугаар сард багтаан төсөвт төлнө.
- 29.13. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу гаргасан хүсэлтээ татварын албанд бүртгүүлсэн албан татвар төлөгч жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

30 дугаар зүйл. Эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоог өөрчлөх замаар эрх борлуулсан, шилжүүлсний татварын харилцаа

- 30.1. “Эцсийн эзэмшигч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д заасныг ойлгоно.
- 30.2. Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно.
- 30.3. Эрх борлуулсан, шилжүүлсний албан татвар ногдуулах орлогын суурийг энэ хуулийн 30.6-д заасан журмын дагуу тооцсон тухайн эрх, тусгай зөвшөөрлийн үнэлгээнээс доор дурдсан баримтаар нотлогдох зардлуудыг хасаж тодорхойлно:

- 30.3.1.төрийн байгууллагаас эрх олгосон тохиолдолд эрх авахтай холбогдон төрийн байгууллагад төлсөн баримтаар нотлогдох төлбөр, хураамж;
- 30.3.2.бусдаас худалдаж, шилжүүлж авсан тохиолдолд хэлцлийн дагуу худалдах, шилжүүлэн авахад төлсөн, шилжүүлсэн баримтаар нотлогдох төлбөр.
- 30.4. Энэ хуулийн 30.3-т заасны дагуу тодорхойлсон албан татвар ногдуулах орлогын сууриас эцсийн эзэмшигчийн борлуулсан, шилжүүлсэн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээс эрх эзэмшигчийн хувьцаанд хамаарах хэмжээгээр тухайн эрхийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож, албан татвар ногдуулах орлогыг эцэслэн тодорхойлно.
- 30.5. Газар ашиглах, эзэмших эрхийн үнэлгээг Газрын тухай хуулийн 38.6-д заасан үнийн шаардлагыг үндэслэн тодорхойлно.
- 30.6. Энэ хуулийн 30.4-т заасан орлогод албан татвар ногдуулах журам, газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлалыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 30.7. Энэ хуулийн 30.1-д заасан эцсийн эзэмшигч нь Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч бол тухайн эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээ борлуулсан, шилжүүлсний орлого болон энэ хуулийн 30.3, 30.4, 30.5, 30.6-д заасны дагуу тооцсон эрх борлуулсан, шилжүүлсний орлогын зөвхөн аль өндөр дүнтэй орлогод холбогдох албан татварыг ногдуулна. Бага дүнтэй орлогыг албан татвараас чөлөөлнө.
- 30.8. Эцсийн эзэмшигч нь эрх эзэмшигчийн тухайд төлөөлүүлэн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн нийт дүн, хэмжээг өөрчлөлгүйгээр эрх эзэмшигчээс эцсийн эзэмшигч хүртэлх үргэлжилсэн хэлхээ холбоонд хамаарах хуулийн этгээд хооронд хувьцаа шилжүүлэх, нэгдэх, нийлэх, тусгаарлах, шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр хэлхээ холбоо доторх хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн бүтцийг өөрчилсөн тохиолдолд эрх борлуулсан, шилжүүлсэн гэж үзэхгүй.
- 30.9. Эрх эзэмшигчийн өөрийн, эцсийн эзэмшигчийн болон эрх эзэмшигчээс эцсийн эзэмшигч хүртэлх үргэлжилсэн хэлхээ холбоонд хамаарах хуулийн этгээдийн хувьцаа гадаад, дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг бол үргэлжилсэн 12 сарын хугацаанд эрх эзэмшигч, түүний эцсийн эзэмшигчийн нээлттэй арилжаалсан хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээнд хамаарах эрх борлуулсан, шилжүүлсний орлогын дүнг албан татвараас чөлөөлнө.
- 30.10.Энэ хуулийн 30.4-т заасны дагуу тодорхойлсон албан татвар ногдуулах орлогод 10 хувиар албан татвар ногдуулна.

- 30.11.Энэ хуулийн 30.10-т заасны дагуу ногдуулах албан татварыг тухайн эрх эзэмшигч ногдуулж, 30 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ.
- 30.12.Энэ хуулийн 30.11-т заасныг үл харгалзан, эрх эзэмшигчийн өөрийн, эцсийн эзэмшигчийн болон эрх эзэмшигчээс эцсийн эзэмшигч хүртэлх үргэлжилсэн хэлхээ холбоонд хамаарах хуулийн этгээдийн хувьцаа гадаад, дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг бол эрх эзэмшигч хагас жилд ногдуулсан албан татварыг 07 дугаар сарын 20-ны дотор багтаан, жилийн эцсийн татварыг дараагийн татварын жилийн 02 дугаар сарын 10-ны дотор төсөвт шилжүүлж, эцсийн тооцоог хийнэ.
- 30.13.Албан татвар төлөгч энэ хуулийн 26.1, 26.2-т заасны дагуу хүргүүлэх татварын тайланд энэ хуулийн 30.11, 30.12-т заасны дагуу ногдуулсан татварын тайланг хавсаргана.

31 дүгээр зүйл. Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн татварын харилцаа

- 31.1. Харилцан хамаарал бүхий Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч болон Монгол Улсад байнга оршин суугч хувь хүн нь гадаадын аж ахуйн нэгжийн нийт хувьцааны тоо хэмжээний, эсхүл саналын эрхийн 50 ба түүнээс дээш хувийг тухайн татварын жилийн аль нэг хугацаанд шууд, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан эзэмшдэг бол тухайн гадаадын аж ахуйн нэгжийг энэ зүйлд заасан “үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж” гэж ойлгоно.
- 31.2. Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийг Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчид хамааруулна.
- 31.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тодорхойлсон оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан, үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн доор дурдсан орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:
- 31.3.1.энэ хуулийн 9.1.2, 9.1.3, 9.1.4, 10.1.1-д заасан орлогын нийт дүнгээр;
 - 31.3.2.энэ хуулийн 10.1.3-т заасан орлогыг энэ хуулийн 18.3-т заасны дагуу;
 - 31.3.3.энэ хуулийн 10.1.4-т заасан орлогыг энэ хуулийн 18.5-д заасны дагуу.
- 31.4. Гадаадын үнэт цаасны анхдагч зах зээлд хувьцаа, нэгж эрхээ нээлттэй арилжаалах зорилгоор байгуулагдсан үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсад хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжид энэ хуулийн 31 дүгээр зүйл хамаарахгүй.
- 31.5. Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж нь энэ хуулийн 30.1-д заасан эцсийн эзэмшигч бөгөөд энэ хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээ шилжүүлсний улмаас

- эрх эзэмшигч нь татварыг ногдуулан тайлагнасан тохиолдолд ногдуулсан татварын хэмжээгээр гадаад улсад албан татварыг бууруулан тооцно.
- 31.6. Энэ хуулийн 31.3-т заасны дагуу тодорхойлсон албан татвар ногдуулах орлогод энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан хувь хэмжээг баримтлан албан татвар ногдуулна.
- 31.7. Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн гадаад улсад ногдуулсан албан татварыг энэ хуулийн 31.3-т заасны дагуу тодорхойлон ногдуулсан тухайн жилийн төлбөл зохих албан татвараас хасаж тооцно. Ийнхүү хасаж тооцохдоо энэ хуулийн 23 дугаар зүйлд заасныг баримтална.
- 31.8. Энэ хуулийн 31.3-т заасны дагуу ногдуулсан албан татварыг гадаад улсын эрх бүхий байгууллагад тайлагнасан татварын тайлангийн хамт энэ хуулийн 31.1-д заасан Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч болон хувь хүн дараагийн татварын жилийн 02 дугаар сарын 10-ны дотор тайлагнаж, эцсийн тооцоог хийнэ.
- 31.9. Энэ хуулийн 31.3-т заасны дагуу ногдуулсан албан татварыг 31.8-д заасан эцсийн тооцоонд үндэслэн дараагийн татварын жилийн 02 дугаар сарын 10-ны дотор төсөвт төлнө.
- 31.10. Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, тайлагнах журам, тайлангийн маягтыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

32 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

32.1. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 03 сарын 22 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын хууль тогтоомж

2.1. Хувь хүний орлогын албан татвар /цаашид “албан татвар” гэх/-ын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан хувь хүний орлогод албан татвар ногдуулах харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“аж ахуйн нэгж” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.2.“биет бус хөрөнгө” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

4.1.3.“бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч” гэж ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй худалдаа, үйлчилгээ, зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь хүнийг;

4.1.4.“гадаад улсад олсон орлого” гэж энэ хуулийн 4.1.7, 4.1.8-д зааснаас бусад орлогыг;

4.1.5.“малчин өрх” гэж малыг байнга маллаж, ашиг шимээр нь үндсэн орлогоо олдог гэр бүлийг;

4.1.6.“мал бүхий этгээд” гэж энэ хуулийн 4.1.5-д зааснаас бусад мал өмчилж байгаа хувь хүнийг;

- 4.1.7.“Монгол Улсад олсон орлого” гэж албан татвар төлөгчийн Монгол Улсад олсон энэ хуулийн 6.3-т заасан орлогыг;
- 4.1.8.“Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого” гэж оршин суугч бус хувь хүний Монгол Улсад байрладаг этгээдэд ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж олсон энэ хуулийн 6.3-т заасан орлого болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.7-д заасан хувь хүнд хамаарах орлогыг;
- 4.1.9.“үл хөдлөх эд хөрөнгө” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.9-д заасныг;
- 4.1.10.“тогтмол бус үйл ажиллагаа” гэж тухайн хувь хүний хууль буюу гэрээгээр байнга эрхлэх ажил үүрэгтэй нь холбоогүй, орлогын тогтмол эх үүсвэр болдоггүй ажил, үйлчилгээг;
- 4.1.11.“суутган төлөгч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.19-д заасныг.

5 дугаар зүйл.Албан татвар төлөгч

- 5.1. Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл энэ хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн албан татвар төлөгч байна.
- 5.2. Албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга оршин суугч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч гэж ангилна.
- 5.3. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч гэж доор дурдсан нөхцөлийн аль нэгийг хангасан хувь хүнийг хэлнэ:
 - 5.3.1.үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин суусан;
 - 5.3.2.албан татвар ногдох орлогын 50 ба түүнээс дээш хувийг Монгол Улсад олсон орлого болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого эзэлж байвал.
- 5.4.Энэ хуулийн 5.3-т заасан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийг тодорхойлоход энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан дарааллыг баримтална.
- 5.5.Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчид Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон, энэ хуулийн 5.3, 5.6-д зааснаас бусад хувь хүнийг хамруулна.
- 5.6.Гадаад улсад томилогдон ажиллаж байгаа Монгол Улсын төрийн албан хаагч нь Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч байна.
- 5.7.Энэ хуулийн 5.3.1-д заасан хугацааг Монгол Улсын хилээр орсон өдрөөс хуанлийн хоногоор тоолох бөгөөд олон удаа орж гарсан тохиолдолд албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хоногийн нийлбэрээр тодорхойлно.

- 5.8.Энэ хуулийн 5.7-д заасан нийлбэрийг тодорхойлоход тухайн татварын жил болон түүний өмнөх татварын жилийг хамруулан тооцно.
- 5.9.Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн нь Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчид хамаарахгүй.
- 5.10.Албан татвар төлөгч үргэлжилсэн 12 сарын хугацаанд Монгол Улсад 183 ба түүнээс дээш хоногоор ажиллах нь хөдөлмөрийн гэрээ, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлөөр нотлогдож байвал уг албан татвар төлөгч Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчөөр бүртгүүлж болно.
- 5.11.Энэ хуульд заасан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийг тодорхойлох, бүртгэх, бүртгэлээс хасах, албан татварын тооцоо хийхтэй холбогдсон журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР НОГДОХ ОРЛОГО

6 дугаар зүйл.Албан татвар ногдох орлого

- 6.1.Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй, түүнчлэн гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно.
- 6.2.Энэ хуулийн 5.5-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно.
- 6.3.Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:
- 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;
 - 6.3.2.үйл ажиллагааны орлого;
 - 6.3.3.хөрөнгийн орлого;
 - 6.3.4.хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;
 - 6.3.5.шууд бус орлого;
 - 6.3.6.бусад орлого.

7 дугаар зүйл.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого

7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:

7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

7.1.2.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;

7.1.3.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;

7.1.4.төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

7.1.5.гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

7.1.6.үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

7.1.7.хоол, унааны мөнгө.

8 дугаар зүйл.Үйл ажиллагааны орлого

8.1.Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж олсон дараах орлогыг хамруулна:

8.1.1.бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого;

8.1.2.хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

8.1.3.шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;

8.1.4.эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээ.

8.2.Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.

9 дүгээр зүйл.Хөрөнгийн орлого

9.1. Хөрөнгийн орлогод дараах орлогыг хамруулна:

9.1.1.хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого;

9.1.2.эрхийн шимтгэлийн орлого;

9.1.3.ногдол ашгийн орлого;

9.1.4.хүүгийн орлого.

- 9.2. Эрхийн шимтгэлийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.2-т заасныг хамааруулна.
- 9.3. Ногдол ашгийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.3-т заасныг хамааруулна.
- 9.4. Хүүгийн орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.4-т заасныг хамааруулна.

10 дугаар зүйл.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого

10.1. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод дараах орлогыг хамруулна:

- 10.1.1.үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;
- 10.1.2.газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;
- 10.1.3.хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого;
- 10.1.4.хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого.

10.2. Биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар төлөгч өөрийн эдийн бус хөрөнгө өмчлөх эрхийг хуульд заасны дагуу бусдад шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.

11 дүгээр зүйл.Шууд бус орлого

11.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараах бараа, ажил, үйлчилгээний орлогыг шууд бус орлогод хамруулна:

- 11.1.1.үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн;
- 11.1.2.орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр;
- 11.1.3.үзвэр үйлчилгээний олговор;
- 11.1.4.ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр;
- 11.1.5.ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;
- 11.1.6.арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;
- 11.1.7.ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж;
- 11.1.8.гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр;
- 11.1.9.Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр;
- 11.1.10.эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл;

- 11.1.11.энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5, 11.1.6, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.10-т заасантай адилтгах бусад орлого.
- 11.2. Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараах шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамруулахгүй:
- 11.2.1.цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан;
 - 11.2.2.амрах байр, бусад үйлчилгээгээр хангах, тухайн ажлын байранд ирэх, буцахад нэгдсэн журмаар унаагаар үйлчилсэн;
 - 11.2.3.орон сууц худалдан авах, барихад зориулж ажилтанд арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;
 - 11.2.4.эрүүл мэндийн байгууллагад төлсөн эмчилгээний зардалд зориулж олгосон тусламж, дэмжлэг;
 - 11.2.5.ажил олгогчоос олгож байгаа албан томилолтын зардал;
 - 11.2.6.хууль тогтоомжийн дагуу ажил олгогчоос олгож байгаа хөдөлмөр хамгааллын болон дүрэмт хувцас, хор саармагжуулах ундааны үнэ, тэдгээртэй адилтгах бусад хангамжийн зардал;
 - 11.2.7.хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор ажил олгогчийн төлсөн сайн дурын амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын болон мэргэжлийн хариуцлагын даатгалын хураамж.
- 11.3. Энэ хуулийн 11.1-д заасан шууд бус орлогыг ажил олгогчоос уг орлогыг олгохтой холбогдон гарсан зардлын дүнгээр тодорхойлно.

12 дугаар зүйл.Бусад орлого

- 12.1. Энэ хуулийн 6.3.6-д заасан орлогод дараах орлогыг хамруулна:
- 12.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого;
 - 12.1.2.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлого;
 - 12.1.3.бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого.

13 дугаар зүйл.Албан татвар ногдох орлогыг тодорхойлох

- 13.1. Албан татвар ногдох орлогын дүнг тодорхойлохдоо албан татвараас чөлөөлөгдсөн орлогыг хасаж тооцно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ

14 дүгээр зүйл.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

14.1. Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна.

15 дугаар зүйл.Үйл ажиллагааны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

15.1. Үйл ажиллагааны орлогод албан татварын ногдуулах орлогыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1-д заасан шаардлагыг хангасан зардлыг хасаж, мөн хуулийн 13.2-т заасан зарчмыг баримталж, 14, 15, 16, 17 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан хасагдах зардлыг албан татвар төлөгч хувийн хэрэглээндээ зарцуулсан бол албан татвар ногдох орлогоос хасахгүй.

15.3.Албан татвар төлөгч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал түүнд ногдох үйл ажиллагааны зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцохгүй.

15.4. Албан татвар төлөгч үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж байгаа машин, механизм, тоног төхөөрөмж, барилгыг гэр бүлийнхээ хэрэгцээнд нэгэн зэрэг ашиглаж байгаа бол ашиглалтын зардлыг хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тусгана.

15.5. Албан татвар төлөгчийн гэр бүлийн гишүүнд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож хасагдах зардалд тооцно.

15.6. Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, уг хүсэлтийг харьяа татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.

15.7. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхтэй албан татвар төлөгч энэ хуулийн 15.6-д заасан хүсэлт гаргахгүй.

15.8. Энэ хуулийн 15.6-д заасан хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

16 дугаар зүйл.Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

16.1.Хөрөнгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

16.1.1.хөрөнгө ашиглуулсны, эсхүл түрээслүүлсний нийт орлогоос тухайн хөрөнгийг ашиглуулах, эсхүл түрээслүүлэхтэй холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлыг хассан зөрүүгээр;

16.1.2.эрхийн шимтгэлийн орлогыг нийт дүнгээр;

16.1.3.ногдол ашгийн орлогыг нийт дүнгээр;

16.1.4.хүүгийн орлогыг нийт дүнгээр.

16.2. Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол албан татвар ногдуулах орлогыг албан татвар төлөгчийн эзэмшилд байгаа хувьцаа болон хувь нийлүүлсэн хөрөнгөд хувь тэнцүүлэн хуваарилсан орлогын дүнгээс уг хувьцаа болон хөрөнгийг анх худалдан авсан үнэ, хувь нийлүүлэхдээ гаргасан зардлыг хасаж тодорхойлно.

17 дугаар зүйл.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

17.1. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

17.1.1.энэ хуулийн 10.1.1-д заасан үл хөдлөх эд хөрөнгө борлуулж олсон орлогыг нийт дүнгээр;

17.1.2.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогоос доор дурдсан баримтаар нотлогдох зардлуудыг хассан дүнгээр:

17.1.2.а.эрх авахтай холбогдуулан төрийн байгууллагад төлсөн баримтаар нотлогдох зардал;

17.1.2.б.хөрөнгийг худалдаж, шилжүүлж авах болон тэдгээртэй холбогдуулан төлсөн баримтаар нотлогдох зардал;

17.1.3.энэ хуулийн 10.1.4-т заасан хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлогоос уг хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардлыг хассан дүнгээр;

17.1.4.хамтран эзэмшиж байсан хувьцаа, үнэт цаас борлуулсан бол энэ хуулийн 17.1.3-т заасны дагуу хассан дүнг тодорхойлсны дараа тухайн албан татвар төлөгчид ногдох хэсгийн үнийн дүнгээр.

17.2. Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ тооцох, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлоход Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.6-д заасан аргачлалыг баримтална.

18 дугаар зүйл.Шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

18.1. Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно.

19 дүгээр зүйл.Бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

19.1. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

19.1.1.урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр;

19.1.2.төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр.

19.2. Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч албан татвар төлөгч тайлант жилд олсон орлогоо өөрийн хүсэлтээр энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан орлогод хамруулан, албан татвар ногдуулан төлж, тайлагнаж болно.

20 дугаар зүйл.Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

20.1. Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

20.2. Монгол Улсад оршин суугч этгээд болон Монгол Улсад оршин суугч бус этгээд хооронд байгуулсан аж ахуйн үйл ажиллагааны гэрээний дагуу тухайн оршин суугч бус этгээдийг төлөөлж Монгол Улсад хүрэлцэн ирж ажилласан хувь хүнд Монгол Улсад оршин суугч этгээдээс олгосон орлогыг талууд гэрээнд тусгасан байна.

20.3. Энэ хуулийн 20.2-т заасан нөхцөл нь гэрээнд тодорхой тусгагдаагүй тохиолдолд гэрээний үнийн тооцоололд багтсан тухайн хувь хүний Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллахтай холбогдон гарсан зардлын дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ

21 дүгээр зүйл.Албан татварын хувь, хэмжээ

- 21.1. Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.
- 21.2. Энэ хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад дурдсан орлогод доор дурдсан хувиар тооцож, албан татвар ногдуулна:
- 21.2.1.энэ хуулийн 17.1.1-д заасан орлогын дүнд 2 хувиар;
 - 21.2.2.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар;
 - 21.2.3.энэ хуулийн 19.1.2-т заасан орлогын дүнд 40 хувиар;
 - 21.2.4.энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар;
 - 21.2.5.энэ хуулийн 20.1-д заасан орлогын дүнд 20 хувиар.
- 21.3. Энэ хуулийн 15.6-д заасан орлогын дүнд 1 хувиар албан татвар ногдуулна.
- 21.4. Энэ хуулийн 12.1.3-т заасан орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал доор дурдсан хязгаарт багтаан тогтооно:
- 21.4.1.ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд албан татварын доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувь, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээнд;
 - 21.4.2.хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд албан татварын доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувь, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээнд.
- 21.5. Энэ хуулийн 21.2.4, 21.2.5-д заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн тухайн хувьцаа, нэгж эрх, өрийн бичигтэй холбоотойгоор олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогод 5 хувиар албан татвар ногдуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

22 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх орлого

- 22.1. Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:
- 22.1.1. хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж;
 - 22.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;

- 22.1.3.гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд үзүүлж байгаа тусламж;
- 22.1.4.малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлого;
- 22.1.5.Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз;
- 22.1.6.Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого;
- 22.1.7.нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлого;
- 22.1.8.энэ хуулийн 5.9-д заасан хувь хүний цалин, нэмэгдэл;
- 22.1.9.энэ хуулийн 22.1.8-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний гадаад улсад олсон орлого.
- 22.2. Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан хувиар албан татвар төлж байгаа хувь хүнд энэ зүйлд заасан чөлөөлөлт үзүүлэхгүй.

23 дугаар зүйл.Албан татварын хөнгөлөлт

- 23.1. Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/
0-6 000 000 хүртэл	240 000
6 000 000-12 000 000 хүртэл	216 000
12 000 000-18 000 000 хүртэл	192 000
18 000 000-24 000 000 хүртэл	168 000
24 000 000-30 000 000 хүртэл	144 000
30 000 000-36 000 000 хүртэл	120 000
36 000 000 ба түүнээс дээш	-

- 23.2. Доор дурдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн болон тариалсан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө:

- 23.2.1.үр тариа;
- 23.2.2.төмс, хүнсний ногоо, түүний үр;
- 23.2.3.жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац;

23.2.4.тэжээлийн ургамал;

23.2.5.модны суулгац.

- 23.3. Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар ипотекийн зээлийн хөрөнгөөр хувьдаа, анх удаа орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид Монгол Улсын Засгийн газрын тодорхойлсон ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүд төлсөн дүнтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ.
- 23.4. Монгол Улсын иргэн өөрийн албан татвар ногдсон орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар зөвхөн хувьдаа, анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан бол ийнхүү орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авахад зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг уг албан татвар төлөгчид эдлүүлэх бөгөөд энэ хөнгөлөлтийн хэмжээ 6 сая төгрөг хүртэл байна.
- 23.5. Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургуульд оюутан, эсхүл суралцагчаар элсэн суралцаж байгаа тохиолдолд түүний анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмших сургалтын хугацаанд тухайн татварын жилд төлсөн, баримтаар нотлогдож байгаа сургалтын төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.
- 23.6. Монгол Улсын иргэн суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд, мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, коллежид анхлан суралцагчийг энэ хуулийн 23.5-д заасан хөнгөлөлтөд хамруулна.
- 23.7. Албан татвар төлөгч өөрийн хэрэгцээнд зориулан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан бол баримтаар нотлогдож байгаа төлбөртэй тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ.
- 23.8. Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож байгаа хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг албан татвар төлөгчид эдлүүлнэ.
- 23.9. Албан татвар төлөгчийн дараах орлогод ногдох албан татварт хөнгөлөлт эдлүүлнэ:
- 23.9.1. донорын олговор;
- 23.9.2. даатгалын нөхөн төлбөр;

- 23.9.3.Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал.
- 23.10.Аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн энэ хуулийн 6.3.2-т заасан орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлнө.
- 23.11.Энэ хуулийн 23.7-д заасан тоног төхөөрөмж, бараа материалын жагсаалтыг Засгийн газар батална.
- 23.12.Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан хувиар албан татвар төлж байгаа хувь хүн энэ хуульд заасан хөнгөлөлт эдлэхгүй.
- 23.13.Албан татвар төлөгч энэ хуулийн 23.3, 23.4-т заасан хөнгөлөлтийн аль нэгийг сонгон эдэлнэ.
- 23.14.Албан татварын хөнгөлөлтийг энэ хуульд заасан эцсийн хугацаанд тайлагнаж төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй бөгөөд энэ хуулийн 23.1, 23.9-д зааснаас бусад албан татварын хөнгөлөлтийг 28 дугаар зүйлд заасны дагуу буцаан олгоно.
- 23.15.Энэ хуулийн 22.1-д заасан чөлөөлөлт болон энэ хуульд заасан хөнгөлөлт эдлүүлэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

24 дүгээр зүйл.Гадаад улсад ногдуулсан албан татварыг төлбөл зохих татвараас хасаж тооцох

- 24.1. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн гадаад улсад төлсөн албан татварыг тус албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татвараас хасаж тооцно.
- 24.2. Энэ хуулийн 24.1-д заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээ нь албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад төлбөл зохих албан татварын дүнгээс хэтрэхгүй байна.
- 24.3. Энэ хуулийн 24.1-д заасны дагуу гадаад улсад ногдуулсан албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийг баримтална.
- 24.4. Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг баталгаажуулах, төлбөл зохих албан татвараас хасаж тооцох журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ, ТӨСӨВТ ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ, ХАСАЛТ
ХИЙХ, БУЦААН ОЛГОХ

25 дугаар зүйл. Албан татвар суутган тооцох, төсөвт төлөх

25.1. Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална:

25.1.1.энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.2.энэ хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.3.энэ хуулийн 17.1.1-д заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.4.энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.2-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.5.энэ хуулийн 19.1.2-т заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.3-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.6.энэ хуулийн 20.1-д заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.5-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

25.1.7.Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогын дүнд энэ хуулийн 21.5-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх.

25.2. Албан татвар төлөгчийн харилцах данс, хадгаламжид хүү тооцох бүрдээ банк, санхүүгийн байгууллага нь суутган төлөгчийн үүрэг хүлээж, албан татвар ногдуулан суутгаж, холбогдох төсөвт шилжүүлнэ.

25.3. Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно.

25.4. Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ.

- 25.5. Суутган төлөгч нь албан татвар төлөгчид энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ.
- 25.6. Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-г зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.

26 дугаар зүйл. Албан татварыг өөрөө тодорхойлж, төсөвт төлөх

26.1. Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, доор дурдсан хугацаанд албан татварыг холбогдох төсөвт төлнө:

- 26.1.1. энэ хуулийн 15.1, 16.1.1, 17.1.2, 17.1.3-г тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.4-г заасан хувиар тооцон тухай бүр албан татвар ногдуулан, дараа сарын 15-ны өдрийн дотор;
- 26.1.2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-г тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.4-г заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
- 26.1.3. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 17.1.1-д тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
- 26.1.4. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
- 26.1.5. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 19.1.1-д тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.2-г заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
- 26.1.6. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон энэ хуулийн 19.1.2-г тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.2.3-г заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;
- 26.1.7. энэ хуулийн 15.6-д тодорхойлсон орлогод энэ хуулийн 21.3-г заасан хувиар албан татвар ногдуулж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

- 26.2. Энэ хуулийн 21.4-т заасан бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь уг зөвшөөрлийг гэрчилгээний хамт олгон, тухай бүр албан татварыг хураан авч, холбогдох төсөвт төвлөрүүлнэ.
- 26.3. Энэ хуулийн 4.1.3-т заасан зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч нь зөвшөөрөл, албан татвар төлсөн гэрчилгээг биедээ авч явах, эсхүл тээврийн хэрэгсэлдээ ил байрлуулна.
- 26.4. Энэ хуулийн 26.2-т заасан албан татвар төлөгчийн албан татвар төлснийг нотлох гэрчилгээний загварыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.
- 26.5. Энэ хуульд заасны дагуу албан татварын тайлан гаргах үүрэг хүлээгээгүй албан татвар төлөгч өөрийн хүсэлтээр тухайн жилийн албан татварын тайлан гаргаж, дараа жилийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлэн, жилийн эцсийн тооцоо хийж болно.
- 26.6. Албан татвар төлөгч нь Монгол Улсад байрладаг аж ахуйн нэгжид ажиллаж, Монгол Улсад байрладаггүй этгээдээс авсан энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд тодорхойлсон орлогод ногдох албан татварыг дараа сарын 10-ны дотор холбогдох төсөвт төлж, тухайн татварын жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

27 дугаар зүйл. Албан татварын тайлан хүргүүлэх хугацаа

- 27.1. Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.
- 27.2. Албан татвар төлөгч энэ хуулийн 15.1, 15.6, 16.1.1, 17.1.2, 17.1.3-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.
- 27.3. Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь энэ хуулийн 26.2-т заасны дагуу хураан авсан албан татварын тайланг харьяа татварын албанд дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.
- 27.4. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч нь гадаад улсад олсон энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2-т тодорхойлсон орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны 02

дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

- 27.5. Энэ хуулийн 22.1.2, 22.1.4, 22.1.7, 23.1-д зааснаас бусад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах албан татвар төлөгч албан татварын тайлан гаргах үүрэгтэй бөгөөд уг тайлан нь түүнийг албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах үндсэн баримт болно.
- 27.6. Албан татвар төлөгч татварын жил дуусахаас өмнө тухайн татварын жилд хамаарах албан татварын тайлан гаргаж, холбогдох тооцоог урьдчилан хийж болно.

28 дугаар зүйл. Албан татварын буцаан олголт

- 28.1. Албан татвар төлөгч, суутган төлөгчийн энэ хуулийн 27.1, 27.2, 27.4, 27.5, 27.6-д заасны дагуу хүргүүлсэн тайлангаар албан татварын илүү, дутуу төлөлтийн тооцооллыг харьяа татварын алба дараах журмаар нягталж, эцсийн тооцоог хийнэ:
- 28.1.1. татварын жилд албан татвар төлөгчид буцаан олгох албан татварын хэмжээ нь энэ хуулийн 23.14-т зааснаар хязгаарлагдах;
 - 28.1.2. албан татвар төлөгч энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эхэлж эдлэх;
 - 28.1.3. энэ хуулийн 23.1-д зааснаас бусад хөнгөлөлтийг албан татвар төлөгч энэ хуулийн 28.1.1-д заасан хязгаарт багтаан өөрөө сонгож эдлэх;
 - 28.1.4. албан татвар төлөгч энэ хуульд заасан хөнгөлөлтийг хэсэгчлэн эдлэхгүй байх;
 - 28.1.5. энэ хуулийн 23.4-т зааснаас бусад хөнгөлөлтийг дараагийн татварын жилд шилжүүлэн эдлүүлэхгүй байх.
- 28.2. Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар нь төлбөл зохих албан татварын хэмжээнээс бага тохиолдолд харьяа татварын алба албан татвар төлөгчид мэдэгдэж, эцсийн тооцоог хийж, зөрүүг төлүүлнэ.
- 28.3. Энэ хуулийн 28.1-д заасан журмыг баримтлан тооцоход албан татвар төлөгчийн татварын жилд төлсөн албан татвар төлбөл зохих албан татварын хэмжээнээс давсан тохиолдолд илүү гарсан дүнг Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 28.4. Энэ хуулийн 28.3-т заасан албан татвар төлөгчийн буцаан авах, илүү төлсөн албан татварыг дараах журмаар буцаан олгоно:
- 28.4.1. буцаан олголтыг тухайн татварын албаны харьяалагдах засаг захиргааны нэгжийн төрийн сангийн дансаар дамжуулан албан татвар төлөгчид буцаан олгох;

28.4.2. харьяа татварын алба энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан тайлан хүргүүлэх хугацаанаас хойш ажлын 20 өдөрт багтаан буцаан олгох албан татварын хэмжээг хянан тодорхойлж, харьяалах төрийн сангийн нэгжид хүргүүлэх;

28.4.3. энэ хуулийн 28.4.1-д заасан буцаан олголтыг дараа жилийн 2 дугаар улиралд багтаан олгох.

28.5. Энэ хуулийн 28.4-т заасан албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих харилцааг зохицуулсан журмыг татварын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД

29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

29.1. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

**ӨРТЭЙ ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ХӨРӨНГӨ БИТҮҮМЖЛЭХ, ХУРААХ,
ХАДГАЛАХ, ХАМГААЛАХТАЙ ХОЛБОГДОХ
ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Өртэй татвар төлөгчийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, авлага, банканд дахь харилцах данс, биет бус хөрөнгө /цаашид “хөрөнгө” гэх/-ийг битүүмжилж, уг хөрөнгөөс татварын өрийг гаргуулах харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.2. Татварын улсын байцаагч өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг Татварын ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу тогтооно.
- 1.3. Татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 55.1.1, 55.1.2, 55.1.3-т заасан хугацаанд татвараа бүрэн төлөөгүй, эсхүл татвар төлөгчид мөн хуулийн 55.1.4-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд татварын алба хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл болно.
- 1.4. Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу татвар төлөгчид татварын өр төлөх хугацааг сунгаж хөнгөлөлт үзүүлсэн тохиолдолд хөнгөлөлтийн хугацаанд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэхгүй.
- 1.5. Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг гаргуулах буюу хөрөнгө битүүмжлэхдээ Татварын ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийг баримтална.
- 1.6. Хөрөнгө битүүмжлэх, хураах ажиллагаанд Татварын ерөнхий хуулийн 19.3-т заасан нөхцөл үүсэх тохиолдолд цагдаагийн байгууллагын дэмжлэг хүснэ.
- 1.7. Хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, хамгаалах ажиллагааг өртэй татвар төлөгчийг харьяалах татварын алба хэрэгжүүлэх бөгөөд битүүмжилсэн эсхүл битүүмжлэх хөрөнгө байршиж буй нутаг дэвсгэрийн татварын албанд битүүмжилсэн хөрөнгөөс татварын өрийг барагдуулах ажиллагааг шилжүүлж болно.

Хоёр. Хөрөнгө битүүмжлэх ажиллагаа

- 2.1. Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэхдээ дараах ажиллагааг хэрэгжүүлсэн байна:
 - 2.1.1. татварын өрийг төлүүлэхээр өртэй татвар төлөгчид “Татварын нэхэмжлэх” хүргүүлсэн байх;

- 2.1.2.Татварын ерөнхий хуулийн 54.1-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд өртэй татвар төлөгчид “Урьдчилан нэхэмжлэх хуудас” хүргүүлсэн байх.
- 2.2. Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг түүний өмчлөл, эзэмшилд хамаарах эсэхийг дараах байдлаар тодорхойлно:
- 2.2.1.өртэй татвар төлөгч нь хөдлөх эд хөрөнгө өмчилдөг байх, үнэт цаасны тухайд эзэмшигч, өмчлөгчөөр эрх бүхий байгууллагад бүртгэлтэй байх;
- 2.2.2.үл хөдлөх эд хөрөнгө, автомашин, агаарын хөлөг, эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эсхүл эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрх бүхий хөрөнгө, зохиогчийн эрх болон бусад биет бус хөрөнгийн тухайд холбогдох бүртгэлийн байгууллагад өртэй татвар төлөгчийн нэрээр бүртгүүлсэн байх;
- 2.2.3.бүртгэлгүй хөрөнгийн хувьд эзэмшиж буй бодит байдал, ашиглалтын байдал нь өртэй татвар төлөгчид хамаарах үндэслэлтэй байх;
- 2.2.4.иргэн, хуулийн этгээдийн эзэмших хувьцаа нь хуулийн этгээдийн дүрэм, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд болон бүртгэх эрх бүхий байгууллагад өртэй татвар төлөгчийн нэрээр бүртгэгдсэн байх;
- 2.2.5.авлагын тухайд зээлийн гэрээ, өрийн бичиг, хадгаламжийн дэвтэр, санхүүгийн тайлан, арбитрын болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, тогтоол, магадал болон бусад бичиг баримтад өртэй татвар төлөгчид хамаарахаар тусгагдсан байх.
- 2.3. Хөрөнгийн бүртгэл нь өртэй татвар төлөгчид шууд хамааралгүй байсан ч худалдах, худалдан авах, бэлэглэл, арилжаа, хөрөнгө оруулалт зэргээр гэрээний дагуу хөрөнгө нь өртэй татвар төлөгчид шилжих нь тодорхой болсон бол уг хөрөнгийг өртэй татвар төлөгчид хамаарах хөрөнгө гэж үзнэ.
- 2.4. Татварын өр хураах зардал, хөрөнгийн хөрвөх чадвар зэргийг харгалзан битүүмжлэх хөрөнгийг татварын алба тогтоох ба татвар төлөгч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд дор дурдсан нөхцөл байдлыг харгалзан үзнэ:
- 2.4.1.гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүй байх;
- 2.4.2.мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар байх;
- 2.4.3.хадгалах эсхүл хураан авахад хялбар байх.
- 2.5. Татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх, эсхүл битүүмжилсэн хөрөнгөөс татварын өр гаргуулах ажиллагааг бусад татварын албанд шилжүүлэх бол тухайн татвар төлөгчийн харьяалах татварын албаны даргын тушаалаар хэрэгжүүлнэ.
- 2.6. Хөрөнгийг битүүмжлэхэд татварын улсын байцаагч нь битүүмжлэх мэдэгдэх хуудас, тэмдэглэл, битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас зэрэг баримт бичгийг үйлдэнэ.

- 2.7. Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг татварын улсын байцаагч гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд 2-5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг тухайн татварын албаны даргын тушаалаар томилно.
- 2.8. Татварын алба битүүмжлэх ажиллагааг эхлэх талаар мэдэгдлийг өртэй татвар төлөгчид ажлын таван өдрийн өмнө биечлэн эсвэл шуудангаар, цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.9. Татварын алба өртэй татвар төлөгчийн банкн дахь данс /татварын өрийг үл маргах журмаар гаргуулах/-аас бусад хөрөнгийн битүүмжлэлийг дараах байдлаар гүйцэтгэнэ:
- 2.9.1.хөрөнгө битүүмжлэхдээ өртэй татвар төлөгч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, нягтлан бодогч болон хөндлөнгийн гэрчийг байлцуулах;
- 2.9.2.хөрөнгө битүүмжилсэн тухай битүүмжлэх акт үйлдэж, актад өртэй татвар төлөгчийн нэр, хаяг, байршил, татварын өрд хамаарах хугацаа, татварын төрөл, татвар төлөх хуулийн хугацаа болон хэмжээ, битүүмжилсэн хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ, шинж чанар, акт үйлдсэн огноо зэргийг тусгах;
- 2.9.3.битүүмжилсэн хөрөнгийг захиран зарцуулах, хадгалах, хамгаалах, ашиглах нөхцөлийг зааж, татварын албаны мэдэлд авах, шаардлагатай бол лацдах, ломбодох, түгжих зэргээр ашиглуулахгүй байх, эсхүл эзэмшигчид ашиглуулах нөхцөлтэйгөөр хариуцуулан өгөх;
- 2.9.4.энэ журмын 2.9.1-д заасан этгээд нь хөрөнгө битүүмжлэх үйл явцыг нотлох үүрэг хүлээж, битүүмжлэх актад гарын үсэг зурах, татгалзсан тохиолдолд шалтгаанаа дурдсан тайлбарыг актад хавсаргах.
- 2.10.Битүүмжилсэн хөрөнгийг хариуцсан эзэмшигч нь уг хөрөнгийг үрэгдүүлэх, худалдах, бусдад шилжүүлэхгүй байх, бүрэн бүтэн байдлыг хангах, татварын албаны зөвшөөрөлгүйгээр лац, ломбо, түгжээг хөдөлгөхгүй байх үүрэг хүлээх бөгөөд уг үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх талаар татварын улсын байцаагч түүнд танилцуулна.
- 2.11.Татварын алба дор дурдсан хөрөнгийг битүүмжлэх тохиолдолд хөрөнгийг эзэмшигч эрх бүхий этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ:
- 2.11.1.барьцааны эрхтэй ба гуравдагч этгээдийн эрхтэй хөрөнгийн битүүмжлэлийн эрх эзэмшигчид;
- 2.11.2.Иргэний хуулийн 185 дугаар зүйлд заасны дагуу урьдчилан тэмдэглэл хийгдсэн хөрөнгийн битүүмжлэлийг бүртгэлтэй эрх бүхий этгээдэд.
- 2.12.Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйлдсэн баримт бичгийн мэдээллийг битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэснээс хойш ажлын гурван өдөрт багтаан холбогдох

бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

2.13.Татварын алба өртэй татвар төлөгчийн өмчлөл, эзэмшилд байгаа Татварын ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлд зааснаас бусад хөрөнгийг битүүмжилнэ.

2.14.Хойшлуулшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд битүүмжлэх ажиллагааг ажлын цагт багтаан гүйцэтгэнэ.

Гурав. Хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаас битүүмжлэх, бэлэн мөнгө хураах

3.1.Татварын алба хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасыг битүүмжлэхдээ дараах ажиллагааг хэрэгжүүлсэн байна:

3.1.1.хөрөнгийг татварын албаны мэдэлд авч, өртэй татвар төлөгчийн захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах арга хэмжээ авах;

3.1.2.хөрөнгө битүүмжлэх акт үйлдэж, хувийг өртэй татвар төлөгчид хүргүүлэх;

3.1.3.өртэй татвар төлөгчийн гэр бүлийн гишүүн, эсхүл харилцан хамааралтай этгээдээс бусад гуравдагч этгээдийн эзэмшилд байгаа хөрөнгийг битүүмжлэх бол уг хөрөнгийг татварын албанд шилжүүлэх тухай гуравдагч этгээдэд бичгээр мэдэгдэнэ;

3.1.4.хөрөнгө шилжүүлэх үүрэг хүлээн авсан гуравдагч этгээдийн өртэй татвар төлөгчтэй байгуулсан түрээсийн гэрээ, хөрөнгө ашиглах, эсхүл орлого олох гэрээг цуцлах, цуцлахгүйгээр гурван сараар хязгаарлан хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох нөхцөлийн аль нэгийг сонгон хэрэгжүүлж болно;

3.1.5.татварын алба битүүмжилсэн хөрөнгийг өртэй татвар төлөгчид, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гуравдагч этгээдэд ашиглах /орлого олох/ болон ашиглахыг зөвшөөрөхгүйгээр хадгалуулж болно;

3.1.6.татварын алба битүүмжилсэн хөрөнгийг өртэй татвар төлөгчид эсхүл тухайн хөрөнгийг эзэмшигч гуравдагч этгээдэд хадгалуулахгүй тохиолдолд зөөн тээвэрлэж, энэ тухай хөрөнгө битүүмжлэх актад тэмдэглэн гарын үсэг зуруулж, хуулбарыг тухайн хөрөнгийг эзэмшиж буй этгээдэд хүргүүлнэ.

3.2. Өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох үед бэлэн мөнгө илэрсэн үед тэмдэглэл үйлдэж, нэн даруй буюу 24 цагийн дотор тухайн этгээдийн төлөх татварын өрийн хэмжээгээр татварын орлогын дансанд тушааж, тушаасан тухай баримтыг өртэй татвар төлөгчид өгнө.

3.3. Татварын алба үнэт цаасыг битүүмжлэх актыг тухайн үнэт цаасыг бүртгэх, хадгалах, арилжих, төлбөр тооцоог гүйцэтгэх үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд, эсхүл бусад холбогдох байгууллагад битүүмжлэх шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор хүргүүлнэ.

Дөрөв. Авлага битүүмжлэх

- 4.1. Авлагад цалин хөлс, ногдол ашиг, гуравдагч этгээдээс авах авлага буюу мөнгөн хөрөнгөнд шилжүүлэх боломжтой хөрөнгийг нэхэмжлэх эрх, шаардах эрх, адилтгах бусад эх үүсвэр хамаарна.
- 4.2. Татварын өрийн хэмжээнээс хамаарч авлагыг бүрэн эсхүл хэсэгчлэн битүүмжлэх бөгөөд авлагыг битүүмжлэхдээ дараах журмыг баримтална:
 - 4.2.1.авлага битүүмжлэх ажиллагаа нь Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу гуравдагч этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлснээр эхэлсэнд тооцно;
 - 4.2.2.битүүмжлэх хугацаа нь битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлснээс эхлэн татварын өрийг бүрэн хураах хүртэл үргэлжилнэ;
 - 4.2.3.цалин хөлсийг битүүмжлэхдээ Татварын ерөнхий хуулийн 64.6 дахь хэсгийг баримтална;
 - 4.2.4.өртэй татвар төлөгч битүүмжлэлийн хугацаанд татварын өрийг бүрэн төлсөн бол татварын алба ажлын гурван өдрийн дотор гуравдагч этгээдэд авлагын битүүмжлэлийг цуцалсан тухай албан бичгээр болон цахимаар мэдэгдэнэ.
- 4.3. Суутгах үүрэг бүхий гуравдагч этгээд нь битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан төлбөрийн хуваарийн дагуу авлагын суутгал хийж, суутгал хийснээс хойш ажлын гурван өдрийн дотор татварын орлогын дансанд шилжүүлнэ.
- 4.4. Өртэй татвар төлөгч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан болон бусад шалтгаанаар татварын өрийг суутгах боломжгүй болсон бол энэ тухай ажлын долоон өдрийн дотор татварын албанд мэдэгдэнэ.
- 4.5. Авлага битүүмжилсэн хугацаанд Татварын ерөнхий хуулийн 64.7-д заасан үйлдэл хийхийг хориглоно.

Тав.Татварын өрийг үл маргах журмаар гаргуулах

- 5.1. Татварын алба татвар төлөгчийн банканд дахь дансыг битүүмжлэх замаар татварын өрийг гаргуулахдаа дараах журмыг баримтална:
 - 5.1.1.банканд дахь данс гэдэгт татвар төлөгчийн арилжааны банканд нээлгэсэн хадгаламжийн болон харилцах данс хамаарна;
 - 5.1.2.татвар төлөгч татварын өрийг Татварын ерөнхий хуулийн 55.1-д заасан хугацаанд бүрэн төлөөгүй бол төлөөгүй татварын дүнгээр хязгаарлан татвар төлөгчийн банканд дахь данснаас татварын өрийг гаргуулах тухай битүүмжлэх мэдэгдэх хуудсыг банканд хүргүүлнэ;
 - 5.1.3.битүүмжлэх мэдэгдэх хуудсыг батлагдсан загвар, агуулгын дагуу үйлдэж, татвар төлөгчийн банканд дахь харилцах дансны зарлагын гүйлгээг бүрэн

эсхүл хэсэгчлэн зогсоох тухай тусгаж, энэ тухайгаа татвар төлөгчид мэдэгдэнэ;

5.1.4. битүүмжлэх мэдэгдэх хуудсанд битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэж байгаа татварын албаны дарга гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна;

5.1.5. битүүмжлэх мэдэгдэх хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж болно.

5.2. Битүүмжлэх хугацаа нь битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлснээс эхлэн татварын өрийг бүрэн хураах хүртэл хугацаанд үргэлжилнэ.

5.3. Битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан арилжааны банк нь Татварын ерөнхий хуулийн 63.1.3-т заасныг хэрэгжүүлэхдээ хоёр буюу түүнээс олон тооны данснаас татварын өр шилжүүлэх бол ийнхүү шилжүүлсний дараа татвар төлөгчид ногдох хүүгийн орлого хамгийн өндөр байх хувилбарыг сонгоно.

5.4. Татвар төлөгчийн банканд дахь дансны үлдэгдэл нь битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан татварын өрийг бүрэн төлж хүрэлцэхгүй бол татвар төлөгчийн дансыг татварын өрийг бүрэн төлж дуусах хүртэл хугацаанд битүүмжилж, битүүмжилсэн дансанд орлого орсон тухай бүр шилжүүлнэ.

5.5. Банк битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан шаардлагыг бүрэн биелүүлсэн бол татварын албанд мэдэгдэнэ.

5.6. Татварын алба энэ журмын 5.5-д заасан банкны мэдэгдлийг үндэслэн ажлын гурван өдрийн дотор битүүмжлэх мэдэгдэх хуудсыг цуцалсан тухай банканд болон татвар төлөгчид мэдэгдэнэ.

5.7. Татвар төлөгч битүүмжлэлийн хугацаанд татварын өрийг үл маргах журмаас бусад хэлбэрээр төлсөн бол татварын алба татварын өр төлсөн хугацаанаас хойш ажлын гурван өдрийн дотор банканд болон татвар төлөгчид мэдэгдэж, битүүмжлэлийг цуцална.

Зургаа. Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх

6.1. Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэхдээ Татварын ерөнхий хуулийн 65 дугаар зүйл болон энэ журмын 2 дугаар зүйлд заасныг баримтлан хэрэгжүүлнэ.

6.2. Татварын алба үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилснээс хойш ажлын гурван өдөрт багтаан бүртгэх байгууллагад мэдэгдэж, битүүмжлэлийг бүртгүүлнэ.

Долоо. Биет бус хөрөнгө битүүмжлэх

7.1. Биет бус хөрөнгөнд Иргэний хуулийн 84.5-д заасан хөрөнгө хамаарна.

7.2. Биет бус хөрөнгийг битүүмжлэхдээ Татварын ерөнхий хуулийн 66 дугаар зүйл болон энэ журмын 2 дугаар зүйлд заасныг баримтлан хэрэгжүүлнэ.

- 7.3. Татварын алба биет бус хөрөнгийг битүүмжилснээс хойш ажлын гурван өдөрт багтаан холбогдох бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, битүүмжлэлийг бүртгүүлнэ.
- 7.4. Татварын алба гуравдагч этгээдийн ашиглаж байгаа биет бус хөрөнгийг битүүмжлэх тухай бүр гуравдагч этгээдэд битүүмжлэх хуудсыг хүргүүлж хэрэгжүүлнэ.

Найм. Битүүмжилсэн хөрөнгийг хадгалах, хамгаалах

- 8.1. Битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийг өртэй татвар төлөгч, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшигч гуравдагч этгээдэд хадгалуулж болно.
- 8.2. Татварын улсын байцаагчийн битүүмжилсэн, хураан авсан хөдлөх эд хөрөнгийг татвар төлөгч, түүний гэр бүлийн гишүүн, гэрээ байгуулсан бусад этгээдэд, эсхүл татварын албаны тусгай зориулалтын байранд хадгалуулж болно.
- 8.3. Энэ журмын 8.1, 8.2-т заасан этгээд хөрөнгийг хадгалж, түүний бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүрэгтэй бөгөөд татварын албаны зөвшөөрөлгүйгээр ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 8.4. Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийн шинж чанараас хамааран түүнийг ашиглах нь эд хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх, үрэгдүүлэх, гэмтээх эрсдэлтэй бол бусад этгээдэд ашиглуулахыг хориглоно.
- 8.5. Битүүмжлэгдсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор зайлшгүй шаардлагатай тохиолдолд түүнийг хөдөлгөх, зөөж тээвэрлэхэд татварын албанд мэдэгдэнэ.
- 8.6. Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцагч этгээд /цаашид “Хадгалагч” гэх/ нь татвар төлөгчийн, эсхүл түүний гэр бүлийн гишүүн биш бөгөөд бусад гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцах асуудлыг Иргэний хуулийн 422 дугаар зүйлд заасан Хадгалалтын гэрээгээр зохицуулна.
- 8.7. Хадгалагч татварын албаны зөвшөөрөлгүйгээр хадгалуулсан эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн, сольсон, үрэгдүүлсэн, гэмтээсэн, устгасан, нуусан, эд хөрөнгийн хэвийн байдлыг өөрчилсөн бол учирсан хохирлыг бүрэн хариуцна.
- 8.8. Үнэт цаасыг бүртгэх, хадгалах, арилжих, төлбөр төлөх, үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, үнэт цаасны арилжаанд оролцогч бусад этгээд нь битүүмжилсэн үнэт цаасыг татварын албаны зөвшөөрөлгүй худалдан борлуулахгүй. Битүүмжлэх тухай шийдвэрийг хүлээн авмагц хязгаарлагдсан эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой гүйлгээг даруй зогсооно.

Ес. Битүүмжлэлийг цуцлах

- 9.1. Татварын алба дараах тохиолдолд битүүмжлэлийг бүрэн болон хэсэгчлэн цуцална:

- 9.1.1. татвар төлөлт, суутган тооцох, татварын тайлан залруулснаар татварын дүнд өөрчлөлт орох зэргээс хамаарч, эсхүл бусад шалтгаанаар битүүмжлэлд хамаарах татварын өр бүрэн барагдсан;
- 9.1.2. битүүмжилсэн хөрөнгийн үнэ цэнэ нь тухайн битүүмжлэлд хамаарах татварын өр хураах ажиллагааны зардал, битүүмжлэлд хамаарах татвараас давуу эрхтэй авлагын нийлбэр дүнд хүрэхгүй болсон;
- 9.1.3. битүүмжлэлд хамаарах татвар хэсэгчлэн төлөгдсөн, суутган тооцогдсон, залруулсан тайлангаар ногдол буурсан, битүүмжилсэн хөрөнгийн үнэ өссөн болон бусад шалтгаанаас тухайн үнэ нь битүүмжлэлд хамаарах татвар болон бусад авлагын нийлбэрээс 2 дахин их болох;
- 9.1.4. өртэй татвар төлөгч битүүмжлэхэд тохиромжтой өөр хөрөнгөөр сольсон, түүнийг нь битүүмжилсэн.
- 9.2. Битүүмжлэлийг цуцлахдаа өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.
- 9.3. Үл хөдлөх эд хөрөнгө болон бусад хөрөнгийн битүүмжлэлийг цуцлахдаа энэ тухай холбогдох бүртгэх байгууллагад мэдэгдэж хэрэгжүүлнэ.
- 9.4. Татварын алба битүүмжлэлийг цуцалсан тухай энэ журмын 2.11-д заасан этгээдэд мэдэгдэнэ.

--oo00oo--

**ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОН
ШУУД ГЭРЭЭГЭЭР МӨНГӨН ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Татварын ерөнхий хуулийн 68.2-т заасан татварын албаны битүүмжилсэн хөрөнгө, барьцааны зүйлээс Иргэний хуулийн холбогдох заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаа зохион байгуулж, эсхүл шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Дуудлага худалдааг явуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийг баримтална.
- 1.3. Татварын ерөнхий хуулийн 33.1.12-т заасны дагуу дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой мэдээллийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгэнэ.
- 1.4. Татварын алба дуудлага худалдаа зохион байгуулах зардал болон дэнчин байршуулах төрийн сангийн данстай байна.
- 1.5. Энэ журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай акт, маягтын загварыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталж болно.

Хоёр. Хөрөнгө худалдан борлуулах дуудлага худалдааны төрөл

- 2.1. Дуудлага худалдааг хөрөнгийн хэлбэрээс хамаарч дараах төрлөөр зохион байгуулна:
 - 2.1.1. албадан дуудлага худалдаа;
 - 2.1.2. үнэ хаялцуулах дуудлага худалдаа.
- 2.2. Өртэй татвар төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйлс, тусгай зөвшөөрөл зэргийг хууль тогтоомжид заасны дагуу албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулна.
- 2.3. Өртэй татвар төлөгчийн энэ журмын 2.2-т зааснаас бусад хөрөнгийг энэ журмын 2.1.2-т заасны дагуу үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар худалдан борлуулна.
- 2.4. Үнэ хаялцуулах дуудлага худалдааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 64.3-т болон Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу явуулна.
- 2.5. Татвар ерөнхий хуулийн 68.5-д заасан нөхцөлд тухайн хөрөнгийг шууд гэрээгээр мөнгөн хөрөнгөнд шилжүүлнэ.

Гурав. Дуудлага худалдааг зохион байгуулах үйл ажиллагааг хариуцах этгээд

- 3.1. Дуудлага худалдааг зохион байгуулахад татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хамаарах татвар төлөгчийн өрийг барагдуулах бол түүнийг том татвар төлөгч хариуцсан нэгж, бусад татвар төлөгчийн өрийг барагдуулахад аймаг, нийслэлийн татварын газар, хэлтэс нь аймаг, нийслэлийн хэмжээнд тус тус ажлын хэсэг байгуулан ажиллуулна.
- 3.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63.7-д зааснаар үнэт цаасны дуудлага худалдааг тухайн үнэт цаасны төлбөр, тооцоо, бүртгэл хариуцсан байгууллагаар гүйцэтгүүлнэ.
- 3.3. Энэ журмын 3.1-д заасан тухайн татварын албаны дарга дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсэг, дуудлага худалдаа эрхлэн хөтлөгчийг томилно.

Дөрөв. Хөрөнгийн дуудлага худалдааны үнэ тогтоох

- 4.1. Ажлын хэсэг нь хөрөнгийн дуудлага худалдааны үнийг тогтоохдоо Татварын ерөнхий хуулийн 68.3-т заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлд заасныг баримтална.
- 4.2. Анхны болон хоёр дахь дуудлага худалдааны үнийг Иргэний хуулийн 177 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 75.3-т заасны дагуу тогтооно.
- 4.3. Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/-ийг дуудлага худалдаагаар худалдан борлуулахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 65.3-т заасныг баримтална.
- 4.4. Хуульд өөрөөр заагаагүй бол Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу үнэлгээчин хийсэн хөрөнгийн үнэлгээний тайланд үндэслэн дуудлага худалдааны үнийг тогтоож болно.

Тав. Хөрөнгийн дуудлага худалдаа явуулах шийдвэр

- 5.1. Дуудлага худалдаа явуулах хугацааг товлосон шийдвэрийг дуудлага худалдаа явагдахаас 15 хоногийн өмнө гаргах ба дараах мэдээллийг тусгана:
 - 5.1.1. хөрөнгийн нэр, хэмжээ, зориулалт, байршил, анхны үнэ, өмчлөгчийн тухай;
 - 5.1.2. дуудлага худалдааг явуулах он, сар, өдөр, цаг, хаяг;
 - 5.1.3. үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар.
- 5.2. Татварын алба нь энэ журмын 3.1-д заасан ажлын хэсэг дараах бичиг баримтыг хүргүүлнэ:
 - 5.2.1. хөрөнгө битүүмжилсэн тухай битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас, битүүмжлэх мэдэгдэх хуудас;
 - 5.2.1. хөрөнгө барьцаалсан тухай барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ;

- 5.2.3.хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт, улсын бүртгэлийн холбогдох баримт бичгийн хуулбар;
 - 5.2.4.тухайн хөрөнгийн ашиглах, эзэмших гэрчилгээний хуулбар;
 - 5.2.5.үл хөдлөх эд хөрөнгө байрлаж байгаа газрыг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн бичиг баримт.
- 5.3. Дуусаагүй барилга байшин, дэд бүтцийн объектыг албадан дуудлага худалдаагаар борлуулах бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 69.2-т заасан бичиг баримтаас гадна тухайн барилга байшин, дэд бүтцийн объектыг барих тусгай зөвшөөрлийн нотлох баримтын шаардлага хангасан хуулбарыг дуудлага худалдааг эрхлэн хөтлөх этгээдэд хүргүүлнэ.
- 5.4. Ажлын хэсэг нь энэ журмын 5.2, 5.3-т заасан бичиг баримтыг хүлээн авч дуудлага худалдаа зохион байгуулах шийдвэр гаргана. Шийдвэрийг бүртгэх байгууллага болон өртэй татвар төлөгчид хүргүүлнэ.

Зургаа. Дуудлага худалдааг хойшлуулах, түдгэлзүүлэх

- 6.1. Татвар төлөгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63.1-д заасны дагуу өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах санал гаргасан тохиолдолд албадан дуудлага худалдааг 3 сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно.
- 6.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 64.5-д зааснаас бусад хөрөнгийн үнэлгээг тогтоож, татвар төлөгч уг хөрөнгийг бие даан худалдан борлуулах санал гаргасан тохиолдолд бол дуудлага худалдааг 2 сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно.
- 6.3. Дуудлага худалдааг дараах үндэслэл, хугацаагаар түдгэлзүүлнэ:
- 6.3.1.хөрөнгийн анхны үнэлгээний талаар шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн эцсийн шийдвэр гартал;
 - 6.3.2.татвар төлөгч иргэн нас барсанд тооцсон, сураггүй алга болсон, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчийг, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй иргэнд асран хамгаалагчийг тогтоох хүртэл;
 - 6.3.3.татвар төлөгч иргэн, эсхүл хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгчийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл.

Долоо. Дуудлага худалдаа явуулах хугацаа

- 7.1. Дуудлага худалдааг ажлын хэсгийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор явуулна.

- 7.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 64.5-д зааснаас бусад хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн үнэлгээ тогтоосноос хойш 2 сарын дотор худалдан борлуулна.
- 7.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63.1-д заасны дагуу татвар төлөгч өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах тухай саналыг татварын алба хүлээн авсан тохиолдолд 3 сарын дотор албадан худалдан борлуулах ажиллагааг явуулна.

Найм. Дуудлага худалдааг нийтэд мэдээлэх, дуудлага худалдааны оролцогч, дуудлага худалдаанд оролцох дэнчин

- 8.1. Дуудлага худалдаа явуулах хэлбэрээс хамаарч дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 70.1, Иргэний хуулийн 197.13-т заасан хугацаанд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр энэ тухай нийтэд мэдээлнэ.
- 8.2. Дэнчин төлж бүртгүүлсэн этгээд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дуудлага худалдаанд оролцоно.
- 8.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 70.3-т заасан дуудлага худалдаанд зөвхөн Монгол Улсын иргэн оролцоно.
- 8.4. Дуудлага худалдаанд дараах этгээд шууд болон шууд бус байдлаар оролцохыг хориглоно:
 - 8.4.1. хөрөнгийг өмчлөгч, эзэмшигч татвар төлөгч этгээд;
 - 8.4.2. татварын албаны татварын улсын байцаагч, ажилтан, албан хаагч.
- 8.5. Анхны болон хоёр дахь дуудлага худалдаанд оролцогч нь хөрөнгийн тогтоосон үнийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дэнчинг дуудлага худалдаа эхлэхээс 24 цагийн өмнө татварын албаны төрийн сан дахь дансанд байршуулна.

Ес. Дуудлага худалдааг зохион байгуулах

- 9.1. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах тухай шийдвэр, төлбөрийн хэмжээ, хөрөнгийн талаар танилцуулга, түүнийг битүүмжилсэн, барьцаалсан он, сар, өдөр, үнийг танилцуулна.
- 9.2. Анхны үнийн санал гарснаар дуудлага худалдааг эхэлсэнд тооцно.
- 9.3. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь хөрөнгийн үнийг өсгөн дуудах үнийн доод хэмжээг тогтоож, тэмдэглэл үйлдэнэ.
- 9.4. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь сүүлийн үнэ хэлэхийг зарлаж, гурван удаа дуудсаны дараа дуудлага худалдааг дуусгавар болгож ялагчийг зарлана.
- 9.5. Үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааг зогсоох, түр хойшлуулах, хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулахдаа Иргэний хуулийн 176, 177 дугаар зүйлийг баримтална.

- 9.6. Дуудлага худалдаагаар борлогдсон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэх нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71.10-г заасан хугацаанаас хэтрэхгүй байна.
- 9.7. Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг нь дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын гурав хоногийн дотор ялагчийн овог, нэр, дуудлага худалдаагаар худалдан авсан хөрөнгийн үнийг бүрэн төлсөн болон, өмчлөх эрх үүсэх, өртэй татвар төлөгч эд хөрөнгө чөлөөлөх хугацааг заасан шийдвэр гаргана.

Арав. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах, хөрөнгийн эрх шилжүүлэх

- 10.1. Ажлын хэсэг дуудлага худалдааны явцад тэмдэглэл үйлдэх бөгөөд уг тэмдэглэлд оролцогчид болон ажлын хэсгийн дарга гарын үсэг зурснаар дуудлага худалдааг хүчин төгөлдөр явагдсанд тооцно.
- 10.2. Дуудлага худалдааны ялагч нь тэмдэглэл болон гэрээнд гарын үсэг зурахаас зайлсхийсэн тохиолдолд дэнчингээ алдана.
- 10.3. Ажлын хэсгээс гаргасан шийдвэрийг үндэслэн харьяалах татварын албаны дарга, дуудлага худалдааны ялагчтай хөрөнгийн “Эрх шилжүүлэх гэрээ”-г байгуулна.
- 10.4. Эрх шилжүүлэх гэрээг байгуулахдаа дэнчинг гэрээний үүргийн гүйцэтгэлд оруулж тооцно.
- 10.5. Хөрөнгийн төлбөр хийгдсэний дараа дуудлага худалдааны ялагч нь татварын албанд хөрөнгийн битүүмжлэлийг цуцлах хүсэлтийг ирүүлэх бөгөөд татварын алба нь уг хүсэлтийг үндэслэн хөрөнгийн битүүмжлэлийг цуцлах тухай шийдвэр гаргаж, битүүмжлэлийг бүртгэсэн байгууллагад хүргүүлэн, холбогдох бүртгэлээс хасуулна.
- 10.6. Татварын алба нь тухайн хөрөнгийн бүртгэлийг хийх эрх бүхий байгууллагад дуудлага худалдааны ялагчийн нэр дээр хөрөнгийн эрхийг шилжүүлэх холбогдох материалыг албан бичгээр хүргүүлнэ.

Арван нэг. Хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулах

- 11.1. Дараах тохиолдолд хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулна:
- 11.1.1. дуудлага худалдаанд нэг оролцогч ирсэн;
 - 11.1.2. дуудлага худалдаанд оролцогчид үнийн санал гаргаагүй;
 - 11.1.3. дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан хөрөнгийн үнийг энэ журамд заасан хугацаанд бүрэн төлөөгүй бол дуудлага худалдааны үед анхны санал болгосон үнээс илүү санал гаргасан дараагийн этгээдэд санал болгож татгалзсан тохиолдол.
- 11.2. Хоёр дахь дуудлага худалдааг явуулах шийдвэрийг тухайн татварын албаны дарга гаргах бөгөөд хоёр дахь дуудлага худалдааг Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.3-т заасан хугацаанд нийтэд мэдээлж, зохион байгуулна.

- 11.3. Хоёр дахь дуудлага худалдаанд орж байгаа хөрөнгийн үнийг харилцан тохиролцож тогтоосон, эсхүл үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 50 хувиар тооцон тогтооно.
- 11.4. Үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар борлогдоогүй хөдлөх эд хөрөнгийн үнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4-т заасныг баримтлан тогтооно.
- 11.5. Энэ журмын дагуу дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй хөрөнгийг шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлнэ.

Арван хоёр. Дуудлага худалдааны орлого хуваарилах

- 12.1. Татварын албадан болон үнэ хаялцуулах дуудлага худалдаа болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг Татварын ерөнхий хуулийн 56.3-т заасныг баримтлан мөн хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу хуваарилна.

Арван гурав. Шууд гэрээгээр хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх

- 13.1. Шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг Татварын ерөнхий хуулийн 68.5-д заасан нөхцөлд татварын албаны даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг энэхүү журамд нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 13.2. Удаан хадгалахад чанар нь муудах түүхий эдийг уг түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг этгээдтэй шууд гэрээ хийж, борлуулж болно.
- 13.3. Шууд гэрээгээр борлуулах хөрөнгийн мэдээллийг ажлын 7 өдрийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар нийтэд зарлаж, энэ тухайгаа өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ. Хүнсний бүтээгдэхүүнээс бусад түргэн муудаж, гэмтэх хөрөнгийн шууд гэрээгээр борлуулах тухай мэдээллийг тухай бүр нь нийтэд зарлаж, өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.
- 13.4. Ажлын хэсэг нь шууд гэрээгээр борлуулах хөрөнгийн үнийг энэ журмын 4.1-д заасныг жишиг болгон тогтоож, татварын албаны даргаар батлуулна.
- 13.5. Шууд гэрээгээр хөрөнгө борлуулахад хоёр ба түүнээс дээш этгээд худалдан авах хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлт гаргасан этгээдээс “Үнийн санал авах хуудас”-ыг нууцлалын шаардлага хангуулан бөглүүлэн авч, хамгийн өндөр үнийн санал өгсөн этгээдтэй гэрээг байгуулна.
- 13.6. Хөрөнгийн биржид бүртгэлтэй хөрөнгийг тухайн өдрийн зах зээлийн үнээр борлуулах бүрэн боломжтой тохиолдолд шууд гэрээгээр борлуулж болно.
- 13.7. Татварын албаны дарга шууд гэрээгээр худалдан авагчтай хөрөнгийг “Худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулна.
- 13.8. Хөрөнгийг шууд гэрээгээр худалдан борлогдоогүй тохиолдолд татвар төлөгчид хөрөнгийг буцаан олгоно.

13.9. Шууд гэрээгээр худалдан авагч нь гэрээний үнийг гэрээнд заасан хугацаанд багтаан төлөх бөгөөд төлөөгүй бол татварын алба худалдах шийдвэрийг цуцална.

--oo00oo--

Татварын ерөнхий газрын даргын
... оны ... сарын ... өдрийн ... дугаар
тушаалын ... дүгээр хавсралт

ТАТВАРЫН ӨР ТӨЛӨХ ХУГАЦААГ ХӨНГӨЛӨХ ЖУРАМ

1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

- 1.1. Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлд заасан татварын өр төлөх хугацааны хөнгөлөлттэй /цаашид “хугацааны хөнгөлөлт” гэх/ холбоотой харилцааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.
- 1.2. Хугацааны хөнгөлөлт үзүүлэхдээ дараах зарчмыг баримтална:
 - 1.2.1. татвар төлөгчийн татварын өрийн дүн нь 10.0 сая төгрөгөөс доош, эсхүл хөнгөлөх хугацаа нь 3 сар хүртэлх татварын өрд барьцаа хөрөнгө шаардахгүй;
 - 1.2.2. энэ журмын 1.2.1-д зааснаас бусад тохиолдолд алдангийн хэмжээг оруулсан дүнгээс багагүй хэмжээний барьцаа хөрөнгийг шаардана;
 - 1.2.3. Татварын ерөнхий хуулийн 53.3.2, 53.3.3, 53.3.4-т заасныг хэрэгжүүлнэ.
- 1.3. Хугацааны хөнгөлөлт үргэлжлэх хугацааг тогтоохдоо татвар төлөгчийн хөрөнгийг үнэлж татварын өрийг бүрэн барагдуулах Татварын ерөнхий хуулийн 53.1, 53.2 дахь хэсэгт заасан хамгийн бага хугацаагаар тогтооно.

2 дугаар зүйл. Хугацааны хөнгөлөлт үзүүлэх нөхцөл

- 2.1. Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1, 53.1.2, 53.1.3, 53.1.4-т заасан хүндэтгэн үзэх нөхцөл үүсч татварын өрийг төлөх боломжгүй болох нь тогтоогдсон бол татвар төлөгч хүсэлтийг бичгээр татварын албанд гаргана. Бичгээр гаргасан хүсэлтэд татварын өрийн хэмжээтэй дүйцэх барьцаа хөрөнгө, эсхүл батлан даагчийн гэрээг хавсаргана.
- 2.2. Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.3-т заасан “татвар төлөгч эрхэлж буй үйл ажиллагаагаа зогсоосон” гэдгийг Компанийн тухай хуулийн 19, 20, 21 дүгээр зүйлд заасныг ойлгоно.
- 2.3. Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.4-т заасныг татвар төлөгчийн үйл ажиллагаанд гурван жил дараалан их хэмжээний алдагдал хүлээсэн, төлбөрийн чадвар муудаж татварын өрийг хуульд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах боломжгүй нөхцөл үүссэнийг хэлнэ.

3 дугаар зүйл. Татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдлэх хүсэлт гаргах

- 3.1. Татвар төлөгч нь энэ журмын 2.1-д заасан хугацааны хөнгөлөлт эдлэх тухайгаа “Татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдлэх хүсэлт /ТТ-01/ маягт”-аар харьяалагдах татварын албанд гаргана.
- 3.2. Татвар төлөгчийн гаргасан хүсэлтэд хугацааны хөнгөлөлт эдлэх нөхцөл байдлыг нотлоход дор дурдсан бичиг, баримтыг хавсаргана:
 - 3.2.1.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу хохирол учирсан болохыг нотолсон акт;
 - 3.2.2.татвар төлөгч хувь хүний эмчилгээ хийлгэсэн магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн магадалгаа, эмчилгээний зардлын баримт;
 - 3.2.3.татвар төлөгчийн үйл ажиллагааг зогсоосон тухай шийдвэр, бүртгэх байгууллагын тодорхойлолт, бусад холбогдох баримт бичиг;
 - 3.2.4.тухайн татварын жилийн өмнөх дараалсан 3 жилийн санхүүгийн болон татварын тайлан;
 - 3.2.5.хөрөнгийн жагсаалт, татвар төлөгчийн төлбөрийн чадварыг харуулсан тооцоо, тодорхойлолт;
 - 3.2.6.үл хөдлөх эд хөрөнгө нь дундын өмчлөл байгаа тохиолдолд бусад өмчлөгчийн нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрөл;
 - 3.2.7.хөнгөлөлтийн хугацаанд татварын өр төлөх хуваарь;
- 3.3. Татвар төлөгч нь Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.3.1-д заасны дагуу барьцаа хөрөнгө шаардлагатай болон мөн хуулийн 53.3.3-т заасны дагуу бусад этгээдийн батлан даалт ашиглах бол хугацааны хөнгөлөлт эдлэх хүсэлт, түүнийг нотолсон дараах баримтуудын аль нэгийг хавсаргана:
 - 3.3.1.барьцааны гэрээ, барьцааны зүйлийн тодорхойлолт, чанар, үнэ, хаяг байршилтай холбоотой бичиг, баримт болон хөрөнгийн даатгалын гэрээ;
 - 3.3.2.батлан даагчийн батлан даалтын гэрээ;
 - 3.3.3.гуравдагч этгээдийн эзэмшлийн хөрөнгийг барьцаалах бол тухайн гуравдагч этгээдийн зөвшөөрлийг тусгасан барьцааны гэрээ;
 - 3.3.4.аж ахуйн нэгжийн өмчлөлийн хөрөнгийг барьцаалах бол хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг тусгасан бичиг баримт;
 - 3.3.5.хөрөнгийн үнэлгээний тайлан.
- 3.4. Татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг ирүүлсэн баримтын хамт хянан үзэж үндэслэлтэй бол татварын өр төлөх хугацааны хөнгөлөлтийг тухайн татварын албаны даргын шийдвэрээр үзүүлж болно.

4 дүгээр зүйл.Хугацааны хөнгөлөлт эдлэх хүсэлтийг хүлээж авах, зөвшөөрөх, хэрэгжүүлэх

- 4.1. Татвар төлөгчөөс хугацааны хөнгөлөлт эдлэхээр ирүүлсэн хүсэлтийг ажлын 10 хоногийн дотор энэ журмын 3.2, 3.3-т заасан баримт бичгийн бүрдлийг нягталж,

- зөвшөөрөх, эс зөвшөөрөх шийдвэрийг харьяалах татварын албаны даргын томилсон татварын улсын байцаагч бичгэн хэлбэрээр гаргана.
- 4.2. Татвар төлөгчөөс гаргасан хүсэлтийн агуулга бүрэн бус, хавсаргасан бичиг баримтын бүрдэл дутуугаас зохих шийдвэр гаргахад хүндрэлтэй бол татвар төлөгчөөр дахин хүсэлт гаргуулна.
- 4.3. Татварын улсын байцаагч энэ журмын 4.1-д заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг дараах байдлаар нягтална:
- 4.3.1.хөнгөлөлт эдлэх үндэслэл байгаа эсэхийг тогтоох;
- 4.3.2.гамшигтай холбоотойгоор гаргасан зардал, эсхүл хүлээсэн хохирол болон санхүүгийн тайлангийн алдагдлын хэмжээ үнэн зөв эсэхийг нягтлах;
- 4.3.3.татвар төлөгчийн хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, татварын өрийг төлөхтэй холбоотой нөхцөлийг тодорхойлох;
- 4.3.4.татвар төлөгчийн хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, өр, төлбөр, аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр, орлого, зардал, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйл, цахим төлбөрийн баримтыг нягтлах;
- 4.3.5.Хугацааны хөнгөлөлт эдлэх хүсэлт ирүүлсэн татвар төлөгчийн одоогийн болон ирээдүйд бий болох төлбөрийн чадвар, эсхүл хөнгөлөлт эдэлсний дараах санхүүгийн байдал, хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өрийн хэмжээ, хөнгөлөлтийн хугацаанд татварын өрийг хуваан төлөх хэмжээ, хугацааны хөнгөлөлтийг тооцоолох болон хугацааны хөнгөлөлтийг цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх зорилгоор татварын албанаас тухайн үеийн төлбөрийн чадварын судалгааг хийх.
- 4.4. Энэ журмын 4.1-д заасан шийдвэрийг үндэслэн татварын албаны дарга өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлэх хугацаа болон татварын өр төлөх хуваарийг баталсан шийдвэр гарган татвар төлөгч, барьцааны хөрөнгийг эзэмшигч, батлан даагч болон холбогдох бусад этгээдэд хүргүүлнэ.
- 4.5. Татварын өр төлөх хугацааг Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.2-т заасан жилээр хязгаарлах ба татвар төлөгчийн төлбөрийн чадвар болон бусад нөхцөл байдлыг харгалзан, хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өрийг бүрэн барагдуулах боломжтой гэж үзсэн хамгийн богино хугацаагаар тогтооно.
- 4.6. Татвар төлөгч хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өрийн дүнг өөрчлөх, эсхүл өмнө нь хөнгөлөлт эдэлж буй татварын өрд нэгтгэн тооцох, хугацааны хөнгөлөлтөд хамруулж болно.
- 4.7. Татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.3.1, 53.3.3-т заасан хөрөнгө барьцаалах болон батлан дахтай холбоотой асуудлыг Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг баримтлан хэрэгжүүлнэ.

- 4.8. Хугацааны хөнгөлөлтийн барьцааг аль болох мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар, үнийн хэлбэлзэл бага байх хөрөнгөөс эхлэн барьцаална. Барьцааны зүйл нь татварын өрийг бүрэн барагдуулах, мөн барьцааг борлуулахад шаардагдах зардалд хангалттай хүрэлцэхүйц үнэ цэнэтэй байвал зохино.
- 4.9. Дараах тохиолдолд хөрөнгө барьцаалах, батлан даалт ашиглах талаарх татвар төлөгчийн саналыг хүлээж авахгүй:
- 4.9.1.барьцаалах хөрөнгийн үнийн санал нь татварын өрийг барагдуулах болон хөрөнгө барьцаалахтай холбогдон гарч болох зардлуудыг нөхөхөд хүрэлцэхгүй байх;
- 4.9.2.хөрөнгийг барьцаанд авснаар татвар төлөгч бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах, эсхүл амьжиргааны нэн тэргүүний хэрэгцээг хангахад нь саад учруулахаар байх;
- 4.9.3.барьцаалах хөрөнгө болон батлан даагчийн хөрөнгө нь хугацааны хөнгөлөлт эдлэх хугацаанд эрх бүхий байгууллагад албан журмын даатгалд даатгалгүй байх.
- 4.10. Барьцааг доорх нөхцөлийн аль нэгд хамаарах тохиолдолд цуцална:
- 4.10.1.хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өрийг бүхэлд нь барагдуулсан;
- 4.10.2.барьцааны зүйлийг өөрчлөн өөр хөрөнгө барьцаалсан;
- 4.10.3.хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өр нь бусад төрлийн татварын илүү төлөлтөөр суутган тооцогдсон.
- 4.11. Барьцаа зүйлийг шаардлагатай тохиолдолд татварын өр хураах үйл ажиллагааны дагуу битүүмжилнэ. Тухайн хөрөнгө гуравдагч этгээдэд хамаарах бол өртэй татвар төлөгчийн нэгэн адил өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 4.12. Энэ журмын 3.1-д заасны дагуу татвар төлөгчийн гаргасан хүсэлт нь Татварын ерөнхий хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмын шаардлагад нийцээгүй бол харьяалах татварын алба хугацааны хөнгөлөлт үзүүлэхгүй.

5 дугаар зүйл.Хугацааны хөнгөлөлтийг цуцлах

- 5.1. Хугацааны хөнгөлөлтийг хэрэгжүүлэх явцад өр төлөгдөхгүй байх нөхцөл үүссэн үед харьяалах татварын албаны даргын шийдвэрээр хугацааны хөнгөлөлтийг цуцалж, татвар төлөх хуваарьт өөрчлөлт оруулж болно:
- 5.1.1.татвар төлөгчийн болон батлан даагчийн төлбөрийн чадвар муудаж, татварын өрийг хугацааны хөнгөлөлт дуусахаас өмнө урьдчилж төлүүлэх нөхцөл үүссэн;
- 5.1.2.татвар төлөгч татварын өрийг хуваарийн дагуу төлөөгүй;
- 5.1.3.татвар төлөгчөөс барьцаалсан болон батлан даагчийн батлан даалтад ашигласан хөрөнгийн үнэ татварын өрийг төлөхөд хүрэлцэхгүй болж

буурсан үед татварын албанаас барьцаа хөрөнгө нэмэх, өөрчлөх талаар татвар төлөгчид хүргүүлсэн мэдэгдлийг биелүүлээгүй, барьцааны зүйлийг өөрчлөхийг зөвшөөрөөгүй;

5.1.4. хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өрөөс гадна шинээр өр үүссэн;

5.1.5. хугацааны хөнгөлөлт, түүнийг сунгах хүсэлт, эсхүл хавсралт бичиг баримтад дараах мэдээллийг үнэн зөв тусгаагүй нь тогтоогдсон:

5.1.5.1. хөнгөлөлтөд хамрагдах шалтгаан нөхцөл үүсээгүй байхад хүсэлт гаргах;

5.1.5.2. хөрөнгөө санаатайгаар бичихгүй, эсхүл байхгүй зүйлийг байгаа мэтээр бичих;

5.1.5.3. орлого, зардлаа бодит байдлаас бууруулах, өсгөх.

5.1.6. хугацааны хөнгөлөлтөд хамаарч буй татварын өрөө татвар төлөгч бүрэн төлсөн байх;

5.1.7. Татварын ерөнхий хуулийн 54.1.1, 54.1.2, 54.1.3, 54.1.4-т заасан заасан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд хугацааны хөнгөлөлтийг цуцалж, барьцааны зүйлээс татварын өрийг гаргуулна.

5.2. Энэ журмын 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5-д заасан нөхцөл байдал үүсэж, хугацааны хөнгөлөлт цуцлах талаар татвар төлөгчид ажлын 3 өдрийн дотор мэдэгдсэнээс хойш 10 хоногийн дотор тайлбар гаргаагүй бол харьяалах татварын албаны даргын шийдвэрээр хугацааны хөнгөлөлтийг цуцална.

5.3. Хугацааны хөнгөлөлтийг цуцалсан талаар татварын албаны даргын шийдвэрийг өртэй татвар төлөгч, батлан даагч, татвар төлөх үүрэг бүхий хоёрдогч этгээдэд ажлын 10 өдрийн дотор мэдэгдэнэ.

5.4. Татвар төлөгчийн гаргасан тайлбарыг татварын алба хүлээн авах үндэслэлтэй гэж үзвэл хөнгөлөлтийн хугацааг өөрчлөх талаар татвар төлөгчтэй зөвшилцөн, харьяалах татварын албаны дарга шийдвэр гарган энэ тухайгаа ажлын 3 өдрийн дотор татвар төлөгчид мэдэгдэнэ.

6 дугаар зүйл. Хугацааны хөнгөлөлтийг сунгах болон татварын өр төлөх хуваарийг өөрчлөх

6.1. Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.2-т заасны дагуу татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн харьяалах татварын алба татвар төлөх хугацааг сунгаж болно. Татвар төлөгч “Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийг сунгах хүсэлт /Маягт ТТ-02/”-ийг татварын албанд ирүүлнэ.

6.2. Хугацааны хөнгөлөлтийг сунгах хүсэлтэд хүндэтгэн үзэх нөхцөл байдлыг нотолсон бичиг баримт, татварын өр төлөх хуваарьт өөрчлөлт оруулах саналыг хавсаргасан байна.

- 6.3. Татвар төлөгчөөс энэ журмын 6.1-д заасны дагуу гаргасан хүсэлтийг татварын алба шалган хугацааны хөнгөлөлтийн хугацааг сунгах болон татварын өр төлөх хуваарьт өөрчлөлт оруулах шийдвэр гаргана.
- 6.4. Татварын өр төлөх хуваарьт өөрчлөлт оруулахдаа татвар төлөгчийн хөрөнгийн байдал болон төлбөрийн чадвараас хамаарч татварын алба татварын өрийг төлөх хугацаа, төлөх татварын хэмжээг тогтооно.
- 6.5. Татварын алба энэ журмын 6.1-д заасан сунгах хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан тухай шийдвэрийг татвар төлөгчид мэдэгдэнэ.

2.Эмчилгээний зардлын мэдээлэл
/сая төгрөг/

Эмчилгээ хийлгэсэн татвар төлөгчийн овог, нэр	Эмчилгээ хийлгэсэн улс, эмнэлгийн нэр, хаяг	Өвчний онош, уг оношлоог хийсэн эмчийн овог, нэр, эмнэлгийн нэр, хаяг	Хийлгэсэн эмчилгээ	Эмчилгээний зардал
Хугацааны хөнгөлөлтөд хамруулах дүн				

3. Татвар төлөгч эрхэлж буй үйл ажиллагаагаа зогсоосон мэдээлэл

Үйл ажиллагааг			Тэмдэглэл
Зогсоосон байдал	Зогсоох үндэслэл	Зогсоох шийдвэр гаргасан этгээдийн нэр, хаяг, шийдвэрийн огноо, дугаар	
бүхэлд нь	хэсэгчлэн		

4. Татвар төлөгчийн үйл ажиллагааны алдагдлын мэдээлэл
/сая төгрөг/

Он	Алдагдлын хэмжээ			
	Санхүүгийн тайлангаар	Татварын тайлангаар		
ДҮН				
Хугацааны хөнгөлөлтөд хамруулах дүн				

Г. Татвар төлөх хугацааны хөнгөлөлтөд хамруулах хөрөнгийн дүн, хөнгөлөлтийг эхлүүлэх огноо болон татварын өр төлөх хуваарийн санал

Хугацааны хөнгөлөлт эхлүүлэх	Огноо	Төлбөр хийх хуваарь				
	Үндэслэл огноо огноо огноо огноо огноо
Хугацааны хөнгөлөлтөд хамруулах өрийн хэмжээ, төгрөгөөр			... төгрөг	... төгрөг	... төгрөг	... төгрөг	... төгрөг

Д. Барьцаалах хөрөнгийн мэдээлэл

Барьцаанд тавих хөрөнгийн					
Нэр төрөл	үнэлгээ	Байршил, хаяг	Эзэмшигчийн нэр, хаяг	Даатгалын гэрээний огноо, дугаар	тэмдэглэл

Е. Хавсаргасан бичиг баримтын жагсаалт

1.
2.

Хүсэлт гаргасан:

Дарга /Захирал/: /
Ерөнхий /ахлах/ нягтлан бодогч: /
Татварын итгэмжлэгдсэн зөвлөх: /
Огноо

Татварын албаны тэмдэглэл

Хүсэлтийг хүлээж авсан			Тэмдэглэл
Татварын албаны нэр	Албан тушаалтны овог, нэр	огноо	



Татварын ерөнхий газрын даргын
... оны ... сарын ... өдрийн ... дугаар
тушаалын ... дүгээр хавсралт

Монголын Татварын Алба Маягт

**ТАТВАР ТӨЛӨХ ХУГАЦААНЫ ХӨНГӨЛӨЛТИЙГ
СУНГАХ ХҮСЭЛТ**

..... татварын албанд

А. Татвар төлөгчийн талаарх мэдээлэл

1. ТТД:
2. Нэр: _____
3. Татвар төлөгчийн одоогийн хаяг:
Аймаг, хот: _____ Утас: _____
Сум, дүүрэг: _____ Факс: _____
Баг, хороо: _____ Шуудангийн хайрцаг: _____
Гудамж, хороолол: _____ Цахим хаяг: _____
Байшин: _____ Хашаа хаалга: _____
Эрхлэх үндсэн үйл ажиллагаа: _____

**Б. Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийн сунгалтад хамруулах татварын өрийн мэдээлэл
/саятөгрөг/**

Татварын төрөл	Өмнөх хөнгөлөлт өд хамрагдсан дүн	Өмнөх хөнгөлөлтийн хугацаанд төлөөгүй үлдсэн татварын өрийн дүн	Үүнээс				Тэмдэглэл
			татвар	торгууль	алданги	хүү	
Нийт дүн							
Дээрх дүнгээс хугацааны хөнгөлөлтийн сунгалтад хамруулах дүн							
Өмнөх хөнгөлөлтийн хугацаанд өрөө төлж чадахгүй болсон шалтгаан							

В. Татвар төлөх хугацааны сунгалтад хамруулах татварын өрийн дүн, хөнгөлөлтийг эхлүүлэх огноо болон татварын өр төлөх хуваарийн санал

Хугацааны хөнгөлөлтийн сунгалтыг эхлүүлэх	Огноо	Төлбөр хийх хуваарь				
	Үндэслэл огноо огноо огноо огноо огноо
Хугацааны хөнгөлөлтийн сунгалтад хамруулах өрийн хэмжээ, төгрөгөөр			... төгрөг	... төгрөг	... төгрөг	... төгрөг	... төгрөг

Г.Барьцаалах хөрөнгийн мэдээлэл

Барьцаанд тавих хөрөнгийн					Тэмдэглэл
Нэр төрөл	үнэлгээ	Байршил, хаяг	Эзэмшигчийн нэр, хаяг	Даатгалын гэрээний огноо, дугаар	

Д. Хавсаргасан бичиг баримтын жагсаалт

1.
2.

Хүсэлт гаргасан:

Дарга /Захирал/:/

Ерөнхий /ахлах/ нягтлан бодогч: /

Татварын итгэмжлэгдсэн зөвлөх:/

Татварын албаны тэмдэглэл

Хүсэлтийг хүлээж авсан			Тэмдэглэл
Татварын албаны нэр	Албан тушаалтны овог, нэр	огноо	

Татварын ерөнхий газрын даргын
... оны ... сарын ... өдрийн ... дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ТАТВАРЫН ӨРИЙГ ТАТВАР ТӨЛӨХ ҮҮРЭГТЭЙ ХОЁРДОГЧ ЭТГЭЭДЭЭС ГАРГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1. Өртэй татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг хураахад уг хөрөнгө хүрэлцэхгүй бол Татварын ерөнхий хуулийн 57 дугаар зүйлд заасан татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өр /цаашид “хоёрдогч этгээд” гэх/ хураан барагдуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2 дугаар зүйл. Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийг тогтоох

- 2.1. Татварын улсын байцаагч татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг Татварын ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу тогтооно.
- 2.2. Татварын улсын байцаагч энэ журмын 2.1-д заасан ажиллагааг явуулахад өртэй татвар төлөгчийн хөрөнгө татварын өрийг төлөхөд хүрэлцэхгүй гэдгийг тогтоосон бол Татварын ерөнхий хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасан татварын өр үүссэн хугацаанаас нэг жилийн өмнөх өдрөөс хойших хугацаанд тухайн өртэй татвар төлөгч хөрөнгөө үнэгүй, эсхүл хэт бага үнээр бусдад шилжүүлсэн эсэх, бусдаас авах авлагаа хүчингүй болгож бусад этгээдэд ашигтай байдлыг бий болгосон эсэхийг шалгаж тогтооно.
- 2.3. Энэ журмын 2.2-т заасан нөхцөл байдал тогтоогдвол тухайн этгээд татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд болно.
- 2.4. Хоёрдогч этгээдийг тогтоохдоо дараах зарчим баримтална:
 - 2.4.1. хөрөнгө бэлэглэх, авлага шилжүүлэх, хөрөнгө оруулах, хөрөнгө орлуулан төлөх зэрэг үнэгүй шилжүүлсэн эсэх;
 - 2.4.2. Иргэний хуулийн 239 дүгээр зүйлд заасны дагуу авлага хүчингүй болгосон эсэх;
 - 2.4.3. зах зээлийн ханш тодорхой үнэт цаас зэрэг хөрөнгийн тухайд үнэ нь зах зээлийн үнээс бага байгаа бол хэт бага үнэ гэж үзэх;
 - 2.4.4. бусад хөрөнгийн тухайд Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д заасан жишиг үнийн аргаар тодорхойлсон үнээс бага дүнтэй бол хэт бага үнэ гэж үзэх.

- 2.5. Бусад татварын албаны өмнө татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд тухайн өртэй татвар төлөгчийн татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд бол тус үүргийг давхардуулан хүлээлгэж болно.

3 дугаар зүйл.Хоёрдогч этгээдийн төлөх татварын хэмжээг тодорхойлох

- 3.1. Хоёрдогч этгээдийн төлөх татварыг өртэй татвар төлөгчийн татварын нийт өрөөс хоёрдогч этгээдийн хариуцах татварын өрийн хэмжээгээр тодорхойлно:
- 3.1.1.өртэй татвар төлөгч хөрөнгөө үнэгүй шилжүүлсэн бол шилжүүлж авсан хөрөнгө, эрхийн үнийн дүнгээр;
- 3.1.2.энэ журмын 3.2-г заасан хөрөнгийг шилжүүлж авсан хөрөнгийн үнэ өөрчлөгдөөгүй тохиолдолд уг хөрөнгөөс бий болсон үр шимийг энэ журмын 3.1.1-д заасан үнийн дүнд нэмж тооцохгүй;
- 3.1.3.шилжүүлж авсан хөрөнгийн үнэ нэмэгдсэн бол тухайн үнийг нэмэгдүүлэхэд гарсан зардлыг хасна;
- 3.1.4.шилжүүлсэн хөрөнгө нь газар дээрх хөрөнгийг өмчлөх зорилгоор газар ашиглах, бусдын газрыг тусгай зориулалтаар ашиглах, түрээслэх, ипотекийн эрх бий болсон бол хөрөнгийн үнэ дээр дээрх эрхийн дагуу олсон орлогыг нэмж, эрх бий болгоход зарцуулсан зардлыг хассан дүнгээр тооцно.
- 3.2. Шилжүүлж авсан хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдан борлуулсан, бэлэглэсэн, гэмтээсэн, гамшигт өртсөн шалтгаанаар уг хөрөнгийн үнэд өөрчлөлт орсон бол үлдсэн хөрөнгийн үнэ дээр дээрх шалтгааны улмаас албадан худалдсан, бэлэглэсэн үнэ, эд зүйлийн төлбөр, даатгалын нөхөн төлбөр, хохирлын нөхөн төлбөр зэрэг орлогыг нэмж тухайн орлогыг олж авахад гарсан зардлыг хассан дүнгээр тооцно.
- 3.3. Өртэй татвар төлөгч нь хөрөнгөө бусдад хэт бага үнээр шилжүүлсэн бол Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д заасан үнээс шилжүүлсэн үнийн дүнгийн зөрүүгээр.
- 3.4. Бусдаас авах авлага, өгөх өглөг хүчингүй болгосон бол хүчингүй болгосон өглөг, авлагын хэмжээгээр.
- 3.5. Хоёрдогч этгээдийн үүргийн хэмжээг тодорхойлж Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд шинээр үүсгэн оруулна.
- 3.6. Өртэй татвар төлөгчийн нийт өрнөөс хоёрдогч этгээдэд хамаарах өрийн дүнг “Бусдаар төлүүлэхээр шийдвэрлэсэн” хэсэгт оруулж нийт өрнөөс тусгаарлана.

4 дүгээр зүйл.Хоёрдогч этгээдэд мэдэгдэх хуудас хүргүүлэх

- 4.1. Өртэй татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.7-д заасан хугацаанд төлөөгүй бол харьяалах татварын алба хоёрдогч этгээдийн төлөх татварын хэмжээг даргын тушаалаар баталгаажуулж, мэдэгдэх хуудас хүргүүлнэ.
- 4.2. Татварын алба хоёрдогч этгээдэд мэдэгдэх хуудсыг биечлэн, шуудангаар, цахим хэлбэрээр хүргүүлнэ. Мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан нь хоёрдогч этгээдийн татвар төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 4.3. Өртэй татвар төлөгчид татварын өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлсэн хугацаанд татварын өртэй нь холбогдуулан татвар төлөх хоёрдогч этгээдэд мэдэгдэх хуудас хүргүүлэхгүй. Хоёрдогч этгээдэд татварын өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлсэн нь өртэй татвар төлөгчид хамаарахгүй.
- 4.4. Энэ журмын 4.1-д заасан үйл ажиллагааг татварын албаны татвар хураах, өр барагдуулах чиг үүрэг хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.
- 4.5. Татварын ерөнхий хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3-т зааснаар мэдэгдэх хуудас, урьдчилан нэхэмжлэх хуудсыг гардуулсанд тооцно.

5 дугаар зүйл. Хоёрдогч этгээдээс татварын өр хураах үйл ажиллагаа

- 5.1. Хоёрдогч этгээдээс татварын өрийг хураах ажиллагаанд Татварын ерөнхий хуулийн 51, 54, 60, 61, 62, 63, 64, 65, 66, 68, 69 дүгээр зүйл нэгэн адил хамаарч үйлчилнэ.
- 5.2. Хоёрдогч этгээд татварын өрийг татварын албаны мэдэгдэх хуудсанд заасан дансанд өөрийн нэрээр төлнө. Хоёрдогч этгээдийн төлсөн татварын хэмжээгээр өртэй татвар төлөгчийн татварын өрийн хэмжээг бууруулна.
- 5.3. Хоёрдогч этгээд мэдэгдэх хуудсанд нэхэмжилсэн татварын өрийг өөрт хамаарах илүү төлсөн татвараас суутган тооцуулж болно.
- 5.4. Өртэй татвар төлөгч татварын өрөө төлсөн, суутган тооцуулсан, татварын ногдлыг бууруулах залруулга хийсэн зэргээр татвар өр хэсэгчлэн буурсан бол буурсан татварын өрийн хэмжээгээр хоёрдогч этгээдийн төлөх татвар буурна.
- 5.5. Хоёрдогч этгээдийн илүү төлөлтөөс татварын өрийг төлөхөд хүрэлцэхгүй бол үлдсэн татварын өрийг төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 5.6. Өртэй татвар төлөгчийн өрийг хоёрдогч этгээд төлөхдөө илүү төлсөн бол хоёрдогч этгээд татварын өртэй тохиолдолд уг дүнг татварын өрөнд суутган тооцно.
- 5.7. Татварын алба энэ журмын 5.2, 5.3, 5.4-т заасныг хэрэгжүүлэхдээ өртэй татвар төлөгч, хоёрдогч этгээдэд тухай бүр мэдэгдэнэ.
- 5.8. Хоёрдогч этгээд Татварын ерөнхий хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т зааснаас бусад тохиолдолд өр үүссэн хугацаанаас хойш ажлын 30 хоногийн дотор нэхэмжлэх хүргүүлнэ.

- 5.9. Хоёрдогч этгээдээс эрсдэлтэй татварыг урьдчилан хураах нөхцөл үүссэн бол Татварын ерөнхий хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасан хугацаанд татварын алба эрсдэлтэй татварыг урьдчилан хураах нэхэмжлэх хуудсыг хүргүүлнэ.
- 5.10. Өртэй татвар төлөгчөөс эрсдэлтэй татварыг урьдчилан хураах нөхцөл үүссэн бол уг шалтгаанаар хоёрдогч этгээдэд урьдчилан хураах үйл ажиллагаа явуулахгүй.
- 5.11. Татварын албанаас хоёрдогч этгээдэд нэхэмжлэх хүргүүлсний дараа татварын өрийн дүн өөрчлөгдсөн бол дараах арга хэмжээ авна:
- 5.11.1. татварын өрийн дүнг бууруулах, залруулах;
 - 5.11.2. хоёрдогч этгээдийн үүрэг үүссэний дараа өртэй татвар төлөгчийн залруулгаар нэмэгдсэн өр хоёрдогч этгээдэд хамаарах бол уг өрийн дүнг нэмж татварын өрийг мэдэгдэх хуудсаар дахин хүргүүлнэ.
- 5.12. Харьяалах татварын алба шаардлагатай гэж үзвэл Татварын ерөнхий хуулийн 60, 61, 62, 63, 64, 65, 66 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хийхдээ дараах зарчмыг баримтална:
- 5.12.1. хоёрдогч этгээдээс татварын өр хураах үед хоёрдогч этгээдийн үүрэг үүссэн хөрөнгөөс бусад хөрөнгийг битүүмжлэхгүй;
 - 5.12.2. хоёрдогч этгээдийн үүрэг үүсэх шалтгаан болсон хөрөнгө, бусад хөрөнгө нийлж нэг хөрөнгийг бүрдүүлж байгаа тохиолдолд энэхүү хөрөнгийг битүүмжилж болно;
- 5.13. Хоёрдогч этгээд Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлд заасан хөнгөлөлт эдлэх хүсэлт гаргасан тохиолдолд харьяалах татварын алба Татварын өр төлөх хугацааг хөнгөлөх журмын дагуу татварын өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлж болно.
- 5.14. Өртэй татвар төлөгчид татварын өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлэхийн өмнө хоёрдогч этгээдийн хөрөнгийг битүүмжилсэн, хөнгөлөлт үзүүлэх хугацаанд тухайн хөрөнгийн үнэ цэнийг бууруулахгүйн тулд их хэмжээний зардал гарч, уг хөрөнгөөс татварын өрийг барагдуулах боломжгүй тохиолдолд битүүмжлэлийг цуцална.
- 5.15. Татварын ерөнхий хуулийн 68, 69 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлэхдээ хөрөнгийг хоёрдогч этгээдийн үүрэг үүсгэсэн хөрөнгө, бусад хөрөнгө гэж хуваахгүй мөнгөн хөрөнгөд шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлсэн бол бусад хөрөнгөд хамаарах мөнгөн дүнг хоёрдогч этгээдэд олгоно.

6 дугаар зүйл. Хоёрдогч этгээдийн үүрэг дуусгавар болох

- 6.1. Татвар төлөгч хоёрдогч этгээдэд хамаарах татварын өрийг бүрэн төлж барагдуулсан бол хоёрдогч этгээдэд энэ тухай мэдэгдэж татвар төлөх үүрэг дуусгавар болно.

- 6.2. Хоёрдогч этгээд энэ журмын 5.2-т заасны дагуу татварын өрийг бүрэн төлсөн бол татвар төлөх хоёрдогч үүрэг дуусгавар болж өртэй татвар төлөгчид энэ тухай мэдэгдэнэ.
- 6.3. Хоёрдогч этгээдээс шүүхэд гаргасан нэхэмжлэлийн дагуу шүүхээс хоёрдогч үүрэг үүсэх нөхцөл, шалгуурыг бодит бус гэж үзэн цуцлах шийдвэр гаргасан бол хоёрдогч этгээдийн үүрэг дуусгавар болж, өртэй татвар төлөгчийн тусгаарласан өрийг сэргээн бүртгэнэ.

ТАТВАР ХУРААЛТЫН ГАРЫН АВЛАГА

(Төслийн зөвлөх багаас хүлээлгэн өгсөн хувилбар)

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАТВАРЫН ӨРИЙГ ЦЭГЦЛЭХ

1. Татварын өрийг цэгцлэнэ гэдэг нь171
2. Татварын өрийг цэгцлэх үндсэн зарчим.....171

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ ХАРИЛЦАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

1. Татвар төлөгчтэй харилцахад баримтлах үндсэн зарчим.....172
2. Татвар төлөгчтэй харилцахад анхаарах зүйлс.....173
3. Уулзалтын үед анхаарах зүйлс.....174
4. Өртэй татвар төлөгч байхгүй байгаа тохиолдолд авах арга хэмжээ.....176

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙРШЛЫН СУДАЛГАА

1. Дотоодын судалгаа177
2. Хамааралтай газруудын судалгаа.....177
3. Төрийн байгууллагын судалгаа.....177

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙН БАЙДЛЫГ ТОГТООХ

1. Хөрөнгийн судалгаа хийхэд анхаарах зүйлс.....179
2. Төрийн байгууллагаас авах судалгаа.....179
3. Санхүүгийн байгууллагын судалгаа.....180
4. Бусад судалгаа.....181
5. Асуулга явуулах, үзлэг хийх.....181

ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙН БИТҮҮМЖЛЭЛ

1. Битүүмжлэх нөхцөл.....185
2. Битүүмжлэлд тавих хязгаарлалт.....185
3. Битүүмжлэх боломжтой хөрөнгө болон битүүмжлэх хөрөнгийг сонгох.....186
4. Хөрөнгийн хамаарлыг тогтоох.....188
5. Битүүмжлэлийн нийтлэг үйл ажиллагаа.....189
6. Битүүмжлэлийн үйлчлэл.....190

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙН ТӨРӨЛ ТУС БҮРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ БИТҮҮМЖЛЭЛИЙН АЖИЛЛАГАА

- Нэгдүгээр хэсэг. Хөдлөх хөрөнгө, үнэт цаасны битүүмжлэл192
1. Хөдлөх хөрөнгийн тодорхойлолт.....192
 2. Үнэт цаасны тодорхойлолт.....192

3. Хөдлөх хөрөнгө, үнэт цаасны судалгаа.....	192
4. Битүүмжлэх ажиллагаа.....	192
5. Хадгалалт, зөөвөрлөлт.....	193
6. Битүүмжлэлийн үйлчлэл.....	194
7. Битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг ашиглах, ашиг орлого олох.....	194
8. Үнэт цааснаас мөнгөн хөрөнгийг гаргуулах.....	194
9. Гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах.....	194
Хоёрдугаар хэсэг. Татварын өрийг үл маргах журмаар хураах.....	195
1. Битүүмжлэх боломжтой банкны данс.....	195
2. Битүүмжлэх ажиллагаа.....	195
3. Битүүмжлэлийн үйлчлэл үүсэх хугацаа.....	195
4. Банкны үүрэг.....	195
Гуравдугаар хэсэг. Авлагын битүүмжлэл.....	196
1. Авлагын тодорхойлолт.....	196
2. Авлагыг сонгох.....	196
3. Битүүмжлэх ажиллагаа.....	196
4. Авлагыг тодорхойлох.....	197
5. Битүүмжлэх авлагын хамрах хүрээ.....	197
6. Авлагын баримт бичгийг хураах.....	197
7. Авлагын битүүмжлэлийн үйлчлэл.....	197
Дөрөвдүгээр хэсэг. Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх.....	198
1. Үл хөдлөх эд хөрөнгө битүүмжлэх.....	198
1.1. Битүүмжлэлд хамаарах үл хөдлөх эд хөрөнгийн хязгаарлалт.....	199
1.2. Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх болон үйлчлэлийн хугацаа.....	199
1.3. Битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох.....	199
2. Агаарын хөлөг битүүмжлэх.....	200
2.1. Агаарын хөлөг битүүмжлэх ажиллагаа болон үйл ажиллагааны үйлчлэлийн хугацаа.....	200
2.2. Агаарын хөлгийг зогсоох, хөдөлгөх зөвшөөрөл олгох.....	201
3. Автомашин, барилгын тоног төхөөрөмж битүүмжлэх.....	201
3.1. Автомашин, барилгын тоног төхөөрөмжийн битүүмжлэлийн ажиллагаа болон үйлчлэлийн хугацаа.....	201
3.2. Автомашиныг мэдэлдээ авах, хадгалах, хөдөлгөх.....	202

Тавдугаар хэсэг. Биет бус хөрөнгө битүүмжлэх.....	204
1. Биет бус хөрөнгийн дотор өглөгтэй гуравдагч этгээдгүй хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа, үйлчлэлийн хугацаа.....	205
1.1. Биет бус хөрөнгийн дотор өглөгтэй гуравдагч этгээдгүй хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа, үйлчлэлийн хугацаа.....	205
1.2. Битүүмжлэх ажиллагаа болон үйлчлэл үүсэх хугацаа.....	205
2. Биет бус хөрөнгийн эрхийн дотор өглөгтэй гуравдагч этгээдтэй хөрөнгийн битүүмжлэх ажиллагаа, үйлчлэлийн хугацаа.....	206
2.1. Биет бус хөрөнгийн эрхийн дотор өглөгтэй гуравдагч этгээдтэй хөрөнгийн төрөл (гол зүйл) болон тухайн өглөгтэй гуравдагч этгээдэд хамрах этгээд.....	206
2.2. Битүүмжлэх ажиллагаа болон үйлчлэх хугацаа.....	206

ДОЛООДУГААР БҮЛЭГ. БИТҮҮМЖЛЭЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

1. Битүүмжлэлийг хүчингүй болгох нөхцөл шаардлага.....	207
2. Битүүмжлэлийг хүчингүй болгох үйл ажиллагаа.....	207
3. Битүүмжлэлийг хүчингүй болгохтой холбоотой хийгдэх үйл ажиллагаа.....	208

НАЙМДУГААР БҮЛЭГ. СУУТГАЛЫН ХҮСЭЛТ

1. Суутгалын хүсэлт гаргах боломжтой нөхцөл шаардлага болон суутгалын хүсэлтийн хязгаар.....	209
2. Суутгах хүсэлтийн арга хэмжээ.....	209
3. Албадан гүйцэтгэлийн дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг хүчингүй болгох болон суутгалын хүсэлтийг цуцлах.....	210
4. Албадан гүйцэтгэлээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээний хөрөнгө шилжүүлэх болон суутгалын хүсэлт хоорондын харилцан хамаарал.....	210
5. Суутгалын хүсэлтийг цуцлах арга хэмжээ.....	210

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙН МӨНГӨН ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ

1. Мөнгөн хэлбэрт шилжүүлэх ерөнхий дүрэм.....	211
2. Дуудлага худалдааг зохион байгуулах ажиллагаа.....	212
3. Шууд гэрээгээр худалдан борлуулах арга хэмжээ.....	216
4. Худалдан борлуулах шийдвэр.....	217
5. Худалдан авах төлбөр төлөх болон үр дүн.....	217
6. Эрх шилжүүлэх арга хэмжээ.....	217

АРАВДУГААР БҮЛЭГ. ХУВААРИЛАХ

1. Хуваарилалтын ач холбогдол.....	219
------------------------------------	-----

2. Хуваарилах шаардлагатай мөнгө.....	219
3. Хуваарилалтын зарчим.....	219
4. Хуваарилалт хийх арга хэмжээ.....	220
5. Татварын давуу эрх.....	221

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАТВАР ТӨЛӨХ ХУГАЦААНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО

1. Хугацааны хөнгөлөлт үзүүлэх нөхцөл.....	223
2. Хугацааны хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ.....	223
3. Хугацааны хөнгөлөлтийн үед гаргах барьцаа.....	224
4. Хугацааны хөнгөлөлтийн нөлөө.....	224
5. Цуцлах.....	224

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ. ТАТВАР ТӨЛӨХ ҮҮРЭГТЭЙ ХОЁРДОГЧ ЭТГЭЭДИЙН ТОГТОЛЦОО

1. Нийтлэг үндэслэл.....	225
1.1. Татвар төлөх үүрэг үүсэх.....	225
1.2. Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд болон өртэй татвар төлөгч хоорондын харилцаа.....	225
1.3. Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдээс татварын өрийг гаргуулах арга хэмжээ.....	226
2. ТЕХ-ийн 57-р зүйлийн татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд.....	227
2.1. Үүрэг бий болох нөхцөл шаардлага.....	227
2.2. Татвар төлөх үүрэгтэй этгээд.....	230
2.3. Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдийн татвар төлөх үүргийн хамрах хүрээ.....	230

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ. ТАТВАРЫН ӨР БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИЛЖҮҮЛЭХ

1. Татварын өр барагдуулах үйл ажиллагааг шилжүүлэх боломжтой тохиолдол.....	232
2. Ажиллагааг шилжүүлэх тухай ойлголт болон хамрах хүрээ.....	232
3. Татвар төлөгчид мэдэгдэх тухай.....	232

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АЛДАНГИЙН ХӨНГӨЛӨЛТ.....

ТАТВАРЫН ӨР ХУРААЛТЫН ГАРЫН АВЛАГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАТВАРЫН ӨРИЙГ ЦЭГЦЛЭХ

1. Татварын өрийг цэгцлэнэ гэдэг нь

“Татварын өрийг цэгцлэх” гэдэг нь татварын өр хураах ажиллагаа багтсан, татвар хураалтын үйл ажиллагааг нийтэд нь авч үзсэн өргөн хүрээний утга агуулгатай юм. Татвар төлөгч татвар төлөх хугацаандаа татвараа төлөөгүй тохиолдолд (1) нэхэмжлэх хүргүүлж (ТЕХ-ийн 51 дүгээр зүйл), (2) нэхэмжлэх хүргүүлснээс хойш 10 өдөр өнгөрсөн ч төлөгдөөгүй бол банкны дансыг битүүмжилж, бусад хөрөнгийг нь битүүмжлэх эсхүл суутгах хүсэлт хүргүүлнэ (ТЕХ-ийн 62-69 дугаар зүйл), (3) эсхүл гамшиг, өвчин зэргээс шалтгаалан төлөхөд хүндрэлтэй болсон бол татвар төлөгч хүсэлт гарган татвар төлөх хугацааны хөнгөлөлт авч болно (ТЕХ-ийн 53 дугаар зүйл), (4) мөн түүнээс гадна үнэгүйгээр эсхүл хэт бага үнээр хөрөнгөө шилжүүлсэн бол татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдэд үүрэг хүлээлгэх (ТЕХ-ийн 57 дугаар зүйл) замаар татварын өрийг хураана. Татварын өрийг цэгцлэнэ гэдэг нь ийнхүү татварын өрийг хураахтай холбоотой хийгддэг шат дараалласан үйл ажиллагаануудыг нийтэд нь хэлж байгаа ба эдгээр ажлуудыг ерөнхийд нь хувааж авч үзвэл Нэгт. Асуулга явуулах, судлах зорилгоор татвар төлөгчтэй уулзах, төлүүлэх талаар хэлэлцэх болон судалгаа хийх зэрэг баримт, мэдээлэлд тулгуурласан дотоод ажлууд, Хоёрт. Битүүмжлэл, мөнгөн хэлбэрт шилжүүлэх, шилжүүлсэн орлогыг хуваарилах зэрэг татварын өр хураалттай холбоотой албадан гүйцэтгэлийн ажлууд гэж хувааж болно. Татварын өрийг хоёр талын хамтын ажиллагааны үр дүнд хурааж цэгцэлдэг.

(Нэмэлт) Татварын өр хураах ажиллагаа гэдэг нь татвар хураах байгууллага гүйцэтгэлийн бие даасан эрхэд үндэслэн татварын авлагаа албадан гүйцэтгэлээр хураах ажиллагааг ерөнхийлөн хэлж байгаа ба ТЕХ-ийн 12 дугаар бүлэгт заасан арга хэмжээнүүдийг хэлнэ.

2. Татварын өрийг цэгцлэх үндсэн зарчим

Татварын өрийг цэгцлэхдээ дараах үндсэн зарчмыг баримтална.

(1).Татвар хураалтын байцаагчийн (Татвар хураахтай холбоотой ажлыг хийдэг татварын байцаагчдын дотроос татварын өр хураах албадан ажиллагааг хийх эрх олгогдсон байцаагчийг хэлнэ.) ажлын гол чиг үүрэг нь татвар төлүүлэхээр хэлэлцэх болон татварын өр хураах ажиллагаагаар татварын өрийг баттай хураах явдал юм (ТЕХ-ийн 29 дүгээр зүйл). Энэхүү ажил үүргийг гүйцэтгэх явцдаа үргэлж татвар төлөгчидтэй тэгш, шударга харьцахаа үндсэн зарчмаа болгон, зөв зохистойгоор

ажиллах ёстой.

(2).Татварын өрийг цэгцлэх ажлын цөм гэж хэлж болохоор татварын өр хураах ажиллагааг хэрэгжүүлэхдээ ТЕХ-аас гадна бусад татварын хуулиуд, Иргэний хууль, Дампуурлын тухай хууль зэргийг ашиглах шаардлагатайгаас гадна хөрөнгийн байдлыг тогтоох, татвар төлөх чадварын судалгааг хийхийн тулд бусад тайлангууд, компанийн бүртгэлийн баримт бичигтэй уншиж танилцан, ойлгодог байх шаардлагатай. Үүний тулд эдгээр хуулийн ач холбогдол, нягтлан бодох бүртгэлийн мэдлэг зэрэгт үргэлж суралцан, татвар хураалтыг илүү өндөр түвшинд хэрэгжүүлэхэд хичээн ажиллах нь зүйтэй юм.

(3).Татварын байцаагчид татвар хураахтай холбоотойгоор хэд хэдэн эрхүүд олгогдсон байгаа ба ажил үүргийн хүрээнд мэдсэн татвар төлөгчийн мэдээллийг чандлан нууцлах үүрэг хүлээнэ (ТЕХ-ийн 14.3). Энэхүү үүргийг зөрчин татвар төлөгчийн нууц мэдээллийг ТЕХ-ийн 14 дүгээр зүйлд зааснаас бусад этгээдэд дамжуулах, хувийн зорилгоор ашиглаваас захиргааны хариуцлага хүлээлгэнэ (ТЕХ-ийн ... дугаар зүйл. Татварын байцаагчийн эрх үүрэг?, 73 дугаар зүйл. Татварын байцаагчийн хариуцлага).

Нууц мэдээллийг хамгаалж, хадгалснаар татвар төлөгч илүү ойлгож хамтран ажиллах ба энэ нь татварын байцаагчид татвар хураах ажил үүргээ гүйцэтгэхэд нь илүү хялбар, асуудалгүй болгоно гэдгийг ойлгох хэрэгтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ ХАРИЛЦАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

1. Татвар төлөгчтэй харилцахад баримтлах үндсэн зарчим

Татварын өрийг цэгцлэх ажил нь хамгийн түрүүнд өртэй татвар төлөгчтэй харилцахаас эхэлдэг. Өртэй татвар төлөгчтэй харилцахгүйгээр татварын өрийг цэгцлэнэ гэдэг нь боломжгүй юм. Мөн өртэй татвар төлөгчтэй харилцахдаа татварын байцаагч “татварын өрийг бүрэн барагдуулж, төлүүлэх” гэсэн хүчтэй хүсэл зорилготой байх шаардлагатай.

Татвар төлөгчтэй харилцах гэдэгт өртэй татвар төлөгчийн гэр, ажлын байранд очиж шууд уулзахаас гадна, өртэй татвар төлөгч татварын албанд ирэх үед хийх уулзалт, утсаар холбогдох, өртэй татвар төлөгчтэй харилцан хамааралтай гуравдагч этгээдтэй холбогдох зэрэг нь мөн хамаарна. Эдгээрийн аль ч тохиолдолд татварын байцаагч нь нас, ажил, туршлага зэрэг нь өөр өөр хүмүүстэй холбогдож, харилцах шаардлагатай тулгардаг.

Татварын байцаагчийн харилцаа сайн, муу байх нь татварын албаны үйл ажиллагаанд итгэх итгэлтэй холбогдох бөгөөд цаашлаад татвар төлөгчийн татвар төлөх ухамсарт нь ч нөлөөлөх магадлалтай.

Иймд, татвар төлөгчтэй харилцахаасаа өмнө хангалттай сайн бэлтгэж, хэрэглэх үгийн сонголт болон хандлагаа зөв байлган, соёлтой боловсон харилцах шаардлагатай ба “хэзээ, хэн, хаана, юуг, яагаад, юу болсон” гэх асуултуудад үндэслэн төлөвлөгөөтэй, цэгцтэйгээр яриаг урагшлуулах нь чухал юм.

(Нэмэлт)

1. Өртэй татвар төлөгчтэй хэлэлцэх татварын өрийг цэгцлэх төлөвлөгөө, үйл явц нь хариуцсан байцаагч болох нэг хувь хүний шийдвэр биш бөгөөд байгууллагын бодлогыг төлөөлөх зүйл юм. Иймд, хатуу шийдэмгий харилцах шаардлага гарах үед хувь хүний үүднээс биш байгууллагын бодлогыг төлөөлж байгаа гэдгээ сайтар илэрхийлэх шаардлагатай.

2. Хүндрэлтэй татварын өрийг шийдвэрлэхдээ өртэй татвар төлөгчийг аль болох татварын албанд олон ирүүлэх, олон удаагийн харилцаа тогтоосноор илүү үр бүтээмжтэй хэлэлцээрийг хийдэг.

2. Татвар төлөгчтэй харилцахад анхаарах зүйлс

(1).Гол санаа болон анхаарах зүйлс

А. Харилцах тал

Зарчмийн хувьд өртэй татвар төлөгч өөртэй нь (ААН бол удирдлага, төлөөлөгч, санхүүгийн хэлтсийн дарга г.м татварын өрийг төлөхтэй холбоотой хариуцлага үүрч байгаа нь тодорхой этгээд) харилцах ба өөр этгээдтэй татвар төлүүлэх талаар хэлэлцэхгүй. Өртэй татвар төлөгчийн гэр бүлийн гишүүн зэрэг этгээд байсан ч нууцыг хадгалах үүргээ ухамсарлан, уулзалт хийх, харилцаа тогтоохдоо анхааралтай байх хэрэгтэй.

В. Хандлага

Өртэй татвар төлөгчтэй уулзахдаа татварын байцаагч өөрийн биеийн хэлэнд (жишээ нь хөлөө ширээн дээр гаргаж тавих, биеэ муруйлгах зэрэг үл тоосон, дээрээс харьцсан, бүдүүлэг байдлыг харуулж болохгүй) анхаарах шаардлагатай.

С. Бусад

а. Өртэй татвар төлөгч татварын байцаагчийн өмнө ихэнхдээ биеэ барьдаг тул харилцаж байгаа татвар төлөгчийг илүү чөлөөтэй байлгах тал дээр анхаарах хэрэгтэй. Үүний тулд өдөр тутмын сул яриа ярих нь ч үр дүнтэй байх тохиолдол бий.

б. Татварын өрийг цэгцэлж байна гэдэг нь хууль хэрэгжүүлж байгаа боловч өртэй татвар төлөгчид тодорхой ойлгомжтой байдлаар тайлбарлаж, ойлгуулах хэрэгтэй.

в. Өртэй татвар төлөгчөөс ирсэн асуулт, хүсэлтэд тодорхойгүй хариулт өгөх, тоглоом шоглоом хийх байдлаар хариу өгч болохгүй ба яг тодорхой хариулж харилцах ёстой.

(2) Утсаар харилцах

Утсаар харилцах нь харилцаж буй хүнтэйгээ уулзахгүй байгаа тул үл ойлголцол үүсч, найрсаг бус харилцаа үүсэхдээ амархан. Иймд нүүр нүүрээ харан уулзаж байгаатай адилаар зөв зохистой харилцах нь маш чухал юм. Хэрэв татварын алба талаас залгасан бол харьяа татварын алба болон нэрээ хэлж, харилцах гэж байгаа этгээд нь мөн эсэхийг нягтална. Харин дуудлага нөгөө талаас ирсэн бол даруй хариу өгч, татварын албаны нэрийг хэлэн, хэнтэй ярьж байгааг асууж лавлах нь утсаар харилцахын хамгийн эхний алхам болно.

3. Уулзалтын үед анхаарах зүйлс

(1) Татвараа аль хэдийн төлчихсөн гэвэл

Өртэй татвар төлөгч татвараа аль хэдийн төлчихсөн гэвэл хураалтын систем болон төлбөрийн баримтыг шалган нягтална.

(2) Бүх татвараа төлөх хүсэлтэй байна гэвэл

Нийт татварын өрөө төлөхөөр хүсэлтэй бол үндсэн татвараас гадна торгууль, алдангийг (цаашид “дагалдах татвар” гэх) орхигдуулалгүй тооцоолж, сайтар нягтлан дахин ажил удахгүй байхад анхаарна.

(3) Татварын өрөө шууд төлөхөд хүндрэлтэй байгаагаа илэрхийлвэл

Шууд төлөхөд хүндрэлтэй байна гэвэл өртэй татвар төлөгчийн нөхцөл байдлыг мэдэхийн тулд яг тухайн үеийн нөхцөл байдал, татварын өр үүссэн шалтгаан, төлөх эрмэлзэл (төлөх төлөвлөгөө), орлого зарлагын байдал, хөрөнгийн байдал зэргийг асууна. Хэрэв татварын өрийн хэмжээ харьцангуй бага бөгөөд богино хугацаанд төлнө гэж байгаа бол аль болох бүгдийг нь төлүүлэх эсхүл одоо төлөх хэмжээг нь ихэсгэх талаар хэлэлцэсний дараа төлөхөд хүндрэлтэй байгаа хэсгийг нь нөхцөл байдалд нь үндэслэн хуваан төлөхийг нь зөвшөөрч болно.

Дээрхээс бусад тохиолдолд дараах байдлаар одоо төлөх боломжтой байгаа хэмжээ болон ирээдүйд төлөх боломжтой хэмжээг тооцон, өртэй татвар төлөгчтэй хэлэлцсэний үндсэн дээр үлдэгдэл хэмжээг нөхцөл байдалд нь тааруулан хуваан төлөхийг нь зөвшөөрч болно. Энэ тохиолдолд нөхцөл байдалд тааруулан (*орч. татвар төлөх хугацааны хөнгөлөлтийн тогтолцооноос өөр*) төлөхийг нь хойшлуулж байгаа хэмжээ нь өндөр эсхүл төлөх хугацаа нь урт бол хөрөнгийг нь битүүмжлэх арга хэмжээг авахгүй бол болохгүй. Мөн нөхцөл байдалд нь тааруулан хуваан төлөхийг нь

зөвшөөрөхдөө өртэй татвар төлөгчтэй “татвар төлөх гэрээ” байгуулах ба шинээр татварын өр нэмэгдүүлж үүсгэхгүй байхаар тухай мөн гэрээндээ заана.

А. Одоо төлөх боломжтой хэмжээг (шууд төлөх боломжтой хэмжээ) тооцох [бэлэн байгаа мөнгө + данснаас гаргах боломжтой мөнгө + бэлэн мөнгө болгох боломжтой үнэт цаас]-ны нийлбэрээс [өмнөх тооцоолсон нийлбэр дүнгээс татвараа төлөх боломжгүй хэмжээ (ойролцоогоор 1 сарын үйл ажиллагаа явуулах мөнгө (үйл ажиллагаа явуулахад шаардагдах төлбөр, цалингийн зардал, түрээс, шууд бус зардал, зээлийн төлбөр, лизингийн төлбөр болон бусад зардал), амьжиргааны зардал, бусад хийгдэх шаардлагатай төлбөр тооцоо]-г хасаж, [төлөх боломжтой хэмжээ]-г гаргана.

В. Ирээдүйд төлөх боломжтой хэмжээг (цаашид хуваан төлөх хэмжээ) тооцох Цаашид сар бүрт орж ирэх орлогоос (борлуулалтын орлого, цалин хөлс, урамшуулал болон бусад орлого) гарах зарлагыг (төлбөр, цалингийн зардал, түрээс, шууд бус зардал, зээлийн төлбөр, лизингийн төлбөр, амьжиргааны зардал болон бусад зардлууд) хасан төлөх боломжтой ерөнхий хэмжээг тооцоолно. Үүнд дээр улирлын шинж чанартай үйл ажиллагаатай холбоотой нэмэгдэж хасагдах орлого, зарлага байвал тооцно. Мөн гэнэтийн орлого (шаардлагагүй хөрөнгийг борлуулах, зээл түрээсийн авлага орж ирэх г.м) эсхүл зарлага (тоног төхөөрөмж засварлах, шинэчлэхтэй холбоотой зардал, орон байраа засах, бусад татвар төлөх г.м) байвал нэмж тооцоолон ирээдүйд төлөх боломжтой хэмжээг гаргана.

(4) Татвараа төлөх тал дээр хамтарч ажиллахгүй байгаа нөхцөлд

Татвараа төлөхгүй байх, эсхүл төлж чадахгүй байгаа шалтгааныг асуусан ч хангалттай хариулт өгөлгүйгээр зөвхөн төлж чадахгүй гэсэн хүчтэй эсэргүүцэл үзүүлэх зэрэг төлье гэсэн хүсэлт эрмэлзэл харагдахгүй байгаа тохиолдолд шууд хатуу байр суурьтайгаар битүүмжлэх арга хэмжээг авна.

(5) Татвар ногдуулалттай холбоотой гомдол гаргавал

Татвар ногдуулалт хариуцсан байцаагчид амаар ногдуулсан татварын талаар гомдолтой байгаагаа илэрхийлвэл зарчмын хувьд хураалт, татварын өр цэгцлэх ажиллагааг үргэлжлүүлэх боловч хэрэв бичгээр гомдол гаргасан тохиолдолд ногдуулалттай холбоотой гомдлыг шийдвэрлэх шийдвэр гарах хүртэл татварын өр цэгцлэх ажиллагааг хэрэгжүүлэхгүй. Гомдол хүлээн авсны дараа нилээдгүй хугацаа өнгөрчихсөн тохиолдолд цаашид авах арга хэмжээ зэргийн талаар татвар ногдуулалт хариуцсан байцаагчаас лавлана.

Татвар ногдуулалтын талаар албан ёсны гомдол гаргалгүй татварын өрийг цэгцлэх явцад амаар гомдол гаргасан бол тэр тухай татвар ногдуулалт хариуцсан байцаагчтай холбогдоно. Асуулга явуулах, судалж шалгах зэргээр ногдуулалтад алдаа гарсан болохыг тогтоосноор тухайн татвар ногдуулалт хүчингүй болсон нь тодорхой болвол

холбогдох бичиг баримтыг бэлтгэн ногдуулалт хариуцсан байцаагчтай холбогдох ба татварын өр цэгцлэх ажиллагааг түр зогсооно.

4. Өртэй татвар төлөгч байхгүй байгаа тохиолдолд авах арга хэмжээ

Өртэй татвар төлөгчийн гэр, ажил зэрэг газруудад очиход байхгүй байгаа тохиолдолд дараах байдлаар арга хэмжээ авна.

- А. Өртэй татвар төлөгч өөрөө эзгүй байсан ч өртэй татвар төлөгчийн эхнэр/нөхөр, компанийн удирдлага зэрэг харилцахад боломжтой этгээд байвал тэдгээр этгээдээс татвар хураахад хэрэг болох асуудлуудын талаар асууж лавлана.
- В. Хэрэв хариуцлагатай харилцах боломжтой этгээд байхгүй эсхүл бүр хэн ч байхгүй байгаа тохиолдолд хөрш, хажуугаас нь оршин сууж байгаа эсэхийг нь лавлах, эзгүй үед нь ирсэн болохыг мэдэгдсэн хуудас (ирсэн шалтгаан болон татварын албанд ирэхийг хүссэн тухай бичсэн хуудас) үйлдэн, шууданд нь хийх эсхүл хаалганд нь хавчуулах зэргээр ирсэн болохыг нотлох баримт үлдээнэ. Гэхдээ, оршин сууж байгаа эсэхийг нь шалгаж чадаагүй бол тухайн мэдэгдэх хуудсыг орхихгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙРШЛЫН СУДАЛГАА

Өртэй татвар төлөгч үйл ажиллагаа нь бүтэлгүйтэх зэрэг янз бүрийн шалтгаанаар хаана байгаагаа тодорхой болгохгүйгээр нүүх зэргээр байршил нь тодорхойгүй болох тохиолдол бий.

Энэ тохиолдолд татварын албанд байгаа судлах боломжтой бичиг баримтуудыг шалган, өртэй татвар төлөгчийн эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа зэрэгт үндэслэн хамааралтай газрууд, хамтрагчид, цагдаагийн байгууллага зэрэг төрийн байгууллагуудтай хамтран судалгаа хийж байршлыг нь тодорхойлох шаардлага тулгардаг.

1. Дотоодын судалгаа

Мэдэгдэж байгаа хаяг, нэр, үйл ажиллагаа явуулдаг газар, утасны дугаар зэрэг нь өөрчлөгдсөн эсэхийг санхүү, татварын тайлан зэргээс нягтлах.

2. Хамааралтай газруудын судалгаа

Байршил нь тодорхойгүй болохын яг өмнөх өртэй татвар төлөгчийн үйл хөдлөл, гэр бүлийн байдал, амьдралын байдал болон байршилаа өөрчилсний дараа хэрхэн холбоо барих талаар хамтрагч, ажил олгогч, хөрш зэргэлдээ айлаас нь асууж тодруулах.

3. Төрийн байгууллагын судалгаа

Дунд шатны, орон нутгийн удирдах байгууллага нь татварын байгууллагатай ажиллахад таатай орчныг бүрдүүлэн, хамтран ажиллах үүрэг хүлээсэн байдаг ба (ТЕХ-ийн 34 дүгээр зүйл), татвар хураалтын судалгааны ажилд шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана.

Гол хамтран ажиллах төрийн байгууллагуудаас доор дурьдвал:

(1) Аймаг, хот, дүүрэг, хороо

а. Хувь хүний бүртгэл

Оршин суугчийн бүртгэл нь аймаг, хот, дүүрэг болон хороодын оршин суугчдыг ам бүлээр нь бүртгэсэн байдаг ба нэр, төрсөн он сар өдөр, хаяг, болон өмнө нь оршин сууж байсан хаяг зэргийг судлах боломжтой.

Оршин суугаа хаягаа шилжүүлэх хүсэлтээ шинэ хаяг руу шилжихээр шийдсэнээс хойш 7 өдрийн дотор хороонд гаргахаар заасан байдаг.

б. Гэр бүлийн бүртгэл

Дүүрэгт бүртгүүлсэн өртэй татвар төлөгчийн гэр бүлийн бүртгэлээс төрсөн, нас барсан, гэрлэсэн зэрэг түүхийг, хамаатан садны хамаарал, өв залгамжлагч болон хаягаа өөрчилсөн эсэхийг нь судална.

(2) Улсын бүртгэлийн газар

а. Хувь хүний бүртгэл

Оршин суугаа газрын бүртгэл болон гэр бүлийн бүртгэл зэргийг судлах.

б. Гадаадын иргэний гэр бүлийн бүртгэл

Монгол Улсын иргэн гадаад улсын иргэнтэй гэр бүл болсон тохиолдолд гэрлэлтийн байдал, хүүхэд зэрэг гэр бүлтэй нь хамааралтай судалгаа хийнэ.

***Гадаадын иргэний бүртгэлийн газар**

Гадаадын иргэний улсын хилээр орсон, гарсан тэмдэглэл болон гадаадын иргэний бүртгэлээс өртэй татвар төлөгчийн иргэншил, нэр, төрсөн он сар өдөр, хаяг (байршил), улсын хилээр нэвтэрсэн эсхүл гарсан он сар өдөр, оршин суух зөвшөөрөл, хугацаа зэргийг судална.

в. Хуулийн этгээдийн бүртгэл (Худалдааны бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл)

Компанийн дугаар, төв оффисын байршил, хувьцаа эзэмшигчдын хаяг, нэр болон эдгээрийн шилжилт хөдөлгөөн, албан үүргээс чөлөөлөгдсөн он сар өдөр, мөн байгуулагдсан огноо, татан буугдсан огноо, татан буулгах комисс зэргийн талаар судална.

г. Газар, барилга зэрэг үл хөдлөх хөрөнгийн бүртгэл

Өмчлөгчийн хаяг, нэр болон бусад шилжилт хөдөлгөөн, шалтгаан, битүүмжлэгдсэн эсэхийн талаар судална. Мөн ипотекийн барьцааны эрх зэрэг эрх бүхий этгээдийн хаяг, нэр болон авлагын хэмжээ зэргийг судална.

(3) Автомашины бүртгэлийн төв

Автомашины дугаар, өмчлөгчийн хаяг, нэр зэргийг судална.

(4) Цагдаагийн газар

Цагдаагийн газар нь татварын байгууллагаас хүсэлт ирүүлбэл Монгол Улсын иргэн, гадаадын иргэн болон иргэншилгүй бөгөөд бүртгэлгүй хүний хаягтай холбоотой мэдээлэлээр хангахаар заасан (ТЕХ-ийн 34 дүгээр зүйл) байгаа ба байршил нь тодорхойгүй этгээдийн байршлын талаар судална.

(5) Шүүх

Дуудлага худалдаа болж байсан түүх байгаа эсэхийн талаар тэмдэглэгээ шүүх, бичиг баримтны хуулбарыг авах хүсэлт гаргах зэргээр шалгана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙН БАЙДЛЫГ ТОГТООХ

Татварын өрийг цэгцлэх явцад өртэй татвар төлөгчийн татвар төлөх санхүүгийн чадварыг тогтоох (одоогийн төлөх чадварын судалгаа болон ирээдүйн төлөх чадварын судалгаа), татварын өрийг хураахын тулд хөрөнгөтэй эсэх, тухайн хөрөнгө нь мөнгөн хэлбэрт шилжүүлэх үнэ цэнэ байгаа эсэх, эрхийн хамаарал, мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хэр зэрэг хялбар байх зэргийг тогтоон, шалгах шаардлагатай байдаг.

(Анхаарах) Одоогийн төлөх чадварын судалгаа болон ирээдүйд төлөх чадварын судалгааны хувьд 2 дугаар бүлгийн 3-(4)-ийг харна уу.

Татвар хураах үед хийгдэх судалгааг хаана хийхээс хамаараад төрийн байгууллагын оролцоотой судалгаа, харилцан хамааралтай этгээдийн судалгаа, газар дээр нь очиж хийх судалгаа зэрэг төрлүүд бий.

Мөн судалгааг хийх аргаас хамааран үйл ажиллагааны хэрэгжилт, явцын судалгаа, асуулга, үзлэг хийх зэргээр хувааж болно.

1. Хөрөнгийн судалгаа хийхэд анхаарах зүйлс:

(1) Шуурхай хэрэгжүүлэх

Үл хөдлөх хөрөнгийг борлуулах, хадгаламжин дахь мөнгө багасах, бусад хөрөнгийг захиран зарцуулах, устгах, өртэй татвар төлөгчийн санхүүгийн чадвар нь алдахаас өмнө хурдан шуурхай арга хэмжээ авах.

(2) Бэлтгэл ажлыг хангах

Судалгааны зорилгоо тодорхой болгон бэлтгэл ажлыг ханган, дараагийн арга хэмжээ болох татварын өр цэгцлэх ажлыг илүү үр дүнтэй, бүтээмжтэй үргэлжлүүлэхэд анхаарах.

(3) Газар дээр нь очиж хийх судалгаа

Амьдралын нөхцөл байдал, үйл ажиллагааны байдал, хөрөнгө санхүүгийн нөхцөл байдлыг газар дээр нь очиж шалгах.

(4) Өртэй татвар төлөгчийн харилцагч талуудад хийх судалгаа

Өртэй татвар төлөгчийн хүсэлтийн агуулгыг шалгаж нягтлахын тулд бусад төрийн байгууллагуудаас лавлагаа авах зэргээр бичиг баримтуудыг цуглуулж бэлдэнэ. Мөн, хөрөнгийн тодорхойлолт, өмчлөл, эзэмшил, зээлдэгч нь хэн болох, өмчлөл эзэмшлийг нь нотлох зэргийг судалгааны зорилгод нийцүүлэн шалгана.

2. Төрийн байгууллагаас авах судалгаа

(1) Төрийн байгууллагын мэдээлэлээр хангах үүрэгт суурилсан мэдээлэл

цуглуулалт

Санхүүгийн байгууллага болон бусад байгууллагууд нь (үнэт цаас арилжааны газар, цагдаагийн газар, гаалийн газар, хувь хүн болон гадаадын иргэний бүртгэл хариуцсан байгууллага, дунд шатны болон орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн албан хаагч) өөрт байгаа зарим мэдээллийг татварын байгууллагад өгөх үүрэг хүлээж байгаа (ТЕХ-ийн ...? дугаар зүйл) тул аль болох их мэдээлэл цуглуулахад хичээн ажиллана.

(2) Дотоодын судалгаа

Дотоодын судалгаагаар (татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан ашиглан бичиг баримтны мэдээлэл цуглуулах) татвар тус бүрийн тайлан болон тайлангийн хавсралтууд, ногдуулалттай холбоотой материалыг судлан, өртэй татвар төлөгчийн орлогын эх үүсвэр, үйл ажиллагааны мэдээлэл (төрөл, үйл ажиллагааны хэлбэр, ашиг орлогын хөдөлгөөн, удирдлага бүтэц г.м), хөрөнгийн байдал зэргийг тодруулна.

Дотоодын судалгаа нь өнгөрсөн татварын өр цэгцлэх материал болон татвар ногдуулалтын материалд үндэслэн хийдэг ба өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдал, үйл ажиллагааны мэдээлэл, ажил гүйлгээтэй холбоотой мэдээллийг харьцангуй хялбар байдлаар шалгах боломжтой боловч нөгөө талаас хязгаартай учраас илүү лавшруулан судлах шаардлагатай байдаг.

(3) Төрийн байгууллагын судалгаа

Улсын бүртгэлийн газар, аймаг, сум, дүүрэг зэрэг байгууллагууд нь үйл ажиллагааг удирдан явуулахад хэрэгцээ шаардлагатайгаас гадна эрхийн харилцааг олон нийтэд мэдээллэхийн тулд тодорхой бүртгэлтэй байдаг.

Эдгээр бүртгэлийн бичиг баримтуудыг судалснаар өртэй татвар төлөгчийн оршин суугаа газар, газар, барилга, газар түрээслэн авах эрх, автомашин зэргийн өмчлөлийн байдал болон бусад эрхийн харилцааг мэдэх боломжтой.

3. Санхүүгийн байгууллагын судалгаа

Хөрөнгийн судалгаа хийхэд санхүүгийн байгууллагын судалгаа зайлшгүй шаардлагатай. Татварын байгууллагын татвар ногдуулалтын бичиг баримт, санхүүгийн байгууллагын лавлагаа, газар дээр нь очиж судлахдаа олж мэдсэн бичиг баримтад үндэслэн гүйлгээ хийдэг санхүүгийн байгууллагыг тодорхой болгон, хэний нэр дээр байхаас үл хамааран өртэй татвар төлөгчид харьяалагдах данс, авлага байгаа эсэхийг шалгана.

Мөн зээлэнд тавьсан барьцаа, банкны гүйлгээний түүхийг мэдсэнээр өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдал болон үйл ажиллагааг тодорхой болгож болно.

4. Бусад судалгаа

Хийн газрын компани, эрчим хүчний компаниас өртэй татвар төлөгчийн байршил, төлбөр төлсөн арга, төлбөр төлж буй данс зэргийг шалгана. Дотоодын судалгаагаар тодорхой болгосон харилцагч талын (авлага болон өглөгтэй этгээд) талаар судалснаар дансны авлага болон өглөг байгаа эсэх, төлбөр зэргийг шалгана. Байшин, барилгын түрээсийн гэрээтэй тохиолдолд түрээсийн төлбөр, хугацаа, дэнчинг төлсөн төлбөрийн хэлбэрийг шалгана. Өртэй татвар төлөгчийн орон байр, ажлын байрыг шалгаснаар өртэй татвар төлөгчид байгаа хадгалсан мөнгө, зээлийн авлага, үнэт цаас болон үнэт метал зэрэг хөдлөх хөрөнгийг олж илрүүлнэ.

5. Асуулга явуулах, үзлэг хийх

(1) Ажил үүрэг гүйцэтгэх явцад хийх судалгаа

Өртэй татвар төлөгчид ногдуулсан татварыг хураах явцад хуулиар хориглосон эсхүл хязгаарласан л биш бол олон төрлийн судалгааг хийх боломжтой.

Хөрш зэргэлдээ айл, гэр бүлийн гишүүн зэрэг этгээдээс асуулт асуух, ажил гүйлгээ хийдэг харилцагчдыг судлах зэрэг ажил үүргийн дагуу олгогдсон эрх, ажиллагааны үүднээс өргөн хүрээг хамарсан судалгааг явуулж болно. Судалгаанд хамаарах тал хэр хамтарч ажиллахаас шалтгаалж хэр зэрэг үр дүнтэй, ашиг тустай болох нь хамаардаг.

(2) Татварын байцаагчийн асуулга, шалгалт

а. Асуулга

Асуулга нь харилцагч талын мэдэж буй мэдээллийг үнэн зөвөөр асуух буюу шууд болон шууд бусаар өртэй татвар төлөгчийн хөрөнгийг судлахын тулд хийгддэг ажиллагаа юм. Асуултын хариуг авахын тулд асуух зүйлсээ өмнөөс бэлдэж, цэгцлэх шаардлагатай байдаг.

- Асуулга явуулах боломжтой тохиолдол

“Татварын өр хураах зорилгоор өртэй татвар төлөгчийн хөрөнгийг судлах” тохиолдолд асуулга явуулах боломжтой (ТЕХ-ийн 59 дүгээр зүйл). Өөрөөр хэлбэл татварын өр хураахын тулд өртэй татвар төлөгч хөрөнгөтэй эсэх, хөрөнгөтэй бол түүний байршил, төрөл, тоо хэмжээ, үнэ цэнэ, ашиглалтын байдал, гуравдагч этгээдийн эрхийн оролцоотой эсэх зэргийг судлах шаардлагатай үед хэрэгжүүлэх боломжтой ажиллагааг хэлж байгаа юм.

- Хэнээс асуулга явуулга вэ?

Дараах этгээдэд асуулга явуулах боломжтой (ТЕХ-ийн 59.2).

а. Өртэй татвар төлөгч

б. Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг мэдэлдээ байлгаж байгаа гуравдагч этгээд

в. Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг мэдэлдээ байлгаж байгаа болох нь тодорхой гэж үзэхэд хангалттай шалтгаан бүхий гуравдагч этгээд

г. Өртэй татвар төлөгчтэй авлага эсхүл өглөгийн харилцаатай болох нь тодорхой гэж үзэхэд хангалттай шалтгаан бүхий этгээд

д. Өртэй татвар төлөгчөөс хөрөнгө авсан болох нь тодорхой гэж үзэхэд хангалттай шалтгаан бүхий этгээд

е. Өртэй татвар төлөгчийн хувьцаа эзэмшигч эсхүл хөрөнгө оруулагч болох хуулийн этгээд

- Асуулга явуулах арга

Асуулгыг амаар эсхүл бичгээр явуулна.

- Асуулгын тэмдэглэл

Амаар эсхүл бичгээр асуулгад хариулсан хариулт чухал мэдээлэл байгаа тохиолдолд эсхүл тухайн хариулттай холбоотой цаашид зөрчил үүсэх магадлалтай бол түүнийг бичгээр тэмдэглэн үлдээх шаардлагатай байдаг. Энэхүү тэмдэглэлийг “асуулгын тэмдэглэл” гэж хэлдэг.

(3) Шалгалт

б. Шалгалт нь өртэй татвар төлөгчид харьяалагдах хөрөнгийг илрүүлэх, тухайн харьяалалтай холбоотой баримт, нотолгоог цуглуулах, эрхийн шилжилт хөдөлгөөн байгаа эсэх болон татварын өр хураах ажиллагаагаар нэмэлт хөрөнгө байгаа эсэхтэй холбоотой материал цуглуулахыг зорилгоо болгон хэрэгжүүлдэг ажиллагаа юм.

Үр дүнтэй шалгалт хийхийн тулд шалгах асуудлууд, бүртгэлийн бичиг баримт, дэс дараалалыг өмнөөс төлөвлөх шаардлагатай.

- Шалгалт хийх боломжтой тохиолдол

Өмнөх хэсгийн “асуулга явуулах боломжтой тохиолдол”-той адил тохиолдолд шалгалт хийх боломжтой.

- Юунд шалгалт хийх боломжтой вэ?

Өмнөх хэсэг буюу 2-ын (2)-т заасан этгээдийн хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн бичиг баримтыг шалгах боломжтой. Энэ тохиолдолд “хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн бичиг баримт” гэдэг нь бэлэн мөнгөний орлого, зарлагын дэвтэр, дансны өглөгийн дэвтэр, газар болон байшин барилгыг түрээслэх гэрээ, хадгаламжийн дэвтэр, худалдах/худалдан авах гэрээ, хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, авлага өглөг эсхүл хөрөнгийн байдлыг тодорхой болгоход шаардлагатай баримт бичгийг (цахим бүртгэл хамаарна) хэлнэ.

- Шалгалт хийх арга

Өртэй татвар төлөгч зэрэг этгээдийн хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн бичиг баримтыг үзүүлж шалгалтыг хийнэ. Шалгалтын явцад тодруулах зүйл гарвал асуулга явуулан тодорхой болгох нь маш чухал юм.

в. Асуулга, шалгалттай холбоотой хариуцлага

Асуулга, шалгалтад хариулт өгөхгүй, саад учруулсан тохиолдолд тухайн этгээдэд хариуцлага тооцно. (ТЕХ-ийн 75.1.5)

(3) Үзлэг хийх

Үзлэг хийх гэдэг нь асуулга, шалгалт явуулахад хамтарч ажиллахгүйгээс хөрөнгийн байдлыг тодруулж чадаагүй эсхүл асуулга шалгалт явуулсан ч олж илрүүлж чадаагүй тохиолдолд өртэй татвар төлөгчийн эд зүйл эсхүл орон байр болон бусад газраас битүүмжилбэл зохих хөрөнгийн илрүүлэх зорилгоор хийгддэг ажиллагаа юм.

Үзлэг хийхдээ нөгөө талын нөхцөл байдлыг бодолцон, урьдчилан үзлэг хийх хугацаа, байршил, арга, дараалал зэргийг хангалттай сайтар төлөвлөж бэлдэх нь чухал байдаг. Үзлэг нь бичиг баримт, санхүүгийн байгууллага зэрэг газруудын судалгаа болон асуулга, шалгалтаар битүүмжилбэл зохих хөрөнгийг илрүүлж чадаагүй тохиолдолд өртэй татвар төлөгчийн оршин суугаа газар болон бусад хөрөнгөө нуусан байх магадлалтай газарт орон судалгаа хийх боломжтой. Мөн өртэй татвартай төлөгчийн хөрөнгийг гуравдагч этгээд эсхүл тусгай харилцан хамааралтай этгээд эзэмшиж байгаа тохиолдолд ч мөн зөвшөөрөгддөг.

- Үзлэг хийх боломжтой тохиолдол

Татварын өр хураах ажиллагаанд шаардлагатай тохиолдолд өртэй татвар төлөгчийн оршин суугаа газар болон хөрөнгөө нуусан байх магадлалтай бусад газарт үзлэг хийж болно (ТЕХ-ийн 59.5). Хөрөнгөө нуусан байх магадлалтай газарт жишээ нь сейф, түрээсийн сейф, шүүгээ, цүнх зэрэг багтана.

- Үзлэг хийх арга

Үзлэг хийх явцад шаардлагатай бол түгжээтэй байгаа хаалга, сейф болон бусад агуулах, савыг онгойлгуулах, эсхүл татвар хураалтын байцаагч өөрөө онгойлгохын тулд шаардлагатай арга хэмжээг авч болно (ТЕХ-ийн 59.6).

- Үзлэг хийх цаг

Үзлэгийг зарчмын хувьд нар шингэхээс нар мандах хугацаанд хийхгүй. Гэхдээ нар шингэхээс өмнө эхлүүлсэн үзлэгийг нар шингэсний дараа ч гэсэн үргэлжлүүлж болно. Мөн зочид буудал, хоолны газар болон бусад оройгоор ч гэсэн орж гарах боломжтой газарт (уушын газар, шөнийн цэнгээний газар, кино театр г.м) татварын өр хураахад шаардлагатай гэж үзэхэд хангалттай шалтгаан байгаа бол тухайн газрыг онгорхой байгаа хугацаанд үзлэг хийж болно.

- Үзлэгийн үед байлцах хөндлөнгийн гэрч

Үзлэгийн үед 18-аас дээш насны, хангалттай ойлголттой бөгөөд татвар төлөгч, татварын алба, татварын байцаагчтай хамаарал байхгүй, ашиг сонирхлын зөрчилгүй гуравдагч этгээдийг хөндлөнгийн гэрчийн үүднээс байлцуулна. Мөн үзлэг хийж буй

хөрөнгийн өмчлөгч эсхүл тухайн хууль ёсны төлөөлөгч эсхүл тухайн орон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулна (ТЕХ-ийн 59.3, 50.1, 50.2).

- Үзлэгийн акт үйлдэх

Үзлэг хийсэн тохиолдолд үзлэгийн актыг үйлдэн, оролцсон этгээд болон хөндлөнгийн гэрчийн гарын үсгийг зуруулна. Хэрэв гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг тайлбарлах боломж олгох ба актад хавсаргана (ТЕХ-ийн 59.3, 50.3). Гэхдээ үзлэгээр битүүмжлэл хийсэн бол битүүмжлэлийн акт үйлдэн түүндээ үзлэг хийсэн болохыг тусгаснаар үзлэгийн акт үйлдэх шаардлагагүй болно. Үзлэгийн акт үйлдсэн тохиолдолд хуулбарыг үзлэг хийлгүүлсэн өртэй татвар төлөгч эсхүл гуравдагч этгээд болон эдгээр этгээдээс гадна байсан хөндлөнгийн гэрчид хүргүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙН БИТҮҮМЖЛЭЛ

Татварын өр үүссэн тохиолдолд татварын байцаагч гүйцэтгэлийн бие даасан эрхийн дагуу татварын өр хураах ажиллагааг хэрэгжүүлнэ. (ТЕХ-ийн 50 дугаар зүйл)

Энэхүү бие даан хэрэгжүүлэх татварын өр хураах ажиллагаа гэдэг нь битүүмжлэлээр эхлэн мөнгөн хэлбэрт шилжүүлэх, шилжүүлсэн орлогыг хуваарилснаар дуусдаг үргэлжилсэн үйл явцыг хэлж байгаа ба татварын өрийг хурдан шуурхай хураахад зорилго нь оршино.

Хөрөнгийг битүүмжлэхэд өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг захиран зарцуулах эрх нь хязгаарлагдах тул амьдрал болон үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд нь том нөлөөг үзүүлдэг. Иймд битүүмжлэлийг зөв зохистой, анхаарал болгоомжтойгоор хэрэгжүүлэхгүй бол болохгүй. Ялангуяа битүүмжлэлийг эхлүүлэхдээ татвар хураалтад саад хохирол учруулахаас бусад тохиолдолд урьдчилан өртэй татвар төлөгчид битүүмжлэх гэж байгаагаа мэдэгдэх болохыг сайтар анхаарах нь зүйтэй.

1. Битүүмжлэх нөхцөл

Татвар төлөгч (өв залгамжлагч, татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд, батлан даагчид хамаарна) нь нэхэмжлэхэд (татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд, батлан даагчийн хувьд агуулга нь бага зэрэг өөр байна) заасан хугацаанд (нэхэмжлэх хүргүүлснээс хойш ажлын 10 өдрийн дотор) тухайн нэхэмжилсэн татварын өрийг бүрэн төлж барагдуулаагүй бол (ТЕХ-ийн 55.1.1, 55.1.3) зарчмын хувьд битүүмжлэх боломжтой болно.

* Нэхэмжлэх хүргүүлсэн өдрийг 1 дүгээр өдөр гэж үзэн, 11 дэх өдөр болоход (зөвхөн ажлын өдрүүдийг тооцно) битүүмжлэх боломжтой болно.

* Эрсдэлтэй татварыг урьдчилан хураах тохиолдолд нэхэмжлэл шаардлагагүйгээр битүүмжлэх боломжтой (ТЕХ-ийн 55.1.2). Мөн, нэхэмжлэх хүргүүлсэн өдрөөс хойш тооцоолон 10 өдрийн дотор эрсдэлтэй татварыг урьдчилан хураахад хамаарах нөхцөл байдал үүссэн бол даруй битүүмжлэх боломжтой (ТЕХ-ийн 55.1.4).

2. Битүүмжлэлд тавих хязгаарлалт

Татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдэлж байхад болон гомдол гарсан тохиолдолд битүүмжлэх боломжгүй ба хэтрүүлэн битүүмжлэх, үр ашиггүй битүүмжлэл хийхийг хориглосон байгаа.

(1) Хэтрүүлэн битүүмжлэхийг хориглох нь

Татварын өрийг хураахад шаардлагатай хөрөнгөөс илүү хөрөнгийг битүүмжилж болохгүй. (ТЕХ-ийн 60.5)

Иймд битүүмжлэх боломжтой хөрөнгийн хамрах хүрээ нь битүүмжлэлд хамаарах татварын өрийн хэмжээнд хүрэлцэх үнэ цэнэтэй хөрөнгөөр хязгаарлагдах ба

битүүмжлэх үед хөрөнгийн борлуулахаар төлөвлөж буй үнэ болон хураавал зохих татварын өрийн хэмжээг харьцуулан ямар хөрөнгийг битүүмжлэхээ тогтоно.

* Борлуулахаар төлөвлөж буй үнэ гэдэг нь тухайн хөрөнгийн хувьд татвараас давуу эрхтэй ипотекийн барьцааны эрх зэрэг эрхүүд байгаа бол тэдгээр давуу эрхээр эхэнд хуваарилагдах авлагын дүнг хасаж тооцсон дүнг хэлнэ.

* Өөр битүүмжлэхэд тохиромжтой хөрөнгөгүй ба 1 ширхэг хөрөнгийг битүүмжлэх бол тухайн хөрөнгийн үнэ хураавал зохих татварын өрийн хэмжээнээс их байсан ч хэтрүүлэн битүүмжилсэнд тооцохгүй.

(2) Үр ашиггүй битүүмжлэлийг хориглох нь

Битүүмжлэх гэж буй хөрөнгийн борлуулахаар төлөвлөсөн үнэ нь тухайн битүүмжлэлд хамаарах татварын хураалтын ажиллагааны зардал болон хураавал зохих татвараас түрүүлж хуваарилагдах авлагын нийт дүнгээс хэтрэхээргүй байвал тухайн хөрөнгийг битүүмжилж болохгүй (ТЕХ-ийн 60.6).

*Татвараас давуу эрхтэй авлага төлөгдөх зэргээс шалтгаалан авлагын дүн өөрчлөгдөх тохиолдол байдаг тул тодорхой зохистой давтамжтайгаар дахин тооцоолж, шалгах шаардлагатай байдаг.

3. Битүүмжлэх боломжтой хөрөнгө болон битүүмжлэх хөрөнгийг сонгох

(1) Битүүмжлэх боломжтой хөрөнгө

Битүүмжлэлийг хэрэгжүүлэх үед дараах нөхцлүүд бүрдсэн байх хэрэгтэй.

- Хөрөнгө нь ТЕХ хэрэгжих нутаг дэвсгэрт (Монгол Улсад) байх

ТЕХ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөнө. Иймд өртэй татвар төлөгчийн гадаад улсын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгийг битүүмжлэх боломжгүй.

- Хөрөнгө нь өртэй татвар төлөгчид харьяалагддаг байх

Хөрөнгө нь өртэй татвар төлөгчид харьяалагдаж байвал бүртгэлтэй нэр эсхүл эзэмшигч нь хэн байх нь хамаагүй.

- Хөрөнгө нь мөнгөн дүнгээр хэмжигдэх үнэ цэнэтэй байх

Битүүмжлэх боломжтой хөрөнгө нь эцсийн дүндээ мөнгөн хэлбэрт шилжүүлж, шилжүүлсэн орлогоос татварын өрийг хураах зорилготой хөрөнгө тул мөнгөн дүнгээр хэмжигдэх үнэ цэнэтэй байхгүй бол болохгүй.

* Мөнгө эсхүл эд зүйлээр төлөгдөхгүй (жишээ нь үзүүлбэр үзүүлэх г.м) авлага нь мөнгөн дүнгээр хэмжигдэх үнэ цэнэгүй гэж үзэх тул битүүмжлэх боломжгүй юм.

- Хөрөнгийг бусдад шилжүүлэх боломжтой байх

Татварын өр хураах ажиллагаагаар битүүмжилсэн хөрөнгийг худалдан борлуулах эсхүл хураах гэсэн 2 аргаар мөнгөн хэлбэрт шилжүүлдэг тул битүүмжлэх боломжтой хөрөнгө

нь шилжүүлэх эсхүл хураах боломжтой байх шаардлагатай.

* Өртэй татвар төлөгчид хамаарах онцгой эрхийг (онцгой эрх гэдэг нь жишээ нь өв залгамжлал) бусдад шилжүүлж болохгүй тул битүүмжлэх боломжтой хөрөнгөд тооцохгүй.

- Битүүмжлэхийг хориглосон хөрөнгө биш байх

Зарим тодорхой хөрөнгийг хуулиар битүүмжлэхийг хориглосон байдаг. ТЭХ-нд битүүмжлэхийг хориглосон хөрөнгө (ТЭХ-ийн 61 дүгээр зүйл), цалин хөлсний тодорхой хэмжээг хориглосон (ТЭХ-ийн 64.6.6) заалтууд байгаа. Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад хуулийн дагуу битүүмжлэхийг хориглосон хөрөнгийг заасан байдаг тул тэдгээрийг харгалзаж, анхаарах шаардлагатай.

(2) Битүүмжлэх хөрөнгийг сонгох

ТЭХ-ийн 55.2 заалтын хувьд нэхэмжлэх хүргүүлсний дараагийн алхам нь “татварын өрийг албадлагаар хураах” ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан байгаа тул хураалтад саад, хохирол учруулах нь тодорхой байх тохиолдлоос бусад үед эхлээд “банкны данс”-ыг битүүмжилнэ.

Дээрхээс бусад тохиолдолд ямар хөрөнгийг битүүмжлэх үү гэдэг нь татварын байцаагчийн эрхийн асуудал юм. Хэдий тийм боловч битүүмжлэл нь өртэй татвар төлөгч болон гуравдагч этгээдийн эрхэд томоохон нөлөө үзүүлэх тул дараах зарчмыг баримтлан анхааралтай хэрэгжүүлэхгүй бол болохгүй.

- Гуравдагч этгээдийн эрхэд хамгийн бага хохирол учруулах хөрөнгөөс эхэлж сонгох

Татварын өр хураах ажиллагаанд саадтай байх, хохирол учруулахаас бусад тохиолдолд аль болох тухайн хөрөнгөд хамаарах гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүй байхаар хэрэгжүүлнэ (ТЭХ-ийн 60.2). Мөн, тодорхой заасан нөхцөлд нийцэж байвал гуравдагч этгээдээс битүүмжилсэн хөрөнгийг солих хүсэлт гаргаж болно (ТЭХ-ийн 60.3).

* Өв залгамжлуулагч татварын өртэй ба түүний өв залгамжлагчийн хөрөнгийг битүүмжлэх тохиолдолд өв залгамжлагчийн эрхийг хамгаалах үүднээс татварын өр хураах ажиллагаанд саад, хохирол учруулахаас бусад үед залгамжилж авсан хөрөнгөөс нь эхэлж битүүмжилнэ.

- Өртэй татвар төлөгчийн амьдрал болон үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд нь аль болох бага нөлөөлөх хөрөнгөөс эхэлж сонгох

Татварын өр хураах ажиллагаанд саад, хохирол учруулахаас бусад тохиолдолд өртэй татвар төлөгчийн амьдрал болон үйл ажиллагаанд бага нөлөөлөх хөрөнгийг сонгоно.

- Мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар байх хөрөнгөөс эхэлж сонгох (ТЭХ-ийн 60.4)

4. Хөрөнгийн хамаарлыг тогтоох

(1) Ердийн тохиолдолд хамаарал тогтоох

Хөрөнгийг өртэй татвар төлөгчид харьяалагдах эсэхийг тогтоохдоо дараахыг харгалзан тогтооно.

- Хөдлөх хөрөнгө, үнэт цаас...Өртэй татвар төлөгчийн эзэмшилд байгаа эсэх
- Бүртгэлтэй улсын бонд, компанийн бонд зэрэг...Өртэй татвар төлөгчийн нэр дээр бүртгэлтэй байгаа эсэх
- Үл хөдлөх хөрөнгө, автомашин, агаарын хөлөг зэрэг бүртгэх тогтолцоо бүрдсэн хөрөнгө...Бүртгэл нь өртэй татвар төлөгчийн нэр дээр эсэх
- Бүртгэлгүй үл хөдлөх хөрөнгө...Бодит байдал дээр мэдэлдээ байлгаж байгаа, бүртгэлийн аливаа бичиг баримтаар өртэй татвар төлөгчид харьяалагдах болох нь тодорхой байгаа эсэх
- Компани зэрэг хуулийн этгээдийн хувь...Өртэй татвар төлөгч нь компанийн дүрэм эсхүл бүртгэлийн бичиг баримт, ажилтны бүртгэл зэргээс харахад эзэмшигч нь эсэх
- Банкны данс...Дансны дэвтэрээс данс нь өртэй татвар төлөгчид харьяалагдах нь тодорхой байгаа эсэх
- Авлага...Авлагын бүртгэл болон бусад хамааралтай бүртгэх бичиг баримтаар өртэй татвар төлөгчид харьяалагдах нь тодорхой байгаа эсэх

(2) Өөр хүний нэр дээрх хөрөнгийн хамаарал

Хөдлөх хөрөнгө, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө эсхүл хувьцаа зэргийн хувьд эдгээрийг эзэмшиж буй этгээд болон бүртгэлийн нэр нь өртэй татвар төлөгч биш байсан ч бүртгэх бичиг баримт, мэдэгдэл, тушаал зэрэгт үндэслэн дараах бодит байдал байгаа нь тодорхой бол тухайн хөрөнгийг өртэй татвар төлөгчид харьяалагдана гэж үзнэ.

- Тухайн хөрөнгийг худалдах, бэлэглэх, солилцох, хөрөнгө оруулах, хөрөнгөөр орлуулан төлөх зэргээр өртэй татвар төлөгчид шилжүүлсэн бол
- Өртэй татвар төлөгч тухайн хөрөнгийг арилжааг урвуулан ашиглах зэргээр хүчин төгөлдөр бус үйлдлээр шилжүүлсэн
- Өв залгамжлал, компани нэгдэх зэргээр хөрөнгийн өмчлөлийн эрх өртэй татвар төлөгчид шилжсэн
- Эрх нь өртэй татвар төлөгчид харьяалагдах боловч өөр этгээдийн нэр дээр байвал

* Бүртгэл хийгддэг тогтолцоо нь бүрдсэн хөрөнгө өөр хүний нэр дээр бүртгэгдсэн ба тухайн хөрөнгийг битүүмжлэх тохиолдолд өртэй татвар төлөгчийн нэр болгон шилжүүлсний дараа битүүмжлэлийг нь бүртгүүлэх боломжтой болно.

* Эхнэр/нөхөр эсхүл хамтран амьдарч буй гэр бүлийн гишүүний хөрөнгийн хамаарлыг

тогтоохдоо өртэй татвар төлөгчийн эхнэр/нөхөр эсхүл хамтран амьдарч буй гэр бүлийн гишүүн нь дангаараа өртэй татвар төлөгчийн хөрөнгө эсхүл орлогоор амьдардаг ба тухайн татвар төлөгчийн оршин суугаа газрын хөрөнгө бөгөөд дор дурдсанаас бусад хөрөнгийг өртэй татвар төлөгчид харьяалагдана гэж үзэхэд асуудалгүй.

- Гэрлэлтээ батлуулахын өмнөөс байсан эхнэр/нөхрийн хөрөнгө болон гэрлэлтээ батлуулсан хугацаанд өөрийн нэр дээр олж авсан хөрөнгө
- Гэрлэлтийн хөрөнгийн гэрээгээр өмчилж буй эхнэр/нөхрийн хөрөнгө
- Дээрхээс бусад эхнэр/нөхрийн эсхүл хамтран амьдардаг гэр бүлийн гишүүний дангаараа ашигладаг хөрөнгө
- Эхнэр/нөхрийн алинд нь харьяалагдах болох нь тодорхойгүй хөрөнгийн хувьд эхнэр/нөхрийн эзэмших хувь хэмжээг

5. Битүүмжлэлийн нийтлэг үйл ажиллагаа

ТЕХ-д хөрөнгийг 1)Хөдлөх хөрөнгө, үнэт цаас, 2) Банкны данс, 3)Авлага, 4)Үл хөдлөх хөрөнгө, агаарын хөлөг, автомашин болон барилгын тоног төхөөрөмж, 5) Биет бус хөрөнгө хэмээн 5 ангилан тус бүрд нь битүүмжлэх ажиллагааг заасан байгаа.

Бүх хөрөнгийн хувьд дараах битүүмжлэх ажиллагааг нийтлэгээр дагаж мөрдөнө.

(1) Битүүмжлэлийн акт үйлдэх

Хөрөнгө битүүмжилсэн тохиолдолд битүүмжлэлийн гүйцэтгэлийг бүртгэн, баримт болгох зорилгоор битүүмжилсэн хөрөнгө ямар ангилалд байхаас үл хамааран битүүмжлэлийн актыг (Журмын ...-р маягт) заавал үйлдэнэ. (ТЕХ-ийн 60.7)

(2) Битүүмжлэлийн актын агуулга

Битүүмжлэлийн актад татварын байцаагч дараах зүйлсийг тусган, татварын албаны даргаар батлуулсан байна.

- Өртэй татвар төлөгчийн нэр болон хаяг эсхүл байршил
- Битүүмжлэлд хамаарах татварын өрийн тайлант он, татварын төрөл, төлөх хугацаа болон хэмжээ
- Битүүмжилсэн хөрөнгийн нэр, тоо хэмжээ, шинж чанар болон байршил
- Үйлдсэн огноо

(3) Битүүмжлэлийн актын хуулбарыг хүргүүлэх

Дараах хөрөнгийг битүүмжилсэн бол битүүмжлэлийн актын хуулбарыг өртэй татвар төлөгчид хүргүүлнэ.

- Хөдлөх хөрөнгө, үнэт цаас
- Банкны данс
- Авлага
- Гуравдагч өглөгтэй этгээд бүхий биет бус хөрөнгө

(4) Барьцааны эрхтэй этгээдэд битүүмжлэлийг мэдэгдэх

Дараах хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд тус тусын татварын албанд мэдэгдэж байгаа эрх бүхий этгээдэд (барьцааны эрхтэй этгээд г.м) бичгээр битүүмжилсэн болохыг болон бусад шаардлагатай зүйлсийг мэдэгдэнэ (...-р маягт). Энэ нь барьцааны эрхтэй этгээд зэрэг битүүмжилсэн хөрөнгийг солихыг хүсэлт гаргах боломжтой гуравдагч этгээдэд эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгох зорилготой юм.

- Барьцаа, ипотекийн барьцааны эрх болон бусад гуравдагч этгээдийн эрхтэй хөрөнгө.....эдгээр эрх бүхий этгээд
- Урьдчилсан бүртгэлтэй хөрөнгө.....урьдчилсан бүртгэлийн эрхтэй этгээд

6. Битүүмжлэлийн үйлчлэл

(1) Ердийн тохиолдол дахь битүүмжлэлийн үйлчлэл

Битүүмжлэлийн үйлчлэл нь хөрөнгийн ангилал, шинж чанараас хамааран өөр өөр байх ба ердийн тохиолдолд үйлчлэл нь дараах тохиолдолд үүснэ.

- Захиран зарцуулалтыг хориглох үйлчлэл

Битүүмжлэлд тухайн битүүмжилсэн хөрөнгийг хуулийн хүрээнд (жишээ нь худалдах, бэлэглэх, барьцаанд тавих) эсхүл бодит байдал дээр (эвдэлж гэмтээх, устгах) захиран зарцуулахыг нь хориглосон үйлчлэл бий. Гэхдээ энэ захиран зарцуулалтыг хориглосон үйлчлэл нь битүүмжлэлд авлагатай талд (улс) давуу бөгөөд битүүмжилсний дараа улстай заргалдах боломжгүй боловч тухайн оролцогч талуудад бол хүчин төгөлдөр байна.

* Өртэй татвар төлөгч битүүмжилсэн хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлэх нь тухайн оролцогч талуудын хувьд хүчин төгөлдөр байна. Харин битүүмжлэлийн авлагатай этгээд болох улсын хувьд өмчлөх эрхийг өөрт шилжүүлж авах боломжгүй учир анхнаасаа эрхийн шилжүүлэг хийгдээгүй гэж үзэн битүүмжилсэн хөрөнгийг олон нийтэд худалдах боломжтой.

* Битүүмжлэлийн авлагатай тал буюу Улсад ашиггүй байх захиран зарцуулалтыг битүүмжлэлээр хязгаарлах ба битүүмжилсэн хөрөнгийг түрээсийг нь цуцлах, битүүмжилсэн хөрөнгийг засаж сайжруулах зэрэг ашигтай байх үйлдлийг бол хийх боломжтой.

- Өв залгамжлалтай тохиолдлын үйлчлэл

Битүүмжилсний дараа өртэй татвар төлөгч нас барах, ААН нэгдэх зэргээр байхгүй болсон бол өв залгамжлагч эсхүл компанийн нэгдлээр үргэлжлүүлэн авч явах компанид нь татварын өр хураах ажиллагааг хэрэгжүүлж болно.

(2) Битүүмжлэлийн үйлчлэл өргөжих хүрээ

А. Туслах эд юмс

Үндсэн хөрөнгийг (жишээ нь барилга) битүүмжилсэн тохиолдолд туслах эд юмсад (жишээ нь барилгын туслах хэсэг) битүүмжлэлийн үйлчлэл үйлчилнэ (Иргэний хуулийн ...-р заалт).

В. Үр шим

- Байгалийн үр шим (natural fruit)

Битүүмжлэлийн үйлчлэл нь битүүмжилсэн хөрөнгөөс (жишээ нь жимсний мод, мал) үүссэн байгалийн үр шимд (жишээ нь жимс, төл) мөн хамаарна. Иймд эдгээр тохиолдолд үүссэн байгалийн үр шимийг шинээр битүүмжлэх шаардлагагүй.

- Хуулийн үр шим (civil fruit)

Битүүмжлэлийн үйлчлэл нь битүүмжилсэн хөрөнгөөс (жишээ нь барилга) үүсэх хуулийн үр шимд (жишээ нь түрээсийн төлбөр) хамаарахгүй. Иймд жишээ нь барилга битүүмжилсэн тохиолдолд түрээсийн төлбөрийг нь хураах шаардлагатай тохиолдолд тусад нь түрээсийг нь нэмж битүүмжлэхгүй бол болохгүй.

Гэхдээ авлага битүүмжилсэн тохиолдолд битүүмжилсний дараа орж ирэх хүүгийн орлогод битүүмжлэлийн үйлчлэл үйлчилнэ гэж үзнэ.

(3) Хохирлын даатгалыг нэхэмжлэх эрх

Битүүмжилсэн хөрөнгийг даатгуулсан байгаа бол тухайн битүүмжлэлийн үйлчлэл нь даатгалын төлбөр авах эрхэд үйлчилнэ. Гэхдээ хөрөнгийг битүүмжилсэн болохыг даатгасан этгээдэд мэдэгдээгүй тохиолдолд тухайн битүүмжлэлтэй холбоотойгоор даатгасан этгээдтэй заргалдах эрхгүй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙН ТӨРӨЛ ТУС БҮРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ БИТҮҮМЖЛЭЛИЙН АЖИЛЛАГАА

Нэгдүгээр хэсэг. Хөдлөх хөрөнгө, үнэт цаасны битүүмжлэл

1. Хөдлөх хөрөнгийн тодорхойлолт

ТЕХ-д хөдлөх хөрөнгө гэдгийг Иргэний хуульд заасан хөдлөх эд хөрөнгөөс ТЕХ-ийн 65 дугаар зүйлд заасан агаарын хөлөг, автомашин болон барилгын тоног төхөөрөмжийг хассанаар ойлгоно.

* Дараах хөрөнгийг хөдлөх хөрөнгө гэж үзэн битүүмжилнэ.

- Мөнгөн хөрөнгө, гадаадын валют болон бэлэн мөнгөний эрхийн бичиг
- Баригдаж дуусаагүй байгаа барилга (Бүртгэх боломжгүй шатанд байгаа барилга)
- Салгаагүй байгаа үр шим (Хөдлөх хөрөнгө гэж үзэн арилжаалагдах хөрөнгө)
- Бүртгэгдээгүй агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмж

2. Үнэт цаасны тодорхойлолт

Үнэт цаасанд хөрөнгийн эрхийг баталсан эрхийн бичиг, тухайн эрхийг хэрэгжүүлэх эсхүл шилжүүлэхэд ашигладаг зүйл болон Үнэт цаасны тухай хуулийн 5.1-д заасан санхүүгийн хэрэгсэл багтана.

* Үнэт цааснаас жишээлбэл ① чек, ② вексель, ③ бүтээгдэхүүний ваучер г.м.

* Зээлийн баримт эсхүл хүлээн авсан баримттай адил баримт бичгийг үнэт цаас гэж үзэхгүй.

3. Хөдлөх хөрөнгө, үнэт цаасны судалгаа

Хөдлөх хөрөнгө болон үнэт цаасны битүүмжлэлийг тухайн хөрөнгийн хэлбэр, үнэ цэнэ, мөнгөн хэлбэрт хөрвөх чанар, гуравдагч этгээдийн эрхийн харилцаа байгаа эсэхийг судлан битүүмжлэхэд тохиромжтой хөрөнгө мөн эсэхийг сайтар бодолцож хэрэгжүүлдэг.

* Гэр бүлийн хэрэгцээний хөдлөх хөрөнгө нь тансаг зэрэглэлийн эд зүйл байсан ч үнэ цэнэ нь буурах тохиолдол ихэнхдээ гардаг. Нөгөө талаас өнгөцөөр дүгнэхэд үнэ цэнэ бага мэт харагдсан ч уран зураг, эртний эдлэл, тансаг эдлэл зэрэг өндөр үнэ хүрэх эд юмс байх тохиолдол бий тул сайтар судлах шаардлага гардаг.

4. Битүүмжлэх ажиллагаа

(1) Өртэй татвар төлөгчийн мэдэлд байгаа хөдлөх хөрөнгө, үнэт цаас

Хөдлөх хөрөнгө болон үнэт цаасыг битүүмжлэхдээ татварын байцаагч мэдэлдээ авч хэрэгжүүлдэг (ТЕХ-ийн 62.1).

* “Мэдэлдээ авах” гэдэг нь татварын байцаагч тухайн хөрөнгийг битүүмжлэх зорилгоор

өөрийн удирдлагад авахыг хэлнэ.

(2) Гуравдагч этгээдийн эзэмшиж буй хөдлөх хөрөнгө болон үнэт цаасыг битүүмжлэх Гуравдагч этгээдээс шилжүүлж авсны дараа тухайн хөрөнгийг (1)-д заасны адилаар битүүмжлэх боловч тухайн гуравдагч этгээд нь татварын албанд шилжүүлэхээс татгалзсан тохиолдолд битүүмжлэх боломжгүй болдог (ТЕХ-ийн 61.3).

Гэхдээ энэ тохиолдолд өртэй татвар төлөгчид өөр мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар бөгөөд татварын өрийн нийт хэмжээг хураах боломжтой хөрөнгө байхгүй бол хугацаа (ажлын 5 өдрийн дотор) заан, бичгээр шилжүүлэхийг тушааснаар шилжүүлж аван битүүмжлэх боломжтой (ТЕХ-ийн 62.5).

Мөн шилжүүлэхийг тушаасан хугацаанд шилжүүлэхгүй бол шууд битүүмжилж болно (ТЕХ-ийн 62.6).

(3) Битүүмжлэлийн акт үйлдэх

Хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг битүүмжилсэн тохиолдолд битүүмжлэлийн акт (...-р маягт) үйлдэж, хуулбарыг өртэй татвар төлөгчид хүргүүлнэ (ТЕХ-ийн 60.7).

Үзлэг, шалгалтаар олсон хөдлөх хөрөнгө эсхүл үнэт цаасыг битүүмжилсэн бол хөндлөнгийн гэрч зэрэг хамааралтай этгээдэд битүүмжлэлийн актын хуулбарыг хүргүүлнэ.

5. Хадгалалт, зөөвөрлөлт

(Өртэй татвар төлөгчид эсхүл гуравдагч этгээдэд хадгалуулах)

Хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг битүүмжилсэн тохиолдолд шаардлагатай бол татварын байцаагч тухайн хөрөнгийг өртэй татвар төлөгч эсхүл тухайн хөрөнгийг мэдэлдээ байлгаж байгаа гуравдагч этгээдэд хадгалуулах боломжтой. Энэ тохиолдолд татварын байцаагч өөрөө тамга, тэмдэглэгээ эсхүл олон нийтэд мэдэгдэх хуудас зэргээр (...-р маягт) битүүмжилсэн хөрөнгө болохыг нь тодорхой заахгүй бол болохгүй.

(Зөөвөрлөлт)

Битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг өртэй татвар төлөгч эсхүл тухайн хөрөнгийг мэдэлдээ байлгаж буй гуравдагч этгээдэд хадгалуулахгүй тохиолдолд даруй зөөвөрлөнө. Битүүмжилсний дараа зөөвөрлөсөн тохиолдолд битүүмжлэлийн актад зөөвөрлөсөн тухай тусгаснаар “зөөвөрлөлтийн акт” болгон өөрчлөх боломжтой болно. Хадгалуулсан байсан ч шаардлагатай тохиолдолд зөөвөрлөлт хийх тохиолдол гардаг. Зөөвөрлөсөн бол татварын байцаагч “зөөвөрлөлтийн акт” (...-р маягт)-ыг үйлдэн, гарын үсэг зурж, өртэй татвар төлөгч эсхүл тухайн хөрөнгийг мэдэлдээ байлгаж буй гуравдагч этгээдэд хуулбарыг хүргүүлнэ.

* Хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг зөөвөрлөсөн бол татварын албанд хадгалах, эсхүл агуулах, хадгалах үйл ажиллагаа эрхлэгчид эсхүл бусад этгээдэд хадгалуулах

боломжтой юм.

6. Битүүмжлэлийн үйлчлэл

1) Үйлчлэл үүсэх хугацаа

Битүүмжлэлийн үйлчлэл нь татварын байцаагч тухайн хөрөнгийг мэдэлдээ авах үед үүснэ.

Гэхдээ тухайн хөрөнгийг өртэй татвар төлөгч, эсхүл мэдэлдээ байлгаж байгаа гуравдагч этгээдэд хадгалуулж байгаа бол тэмдэг, тэмдэглэгээ эсхүл олон нийтэд ил болгох хуудас зэргээр битүүмжилсэн болохыг тодорхой болгох үед үйлчлэл нь үүснэ (ТЕХ-ийн 62.8).

2) Мөнгөн хөрөнгийн битүүмжлэлийн үйлчлэл

Бэлэн мөнгийг битүүмжилсэн тохиолдолд тухайн битүүмжилсэн хэмжээгээр хязгаарлан өртэй татвар төлөгчөөс битүүмжлэлд хамаарах татварын өрийг хураасан гэж үзэн (ТЕХ-ийн 62.2), өртэй татвар төлөгчөөс хураасан мөнгийг даруй татварын орлогын дансанд хийнэ (ТЕХ-ийн 69.1.2).

* Хураасан гэж үзнэ гэдэг нь хураасан хэмжээгээр хязгаарлан тухайн битүүмжлэлд хамаарах татварын өрийг төлөх үүрэг нь устана гэсэн үг.

7. Битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг ашиглах, ашиг орлого олох

Битүүмжилсэн хөдлөх хөрөнгө нь устаж алга болох магадлал өндөр учир зарчмын хувьд битүүмжилсний дараа ашиглах эсхүл ашиг, орлого олохыг нь зөвшөөрөхгүй. Гэхдээ өртэй татвар төлөгч эсхүл гуравдагч этгээдэд битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг хадгалуулснаар хураалтад саад учруулахгүй болох нь тодорхой тохиолдолд ашиглах, ашиг орлого олохыг нь зөвшөөрч болно (ТЕХ-ийн 62.9).

8. Үнэт цааснаас мөнгөн хөрөнгийг гаргуулах

Битүүмжилсэн үнэт цаасанд хамаарах мөнгөн хөрөнгийн авлагыг хураахдаа үнэт цаасанд хамаарах мөнгөн хөрөнгийг гаргуулах хугацаа нь аль хэдийн болсон эсхүл ойрын хугацаанд болох гэж байгаа бөгөөд мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагаа хийснээс шууд гаргуулсан нь татвар хураалтын ажилд ашигтай болох нь тодорхой байвал хурааж, гаргуулна. Хэрэв хурааж чадахгүй тохиолдолд мөнгөн хэлбэрт шилжүүлэх аргаар гаргуулж авдаг (ТЕХ-ийн 62.3).

9. Гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах

Өртэй татвар төлөгчийн хөдлөх хөрөнгийг мэдэлдээ байлгаж байгаа гуравдагч этгээд битүүмжлэлээс болж тухайн хөрөнгийг татварын албанд шилжүүлснээр мэдэлдээ байлгах зорилгодоо хүрч чадахгүй болвол гэрээг цуцлах, эсхүл гэрээг цуцлахгүйгээр 3

сараар хязгаарлан тухайн хөрөнгийг ашиглах болон ашиг, орлого олохоо үргэлжлүүлэх гэсэн 2 сонголтоос сонгож болно.

Хоёрдугаар хэсэг. Татварын өрийг үл маргах журмаар хураах

(Банкны дансны битүүмжлэл)

1. Битүүмжлэх боломжтой банкны данс

Өртэй татвар төлөгчийн татварын өрийг хураах зорилгоор битүүмжлэх боломжтой банкны данс нь татвар төлөгчийн банкинд нээлгэсэн энгийн данс (харилцах хамаарна) болон хугацаатай данс байна.

2. Битүүмжлэх ажиллагаа

(1) Өртэй татвар төлөгчийн банкны дансыг битүүмжлэхдээ татварын өрийг өртэй татвар төлөгчийн банкны данснаас хураах тухай тусгаж, татварын албаны даргаар батлуулан, банкинд данс битүүмжлэх мэдэгдэх хуудсыг (...-р маягт) хүргүүлж хэрэгжүүлнэ (ТЕХ-ийн 64.1).

(2) Данс битүүмжлэх мэдэгдэх хуудсанд дараах зүйлсийг тусгана (ТЕХ-ийн 63.1.2).

- Өртэй татвар төлөгчийн нэр, хаяг болон байршил, татвар төлөгчийн дугаар
- Татварын өр хураах үндэслэл болон татварын өрийн хэмжээ
- Дансны төрөл болон мөнгөн дүн
- Банкны нэр, хаяг
- Зарлагын гүйлгээг бүрэн эсхүл хэсэгчилэн зогсоох тухай
- Битүүмжилсэн дансны мөнгийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар

3. Битүүмжлэлийн үйлчлэл үүсэх хугацаа

Битүүмжлэлийн үйлчлэл нь данс битүүмжлэх мэдэгдэх хуудсыг банкинд хүргүүлэх үед үүснэ (ТЕХ-ийн 63.1.1).

4. Банкны үүрэг

(1) Банк нь данс битүүмжлэх мэдэгдэх хуудасны дагуу татварын өртэй тэнцэх хэмжээг татварын албаны дансанд шилжүүлнэ (ТЕХ-ийн 63.1.3).

(2) Банк нь өртэй татвар төлөгчийн дансны үлдэгдэл нь данс битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан татварын өрийн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд тухайн данснаас гарах шүүхийн шийдвэртэй төлбөрийг оруулан зарлагын гүйлгээг бүрэн эсхүл хэсэгчилэн зогсоож, татварын өрийн битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан татварын албаны данс руу шилжүүлнэ (ТЕХ-ийн 63.1.4).

(3) Банк нь битүүмжлэлд хамаарах татварын өрийн хэмжээтэй тэнцэх мөнгийг шилжүүлсэн болохыг (нийт дүнгээр шилжүүлсэн эсхүл хэсэгчилэн шилжүүлсэн аль аль нь хамаарна) татварын албанд мэдэгдэнэ.

(4) Татварын алба (3)-д заасан мэдэгдэлд үндэслэн татварын өр бүрэн төлөгдөж битүүмжлэлийг цуцалсан бол ажлын 3 өдрийн дотор банкинд мэдэгдэнэ.

Гуравдугаар хэсэг. Авлагын битүүмжлэл

1. Авлагын тодорхойлолт

Битүүмжлэх авлага гэдэг нь мөнгөн хөрөнгө эсхүл мөнгөн хөрөнгөд шилжүүлэхэд зохистой хөрөнгөөр төлбөрийн гүйцэтгэлийг хийх авлагыг хэлж байгаа ба борлуулалтын орлого, банкны данс, түрээсийн төлбөр, цалин хөлс зэрэг авлагуудыг жишээ татаж болно.

Гэхдээ авлага гэж хэлж болох ч шинж чанар, хураахад тохиромжтой байдал, мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагаа хийж байж хураах авлагыг биет бус хөрөнгө гэж үзэн битүүмжилнэ.

2. Авлагыг сонгох

Авах нь тодорхой байгаа авлагыг сонгон битүүмжлэлийг хийх ба авах магадлал өндөр авлагад дараах авлагуудыг жишээ татаж болно.

- Хувь хүний үүднээс төрийн байгууллагаас авах авлага
- Жижиг ААН-ийн том ААН-ээс авах авлага
- Барьцаатай авлага

* Агуулгын хувьд адил авлагуудын хувьд аль хурдан авах боломжтой авлагаас эхэлж битүүмжилнэ.

3. Битүүмжлэх ажиллагаа

Авлага битүүмжилсэн тохилдолд гуравдагч өглөгтэй этгээдэд (өртэй татвар төлөгчид өглөгтэй этгээд) авлага битүүмжлэх мэдэгдэх хуудсыг (...-р маягт) хүргүүлнэ (ТЕХ-ийн 64.1).

* Авлага битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлнэ гэдэг нь авлагын битүүмжлэлийн үйлчлэл үүсэх урьдач нөхцөл тул биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар хүргүүлнэ.

Авлага битүүмжлэх мэдэгдэх хуудсанд авлагын гүйцэтгэл хийгдэх хугацаан бүрт татварын албанд шилжүүлэх тухай болон гүйцэтгэлийн хугацаа нь аль хэдийн болчихсон бол яаралтай татварын алба руу шилжүүлэх тухай тусгана. Өртэй татвар

төлөгчид битүүмжлэлийн актын хуулбарыг битүүмжилсний дараа хүргүүлэхийн зэрэгцээ авлагыг өөрт авах, шилжүүлэх болон бусад арга хэмжээ авахыг нь хориглох тухай тусгана (Журмын ...-р заалт).

4. Авлагыг тодорхойлох

Авлагыг битүүмжлэхдээ авлагатай этгээд (өртэй татвар төлөгч), авлагын төрөл, авлагын хэмжээ, төлбөрийн агуулга, авлага үүссэн хугацаа зэргийг тодорхой болгоно.

5. Битүүмжлэх авлагын хамрах хүрээ

Авлагыг битүүмжлэхдээ нийт авлагын хэмжээгээр битүүмжлэх боловч татварын өрийн хэмжээ нь авлагын хэмжээнээс бага бол хураавал зохих татварын өрийн хэмжээгээр битүүмжилж болно (ТЕХ-ийн 64.2).

* Татварын өрийн хэмжээ авлагын хэмжээнээс бага байсан ч гуравдагч өглөгтэй этгээдийн санхүүгийн чадвар, төлбөрийн баталгаа нь баттай биш, хэзээ төлөгдөх нь тодорхойгүй бол авлагыг хэсэгчилэн битүүмжилж болохгүй.

6. Авлагын баримт бичгийг хураах

Авлагыг битүүмжлэхэд шаардлагатай бол хөдлөх хөрөнгийг битүүмжлэх ажиллагааны адилаар тухайн авлагатай холбоотой баримт бичгийг (жишээ нь хэрэглээний зээлийн баримт бичиг, банкны дансны баталгаа г.м) хурааж авах боломжтой (ТЕХ-ийн 64.4). Энэ тохиолдолд татварын байцаагч тухайн авлагын баримт бичгийг өөрийн мэдэлд авна.

Авлагын баримт бичгийг хураасан тохиолдолд “хураалтын акт” (...-р маягт)-ыг үйлдэн, өртэй татвар төлөгч болон бусад энэ ажиллагаанд хамааралтай этгээдэд хуулбарыг хүргүүлнэ.

Гэхдээ баримт бичгийг хураахдаа битүүмжлэлийн акт эсхүл үзлэгийн, шалгалтын актыг үйлдэх үед эдгээр актад хураасан баримт бичгийн нэрс зэргийг бичиж түүнийгээ хураалтын акт гэж ойлгох боломжтой.

7. Авлагын битүүмжлэлийн үйлчлэл

(1) Үйлчлэл үүсэх хугацаа

Авлагын битүүмжлэлийн үйлчлэл нь гуравдагч өглөгтэй этгээдэд авлага битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргэгдэх үед үүснэ (ТЕХ-ийн 64.1).

(2) Авлагын гүйцэтгэлийг хориглох

Гуравдагч этгээд нь өртэй татвар төлөгчид авлагыг өгөхийг хориглоно.

(3) Авлагыг авахыг хориглох

Өртэй татвар төлөгч нь битүүмжилсний дараа тухайн авлагыг авах, шилжүүлэх, чөлөөлөх, хугацааг нь сунгах зэргийг хийх боломжгүй. Өртэй татвар төлөгч авлага үүсэх үндэслэл болсон гэрээг өөрчлөх эсхүл хүчингүй болгохыг хориглоно (ТЕХ-ийн 64.7).

Өртэй татвар төлөгчид хүргүүлэх битүүмжлэлийн актын хуулбарт тухайн авлагатай холбоотой дээрх арга хэмжээ авахыг хориглосон болохыг заасан байна.

* Өртэй татвар төлөгч тухайн авлагыг авчихсан бол гуравдагч өглөгтэй этгээд татварын албанд төлөх шаардлагатай болно.

(4) Тогтмол орлогын үйлчлэл

Цалин, тэтгэвэр, түрээсийн төлбөр зэрэг (цаашид “цалин хөлс зэрэг авлага” гэх) тогтмол орж ирэх орлогын авлагын битүүмжлэлийн үйлчлэл нь хураавал зохих татварын өрийн хэмжээгээр хязгаарлан, битүүмжилсний дараа орж ирэх орлогод үйлчилнэ (ТЕХ-ийн 64.3).

* Цалин хөлс зэрэг тогтмол орж ирэх авлагын хувьд түүнийг олгох үүрэгтэй хувь хүн эсхүл ААН-д авлага битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлэх ба битүүмжлэлд хамаарах татварын өрийн хэмжээгээр хүчинтэй байх тул орлого орж ирэх бүрт дахин битүүмжлэх шаардлагагүй юм. Авлага битүүмжлэх мэдэгдэх хуудсанд “татварын өрийн хэмжээнд хүрэх хүртэл” битүүмжлэх болохыг тодорхой зааж битүүмжилнэ.

Цалин хөлс зэрэг авлагын битүүмжлэлд Хөдөлмөрийн тухай хуульд заасан битүүмжлэх боломжгүй тодорхой хэмжээг заасан байгаа (ТЕХ-ийн 64.6.6). Гэхдээ өртэй татвар төлөгч татварын албанд шилжүүлэхийг зөвшөөрөх тохиолдолд хамаарахгүй.

(5) Авлагыг хураах эрх

Авлагыг битүүмжилсэн бол тухайн авлагыг хураах боломжтой болно гэсэн үг (ТЕХ-ийн 64.5). Иймд төлөгдөх хугацаа нь болсон тохиолдолд яаралтай хураах эрхээ хэрэгжүүлэн нэхэмжлэх ба мөнгөн хөрөнгөөр хураасан бол хураасан хэмжээгээр хязгаарлан татварын өрийг хураасан гэж үзэх ба мөнгөн хөрөнгө биш бол тухайн хөрөнгийн төрөл зүйлээс хамааран зохих битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлнэ.

* Төлөх хугацаа нь болсон ч гуравдагч өглөгтэй этгээд төлбөрөө хийхгүй бол даруй бичгээр нэхэмжилж, нэхэмжлэлийг гүйцэлдүүлэхгүй тохиолдолд авлагыг хураахад шаардлагатай арга хэмжээг (шүүхэд нэхэмжлэх г.м) авна.

Дөрөвдүгээр хэсэг. Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх

1. Үл хөдлөх эд хөрөнгө битүүмжлэх

Битүүмжлэлд хамаарах үл хөдлөх эд хөрөнгийн хязгаар, үл хөдлөх эд хөрөнгийн битүүмжлэл, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох харилцааг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

1.1. Битүүмжлэлд хамаарах үл хөдлөх эд хөрөнгийг дараах байдлаар хязгаарлана.

- 1) Иргэний хуульд заасан үл хөдлөх эд хөрөнгө (Газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс) Иргэний хуулийн 84.3-р зүйл
- 2) Үл хөдлөх эд хөрөнгийг гол зорилгоо болгосон эд юмсын эрх (газар дээрх эд хөрөнгө өмчлөх зорилгоор газар ашиглах эрх)
- 3) Үл хөдлөх эд хөрөнгө гэж үздэг хөрөнгө (үйлдвэрийн сан, ашигт малтмалын сан гм)
- 4) Үл хөдлөх эд хөрөнгөд хамаарах заалтыг баримталдаг хөрөнгө (ашигт малтмалын эрх)
- 5) Үл хөдлөх эд хөрөнгийн үүднээс авч үздэг хөрөнгө (төмөр замын сан)
 - ❖ Барилгын ажил хийгдэж байгаа барилгыг (барилгыг ашиглах гэдэг талаас харахад тухайн барилга ашиглах боломжтой гүйцэтгэлийн түвшинд хүрээгүй байх) хөдлөх хөрөнгө гэж үзэн битүүмжилж болно.
 - ❖ Бүртгэлгүй барилгын (барилга гэж бүртгүүлээгүй байх) хувьд барилгын зураг болон давхар бүрийн талбайн зургийг боловсруулж, бүртгэлийн хуудсанд хавсарган битүүмжлэлийн бүртгэлийг хийлгэнэ.

1.2. Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх болон үйлчлэлийн хугацааг дараах байдлаар тодорхойлно.

1.2.1. Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэхдээ, битүүмжлэлийн хуудсыг (...-р маягт) өртэй татвар төлөгчид хүргүүлж хэрэгжүүлнэ. Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд гуравдагч этгээд заргалдах боломжгүй болгохын тулд битүүмжлэлийн бүртгэлийг улсын бүртгэлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай.

❖ Битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ битүүмжлэлийн хуудас үйлдэх, өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудас хүргэгдэх учраас битүүмжлэлийн актын хуулбарыг өгөхгүй байх, барьцааны эрх зэрэг эрхтэй этгээдэд битүүмжлэл хийгдсэн талаар мэдэгдэхийг анхаарах.

1.2.2. Үл хөдлөх эд хөрөнгийн битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь битүүмжлэлийн хуудсыг өртэй татвар төлөгчид хүргүүлсэн үед үүснэ (ТЕХ 65.1.1). Гэхдээ битүүмжлэлийн бүртгэлийг битүүмжлэлийн хуудас хүргүүлэхээс өмнө хийсэн бол битүүмжлэлийн бүртгэл хийгдсэн үед битүүмжлэх ажиллагааны үйлчлэл үүснэ (ТЕХ 65.1.2.)

1.3. Битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох

Өртэй татвар төлөгч эсхүл үл хөдлөх хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох эрхтэй гуравдагч этгээд нь хуулийн дагуу ашиглах, ашиг орлого олох боломжтой. Гэхдээ үл

хөдлөх эд хөрөнгийн үнэ цэнийг огцом бууруулах магадлалтай үйлдэл хийх гэж байгаа нь тогтоогдсон тохиолдолд тухайн үл хөдлөх хөрөнгийг ашиглах болон ашиг олох үйл ажиллагааг хязгаарлаж болно (ТЕХ 65.1.3).

- ❖ Ашиглах, ашиг орлого олох үйл ажиллагааг хязгаарлаж буйг илэрхийлэх аргын хувьд үйл ажиллагааг хязгаарласан талаар бичиж тэмдэглэсэн босоо самбар тавих зэргээр бодит үйлдэл хийх эсхүл үйл ажиллагааг хязгаарласан талаар мэдэгдсэн тушаал гаргах гм үйлдэл хамаарна.

2. Агаарын хөлөг битүүмжлэх

Агаарын хөлөг битүүмжлэх болон битүүмжлэх үйл ажиллагааны үйлчлэлийн хугацаа, агаарын хөлгийг зогсоох, хөдөлгөх зөвшөөрөл олгох ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

2.1 Агаарын хөлөг (бүртгэлтэй агаарын хөлөг болон нисдэг тэргийг хэлнэ. Цаашид адил утгаар ойлгоно.) битүүмжлэх ажиллагаа болон үйл ажиллагааны үйлчлэлийн хугацаа

2.1.1. Агаарын хөлгийг битүүмжлэхдээ битүүмжлэлийн хуудсыг өртэй татвар төлөгчид хүргүүлснээр хэрэгжүүлнэ (ТЕХ 65.2.1-д ТЕХ 65.1.1-ийг баримтална).

Агаарын хөлгийг битүүмжилсэн бол гуравдагч этгээд заргалдах боломжгүй болгохын тулд битүүмжлэлийн бүртгэлийг улсын бүртгэлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай (ТЕХ 65.2.1-д ТЕХ 65.1.1-ийг баримтална).

- ❖ Бүртгэлээр гуравдагч этгээд заргалдах эрхгүй болдог хөдлөх хөрөнгө болох агаарын хөлгийн хувьд түүний битүүмжлэлийг ердийн хөдлөх хөрөнгөнөөс ялган авч үзэж үл хөдлөх эд хөрөнгө гэж авч үзнэ.
- ❖ Бүртгэлгүй агаарын хөлөг болон бүртгүүлэх боломжгүй моторгүй нисэх онгоцийг хөдлөх хөрөнгө гэж авч үзэн битүүмжилнэ.
- ❖ Битүүмжлэлийн ажиллагааг хэрэгжүүлэхдээ битүүмжлэлийн хуудас үйлдэх, өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудсыг хүргүүлэх учир битүүмжлэлийн актын хуулбарыг өгөхгүй байх, барьцааны эрх зэрэг эрх бүхий этгээдэд битүүмжлэл хийгдсэн талаар мэдэгдэхийг анхаарах.

2.1.2. Битүүмжлэх ажиллагааны үйлчлэлийн хугацаа нь битүүмжлэлийн хуудас өртэй татвар төлөгчид хүргүүлсэн үед үүснэ (ТЕХ 65.2.1-д ТЕХ 65.1.1-ийг баримтална). Гэхдээ битүүмжлэлийн бүртгэлийг битүүмжлэлийн хуудас хүргүүлэхээс өмнө хийсэн бол битүүмжлэлийн бүртгэл хийгдсэн үед битүүмжлэх ажиллагааны үйлчлэл үүснэ (ТЕХ 65.2.1-д ТЕХ 65.1.2-ыг баримтална). Мөн битүүмжлэлийн хуудас хүргүүлэхээс өмнө агаарын хөлгийг хамгаалах, хадгалах арга хэмжээг авсан бол өмнөх заалтаас үл

хамааран хадгалах, хамгаалах арга хэмжээг авах үед битүүмжлэх ажиллагааны үйлчлэл эхэлнэ. (ТЕХ 65.2.4).

2.2 Агаарын хөлгийг зогсоох, хөдөлгөх зөвшөөрөл олгох

2.2.1 Өр барагдуулах үйл ажиллагаанд шаардлагатай бол нислэг үйлдэхэд бэлэн байгаа агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийг татварын албаны даргын шийдвэрээр түр хугацаагаар зогсоох боломжтой (ТЕХ 65.2.2).

2.2.2 Өр барагдуулах үйл ажиллагаанд шаардлагатай бол хамгаалах, хадгалахад шаардлагатай арга хэмжээг авах боломжтой (ТЕХ 65.2.3).

❖ “хамгаалах” гэдэг нь тухайн хөрөнгийн байрлаж буй байрлалыг солихоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэлэх бөгөөд “хадгалах” гэдэг нь тухайн хөрөнгийн үр ашигтай байдлыг хадгалах арга хэмжээг хэлнэ. Гэхдээ хамгаалан хадгалах ажиллагааг битүүмжлэх ажиллагааны өмнө хойно гэдгээс үл хамааран хэрэгжүүлэх боломжтой. “шаардлагатай арга хэмжээ”-д агуулахад хийх, хариуцах хүнийг байлгах, агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг авах гм ажиллагаа хамаарна.

2.2.3 Татварын албаны даргын шийдвэрээр агаарын хөлгийг битүүмжилсэн, эсхүл ТЕХ

2.2.1-т заасны дагуу агаарын хөлгийг зогсоосон тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзвэл өртэй татвар төлөгч, барьцааны эрх болон бусад эрхийн үйлчлэлтэй этгээдийн хүсэлтийн дагуу агаарын хөлгийг хөдөлгөх зөвшөөрөл олгох боломжтой (ТЕХ 65.2.5).

3. Автомашин, барилгын тоног төхөөрөмж битүүмжлэх

Автомашин, барилгын тоног төхөөрөмж битүүмжлэх ажиллагаа, түүний үйлчлэлийн хугацаа, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг мэдэлдээ авах, хадгалах, хөдөлгөх ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

3.1.Автомашин, барилгын тоног төхөөрөмжийн (улсын бүртгэлтэй автомашин болон барилгын тоног төхөөрөмжийг хэлнэ. Цаашид “автомашин, барилгын тоног төхөөрөмж” гэнэ.) битүүмжлэлийн ажиллагаа болон үйлчлэлийн хугацаа

3.1.1.Автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэхдээ өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудсыг хүргүүлж хэрэгжүүлнэ (ТЕХ 65.3.1-д ТЕХ 65.1.1-ийг баримтална). Бүртгэлтэй автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжилсэн бол гуравдагч этгээд заргалдах боломжгүй болгохын тулд битүүмжлэлийн бүртгэлийг улсын бүртгэлийн байгууллагаар хийлгүүлэх шаардлагатай (ТЕХ 65.2.1-д ТЕХ 65.1.2-ийг баримтална.)

❖ Эрхийн бүртгэлээр гуравдагч этгээд заргалдах боломжгүй болдог хөдлөх хөрөнгө (автомашин, барилгын тоног төхөөрөмж)-ийн хувьд

түүний битүүмжлэлийг ердийн хөдлөх хөрөнгөөс ялгаатай авч үзэж үл хөдлөх эд хөрөнгө гэж авч үзнэ.

- ❖ Бүртгэлгүй автомашин, барилгын тоног төхөөрөмж, бүртгэх боломжгүй жижиг оврын автомашиныг бол хөдлөх хөрөнгө гэж битүүмжилнэ.
- ❖ Битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ битүүмжлэлийн акт үйлдэх, өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудас хүргэгдэх тул битүүмжлэлийн актын хуулбарыг өгөхгүй байх, барьцааны эрх зэрэг эрхтэй этгээдэд битүүмжлэл хийгдсэн талаар мэдэгдэхийг анхаарах.

3.1.2. Битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудас хүргүүлсэнээр эхэлнэ (ТЕХ 65.3.1-д ТЕХ 65.1.1-ийг баримтална). Гэхдээ битүүмжлэлийн бүртгэлийг битүүмжлэлийн хуудас хүргүүлэхээс өмнө хийсэн бол битүүмжлэлийн бүртгэл хийгдэх үед битүүмжлэх ажиллагааны үйлчлэл эхэлнэ (ТЕХ 65.3.1-д ТЕХ 65.1.2-ыг баримтална). Мөн битүүмжлэлийн хуудсыг хүргүүлэхээс өмнө хамгаалан хадгалах арга хэмжээг авсан бол өмнөх заалтаас үл хамааран хамгаалан хадгалах арга хэмжээ авсан үед битүүмжлэлийн ажиллагааны үйлчлэл эхэлнэ (ТЕХ 65.3.1-д ТЕХ 65.2.4-ыг баримтална)

3.1.3. Өр барагдуулах үйл ажиллагаанд шаардлагатай бол хамгаалах болон хадгалахад шаардлагатай арга хэмжээг авах боломжтой. (ТЕХ 65.3.2-д ТЕХ 65.2.3-ыг баримтална).

- ❖ “хамгаалах” гэдэг нь тухайн хөрөнгийн байрлаж буй байрлалыг солихоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэлэх бөгөөд “хадгалах” гэдэг нь тухайн хөрөнгийн үр ашигтай байдлыг хадгалах арга хэмжээг хэлнэ. Гэхдээ хамгаалан хадгалах ажиллагааг битүүмжлэх ажиллагааны өмнө хойно гэдгээс үл хамааран хэрэгжүүлэх боломжтой. “шаардлагатай арга хэмжээ”-д гражд хийх, автомашины үзлэгийн хуудсыг хураах гм ажиллагаа хамаарна.

3.2. Автомашиныг мэдэлдээ авах, хадгалах, хөдөлгөх

3.2.1. Шилжүүлэн өгөхийг тушаах, мэдэлдээ авах

Татварын албаны шийдвэрээр, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжилсэн бол өртэй татвар төлөгчид эдгээрийг татварын албаны мэдэлд шилжүүлэн өгөх тушаал гаргаж татвар хураалтын байцаагчаар дамжуулж мэдэлдээ авах боломжтой (ТЕХ 65.3.3).

3.2.2. Татвар хураалтын байцаагч мэдэлдээ авах арга хэмжээ

3.2.2.1.Өртэй татвар төлөгч эсхүл гэр бүлийн гишүүн, тусгай харилцан хамааралтай этгээдийн мэдэлд байгаа автомашин, барилгын тоног төхөөрөмжийг мэдэлдээ авах

Хөрөнгийг мэдэлдээ байлгаж буй этгээдэд автомашин, барилгын тоног төхөөрөмж-ийг шилжүүлэн өгөхийг шаардаж, шаардлагын дагуу татвар хураалтын байцаагчид шилжүүлэн өгсөн бол татвар хураалтын байцаагч хөрөнгийг мэдэлдээ авна. Тушаалыг дагаагүй тохиолдолд татвар хураалтын байцаагч нь албадан мэдэлдээ авах боломжтой (ТЕХ 65.3.4-д ТЕХ 62.1-ийг баримтална)

3.2.2.2.Өртэй татвар төлөгчийн гэр бүлийн гишүүн, тусгай харилцан хамааралтай этгээдээс бусад гуравдагч этгээдийн мэдэлд буй автомашин, барилгын тоног төхөөрөмжийг мэдэлдээ авах

Гуравдагч этгээд хөрөнгийг татвар хураалтын байцаагчид шилжүүлэн өгсөн бол шууд мэдэлдээ авах боломжтой боловч шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд татварын албанд шилжүүлэн өгөх тушаалыг өгсөнөөр мэдэлдээ авна. Энэхүү шилжүүлэн өгөх тушаалын шаардлага, арга хэмжээ, үр дүнгийн хувьд гуравдагч этгээдийн мэдэлд буй хөдлөх хөрөнгийг битүүмжлэх ажиллагаанд хамааралтай зүйл заалтыг баримтална (ТЕХ 65.3.4-д ТЕХ 62.4, 62.6, 62.7-г баримтална). Татварын албанд шилжүүлэн өгөх тушаалыг гуравдагч этгээдэд гаргахаас өмнө өртэй татвар төлөгчид амаар эсхүл бичгээр тушаалыг өгнө. Хэрэв өртэй татвар төлөгч үүнийг хүлээн аваагүй тохиолдолд автомашин, барилгын тоног төхөөрөмж-ийг мэдэлдээ авахын тулд шилжүүлэн өгөх тушаалыг гуравдагч этгээдэд бичгээр өгч, өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ. Шилжүүлэн өгөх эцсийн хугацаа нь тушаалыг илгээсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор байна. Гуравдагч этгээд нь заасан хугацаанд шилжүүлэн өгсөн бол эсхүл эцсийн хугацаа өнгөрсөнч тушаалыг дагаагүй тохиолдолд тухайн автомашин, барилгын тоног төхөөрөмжийг шууд мэдэлдээ авах боломжтой. Гэхдээ гуравдагч этгээдээс нэхэмжлэх ирвэл мэдэлдээ авах гэрээнд заасан хугацааг хянаж үзэн 3 сар хүртлэх хугацаагаар үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрнө.

3.2.3.Татвар хураалтын байцаагч нь мэдэлдээ авсан автомашин, барилгын тоног төхөөрөмж-ийн өртэй татвар төлөгч эсхүл гуравдагч этгээдэд хадгалуулах

Татвар хураалтын байцаагч нь мэдэлдээ авсан автомашин, барилгын тоног төхөөрөмжийг байрнаас зөөлгүйгээр өртэй татвар төлөгч эсхүл гуравдагч этгээдэд хадгалуулж болно. Энэ тохиолдолд татвар хураалтын байцаагч нь мэдэлдээ авсан талаар бичиж тэмдэглэсэн “битүүмжилсэн хөрөнгийг мэдэлд авсан акт” үйлдэж, лацдаж, олон нийтэд мэдэгдэх хуудас болон бусад аргаар тухайн автомашин, барилгын тоног төхөөрөмжийг татварын алба мэдэлдээ авсныг тодорхой болгоно (ТЕХ 65.3.5).

Түүнчлэн хадгалуулсан автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хөдөлгөх эсхүл ашиглах зөвшөөрөл олгохоос бусад тохиолдолд татвар хураалтын байцаагч нь

хөдөлгөх эсхүл ашиглуулахгүй байх үүднээс тохирох арга хэмжээг авна. Дээрх “татвар хураалтын байцаагч мэдэлдээ авах”-ыг тодорхой болгохын зэрэгцээ автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хөдөлгөхгүй байх үүднээс авах “тохирох арга хэмжээ” болгож олон нийтэд мэдэгдэх хуудас болон дугуй түгжих арга хэмжээг авч болно.

- ❖ Дугуй түгжих арга хэмжээ гэдэг нь автомашиныг хөдөлгөөнд оруулах боломжгүй болгох үүднээс дугуйнд зүүх метал хэрэгсэл бөгөөд битүүмжилсэн автомашины хувьд шилжүүлэн өгөх тушаал гаргаж татвар хураалтын байцаагч автомашиныг мэдэлдээ авсаны дараа хэрэгжүүлнэ. Мөн олон нийтэд зарлах хуудсыг жолоочийн нүдэнд харагдах газар, урд талын толин дээр наана.

3.2.4. Мэдэлдээ авсан автомашин, барилгын тоног төхөөрөмж-ийн хөдөлгөөнд орох эсхүл ашиглах зөвшөөрөл

Татварын албан битүүмжилсэн автомашин, барилгын тоног төхөөрөмжийг мэдэлдээ авсан тохиолдолд (өртэй татвар төлөгч эсхүл гуравдагч этгээдэд хадгалуулсан бол мөн адил хамаарна) хүндэтгэн үзэх шалтгаантай бол өртэй татвар төлөгч, ипотекийн барьцааны эрх болон бусад эрхийн үйлчлэлтэй этгээдийн хүсэлтийн дагуу автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хөдөлгөх эсхүл ашиглах зөвшөөрөл олгох боломжтой (ТЕХ 65.3.6).

3.2.5. Автомашин, барилгын тоног төхөөрөмжийг зөөх болон хадгалах

Битүүмжилсэн автомашин, барилгын тоног төхөөрөмжийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх тохиолдолд зарчмын хувьд мөнгөн хэлбэрт шилжүүлэхийн өмнө татвар хураалтын байцаагч мэдэлдээ авах ёстой. Зөвхөн битүүмжлэх эсхүл мэдэлдээ аваад орхисноор өртэй татвар төлөгч автомашин, барилгын тоног төхөөрөмжийг нуух, гэмтээх зэргээр дуудлага худалдаанд оруулахаас зугтах арга хэмжээ авах магадлалтай. Иймд татвар хураалтын байцаагч мэдэлдээ авч, байрлалаас нь зөөх, хадгалах шаардлагатай. Энэ тохиолдолд мэдэлдээ авч зөөсөн талаар тэмдэглэсэн “битүүмжилсэн хөрөнгийг зөөх акт”-ыг үйлдэнэ. Мөн автомашины үзлэгийн хуудсыг гм-ийг хураан авсан бол “Хураан авсан акт”-ыг үйлдэнэ. Зөөсөн автомашиныг хадгалах ажил үүргийн хувьд татвар хураалтын байцаагч сайтар анхааралдаа байлгах үүрэгтэй тул тохиромжит хадгалах байрыг бэлдэж, хяналтанд байлгах арга хэмжээг авах шаардлагатай.

Тавдугаар хэсэг. Биет бус хөрөнгө битүүмжлэх

Хөдлөх хөрөнгө, үнэт цаас, хадгаламжийн данс, авлага, үл хөдлөх эд хөрөнгө болон агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийн битүүмжлэлд хамаарахгүй хөрөнгийг “биет бус хөрөнгө” гэж үзэн гуравдагч этгээдийн (өглөгтэй гуравдагч этгээд

гм (өглөгтэй гуравдагч этгээд эсхүл үүнтэй адилтгах этгээдийг хэлнэ)-гүй хөрөнгө) ашиглаж байгаа болон ашиглаагүй гэж ангилан тус бүрийн битүүмжлэх ажиллагааны талаар заасан.

1. Биет бус хөрөнгийн дотор өглөгтэй гуравдагч этгээдгүй хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа, үйлчлэлийн хугацаа

1.1. Биет бус хөрөнгийн дотор өглөгтэй гуравдагч этгээдгүй хөрөнгийн төрөл

1) Патентийн эрх, практикт хэрэглэх шинэ санаачлагын эрх , дизайны эрх , бараа тэмдэгтийн эрх

2) Зохиогчийн эрх (болон дагалдах эрх)

❖ Патентийн эрх гм аливаа үйлдвэрлэлийн эзэмшлийн эрх нь бүртгэл хийгдсэнээр бий болдог (Патентийн тухай хууль оозүйл, практикт хэрэглэх шинэ санаачлагын тухай хуулийн оозүйл, дизайны тухай хуулийн оозүйл, бараа тэмдэгтийн тухай хуулийн оозүйл). Мөн үйлдвэрлэлийн эзэмшлийн эрхээс бусад биет бус хөрөнгийн эрх болох зохиогчийн эрх (болон дагалдах эрх) нь зохиогчийн бүтээл (болон жүжиг гм)-ээр үүсдэг хэдий ч, тухайн эрхийг шилжүүлэхэд бүртгэл нь гуравдагч этгээд заргалдах боломжгүй болно. (Зохиогчийн эрхийн тухайн хуулийн ...-р зүйл).

1.2. Битүүмжлэх ажиллагаа болон үйлчлэл үүсэх хугацаа

1.2.1. Патентийн эрх, зохиогчийн эрх гм-ийн өглөгтэй гуравдагч этгээдгүй биет бус хөрөнгийг битүүмжлэхдээ өртэй татвар төлөгчид битүүмжлэлийн хуудсыг хүргүүлсэнээр хэрэгжүүлнэ (ТЕХ 66.1.1).

Биет бус хөрөнгө гм тухайн эрхийг шилжүүлэхдээ бүртгэл хийх шаардлагатай зүйлийг битүүмжилсэн тохиолдолд битүүмжлэлийн бүртгэлийг холбогдох бүртгэлийн байгууллагаар хийлгүүлэх шаардлагатай. (ТЕХ 66.1.2).

❖ Битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ битүүмжлэлийн хуудсыг үйлдэх, өртэй татвар төлөгчид битүүмжлэх хуудас хүргэгдэх тул битүүмжлэлийн актын хуулбарыг өгөхгүй байх, барьцааны эрх зэрэг эрхтэй этгээдэд битүүмжлэл хийгдсэн талаар мэдэгдэхийг анхаарах

1.2.2. Битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь зарчмын хувьд битүүмжлэлийн хуудас өртэй татвар төлөгчид хүргэгдсэнээр үүсдэг (ТЕХ-ийн 66.1.1) боловч бүртгэл хийгдсэнээр гуравдагч этгээд заргалдах эрхгүй болох зохиогчийн эрх, дагалдах эрх байх тохиолдолд битүүмжлэлийн бүртгэлийг битүүмжлэх хуудас хүргэгдэхээс өмнө хийгдсэн бол битүүмжлэлийн бүртгэл хийгдсэн үед битүүмжлэлийн үйлчлэл үүснэ. Гэхдээ бүртгэл нь үйлчлэл үүсэх нөхцөл болдог патентийн эрх, практикт хэрэглэх шинэ санаачлагын эрх, дизайны эрх , барааны тэмдэгтийн эрх

байх тохиолдолд битүүмжлэлийн бүртгэл хийгдсэн үед битүүмжлэлийн үйлчлэл үүснэ (ТЕХ 66.1.4).

2. Биет бус хөрөнгийн эрхийн дотор өглөгтэй гуравдагч этгээдтэй хөрөнгийн битүүмжлэх ажиллагаа, үйлчлэлийн хугацаа

2.1. Биет бус хөрөнгийн эрхийн дотор өглөгтэй гуравдагч этгээдтэй хөрөнгийн төрөл (гол зүйл) болон тухайн өглөгтэй гуравдагч этгээдэд хамрах этгээд

- 1) Үйлдвэрлэл эзэмшигчийн эрх (патентийн эрх, практикт хэрэглэх шинэ санаачлагын эрх, дизайны эрх, барааны тэмдэгтийн эрх)-ийг хэрэгжүүлэх эрх эсхүл ашиглах эрх . . . тус бүрийн үйлдвэрлэл эзэмших эрхтэй этгээд
- 2) Хэвлэх эрх...зохиогчийн эрх
- 3) Түрээсийн эрх ...түрээслэгч
- 4) Төрөл бүрийн холбооны гишүүний эзлэх хувь ...тус бүрийн холбоо
- 5) Компани тус бүрийн ажилтны эзлэх хувь...тус бүрийн компани
- 6) Хөдлөх хөрөнгийн хамтын эзэмшил...бусад хамтран эзэмшигч

2.2. Битүүмжлэх ажиллагаа болон үйлчлэх хугацаа

2.2.1. Үйлдвэрлэл эзэмших эрх болон бусад өглөгтэй этгээдтэй биет бус хөрөнгийн эрхийг битүүмжлэхдээ өглөгтэй гуравдагч этгээдэд битүүмжлэлийн мэдэгдэх хуудас (битүүмжлэлийн хуудас) хүргүүлсэнээр битүүмжилнэ. Бүртгэл хийх шаардлагатай хөрөнгийг битүүмжилсэн бол битүүмжлэлийн бүртгэлийг холбогдох бүртгэлийн байгууллагаар хийлгэнэ. (ТЕХ 66.2.1).

❖ Битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ битүүмжлэлийн хуудсыг үйлдэх, өртэй татвар төлөгчид битүүмжлэх хуудас хүргэгдэх тул битүүмжлэлийн актын хуулбарыг өгөхгүй байх, барьцааны эрх зэрэг эрхтэй этгээдэд битүүмжлэл хийгдсэн талаар мэдэгдэхийг анхаарах.

2.2.2. Битүүмжлэлийн үйлчлэл нь зарчмын хувьд битүүмжлэлийн хуудас өртэй татвар төлөгчид хүргэгдсэнээр үүсэх (ТЕХ 66.2.1) боловч битүүмжлэлийн бүртгэл хийх шаардлагатай хөрөнгийн хувьд битүүмжлэлийн бүртгэлийг битүүмжлэх хуудас хүргэгдэхээс өмнө хийгдсэн бол битүүмжлэлийн бүртгэл хийгдсэн үед үйлчлэл үүснэ. Гэхдээ бүртгэл нь үйлчлэл үүсэх нөхцөл болдог үйлдвэрлэлийн эзэмшлийн эрхийг хэрэгжүүлэх эсхүл ашиглах онцгой эрхийн хувьд өмнөх заалтаас үл хамааран битүүмжлэлийн бүртгэл хийгдсэн үед битүүмжлэлийн үйлчлэл үүснэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. БИТҮҮМЖЛЭЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

1. Битүүмжлэлийг хүчингүй болгох нөхцөл шаардлага

Битүүмжлэлийг хүчингүй болгосноор цаашид битүүмжлэлийн үр дүнд авч болох арга хэмжээг авах боломжгүй болно. Иймд битүүмжлэлээр аль хэдийн бий болсон арга хэмжээний хувьд (хэсэгчлэн хураах болон суутгал) бол нөлөөлөхгүй.

Битүүмжлэлд зайлшгүй хүчингүй болгох шаардлагатай тохиолдол болон хүчингүй болгох боломжтой тохиолдол гэсэн 2 тохиолдол байдаг.

1.1. Битүүмжлэлийг хүчингүй болгох шаардлагатай тохиолдол

- 1) Төлөлт хийгдэх, суутгал, тайлангийн залруулга гм бусад шалтгааны улмаас битүүмжлэлд хамаарах өртэй татвар төлөгчийн татварын нийт өр хүчингүй болсон үед (ТЕХ 60.8)
- 2) Битүүмжилсэн хөрөнгийн үнэ цэнэ нь тухайн битүүмжлэлд хамаарах татварын өр хураах зардал болон битүүмжлэлд хамаарах татварын өрөөс давуу эрхтэй байх бусад авлагын нийт үнийн дүнгээс давах магадлалгүй болсон үед
 - ❖ Битүүмжлэлийг хүчингүй болгох шаардлагатай тохиолдолд дээрхээс гадна гуравдагч этгээдээс битүүмжилсэн хөрөнгийг солих хүсэлт ирүүлж хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн тохиолдол (ТЕХ 60.3) байдаг.

1.2. Битүүмжлэлийг хүчингүй болгох боломжтой тохиолдол

- 1) Битүүмжлэлд хамаарах татварын өрийн нэг хэсгийг төлсөн, суутгасан, тайлангийн залруулгаар нэг хэсэг нь хүчингүй болсон, битүүмжилсэн хөрөнгийн үнийн өсөлт болон бусад шалтгааны улмаас битүүмжилсэн хөрөнгийн үнэ цэнэ битүүмжлэлд хамаарах татварын өр болон энэ татварын өрөөс давуу эрхтэй байх авлагын нийт үнийн дүнг хэт давахаар байгаа нь хүлээн зөвшөөрөгдсөн үед
- 2) Өртэй татвар төлөгч нь битүүмжлэх боломжтой бусад тохирох хөрөнгийг өгсөн тохиолдолд тухайн хөрөнгийг битүүмжилсэн бол
 - ❖ Битүүмжлэлийг хүчингүй болгох боломжтой тохиолдол гэдэгт дээрхээс гадна татварын хөнгөлөлт эдэлсэн үед татвар төлөгчөөс хүсэлт ирсэн бол (ТЕХ 60.3)

2. Битүүмжлэлийг хүчингүй болгох үйл ажиллагаа

Битүүмжлэлийг хүчингүй болгохдоо энэ талаар өртэй татвар төлөгчид бичгээр (“битүүмжлэлийг хүчингүй болгох мэдэгдэх хуудас” маягт ...) мэдэгдсэнээр хэрэгжүүлнэ.

Гэхдээ авлага болон өглөгтэй гуравдагч этгээдтэй биет бус хөрөнгийн битүүмжлэлийг хүчингүй болгохдоо энэ талаар өглөгтэй гуравдагч этгээдэд мэдэгдсэнээр хэрэгжүүлнэ.

Битүүмжлэлийг хүчингүй болгох ажиллагаа нь энэхүү битүүмжлэлийг хүчингүй

болгосон талаарх бичгийг өртэй татвар төлөгч эсхүл өглөгтэй гуравдагч этгээдэд хүргүүлсэнээр үйлчилж эхэлнэ.

3. Битүүмжлэлийг хүчингүй болгохтой холбоотой хийгдэх үйл ажиллагаа

1) Өртэй татвар төлөгчид мэдэгдэх

Авлага эсхүл өглөгтэй гуравдагч этгээдийн эрхийн үйлчлэлтэй биет бус хөрөнгийн битүүмжлэлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ талаар өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

2) Барьцааны эрх зэрэг эрхтэй этгээдэд мэдэгдэх

Битүүмжлэлийг хүчингүй болгосон тохиолдолд барьцааны эрхтэй этгээдийн дотор, танигдаж байгаа болон суутгалын хүсэлт гаргасан хүн байгаа бол эдгээр хүмүүст битүүмжлэлийг хүчингүй болгосон талаар болон бусад шаардлагатай зүйлсийн талаар мэдэгдэнэ.

3) Лац тэмдэглэгээг салгах

Лаци, олон нийтэд мэдэгдэх хуудас болон битүүмжлэлийг тодорхой болгох үүднээс авсан бусад зүйлийг тухайн хөрөнгийн битүүмжлэлийг хүчингүй болгосон үед салгана.

4) Хөрөнгийг буцаан өгөх

Битүүмжлэлийг хүчингүй болгосон тохиолдолд мэдэлд авсан хөрөнгө байгаа бол тухайн хөрөнгийг буцаан олгоно.

Битүүмжлэлийг хүчингүй болгохдоо битүүмжилсэн хөрөнгийг анх байсан газарт буцаан олгох боловч татварын авлагатай этгээдийн хариуцлага бүхий шалтгааны улмаас (тайлангийн залруулгаар хүчингүй болсон гм) битүүмжлэлийг хүчингүй болгох шаардлагатай тохиолдолд битүүмжлэлийг хийх үед хөрөнгө анх байсан газарт хийнэ.

Буцаан олголтыг хүлээн авах этгээд нь зарчмын хувьд өртэй татвар төлөгч байдаг ч битүүмжлэх үед өртэй татвар төлөгчөөс гадна гуравдагч этгээдийн мэдэлд байсан хөрөнгийн хувьд гуравдагч этгээдээс өртэй татвар төлөгчид буцаан олгохыг хүссэнээс бусад тохиолдолд гуравдагч этгээдэд буцаан олгоно.

5) Битүүмжлэлийн бүртгэлээс хасах

Үл хөдлөх эд хөрөнгийн болон бусад битүүмжлэлийн бүртгэл хийлгэсэн хөрөнгийн битүүмжлэлийг хүчингүй болгосон бол тухайн бүртгэлийн хасалтыг холбогдох бүртгэлийн байгууллагаар хийлгүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. СУУТГАЛЫН ХҮСЭЛТ

Суутгалын хүсэлт гэдэг нь өртэй татвар төлөгчийн хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагаа эхэлсэн үед энэ ажиллагаанд оролцож хуваарилалтаас хүртэж татварын өрийг хураах тогтолцоо юм.

1. Суутгалын хүсэлт гаргах боломжтой нөхцөл шаардлага болон суутгалын хүсэлтийн хязгаар

1.1. Суутгалын хүсэлт гаргах боломжтой нөхцөл шаардлага гэдэгт ① өртэй татвар төлөгчийн хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ хэрэгжиж байх ② татварын өртэй байх нөхцөл орно.

- ❖ Албадан гүйцэтгэх ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ гэдэг нь татвар төлөгчийн хөрөнгөнд өр барагдуулах үйл ажиллагаа, албадан гүйцэтгэл, барьцааны эрхийг хэрэгжүүлэх дуудлага худалдаа болон дампуурах арга хэмжээг хэрэгжүүлэхийг хэлнэ.
- ❖ Суутгалын хүсэлт гаргах боломжтой татвар нь татвар төлөх эцсийн хугацаанаас өмнө төлөөгүй байх бөгөөд тухайн татварын шаардлага хүргүүлсэн эсэхээс үл хамаарна.

1.2. Өртэй татвар төлөгч нь мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар, гуравдагч этгээдийн эрхийн үйлчлэлгүй хөрөнгийг эзэмшдэг дээр нь тухайн хөрөнгөөр татварын нийт өрийг бүрэн барагдуулах боломжтой гэж үзсэн тохиолдолд суутгалын хүсэлтийг гаргалгүйгээр тухайн хөрөнгийг битүүмжилнэ. (ТЕХ 67.2)

2. Суутгах хүсэлтийн арга хэмжээ

2.1. Суутгалын хүсэлтийг хийхдээ “суутгалын хүсэлтийн хуудас”-ыг албадан гүйцэтгэх ажиллагаагаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа байгууллагад хүргүүлнэ (ТЕХ 67.1).

Суутгалын хүсэлт гаргасан тохиолдолд өртэй татвар төлөгчид энэ талаар “суутгах хүсэлтийн мэдэгдэх хуудас” –аар мэдэгдэж, суутгалын хүсэлтэд хамаарах хөрөнгийн барьцааны эрхтэй этгээдийн дотор мэдэгдэж байгаа хүнд энэ талаар “суутгах хүсэлтийн мэдэгдэх хуудас” (эрхтэй этгээдэд) (Маягт○○)-аар мэдэгдэнэ (ТЕХ 67.1).

- ❖ Дампуурлын арга хэмжээнд суутгалын хүсэлт гаргасан тохиолдолд авлагатай гэдэг утга илэрхийлэхээс хэтрэхгүй тул өртэй татвар төлөгч болон хөрөнгийн барьцааны эрхтэй этгээдийн дотор мэдэгдэж байгаа хүнд мэдэгдэх шаардлагагүй.

2.2. Суутгалын хүсэлтийг дараах хугацаанд хэрэгжүүлнэ.

- 1) Өр барагдуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд
 - Хөрөнгийг худалдан борлуулах замаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх
 - худалдан борлуулах шийдвэр гарах өдрийн өмнөх өдөр хүртэл

- Мөнгөн хөрөнгийг хураан авах замаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх . . . тухайн хураан авах үе хүртэл
- 2) Албадан гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд
 - Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмж . . . шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хуваарилах хүсэлтийн эцсийн хугацаа
 - Хөдлөх хөрөнгө . . . хэрэгжүүлэгч албан тушаалтан худалдан борлуулах төлбөрөө авах хүртэл
- ❖ Мөнгөн хэлбэрийн төлөлт эсхүл хөдлөх хөрөнгийг өгөх авлага . . . хэрэгжүүлэх хуулиар заасан хугацаа хүртэл
- 3) Барьцааны эрхийн хэрэгжилт болох дуудлага худалдаа . . . шүүхийн шийдвэр хэрэгжүүлэх хуульд заасан хугацаа хүртэл

3. Албадан гүйцэтгэлийн дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг хүчингүй болгох болон суутгалын хүсэлтийг цуцлах

Суутгалын хүсэлтийг хүлээн авсан хэрэгжүүлэгч байгууллагын албадан гүйцэтгэлээр хэрэгжүүлж буй мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ нь цуцлагдсан эсхүл хүчингүй болсон тохиолдолд суутгалын хүсэлтийн үйлчлэл хэрэгжихгүй. Түүнчлэн энэ тохиолдолд суутгалын хүсэлтийг цуцлах арга хэмжээ авах шаардлагагүй.

4. Албадан гүйцэтгэлээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээний хөрөнгө шилжүүлэх болон суутгалын хүсэлт хоорондын харилцан хамаарал

Албадан гүйцэтгэлийн мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагын ажиллагаа эхэлсний дараа хөрөнгийг шилжүүлсэн байсанч суутгалын хүсэлтийн дагуу хуваарилалтаас хүртэх боломжтой.

5. Суутгалын хүсэлтийг цуцлах арга хэмжээ

5.1.Төлөлт, суутгал, тайлангийн залруулга болон бусад шалтгаанаар суутгалын хүсэлтэд хамаарах татварын өр хүчингүй болсон бол суутгалын хүсэлтийг цуцлах шаардлагатай.

5.2.Суутгалын хүсэлтийг цуцалсан талаар “суутгалын хүсэлтийг цуцалсан мэдэгдэх хуудас” (Маягт○○)-аар суутгалын хүсэлт гаргасан хэрэгжүүлэгч байгууллагад мэдэгдэж хэрэгжүүлнэ.

Суутгалын хүсэлтийг цуцалсан бол өртэй татвар төлөгч болон барьцааны эрх зэрэг эрхтэй этгээдэд “суутгалын хүсэлтийг цуцалсан мэдэгдэх хуудас” –аар энэ талаар мэдэгдэнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨРӨНГИЙГ МӨНГӨН ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ

Битүүмжилсэн хөрөнгө нь мөнгөн хөрөнгөөс бусад хөрөнгө байх тохиолдолд мөнгөн хэлбэрт шилжүүлж, шилжүүлсэн төлбөрийг татварын өрөнд суутгадаг. Энэхүү битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх албадан гүйцэтгэлийн арга хэмжээг “мөнгөн хэлбэрт шилжүүлэх” гэнэ.

Өргөн утгаараа мөнгөн хэлбэрт шилжүүлэхийг ① авлагыг хураан авах болон ② хөрөнгийг худалдан борлуулах гэж хуваах бөгөөд явцуу утгаар “мөнгөн хэлбэрт шилжүүлэх” гэнэ. Зарчмын хувьд авлагыг хураан авах нь зүйтэй боловч худалдан борлуулах замаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх боломжтой. Бусад хөрөнгийн хувьд зарчмын хувьд худалдан борлуулах замаар мөнгөн хэлбэрт шилжүүлдэг хэдий ч хураан авах замаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх боломжтой. Түүнчлэн хураан авах замаар авсан зүйл нь мөнгөнөөс бусад хөрөнгө байх тохиолдолд үүнийг битүүмжилж мөнгөн хэлбэрт шилжүүлнэ. Явцын утгын “мөнгөн хэлбэрт шилжүүлэх” нь зарчмын хувьд дуудлага худалдаа хийдэг боловч шууд гэрээгээр худалдан борлуулах тохиолдолд ч байдаг.

1. Мөнгөн хэлбэрт шилжүүлэх ерөнхий дүрэм

1.1. Мөнгөн хэлбэрт шилжүүлэх аргын төрөл

1) Чөлөөт өрсөлдөөнөөр худалдан борлуулах “дуудлага худалдаа”

Мөнгөн хэлбэрт шилжүүлэхдээ худалдан борлуулах хамгийн доод үнэ гэж анхны үнийг тогтоож, тодорхой бус хэд хэдэн худалдан авах хүсэлт гаргагчийг чөлөөтэй өрсөлдүүлж, анхны үнээс дээш хамгийн өндөр үнэ санал болгосон хүнд худалдан борлуулах шийдвэрийг гаргаж худалдан борлуулдаг. Энэ нь мөнгөн хэлбэрт шилжүүлэх ерөнхий зарчмын арга юм.

2) Тодорхой хүнд худалдан борлуулах “шууд гэрээ”

Битүүмжилсэн хөрөнгийг худалдан борлуулахдаа чөлөөтэй өрсөлдүүлэх нь тохиромжгүй тохиолдолд тодорхой харилцагчийг худалдан авах хүн гэж тогтож тухайн хүнд худалдан борлуулна. (ТЕХ 68.5)

1.2. Мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааны хязгаарлалт

Битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг дараах тохиолдолд хэрэгжүүлэхийг хязгаарлана.

1.2.1. Хөрөнгийн чанараас хамааран мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг хязгаарлах

Боловсорч гүйцээгүй үр жимс, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа бүтээгдэхүүн гм –ийн хувьд ердийн ажил гүйлгээнд ороход бэлэн бүтээгдэхүүн болох хүртэл мөнгөн хэлбэрт шилжүүлэхийг хязгаарлана

1.2.2.Татвар төлөх хөнгөлөлтэй тохиолдолд мөнгөн хэлбэрт шилжүүлэхийг хязгаарлах

Татвар төлөх хугацааны хөнгөлөлттэй үед мөнгөн хэлбэрт шилжүүлэхийг хязгаарлана. (ТЕХ 53.4)

1.2.3.Мөнгөн хэлбэрт шилжүүлэх дарааллын хязгаарлалт

Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд болон батлан даагчийн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэхдээ үндсэн татвар төлөгчийн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэний дараагаар шилжүүлнэ. (ТЕХ 53.6, 58.4).

1.2.4.Гомдол гаргасан үед мөнгөн хэлбэрт шилжүүлэхийг хязгаарлах

Татвар төлөгчөөс гомдол гаргасан тохиолдолд тухайн хөрөнгийн үнэ хэт буурах магадлалтай эсхүл гомдол гаргасан этгээдээс өөр хүсэлт ирүүлсэнээс бусад тохиолдолд гомдлыг шийдвэрлэх хүртэл мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхгүй (ТЕХ 68.1).

1.2.5.Шүүх ажиллагаа үргэлжилж байгаа үед мөнгөн хэлбэрт шилжүүлэхийг хязгаарлах

Гомдол гарсанаас хойш шүүхийн шийдвэр гарах хүртэл мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхгүй (ТЕХ 68.2).

1.3.Битүүмжилсэн хөрөнгийг худалдан авах этгээдэд тавих хязгаарлалт

1.3.1.Өртэй татвар төлөгч болон татварын улсын байцаагч, татварын албаны ажилтан худалдан авахыг хориглоно.

Өртэй татвар төлөгч нь мөнгөн хэлбэрт шилжүүлэхээр болсон өөрийн хөрөнгийг шууд болон шууд бусаас үл хамааран худалдан авах эрхгүй. Мөн татварын улсын байцаагч, татварын албаны ажилтан нь ажлынхаа тэгш шудрага байдлыг хангах үүднээс худалдан авах эрхгүй (ТЕХ 68.4).

1.3.2.Худалдан авагчийн хязгаарлалт

Хар тамхи, хор, мансууруулах бодис гм-ийг худалдан авах хүн нь үүнийг ашиглах үнэмлэх, гэрчилгээтэй байх шаардлагатай

1.3.3.Зөвшөөрлийн дагуу шилжүүлэн өгөх зүйл

Засгийн газрын байгууллагын зөвшөөрөл шаардлагатай зүйл • • • бууны дарь, буу гм.

2. Дуудлага худалдааг зохион байгуулах ажиллагаа

2.1.Дуудлага худалдааны ач холбогдол

Дуудлага худалдаа нь битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэхийн тулд тухайн хөрөнгийг худалдан авах хүсэлтэй хүмүүсийг чөлөөтэй өрсөлдөлдүүлэн санал болгосон хамгийн өндөр үнэ болон худалдан авах хүнийг шийдэх арга хэмжээ юм.

2.2.Дуудлага худалдааны урьдчилсан бэлтгэл

Дуудлага худалдааны урьдчилсан бэлтгэл нь дуудлага худалдааг явуулахад чухал нөлөөтэй ажил юм. Бэлтгэл ажлыг зөв хангасан эсэх нь дуудлага худалдаанд ихээхэн нөлөөлдөг.

2.2.1. Дуудлага худалдааны урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх

Өртэй татвар төлөгчид дуудлага худалдааны мэдэгдэл хүргэхээс өмнө татвар төлөгчийг татвараа төлөхийг сануулж, дуудлага худалдааг хэрэгжүүлсэнээр үүсэх магадлалтай маргаан, асуудлыг урьдчилан сэргийлэхийн тулд “дуудлага худалдааны урьдчилсан мэдэгдэл” (маягт 00)-ийг хүргүүлнэ.

2.2.2. Дуудлага худалдааг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг нягталж үзэх

Шаардлага болон татвар төлөх хугацааны хөнгөлөлттэй эсэх, битүүмжлэлийн актын хуулбар, битүүмжлэлийн мэдэгдэл, битүүмжлэлийн хуудас хүргүүлсэн эсэх, бүртгэлтэй эсэх, хадгалуулах тушаал өгсөн хөрөнгө байгаа эсэх, лацдах, олон нийтэд мэдэгдэх хуудастай эсэх, гуравдагч этгээдийн эрхийн үйлчлэлтэй хөрөнгийн хувьд мэдэгдэл байгаа эсэх, гуравдагч этгээдийн эрхийг хүндэтгэн дуудлага худалдаа явуулж болохгүй эсэх, татвар төлөх үүргийн залгамжлал байгаа эсэх гм арга хэмжээ нь зөв зүйтэй явагдаж байгаа эсэхийг шалгаж үзнэ.

2.3. Дуудлага худалдааны талаар нийтэд мэдэгдэх, дуудлага худалдааг мэдэгдэх

2.3.1. Дуудлага худалдааны талаар нийтэд мэдэгдэх

Битүүмжилсэн хөрөнгийг дуудлага худалдаанд оруулахдаа “дуудлага худалдааны талаар нийтэд мэдэгдэх” арга хэмжээг авдаг нь тухайн хөрөнгийг худалдан авах эрэлтийг нэмэгдүүлж, үр дүнтэй ашигтай хүсэлт авахын тулд бөгөөд тогтсон зарлалын самбард зарлал тавина. Зарчмын хувьд дуудлага худалдаа болох өдрөөс дор хаяж 10 хүртлэх хоногийн өмнөх өдөр хүртэл дуудлага худалдаанд орох хөрөнгийн нэр, дуудлага худалдааны арга, анхны үнэ, өдөр цаг, байршил гм-ийг нийтэд мэдэгдэнэ.

- ❖ Үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааг хийхдээ тухайн хөрөнгийн талаар, байршлын зураг, байрлал гм-ийг бичиж тэмдэглэсэн “дуудлага худалдааны хөрөнгийн дэлгэрэнгүй хуудас”-ыг үйлдэж, худалдан авах хүсэлтэй этгээдэд тарааж өгнө.

2.3.2. Дуудлага худалдааны мэдэгдэл

Дуудлага худалдааг нийтэд мэдэгдсэн бол өртэй татвар төлөгч, суутгалын хүсэлт гаргасан хүн, дуудлага худалдааны хөрөнгийн барьцаалсан эрх бүхий этгээдийн дотор мэдэгдэж байгаа этгээдэд “дуудлага худалдааны мэдэгдэх хуудас” (маягт 00)-аар мэдэгдэнэ. Мөн үүнтэй хамт авлагын хүсэлтийн хуудсыг худалдан борлуулах шийдвэр гарах өдрийн өмнөх өдөр хүртэл гаргах хэрэгтэй талаар мэдэгдэнэ.

2.4. Анхны үнийг тогтоох

2.4.1. Анхны үнийг тогтоох

Дуудлага худалдаа хийх тохиолдолд анхны үнийг тогтоох шаардлагатай. Энэ тохиолдолд анхны үнийг ажлын хэсэг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу (ТЕХ 68.3) дуудлага худалдааны онцлогийг харгалзан үзэж тооцно. Мөн шаардлагатай бол шинжээчийн саналыг авч ашиглах боломжтой.

2.4.2. Анхны үнийг нийтэд мэдээллэх

Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийн тендер, үнэ хаялцах арга хэмжээг хэрэгжүүлэх тохиолдолд анхны үнийг “дуудлага худалдааг олон нийтэд мэдэгдэх”-дотор бичиж тэмдэглэн мэдэгдэх шаардлагатай.

- ❖ Дуудлага худалдааг хэрэгжүүлэхдээ битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг татварын өрөнд суутгах авлагатай этгээдийн байр суурьнаас мөн өртэй татвар төлөгч, бусад ашиг сонирхлын хамааралтай хүний байр суурьнаас авч үзсэнч аль болох өндөр үнэтэй, ашигтайгаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх хэрэгтэй.

2.4.3. Дуудлага худалдааны баталгааны мөнгө

Дуудлага худалдаанд оролцох хүн татварын албаны даргын тогтоосон дуудлага худалдааны баталгааны мөнгийг (анхны үнийн 10%-аас дээш үнэ) өгнө. Тендерт оролцогч гм нь дуудлага худалдааны баталгааны мөнгө гаргасны дараа тендерт оролцоно.

2.5. Дуудлага худалдааг зохион байгуулах арга

Дуудлага худалдааг зохион байгуулах танхимийн арга болон интернетийн арга гэсэн хоёр арга байдаг. Эхний аргын хувьд интернет ашиглалгүйгээр танхимд тендерийн материал өгч, хүсэлт гаргах арга юм. Дараагийн арга нь дуудлага худалдааны цахим хуудас (интернэт дээр тендер эсхүл үнэ хаялцах ажиллагааг хэрэгжүүлж болох үйлчилгээ) -ны үйл ажиллагаа эрхэлдэг (цахим хуудас эрхлэгч) хүнийг үнэ хаялцуулах хүнээр сонгож, тухайн цахим хуудас эрхлэгчийн дуудлага худалдааны цахим хуудсыг ашиглан хэрэгжүүлдэг дуудлага худалдаа юм.

2.6. Дуудлага худалдааг зохион байгуулах арга (тендер эсхүл үнэ хаялцах ажиллагаанаас хамгийн өндөр үнэ санал болгосон хүнийг сонгох хүртэл)

2.6.1. Танхимд зохион байгуулах сонгон шалгаруулалт болон үнэ хаялцах аргыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

- 2.6.1.1. Танхимийн сонгон шалгаруулалт нь, нийтэд мэдэгдсэн өдөр, газарт худалдан авах хүсэлт гаргасан хүмүүс харилцан нэг нэгнийхээ санал болгосон үнийн дүнг мэдэх боломжгүй нөхцөлд өрсөлдөх бөгөөд худалдан авах хүсэлтэй хүмүүсээс сонгон шалгаруулалтын материалыг авч явуулдаг арга юм. Үүнд “хоногийн сонгон шалгаруулалт” болон “хугацаат сонгон шалгаруулалт” гэж байдаг.

2.6.1.2. Дуудлага худалдааг нийтэд мэдэгдсэн хугацаа болон газарт худалдан авах хүсэлт гаргасан хүмүүс харилцан нэг нэгнийхээ санал болгох үнийг мэдэж, дарааллаараа үнийн саналаа хэлж үнийн дүнг нэмэгдүүлэн явуулдаг арга нь “хоногийн үнэ хаялцах” арга юм. Анхны үнийг хамгийн доод үнэ болгон дарааллаар үнэ хаялцуулж хамгийн сүүлийн санал болгосон үнийг 3 дахин дуудах бөгөөд үүнийг давах үнийн санал гарч ирэхгүй болтол үргэлжлүүлнэ.

2.6.1.3. Дуудлага худалдааны үр дүнд анхны үнээс дээш үнэ санал болгосон ороцогч эсхүл үнэ хаялцуулах аргаар худалдан авах хүсэлт гаргагчийн дотор хамгийн өндөр үнэ санал болгосон хүнийг хамгийн өндөр үнэ санал болгосон худалдан авагчаар тогтоно. Хамгийн өндөр үнэ санал болгосон хүнийг тогтсон бол тухайн хүний овог нэр болон үнийг дуудсаны дараагаар сонгон шалгаруулалт, үнэ хаялцуулах ажиллагаа дууссаныг мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэн тохиолдолд дуудлага худалдаанд оруулсан хөрөнгө нь хөдлөх хөрөнгө, үнэт цаас, өглөгтэй гуравдагч этгээдтэй биет бус хөрөнгөнөөс бусад хөрөнгө байх бол хамгийн өндөр үнэ санал болгосон худалдан авагчийн овог нэр, үнэ, худалдан борлуулах шийдвэр гаргах өдөр, цаг газрыг өртэй татвар төлөгч болон ашиг сонирхлын харилцан хамааралтай этгээдэд мэдэгдэхийн зэрэгцээ эдгээрийг нийтэд мэдэгдэнэ. Хамгийн өндөр үнэ санал болгосон худалдан авагчаас бусад оролцогчид ажлын 3 өдрийн дотор баталгааны мөнгийг буцаан олгоно. Үүний дараа худалдан борлуулах шийдвэр, төлбөрийг төлөх, эрхийг шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.6.2. Цахим сонгон шалгаруулалт болон үнэ хаялцуулах аргыг дараах байдлаар хэрэгжүүлнэ. (⑥ -аас бусад нь сонгон шалгаруулалт, үнэ хаялцах нь адил.)

- 1) Татварын албаны цахим хуудсанд дуудлага худалдааны програмыг ашиглан интернетээр дуудлага худалдааг нийтэд зарлаж, хамгийн доод анхны үнийг бичиж мэдэгдэнэ.
- 2) Цахим дуудлага худалдаанд оролцох хүсэлтэй хүн дуудлага худалдааны зарлалд бичигдсэн хүсэлтийн хугацаанд хүсэлтээ гаргаж баталгааны мөнгийг төлнө.
- 3) Оролцох хүсэлтийг хүлээн авсан татварын албаны дарга, интернет дуудлага худалдааг хэрэгжүүлнэ.

Програмд нэвтэрч ороход хэрэгтэй хэрэглэгчийн нэр болон нууц үгийг өгч, дуудлага худалдаанд оролцогч болсоныг баталгаажуулж оролцогчид мэдэгдэнэ.

- 4) Бүртгэлийг дуудлага худалдаа эхлэхээс 30 мин өмнө хаана.
- 5) Ойролцоогоор 1 долоо хоногийн дараа худалдан авах хүсэлтийн хугацааг тогтоож (ердийн үед 2-3 өдрийн дотор) оролцогчоос худалдан авах хүсэлтийг авна.
- 6) Үнэ хаялцуулах аргын хувьд, оролцогч нь хүсэлт гаргах хугацаанд нэвтрэн орж, бусад оролцогчийн санал болгосон үнийг харах боломжтой бөгөөд санал болгож буй үнийн дүнг хэдэн удаач солих боломжтой (буулгах боломжгүй). Сонгон шалгаруулалтын хувьд дуудлага худалдаанд оролцогч нь бусад оролцогчийн санал болгосон үнийг харах боломжгүй бөгөөд зөвхөн 1 удаа үнэ санал болгох боломжтой.
- 7) Хүсэлт гаргах эцсийн хугацаа дууссан өдрийн дараах өдөр худалдан авах хүсэлтэй хүмүүсийн дотор анхны үнээс дээш хамгийн өндөр үнэ санал болгосон хүнийг хамгийн өндөр үнэ санал болгосон худалдан авагч гэж тогтож, энэ талаар бүх оролцогчид мэдэгдэхийн зэрэгцээ хамгийн өндөр үнэ санал болгосон худалдан авагчаас бусад оролцогчид ажлын 3 өдрийн дотор баталгааны мөнгийг буцаан олгоно. Үүний дараа, худалдан борлуулах шийдвэр, төлбөр төлөх, эрх шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 8) Тендерийн хугацаа дууссаны дараа ажлын хэсгийн бүх ажилчид оролцогчдийн тэмдэглэлийг нягталж, гарын үсэг зурна.

3. Шууд гэрээгээр худалдан борлуулах арга хэмжээ

3.1. Дараах тохиолдолд шууд гэрээгээр худалдан борлуулах боломжтой. ① битүүмжилсэн хөрөнгийг дуудлагаар борлуулахад тохиромжгүй эсхүл түргэн гэмтэж муудах магадлалтай байх ② хөрөнгийн биржид бүртгэлтэй хөрөнгийг тухайн өдрийн зах зээлийн үнээр борлуулах ③ дуудлага худалдааг хоёр удаа зохион байгуулсан боловч худалдан авах хүсэлтэй хүн байгаагүй, худалдан авах хүсэлт гаргасан үнэ нь дуудлага худалдааны анхны үнэд хүрэхгүй, эсхүл худалдан авагч төлбөр төлөх хугацаандаа төлбөрөө төлөөгүйгээс худалдан авах шийдвэрийг цуцалсан байх

3.2. Шууд гэрээгээр худалдан борлуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ① зарчмын хувьд шууд гэрээгээр худалдан борлуулах талаар мэдэгдэх ② анхны үнийг олон нийтэд мэдэгдэх шаардлагатай бол нийтэд мэдэгдэх ③ худалдан борлуулалт хийх өдөр худалдан авагчийг шийдэх ④ тогтсон хөрөнгийн хувьд эцсийн шийдвэрийг мэдэгдэж, нийтэд зарладаг. Үүний дараа, худалдан борлуулах шийдвэр, төлбөр төлөх, эрхийг шилжүүлэх арга хэмжээг авдаг эдгээр арга хэмжээ нь дуудлага худалдаа хэрэгжүүлэхтэй адилхан байдаг.

4. Худалдан борлуулах шийдвэр

4.1.Худалдан борлуулах шийдвэр гэдэг нь дуудлага худалдаагаар хамгийн өндөр үнэ санал болгосон худалдан авагч эсхүл шууд гэрээгээр худалдан авах болсон этгээдэд мөнгөн хэлбэрт шилжүүлэх хөрөнгийг худалдан борлуулах шийдвэр гаргах юм. Энэ худалдан борлуулах шийдвэрийн дагуу шийдвэрийг хүлээн авсан этгээд өөрөөр хэлбэл худалдан авагч болон өртэй татвар төлөгч хоорондын худалдах худалдан авах асуудал үүсч, худалдан авагч мөнгөн хэлбэрт шилжүүлэх төлбөрийг төлөх үүрэг хүлээх болно.

4.2.Худалдан борлуулах шийдвэр гаргах өдрийн хувьд тухайн мөнгөн хэлбэрт шилжүүлэх хөрөнгө нь ① хөдлөх хөрөнгө, үнэт цаас байх тохиолдолд дуудлага худалдаа хийх өдөр эсхүл шууд гэрээгээр худалдан борлуулах өдөр байх бөгөөд ② бусад хөрөнгө байх тохиолдолд дуудлага худалдаа хийх өдөр эсхүл шууд гэрээгээр худалдан борлуулсан өдрөөс 7 хоногийн дараах өдөр байна.

5. Худалдан авах төлбөр төлөх болон үр дүн

5.1.Худалдан авах төлбөр төлөх

Худалдан авагч нь худалдан авах төлбөрөө хугацаанд нь бэлэн мөнгөөр эсхүл банкаар шилжүүлж төлнө.

Худалдан авагч төлбөр төлөх эцсийн хугацаанд төлбөрөө төлөхгүй байх тохиолдолд татварын албаны дарга худалдан борлуулах шийдвэрийг цуцлах боломжтой.

5.2.Худалдан авах төлбөрийг төлсөнөөр үүсэх үр дүн

Худалдан авагч нь худалдан авах төлбөрөө төлсөн үед өртэй татвар төлөгчөөс мөнгөн хэлбэрт шилжүүлэх хөрөнгийг эзэмших эрхийг авна.

❖ Мөнгөн хэлбэрт шилжүүлэх хөрөнгийг эвдэж сүйтгэснээс үүсэх аливаа хохирлыг тухайн хүн хариуцах асуудлыг худалдан авах төлбөрийг төлсөн үед худалдан авагчид шилжүүлэх талаар дуудлага худалдааны нийтэд зарлах хэсэгт тэмдэглэж мэдэгдэнэ.

5.3.Татварын албаны байцаагч нь худалдан авах төлбөрийг хүлээн авсан үед тухайн хэмжээгээр өртэй татвар төлөгчөөс татварын өрийг хураасан гэж үзнэ.

6. Эрх шилжүүлэх арга хэмжээ

6.1.Худалдан борлуулах шийдвэрийн мэдэгдэх хуудас өгөх

Үнэт цааснаас бусад хөрөнгө байх тохиолдолд худалдан авагчид “худалдан борлуулах шийдвэрийн мэдэгдэх хуудас” –ыг өгнө. Хөдлөх хөрөнгийн хувьд өгөхгүй байж болно.

6.2.Эрх шилжүүлэх арга хэмжээ

Хөдлөх хөрөнгө гм эзэмшилтэй хөрөнгийг дамжуулан өгч, үнэт цаасны арын нүүр гм, шилжүүлгийн бүртгэл болон барьцааны эрхийг цуцлах бүртгэлийг хийлгэх, худалдан

борлуулах шийдвэрийн мэдэгдэх хуудсыг өглөгтэй гуравдагч этгээдэд өгөх, баталгааны хуудсыг өгнө.

АРАВДУГААР БҮЛЭГ. ХУВААРИЛАХ

1. Хуваарилалтын ач холбогдол

Хуваарилах гэдэг нь битүүмжилсэн хөрөнгийг худалдан борлуулсан орлого, авлагын битүүмжлэлийн дагуу өглөгтэй гуравдагч этгээдээс авсан мөнгө гм татварын өр барагдуулах үйл ажиллагаанд үндэслэн авсан мөнгийг битүүмжлэх үйл ажиллагаанд хамаарах татвар (татварын өр хураах зардал орно. Энэ бүлэгт адил утгатай.) болон бусад тодорхой зарим авлагад хуваарилах арга хэмжээ юм.

2. Хуваарилах шаардлагатай мөнгө

Хуваарилах шаардлагатай мөнгөнд дараах мөнгө орно.

2.1.Битүүмжилсэн хөрөнгийг худалдан борлуулсан орлого

2.2.Үнэт цаас, авлага эсхүл биет бус хөрөнгийн эрхийн битүүмжлэлээр өглөгтэй гуравдагч этгээдээс авсан мөнгө

2.3.Битүүмжилсэн мөнгө

2.4.Суутгалын хүсэлтээр авах мөнгө

3. Хуваарилалтын зарчим

3.1.Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн төлбөрийг хуваарилах

Өмнөх 2.1.1, 2.1.2-ын мөнгийг (цаашид “мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлого” гэнэ) дараах татвар болон бусад авлагад хуваарилана. (ТЕХ 69.1.1).

3.1.1.Битүүмжлэх ажиллагаанд хамааралтай татвар

3.1.2.Суутгалын хүсэлт авсан татвар

3.1.3.Битүүмжилсэн хөрөнгөд хамаарах барьцаат авлагын эрх, ипотекийн зээлийн эрхийн дагуу барьцаалагдсан барьцаалагдсан авлага

3.2.Битүүмжилсэн мөнгийг суутгах

Өмнөх 2.1.3 болон 2.1.4-ийн мөнгийг битүүмжилсэн эсхүл суутгалын хүсэлтэд хамаарах татварт суутгана. (ТЕХ 69.1.2).

3.3.Үлдэгдэл мөнгийг буцаан өгөх

Дээрх 3.1 болон 3.2-аар хуваарилсан мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогоос үлдэгдэл гарсан бол үлдэгдэл мөнгийг өртэй татвар төлөгчид өгнө. (ТЕХ 69.1.3).

3.4.Татвар болон бусад авлага хоорондын зохицуулалт

Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлого нь 3.1-д заасан татвар болон бусад авлагын нийт үнийн дүнд хүрэлцэхгүй байх тохиолдолд татварын давуу эрхийн заалт болон иргэний хууль, бусад хууль тогтоомжийн дагуу хуваарилалт хийх дараалал болон үнийн дүнг тогтоож хуваарилна. (ТЕХ 69.1.4)

3.5.Татварын өр хураах зардлыг тухайн үндсэн татвараас түрүүнд хураана.

Мөн дээрх 3.1 эсхүл 3.2-ын заалтын дагуу татварт хуваарилсан мөнгийг тухайн

татварын үндсэн татвар болон алдагдал, торгуульд суутгах ёстой тохиолдолд тухайн мөнгийг эхлээд үндсэн татварт суутгана. (69.1.5).

4. Хуваарилалт хийх арга хэмжээ

4.1. Авлагын дүнг нягтлах

Хуваарилалт хийхдээ эхлээд хуваарилалтаас хүртэх авлагатай этгээд болон үнийн дүнг нягтална (ТЕХ 69.2).

4.1.1. Авлагын хүсэлт гаргах

Хуваарилалтаас хүртэх авлагатай этгээд нь худалдан борлуулах шийдвэр гарах хүртэл “авлагын хүсэлт” (маягт ○○)-ийг татварын албанд гаргана. (ТЕХ 69.2.1).

Энэ авлагын хүсэлтэнд авлагын үндсэн дүн болон хүү, төлж дуусгах эцсийн хугацаа гм-ийг тэмдэглэнэ.

4.1.2. Авлагын дүнг нягтлах

Татварын албаны дарга нь авлагын хүсэлтийн хуудсыг хүлээн авч, авлагын дүнг нягтална. Мөн авлагын хүсэлт гаргаагүй тохиолдолд бүртгэгдсэн барьцаат авлагын эрх, ипотекийн зээлийн эрхийн дагуу барьцаалагдсан авлагын хувьд татварын албаны дарга шалгаж нягтална. (ТЕХ 69.2.2). Дээрх 3.1-д заасан барьцаалагдсан авлагын хувьд бүртгэгдсэнээс бусад авлагатай этгээд худалдан борлуулах шийдвэр гарах хүртэл авлагын хүсэлт гаргаагүй бол тухайн авлагатай этгээдэд хуваарилахгүй. (ТЕХ 69.2.3).

4.2. Хуваарилалтын тооцооллын акт үйлдэх

Хуваарилалт хийхдээ “хуваарилалтын тооцооллын акт” (маягт ○○) үйлдэж, мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгийн худалдан борлуулсан төлбөрийг төлсөн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор дараах этгээдэд хуваарилалтын тооцооллын актын хуулбарыг хүргүүлнэ. (тухайн этгээдэд бодит байдалд хуваарилалт хийх эсэх хамаарахгүй.) (ТЕХ 69.3.1).

4.2.1. Авлагын хэмжээг тодорхойлон хүсэлт гаргасан этгээд

4.2.2. Авлагын хэмжээг тодорхойлсон хүсэлт гаргаагүй боловч татварын албаны даргын судалгаагаар авлагын дүнг тодорхой болгосон авлагатай этгээд

4.2.3. Өртэй татвар төлөгч

4.3. Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн төлбөрийг олгох хугацаа

Хуваарилалтын тооцооллын актын хуулбарыг явуулсан өдрөөс хойш ажлын 7 өдрийн дараах өдөр (бүх өдрийг ажлын өдөр гэж үзвэл илгээх өдрийг 1 дэх өдөр гэж тооцож 8 дах өдрийг хэлнэ)-ийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн төлбөрийг өгөх гэж тогтоож хуваарилалтын тооцооллын актын хуулбарт энэ хугацааг тэмдэглэж мэдэгдэнэ. (ТЕХ 69.3.2).

Гэхдээ хуваарилалтаас хүртэх барьцаат авлагын эрх, ипотекийн зээлийн эрхтэй хүн байхгүй тохиолдолд ажлын 7 өдрийн хугацааг богиносгож болно.

4.4. Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг олгох

Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг олгох өдөр хуваарилалтын тооцооллын актын дагуу хуваарилах шаардлагатай мөнгийг олгоно. (ТЕХ 69.3.3). Шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг олгох өдөр хүртэл хуваарилалтын тооцооллын акттай холбоотой санал гомдол гаргах боломжтой (ТЕХ 69.3.3) санал гомдол гарсан тохиолдолд тухайн агуулгыг харгалзан үзэн шийдвэрлэнэ.

5. Татварын давуу эрх

5.1.Татварын давуу байдлын зарчим

Татвар нь албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх харга хэмжээний хувьд бусад авлагатай этгээдтэй өрсөлдөх тохиолдолд зарчмын хувьд улсын татварыг бусад авлагаас түрүүлж хураана. (ТЕХ 56.1).

- ❖ “түрүүлж хураана” гэдэг нь өртэй татвар төлөгчийн хөрөнгийг албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх арга хэмжээгээр мөнгөн хөрөнгөд шилжүүлж, авлагыг буцаан төлөхөд суутгах үед шилжүүлсэн мөнгөн хөрөнгө бүх авлагыг төлөхөд хүрэлцэхгүй байх тохиолдолд бусад авлагаас давуу эрхтэйгээр барагдуулахыг хэлнэ.

5.2.Татвараас давуу эрхтэй авлагууд

5.2.1.Мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны зардал (ТЕХ 56.2)

Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд суутгалын хүсэлт гаргасан бол тухайн арга хэмжээнд хамаарах зардлыг суутгалын хүсэлтэд хамаарах татвараас давуу байдалтайгаар түрүүлж гаргана.

5.2.2.Татварын өр хураах ажиллагааны шууд зардал (ТЕХ 56.3)

Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг өр хураах ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлсэн бол тухайн өр хураах ажиллагаанд шууд зарцуулсан зардлыг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн төлбөрөөс бусад татвар болон авлагаас давуу байдалтайгаар түрүүлж хураана.

5.2.3.Онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татвар (ТЕХ 56.4)

Онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татвар ногдох зүйлийг албадан гүйцэтгэх ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлсэн бол тухайн мөнгөн хөрөнгөнөөс шилжүүлгийн дүнд үүссэн онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татварыг (өр хураах шууд зардал хамаарахгүй) бусад татвар болон авлагаас түрүүлж хураана.

5.2.4.Татвар хоорондын давуу байдлын дараалал

Татвар хоорондоо адил түвшинд байдаг тул дараах байдлаар дарааллыг зохицуулна.

5.2.4.1.Битүүмжлэлийн хугацаанаас хамаарч давуу байдал үүснэ.

Түрүүлж битүүмжилсэн татвар нь түүний дараа суутгалын хүсэлт гаргасан татвараас

давуу эрхтэй байна. (ТЕХ 56.5.1)

5.2.4.2.Суутгалын хүсэлт гаргасан хугацаанаас хамаарч давуу байдал үүснэ. албадан гүйцэтгэх арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд суутгалын хүсэлтийн дарааллыг тогтоохдоо түрүүлж суутгалын хүсэлт гаргасан татвар нь түүний дараа суутгалын хүсэлт гаргасан татвараас давуу байна. (ТЕХ 56.5.2)

5.2.4.3.Барьцаат татварын давуу байдал

Барьцаат татварыг бусад татвараас давуу байдалтайгаар (өр хураах ажиллагааны зардал болон онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татвар (ТЕХ 56.4) хамаарахгүй) барьцаат хөрөнгийн мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогоос хураана (ТЕХ 56.5.3).

5.2.5.Барьцаат эрх, ипотекийн зээлийн эрх эсхүл гуравдагч этгээдээс давуу байх нэхэмжлэхийн дагуу барьцаалагдсан авлагын давуу байдал

Барьцаат эрх, ипотекийн зээлийн эрх эсхүл гуравдагч этгээдээс давуу байх нэхэмжлэхийн дагуу барьцаалагдсан авлагыг татвараас (өр хураах ажиллагааны зардал болон онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татвар гм хамаарахгүй) түрүүлж хураана (ТЕХ 56.6).

Гэхдээ бүртгэлгүй барьцааны эрх эсхүл бүртгэлгүй гуравдагч этгээдээс давуу байх нэхэмжлэхийн хувьд хэрэгжүүлэгч байгууллагад авлагатай гэдгийг баталсан тохиолдолд татвараас давуу байна. Баталж чадахгүй тохиолдолд давуу эрх эдлэх боломжгүй. (ТЕХ 56.8).

5.2.6.Хохирол барагдуулах нэхэмжлэх эрх, тэжээх үүрэгт хамаарах нэхэмжлэх эрх гм нь, Татварын ерөнхий хуулийн зүйл заалтаас үл хамааран татвар болон бусад авлагаас түрүүнд суутгагдана.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАТВАР ТӨЛӨХ ХУГАЦААНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО

Татвар төлөгч татвараа хугацаанд төлөх боломжгүй тохиолдолд зарчмын хувьд тогтсон арга хэмжээний дагуу албадан хураадаг. Гэхдээ татвар төлөгчийн хувийн нөхцөл байдлаас шалтгаалан албадан хураахад тохиромжгүй байх тохиолдол байдаг. Ийм тохиолдолд авах боломжтой арга хэмжээ нь татвар төлөх хугацааны хөнгөлөлтийн арга хэмжээ юм.

1. Хугацааны хөнгөлөлт үзүүлэх нөхцөл

Татвар төлөгч (татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд, татварын батлан даагч хамаарна. Цаашид энэ бүлэгт адил утгаар ойлгоно.) дор дурдсан нөхцөл байдлын аль нэг үүсэж үүнээс болж татварын өрийг төлөх боломжгүй болох нь тогтоогдсон бол тухайн төлөх боломжгүй үнийн дүнгээр 1 жил хүртэлх хугацаагаар татвар төлөх хөнгөлөлт үзүүлэх боломжтой.(ТЕХ 53.1 болон ТЕХ 53.2)

1.1.Татвар төлөгч нь гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан гамшиг болон үер, газар хөдлөлт, гал түймэрт өртсөн(ТЕХ 53.1.1)

1.2.Татвар төлөгч өвчин тусч өмнөх жилийн татвар ногдох орлогоос илүү хэмжээтэй эмчилгээний зардал гаргасан(ТЕХ 53.1.2)

1.3.Татвар төлөгч эрхэлж байгаа үйл ажиллагаагаа зогсоосон(ТЕХ 53.1.3)

1.4.татвар төлөгчийн үйл ажиллагаанд 3 жил дараалан их хэмжээний алдагдал хүлээж, төлбөрийн чадвар муудсан(ТЕХ 53.1.4)

❖ “Тухайн нөхцөл байдал үүсэж татварын өрийг төлөх боломжгүй болсон” гэдэг нь тухайн нөхцөл байдалд үндэслэн зардал гарсан эсхүл хохирол учирч, санхүү муудсанаас болж татварын өрийг төлөх боломжгүй болсоныг хэлнэ. Иймд хугацааны хөнгөлөлт эдлэх боломжтой татварын хэмжээ нь тухайн зардал эсхүл хохирлын хэмжээгээр хязгаарлагдана.

❖ Төлөхөд хүндрэлтэй татварын хэмжээ болон хуваан төлөх хэмжээг тооцохдоо төлбөрийн чадварын судалгаанд үндэслэн тогтоно.

2. Хугацааны хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ

Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийг эдлэх хүсэлтэй татвар төлөгч “татвар төлөх хугацааны хөнгөлөлтийн хүсэлтийн хуудас”-ыг татварын албаны даргад гаргана. (ТЕХ-ийн 53.3.4).

Энэхүү хугацааны хөнгөлөлтийн хүсэлтэд хөрөнгийн байдал болон санхүүгийн чадавхийг бичихийн зэрэгцээ тэдгээрт үндэслэн гаргасан хуваан төлөх төлөвлөгөөг тусгана (ТЕХ-ийн 53.3.4). Хүсэлт хүлээн авсан тохиолдолд хөнгөлөлт үзүүлэх эсэхийг бичгээр мэдэгдэнэ (Хугацааг дахин сунгах тухайд мөн адил) (ТЕХ-ийн 53.9).

- ❖ Хугацааны хөнгөлөлтийн хүсэлтийг хөнгөлөлт үзүүлэх нөхцөл байдал үүссэн нөхцөлд л гаргах боломжтой.

3. Хугацааны хөнгөлөлтийн үед гаргах барьцаа

Татвар төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлэхдээ барьцаа авна. Гэхдээ татварын өрийн хэмжээ 1 сая төгрөгөөс бага эсхүл хөнгөлөх хугацаа нь 3 сарын дотор байвал барьцаа хөрөнгө шаардахгүй (ТЕХ-ийн 53.3.1). Барьцааны хөрөнгийн төрөл нь үл хөдлөх хөрөнгө, Засгийн газрын үнэт цаас болон батлан даагчийн баталгаа байх ба барьцаалах ажиллагааг Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг баримтлан хэрэгжүүлнэ (ТЕХ-ийн 53.3.2, 53.3.3).

4. Хугацааны хөнгөлөлтийн нөлөө

- 4.1. Татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдэлж байх хугацаанд хөнгөлөгдсөн татварын хувьд шинээр нэхэмжлэх хүргүүлэх болон татварын өр хураах ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй (ТЕХ-ийн 53.4).
- 4.2. Хөрөнгө битүүмжилсэн байгаа тохиолдолд хүсэлт гарган битүүмжлэлийг цуцлах боломжтой (ТЕХ-ийн 60.8)
- 4.3. Хугацааны хөнгөлөлт эдэлж байх хугацаанд алдангийн 20%-ийг хөнгөлнө (ТЕХ-ийн 53.5)

5. Цуцлах

Татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдэлж буй татвар төлөгчид дараах нөхцөл байдал үүсвэл хугацааны хөнгөлөлтийг цуцалж барьцааны хөрөнгөөс татварын өрийг гаргуулна (ТЕХ-ийн 53.6).

- 5.1. Татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдлэх хугацаанд эрсдэлтэй татварыг урьдчилан хураах нөхцөл байдал үүсч, хөнгөлөлтийн хугацаанд татварын өрийг бүрэн хураахааргүй болсон
- 5.2. Хуваан төлөх хуваарийн дагуу төлөөгүй
- 5.3. Барьцааны зүйлийг өөрчлөхийг зөвшөөрөөгүй
- 5.4. Түүний дараа гарах нөхцөл байдлын өөрчлөлт нь хугацааны хөнгөлөлтийг үргэлжлүүлэхэд зохисгүй

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТАТВАР ТӨЛӨХ ҮҮРЭГТЭЙ ХОЁРДОГЧ ЭТГЭЭДИЙН ТОГТОЛЦОО

1. Нийтлэг үндэслэл

Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийн тогтолцоо нь татварын өрийг хураах нэгэн арга бөгөөд үндсэн татвар татвар төлөгч (татварын өрийг төлөх үндсэн үүрэгтэй этгээдийг хэлнэ.)-өөс татварын өрийг хураах боломжгүй тохиолдолд өртэй татвар төлөгчтэй тодорхой харилцаатай этгээдэд татвар төлөх үүргийг үүрүүлэхийн тулд хуулинд тусгайлан оруулсан тогтолцоо юм.

1.1 Татвар төлөх үүрэг үүсэх

ТЕХ-д заасан татвар төлөгч татварын өртэй болсон бөгөөд энэ зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа этгээдэд татвар төлөх хоёрдогч этгээдийн үүрэг үүснэ.

* татвар төлөх хоёрдогч үүрэг үүсч мэдэгдэх хуудас (маягт 00) хүргүүлж үүнийг баталгаажуулсаны дараа тухайн үүрэг үүсэх нөхцөл, шаардлагад өөрчлөлт орсон байлаа ч нэгэнт баталгаажсан татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд нөлөөлөхгүй.

* татвар төлөх хоёрдогч үүрэг үүсэх нөхцөлтэй холбоотой шүүхийн шийдвэр (шүүхийн шийдвэртэй адил үйлчлэлтэй шийдвэр хамаарна.) -ээр тухайн нөхцөл шаардлагад хамаарах бодит байдал үгүй болсон эсхүл татвар төлөх хоёрдогч үүргийн талаар мэдэгдэх хуудсаар мэдэгдэх үндэс болсон нөхцөл шаардлагаас ялгаатай бодит байдал бий болсон тохиолдолд тухайн мэдэгдлийг цуцлана.

1.2 Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд болон өртэй татвар төлөгч хоорондын харилцаа

Татвар төлөх хоёрдогч үүрэг нь үндсэн татвар төлөх үүргийг нөхөж буюу нэмэлтээр байгаа үүрэг юм. Өөрөөр хэлбэл татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд нь үндсэн татвар төлөх үүрэг биелээгүй буюу татварын өр үүссэн түүнчлэн хураах дүнд хүрэлцэхгүй байгаа нь тодорхой болсон тохиолдолд хоёрдогч буюу нөхөх үүргийн биелэлтийг шаардах бөгөөд гол татвар төлөх үүрэгтэй холбоотой үүссэн үйлчлэл нь зарчмын хувьд татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд ч мөн адил үйлчилнэ.

1.2.1 Татвар төлөх үүргийн биелэлт хоорондын харилцаа

Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд нь татвар төлөх үүргээ биелүүлсэн тохиолдолд үндсэн татвар төлөх үүрэг тухайн биелэлтийн хэмжээгээр хасагдах бөгөөд өртэй татвар төлөгч нь татвар төлөх үүргийн биелэлтийг бүрэн хангасан тохиолдолд татвар төлөх хоёрдогч үүрэг дуусгавар болно.

1.2.2 Татвар төлөх үүргээс чөлөөлөх харилцаа

Үндсэн татвар төлөх үүргийн чөлөөлөлт нь татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд мөн адил үйлчлэх боловч татвар төлөх хоёрдогч үүргийн чөлөөлөлт нь үндсэн татвар төлөх үүрэгт хамаарахгүй.

1.2.3 Татвар төлөх хугацааны хөнгөлөлт хоорондын хамаарал

Үндсэн татвар төлөх үүрэгт хамаарах татвар төлөх хугацааны хөнгөлөлт нь татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд үйлчлэх учраас татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд төлбөр төлөх мэдэгдэл, шаардлага болон татварын өр барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй. Харин нөгөөтэйгүүр татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдийн татвар төлөх хугацааны хөнгөлөлт нь үндсэн татвар төлөх үүрэгт хамаарахгүй.

1.3 Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдээс татварын өрийг гаргуулах арга хэмжээ

1.3.1 Мэдэгдэх хуудсаар татварын үүрэг ногдуулах

Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдээс татварын өрийг гаргуулах тохиолдолд татварын албаны дарга тухайн хоёрдогч этгээдэд төлөх ёстой татварын дүн, эцсийн хугацаа (мэдэгдэх хуудас хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 20 өдрийн дараах өдөр (ТЕХ 58.2)), газар байр болон бусад шаардлагатай мэдээллийг бичиж тэмдэглэсэн мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ (ТЕХ 58.1). Энэхүү мэдэгдэх хуудас нь хийсвэрээр үүсээд байсан татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдийг тодорхой болгож баталгаажуулах шинж чанарыг агуулдаг учир, албан ёсоор бие даасан татвар ногдуулах арга хэмжээ болохын зэрэгцээ бодит байдалд үндсэн татвар ногдуулах арга хэмжээний дагуу бий болсон татвар төлөх үүргийн нэг арга хэмжээ болно. Мөн энэхүү үүргийн үйлчлэл нь мэдэгдэх хуудас хүргүүлсэнээр үүснэ.

* Өртэй татвар төлөгчид нэхэмжлэх хүргүүлсэн эсэхээс үл хамааран татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд мэдэгдэх хуудсыг хүргүүлэх боломжтой. Түүнчлэн татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд мэдэгдэхдээ өртэй татвар төлөгч татварын өртэй болж буй тухайн үед хүргүүлэх боломжтой.

1.3.2 Нэхэмжлэх

Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд татварыг заасан хугацаанд бүрэн төлөөгүй бол татварын алба “эрсдэлтэй татварыг урьдчилан хураах” үйл ажиллагааг явуулахаас бусад тохиолдолд нэхэмжлэх хүргүүлнэ (ТЕХ 58.3). Энэ нэхэмжлэхэд “татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд болон өртэй татвар төлөгчийн овог нэр, татвар

төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдийн төлөх татварын дүн” гм татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд хамааралтай мэдээллүүдийг бичиж тэмдэглэх шаардлагатай.

1.3.3 Татварын өр барагдуулах үйл ажиллагаа

Нэхэмжлэх хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд нь нэхэмжлэх дэх татварын өрийг бүрэн барагдуулаагүй бол татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдийн хөрөнгийг битүүмжлэх боломжтой.

1.3.4 Урьдчилан хураах, татвар төлөх хугацааны хөнгөлөлт

54-р зүйлийн (Эрсдэлтэй татварыг урьдчилан хураах) заалт болон 53-р зүйлийн (татвар төлөх хугацааны хөнгөлөлт) -ийн заалт татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд нэгэн адил үйлчилнэ (ТЕХ 58.4).

1.3.5 Мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааны хязгаарлалт

Хөрөнгийн үнэ цэнэ огцом буурах магадлалтайгаас бусад тохиолдолд татварын өрийг өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийн хөрөнгөөс татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлж болохгүй (ТЕХ 58.5). Мөн татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд нь мэдэгдэл, нэхэмжлэх эсхүл өр барагдуулах үйл ажиллагааны талаар маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан эсхүл шүүхэд гомдол гаргасан бол тухайн асуудал хэлэлцэгдэх хугацаанд эсхүл эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдийн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлж болохгүй.

2. ТЕХ-ийн 57-р зүйлийн татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээд

Татвар төлөгч хуулиар тогтоосон татвар төлөх эцсийн хугацаанаас нэг жилийн өмнөх өдрөөс хойш хугацаанд хөрөнгөө үнэгүй, эсхүл хэт бага үнээр бусдад шилжүүлсэн, бусдаас авах авлагаа хүчингүй болгож бусад этгээдэд ашигтай байдлыг бий болгосон бол тухайн хөрөнгийн шилжүүлэн авсан этгээдэд татвар төлөх хоёрдогч үүргийг үүрүүлж болно. Үүнийг хууран мэхлэх, луйврын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээний оронд хялбар хурдан шуурхайгаар татварыг хураан авах арга гэж харж байхад нөгөөтэйгүүр нэг төрлийн шударга бусаар ашиг олохтой адил гэж харах нь ч бий.

2.1 Үүрэг бий болох нөхцөл шаардлага

Энэхүү татвар төлөх хоёрдогч үүрэг нь дараах нөхцөл шаардлагын дагуу үүснэ.

2.1.1 Татвар төлөгч хөрөнгөө үнэгүй, эсхүл хэт бага үнээр бусдад шилжүүлсэн, бусдаас

авах авлагаа хүчингүй болгож бусад этгээдэд ашигтай байдлыг бий болгосон байх (улс болон олон нийтийн корпораци хамаарахгүй) .

2.1.1.1 “үнэгүй, эсхүл хэт бага үнээр бусдад шилжүүлэх” гэдэг нь бэлэглэх, хөрөнгө зааж гэрээслэлээр бэлэглэх, худалдах худалдан авах, солилцоо хийх, авлагыг шилжүүлэх, хөрөнгө оруулах, хөрөнгөөр орлуулан төлж эрхийг шилжүүлэх зэргийг хэлэх бөгөөд өв залгамжлал зэрэг ерөнхий залгамжлалаар олгосон зүйл бол хамаарахгүй. Энэ тохиолдолд худалдах худалдан авах, солилцоо хийх, авлагыг шилжүүлэхийн хувьд үүгээр дамжуулан олсон мөнгөн хөрөнгө эсхүл хөрөнгө, хөрөнгө оруулалтын хувьд үүгээр дамжуулан авсан хувьцаа, хувь оролцоо, хөрөнгөөр орлуулан төлөхийн хувьд үүгээр дамжуулан утсан өглөг, аль аль нь “төлбөр” болно.

2.1.1.2 “хэт бага үнэ” –ээр өгсөн эсэх талаар тухайн хөрөнгийн төрөл, тоо, одоогийн үнэ болон төлбөрийн зөрүү хэр зэрэг байгааг ерөнхийд нь анхаарч ердийн үеийн ажил гүйлгээтэй харьцуулахад хэт бага үнэ болох эсэх гэдгээр тодорхойлж болох хэдий ч дараах зүйлүүдэд анхаарах хэрэгтэй.

- Ерөнхийдөө одоогийн үнэ нь тодорхой хөрөнгө (зах зээлд байгаа хувьцаа, бонд гм) -ийн хувьд төлбөр нь одоогийн үнээс бага байх тохиолдолд тухайн зөрүү үнэ нь харьцангуй бага байсан ч “хэт бага үнэ” гэж тодорхойлох тохиолдол байдаг.
- Үнийн цар хүрээ өргөн хөрөнгийн (ҮХЭХ гм) хувьд төлбөр нь одоогийн үнээс ойролцоогоор 2-ны 1-д (ойролцоогоор 2-ны 1 гэдэг нь 2 хуваасны 1 –ээс тодорхой хэмжээгээр нааш цааш хэлбэлзэхийг хэлнэ) хүрэхгүй байх тохиолдолд онцгой нөхцөл байдалтайгаас бусад тохиолдолд “хэт бага үнэ” гэж тооцно.

* төлбөр нь одоогийн үнээс маш бага байсан ч үүнийг хэт бага үнэ гэж үзэхгүй бол энэ зүйлийн нөхцөл шаардлагыг хангахгүй болно.

2.1.1.3 “Хэт бага үнээр шилжүүлсэн” эсэхийг тодорхойлохдоо зарчмын хувьд тухайн шилжүүлгийг хийх үндэс болсон гэрээг байгуулсан хугацаагаар тодорхойлно.

2.1.1.4 “Авах авлагаа хүчингүй болгох” гэдэг нь Иргэний хуулийн 239-р зүйл «чөлөөлөх» заалтын дагуу авах авлага хүчингүй болохыг хэлнэ. Энэ тохиолдолд авах авлагыг хүчингүй болгосон болон төлбөр хоорондын харилцаанд эсрэг ашиг олсон нөхцөл үүссэн бол үүнийг “төлбөр” гэж үзнэ.

2.1.1.5 “Бусад этгээдэд ашигтай байдлыг бий болгох” гэдэг нь хөрөнгийг шилжүүлэх, авах авлагаа хүчингүй болгосноос бусад арга хэмжээний дотор өртэй татвар төлөгчийн

актив хөрөнгө буурсны үр дүнд (өртэй татвар төлөгчий өөрт буй онцгой эрхээ хэрэгжүүлэх хэрэгжүүлэхгүй байх үр дүнгээс бий болох зүйл хамаарахгүй.), бусад этгээдэд ашигтай байдлыг бий болгож буй байдлыг хэлэх бөгөөд жишээ нь газар дээрх, газар дээрх эрх, ипотекийн барьцааны эрх, түрээсийн эрх гм-ийг тогтоох, өв залгамжлалын хөрөнгийг хуваарилах хамтын ажиллагаа, хувьцаа эзэмшигчид олгох илүүдэл ногдол ашиг гм юм. Энэ тохиолдолд эрхээ шилжүүлэхэд оронд нь авсан төлбөр (жишээ нь эрхийн төлбөр, талархлын мөнгө гм) байгаа бол энэ нь “төлбөр”-тэй дүйцнэ.

2.1.2 Дээрх үнэгүй эсхүл хэт бага үнээр шилжүүлсэн, бусдаас авах авлагаа хүчингүй болгосон, бусад этгээдэд ашигтай байдлыг бий болгосон үйл явдал хуулиар тогтоосон татвар төлөх эцсийн хугацаанаас нэг жилийн өмнөх өдрөөс хойш хийгдсэн байх. Энэ “хуулиар тогтоосон хугацаанаас нэг жилийн өмнөх өдрөөс хойш хугацаа”-д хуулиар тогтоосон хугацаанаас нэг жилийн өмнөх өдөр орно. Түүнчлэн дараахзүйлд анхаарах хэрэгтэй.

- 1) Гэрээ байгуулсан үе болон үүнд үндэслэн шилжүүлэх арга хэмжээг авсан үе нь (эрхийг авч үүргээс чөлөөлөгдөх үе) өөр байх тохиолдолд шилжүүлэх арга хэмжээг авсан тухайн өдрийг нэг жилийн өмнөх өдрөөс хойш хугацаа мөн эсэхийг тогтооно.
- 2) Шилжүүлгийг хийхдээ гуравдагч этгээд заргалдах боломжгүй болгохоор бүртгүүлэх эсхүл үйлчлэл үүсэх нөхцөл шаардлагатай бол, тухайн шаардлага тавьсан өдрийг нэг жилийн өмнөх өдрөөс хойш хугацаа мөн эсэхийг тогтооно. Энэ тохиолдолд түр бүртгэл болон үүнд үндэслэсэн үндсэн бүртгэл байх бол үндсэн бүртгэлээр тооцно.

2.1.3 Өртэй татвар төлөгчийн хөрөнгөд өр барагдуулах ажиллагааг хэрэгжүүлээ ч татварын өрөнд хүрэлцэхгүй байх (цаашид “татвар хураахад хүрэлцэхгүй байх” гэнэ). Энэ тохиолдолд дараах байдлаар тогтооно.

- 1) Татвар хураахад хүрэлцэхгүй гэдгийг тодорхойлохдоо, өртэй татвар төлөгчийн хөрөнгөөр өр барагдуулах ажиллагааг хэрэгжүүлснээр хураах боломжтой мөнгөн дүн болон өртэй татвар төлөгчийн татварын өрийн нийт дүнг (татвар хураахад хүрэлцэхгүй гэх шийдвэр гарах хүртлэх алданги, өр барагдуулах ажиллагааны зардал болон татвар төлөх эцсийн хугацаа болоогүй ч тодорхой болсон татварын өр хамаарна.) харьцуулж тогтооно.
- 2) Энэ тохиолдолд өртэй татвар төлөгчид харьяалагдах хөрөнгөд бүртгэлийн

албан бичиг баримт эсхүл бусад бүртгэлийн бичиг баримтаас л хөрөнгийн судалгааг хийх бус шаардлагатай тохиолдолд асуулга, шалгалт, үзлэгээр судлана.

2.2 Татвар төлөх үүрэгтэй этгээд

Татвар төлөх хоёрдогч үүрэг үүрэх этгээд нь үнэгүй шилжүүлгийн дагуу эрхийг авсан эсхүл үүргээс чөлөөлөгдсөн байна. Энэ тохиолдолд “эрх авч эсхүл үүргээс чөлөөлөгдсөн этгээд” гэдэг нь үнэгүй шилжүүлэх арга хэмжээний дагуу эзэмших эрх, газар дээр, түрээсийн эрх, биет бус хөрөнгийн эрх болон бусад хөрөнгийн эрхийг авсан этгээд эсхүл өглөгөөс чөлөөлөгдсөн этгээд, үүрэх ёстой өглөгөөс чөлөөлөгдсөн этгээд байна.

2.3 Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдийн татвар төлөх үүргийн хамрах хүрээ

2.3.1 Татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдээс хураан авах боломжит мөнгөн дүн нь үнэгүй шилжүүлсэнээр олж авсан ашгийн хэмжээгээр хязгаарлагдаж, өртэй татвар төлөгчийн нийт өр байна.

2.3.2 Үнэгүй шилжүүлсэнээр олж авсан ашиг нь дараах “үнэгүй шилжүүлсэнээр олж авсан хөрөнгийн үнэ”-ээс “төлбөрийн үнэ” (үнэгүй шилжүүлэх арга хэмжээ авсан үеийн төлбөр) болон ашиг олохын тулд зарцуулсан зардалаар шууд хамааралтай зүйл” – ийг хассан үнийн дүн

- 1) Үнэгүй шилжүүлсэнээр өртэй татвар төлөгчөөс авсан ашиг нь мөнгөн хөрөнгө байх бол тухайн үнийн дүн
- 2) Мөнгөн хөрөнгөөс бусад зүйл байх бол үнэгүй шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлсэн бодит байдалдах тухайн хөрөнгийн үнийг авах авлагаа хүчингүй болгосон үеийн авлагын үнийн дүн

* Авах авлагаа хүчингүй болгосноор олж авсан ашгийг тооцохдоо гуравдагч өглөгтэй этгээдийн төлөх чадвар, бүрэн төлж дуусах хугацаа, барьцаатай эсэх гэдгийг бодолцон үзэж тогтоосон үнийн дүн

- 3) Эрхийн шилжүүлэг байх тохиолдолд тухайн арга хэмжээг авсан бодит нөхцөл байдалдах тухайн эрхийн үнэ

* “ашиг олохын тулд зарцуулсан зардалтай шууд хамааралтай зүйл” гэдэг нь жишээ нь гэрээтэй холбоотой зардал, бүртгэлийн улсын тэмдэгтийн хураамж гм юм.

2.3.3 Үнэгүй шилжүүлэх гм арга хэмжээнүүдийн дараа авсан ашиг нь утсанаас болж одоо байхгүй байгаа тохиолдолд, авсан хөрөнгөндөө зардал гаргасан тохиолдолд, тухайн хөрөнгөний барьцааны эрх, түрээсийн эрх гм-ийг бий болгосон тохиолдолд, авсан хөрөнгөнөөс үүссэн үр шим байгаа тохиолдолд байсан ч эдгээр нөхцөл байдлыг тооцож үзэхгүй.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТАТВАРЫН ӨР БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИЛЖҮҮЛЭХ

13.1. Татварын өр барагдуулах үйл ажиллагааг шилжүүлэх боломжтой тохиолдол Татварын албаны дарга битүүмжилбэл зохих хөрөнгө болон битүүмжилсэн хөрөнгө нь тухайн албаны харьяа нутаг дэвсгэрийн гадна оршиж байвал тухайн хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн татварын албаны даргад татварын өр хураах ажиллагааг шилжүүлэх боломжтой (ТЕХ-ийн 70.1). Мөн татварын албаны дарга битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай бол өөр татварын албаны даргад татварын өр хураах ажиллагааг шилжүүлэх боломжтой (ТЕХ-ийн 70.2).

13.2. Ажиллагааг шилжүүлэх тухай ойлголт болон хамрах хүрээ
ТЕХ-ийн 70.1-д заасан татварын өр хураах ажиллагааг шилжүүлэх гэдэг нь татварын өрийг хураах ажиллагаа хэрэгжүүлэх урьдач нөхцөл болох нэхэмжлэхийг хүргүүлсэн татварын өрийн хувьд хөрөнгийг битүүмжлэх, суутгах хүсэлт гаргах, авлагыг хураах, дуудлага худалдаа зохиох, дуудлага худалдааны орлогыг авах, суутгал хийх болон хуваарилах эрхийг бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шилжүүлэхийг хэлнэ. Харин ТЕХ-ийн 70.2-т заасан татварын өр хураах ажиллагааг шилжүүлэх гэдэг нь битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх эрхийг бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шилжүүлэхийг хэлнэ.

13.3. Татвар төлөгчид мэдэгдэх тухай

Татварын өр хураах ажиллагааг шилжүүлсэн тохиолдолд шилжүүлэн авсан татварын алба даруй тэр тухайгаа татварын өр хураах ажиллагааг шилжүүлэн авсан тухай мэдэгдэх хуудсаар (...-р маягт) татвар төлөгчид мэдэгдэнэ (ТЕХ-ийн 70.3).

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АЛДАНГИЙН ХӨНГӨЛӨЛТ

ТЕХ-ийн 53 дугаар зүйлийн дагуу татвар төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлсэн тохиолдолд хөнгөлөх алданги гэдэг нь алданги төлөх үүргийн нэг хэсгийг л хөнгөлж байгаа явдал бөгөөд дараах байдлаар хэрэгжүүлнэ.

14.1 Алданги хөнгөлөх хугацаа нь татвар төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлэх хугацаа байна.

14.2 Алдангиас хөнгөлөх хэмжээ нь хугацааны хөнгөлөлт үзүүлэх хугацаанд үүссэн алдангийн 20% байна (ТЕХ-ийн 53.5).

14.3. Алдангийн хөнгөлөлтийг үндсэн татвар бүрэн төлөгдсөнийн дараа алдангийг хураах үед үзүүлнэ.

14.4. Алдангиас хөнгөлсөн тохиолдолд алданги хөнгөлөх шийдвэрийн хуудсаар (...-р маягт) шийдвэр гаргасны дараа үндсэн татварын тайлант он, татварын төрөл, хэмжээ болон хөнгөлөх хугацаа зэргийг тусгасан алдангиас хөнгөлөх мэдэгдэх хуудсыг (...-р маягт) татвар төлөгчид хүргүүлж мэдэгдэнэ.

**ХОЛБОГДОХ МАЯГТУУД
(ТӨСӨЛ)**

МАЯГТЫН ЖАГСААЛТ

Маягт 1	Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үеийн онцгой татвар хураах мэдэгдэх хуудас 1
Маягт 2	Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үеийн онцгой татвар хураах мэдэгдэх хуудас 2
Маягт 3	Битүүмжлэлийг солих тухай нэхэмжлэх хуудас
Маягт 4	Битүүмжлэлийг солих тухай нэхэмжлэлийг татгалзах тухай мэдэгдэл
Маягт 5	Даатгалд хамрагдсан хөрөнгийг битүүмжлэх мэдэгдэл
Маягт 6	Барьцааны эрх бүхий хөрөнгийг битүүмжлэх мэдэгдэл
Маягт 7	Хөрөнгө шилжүүлэхийг үүрэг болгох хуудас
Маягт 8	Хөрөнгө шилжүүлэхийг үүрэг болгосон тухай мэдэгдэл
Маягт 9	Бичиг баримт хураах тухай акт
Маягт 10	Битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авах тухай акт
Маягт 11	Битүүмжилсэн хөрөнгийг ашиглах зөвшөөрлийн хүсэлт
Маягт 12	Хөрөнгийг битүүмжлэх актыг хүчингүй болгох тухай мэдэгдэл 1 (Өртэй татвар төлөгч, гуравдагч өглөг бүхий этгээд)
Маягт 13	Хөрөнгийг битүүмжлэх актыг хүчингүй болгох тухай мэдэгдэл 2 (Харилцан хамааралтай этгээд)
Суутгах хүсэлт	
Маягт 14	Суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл 1 (Гүйцэтгэх байгууллага, өртэй татвар төлөгч)
Маягт 15	Суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл 2 (өртэй татвар төлөгч)
Маягт 16	Суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл 3 (Эрх бүхий этгээд)
Маягт 17	Суутгах хүсэлтийг хүчингүй болгох тухай нэхэмжэл
Маягт 18	Суутгах хүсэлтийг хүчингүй болгохыг татгалзах тухай мэдэгдэл
Дуудлага худалдаа	
Маягт 19	Дуудлага худалдааны зар
Маягт 20	Дуудлага худалдааны мэдэгдэл
	Дуудлага худалдааны урьдчилсан мэдэгдэл
Маягт 21	Дуудлага худалдааны мэдэгдэл ба авлагын хүсэлт гаргах тухай шаардлага
Маягт 22	ҮХХ-ийн дуудлага худалдааны ялагчийг тогтоох шийдвэрийн мэдэгдэл
Маягт 24	Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгийг худалдан авах хүсэлтийг хүчингүй болгох тухай өргөдөл
Маягт 25	ҮХХ-ийн дуудлага худалдааны ялагчийн шийдвэрийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл
Маягт 26	Худалдах шийдвэрийг хүчингүй болгох тухай мэдэгдэл
Маягт 27	Авлагын өнөөгийн дунгийн талаарх хүсэлт 1 (хувийн авлага)
Маягт 28	Авлагын өнөөгийн дунгийн талаарх хүсэлт 2 (татварын албанд)
Маягт 30	Татварын өр барагдуулалтын үйл ажиллагааг шилжүүлсэн тухай мэдэгдэл
Татвар төлөх хугацааны хөнгөлөлт	
Маягт 32	Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийн хүсэлт
Маягт 33	Татвар төлөх баталгаа
Маягт 34-1	Татвар төлөх тухай мэдэгдэл
Маягт 34-2	Барьцааны хуудас
Маягт 35	Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийн зөвшөөрлийн мэдэгдэл

Маягт 40	Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийн хугацаа сунгах тухай хүсэлт
Маягт 41	Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийг сунгах зөвшөөрлийн мэдэгдэл
Маягт 43	Татвар төлөх хугацааны хөнгөлөлтийг хүчингүй болгох тухай мэдэгдэл
Татвар төлөх хоёрдогч үүрэг	
Маягт 46	Татвар төлөх хоёрдогч үүргийн тухай мэдэгдэл
Маягт нэмэлт	Татвар төлөх хоёрдогч үүрэг бүхий үнийн дүнг хүчингүй болгосон тухай мэдэгдэл
Маягт нэмэлт	Олон нийтэд мэдэгдэх хуудас

Маягт 1 (Гүйцэтгэх байгууллагад зориулав)

Ашиглах хүрээ

Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үеийн онцгой татвар хураах мэдэгдэх хуудас 1						
он сар өдөр						
Гүйцэтгэгч байгууллагын нэр						
Татварын хэлтсийн дарга СЯ-ны ТНБД тамга						
Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагаанд оруулж буй дараах эд барааны хувьд ТЕХ-ийн 56.4 дэх заалтын дагуу худалдан борлуулсан төлбөрөөс дор дурдсан онцгой татварыг хураана.						
Татвар төлөгч (эд барааны эзэмшигч)	хаяг					
	Овог нэр					
Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагаанд оруулж буй эд хөрөнгө болон татварын дүн	Хөрөнгийн нэр	Төрөл эсхүл	Тоо хэмжээ	Татварын төрөл	Татварын хувь	Татварын дүн
Гүйцэтгэгч байгууллагын нэр				Битүүмжилсэн он сар өдөр		

1. Энэхүү мэдэгдэх хуудсыг ТЕХ-ын 56.4 дэх заалтад хамаарах тохиолдолд хэрэгжүүлэгч байгууллагад мэдэгдэл хүргэхийн тулд ашиглах бөгөөд мэдэгдэл хүргэж буй хэрэгжүүлэгч байгууллагын битүүмжлэлийн акт (хуулбар) эсхүл үйл явц тус бүрээр тусад нь үйлдэнэ.
2. Энэхүү мэдэгдэх хуудсыг “Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үеийн онцгой татвар хураах мэдэгдэх хуудас” 2 (Татвар төлөгчийн хэрэгцээнд) ын хамт олон хувиар үйлдэнэ.
3. “Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагаанд оруулж буй эд хөрөнгө болон татварын дүн” хэсгийн “хөрөнгийн нэр” хэсэгт албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг явуулж байгаа онцгой татвар ногдуулагдсан хөрөнгийн нэр, байгаа газар зэргийг тэмдэглэн “төрөл, ангилал” хэсэгт татвар ногдуулсан хөрөнгийн төрөл болон ангилал зэргийг тэмдэглэнэ.
4. “Гүйцэтгэгч байгууллагын нэр” хэсэгт мэдэгдэл хүргүүлэх байгууллагын нэрийг бичиж тэмдэглэнэ.
5. “Битүүмжилсэн он сар өдөр” хэсэгт албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагаа нь татварын өр барагдуулах арга хэмжээ байх тохиолдолд битүүмжлэл хийсэн он сар өдөр, бусад арга хэмжээ байх тохиолдолд тухайн арга хэмжээтэй холбоотой хэргийн дугаарыг бичиж тэмдэглэнэ.

Маягт 2 (Татвар төлөгчид зориулав)

Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үеийн онцгой татвар хураах мэдэгдэх хуудас 2		
он сар өдөр		
Татвар төлөгч		
Хаяг		
Овог нэр		
Татварын хэлтсийн дарга		
СЯ-ны ТНБД		
тамга		
Дараах эд барааг албадан мөнгөн хэлбэрт шилжүүлсэн тохиолдолд ТЭХ-ийн 56.4 дэх заалтын дагуу худалдан борлуулсан төлбөрөөс дор дурдсан онцгой татварыг хураана.		
Татвар төлөгч (эд барааны эзэмшигч)	хаяг	
	Овог нэр	
Цаашид “Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үеийн онцгой татвар хураах мэдэгдэх хуудас” 1 (хэрэгжүүлэгч байгууллагын хэрэгцээнд)		

Ашиглах хүрээ

Энэхүү мэдэгдэх хуудсыг ТЭХ-ийн 56.4-ийн заалттай нийцэж байгаа тохиолдолд, татвар төлөгчид энэ талаар мэдэгдэхэд ашиглах ба “Албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үеийн онцгой татвар хураах мэдэгдэх хуудас” 1 (гүйцэтгэгч байгууллагад зориулав)-ийн хамт олшруулан үйлдэнэ.

Битүүмжлэлийг солих тухай нэхэмжлэх хуудас									
Татварын хэлтсийн дарга танаа Нэхэмжлэгч этгээд хаяг Овог нэр								он сар өдөр	
								тамга	
Дараах байдлаар нэхэмжилнэ									
Өртэй татвар төлөгч, эсхүл өв залгамжлуулагч		хаяг							
		Овог нэр							
Татварын өрийн дүн	он	Татварын төрөл	Татвар төлөх эцсийн хугацаа	Татварын дүн	Торгууль	Хүүгийн татвар	Алданги, торгууль	өр барагдуулах зардал	Тэмдэглэл
				₮	₮	Хуулиар төлөх ₮	Хуулиар төлөх ₮	Хуулиар төлөх ₮	
						“	“	“	
						“	“	“	
						“	“	“	
Битүүмжилсэн хөрөнгө	Нэр, тоо хэмжээ, шинж чанар, байршил, бусад							Эрхийн агуулга	
	Битүүмжилсэн он сар өдөр		он сар өдөр						
Шинээр битүүмжлэлийн нэхэмжлэл хийх хөрөнгө	Нэр, тоо хэмжээ, шинж чанар, байршил, бусад							Үнэ	
								₮	

Ашиглах хүрээ

- Энэхүү нэхэмжлэлийг, гуравдагч этгээд ТЕХ-ын 60.3-т заасны дагуу битүүмжлэлийг солих тухай нэхэмжлэл гаргахад ашиглана.
- “Өртэй татвар төлөгч, эсхүл өв залгамжлуулагч” хэсэгт “Өртэй татвар төлөгч” эсхүл “Өв залгамжлуулагч”-д тохирохгүй аль нэг үгийг хасах, мөн нэхэмжлэгч нь өв залгамжлагч байгаа тохиолдолд, “хаяг” дээр өв залгамжлуулагчийн нас барах үеийн хаягийг тусгана.
- “Битүүмжилсэн хөрөнгө” хэсгийн “Эрхийн агуулга” -д битүүмжилсэн хөрөнгийн хувьд, битүүмжлэлийг солих нэхэмжлэл гаргагч гуравдагч этгээдийн эзэмших барьцаа, ипотекийн эрхийн нэр болон бусад шаардлагатай асуудлуудыг тусгана. Өв залгамжлагч битүүмжлэлийг солих нэхэмжлэл гаргаж байгаа бол, энэ хэсгийг бөглөх шаардлагагүй.

Битүүмжлэлийг солих тухай нэхэмжлэлийг татгалзах тухай мэдэгдэл		
Нэхэмжлэгч этгээд хаяг Овог нэр		он сар өдөр танаа Татварын албаны дарга СЯ-ны ТНБД тамга
Битүүмжлэлийг солих тухай таны нэхэмжлэлийг дараах шалтгааны улмаас хүлээн авах боломжгүй байна.		
Өртэй татвар төлөгч, эсхүл өв залгамжлуулагч	хаяг	
	нэр	
Битүүмжлэлийг солихыг татгалзах шалтгаан		
Тэмдэглэл		

Ашиглах хүрээ

- Энэхүү мэдэгдлийг, битүүмжлэлийг солих тухай нэхэмжлэлд татгалзсан хариу өгөхөд ашиглана.
- “Тэмдэглэл” хэсэгт шаардлагата бол, нэхэмжлэлийн огноо, энэхүү нэхэмжлэлийн шалтгаан болсон битүүмжлэлийн хийгдсэн огноог оруулан бичнэ.
- “Өртэй татвар төлөгч, эсхүл өв залгамжлуулагч” хэсэгт “ Өртэй татвар төлөгч” эсхүл “Өв залгамжлуулагч”-д тохирохгүй аль нэг үгийг хасах.

Даатгалд хамрагдсан хөрөнгийг битүүмжлэх мэдэгдэл									
									он сар өдөр
Даатгагч байгууллагын хаяг									
Нэр					танаа				
									Татварын албаны дарга СЯ-ны ТНБД
									тамга
Доор дурьдсанчилан хөрөнгийг битүүмжилсэн тул Татварын ерөнхий хуулийн 64.1-т заасны дагуу, даатгалын нөхөн төлбөрийг татварын албанд шилжүүлэх шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж байна.									
Татварын өртэй этгээд		хаяг нэр							
Өрийн дүн	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	дүн	алданги	хүү	торгууль	Өр барагдуулалтын зардал	тэмдэглэл
				₮			Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮	
							“	“	
Битүүмжилсэн хөрөнгө	-----								

Битүүмжилсэн огноо									
									он сар өдөр

Тайлбар: “Өр барагдуулалтын зардал” хэсэгт тусгасан үнийн дүн нь энэхүү мэдэгдлийг бичигдсэн огноо хүртэлх дүн болно.

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг даатгалын байгууллагад хөрөнгө битүүмжилснийг мэдэгдэхэд ашиглана.
- “Битүүмжилсэн хөрөнгө” хэсэгт даатгалд хамрагдсан хөрөнгийн нэр, тоо хэмжээ, шинж чанар, хаяг байршлыг тусгах бөгөөд тухайн хөрөнгийн даатгалтай холбоотой агуулгыг тусгахгүй болохыг анхаарах.
- “Битүүмжилсэн огноо” хэсэгт битүүмжлэлийн актын он сар өдрийг тусгана.

Маягт 6

Барьцааны эрх бүхий хөрөнгийг битүүмжлэх мэдэгдэл									
<p>Эрх бүхий этгээдийн хаяг</p> <p>Нэр _____ танаа _____</p> <p style="text-align: right;">Татварын албаны дарга СЯ-ны ТНБД _____ тамга _____</p> <p>Доор дурьдсанчилан, татварын өрийг хураах зорилгоор хөрөнгийг битүүмжилсэн болно.</p>								он сар өдөр	
Татварын өртэй этгээд		хаяг _____							
		нэр _____							
Өрийн дүн	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	дүн	торгууль	хүү	алданги	Өр барагдуулалтын зардал	тэмдэглэл
				₮		₮	Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮
							“	“	“
							“	“	“
							“	“	“
Битүүмжилсэн хөрөнгө		<hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/> <hr/>							
Битүүмжилсэн огноо			он сар өдөр						

Тайлбар: “Өр барагдуулалтын зардал” хэсэгт тусгасан үнийн дүн нь энэхүү мэдэгдлийг бичигдсэн огноо хүртэлх дүн болно.

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг битүүмжилсэн хөрөнгөд хамаарах барьцаа, ипотекийн барьцааны эрх бүхий гуравдагч этгээдийн дотроос мэдэгдэж байгаа этгээдүүдэд хөрөнгө битүүмжилснийг мэдэгдэхэд ашиглана.
- “Битүүмжилсэн хөрөнгө” хэсэгт битүүмжилсэн хөрөнгө нь Иргэний хуулийн 185 зүйлд заасан “Улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл” хийгдсэн байгаа тохиолдолд, энэхүү урьдчилсан тэмдэглэлийн дугаарыг тусгах.
- “Битүүмжилсэн огноо” хэсэгт битүүмжлэлийн актын он сар өдрийг тусгана.

Хөрөнгө шилжүүлэхийг үүрэг болгох хуудас									
он сар өдөр									
Хөрөнгийг мэдэлдээ байлгаж буй этгээд (ашиглах, орлого олох)									
хаяг									
Нэр танаа									
Татварын албаны дарга СЯ-ны ТНБД тамга									
Доор дурьдсанчилан, татварын өрийг хураах шаардлагатай байгаатай холбоотойгоор таны мэдэлдээ байлгаж буй татварын өртэй этгээдийн өмчлөл бүхий дараах хөрөнгийг татвар хураалтын байцаагчид шилжүүлнэ үү.									
Татварын өртэй этгээд		хаяг							
		нэр							
Өрийн дүн	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	дүн	торгууль	хүү	алданги	Өр барагдуулалтын зардал	тэмдэглэл
				₮	₮	Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮	
							“	“	“
							“	“	“
							“	“	“
Шилжүүлэхийг үүрэг болгох хөрөнгө		Эзэмшиж буй этгээдийн		хаяг			Овог нэр		
Шилжүүлэх хугацаа						Хаана шилжүүлэх			
Хөрөнгө шилжүүлэхийг үүрэгдэх хуудас хүргүүлэх үндэслэл									

Тайлбар: “Өр барагдуулалтын зардал” хэсэгт тусгасан үнийн дүн нь энэхүү хуудсыг бичсэн огноо хүртэлх дүн болно.

Ашиглах хүрээ:

- Энэхүү хуудсыг ТЕХ-ын 62.5-д заасны дагуу, татварын өртэй этгээдийн хөдлөх хөрөнгө, эсхүл үнэт цаасыг ашиглах, эсхүл орлого олох эрх бүхий гуравдагч этгээдэд, энэхүү хөрөнгийг татвар хураалтын байцаагчид шилжүүлэхийг үүрэг болгох тохиолдолд (ТЕХ-ийн 64.4-т заасны дагуу авлагыг битүүмжлэхдээ холбогдох баримт бичгийг хураах, 65.3.4-т заасны дагуу автомашин, барилгын тоног төхөөрөмжийг татварын албаны мэдэлд шилжүүлсэн тохиолдолдлыг оруулаад) энэхүү хуудсыг ашиглана.
- Энэ хуудсыг “Хөрөнгө шилжүүлэхийг үүрэг болгосон тухай мэдэгдэл”-ийн хамт хувиалан бэлтгэнэ.
- “Шилжүүлэхийг үүрэг болгох хөрөнгө” хэсэгт шилжүүлэхийг үүрэгдэж буй хөдлөх хөрөнгө, эсхүл үнэт цаасны нэр, тоо хэмжээ, шинж чанар, хаяг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгана.

Хөрөнгө шилжүүлэхийг үүрэг болгосон тухай мэдэгдэл									
он сар өдөр									
Татварын өртэй этгээдийн хаяг									
Нэр танаа									
Татварын албаны дарга СЯ-ны ТНБД									
тамга									
Доор дурьдсанчилан, татварын өрийг хураах зорилгоор таны хөрөнгийг мэдэлдээ байлгаж буй дараах этгээдэд хөрөнгө шилжүүлэхийг үүрэг болгох хуудсыг хүргүүлсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.									
Татварын өртэй этгээд		хаяг							
		нэр							
Өрийн дүн	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	дүн	торгууль	хүү	алданги	Өр барагдуулалтын зардал	тэмдэглэл
				₮	₮	Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮	
						“	“	“	
						“	“	“	
						“	“	“	
Шилжүүлэхийг үүрэг болгох хөрөнгө	Эзэмшиж буй этгээдийн		хаяг				Овог нэр		
Шилжүүлэх хугацаа						Хаана шилжүүлэх			
Хөрөнгө шилжүүлэхийг үүрэгдэх хуудас хүргүүлэх үндэслэл									

Тайлбар: “Өр барагдуулалтын зардал” хэсэгт тусгасан үнийн дүн нь энэхүү мэдэгдлийг бичигдсэн огноо хүртэлх дүн болно.

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг татварын өртэй этгээдийн хөдлөх, эсхүл үнэт цаасыг ашиглах, эсхүл орлого орогч гуравдагч этгээдэд, энэхүү хөрөнгийг шилжүүлэхийг үүрэг болгох хуудсыг хүргүүлсэн тохиолдолд, ТЭХ-ийн 62.5-д (64.4, 65.3.4-ийг оруулаад) заасны дагуу, татварын өртэй этгээдэд мэдэгдэхэд ашиглана. “Хөрөнгө шилжүүлэхийг үүрэг болгох хуудас”-ын хамтаар хувиан хэрэглэнэ.

Маягт 9

Бичиг баримт хураах тухай акт		
		он сар өдөр
Татварын албаны дарга СЯ-ны ТНБД		тамга
Татварын өрийг хураахтай холбоотойгоор дараах бичиг баримтыг хурааж байна.		
Татварын өртэй этгээд	хаяг нэр	
Хураасан бичиг баримт	Бичиг баримтын нэр	Битүүмжилсэн хөрөнгө
Бичиг баримт хураах тухай актын хуулбарыг хүлээн авлаа.		
Байлцсан этгээд ()		тамга
Бичиг баримт хураах тухай актын хуулбарыг (арга хэмжээ авагдсан этгээдэд хаягласан) хүлээн авлаа.		
он сар өдөр ()		тамга

Ашиглах хүрээ:

- Энэхүү актыг ТЕХ-ын 64.4-д заасны дагуу, авлагад хамаарах нотолгоо бичиг баримтыг хураах тохиолдолд үйлдэнэ.
- Битүүмжлэхийн өмнө баримт нотолгоог хураан авсан тохиолдолд, “Хураасан бичиг баримт” хэсгийн “Битүүмжилсэн хөрөнгө” хэсгийг бөглөх шаардлагагүй.
- “Бичиг баримт хураах тухай актын хуулбарыг хүлээн авлаа” гэсэн хэсгийн хаалтанд, арга хэмжээ авагдаж буй этгээд ба байлцсан этгээд хоорондын хамаарлыг тусгана.
- “Бичиг баримт хураах тухай актын хуулбарыг (арга хэмжээ авагдсан этгээдэд хаягласан) хүлээн авлаа” гэж бичигдсэн хэсгийн хаалтан дотор, арга хэмжээ авагдсан этгээд ба хуулбарыг хүлээн авсан этгээд хоорондын хамаарлын талаар тусгана.

Маягт 10

Битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авах тухай акт		
он сар өдөр		
Татварын албаны дарга СЯ-ны ТНБД		
		тамга
Доор дурьсанчилан, битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авсан болно.		
Татварын өртэй этгээд	хаяг нэр	
Мэдэлдээ авсан хөрөнгө		
	Битүүмжилсэн огноо	он сар өдөр
Битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авах тухай актын хуулбарыг хүлээн авлаа.		
Байлцсан этгээд ()		тамга
Битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авах тухай актын хуулбарыг (арга хэмжээ авагдсан этгээдэд хаягласан) хүлээн авлаа.		
он сар өдөр ()		тамга

Дээрх битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авах тухай актад заасан хөрөнгийг хадгалж, хамгаалахыг тушааж байна.		
он сар өдөр		
Татварын албаны дарга СЯ-ны ТНБД		
		тамга

Ашиглах хүрээ:

- Энэхүү актыг ТЕХ-ын 65.3.3-д заасны дагуу, битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, барилгын тоног төхөөрөмжийг татварын алба мэдэлдээ авсан бөгөөд үзлэгийн тэмдэглэл хөтлөхгүй тохиолдолд үйлдэнэ.
- “Мэдэлдээ авсан хөрөнгө” хэсгийг битүүмжлэх актын агуулгад нийцүүлэн бөглөнө.
- “Битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авах тухай актын хуулбарыг хүлээн авлаа” гэсэн хэсгийн хаалтанд, хөрөнгийг хадгалагч ба байлцсан этгээд хоорондын хамаарлыг тусгана.
- “Битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авах тухай актын хуулбарыг (арга хэмжээ авагдсан этгээдэд хаягласан) хүлээн авлаа” гэж бичигдсэн хэсгийн хаалтан дотор, хөрөнгийг хадгалагч ба хуулбарыг хүлээн авсан этгээд хоорондын хамаарлын талаар тусгана.
- Мэдэлдээ авсан хөдлөх хөрөнгө, барилгын тоног төхөөрөмжийг гуравдагч этгээдэд хадгалуулах тохиолдолд, хамгийн доод талын хэсгийг “Дээрх хөрөнгийг мэдэгдэл хүлээн авах хүртэл үнэ төлбөргүйгээр хадгална” гэж өөрчлөх, эсхүл хүснэгтийн гадна талд энэ талаар тэмдэглэн, хадгалагчийн гарын үсэг (овог нэр), тамгыг даруулна.

Битүүмжилсэн хөрөнгийг ашиглах зөвшөөрлийн хүсэлт		
он сар өдөр		
Татварын албаны дарга танаа		
Хүсэлт гаргагч () Хаяг, нэр, тамга () Хаяг, нэр, тамга () Хаяг, нэр, тамга		
Доор дурьсан битүүмжилсэн хөрөнгийг ашиглахыг (хөдөлгөх, тээвэрлэх) зөвшөөрнө үү.		
Татварын өртэй этгээд	хаяг нэр	
Битүүмжилсэн хөрөнгө	
	
	Битүүмжилсэн огноо	Он сар өдөр
Ашиглах шалтгаан	
<u>Зөвшөөрсөн эсэхийн талаарх мэдэгдэл</u>		
он сар өдөр Татварын албаны дарга тамга		
.....		

Ашиглах хүрээ:

- Энэхүү хүсэлтийг татварын өртэй этгээд ТЕХ-ын 65.2.5-д заасны дагуу, битүүмжилсэн агаарын хөлгийг нисгэх зөвшөөрөл хүсэх болон мөн хуулийн 65.3.6-д заасны дагуу битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, барилгын тоног төхөөрөмжийг ашиглах хүсэлт гаргах үед үйлдэнэ.
- Мөн энэхүү маягтыг хүсэлт гаргагчид ашиглахыг зөвшөөрсөн эсэхийг мэдэгдэх тохиолдолд хэрэглэх тул хэд хэдэн хувиар үйлдэнэ.
- “Хүсэлт гаргагчийн хаяг”-ийн эхэнд байгаа хаалтанд, жишээлбэл (барьцааны эрх бүхий этгээд), (суутгалын хүсэлт гаргах хүсэлт гаргах эрх бүхий этгээд) гэх зэргээр битүүмжилсэн хөрөнгөтэй холбоотой хүсэлт гаргагчийн эрхийг тодорхойлж бичнэ.
- “Ашиглах шалтгаан” гэсэн хэсэгт ашиглах хэрэгцээ шаардлагын шалтгаан болон ашиглах нөхцөлийг аль болох нарийвчилан тусгана.
- “Битүүмжилсэн хөрөнгийг мэдэлдээ авах тухай актын хуулбарыг (арга хэмжээ авагдсан этгээдэд хаягласан) хүлээн авлаа” гэж бичигдсэн хэсгийн хаалтан дотор, хөрөнгийг хадгалагч ба хуулбарыг хүлээн авсан этгээд хоорондын хамаарлын талаар тусгана.
- “Зөвшөөрсөн эсэхийн талаарх мэдэгдэл” хэсэгт тухайн хүсэлтийг зөвшөөрөх тохиолдолд “Дээрх хүсэлтийг ёсоор болгож ашиглахыг зөвшөөрөв” гэж бичин, зөвшөөрөхдөө тодорхой нөхцөл тавих бол энэхүү нөхцөл шаардлагын талаар тусгана.

Маягт 12 (Татварын өртэй этгээд, гуравдагч өглөг бүхий этгээд)

Хөрөнгийг битүүмжлэх актыг хүчингүй болгох тухай мэдэгдэл 1		
Татварын өртэй этгээд, гуравдагч өглөг бүхий этгээд		он сар өдөр
хаяг		
Нэр	танаа	
	Татварын албаны дарга	
	СЯ-ны ТНБД	тамга
Доорх хөрөнгийн битүүмжлэх актыг хүчингүй болгож байгаа мэдэгдэж байна.		
Татварын өртэй этгээд	хаяг	
	нэр	
Битүүмжлэлийг цуцалсан хөрөнгө	Нэр, тоо хэмжээ, шинж чанар, хаяг байршил, бусад	Битүүмжилсэн огноо
		он сар өдөр
Тэмдэглэл		

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг ТЕХ-ын 60.8-д заасны дагуу, хөрөнгө битүүмжлэх актыг хүчингүй болгосон тухай татварын өртэй этгээд болон гуравдагч өглөг бүхий этгээдэд мэдэгдэхэд ашиглана.
- Битүүмжлэлийн актыг хүчингүй болгосон хөрөнгийн тухайд, барьцааны эрхтэй этгээдийн дотроос мэдэгдэж байгаа этгээд, эсхүл суутгах хүсэлт гаргасан болон гуравдагч өглөг бүхий этгээд байгаа тохиолдолд, “Хөрөнгийн битүүмжлэх актыг хүчингүй болгох тухай мэдэгдэл 2”-тэй хамтатган (Харилцан хамаарал бүхий этгээд, гуравдагч өглөг бүхий этгээд байгаа тохиолдлын татварын өртэй этгээдэд зориулсан) хуулбарыг үйлдэнэ.
- “Битүүмжлэлийг цуцалсан хөрөнгө”-ийн хэсгийн “Битүүмжилсэн огноо” нүдэнд битүүмжилсэн он, сар, өдрийг бичиж, энэхүү огноо нь хөрөнгө тус бүрээр ялгаатай бол тус тусад нь ялган оруулна.
- “Тэмдэглэл” гэсэн хэсэгт дараах зүйлсийг тусгана:
- “Битүүмжлэлийг цуцлах хөрөнгө нь хөдлөх хөрөнгө ба үнэт цаас байгаад энэхүү хөрөнгийг татварын байцаагч, эсхүл гуравдагч этгээдэд хадгалж байгаа бол хөрөнгийг шилжүүлэх талаарх тэмдэглэл.
- Лацдах, олон нийтэд мэдээлсэн болон бусад битүүмжлэл тодорхойлох аргаар битүүмжилснийг татварын өртэй этгээдээр өөрөөр нь тайлуулах бол энэ талаар тусгах
- ТЕХ-ийн 64.4-т заасан хураасан эрхтэй холбоотой баримт бичиг байгаа бол түүнийг шилжүүлэх тухай тусгах
- Битүүмжлэлийн актыг хүчингүй болгох шалтгааны талаар тусгах шаардлагатай бол энэ талаар бичих
- Битүүмжлэлийн үйлчлэлд хамаарах хамтран битүүмжлэгч байгууллагад тухайн хөрөнгийг шилжүүлсэн бол энэ талаар тусгах.
- Бусад энэхүү мэдэгдэлд тусгах нь зүйтэй гэж үзсэн асуудлууд

Маягт 13 (Харилцан хамаарал бүхий этгээд, гуравдагч өглөг бүхий этгээд байгаа тохиолдлын татварын өртэй этгээдэд зориулсан)

Хөрөнгийг битүүмжлэх актыг хүчингүй болгох тухай мэдэгдэл 2		
Татварын өртэй этгээд, гуравдагч өглөг бүхий этгээд		он сар өдөр
хаяг		
Нэр	танаа	
Татварын албаны дарга СЯ-ны ТНБД		тамга
Доорх хөрөнгийн битүүмжлэх актыг хүчингүй болгож байгаа мэдэгдэж байна.		
Татварын өртэй этгээд	хаяг	
	нэр	
Битүүмжлэлийг цуцалсан хөрөнгө	Нэр, тоо хэмжээ, шинж чанар, хаяг байршил, бусад	Битүүмжилсэн огноо
		он сар өдөр
Тэмдэглэл		

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг ТЕХ-ын 60.8-д заасны дагуу, хөрөнгө битүүмжлэх актыг хүчингүй болгосон тухай татварын өртэй этгээд болон гуравдагч өглөг бүхий этгээдэд мэдэгдэхэд ашиглана.
- Мэдэгдлийг, “Хөрөнгө битүүмжлэх актыг хүчингүй болгох тухай мэдэгдэл” 1-тай (харилцан хамаарал бүхий этгээд, татварын өртэй этгээдэд зориулсан) хамтатган хуулбарыг үйлдэнэ.

Маягт 14 (Гүйцэтгэгч байгууллагад зориулсан)

Суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл 1		
Гүйцэтгэгч байгууллагын нэр		он сар өдөр
танаа		
Татварын албаны дарга СЯ-ны ТНБД		тамга
Доорх байдлаар суутгах хүсэлтийг хүчингүй болгож байгааг мэдэгдэж байна.		
Татварын өртэй этгээд	хаяг нэр	
Суутгах хүсэлтийг цуцлахтай холбоотой хөрөнгө, эсхүл үйл явцын нэр	Нэр, тоо хэмжээ, шинж чанар, хаяг байршил, бусад	
	Суутгах хүсэлтийн огноо	
Гүйцэтгэгч байгууллагын нэр		

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тохиолдолд, энэхүү ажиллагааг гүйцэтгэгч байгууллагад мэдэгдэхэд ашиглана.
- Мэдэгдлийг, татварын өртэй этгээдэд зориулсан хувилбартай хамтатган хувилж бэлтгэнэ.
- Мэдэгдлийг, албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа нь татварын өр барагдуулах үйл ажиллагаанаас тусдаа процесс байгаа тохиолдолд, үйл явц тус бүрээр хавсралт үйлдэнэ.

Маягт 15 (Татварын өртэй этгээдэд зориулсан)

Суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл 2		
Татварын өртэй этгээд хаяг Нэр		он сар өдөр танаа Татварын албаны дарга СЯ-ны ТНБД тамга
Доорх байдлаар суутгах хүсэлтийг хүчингүй болгож байгааг мэдэгдэж байна.		
Татварын өртэй этгээд	хаяг нэр	
Суутгах хүсэлтийг цуцлахтай холбоотой хөрөнгө, эсхүл үйл явцын нэр	Нэр, тоо хэмжээ, шинж чанар, хаяг байршил, бусад	
Гүйцэтгэгч байгууллагын нэр		Суутгах хүсэлтийн огноо

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тохиолдолд, энэ талаар төтвөрын өртэй этгээдэд мэдэгдэхэд ашиглана.
- Мэдэгдлийг, гүйцэтгэгч байгууллагад зориулсан хувилбартай хамтатган хувилж бэлтгэнэ.
- Мэдэгдлийг, албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа нь татварын өр барагдуулах үйл ажиллагаанаас тусдаа процесс байгаа тохиолдолд, үйл явц тус бүрээр хавсралт үйлдэнэ.

Маягт 16 (Эрх бүхий этгээдэд зориулсан)

Суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл 3			
Эрх бүхий этгээд			
хаяг			
Нэр	танаа	Татварын албаны дарга СЯ-ны ТНБД	
		тамга	
Доорх байдлаар суутгах хүсэлтийг хүчингүй болгож байгааг мэдэгдэж байна.			
Татварын өртэй этгээд	хаяг		
	нэр		
Суутгах хүсэлтийг хүчингүй болгосон хөрөнгө, эсхүл үйл явцын нэр	Нэр, тоо хэмжээ, шинж чанар, хаяг байршил, бусад		Суутгах хүсэлтийн огноо
Гүйцэтгэгч байгууллагын нэр			

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, тухайн хөрөнгөд барьцааны эрх бүхий этгээдийн дотроос мэдэгдэж байгаа этгээдэд суутгах хүсэлтийг хүчингүй болгосон тухай мэдэгдэхэд ашиглана.
- “Суутгах хүсэлтийг хүчингүй болгосон хөрөнгө” хэсэгт албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа нь татварын өр барагдуулах үйл ажиллагаанаас тусдаа процесс байсан ч үйл явцын дугаараар илэрхийлсэн бичилтийг хийхгүй.

Суутгах хүсэлтийг хүчингүй болгох тухай нэхэмжэл			
Татварын албаны дарга танаа		он сар өдөр	Нэхэмжлэл гаргагч Хаяг Нэр тамга
Доор дурьсанчилан суутгах хүсэлтийг хүчингүй болгох нэхэмжлэл хийж байна.			
Татварын өртэй этгээд	хаяг		
	нэр		
Суутгах хүсэлт гаргасан гүйцэтгэх байгууллагын нэр		Суутгах хүсэлтийн огноо	он, сар, өдөр
Суутгах хүсэлтийг хүчингүй болгохыг нэхэмжлэх шалтгаан		
		
		
		
		
		
		
		
		
		

Ашиглах хүрээ:

- Энэхүү нэхэмжлэлийг албадан мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанаас суутгуулах эрх бүхий авлагатай этгээд, суутгах хүсэлтийг хүчингүй болгох тухай нэхэмжлэл гаргахад ашиглана.

Суутгах хүсэлтийг хүчингүй болгохыг татгалзах тухай мэдэгдэл		
Нэхэмжлэгч		
хаяг		
Нэр	танаа	Татварын албаны дарга СЯ-ны ТНБД
		тамга
Таны суутгах хүсэлтийг хүчингүй болгох нэхэмжлэлийн тухайд, дараах шалтгаанаар зөвшөөрөх боломжгүй байгааг мэдэгдэж байна.		
Татварын өртэй этгээд	хаяг	
	нэр	
Суутгах хүсэлтийг хүчингүй болгохыг татгалзах шалтгаан		
тэмдэглэл		

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, суутгах хүсэлтийг хүчингүй болгох нэхэмжлэл гарсан боловч, тухайн нэхэмжлэлийг үндэслэлгүй хэмээн үзэж байгаа талаар нэхэмжлэгч талд мэдэгдэхэд ашиглана.
- “Тэмдэглэл” хэсэгт шаардлагатай гэж үзвэл суутгах хүсэлтийг хүчингүй болгох нэхэмжлэл гарсан он, сар, өдөр, тухайн нэхэмжлэлд хамаарах суутгах хүсэлтийн он, сар, өдрийг тусгана.

Дуудлага худалдааны зар					
					он сар өдөр
Татварын албаны дарга			тамга		
Доор дурьсанчилан битүүмжилсэн хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулна.					
Худалдах хөрөнгө, дуудлага худалдааны дэнчин, анхны үнэ	борлуулах ангилал	Худалдах хөрөнгө		Дуудлага худалдааны дэнчин	Анхны үнэ (борлуулах хамгийн доод үнэ)
		Нэр, шинж чанар, хаяг байршил, эрхийн талаарх агуулга, бусад	Тоо хэмжээ		
				₮	₮
Жич: 1. Дээрх борлуулах ангилал тус бүрээр дуудлага худалдаа хийнэ. 2. “Анхны үнэ” хэсэгт ※ тэмдэглэгээ байгаа бол энэхүү үнийг худалдах хөрөнгөд наасан болохыг илтгэнэ.					
Сонгон арга	шалгаруулалтын	Үнэ хаялцах Албадан дуудлага худалдаа Интернет дуудлага худалдаа			
Дуудлага худалдааны тов	Үнэ хаялцуулахоны.....сарынөдөр.....цагаас эхлэх			
Хаана болох					
Худалдах шийдвэр	Өдөр, цагоны.....сарынөдөр.....цаг	хаана		
Төлбөр хийх хугацааоны.....сарынөдөр.....цаг				
Ялагчид тавигдах шаардлага, бусад нөхцөл					
Бусад	1. Анхны үнэд хүрэхээр үнэ хэлсэн оролцогч байхгүй бол дахин даруй үнэ хаялцуулна.				
	2. Дуудлага худалдаагаар эрх шилжүүлэхтэй холбоотой зардлыг (шилжилтийн бүртгэлийн хураамж) шилжүүлэн авах ялагч хариуцна.				
	3.				
<u>Суутгал авах этгээдийн эрхийн талаар</u>					
Дуудлага худалдаагаар борлуулсан хөрөнгөөс суутгал хүртэх эрх бүхий барьцаа, ипотекийн эрх, түрүүлж авах давуу эрх бүхий этгээд нь худалдах шийдвэр гарах өдрийн өмнөх өдөр хүртэлх хугацаанд авлагын дүнг тусгасан хүсэлтийг татварын албанд гаргана уу. Хүсэлт гаргах маягыг татварын албаны хариуцсан хэлтсээс авах боломжтой.					

Ашиглах хүрээ:

- Энэхүү зарыг “Дуудлага худалдаа зохион байгуулах, шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 8.1-т заасны дагуу дуудлага худалдаа зохион байгуулах талаар нийтэд мэдэгдэхэд ашиглана.
- Зарыг хөдлөх хөрөнгө, үнэт цаас ба бусад хөрөнгийн ангилал тус бүрээр үйлдэнэ.
- Дуудлага худалдаагаар борлуулах хөрөнгийн нэр, шинж чанарыг тусгах нүдэнд, татварын өртэй этгээдийн хаяг, нэрийг давхар оруулна.
- Дуудлага худалдааны дэнчин шаардахгүй тохиолдолд, холбогдох хэсэгт “Шаардлагагүй” гэж бичнэ.
- “Анхны үнэ”-ийн талаар тусгахдаа дараах зүйлсийг анхаарна:
 - Анхны үнийг зарлахгүй тохиолдолд, энэ талаар холбогдох хэсэгт тусгана.
 - Хөдлөх хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулахдаа, тухайн хөрөнгө дээр анхны үнийг наасан байсан ч, анхны үнийг хүснэгтэд заавал тусгана.
 - Анхны үнийн талаарх шийдвэр нь дуудлага худалдааны зарын товоос хойш гардаг тул, анхны үнийг дараа нь зарлах тохиолдолд, энэ тухайгаа тайлбар оруулна. Энэ тохиолдолд, анхны үнийн зарыг тогтсон маягтын дагуу бичиж, дуудлага худалдааны зарын баруун талд байрлуулна.
- Дуудлага худалдаагаар оруулах хөрөнгийн тоо олон бөгөөд “Худалдах хөрөнгө, дуудлага худалдааны дэнчин, анхны үнэ” хэсгийг тусад нь хавсаргах тохиолдолд, энэ хэсэгт “Хавсралтаар үзүүлэв” гэж оруулна.
- “Бусад” хэсэгт дуудлага худалдааны зард тусгаагүй байсан ч хуулийн хүрээнд тодорхой асуудлуудыг ажиллагааны зохистой байдлын хангах үүднээс бичилт хийнэ.

Анхны үнийн хуудас					
			он	сар	өдөр
			Татварын албаны дарга		тамга
борлуулах ангилал		Хөрөнгийн нэр			
Анхны үнэ (борлуулах хамгийн доод үнэ)			₮	Дуудлага худалдааны дэнчин	₮

Ашиглах хүрээ:

- Энэхүү анхны үнийн хуудсыг дуудлага худалдаагаар борлуулах хөдлөх хөрөнгөд анхны үнийг бичсэн хуудас нааж, анхны үнийг нийтэд зарлахыг орлуулах тохиолдолд ашиглана.

Маягт 20

Дуудлага худалдааны мэдэгдэл										
Татварын өртэй этгээд хаяг Нэр								он сар өдөр		
танаа				Татварын албаны дарга СЯ-ны ТНБД				тамга		
Доорх байдлаар битүүмжилсэн хөрөнгийг дуудлага худалдаанд оруулахыг мэдэгдэж байна.										
Дуудлага худалдаагаар борлуулах хөрөнгө	Татварын өртэй этгээд хаяг		нэр							
	Нэр, шинж чанар, байршил, эрх, бусад					Тоо хэмжээ	дэнчин	Анхны үнэ		
							₮	₮		
Дуудлага худалдааны тов	Үнэ хаялцуулах	оны.....сарынөдөр.....цагаас эхлэх							
Хаана болох										
Худалдах шийдвэр		Өдөр, цагоны.....сарынөдөр.....цаг				хаана			
Төлбөр хийх хугацаа	оны.....сарынөдөр.....цаг								
Ялагчид тавигдах шаардлага, бусад нөхцөл										
Бусад										
Дуудлага худалдаанд хамаарах татвар	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Татварын дүн	Торгууль	Хүү	алданги	Өр барагдуу лалтын зардал	тэмдэглэ л	
				₮	₮	Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮	Хуульд заасан ₮		
						“	“			
						“	“			
						“	“			

Тайлбар: “Өр барагдуулалтын зардал” хэсэгт тусгасан үнийн дүн нь энэхүү мэдэгдлийг бичигдсэн огноо хүртэлх дүн болно.

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 5.4-т заасны дагуу татварын өртэй этгээдэд дуудлага худалдааны талаар мэдэгдэхэд ашиглана.
- “Дуудлага худалдаанд хамаарах татвар” хэсэгт шаардлагатай бол, ногдуулах татвараас гадна, татварын өр үүсээд буй татварын төрлийн талаар тодорхой дурьдах боломжтой.

хаяг	
нэр	танаа

Дуудлага худалдааны урьдчилсан мэдэгдэл

он сар өдөр

Татварын албаны дарга

СЯ-ны ТНБД тамга

Дараах битүүмжилсэн хөрөнгийг татвараа бүрэн төлөөгүй шалтгаанаар ойрын хугацаанд дуудлага худалдаанд оруулах төлөвлөгөөтэй байгаа тул яаралтай татварын өрөө бүрэн барагдуулахыг санал болгож байна. Татвар төлөхөд хүндрэлтэй тохиолдолдонысарын-ны өдрийнцаг хүртэл Татвар хураалт хариуцсан нэгжид энэ талаараа мэдэгдэнэ үү.

Татварын өрийн дүн	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль	алданги	хүү	Өр барагдуул алтын	тэмдэглэл
Битүүмжилсэн хөрөнгө									

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, дуудлага худалдаа зохион байгуулахын өмнө бэлтгэн ашиглана.
- “Битүүмжилсэн хөрөнгө” хэсгийг битүүмжлэх актаас хуулан оруулна. Битүүмжилсэн хөрөнгийн төрөл олон бөгөөд энд багтаан бичилт хийх боломжгүй тохиолдолд, гол хөрөнгийг товчлон оруулж болно.

Дуудлага худалдааны мэдэгдэл ба авлагын хүсэлт гаргах тухай шаардлага			
Харилцан хамааралтай этгээд хаяг			
Нэр	танаа	Татварын албаны дарга СЯ-ны ТНБД	тамга
Доор дурьдсанчилан битүүмжилсэн хөрөнгийг дуудлага худалдаанд оруулна. Энэхүү хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэнтэй холбоотой барьцаа, ипотек, түрүүлж авах эрх бүхий этгээдүүд, “Авлагын өнөөгийн дүнгийн талаарх хүсэлт” -ийг борлуулахаар товлосон өдрийн өмнөх өдөр хүртэлх хугацаанд татварын албанд гаргана уу.			
(дуудлага худалдааны мэдэгдэлтэй адил)			

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотойгоор, хууль эрх зүйн хүрээний эрх нь хөндөгдөх магадлалтай, бүртгэлийн байгууллагад бүртгэлтэй этгээдийн (ШШГХ-ийн 60.3) дотроос мэдэгдэж байгаа этгээдүүдэд дуудлага худалдааны талаар мэдэгдэх тохиолдолд ашиглана.
- Суутгах хүсэлт гаргасан этгээдэд хүргүүлэх тохиолдолд, “Дуудлага худалдаанд оруулах хөрөнгө” хэсэгт энэ талаар товч тэмдэглэн, дуудлага худалдааны дэнчин ба анхны үнийн талаар бичилт хийхгүй.
- Энэхүү шаардлагыг хүргүүлэхдээ “Авлагын өнөөгийн дүнгийн талаарх хүсэлт”-ийг хавсарган хүргүүлнэ.
- “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 13.1-т заасны дагуу битүүмжилсэн хөрөнгийг шууд гэрээгээр борлуулах тохиолдолд, энэхүү шаардлагыг агуулгад нийцүүлэн өөрчилж ашиглана.

ҮХХ-ийн дуудлага худалдааны ялагчийг тогтоох шийдвэрийн МЭДЭГДЭЛ			
Татварын өртэй этгээд, харилцан хамааралтай этгээд хаяг Нэр _____ танаа _____		он сар өдөр Татварын албаны дарга СЯ-ны ТНБД _____ тамга	
Доорх байдлаар мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгийн ялагчийг тогтоосон болохыг мэдэгдэж байна.			
Татварын өртэй этгээд	хаяг		
	нэр		
Мөнгөн хэлбэрт шилжүүлэх хөрөнгө		Дээд үнийн дүн	Ялагчийн нэр
Нэр, бусад	Тоо хэмжээ		
Ялагчийг тогтоох шийдвэрийн огноо	он.....сар.....өдөр	
Худалдах шийдвэр	Өдөр, цаг	хаана	
оны....сарын....өдрийнцаг		

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 9.4 ба 9.7-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааны ялагчийн талаарх мэдээллийг татварын өртэй этгээд болон харилцан хамааралтай этгээдийн дотроос мэдэгдэж байгаа этгээдүүдэд хүргүүлэхэд ашиглана.
- Энэ мэдэгдлийн гадна талд “Ялагч нь худалдах шийдвэр гарсны дараа төлбөрийг бүрэн барагдуулсан (төлбар хийх хугацааоны....сарын...өдөр)тохиолдолд дээрх хөрөнгийг шилжүүлэн авах эрхтэй” гэж тусгана.

Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгийг худалдан авах хүсэлтийг хүчингүй болгох өргөдөл		
Татварын албаны дарга танаа		он сар өдөр Өргөдөл гаргагч Хаяг, нэр, тамга
Доор дурьсанчилан мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгийг худалдан авах хүсэлтийг хүчингүй болгож байна.		
Татварын өртэй этгээд	хаяг нэр	
Худалдан авалтын хүсэлтийг хүчингүй болгох хөрөнгө	Нэр, бусад	Тоо хэмжээ
Худалдан авалтын хүсэлтийг хүчингүй болгох шалтгаан		

Ашиглах хүрээ:

- Энэхүү өргөдлийг, дуудлага худалдааны ялагч нь хөрөнгийн худалдан авах хүсэлтээ хүчингүй болгох тохиолдолд ашиглана.

Маягт 25

ҮХХ-ийн дуудлага худалдааны ялагчийн шийдвэрийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл		
Ялагч, Татварын өртэй этгээд, харилцан хамааралтай этгээд хаяг Нэр		он сар өдөр танаа Татварын албаны дарга СЯ-ны ТНБД тамга
Доорх байдлаар дуудлага худалдааны ялагчийн шийдвэрийг хүчингүй болгов.		
Ялагч	хаяг	
	нэр	
Татварын өртэй этгээд	хаяг	
	нэр	
Ялагчийн шийдвэрийг хүчингүй болгох хөрөнгө	Нэр, бусад	Тоо хэмжээ
Ялагчийн шийдвэрийг хүчингүй болгох шалтгаан	ТЕХ-ийнзүйлд заасны дагуу	
Тэмдэглэл		

Худалдах шийдвэрийг хүчингүй болгох тухай мэдэгдэл		
Ялагч, Татварын өртэй этгээд, харилцан хамааралтай этгээд хаяг Нэр		он сар өдөр
танаа		Татварын албаны дарга СЯ-ны ТНБД
		тамга
Доорх байдлаар дуудлага худалдааны шийдвэрийг хүчингүй болгов		
Ялагч	хаяг	
	нэр	
Татварын өртэй этгээд	хаяг	
	нэр	
Ялагчийн шийдвэрийг хүчингүй болгох хөрөнгө	Нэр, бусад	Тоо хэмжээ
Ялагчийн шийдвэрийг хүчингүй болгох шалтгаан	ТЕХ-ийнзүйлд заасны дагуу	
Тэмдэглэл		

“ҮХХ-ийн дуудлага худалдааны ялагчийн шийдвэрийг хүчингүй болгосон тухай мэдэгдэл” болон “Худалдах шийдвэрийг хүчингүй болгох тухай мэдэгдэл” -ийг ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, ТЕХ-ийн 68.4, “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 10.2 ба 10.5-д заасан дуудлага худалдаа зохион байгуулах үйл ажиллагаанд зөрчил гарсантай холбоотойгоор ялагчийг тогтоох шийдвэр, худалдах шийдвэрийг хүчингүй болгон, ялагч, татварын өртэй этгээд, харилцан хамааралтай этгээдэд энэ талаар мэдэгдэхэд ашиглана.
- Мэдэгдлийг, дуудлага худалдаанд оролцогсад (ялагч, эсхүл худалдан авагч), татварын өртэй этгээд, харилцан хамааралтай этгээд, гуравдагч өглөгтэй этгээд, суутгах хүсэлт гаргагч болон бусад шаардлагатай этгээдэд хүргүүлнэ.
- “ҮХХ-ийн дуудлага худалдааны ялагчийн шийдвэрийг хүчингүй болгох шалтгаан” болон “Худалдах шийдвэрийг хүчингүй болгох шалтгаан” хэсэгт холбогдох заалтуудыг тусган, ийм заалт байхгүй бол “Хууль бус, эсхүл зөрчилтэй” хэмээн бичнэ.
- Тэмдэглэл хэсэгт, дэнчин болон төлбөрийг буцаан олгох, хөрөнгийг хэрхэх болон бусад шаардлагатай зүйлсийн талаар тусгана.

Маягт 27(Хувийн авлага)

Авлагын өнөөгийн дүнгийн талаарх хүсэлт 1			
Татварын албаны дарга танаа		Хүсэлт гаргагч Хаяг, нэр, тамга	
Дуудлага худалдаанд оруулж буй хөрөнгийн хувьд дараах эрхийг би эдэлдэг болно.			
Татварын өртэй этгээд	хаяг		нэр
Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгө			
Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгөтэй холбоотой эрх	Эрхийн талаарэрх (ипотекийн эрх) авлагын дүн₮ битүүмжлэх үеийн авлагын дүн.....₮эрх (ипотекийн эрх) авлагын дүн₮ битүүмжлэх үеийн авлагын дүн.....₮
	Өглөгтэй этгээд	хаяг	
	Барагдуулах хугацаа	нэр	
	Бусад		
Авлагын өнөөгийн дүн	Үндсэн авлага		₮
	Хүү	(Үндсэн авлага) (хүү) (хугацаа) тооцсон өдөр₮ х х огноо =	(Үндсэн авлага) (хүү) (хугацаа) тооцсон өдөр₮ х х огноо =
			₮
			₮
Хавсаргасан бичиг баримт (авлагын агуулга, үнийн дүнг нотлох зүйл)			
Тайлбар: Хүүгийн тухайд, “Дуудлага худалдаан зар” эсхүл “Дуудлага худалдааны мэдэгдэл ба авлагын хүсэлт гаргах тухай шаардлага” хэсэгт бичигдсэн дуудлага худалдааны төлбөр төлөх хугацаа хүртэлх хугацаагаар тооцон бичих.			

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 69.2.1 ба 69.2.2-т заасны дагуу 69.1.1-т заасан авлагатай этгээд дуудлага худалдааны төлбөрөөс авлагаа суутгуулахын тулд авлагын өнөөгийн үнийн дүнгийн талаар хүсэлт гаргахад ашиглана.
- Энэхүү хүсэлтийг хөрөнгө тус бүрээр үйлдэнэ.

Маягт 28 (Татвар)

Авлагын өнөөгийн дүнгийн талаарх хүсэлт 2											
Татварын албаны дарга танаа						он сар өдөр					
Хүсэлт гаргагч											
Хаяг, нэр, тамга											
Дуудлага худалдаанд оруулж буй хөрөнгийн хувьд дараах эрхийг би эдэлдэг болно.											
Татварын өртэй этгээд				хаяг		нэр					
Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгө											
Татварын өнөөгийн дүн											
ОН	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	Торгууль	Хүү		алданги		Өр барагдуулаг тын зардал	Нийт дүн	Барагдуулах хуулийн хугацаа
					дүн	торгууль Хэзээнээс тооцох	дүн	торгууль Хэзээнээс тооцох			
			₮	₮	₮	₮	₮	₮	₮	₮	

Тайлбар: Хүү болон алдангийн тухайд, “Дуудлага худалдааны мэдэгдэл ба авлагын хүсэлт гаргах гухай шаардлага” хэсэгт бичигдсэн дуудлага худалдааны төлбөр төлөх хугацаа хүртэлх хугацаагаар тооцон бичих.

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 69.1.1-т заасан суутгах хүсэлт гаргасан татварыг, дуудлага худалдааны төлбөрөөс суутгуулахын тулд хүсэлт гаргахад ашиглана.

**Татварын өр барагдуулалтын үйл ажиллагааг шилжүүлсэн тухай
МЭДЭГДЭЛ**

он сар өдөр

Татварын албаны дарга
СЯ-ны ТНБД

тамга

Доорх байдлаар татварын өрийг барагдуулах үйл ажиллагааг тус татварын алба шилжүүлэн авсан тул цаашид таны хөрөнгөөр татварын өр барагдуулах ажиллагааг гүйцэтгэх болсныг мэдэгдэж байна.

Татварын өр барагдуулалтын үйл ажиллагааг шилжүүлсэн татварын
албаны нэр

.....татварын алба

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, ТЕХ-ын 70.1-т заасны дагуу, татварын албаны дарга бусад татварын албаны даргаас өр барагдуулалтын үйл ажиллагааг шилжүүлэн авсан тохиолдолд, мөн хуулийн 70.3-т заасны дагуу энэ талаар татвар төлөгчид мэдэгдэхэд ашиглана.
- Нэмэлтээр үйл ажиллагааг шилжүүлэн авах үед, энэ талаар мэдэгдэхгүй байж болно.

**Татвар төлөх хугацааны
хөнгөлөлтийн хүсэлт**

Хүсэлт гаргасан огноо	оны.....сарынөдөр	
Хүсэлт гаргагч	хаяг	ажил	
	нэр	утас	

дугаар	Нэхэмжлэхийн хугацаа

										Төлөх төлөвлөгөө	
										огноо	Үнийн дүн
Хугацааны хөнгөлөлтөд хамруулах хүсэлт гаргах татварын дүн											
Зөвшөөрлийн ангилал		02		02		02		02		02	
Татварын төрөл											
Ногдуулалтын хугацаа		04		04		04		04		04	
		05		05		05		05		05	
Хураах огноо		06		06		06		06		06	
Хураалтын ангилал		07		07		07		07		07	
Хуваан төлөх давтамж		08		08		08		08		08	
Татварын үнийн дүнгийн ангилал	Үндсэн	₮		₮		₮		₮		₮	
	торгууль										
	Алданги										
	Хүү										
	зардал										
Хөнгөлөлтөд хамрагдах хугацаа				..оны...сарын...өдрөөс ...оны...сарын...өдөр хүртэл							
Хөнгөлөлтөд хамрагдах шалтгаан								барьцаа			

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, ТЕХ-ын 53.1-т заасны дагуу, татвар төлөгч татвар төлөх хугацааны хөнгөлөлт эдлэх хүсэлт гаргах тохиолдолд ашиглана.
- Хүсэлт гаргагч нь хуулийн этгээд байгаа тохиолдолд, “Хүсэлт гаргагч” хэсэгт хуулийн этгээдийн удирдлагын нэр, хаягийг оруулна.
- “Хөнгөлөлтөд хамрагдах шалтгаан” хэсэгт ТЕХ-ын 53.1-т заасан бодит байдлыг болон татварыг нэг удаагийн төлөлтөөр бүрэн барагдуулах боломжгүй байгаа байдлын талаар тусгах.
- Хөнгөлөлтөд хамруулахаар хүсэлт гаргасан татварын үнийн дүн нь 10,000,000₮ давах тохиолдолд, “Барьцаа” хэсэгт барьцаалах зүйлийн төрөл, тоо хэмжээ, үнийн дүн, байршил болон бусад холбогдох мэдээллийг, эсхүл барьцаа гаргах боломжгүй бол шалтгааныг нарийвчилан тусгах.
- Шаардлагатай бол барьцаатай холбоотой баримт бичгийг хавсаргана.
- Энэхүү хүсэлтийг хүлээн авсан бол хариуцсан нэгжээр батлуулна.

Татвар төлөх баталгаа										
Татварын албаны дарга танаа								он сар өдөр		
Батлан даагч Хаяг Нэр Батлан даагч Хаяг Нэр								тамга		
Татвар төлөх хугацааны хөнгөлөлттэй холбоотойгоор дараах татвар төлөгчийн хөнгөлөлтөд хамрагдах татварын төлөлтийг би батлан дааж байна.										
Татвар төлөгч		хаяг					нэр			
Хөнгөлөх татварын дүн	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль	алданги	хүү	Өр барагдуулалтын зардал	тэмдэглэл	
	Нийт дүн									

Ашиглах хүрээ:

- Энэхүү баталгааг, татвар төлөгчийн хугацааны хөнгөлөлттэй холбоотой барьцаа нь батлан даагчийн баталгаа байгаа тохиолдолд, тухайн батлан даагчаар үйлдүүлэн, татвар төлөгчөөс татварын албаны даргад гаргуулна.
- Хүснэгтийг дараах байдлаар бөглөнө:
 - 2-оос дээш батлан даагчтай тохиолдолд, хаяг нэрийг жагсаан, хамтран батлан дааж байгаа талаар тусгана. Батлан даагч нь хуулийн этгээд байгаа тохиолдолд, тухайн хуулийн этгээдийн удирдлага, эсхүл төлөөлөх эрх бүхий этгээдийн нэрийг оруулна.
 - Батлан даагчийн гарын үсэг, тамгын тухайд, гарын үсэг тамгын баталгааг хавсаргана.
Батлан даагч нь хуулийн этгээд байгаа тохиолдолд, тухайн хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нэмж хавсаргана.

Батлан даагчийн	хаяг	
	нэр	

Маягт

Энэхүү мэдэгдэлтэй холбоотой гомдол саналаа татварын албаны даргад мэдэгдэл хүлээн авсны дараах өдрөөс тооцон 3 сарын дотор гаргах эрхтэй.

Татвар төлөх тухай мэдэгдэл

он сар өдөр

Татварын албаны дарга

СЯ-ны ТНБД тамга

Доорх татвар төлөгчийн татварын өр болон татварын өр барагдуулалтын зардлыг батлан даагчийн хувьд та төлөх шаардлагатай болсон тул заасан хугацаанд барагдуулна уу.

Татвар төлөгч	харьяалал						нэр			
Татварын өр	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль		алданги	хүү	Өр барагдуулалтын зардал	Тэмдэглэл
Дээрх татвар төлөгчийн татварын өр ба өр барагдуулалтын зардлын үнийн дүнд батлан даагчийн гаргасан баталгааны үнийн дүн									₮	
Төлөх хугацаа	...оны...сарын...			Хаана төлөх	Банкны дансны мэдээлэл					
Тэмдэглэл										

Барьцааны хуудас									
он сар өдөр									
Татварын албаны дарга танаа					Барьцаа гаргагчийн хаяг Татвар төлөгчийн нэр тамга				
Татвар төлөх хугацааны хөнгөлөлтөд хамруулах хүсэлтийн барьцаа болгон дараах хөрөнгийг гаргаж байна.									
Хугацааны хөнгөлөлтөд хамрагдах татварын дүн									Барьцаа хөрөнгө
он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль	алданги	хүү	Өр барагдуулалтын зардал	Тэмдэглэл	
Татвар төлөх хугацааны хөнгөлөлтөд хамруулах хүсэлтийн барьцаа болгосон дээрх хөрөнгийг хүлээн зөвшөөрөв.									
					Барьцаа хөрөнгийг эзэмшигчийн хаяг нэр тамга				
он.....сар.....өдөр									
Хавсаргасан бичиг баримт									

Ашиглах хүрээ:

- Энэхүү хуудсыг, татвар төлөгчийн хугацааны хөнгөлөлттэй холбоотой барьцаа гаргах тохиолдолд, барьцаа гаргагч үйлдэнэ.
- Хүснэгтийг дараах байдлаар бөглөнө:
 - Хуудсыг барьцааны төрөл тус бүрээр хавсралт үүсгэн бичнэ.
 - Барьцаа гаргагч болон тухайн барьцааг эзэмшигч ялгаатай тохиолдолд, эзэмшигчийн нэр, гарын үсэг, тамгийг оруулахын хамт, гарын үсэг тамгын баталгааг хавсаргана. Батлан даагч баталгаа гаргаж байгаа тохиолдолд, татвар төлөх баталгаа гаргуулсан бол барьцааны хуудсанд батлан даагчийн гарын үсэг зуруулахгүй байж болно.
 - “Хугацааны хөнгөлөлтөд хамрагдах татварын дүн” хэсгийн “тэмдэглэл” хэсэгт хөнгөлөлтөд хамруулах тайлант хугацаа, жилийн ба сарын дүнг оруулна.

Энэхүү зөвшөөрөлтэй холбоотой гомдлыг зөвшөөрөл хүлээн авсан өдрийн маргаашаас тооцон 30 хоногийн дотор татварын албаны даргад гаргах боломжтой

Хүсэлт гаргагч	хаяг		
	нэр	танаа	
		Дугаар	

**Татвар төлөх хугацааны
хөнгөлөлтийн зөвшөөрлийн
мэдэгдэл**

Таны улсын болон орон нутгийн татвар төлөх хугацааны хөнгөлөлт хүссэноны ...сарын ..-ны өдрийн хүсэлтийг дараах байдлаар зөвшөөрсөн болохыг мэдэгдэж байна.

.....оны.....сарынөдрийн хүсэлт

Татварын албаны дарга

.....онысарын ... өдөр

СЯ-ны ТНБД

Хөнгөлөлтөд хамрагдах татварын дүн									Төлөлтийн төлөвлөгөө		
он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль	алданги	хүү	Өр барагдуулалтын зардал	Тэмдэглэл	огноо	дүн	
			₮	₮	Хуульд заасан дүн ₮	₮	Хуульд заасан дүн ₮				
Хөнгөлөлтийн хугацаа	оны.....сарын...өдрөөсоны....сарын....хүртэл.....сарын хугацаатайгаар									
Хуулийн заалт		ТЕХ-ийн 53.1									
Барьцаа											

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, татвар төлөлтийн хугацааны хөнгөлөлтийг зөвшөөрсөн тохиолдолд ТЕХ-ийн 53.1-т заасны дагуу энэ тухай татвар төлөгчид мэдэгдэхэд ашиглана.
- “Татвар төлөлтийн хугацааны хөнгөлөлтийн хүсэлт”-ийн дагуу зөвшөөрөл гарсан бол дээрх, гомдол, маргааны талаарх бичилтийг устгана.

**Татвар төлөх хугацааны
хөнгөлөлтийн хугацаа
сунгах тухай хүсэлт**

Хүсэлт гаргасан огноо	..он...сар...өдөр	Тел	
Хүсэлт гаргагч	хаяг		
	нэр	тамга	

Татварын албаны дарга танаа

ТЕХ-ийн 53.2-т заасны дагуу, дараах байдлаар татвар төлөх хугацааны хөнгөлөлтийн хугацааг сунгаж өгнө үү.

Хөнгөлөлтийн хугацааны сунгалалтанд хамрагдах татварын дүн									Төлөлтийн төлөвлөгөө		
он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль	алданги	хүү	Өр барагдуулалтын зардал	Тэмдэглэл	огноо	дүн	
			₮	₮	Хуульд заасан дүн ₮	₮	Хуульд заасан дүн ₮			₮	
Хөнгөлөлтийн хугацаа		оны....сарын...өдрөөсоны....сарын....хүртэл....сарын хугацаатайгаар								
Хугацааны сунгалт хийх шалтгаан											
Барьцаа											

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, ТЕХ-ийн 53.1-т заасны дагуу татвар төлөлтийн хугацааны хөнгөлөлтийг сунгах хүсэлт гаргасан тохиолдолд ашиглана.
- Хүсэлт гаргагч нь ААН байгаа тохиолдолд, “Хүсэлт гаргагч” хэсэгт захирлын нэр, хаягийг тусгана.
- “Хөнгөлөлтийн хугацааны сунгалтанд хамрагдах татварын дүн” хэсэгт сунгалт хийх хүсэлт гаргасан татварын он, татварын төрөл, хугацаа, мөнгөн дүнг бичнэ.
- “Хугацааны сунгалт хийх шалтгаан” хэсэгт, татвар төлөх хөнгөлөлтийн хугацаанд татвараа барагдуулах боломжгүй болсон шалтгааныг тодорхой тусгана.
- “Барьцаа” хэсэгт, шинээр барьцаа гаргах тохиолдолд, тухайн барьцааны төрөл, тоо хэмжээ, үнэ болон байршил, бусад барьцаатай холбоотой асуудлуудыг, эсхүл барьцаа гаргах боломжгүй тухайлсан нөхцөл байдал байгаа бол энэ талаар тусгана.
- Энэхүү хүсэлтэд, шаардлагатай тохиолдолд, барьцаа хөрөнгөтэй холбоотой бичиг баримтыг хавсаргана.
- Хүсэлтийг хүлээн авсны дараа холбогдох газар нэгжид шилжүүлэн хариу авна.

Маягт 41

Энэхүү зөвшөөрөлтэй холбоотой гомдлыг зөвшөөрөл хүлээн авсан өдрийн маргаашаас тооцон 30 хоногийн дотор татварын албаны даргад гаргах боломжтой

Хүсэлт гаргагч	хаяг		
	нэр	танаа	
		Дугаар	

**Татвар төлөх хугацааны
хөнгөлөлтийг сунгах зөвшөөрлийн
мэдэгдэл**

Таны улсын болон орон нутгийн татвар төлөх хугацааны хөнгөлөлтийг сунгахыг хүссэноны ...сарын ..-ны өдрийн хүсэлтийг дараах байдлаар зөвшөөрсөн болохыг мэдэгдэж байна.

.....оны.....сарынөдрийн хүсэлт

Татварын албаны дарга

.....онысарын ... өдөр

СЯ-ны ТНБД

Хөнгөлөлтөд хамрагдах татварын дүн									Төлөлтийн төлөвлөгөө		
он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль	алданги	хүү	Өр барагдуулалтын зардал	Тэмдэглэл	огноо	дүн	
			₮	₮	Хуульд заасан дүн ₮	₮	Хуульд заасан дүн ₮				
Хөнгөлөлтийн хугацаа	оны.....сарын...өдрөөсоны.....сарын.....хүртэл.....сарын хугацаатайгаар									
Сунгалт хийх шалтгаан											
Барьцаа											

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, татвар төлөлтийн хугацааны хөнгөлөлтийг сунгахыг зөвшөөрсөн болохыг татвар төлөгчид мэдэгдэхэд ашиглана.
- “Татвар төлөлтийн хугацааны хөнгөлөлтийн хүсэлт”-ийн дагуу зөвшөөрөл гарсан бол дээрх, гомдол, маргааны талаарх бичилтийг устгана.

Энэхүү хүчингүй болгохтой холбоотой гомдлыг мэдэгдэл хүлээн авсан өдрийн маргаашаас тооцон 30 хоногийн дотор татварын албаны даргад гаргах боломжтой

Татвар төлөгч	хаяг		
	нэр	танаа	
		Дугаар	

**Татвар төлөх хугацааны
хөнгөлөлтийг хүчингүй болгох тухай
МЭДЭГДЭЛ**

Таны улсын болон орон нутгийн татвар төлөх хугацааны хөнгөлөлтийноны ...сарын ..-ны өдрийн зөвшөөрлийг дараах байдлаар хүчингүй болгосныг ТЕХ-ийн 53.1-д заасны дагуу мэдэгдэж байна.

.....оны.....сарынөдөр

Татварын албаны дарга

тамга

Татвар төлөлтийн хугацааны хөнгөлөлтийг хүчингүй болгох татварын дүн									Хүчингүй болгох шалтгаан
он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль	алданги	хүү	Өр барагдуулалтын зардал	Тэмдэглэл	
			₮	₮	Хуульд заасан дүн ₮	₮	Хуульд заасан дүн ₮		

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, татвар төлөлтийн хугацааны хөнгөлөлтийг хүчингүй болгосон тохиолдолд, ТЕХ-ийн 53.6-д заасны дагуу энэ тухай татвар төлөгчид мэдэгдэхэд ашиглана.

Маягт 46

Энэхүү мэдэгдэлтэй холбоотой гомдлыг мэдэгдэл хүлээн авсан өдрийн маргаашаас тооцон 30 хоногийн дотор татварын албаны даргад гаргах боломжтой

.....онысарын ... өдөр

Татвар төлөх хоёрдогч үүргийн тухай мэдэгдэл

Татварын албаны дарга

СЯ-ны ТНБД

Та доор дурьдсан хуулийн заалтын дагуу, дараах татвар төлөгчийн татварын өр болон өр барагдуулалтын зардалтай холбоотой доор заасан үнийн дүнг төлөх татвар төлөх хоёрдогч үүргийг хүлээж байгаа тул заасан хугацаанд төлбөрийг хийхийг мэдэгдэж байна.

Татвар төлөгч		хаяг		нэр					
Татварын өр	он	Татварын төрөл	Төлөх хугацаа	Үндсэн татвар	торгууль	алданги	хүү	Өр барагдуулалтын зардал	Тэмдэглэл
					₮		₮	₮	Хуульд заасан дүн ₮
Дээрх татвар төлөгчийн татварын өр ба өр барагдуулалтын зардлын хүрээнд татвар төлөх хоёрдогч үүрэгтний төлөх дүн						₮			
Төлөх хугацааонысарын ... өдөр			Төлөх газар	Банкны дансны мэдээлэл				
Татвар төлөх хоёрдогч үүрэг хүлээлгэхтэй холбоотой хуулийн зүйл заалт						ТЕХ-ийн 57.1			

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг, татвар төлөх хоёрдогч үүргийг хүлээлгэх тохиолдолд, ТЕХ-ийн 58.1-т заасны дагуу энэ тухай татвар төлөх хоёрдогч үүрэг бүхий этгээдэд мэдэгдэхэд ашиглана.
- Шаардлагатай тохиолдолд, нэмэлтээр үзүүлэлт оруулах, мөн татвар төлөх газрын талаарх бичилтийг өөрчлөх боломжтой.
- Татвар төлөх мэдэгдлийн “Татварын өр” хэсэгт үндсэн татвар төлөгчийн татварын өрийн нийт дүнг оруулна.

- “Дээрх татвар төлөгчийн татварын өр ба өр барагдуулалтын зардлын хүрээнд татвар төлөх хоёрдогч үүрэгтний төлөх дүн” хэсэгт “.....₮ (авсан ашгийн дүн)-ийг дээд хязгаар болгон, дээрх татварын өрийн нийт дүн” гэж бичнэ.
- “Тэмдэглэл” хэсэгт, татвар төлөх хоёрдогч үүрэг үүсэх шалтгаан болсон хөрөнгө, ашгийн агуулгыг бичнэ.
- “Татвар төлөх хугацаа” хэсэгт, татвар төлөх мэдэгдлийг гаргасны маргаашаас тооцон, 20 хоногийг дараах хугацааг бичнэ. 20 хоногийн дараах өдөр нь амралтын өдөр байгаа тохиолдолд, амралтын өдрөөс өөр өдөрт тохируулан бичилт хийнэ.

Нэмэлт маягт.

Татвар төлөхийг шаардах хуудас

(Татвар төлөх хоёрдогч үүрэг бүхий этгээдэд зориулав)

Таны төлөх ёстой болохыг өмнө мэдэгдсэн татвар төлөгдөөгүй татварын өр хэвээр байгаа тул яаралтай төлж барагдуулахыг шаардаж байна.

хаяг
нэр

Анхаарах <ul style="list-style-type: none"> • Энэхүү шаардах хуудас хүргэгдсэн өдрийг оруулан тооцоод 11 дэхь хоног хүртэл өр барагдуулаагүй тохиолдолд хөрөнгийг битүүмжилнэ. • Энэхүү шаардах хуудастай холбоотой гомдлыг шаардах хуудас хүлээн авсан өдрийн маргаашаас тооцон 30 хоногийн дотор татварын албаны даргад гаргах боломжтой 	Дугаар	хаяг	
		нэр	
	Дээрх татвар төлөгчтэй холбоотой татвар төлөх хоёрдогч үүрэг хүлээж байгаагийн хувьд таны төлөх татварын дүн		₮

Нэмэлт маягт

Татвар төлөх хоёрдогч үүрэг бүхий үнийн дүнг хүчингүй болгосон тухай мэдэгдэл

Хаяг

он сар өдөр

Нэр

танаа

Татварын албаны дарга

СЯ-ны ТНБД тамга

Таны төлөх ёстой татвар төлөх хоёрдогч үүрэгт хамаарах дараах татварын үнийн дүнг хүчингүй болгосныг үүгээр мэдэгдэж байна.

Хоёрдогч үүрэг бүхий этгээд	хаяг		нэр	
Хүчингүй болсон татвар төлөх хоёрдогч үүрэг	Татвар төлөгч	хаяг	нэр	
	Холбогдох хуулийн заалт			
	Татвар төлөх мэдэгдэл хүргүүлсэн огноооны....сарынөдөр		
	Хүчингүй болсон үнийн дүн	₮		
Хүчингүй болгосон шалтгаан				
Тэмдэглэл				

Ашиглах хүрээ:

- Энэхүү мэдэгдлийг дараах тохиолдолд ашиглана.
 - Үндсэн татвар төлөгчийн татварын өр нь татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдээс хамаарахгүйгээр буурсан бол энэ талаар татвар төлөх хоёрдогч үүрэгтэй этгээдэд мэдэгдэх.
 - Татвар төлөх хоёрдогч үүрэгт хамаарах татварын өр нийт үнийн дүнгээр буурсан тохиолдолд, энэ талаар хоёрдогч үүрэг бүхий этгээдийг харьяалах татварын албаны даргад (харьяалах татварын алба нь өөрийн татварын алба байгаа тохиолдлоос бусад) мэдэгдэхэд ашиглана.
- “Хүчингүй болсон татвар төлөх хоёрдогч үүрэг” хэсгийн “Хүчингүй болсон үнийн дүн” хэсэгт нийт дүнгээр хүчингүй болсон бол “Нийт дүн” гэж бичнэ.
- “Хүчингүй болгосон шалтгаан” хэсэгт, хүчингүй болсон шалтгаан (жишээлбэл, “төлсөн” гэх мэт) ба хамаарах он сар өдрийг тусгана.
- “Тэмдэглэл” хэсэгт, хоёрдогч үүрэгт хамаарах үнийн дүнгийн нэг хэсгийг хүчингүй болгосон бол, үлдэгдэл дүнг оруулна.
- Хоёрдогч үүрэг бүхий этгээдийг харьяалах татварын албаны даргад мэдэгдэх тохиолдолд, шаардлагатай байдлаар өөрчлөлт оруулж болно.

...ОНЫ...сарын...өдөр

Татварын өр барагдуулалтад
зориулан битүүмжилсэн
хөрөнгө болно.

.....татварын алба тамга

Энэхүү лацыг дур мэдэн тайлсан болон
битүүмжилсэн хөрөнгийг нуусан,
эвдэлж гэмтэл учруулсан
тохиолдолд.....хуулийн дагуу
хариуцлага хүлээхийг мэдэгдэж байна.

МЭДЭГДЭХ ХУУДАС

Өртэй татвар төлөгчийн хаяг

Нэр

Хөрөнгийн талаарх тодорхойлолт

Дээрх хөрөнгө нь ТЕХ-ийн 60.1-т заасны дагуу ...оны...сарын..өдөрт битүүмжлэгдсэн болохыг нийтэд мэдэгдэж байна.

...оны...сарын...өдөр

Татварын алба

СЯ-ны ТНБД тамга

Энэхүү мэдэгдлийг устгасан болон бусад аргаар хүчингүй болгосон этгээдийг Эрүүгийн хуулийн ...заалтын дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Ашиглах хүрээ:

- Битүүмжилсэн хөрөнгө нь хөдлөх хөрөнгө бөгөөд лацдахад тохиромжгүй тохиолдолд энэхүү мэдэгдэх хуудсыг тухайн тоног төхөөрөмжийг байрлуулсан байр, үйлдвэрийн хаалган дээр наана. Хуудсыг байршуулсан газрын тухай битүүмжлэх хуудасны “Битүүмжилсэн хөрөнгө” хэсэгт тэмдэглэн, гарч болшгүй гомдол, саналаас сэргийлнэ.

ТАТВАРЫГ ХУВААН ТӨЛӨХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Татварын албаны дарга

.....ОНсарөдөр

Хаяг (байршил)	TEL	1. Төлөгдөөгүй татварын дүн				иен			
Овог нэр (нэр)	тамга	2. Төлөх боломжит үнийн дүн				иен			
Үйл ажиллагааны төрөл (хаяг) TEL		Төлөх хуваарь		сар	иен	сар	иен	сар	иен
				сар	иен	сар	иен	сар	иен
		сар	иен	сар	иен	сар	иен	сар	иен
		сар	иен	сар	иен	сар	иен	сар	иен

[нэг дор төлөх боломжгүй байгаа нөхцөл байдал] түр зуурын зардал ажлын үр дүн муу авлага авах хугацаа хойшилсон, буцаан авах боломжгүй болсон бусад

(Агуулга:)

[Төлбөрийн санхүүжилт] (1 сарын дундаж орлого зардлын байдлыг тэмдэглэх)		Орлого
Зардал		
Бараа татан авалт	иен	Борлуулалт
Цалин, урамшуулал	иен	Цалин урамшуулал
Түрээс	иен	
Бусад зардал	иен	
Амьдралын зардал	иен	
Зээлийн эргэн төлөлт	иен	
	иен	
	иен	

Татвар төлөх төлөвлөгөөг хугацаанд орж ирэх болон гарах магадлалтай түр хугацаагааны орлого болон зардал	
Зардал	Орлого

Татварын алба, Орлогын тасаг утас харгүдсэн ажилтан

Татвар төлөх хоёрдогч үүргийн хяналт шалгалтын хүснэгт (ТЭХ-ийн 57-р зүйлд хамааралтай)

Үндсэн татвар төлөгч	Хаяг	Овог нэр	Шалгалтын үр дүн	Он сар өдөр	Боломжтой	Баримтлах боломжгүй шалтгаан	Тамга	Хариуцсан ажилтан
Хоёрдогч үүрэгтэй татвар төлөгч	Хаяг	Овог нэр	Шалгалтын үр дүн	Зүйл заалтыг баримтлах боломжтой эсэх	Боломжгүй			
Шалгалтын асуулт		Шалгалтын огноо	Шалгалтын үр дүн	Он сар өдөр	Шалгалтын хязгаарлалт болон арга барил			
1	Хуулиар заасан татвар төлөх хугацаанаас нэг жилийн өмнөх өдрөөс хойш үнэгүй шилжүүлэг хийх гм арга хэмжээг авсан уу? (1) Нэг жилийн өмнөх өдрөөс хойш	Он сар өдөр	Байгаа (A нь B-ээс түрүүнд) Байхгүй (B болон B нь ижил, B нь A-ээс түрүүнд)	А. Хуулиар заасан хугацаанаас нэг жилийн өмнөх өдөр В. Үнэгүй шилжүүлэг хийсэн хугацаа ...шалгалтын арга = <input type="radio"/> гэрээ <input type="radio"/> санхүүгийн холбогдолтой дансны бүртгэл <input type="radio"/> ерөнхий журнал <input type="radio"/> асууж лавлах онсарөдөронсарөдөр			
(2)	Үнэгүй шилжүүлэх арга хэмжээ А. Хэт бага үнээрх шилжүүлгийн шийдвэр В. Үнэгүй шилжүүлгийн агуулга	Он сар өдөр	Байгаа байхгүй (A:B)	А. Гэрээний ердийн үнэ <input type="text"/> иен ...үнэлгээний арга = <input type="radio"/> худалдах худалдан авах бодит жишээний арга <input type="radio"/> үнийн арга <input type="radio"/> ашиг буцаах арга <input type="radio"/> бусад () В. Шилжүүлсэн хөрөнгийн үнэ <input type="text"/> иен ... а. Үнийг тодруулах арга = <input type="radio"/> гэрээ <input type="radio"/> санхүүгийн холбогдолтой дансны бүртгэл <input type="radio"/> асууж лавлах Б. Үнийн агуулга [.....]				
2	Татвар хураахад хүрэлцэхгүй байгаа нь тухайн үнэгүй шилжүүлэг хийх арга хэмжээ авснаас шалтгаалж байгаа юу?	Он сар өдөр	Байгаа (A<B) Байхгүй (A>B)	Хуулиар заасан татвар төлөх хугацаанаас 1 жилийн өмнөх өдрөөс хойшхи улсын татварын нийт дүн -ийг хураах боломжит хөрөнгийг авсан бодит нөхцөл байдал ... шалгалтын арга <input type="radio"/> газар дээрх шалгалт <input type="radio"/> асууж лавлах <input type="radio"/> бусад				
3	Татвар хураахад хүрэлцэхгүй байна уу	Он сар өдөр		А. Үндсэн татвар төлөгчийн хөрөнгө = Үндсэн татвар төлөгчийн хөрөнгөөр өр барагдуулах төлөвлөгөөт үнийн дүн (иен) + баглан даагчийн хөрөнгөөр өр барагдуулах төлөвлөгөөт үнийн дүн (иен) + баталгааг хөрөнгийн ө/б төлөвлөгөөт үнийн дүн (иен) - давуу эрхтэй авлагын дүн (иен) хуваарилах үнийн дүн (иен) В. Үндсэн татвар төлөгчийн татвар = Татварын өр (иен) + татвар төлөх хугацаа нь болоогүй ногдох татварын дүн (иен) + шийдвэр гарах хугацаа хүртлэх алданги болон өр барагдуулах ажиллагааны зардал (иен)				
		Он сар өдөр		Оршин суугчийн үнэмлэхний данс бүртгэл <input type="radio"/> газар дээрх судалгаа () <input type="radio"/> санхүүгийн холбогдолтой дансны бүртгэл () <input type="radio"/> асууж лавлах () <input type="radio"/> ногдуулалтын материал <input type="radio"/> бусад ()				
	Хаяг	Он сар өдөр		Хариуцлагын Хүлээн авсан мөнгөн дүнгийн хэмжээгээр Эд зүйлийн ердийн үнийн хэмжээгээр Чөлөөлөгдсөн авлагын ердийн үнийн хэмжээгээр Газар дээрх эрхийн ердийн үнийн хэмжээгээриениениениен	-үнэ <input type="text"/> иен - зардал <input type="text"/> иен агуулга <input type="text"/> иен		
	Үнэгүй шилжүүлэх хөрөнгийн гэрээний үйлчлэл бий болсоноор олсон ашгийн дүн							